



**SUSTAINABILITY**  
EAST ASIA LLC

**СЕНТЕРРА ГОУЛД**

**НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ  
ТАЙЛАН**

**ГАЦУУРТЫН АЛТНЫ УУРХАЙН ТӨСӨЛ**

May 2016





Хянасан байдал	Боловсруулсан	Хянасан	Баталсан	Огноо
Rev A Дотоод хяналтанд зориулсан ноорог	Э. Секстон М. Бямбабат З. Янжинлхам К. Грант А. Солонго	Ж. Мираглиотта Э. Секстонн	Ж. Мираглиотта	01/07/2015
Rev 0 Захиалагчдад зориулсан ноорог тайлан	Э. Секстон К. Грант М. Бямбабат З. Янжинлхам А. Солонго	Э. Секстонн Ж. Мираглиотта	Э. Секстонн Ж. Мираглиотта	10/07/2015
Rev1 Захиалагчдад зориулсан эцсийн тайлан	К. Грант М. Бямбабат З. Янжинлхам А. Солонго	Э. Секстонн Ж. Мираглиотта	Ж. Мираглиотта	14/09/2015
Rev2 Шинэчлэн засварласан эцсийн ноорог	Э. Секстон К. Грант	Ж. Мираглиотта	Ж. Мираглиотта	02/12/2015
Rev3	К. Грант	Ж. Мираглиотта	Ж. Мираглиотта	18/03/2016



## ГАРЧИГ

<b>НЭР ТОМЬЁОЛЛЫН ТАЙЛБАР .....</b>	<b>XI</b>
<b>ХУРААНГУЙ.....</b>	<b>I</b>
ОРШИЛ .....	I
ТӨСЛИЙН ТОЙМ ТАНИЛЦУУЛГА БА БАЙРШИЛ .....	I
СУДАЛГААНЫ ЗОРИЛГО БА АРГА ЗҮЙ .....	II
<b>НИЙГМИЙН СУДАЛГААГААР ТОДОРХОЙЛСОН ГОЛ АСУУДЛУУД.....</b>	<b>VI</b>
ХҮН АМ ЗҮЙ.....	VI
НИЙГМИЙН БҮТЭЦ .....	VII
ЭДИЙН ЗАСАГ .....	VIII
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ .....	IX
НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ .....	XI
ГАЗАР АШИГЛАЛТ БА БАЙГАЛИЙН НӨӨЦ .....	XII
ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА БА АЮУЛГҮЙ БАЙДАЛ ....	XIV
СОЁЛЫН ӨВ.....	XVI
ГОЛ ҮР АШИГ, НӨЛӨӨЛӨЛ БОЛОН НӨЛӨӨЛӨЛ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ.....	XVII
<b>1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА БА НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ .....</b>	<b>1</b>
1.1 ОРШИЛ.....	1
1.2 ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ .....	3
<b>2. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА .....</b>	<b>4</b>
2.1 БАЙРШИЛ БА ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН .....	4
Сэлэнгэ аймаг .....	4
Мандал сум.....	4
Баянгол сум.....	5
2.2 ТӨСЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮД.....	7
2.2.1 Гацууртын уурхай.....	7
2.3 ТӨСЛИЙН НӨЛӨӨЛЛИЙН БҮС.....	12
2.4 ХУВИЛБАРУУД.....	14
2.4.1 Төслийн хувилбарууд.....	14
2.4.2 Төсөл хэрэгжихгүй байх хувилбар .....	15
<b>3. ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧИН .....</b>	<b>16</b>
3.1 ОРШИЛ.....	16
3.2 МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, ЭРХЗҮЙН ОРЧИН .....	16
3.2.1 Хууль тогтоомжийн тойм .....	16
3.2.2 Монгол Улсын Үндсэн хууль.....	17
3.2.3 Засгийн газар .....	17
3.2.4 Хууль тогтоомж .....	18
3.2.5 Монгол Улсын байгаль орчин, эрүүл мэнд болон аюулгүй ажиллагааны стандартууд .....	25
3.3 ОЛОН УЛСЫН СТАНДАРТУУД БА ЗЭЭЛДЭГЧДИЙН ШААРДЛАГУУД.....	27
3.3.1 Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрүүд.....	27
3.4 ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ШААРДЛАГУУД .....	30



# SUSTAINABILITY

EAST ASIA LLC

3.5	СЕНТЕРРА КОМПАНИЙН БОДЛОГО .....	31
<b>4.</b>	<b>АРГАЗҮЙ .....</b>	<b>34</b>
4.1	НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮЙЛ ЯВЦЫН ТОЙМ .....	34
4.2	НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ (ННУ) ҮЕ ШАТ .....	34
4.2.1	Ерөнхий үнэлгээ .....	34
4.2.2	Талуудын оролцоо .....	35
4.2.3	Суурь мэдээлэл цуглуулах .....	35
4.2.4	Болзошгүй нөлөөллийн үнэлгээ ба бууруулах арга хэмжээ .....	36
4.2.5	Үнэлгээний ач холбогдол .....	39
4.2.6	Нөлөөллийн ач холбогдолын тодорхойлолт .....	42
4.2.7	Нөлөөлөл бууруулах арга хэмжээ .....	43
4.2.8	Үлдэгдэл нөлөөллийн үнэлгээ .....	43
4.2.9	Хуримтлагдах нөлөөлөл .....	44
4.2.10	Тодорхой бус байдалд анхаарлаа хандуулах нь .....	44
4.2.11	Нийгмийн менежментийн төлөвлөгөө .....	45
4.2.12	Олон нийтэд тайлагнах, мэдээлэл танилцуулах .....	45
4.3	МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ .....	45
<b>5.</b>	<b>ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫГ ТАТАН ОРОЛЦУУЛАХ.....</b>	<b>47</b>
5.1	ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮЙЛ ЯВЦ .....	47
5.2	ӨМНӨ ХИЙЖ БАЙСАН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫГ ТАТАН ОРОЛЦУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ .....	49
5.3	ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХ ЯВЦ.....	50
5.4	ХЭРЭГЖИЖ БҮЙ ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦООНЫ ҮЙЛ ЯВЦ .....	51
6.4	ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ.....	96
6.4.1	Оршил .....	96
6.4.2	Ашигласан тоо мэдээлэл .....	96
6.4.3	Ажиллах хүч ба хөдөлмөрийн оролцоо .....	96
6.4.4	Хөдөлмөр эрхлэлт.....	97
6.4.5	Орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэх.....	99
6.4.6	Цалин, хөлс.....	101
6.4.7	Ажлын нөхцөл .....	102
6.4.8	Шинээр бий болж буй ажлын байр.....	102
6.4.9	Ажилгүйдэл.....	103
6.4.10	Дүгнэлт.....	105
6.5	НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ.....	107
6.5.1	Оршил .....	107
6.5.2	Ашигласан тоо мэдээлэл .....	107
6.5.4	Эрчим хүч, дулаан .....	115
6.5.5	Усан хангамж .....	118
6.5.6	Бохир ус, цэвэрлэх байгууламж болон хатуу хог хаягдлын менежмент .....	121
6.5.7	Харилцаа холбоо, шуудангийн үйлчилгээ.....	122
6.5.8	Зам тээврийн дэд бүтэц.....	124
6.5.9	Дүгнэлт.....	131
6.6	ГАЗАР АШИГЛАЛТ БА БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАЛТ .....	133
6.6.1	Оршил .....	133
6.6.2	Ашигласан тоо мэдээлэл .....	133
6.6.3	Газар ашиглалт .....	133
6.6.4	Газар өмчлөл ба эзэмшил.....	145
6.6.5	Байгалийн нөөц ашиглалт .....	148
6.6.6	Дүгнэлт.....	155
6.7	ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА БА АЮУЛГҮЙ БАЙДАЛ.....	157
6.7.1	Оршил .....	157
6.7.2	Ашигласан тоо мэдээ .....	157
6.7.3	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ ба стандарт.....	157





# SUSTAINABILITY

EAST ASIA LLC

6.7.4	Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоо .....	165
6.7.5	Замын хөдөлгөөн ба зам тээврийн осол .....	168
6.7.6	Гэмт хэрэг ба нийгмийн дэг журам .....	172
6.7.7	Дүгнэлт.....	177
6.8.6	Дүгнэлт.....	192
<b>7.</b>	<b>НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ .....</b>	<b>193</b>
7.1	НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ, НӨЛӨӨЛӨЛ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ .....	193
7.1.1	Эдийн засаг.....	193
7.1.2	Хүн амзүй .....	210
7.1.3	Газар ашиглалт болон амьжиргаа .....	212
7.1.5	Эрүүл мэнд.....	223
7.2.1	Өмнөх хийгдсэн ажил .....	243
7.2.2	Эдийн засгийн хөрөнгө оруулалт.....	244
7.2.3	Уламжлалт амьжиргаа .....	244
<b>8.</b>	<b>НИЙГМИЙН МЕНЕЖМЕНТИЙН ХАМРАХ ХҮРЭЭ .....</b>	<b>247</b>
8.1	ОРШИЛ.....	247
8.2	МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО .....	247
8.3.2	Төлөвлө .....	250
8.3.3	Гүйцэтгэ.....	251
8.3.4	Шалга.....	252
8.3.5	Арга хэмжээ ав .....	253
<b>9.</b>	<b>НӨЛӨӨЛӨЛ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУРААНГУЙ.....</b>	<b>254</b>
<b>ХАВСРАЛТ А СУУРЬ СУДАЛГААНЫ НЭМЭЛТ БИЧИГ БАРИМТ .....</b>		<b>262</b>
<b>АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....</b>		<b>263</b>
<b>СУУРЬ СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ.....</b>		<b>266</b>
СУУРЬ СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ .....		266
Судалгааны бүс нутаг .....		266
Суурь судалгааны хамрах хүрээ .....		267
Суурь судалгааны түүвэр .....		267
Бэлтгэл ажил ба туршилт .....		272
Судалгааны төлөвлөгөөт ба бодит түүвэрлэлтийн зөрүүтэй байдлын тайлбар .....		272
Суурь судалгааны мэдээллийг цуглуулах явцад тулгарсан бэрхшээлүүд.....		272
МЭДЭЭЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА.....		273
ЧАНАРЫН ХЯНАЛТ.....		273
<b>ХАВСРАЛТ Б ГАЦУУРТ ТӨСӨЛ - БИЧИЛ УУРХАЙН ХАВСРАЛТ .....</b>		<b>275</b>
<b>ГАЦУУРТ ТӨСӨЛ – БИЧИЛ УУРХАЙН ХАВСРАЛТ .....</b>		<b>276</b>
Зорилго 276		
Суурь нөхцөл ба нөлөөллийн үнэлгээ .....		276
Компанийн үүрэг амлалт .....		283



## ХҮСНЭГТ

Хүснэгт 2.1	Уурхайн гол бүрэлдэхүүн хэсгүүд ба Гацууртын төслийн ашиглалтын үе шатны арга хэмжээнүүд .....	7
Хүснэгт 2.2	Төслийн нөлөөллийн бүс .....	14
Хүснэгт 3.1	Соёлын өвийн тухай Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвенцүүд ..	23
Хүснэгт 3.2	Гацууртын төслийн үйл ажиллагаанд хамааралтай нийгэм, байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны стандартууд .....	25
Хүснэгт 3.3	Сентеррагийн компанийн хариуцлагын стандартууд .....	32
Хүснэгт 4.1	Нөлөөллийн хэмжээ, мэдрэмжийн үнэлгээ .....	38
Хүснэгт 4.2	Нөлөөний үнэлгээний тодорхойлолт .....	41
Хүснэгт 4.3	Болзошгүй нөлөөллийн ач холбогдолын үнэлгээний тодорхойлолт .....	42
Хүснэгт 4.4	Магадлалын үнэлгээний тодорхойлолт .....	42
Хүснэгт 6.1	Сэлэнгэ аймгийн шилжилт хөдөлгөөний байдал, 2012 – 2014 он .....	54
Хүснэгт 6.2	Хот, хөдөөгийн хүн амын хувийн жин, 2012, 2014 он .....	55
Хүснэгт 6.3	Судалгаанд оролцогсдын боловсролын түвшин, хувь .....	58
Хүснэгт 6.4	15 буюу түүнээс дээш насны хүн амын шашин шүтлэгийн статус, хувь .....	61
Хүснэгт 6.5	Судалгаанд оролцогсдын шашин шүтлэг, шашин шүтлэгийн төрөл ба хувиар .....	61
Хүснэгт 6.6	Төрийн байгууллагуудын эрх мэдэл, сонгогдох үйл явц .....	64
Хүснэгт 6.7	Сүүлийн гурван удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүн, 2005, 2009 ба 2013 он .....	66
Хүснэгт 6.8	Сонгогчдын оролцоо, 1992, 1996, 2000, 2004, 2008, 2012 .....	67
Хүснэгт 6.9	Бүртгэгдсэн аж ахуйн нэгжүүдийн тоо, 2015 оны 4 сарын байдлаар .....	72
Хүснэгт 6.10	Сэлэнгэ аймагт бүртгэлтэй төрийн бус байгууллагуудын (ТББ) жагсаалт ....	72
Хүснэгт 6.11	Таны амьдралтай холбоотой асуудлуудыг багийн хурлаар хэлэлцдэг эсэх, сум багаар .....	74
Хүснэгт 6.12	Амьжиргаа сайжруулах, ашиг орлогыг нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн хүртээмж (%) .....	75
Хүснэгт 6.13	Сум, аймгийн төсвийн орлого, зарлага, мян. төгрөгөөр, 2014 .....	82
Хүснэгт 6.14	Мал аж ахуйн үзүүлэлтүүд, Сэлэнгэ, сонгосон сумдаар, 2014 .....	84
Хүснэгт 6.15	Банкны салбарын үзүүлэлтүүд, сая төгрөг, Сэлэнгэ аймаг, 2012 – 2014 .....	89
Хүснэгт 6.16	Үүрэн телефон, гэрийн интернет ашиглагчдын хүн амд эзлэх хувийн жин ..	93
Хүснэгт 6.17	Судалгаанд оролцогчдын ажлын нөхцлын талаар ойлголт .....	102
Хүснэгт 6.18	Бүртгэлтэй ажилгүйчүүдийн хувийн жин, боловсролын түвшингээр, Сэлэнгэ, 2012-2014 он .....	105
Хүснэгт 6.19	Элсэн орсон ба төгссөн байдал, 2012-2015 оны хичээлийн жилд .....	110
Хүснэгт 6.20	Төслийн бүсийн зарим нэг сургуулийн үзүүлэлт (бага, дунд, ахлах), 2012-2015 оны хичээлийн жилд .....	111
Хүснэгт 6.21	Ерөнхий боловсролын сургуулиудын багш-сурагчийн харьцаа, хичээлийн жилээр .....	113
Хүснэгт 6.22	Мандал сумын мэргэжлийн боловсролын сургалтын төвийн оюутнуудын тоо, мэргэжлээр, 2015 .....	114
Хүснэгт 6.23	Боловсролын дүйцсэн хөтөлбөрт хамрагдсан суралцагчдын тоо, 2014/2015 .....	115
Хүснэгт 6.24	Усны эх үүсвэрийн тооллогын дүн, 2014 .....	119
Хүснэгт 6.25	Ундны усны гол эх үүсвэр, судалгаанд хамрагдсан сум, баг (%) .....	121
Хүснэгт 6.26	Харилцаа холбоо, шуудангийн үйлчилгээ, Сэлэнгэ аймаг, жилээр .....	122
Хүснэгт 6.27	Техникийн үзлэгт орсон тээврийн хэрэгслийн тоо .....	126
Хүснэгт 6.28	Өдөр болон шөнийн аялалын чиглэл .....	128
Хүснэгт 6.29	Төмөр замын тээврийн гол үзүүлэлтүүд, аймгаар, 2014 .....	130
Хүснэгт 6.30	Төмөр замын зорчигчдын билетийн үнэ, төгрөг .....	130
Хүснэгт 6.31	Сэлэнгэ аймгийн төвөөс сумд болон Улаанбаатар руу явах нийтийн тээврийн үнэ, төг .....	131
Хүснэгт 6.32	Орон нутгийн тусгай хамгаалалттай 2 газар нь Гацууртын төслийн хүдэр тээвэрлэхээр санал болгож буй замтай огтлолцсон байдал .....	136
Хүснэгт 6.33	Малчин өрхийн тоо, аймаг ба сум, 2010 – 2013 .....	140
Хүснэгт 6.34	Газрын маргаанд оролцсон талууд, судалгаанд хамрагдагсдын эзлэх хувь ..	142
Хүснэгт 6.35	Бэлчээртэй холбоотой маргаан гарах давтамж .....	142
Хүснэгт 6.36	Бэлчээр ашиглалттай холбоотой маргааныг шийдвэрлэх нийтлэг аргууд ..	143
Хүснэгт 6.37	Шилжин ирэгсэдтэй холбоотой бэлчээрийн менежмент асуудлууд .....	143



# SUSTAINABILITY

EAST ASIA LLC

Хүснэгт 6.38	Сэлэнгэ аймагт газар өмчилсөн байдал, 2015 оны 5 дугаар сарын байдлаар .....	146
Хүснэгт 6.39	Өрхийн зориулалтаар өмчилж авсан иргэдийн газрын байршил .....	146
Хүснэгт 6.40	Нутгийн иргэдийн газар эзэмшиж, ашиглаж буй байдал.....	148
Хүснэгт 6.41	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль хамгаалалд зарцуулагдах төлбөрийн хувь, хэмжээ (Монгол Улсын бүх сумдад) .....	148
Хүснэгт 6.42	Усны хэрэглээтэй холбоотой үүсдэг маргааны давтамж (өрхүүдийн мэдээлснээр), (%).....	154
Хүснэгт 6.43	Судалгаанд хамрагдагсдын дунд ундны усны чанараа шалгадаг хүмүүсийн эзлэх хувь .....	154
Хүснэгт 6.44	Монгол Улсад үзүүлж буй эрүүл мэндийн үйлчилгээний тойм, 2012 .....	159
Хүснэгт 6.45	Эрүүл мэндийн байгууламжуудын тоо, аймгийн ба сумын түвшний эмнэлгийн ор ба эрүүл мэндийн ажилтны тоо, 2014.....	161
Хүснэгт 6.46	Монголын уламжлалт эрүүл мэндийн үйлчилгээ .....	162
Хүснэгт 6.47	Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж (%).....	163
Хүснэгт 6.48	Аймаг, сумын түвшний төрөлт ба нас баралтын тоо.....	166
Хүснэгт 6.49	Аймаг, сумын түвшний халдварт өвчний тохиолдол, өвчилсөн хүмүүсийн тоогоор.....	167
Хүснэгт 6.50	Аймаг сумын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, 2015 оны 5 дугаар сарын байдлаар.....	173
Хүснэгт 6.51	Археологийн мэдэгдэж буй нөөцийн он цагийн хураангуй.....	180
Хүснэгт 7.1	Сентеррагийн шууд хөдөлмөр эрхлэлт.....	194
Хүснэгт 7.2	Гэрээт гүйцэтгэгчийн шууд бус хөдөлмөр эрхлэлт.....	195
Хүснэгт 7.3	Монгол Улсад оруулах шууд үр ашгийн бүрэлдэхүүн хэсгийн задаргаа (нийт үр ашгаас % ) .....	199
Хүснэгт 7.4	Урьдчилсан байдлаар тооцоолсон татвар, төлбөр, хураамж (төгрөг, сая) .....	199
Хүснэгт 7.5	Гацууртын төслийн хувиарлалт.....	200
Хүснэгт 7.6	Сентеррагийн СХС-гийн санхүүжилтаар хэрэгжүүлсэн төслүүдийн тоо, төрөл, АНУ доллар, 2004 - 2012 .....	203
Хүснэгт 7.7	Ирээдүйн Сентеррагийн хөрөнгө оруулалтаас орон нутгийн иргэдийн хүлээх хүлээлт .....	203
Хүснэгт 7.8	ННҮ-д хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээг уялдуулах.....	243
Хүснэгт 8.1	Нийгмийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үүрэг, хариуцлага.....	251
Хүснэгт 9.1	Нөлөөлөл, бууруулах арга хэмжээний хураангуй .....	255



## ЗУРАГ

Зураг Х 1.1	Гацууртын төслийн байршлийн зураг .....	v
Зураг 2.1	Төслийн байршил .....	6
Зураг 2.2	Төслийн талбайн газрын зураг.....	13
Зураг 4.1	Үнэлгээний аргазүй.....	34
Зураг 4.2	Нөлөөллийн шинж чанар, төрөл болон эргэн өөрчлөгдөх боломж .....	38
Зураг 4.3	Ач холбогдолын үнэлгээ .....	40
Зураг 4.4	Ач холбогдолын зэргийн тодорхойлолт .....	44
Зураг 6.1	Хүн амын жилийн дундаж өсөлт, улс, аймаг, сумын түвшинд .....	54
Зураг 6.2	Төслийн бүсийн боловсролын түвшин .....	58
Зураг 6.3	Улс орны өнөөгийн улс төрийн нөхцөл байдлын талаарх ойлголт, сумдаар (%).....	68
Зураг 6.4	Судалгаанд хамрагдсан хүмүүсийн санал өгөх үндэслэл, хувиар, сумаар ....	69
Зураг 6.5	Судалгаанд оролцогчдын байгууллагуудад итгэх хувь, сумаар .....	71
Зураг 6.6	Сумын захиргааны чиг үүрэгт сэтгэл дундуур байгаа гол асуудлууд.....	71
Зураг 6.7	Эрчүүдийн хийж болох гэрийн ажлууд, Баянгол сумаар (%).....	76
Зураг 6.8	Өрхийн санхүүтэй холбоотой шийдвэрийг хэн гаргадаг вэ (%) .....	77
Зураг 6.9	Гэр бүлийн хүчирхийлэлд илүү өртдөг хохирогчид (%).....	78
Зураг 6.10	Шилжин ирэгсэд буюу “гаднаханд” хандах хандлага, хувиар, сумаар .....	79
Зураг 6.11	Сэлэнгэ аймгийн орон нутгийн төсөв (сая төгрөгөөр), 1990-2014 он .....	82
Зураг 6.12	Сэлэнгэ аймгийн гол нэрийн бүтээгдэхүүний үнийн судалгаа, 1997 – 2014 он.....	83
Зураг 6.13	Банкны салбарын хөрөнгө ба эх үүсвэр, сая. төгрөгөөр, 2009 – 2014 он.....	90
Зураг 6.14	Төслийн бүсэд байрлах өрхүүдийн дундаж орлого.....	92
Зураг 6.15	Ядуурлын зураглал, аймаг, сумаар, 2010 он.....	94
Зураг 6.16	Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйсээр, Сэлэнгэ аймаг, 2012-2014.....	97
Зураг 6.17	Сэлэнгэ аймгийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин, 2012–2014 он .....	98
Зураг 6.18	Ажилгүйдлийн түвшин, нийт хүн ам болон хүйсээр, Сэлэнгэ, 2012 - 2014 он.....	104
Зураг 6.19	Төслийн бүсийн цэцэрлэгийн багш–хүүхдийн харьцаа, 2014/2015 он .....	109
Зураг 6.20	Сургуульд хамрагдалтын хүйсийн харьцаа, 2014-2015 оны хичээлийн жилд, сумдаар .....	112
Зураг 6.21	Сургуулийн анги дүүргэлт, 2014-2015 хичээлийн жилд (өдрийн ангийн сурагчид).....	113
Зураг 6.22	Төвлөрсөн эрчим хүчний эх үүсвэрээс цахилгаан авч буй малчин өрхийн тоо .....	117
Зураг 6.23	Өрхийн хэрэглэдэг цахилгааны эх үүсвэрийн төрөл, сум, багаар, хувиар..	118
Зураг 6.24	Баянгол сумын усны эх үүсвэр .....	120
Зураг 6.25	Мандал сумын усны эх үүсвэр.....	120
Зураг 6.26	Харилцаа холбоо, шуудангийн үйлчилгээний хүртээмж, 2015, сумаар, хувиар .....	123
Зураг 6.27	Радио, телевизийн хэрэглээ, 2015, сумаар, хувиар .....	123
Зураг 6.28	Төслийн бүсийн авто болон төмөр замын дэд бүтцийн зураг, Баянгол сум	125
Зураг 6.29	Төслийн бүс нутгийн авто болон төмөр замын дэд бүтцийн зураг, Мандал сум.....	125
Зураг 6.30	Замын хөдөлгөөний судалгаа хийсэн байршил .....	127
Зураг 6.31	Гацууртын тээврийн зам дагуух замын хөдөлгөөний тооллого .....	127
Зураг 6.32	Байршил тус бүрээр замын хөдөлгөөний дундаж тоог зорчих цагаар харуулав.....	128
Зураг 6.33	Гацууртын уурхайн талбай хүртэлх замын хөдөлгөөн .....	129
Зураг 6.34	Гацууртын төслийн орчим уул уурхайн зориулалтаар олгогдсон газрууд..	135
Зураг 6.35	Төслийн талбайд байрлах орон нутгийн тусгай хамгаалалттай 2 газрын байршил .....	137
Зураг 6.36	Малын тоо толгой, аймаг ба сумдаар, 2011 – 2014 .....	139
Зураг 6.37	100 га бэлчээрт оногдох хонин тоо толгой, улсын дундаж, 2014 .....	139
Зураг 6.38	Төслийн талбай дах судалгаанд хамрагдсан малчин өрх .....	140
Зураг 6.39	Газрыг өрхийн зориулалтаар ашиглаж байгаа хүмүүсийн эзлэх хувь (%) .	147
Зураг 6.40	Өвөлжөө / хаваржааны бэлчээрийн хүртээмж .....	149
Зураг 6.41	Мандал сумын гадаргын усны нөөц .....	152
Зураг 6.42	Баянгол сумын гадаргын усны нөөц .....	152



# SUSTAINABILITY

EAST ASIA LLC

Зураг 6.43	Усны нөөцийг эрх тэгш ашиглаж байгаа эсэх талаарх асуултанд өрхүүдийн хариулсан байдал (%).....	153
Зураг 6.44	Эрүүл мэндийн үйлчилгээний сонголт (сум, баг, ба өрхийн түвшинд) .....	163
Зураг 6.45	Иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдахгүй байгаа шалтгаан .....	164
Зураг 6.46	Сэлэнгэ аймаг дахь нас баралтын гол шалтгаан .....	166
Зураг 6.47	Зам тээврийн ослын гол шалтгаан .....	169
Зураг 6.48	Баянгол ба Мандал суманд зам тээврийн ослын улмаас гарсан гэмтэл ба нас баралт, тоогоор.....	170
Зураг 6.49	Баянгол ба Мандал суманд гарсан зам тээврийн ослын гол шалтгаан, тоогоор.....	170
Зураг 6.50	Баянгол ба Мандал суманд гарсан зам тээврийн ослын төрөл, тоогоор ....	171
Зураг 6.51	Аймгийн хэмжээнд гарсан гэмт хэргийн бүтэц, 2015 оны 5 дугаар сарын байдлаар .....	173
Зураг 6.52	Сумын хэмжээнд гардаг гэмт хэргийн бүтэц, 2015 оны 5 дугаар сарын байдлаар .....	174
Зураг 6.53	Сум, багийн хэмжээнд сүүлийн 2 жилд гарсан гэмт хэргийн бүтэц .....	175
Зураг 6.54	Төслийн талбайд эрх нь зөрчигдөж буй хүн амын гол бүлгүүд, тоогоор (Судалгаанд оролцогчдын бодлоор).....	176
Зураг 6.55	Гацууртын төслийн нөлөөллийн бүсэд байрлах соёлын биет өв газар .....	183
Зураг 6.56	1926-1927 оны Ноён уулнаас олдсон археологийн олдворууд.....	184
Зураг 6.57	Сумын соёлын өвийн ач тусын талаарх өрхийн судалгаанд хамрагдсан оролцогчдын хариулт, хувиар.....	185
Зураг 6.58	Мөргөлчид өглөө эртлэн Ноён уулын тахилгын ёслолд ирж байгаа нь, 2015 оны 6 дугаар сар .....	187
Зураг 6.59	Ноён уулан дээр бөө нарын шинээр босгосон овоо.....	187
Зураг 6.60	Ноён уулын орой болох Хатан овоо тахилгын газар.....	188
Зураг 6.61	Түүх, соёлын өвийн хамгаалалтын талаархи олон нийтийн ойлголт хандлага, хувиар .....	191
Зураг 6.62	Соёлын өвийн мэдээллийг олж авдаг эх сурвалж, хувиар.....	191
Зураг 7.1	Үүсгэн багуулсанаас хойш сумын Хөгжлийн санд хийсэн хөрөнгө оруулалтууд, АНУ доллар .....	202
Зураг 8.1	Компаний бодлого, систем, төлөвлөгөө болон журмын шатлал.....	247
Зураг 8.2	Үйл ажиллагааны чиглэлээр харуулсан Гацууртын төслийн менежментийн төлөвлөгөө.....	250



## ТОВЧЛОЛ

БУ	Бичил уурхай
ХҮУИ	Хэрэглээний үнийн улсын индекс
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ИЗНН	Иргэний зориг – Ногоон нам
БГ	Аймгийн Боловсролын газар
БОНБНУ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ
ДСЦТС	Дархан, Сэлэнгийн Цахилгаан түгээх сүлжээ
ЭМГ	Эрүүл мэндийн газар
АН	Ардчилсан нам
БОНБУ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
БОННУ	Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ
ЦТС	Цахилгаан түгээх сүлжээ
УМХГ	Улсын Мэргэжлийн хяналтын газар
БОНБЕУ	Байгаль орчин нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ӨНЭЗС	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
АУДС	Монгол Улсын Анагаахын ухааны дээд сургууль
ОУСК	Олон улсын санхүүгийн корпораци
ОУХБ	Олон улсын Хөдөлмөрийн байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
МАН	Монгол Ардын нам
МАХН	Монгол Ардын хувьсгалт нам
Саят/ж	жилд сая тонн
АМГ	Монгол Улсын Ашигт малтмалын газар
ТББ	Төрийн бус байгууллага
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАН	Хятад улсын Ардын нам
ХАССТ	Хүн амын сургалт, судалгааны төв
УСГ	Усны сав газар
УМ	Уурхайгаас гарч буй материал
БНН	Бүгд найрамдах нам
ТБУ төсөл	Тогтвортой бичил уурхай төсөл
ШХА	Швейцарийн хөгжлийн агентлаг
ННУ	Нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ
ТАТ	Тогтвортой амьжиргааны төсөл
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
БЗХӨ	Бэлгийн замын халдварт өвчин
м²	Квадрат метр
С	Сүрье



## НЭР ТОМЬЁОЛЛЫН ТАЙЛБАР

<i>аймаг</i>	Монгол Улсын нутаг дэвсгэр дэх засаг захиргааны орон нутгийн нэгж
<i>сум</i>	Монгол Улсын нутаг дэвсгэр дэх засаг захиргааны хоёр дах түвшний орон нутгийн нэгж
<i>баг</i>	Тосгон; Монгол Улсын нутаг дэвсгэр дэх засаг захиргааны хамгийн длд түвшний орон нутгийн нэгж
<i>BIOX®</i>	BIOX® процесс нь Өмнөд Африкийн Biomin компани эзэмшдэг технологи бөгөөд лицензийг нь хэд хэдэн уурхай ашигладаг юм. Энэхүү BIOX® процессэд хутгалттай саванд сульфидын хүдрийн бактераар урьдчилан исэлдүүлэх арга, уламжлалт цианидийн уусгалтаар алтыг баяжуулах арга зэрэг багтана.
<i>зуд</i>	Хахир өвлийн цаг агаарын нөхцөл байдал
<i>гол</i>	Гол
<i>дотоодын шилжилт хөдөлгөөн</i>	Тухайн <i>аймгийн</i> өөр өөр <i>сумдууд</i> руу шилжих хөдөлгөөн
<i>хурал</i>	Засаг захиргааны хуралдаан
<i>нэгдэл</i>	Социализмын үед Монгол Улсад үүсэж байсан хөдөө аж ахуйн хоршоодын түгээмэл нэр
<i>гадагшаа чиглэсэн шилжилт хөдөлгөөн</i>	<i>Сум, аймгаас</i> Монгол Улсын бусад газар болон далайн чанд руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн
<i>овоо</i>	Овоо нь ихэвчлэн уулын савдаг, ариун шүтээн мод, нуур, булаг зэрэг сүнстэй холбогдолтой байгалийн хүчин зүйлсүүдийг тодотгоход зориулсан байдаг. Овоог орон нутгийн иргэд байгалийн гамшгийн (ойн түймэр, зуд) үед залбирал үйлдэх шашны мөргөлийн газар болгон хэрэглэдэг.
<i>сум</i>	Монгол Улсын нутаг дэвсгэр дэх засаг захиргааны хоёр дах түвшний орон нутгийн нэгж
<i>уул</i>	Уул
<i>Эмзэг өрх</i>	Ядуурлын түвшнээс доогуур буюу (эмэгтэйчүүд, өндөр настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг) эмзэг бүлгийн гишүүдтэй өрх



## ХУРААНГУЙ

### ОРШИЛ

Сентерра Гоулд Инк (цаашид Сентерра буюу компани гэх) нь Састэйнабилити Ийст Эйжия ХХК-аар (цаашид Састэйнабилити гэх) Гацуурт төслийн (цаашид Төсөл гэх) Нийгмийн нөлөөллийн үнэлгээг хийж гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан. Энэ нь хоёр хэсгээс бүрдэнэ: нэгдүгээрт, гэрээт гүйцэтгэгч болох Хүн амын сургалт судалгааны төвтэй (ХАССТ) хамтран Гацуурт төслийн Нийгмийн суурь судалгааг боловсруулах; хоёрдугаарт төслийн барилга, үйл ажиллагаа ба хаалтын үе шатуудын Нийгмийн нөлөөллийн үнэлгээг Сэлэнгэ аймаг, Мандал, Баянгол зэрэг зорилтот сумдад (Түнхэл багийг тусгайлан авч үзсэн) боловсруулах ажил багтана.

Тус Хураангуй хэсэгт Нийгмийн суурь судалгаа болон Нөлөөллийн үнэлгээний гол үр дүнгийн товч тоймыг танилцуулав. Үүнд, Сентерра компанийнн Монгол Улсад хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагаа, Гацууртын төсөл; нийгмийн суурь судалгаа ба нөлөөллийн үнэлгээний арга зүй; түүнчлэн хүн ам зүй, нийгмийн бүтэц, эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн үйлчилгээний дэд бүтэц, газар ашиглалт ба байгалийн нөөц, орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал, соёлын өв зэрэг нийгмийн судалгааны гол асуудлууд болон төслөөс үүсч болзошгүй нөлөөллүүд багтсан байна. Эцэст нь төслийн гол нөлөөллүүд болон тэдгээрийг бууруулах арга хэмжээний хураангуйг орууллаа.

### ТӨСЛИЙН ТОЙМ ТАНИЛЦУУЛГА БА БАЙРШИЛ

Гацууртын төсөл нь Улаанбаатар хотоос хойд зүгт 90 км, Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгоноос баруун зүгт 14 км зайд байрлах Хэнтийн нурууны хөндийд оршдог. Зураг Х 1.1-д төслийн байршил үзүүлэв. Сентерра нь Бороо Гоулд уурхайгаас (одоогоор зөвхөн алт баяжуулах үйл ажиллагаа явуулж байна) 35 км зайд байрлах Гацуурт төслийг 100% эзэмшдэг. Гацуурт төслийн талбай нь Бороогийн уурхайн талбайтай 55 км-ийн урттай замаар холбогдсон бөгөөд энэ замыг Мандал сумын засаг захиргааны захиалгаар 2010 онд бариулсан билээ.

Сентерра Гоулд, Монгол Улсын Засгийн газрын хооронд байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээнд тус компани нь алтны ил уурхайг ажиллуулж жилд нэг сая хүртэл тонн (саят/ж) алтны хүдрийг 10 жилийн хугацаанд олборлохоор тусгасан юм. Гацууртын өнөөгийн төлөвлөгөөний дагуу тус компани нь Гацуурт төслийн үйл ажиллагааны эхний хоёр жил хагасын хугацаанд тонн тутамд 2.86 грамм алтны дундаж агуулгатай 3.6 сая орчим тонн хүдрийг одоо байгаа Бороогийн уурхайн байгууламжийг ашиглан боловсруулах төлөвтэй байна. Энэ хугацаанд Бороогийн уурхайн одоо ашиглаж буй байгууламж дээр BIOX® байгууламжийг нэмж байгуулахаар төлөвлөсөн бөгөөд энэ нь тонн тутамд 2.92 грамм алтны дундаж агуулгатай нийт 13.5 сая орчим тонн үлдэгдэл BIOX® хүдрийг боловсруулах зориулалтаар ашиглах юм. BIOX® процесс нь хутгалттай саванд алтны хүдрийн бактериар урьдчилан исэлдүүлэх арга, уламжлалт цианидийн уусгалтын аргаар алтыг баяжуулах технологи юм.

Тус компани нь хүдрээ Гацууртын уурхайн талбайгаас олборлож, Бороогийн уурхайн одоо ашиглаж буй тээрэмд тээвэрлэн авчирч боловсруулахаар төлөвлөж байна. Гацуурт, Бороо хоёр уурхайг холбож буй хүдэр тээвэрлэлтийн зам, уурхайн дотоод зам, уурхайн бусад байгууламжуудыг 2010 онд барьж байгуулж дуусгасан билээ.

Төслийн гол үзүүлэлтүүд:



- Гацууртын уурхайгаас жилд нэг тонн хүртэл алтны хүдрийг ил уурхайн аргаар олборлоно;
- Компанид 487 ажилтан, уурхайн гэрээт гүйцэтгэгч компанид 300 гэрээт ажилтан, хүдэр тээвэрлэлтийн компанид 144 гэрээт ажилтан, кэмпийн үйлчилгээний гэрээт компанид 500 ажилтан ажилд авахаар төлөвлөж байна;
- Ил уурхайн хүнд механизмын парк нь экскаватор/ утгуурт экскаватор, өөрөө буулгагч хүнд механизм, бульдозер, грейдер, усны машинуудтай байна;
- Бороогийн уурхайн тээрмийг хадгалан үлдээх бөгөөд нэмээд жилд 1.75 сая тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай BIOX® үйлдвэрийг барьж байгуулна;
- Бороогийн уурхайн одоо ашиглаж буй Хаягдал хадгалах байгууламжийн өргөтгөл, үйл ажиллагаанд зориулж нэмэлт өндөрлөгөө барина;
- Гацууртын гол дээрхи усны тунгаагуур, урсац өөрчлөх далан, бусад холбогдох дэд бүтэц бүхий Гацууртын уурхайн усны менежментийн дэд бүтцийг сайжруулж ажиллуулах боломжтой;
- Цахилгаан, холбооны нэмэлт дэд бүтцийг суурилуулах боломжтой.

Тус төслийн хүрээнд өмнө нь хийгдсэн судалгаануудад 2011 онд хийгдсэн Нийгэм, эдийн засаг, Эрүүл мэнд, Соёлын суурь судалгаа, 2010 онд хийгдсэн Газар ашиглалтын судалгаа болон Техник эдийн засгийн үндэслэл (2005 оны тайлан ба түүний 2006 оны нэмэлт тодотгол) мөн Монгол Улсын холбогдох шаардлагуудын дагуу боловсруулсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (2009 оны тайлан ба түүний 2014 оны нэмэлт тодотгол) зэрэг багтана.

## **СУДАЛГААНЫ ЗОРИЛГО БА АРГА ЗҮЙ**

### **Суурь судалгаа**

Энэхүү Нийгмийн суурь судалгааны зорилго нь төслийн нөлөөллийн талбай дахь нийгэм, эдийн засгийн өнөөгийн төлөв байдлыг тодорхойлоход эх сурвалж болгон ашиглаж болох анхдагч болон хоёрдогч гол мэдээллүүдийг цуглуулахаас гадна Нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээний суурь мэдээлэл болох явдал юм.

Суурь судалгаагаар аймаг, сум, баг ба өрх зэрэг дөрвөн түвшинд мэдээ баримтуудыг цуглуулав. Аймаг, сум, багийн түвшний мэдээ нь Сэлэнгэ аймаг, Баянгол ба Мандал сумд, мөн Түнхэл багийн нийгэм, эдийн засгийн гол шалгуур үзүүлэлтүүдийг харуулна. Тус суурь судалгаанд анхдагч мэдээ цуглуулж, дүн шинжилгээ хийхэд Өрхийн судалгаа, Гол талуудтай хийсэн ярилцлага, Зорилтот бүлгийн хэлэлцүүлэг зэргийг ашигласан. Өрхийн судалгааны мэдээллийг Статистикийн хэрэглээний багц программыг (SPSS) ашиглан боловсруулсан. Орон нутгийн иргэд, сумын удирдлага, бизнес эрхлэгч, иргэний нийгмийн төлөөлөл зэрэг Гол талуудтай хийсэн ярилцлага, Зорилтот бүлгийн хэлэлцүүлгийг нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг гүнзгийрүүлж судлах зорилгоор явуулсан. Төслийн нөлөөллийн бүсийн нийгэм, эдийн засгийн өнөөгийн төлөв байдлыг тодорхойлох зорилгоор их хэмжээний хоёрдогч мэдээллийг цуглуулж, боловсруулсан.

## **Нийгмийн нөлөөллийн үнэлгээ**

Нийгмийн нөлөөллийн үнэлгээний (ННУ) зорилго нь ашиглахаар төлөвлөж буй Гацууртын төслөөс үүсч болзошгүй нөлөөллийг тодорхойлж, дүн шинжилгээ хийх, тогтвортой хөгжлийн боломжуудыг бодит байдал дээр хэрэгжүүлэх санаачлага зөвлөмж боловсруулах, мөн сөрөг нөлөөллийг бууруулах явдал юм. Нийгмийн нөлөөллийн үнэлгээнд дараах үйл ажиллагааны нөлөөлөлд өртөж болзошгүй орон нутгийн иргэдийг хамруулсан төслийн бүс нутгийг авч үзсэн.

- Гацууртын төслийн талбай дахь уурхай ба холбогдох үйл ажиллагаанууд
- Гацуурт ба Бороогийн төслийн хооронд хүдэр тээвэрлэх ачааны машин ба төслийн бусад тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөн, мөн
- Одоогийн Бороогийн төслийн талбайд баяжуулахын нэмэлт байгууламжууд ба тоног төхөөрөмжүүдийг барьж байгуулах, ажиллуулах.

Нийгмийн нөлөөллийн үнэлгээний хамрах хүрээнд төслийн барилга, үйл ажиллагаа ба хаалтын үе шаттай холбоотойгоор үүсэх нөлөөллийг үнэлж, нөлөөллийг бууруулахад авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулж, санал болгох зэрэг багтана. Ингэснээр, нөлөөллөөс урьдчилан сэргийлж, нөлөөллийг бууруулан, хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд тогтоон барьж, эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх боломжтой болно. Нийгмийн нөлөөллийн үнэлгээ нь сонирхогч талуудын үр дүнтэй оролцоог хангах байдлаар нөлөөлөл, эрсдэл ба холбогдох сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар Сентерра-д тодорхой ойлголт өгөх зорилготой. Гацууртын уурхайн бүтээн байгууллацтай холбоотойгоор үүсэх нийгэм, эдийн засгийн болзошгүй нөлөөллүүд, эрсдлүүд ба үр дагаварыг (компани болон олон нийтийн аль аль нь) үнэлсэнээр нийгмийн эрсдэлийг бууруулах цогц төлөвлөгөө боловсруулахад хэрэгцээтэй мэдээлэл болсон бөгөөд дээрхи төлөвлөгөө нь гомдол барагдуулах менежментийн үйл ажиллагаа бүхий Нийгмийн менежментийн төлөвлөгөө (НМТ) ба Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөө (ТТОТ) зэргээс бүрдэнэ. Нийгмийн менежментийн ерөнхий бүтцийг олон нийтэд танилцуулах баримт бичгүүдийн нэг хэсэг болгон боловсруулсан ба Нийгмийн менежментийн нарийвчилсан төлөвлөгөөг барилгын ажил эхлэхээс өмнө боловсруулж, төслийн Байгаль орчин, нийгмийн менежментийн тогтолцооны (БОНМТ) нэг бүрэлдэхүүн хэсэг болгоно. Нийгмийн менежментийн төлөвлөгөөнд дараах төлөвлөөгөнүүд багтсан байна: ажиллагсдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа; онцгой байдлын үед авах хариу арга хэмжээ; оролцогч талуудыг татан оролцуулах ; гомдол барагдуулах; орон нутгийн хөгжил; соёлын өв; байгалийн нөөцийн менежмент; хөдөлмөр эрхлэлт, сургалт; орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал; худалдан авалт, хангамжийн сүлжээ.

Үнэлгээний арга зүйнд дараах үе шатууд багтах бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн аль хэсгээс олж болохыг тусгасан байна:

### **Ерөнхий үнэлгээ**

Бүлэг 2 Төслийн танилцуулга хэсэгт нөлөөлөлд өртөгч болон байгалийн нөөцөд үзүүлж болзошгүй ноцтой нөлөөлөлд хүргэх магадлалтай үйл ажиллагаа болон нөлөөллийн зэргийг тодорхойлсон. Төслийн төлөвлөгөө, шийдвэр гаргалт ба төслийг сайжруулах үйл ажиллагааг Төсөл хэрэгжүүлэх явцад тодорхойлогдсон нөлөөллүүдийн зохицуулалтыг үнэлэхдээ өөрчлөн сайжруулдаг.

### **Оролцогч талуудыг татан оролцуулах**

Бүлэг 5-д тодорхойлсноор, төслийн төлөвлөлтийн явцад хууль эрхзүйн шаардлагыг хангаж, оролцогч талуудын саналыг харгалзан үзсэн, одоогийн байгаа мэдээ баримтын эх сурвалж, шинжээчдийг тодорхойлсон зэргийг баталгаажуулах үүднээс үнэлгээний үйл ажиллагааны явцын турш үргэлжилнэ.

**Суурь мэдээлэл цуглуулах**

Бүлэг 6-д тайлбарласнаар, төслийн талбай, ойр орчмын бүсийн өнөөгийн төлөв байдал ба хууль эрхзүйн шаардлагуудыг тогтоож, хянаж үзэх, болзошгүй нөлөөлөлд өртөгч тал ба байгалийн нөөцийг тодруулна.

**Нөлөөллийн үнэлгээ ба нөлөөллийг бууруулах**


Үнэлгээний тодорхой шалгуурын дагуу тодорхойлсон нөлөөлөлд өртөгч болон байгалийн нөөцөд үзүүлж болзошгүй нөлөөллийн зэрэг, эрчмийг урьдчилан тооцож үнэлэх; урьдчилж таамагласан аливаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах буюу нөхөн төлөх болон эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг боловсруулж танилцуулах, мөн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авсны дараах үлдэгдэл нөлөөллийн эрчмийн талаар мэдээлнэ. Энэхүү үе шатыг Бүлэг 7-д тайлбарласан.

**Нэгтгэл**

Менежментийн төлөвлөгөөний хүрээнд тодорхой хугацаа, хариуцлагын дагуу хэрэгжүүлэх үүрэг даалгавар болгон ашиглах нөлөөллийг бууруулах арга хэмжээг Төсөлд нэгтгэх зохион байгуулалттай арга зүйг боловсруулна.

**Тайлагналт**

Техникийн бус хураангуйг багтаасан нөлөөллийн үнэлгээний үр дүнг танилцуулна.



**Зураг Х 1.1 Гацууртын төслийн байршлийн зураг**



## **НИЙГМИЙН СУДАЛГААГААР ТОДОРХОЙЛСОН ГОЛ АСУУДЛУУД**

### **ХҮН АМ ЗҮЙ**

Хүн амзүйн тухай энэ бүлэгт төслийн нөлөөллийн бүсийн хүн амын гол үзүүлэлт, нас хүйсийн харьцаа, хот хөдөөгийн хүн амын динамик, шилжилт хөдөлгөөн, боловсрол, бичиг үсэг тайлагдсан байдал, яс үндэс болон шашин шүтлэг зэрэг хүн амзүйн асуудлуудын талаар тайлбарлав. Нийгмийн суурь судалгааны явцад тодорхойлсон хүн амзүйн гол сэдвүүдэд:

- Шилжилт хөдөлгөөний асуудлаар сумын албан тушаалтнуудтай хийсэн ярилцлагын явцад Сэлэнгэ аймагт гаднаас шилжин иргэдийн тоо буурсан явдал нь бэлчээр ашиглалтын бэрхшээл, бэлчээрийн даац хэтэрснээс үүдэлтэй газрын талхлагдал зэргээс болж шилжин ирэгсдийн сонирхол буурч байгаатай холбоотой гэж байв. Статистикийн мэдээлэл (шилжилт хөдөлгөөний бууралтыг харуулсан) болон албаны хүмүүсийн санал бодлоос эсрэгээр гаднаас шилжин ирсэн малчдын тоо нэмэгдэж байгаа гэж ЗБХ-т оролцогчид илэрхийлсэн байна. Тиймээс бодит байдал дээр шилжин ирэгсдийн тоо буурч байгаа хэдий ч бэлчээрийн доройтол, газар ашиглалтын маргааны гол эх сурвалж болсон гаднаас шилжин ирэх малчдын тоо ихэссэн гэсэн ойлголт хүмүүсийн дунд байсаар байна.
- 20 – 24 насны залуучууд ихтэй Мандал суманд тулгарч буй гол бэрхшээл нь залуучуудад зориулсан техник мэргэжлийн, боловсрол, эдийн засгийн боломж бүрдүүлэх, ажлын байраар хангах явдал юм. Бага насны хүүхдүүд ихтэй Баянгол сумын гол бэрхшээл нь цэцэрлэг, бага, дунд сургууль, эмнэлэгийн анхан шатны үйлчилгээ зэрэг шаардлага хангасан байгууламжаар хангах явдал юм.
- Баянгол ба Мандал суманд нэмэгдэж буй салалтын түвшинтэй холбоотой үүсэх гол эрсдэл нь өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо нэмэгдэж байгаа явдал юм. Статистикийн мэдээнээс үзэхэд Мандал сумын өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо 2012 онд 134 байснаас 2013 онд 167 болж 33 өрхөөр нэмэгдсэн байна. Энэхүү хандлага нь багийн түвшинд мөн ажиглагдаж байгаа бөгөөд Түнхэл багт мөн энэ хугацаанд 11 өрх толгойлсон эмэгтэйгээр нэмэгдсэн байна.
- Боловсрол эзэмшээгүй хүн амын ихээхэн хувь (11%) нь Түнхэл багт байгаа нь харагдсан. Түнхэл багийн боловсролын ерөнхий түвшин Мандал, Баянгол сумд болон Хэрх багийн боловсролын түвшнээс доогуур байгаа нь тус багийн хувьд хамгийн гол асуудал юм. Боловсролын хүртээмж тааруу байгаа байдал нь үр хүүхдийн амьдралд төдийгүй ядуурлыг буруулах, хувь хүний болон эдийн засгийн хөгжилд муугаар нөлөөлөх зэрэг урт хугацааны уршигтай. Түнхэл багийн иргэд боловсролын түвшнээр доогуур байгаа учир эдийн засгийн болоод хөдөлмөр эрхлэлтийн аливаа боломжуудыг хүртэх чадвараар дутмаг байж болох юм.
- 2010 оны 12 дугаар сард Монгол Улсын Ерөнхий сайд “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам” -ыг баталсан. Энэ журамд бичил уурхайн үйл ажиллагаатай холбоотой үүсэх газар ашиглалтын аливаа маргааныг зохицуулах бүрэн эрх нь орон нутгийн удирдлага байгууллагад холбогдох оролцогч талуудтай гэрээ байгуулах замаар хадгалагдана гэж заасан байдаг. Гурван тал гэрээг ашиглалтын тусгай зөвшөөрөл

эзэмшигч, холбогдох бичил уурхай эрхлэгч бүлэгтэй байгуулах буюу хоёр талт гэрээг сумын удирдлага ба бичил уурхайн нөхөрлөл хоорон шууд байгуулах боломжтой. Сэлэнгэ аймгийн удирдлага нь бичил уурхай эрхлэгчдийг зохицуулж эхлээд байна. Энэ нь уул уурхай зонхилсон сумдад бичил уурхай эрхлэгчдийн нөхөрлөл байгуулагдахад хүргэсэн байна. Нийгэм, эдийн засгийн суурь судалгааг явуулж байх үед Мандал сумын өрхүүдийн 60% нь буюу 4,228 айл өрх бичил уурхай эрхэлдэг бөгөөд 228 орчим сумын иргэд 30 албан ёсны бүртгэлтэй бичил уурхайн нөхөрлөлийн гишүүн байв (30-аас 100 гишүүнтэй 3 том төрийн бус байгууллага ба 3-10 гишүүдтэй 27 жижиг нөхөрлөлүүд). Гацууртын төслийн бичил уурхай эрхлэгчидтэй холбоотой нэмэлт нэхцөл байдал, дүн шинжилгээ Хавсралт В-ээс харна уу.<sup>1</sup>

## НИЙГМИЙН БҮТЭЦ

Энэ бүлэгт нийгмийн бүтцийн өөрчлөлт, хандлага, өнөөгийн нөхцөл байдал зэрэг нийгмийн бүтцийн улсын дундаж үзүүлэлтийг Сэлэнгэ аймаг, Мандал, Баянгол сумд ба Түнхэл багийн үзүүлэлтүүдтэй харьцуулсан байна. Энэхүү тайлан нь нийгмийн хөгжил, улс төрийн түүх, иргэдийн нийгэм – улс төрийн оролцоо, сонгогдсон улс төрчдийн үнэлгээ, шийдвэр гаргах албан ба албан бус үйл явц, нийгмийн байгууллагуудын өнөөгийн байр суурь зэрэг сэдвүүдийг тусгайлан авч үзсэн. Нийгмийн бүтцийн талаар судлах явцад дараах гол асуудлуудыг тодорхойлсон байна:

- Төр захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд сэтгэл хангалуун биш байдаг учраас иргэдийн төрийн байгууллагуудад итгэх итгэл бага байв. Судалгаанд хамрагдсан хоёр суманд сумын ЗДТГ, ИТХ –д итгэх итгэлийн түвшин өндөр ч улс төрийн намууд, ТББ-уудад итгэх итгэл бага байна.
- Багийн иргэдийн дуу хоолой ямар ч шийдвэрт нөлөөлдөггүй, ИТХ-аас иргэддээ мэдээлэл муу хүрдэгийн улмаас иргэдийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох оролцоог хязгаарладаг гэсэн ойлголт бүхий бэрхшээлүүдтэй төслийн бүсийн багууд тулгараад байна.
- Иргэний нийгмийн байгууллагуудад (ИНБ) гол тулгардаг бэрхшээл нь үйл ажиллагаа явуулах өөрийн оффис/ажлын байр дутагдалтай, иргэдийн оролцоо дутмаг, ажилтнуудын чадавхи сул, санхүүжилт хангалтгүй зэрэг байдаг. Энэ нь ихэнхи байгууллагуудыг эрх мэдэл багатай учраас үйл ажиллагаагаа бусдад хүргэх, санхүүжилтээ зохицуулах буюу байгууллагаа үр дүнтэй хөгжүүлэх чадавхи байхгүйгээс амжилттай үйл ажиллагаа явуулж чадахгүйд хүргэдэг.

<sup>1</sup> Гацууртын төслийн нийгмийн суурь судалгааг 2015 оны 4 – 5 саруудад хийсэн үеийг БУ эрхлэгчид өөр хэлбэрээр 2015 оны 9-р сард гарч ирсэнтэй харьцуулахад бичил уурхайн нөхцөл байдал өөрчлөгдсөн байна. Иймд, бичил уурхайтай холбоотой асуудлыг тусад нь (Хавсралт В) нөхцөл байдал /суурь мэдээлэл, нөлөөлөлд дүн шинжилгээ хийх замаар энэхүү асуудлыг үр дүнтэй шийдэх менежментийн арга хэмжээ, компанийн үүрэг хариуцлагыг тодорхойлно. Менежментийн арга хэмжээнүүдийг Гацууртын төслийн Нийгмийн менежментийн төлөвлөгөөнд бас оруулсан байгаа.

- Түнхэл багийн гол асуудал нь багаа сумын статустай болгож өөрчлөх хүсэл юм. Түнхэл баг нь Монголын олон сумдын хүн амаас их буюу ойролцоогоор 3500 хүн амтай байгаа нь энэхүү өөрчлөлтийг хийхийг хүссэн гол шалтгаан юм. Түнхэл нь сум болбол (Гацууртын төслөөс олох байгалийн баялгийн орлогын боломжит хуваарилалт) төсвийн орлогын талаас ач холбогдолтой байх болно. Сумын хувьд Түнхэл төсвийн томоохон хувийг хүлээн авах болно. Багуудад төсвийн хуваарилалт, зарцуулалтын ямар ч эрх мэдэл байхгүй ба Түнхэл баг нь сум болбол бие даасан байдалтай болох юм. Түнхэл багийн ИТХ нь сум болох оролдлогыг дэмжсэн санал өгсөн боловч энэ хүсэлт нь сумын ИТХ түвшинд буцаагдсан ба энэ шатанд ямар нэгэн ахиц гаргаагүй байна.
- Төслийн бүс нутагт уламжлалт хүйсийн үүрэг давамгайлж байгаа хэдий ч эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засгийн үүрэг, хувь нэмэр өсөн нэмэгдэж байна. Мандал сумын оролцогчид уламжлал ёсоор эмэгтэйчүүд давамгайлж байдаг гэр ахуйн ажилд (өөрөөр хэлбэл хүүхэд, өндөр настан, өвчтэй хүмүүсийг асрах, угаалга хийх, дэлгүүр явах, хоол хийх гэх зэрэг) эрэгтэйчүүд оролцоход илүү нээлттэй хандаж байна. Харин эсрэгээрээ Баянгол сумын судалгаанд оролцогчдын ихэнх нь дээр дурьдсан гэр ахуйн ажлыг эрэгтэйчүүд/нөхрүүд хийхэд тохиромжтой биш гэж үзсэн. Энэ хоёр сумдын иргэдийн санаа бодлын ялгаатай хандлага нь магадгүй Мандал суманд илүү суурин хүн ам байдаг учир жендэрийн үүрэг хатуу тогтсон бус шинэлэг нөлөөлөлд нээлттэй байгаатай холбоотой байж болох юм.
- Мандал сумын судалгаанд оролцогчдын 62.8% нь, Баянгол сумын судалгаанд оролцогчдын 60.6% нь суманд хэрэгжиж буй халамжийн төсөл, хөтөлбөрийн талаар мэдээлэлгүй байна. Мандал, Баянгол сумдын судалгаанд оролцогчдын ойролцоогоор дөрөвний нэг нь Засгийн газраас хэрэгжүүлж буй "малжуулах хөтөлбөр"-ийн талаар мэдээлэлтэй байсан.
- Мандал сумын нийт судалгаанд оролцогчдын 50.6% нь өөр аймаг, сумдаас ирсэн шилжин ирэгсэдэд эерэг ханддаг гэж хариулсан бол Баянгол сумын хувьд судалгаанд оролцогчдын 44.1% нь шилжин ирэгсэд, гадныханд таагүй ханддаг гэж хариулсан байна. Судалгаанд оролцогчдын эерэгээр хариулсан шалтгааныг нь тодруулахад судалгаанд оролцогчид сумын хүн ам нэмэгдэнэ, гадныхан орон нутагт их зүйлийг хийдэг, мөн шинэ хүмүүстэй танилцана гэж дурдсан байна. Таагүй ханддаг шалтгааныг тодруулахад бэлчээр, ус зэрэг байгалийн нөөцийн хомсдол үүсэх, гадныхан аюултай байдаг, орон нутагт ажлын байр багасна гэж хариулсан байна.

## **ЭДИЙН ЗАСАГ**

Энэ бүлэгт Сэлэнгэ аймаг, Мандал ба Баянгол сумдын орон нутгийн эдийн засгийн асуудлууд болох орон нутгийн төсөв, үнэ ханш, эдийн засгийн салбарыг бүрдүүлэгч хөдөө аж ахуй, аж үйлдвэр, уул уурхай, мал аж ахуй зэргийн хөгжил, мөн хөгжиж буй зах зээл, амьжиргаа, өрхийн орлогын талаар дэлгэрэгүй өгүүлэх болно.

Анхдагч болон хоёрдогч эх сурвалжийн мэдээлэл дээр дүн шинжилгээ хийх явцад гарч ирсэн гол асуудлуудад:

- Бараа бүтээгдэхүүний үнэ огцом нэмэгдсэн нь өрхийн гол асуудлын нэг болсон хэмээн судалгаанд оролцсон өрхийн 85% гаруй нь хариулсан байна. Түүнчлэн, бараа бүтээгдэхүүний чанар муу, зах зээлийн өргөн сонголтгүй зэрэг нь өрхийн хувьд нэмэлт бэрхшээл болдог. Ялангуяа, аймаг, сумын төвөөс нилээд алслагдмал орших Түнхэл багийн хувьд энэхүү асуудал нь илүү ажиглагддаг.
- Төслийн бүсийн өрх айлууд өндөр ургац авч илүү ашигтай газар тариалан, үр дүнтэй ногооны ферм эрхлэхэд шаардлагатай мэргэжлийн туслалцаа, технологи, мэдлэг дутагдалтай, хязгаарлагдмал байдагт сэтгэл гонсгор явдаг байна.
- Сэлэнгэ аймгийн нийт малын 3.4% нь малын индексжүүлсэн даатгалд хамрагдсан бөгөөд нийт мал бүхий өрхийн 4.7% нь даатгалд хамрагдсан нь даатгалд хамрагдалт хангалтгүй байгааг илтгэж байна. Сэлэнгэ аймагт малын даатгалд бага хамрагддаг шалтгаан нь Монголын бусад аймгуудтай харьцуулахад Сэлэнгэ аймаг бэлчээр сайтай тул ерөнхийдөө малынхаа төлөө санаа зовох шаардлаггүй (зуд<sup>2</sup> мэтийн байгалийн аюул) гэсэн ойлголт малчдын дунд өргөн тархсан байдаг. Ерөнхийдөө, даатгал ба түүний үр өгөөжийн талаар мэдлэг багатай (зуд, гал түймэр, ган гачиг, байгалийн гамшиг г.м.) байдаг байна.
- Өрхийн судалгаанд оролцогчдын уул уурхайн компанийн нийгмийн хариуцлагын түвшний тал дээрх санал бодол ялгаатай байв. Мандал сумаас илүүтэйгээр Баянгол сумын судалгаанд оролцогчид уул уурхайн салбар хөгжсөнөөр илүү цалинтай болж амьжиргаа дээшилнэ гэдэгтэй санал нийлж байна. Суурин газрын болон малчин айл өрхийн өгсөн хариултыг харьцуулахад нэг их ялгаа байгаагүй (ойролцоогоор тэн хагас нь дээрх мэдэгдэлтэй санал нийлж байна). Эдгээр хариултууд нь уул уурхайгаас үзүүлж болзошгүй ашиг болон нөлөөллийн талаар орон нутгийн түвшинд мэдлэг багатай байгааг нотлож байна. Мөн төслийн талбайд олон тооны “аялдан дагалдагч” буюу санал бодол, үзэл баримтлал нь байнга өөрчлөгддөг хэсэг бүлэг хүмүүс байдгийг харуулж байна.
- Төслийн бүс нутагт зээлээс хамааралтай амьдарч байгаа айл өрхийн тоо нэмэгдэж байна, мөн зээлээ эргэн төлөхдөө бэрхшээлтэй учирч байна. Аймгийн хэмжээнд бага хуримтлал, хадгаламжийн түвшинд байгаа нь энэхүү хандлагыг бий болгож байна.

## **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ**

Тайлангийн энэ бүлэгт ажиллах хүч, хөдөлмөрийн оролцоо, ажил эрхлэлт болон ажилгүйдэл, гол салбарын ажиллагсад, ажиллах нөхцөл болон цалин орлого зэрэг төслийн бүс нутгийн ажил эрхлэлтийн талаар авч үзнэ.

Хөдөлмөр эрхлэлтэй холбоотой дараах зарим гол асуудлууд байна:

---

<sup>2</sup> Хатуу ширүүн өвлийн цаг агаарын байдал



- Сэлэнгэ аймагт 2012 оноос хойш хөдөлмөр эрхлэлтийн түвшин тогтмол буурч иржээ. Энэ түвшин 2012 онд 94% -аас 2013 онд 91% цаашлаад 2014 онд 89.8% хүрч бууржээ. Төрийн албан дах хөдөлмөр эрхлэлт тогтмол өссөөр ирсэн бөгөөд Монгол Улсын эдийн засгийн ерөнхий хямралтай холбоотойгоор хувийн хэвшилд хөдөлмөр эрхлэх нь буурсан. Хувийн хэвшилд хөдөлмөр эрхлэх нь хамгийн түгээмэл бөгөөд энд үйл ажиллагаа явуулдаг томоохон аж үйлдвэрүүд болох нэрэх үйлдвэр, хөдөө аж ахуйн ба газар тариалангийн үйл ажиллагаагаар илэрдэг.
- Өрхийн судалгаанаас үзэхэд нийт оролцогчдийн 51.6 % нь орлого олох ямар нэгэн ажил эрхэлдэг бол Баянгол сумын хэмжээнд энэ тоо нь 43.3% байгаа бол Мандал сумын хувьд 56.7% байна. Түнхэл ба Хэрх багийн нийт оролцогчдийн 50%-аас илүү хувь нь орлого олох албан ба албан бус ажил эрхэлдэг байна. Сумын мэдээнд шинжилгээ хийж үзэхэд Баянгол суманд нийт оролцогчдийн 67.5% нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг бол 21.4% нь хувийн хэвшилд ажиллаж үлдсэн 10.3% нь төрийн байгууллагуудад ажилладаг байна. Харин Мандал сумын хувьд 38.9% нь хувиараа хөдөлмөр эрхэлж, 38.9% нь хувийн хэвшилд ажиллаж үлдсэн 17.2% нь төрийн байгууллага буюу төрийн албанд ажилладаг байна.
- Сэлэнгэ аймагт шинэ ажлын байрны боломж 2013-2014 оны хооронд 8.2%-иар буурчээ. Энэхүү чиг хандлага нь Мандал суманд 3.3%-иар буурсан ба харин энэ хугацаанд Баянгол суманд шинэ ажлын байрны тоо 17.7%-иар (93 шинэ ажлын байр) нэмэгдсэн байна. Харин фокус бүлгийн хэлэлцүүлэгт оролцогчид Баянгол сумаас Мандал суманд илүү ажлын байрны боломж бий болж байгаа гэж тодорхойлж байсан. Энэ нь Мандал сум эдийн засгийн хувьд харьцангуй илүү идэвхитэй бүс тул Баянгол сумаас илүү эдийн засгийн боломж бий болж буй гэсэн ойлголттой холбоотой юм.
- Төслийн бүс нутагт ажилгүйдэл чухал асуудал болоод байна (2012 оноос 2014 оны хооронд Сэлэнгэ аймагт 67.4%-аар өссөн). Сэлэнгэ аймагт залуучуудын дунд тэр дундаа ихэнхи боловсролтой залуучуудад ажилгүйдэл бол гол асуудал болж байна. Залуучуудын ажилгүйдэл болон боломж хомс байгаа байдал нь Түнхэл багийн иргэдийн хамгийн том асуудал юм.
- Төслийн бүс нутагт ажилгүйдлийн түвшин өндөр байгаа нь мэргэжлээрээ ажиллах боломж хомс байгаатай холбоотой. Гол оролцогч талуудтай хийх ярилцлага болон зорилтот бүлгийн хэлэлцүүлгийн оролцогчид бэлэн байгаа ажлын байрны ихэнх нь түр зуурын болон/буюу улирлын чанартай байдаг учраас хүмүүс баталгаатай орлоготой байх боломжгүй байдаг гэж тодорхойлж байсан.
- Хөдөлмөр эрхлэлтийн хувьд авч үзвэл Мандал суманд худалдаа үйлчилгээний буюу хөдөө аж ахуйн салбарт илүү ажиллах магадлал их байгаа бол Баянгол сумын ихэнх хүмүүс бүрэн дунд боловсролтой бөгөөд мал аж ахуй салбарт түлхүү ажиллаж байна.

- Төслийн бүс нутагт өрхийн эрсдэлээ удирдах чухал арга зам нь орлогоо төрөлжүүлэх стратеги юм. Ихэнх өрхүүд орлогоо нэмэгдүүлэх, гэр бүлээ тэжээхийн тулд олон төрлийн үйл ажиллагааг эрхэлж байгаа нь харагдсан. Малчдын хувьд уул уурхайн (болон бусад) салбарт ажиллахад шаардагдах Англи хэлний ур чадвар, салбарын туршлага болон бусад ур чадвар дутмаг учраас мал аж ахуйгаас гадна өөр ажлыг хийж чадахгүй гэдгээ мэдэрдэг гэж тайлбарлаж байсан.
- Төслийн бүс нутагт сарын дундаж цалин Түнхэл багт хамгийн бага байгаа ба мөн адил хүн амынх нь боловсрол бага байна.

## **НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ**

Нийгмийн суурь судалгааны тайлангийн энэ бүлэгт төслийн бүсийн нийгмийн дэд бүтэц, тэдгээрийн бүтээн байгуулалт, өнөөгийн байдал, дэд бүтцийн хангамж, хэрэглээ, ашиглагдаж буй дэд бүтцийн хүрэлцээ зэргийг танилцуулж байна. Сэдвийн агуулгын хүрээнд Сэлэнгэ аймгийн судалгаанд оролцсон сум, багийн боловсрол, эрчим хүч, усан хангамж, бохир усны менежмент, хог Хаягдлын менежмент, тээврийн дэд бүтэц, харилцаа холбоо, шуудангийн үйлчилгээ зэргийг илүү дэлгэрэнгүй авч үзэх болно. Дараах гол асуудлуудыг судалгааны явцад гаргаж ирсэн.

- Мандал болон Баянгол сумдын аль алинд нь цэцэрлэгийн ирцийн түвшин ойролцоогоор 87%-тай байгаа ба хүүхдүүдийн үлдсэн 13% нь цэцэрлэгийн хүчин чадлаас хамааран цэцэрлэгийн үйл ажиллагаанд оролцож чадахгүй байна.
- 2014-2015 оны хичээлийн жилийн байдлаар дунд ангиас (9-р анги) ахлах ангид (10-р анги) шилжигсдийн хувь буурсан байна. Энэхүү шилжилтийн үед эмэгтэй суралцагсдын хувь эрэгтэй сурагцагсдын хувиас илүү их байна. Цаашид боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх боломжинд жендэрийн энэ ялгаатай байдал нөлөө үзүүлэхүйц үзүүлэлт болох юм. Дунд ангид эмэгтэй сурагцагчид илүү сурч байгаа нь эмэгтэйчүүд цаашид илүү боловсрол (дээд болон мэргэжлийн) олж авах, илүү дээр ажилд орох, мөн орлого олох боломжтой болж болох юм.
- Төслийн бүс нутагт техник мэргэжлийн боловсролын сургалтын хүрэлцээ хомс ба үйл ажиллагаа явуулж байгаа сургалтын төв нь уламжлал ёсоор эрэгтэйчүүдийн мэргэжлийн чиглэлийн сургалтуудыг ихэвчлэн эрэгтэй оюутнуудад явуулдаг. Аймгийн хэмжээнд Мандал суманд нэг мэргэжлийн сургалтын төв байна. Энэхүү техник мэргэжлийн сургууль нь барилгын салбарын мэргэжлүүдэд илүүтэй анхаарал хандуулсан байгаа ба эдгээр нь илүү эрэгтэй давамгайлсан мэргэжлүүд юм. Эмэгтэй оюутнуудын ихэнх нь тогооч, оёдолчин, үсчин, барилгын засал чимэглэгч, фермерийн аж ахуй эрхлэгчээр суралцдаг бол эрэгтэй оюутнууд голдуу ерөнхий механикч, хүнд ачааны машины механикч, өрлөгчин, гагнуурчин, сантехникч зэрэг мэргэжлээр суралцаж байна.

- Төслийн бүс нутгийн ундны усны гол эх үүсвэр нь худаг<sup>3</sup>, гол горхи, булаг, зөөврийн ус түгээх цэг зэрэг байна. Өрхийн ундны усны хангамж нь хэрэглэгчдийн ангилал хооронд ерөнхийдөө их төстэй (малчид/суурин өрх, сум/баг буюу хөдөөгийн өрх) бөгөөд ихэнх айл өрхүүдийн гол эх үүсвэр болсон хамгаалагдсан худгыг ашигладаг. Баянгол сумын эх үүсвэр болсон хамгаалалтгүй худгаас ус авч ашиглах нь Мандал сумаас илүү байна (хамгаалалттай худагаас бохирдлын эрсдэл өндөр).
- Сумдын төвд оршин суудаг айл өрхийн дийлэнх нь төвийн эрчим хүчний системээс эрчим хүч хэрэглэж байгаа ба Мандал сумын судалгаанд хамрагдсан өрхийн 21.5% нь, Баянгол сумын судалгаанд хамрагдсан өрхийн 39.9% нь сэргээгдэх эрчим хүч ашигладаг гэсэн байна. Нарны эрчим хүчний төхөөрөмжийг судалгаанд хамрагдсан газар нутагт ялангуяа малчид, Баянгол сумын иргэд нилээд хэрэглэж байна. Түнхэл багийг бусад багуудтай харьцуулахад орон нутгийн төвлөрсөн буюу дизель системийг илүү хэрэглэдэг байна. Мандал сумын судалгаанд хамрагдсан өрхийн 19.5% нь орон нутгийн төвлөрсөн буюу дизель системийг гол эрчим хүчний эх үүсвэрээ гэж хариулсан ба энэ нь зөвхөн аравдугаар сараас дөрөвдүгээр сарын хооронд ажилладаг байна.
- Дулаан хангамж нь Монголд чухал хэрэгцээтэй суурь үйлчилгээ боловч энэ нь хүн бүрт ялангуяа Мандал ба Баянгол сумын хөдөө орон нутгийн гэр сууцанд амьдардаг иргэдэд хүртээмжтэй биш байна. Сумдын одоогийн дулааны систем нь голдуу (а) жижиг зуух; ба (б) төвлөрсөн болон төвлөрсөн бус нүүрсээр галладаг зуухнаас<sup>4</sup> бүрддэг. Энэ нь сургууль, дотуур байр, эмнэлэг, орон нутгийн засаг захиргааны барилга, зарим орон сууцыг галлахад ашигладаг. Галлагаатай өрхийн дийлэнх нь халаалтын төвлөрсөн сүлжээнээс ангид байдаг.
- Төслийн бүс нутаг болох Мандал, Баянгол сумдын аль алинд нь олон хүн радианоос илүүтэйгээр телевизор ашигладаг байна. Энэ нь орон нутгийн иргэд телевизороос үндсэндээ мэдээ мэдээлэл, зугаа цэнгэлийн талаар хүлээн авдаг бөгөөд төслийн талбай орчим орон нутгийн иргэдтэй харилцах хамгийн үр дүнтэй арга нь энэ байж болохыг харуулж байна.
- Сэлэнгэ аймгийн нийтийн тээврийн үйлчилгээнд авто болон төмөр замын тээвэр гэсэн хоёр хэлбэр ашиглагдаж байна. Сэлэнгэ аймгийн иргэдийн өргөн хэрэглэдэг нийтийн тээвэр бол галт тэрэг юм. Төмөр зам нь Баянгол, Мандал сумдын төвөөс гадна Түнхэл багаар дамжин Улаанбаатар хот болон Сэлэнгэ аймаг хооронд зорчигч тээврийн үйлчилгээг хүргэдэг.

## ГАЗАР АШИГЛАЛТ БА БАЙГАЛИЙН НӨӨЦ

Энэхүү бүлэгт төслийн ойролцоох талбайн газар эзэмшил, өмчлөл, ашиглалт болон байгалийн баялгийн ашиглалттай холбоотой асуудлууд тусгагдсан ба эдгээр асуудлуудыг аймгийн хэмжээнд болон Мандал, Баянгол сумдын хэмжээнд ялангуяа Түнхэл багийн айл өрхүүдийн хувьд голчлон авч үзэх болно.

<sup>3</sup> Хамгаалагдсан болон хамгаалагдаагүй худаг. Хамгаалагдсан худаг нь хүн, амьтаны улмаас үүсэх бохирдлоос хамгаалагдсан худгийг хэлнэ (жишээлбэл: тагтай).

<sup>4</sup> Төвийн системд холбогдоогүй нүүрсэн галлагаат уурын зуух нь сум/багийн төв дээр байрлах бөгөөд, төвийн системд холбогдсон нүүрсэн галлагаат уурын зуух нь Улаанбаатар болон томоохон хотуудад байдаг (Эрдэнэт, Дархан).

Газар ашиглалт ба байгалийн нөөцийн талаар судлах явцад гарсан гол асуудлууд:

- Сэлэнгэ аймгийн хамгийн гол асуудал нь бэлчээрийн даац хэтэрсэн явдал юм. Бэлчээр талхлагдах асуудлын гол шалтгаан нь малчид болон мал бүхий иргэд малын тоо толгойгоо нэмэгдүүлсэнтэй холбоотой (2011-2014 оны хооронд малын тоо толгой ойролцоогоор 14%-иар өссөн). Мандал суманд малын тоо толгой 2013 оны байдлаар 5% өссөн бол 2014 онд Баянгол суманд 9% (албан бус мэдээнээс үзэхэд Мандал суманд 2014 онд мөн адил өссөн байна) өсөн байна. ЗБХ-ийн үеэр бэлчээрийн даац хэтэрсэн шалтгааныг шилжин ирэгсэдтэй ерөнхийдөө холбон тайлбарлаж байгаа хандлага ажиглагдсан ч шилжин ирэгсдийн тоо харьцангуй бага байгаа, эсрэгээрээ уугуул малчдын малын тоо ихээр өссөн нөхцөл байдлыг тооцон үзвэл бэлчээр талхлагдах асуудлыг шилжин ирэгсэдтэй холбон тайлбарлах нь өрөөсгөл ойлголт юм.
- Мандал болон Баянгол сумдад бэлчээрийн даац хэтэрснээс тухайн бүс нутгийн зарим хэсэгт малчдын хооронд, мөн малчид, тариаланчдын хооронд газрын маргаан үүсэх шалтгаан болоод байна. Бэлчээрийн газрын маргаан гарах давтамж нь өөр өөр байгаа ба судалгаанд оролцогчдын гуравны нэг нь сар бүр газрын маргаан гардаг талаар мэдээлж байв. Мандал суманд бэлчээр ашиглалттай холбоотой газрын маргаан хамгийн их гарч байгаа нь Баянгол сумтай харьцуулахад тухайн суманд бэлчээрийн талбай харьцангуй бага, улмаар энэ нь бэлчээрийн даац хэтрэхэд хүргэсэнтэй холбоотой юм. Малчин өрхийн 30% гаруй нь улирлын чанартай тариалангийн болон хадлангийн ажлын улмаас маргаан үүсдэг гэж хариулжээ.
- Малчдын ихэнх нь өвөлжөө, хаваржааны газраа эзэмшдэг ч тэр бүр газар эзэмших эрхийн гэрчилгээгээ аваагүй, улмаар газрын төлбөр төлдөггүй байна. Энэ нь газрын төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн хэмжээнд сөргөөр нөлөөлөх юм. Учир нь холбогдох журмын дагуу газрын төлбөрийн орлогын 15%-ийг байгаль хамгаалалд зарцуулахаар заасан ба газар эзэмших эрхээ бүртгүүлэн газрын төлбөрөө төлөхгүй байгаа нь энэ зориулалтаар зарцуулагдах орлого багасахад нөлөөлж байна.
- Судалгаанд оролцогчдын ихэнх нь ус ашиглалтын талаар орон нутгийнхны дунд маргаан гардаггүй талаар мэдэгдэж байв. Ус ашиглалтын талаар маргаан бага гардаг, мөн усыг эрх тэгш ашиглах боломжтой зэргээс харвал Төсөл хэрэгжих бүс нутагт усны хүрэлцээтэй холбоотой асуудал байхгүй байгааг харуулж байгаа юм. Энэ нь уул уурхайн төслөөс орон нутгийн усны нөөцийн хүрэлцээ ба чанарт үзүүлж болзошгүй нөлөөлөл нь гол асуудал байв (уурхайн үйл ажиллагаатай холбоотой үүсэх эрсдэлийн тухай санал асуулганд оролцсон хүмүүсийн 50%-аас илүү нь ийм санал илэрхийлсэн). Үнэхээр ч судалгаанд харагдагсдын ихэнх нь (59-74%) одоогийн байдлаар ундны усны чанар хангалттай байгаа гэж хариулсан бол үлдсэн нь ус хэт хатуулагтай тул ундны хэрэгцээнд тохиромжгүй (Баянгол сумын бүх багийн хувьд), мөн уул уурхайн үйл ажиллагааны (Мандал сумын Түнхэл баг) улмаас бохирдсон хэмээн хариулсан. Энэ нь ялангуяа Түнхэл багийн хэмжээнд усны бохирдол нийгмийн хамгийн чухал асуудлуудын нэг болж эхлээд байгаагийн илрэл юм.

## **ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА БА АЮУЛГҮЙ БАЙДАЛ**

Энэ бүлэгт төслийн бүсийн орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал ба аюулгүй ажиллагааны талаарх суурь нөхцөл байдлыг танилцуулах ба эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийн тогтолцоо, гэмт хэрэг болон нийгмийн дэг журмыг (мөн хүний эрхийн асуудлыг оруулан) авч үзнэ. Төслийн бүс нутгийн орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа ба аюулгүй байдлын талаарх гол сэдвүүдэд дараах орно:

- Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж муу байгаа байдал нь төслийн бүс нутгийн гол асуудал байв. Мандал суманд эмч ихээхэн дутагдалтай ч сувилагч харьцангуй их байдаг байхад Баянгол суманд эмч болон сувилагчийн талаар ДЭМБ-аас гаргасан шалгуур үзүүлэлт болон улсын дунджаас хамаагүй бага байгааг харуулж байна.
- Эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотойгоор айл өрхүүд эрүүл мэндийн үйлчилгээ муу, эмнэлэгт очиж үйлчлүүлэх цаг гардаггүй, эмнэлэг хүртэлх зай хол байдаг (чухал байдлаар нь эрэмбэлэв) гэсэн хүндрэлүүдийг дурдаж байв.
- Төслийн бүс нутгийн нас баралтын гол шалтгаан нь зүрх судасны өвчин болон хорт хавдар байна. Энэ нь Монгол Улс дахь нас баралтын түгээмэл шалтгаантай таарч байгаа юм. 2014 оныхтой харьцуулвал аймгийн хэмжээнд халдварт өвчний тоо 6.8%-аар өссөн байгаагаас бэлгийн замын халдварт өвчний тохиолдол нийт халдварын дунд хамгийн дээгүүр орсон байв. Сэлэнгэ аймагт бүртгэгдсэн сүрьеэний тохиолдол улсын хэмжээнд хамгийн өндөр байгаа нь тус аймагт бичил уурхай эрхлэгчид их байгаатай холбоотой байж болзошгүй. Бичил уурхайчд эрхлэгчдын ихэнх нь газар доор битүү хязгаарлагдмал орчинд ажилладаг тул сүрьеэний халдвартай хүмүүс өөр бусад эмзэг, сул биетэй хүмүүст халдвар тараах нөхцөл бүрддэг.
- Түнхэл багт зохион байгуулсан ЗБХ-ийн үеэр оролцогчид шороон замаас үүдэлтэй тоос орон нутгийн иргэдийн эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй асуудлыг хөндсөн ба тоосноос шалтгаалан амьсгалын замын өвчлөл нэмэгдэх магадлалтай талаар дурдаж байв. Түнхэлд амьсгалын замын өвчин их байгааг тодорхойлох бололцоогүй, мөн дээрх амьсгалын замын өвчний эрсдэлийг үнэн хэрэгтээ замын тоосжилттой холбон үзэх боломжгүй юм. Алс хол байрлалтай Түнхэл багийн оршин суугчдын ихэнх нь шороон замаа хатуу хучилттай болгох хүсэлтэй байгаа талаар энд тэмдэглэх нь зүйтэй. Тоос, түүнтэй холбоотой үүсэх эрүүл мэндийн асуудал, нөлөөлөл нь багийн хөгжил, тэр дундаа Гацууртын уурхайн хөгжилтэй холбоотой өргөн хүрээтэй асуудал бөгөөд цогцоор шийдвэрлэх шаардлагатай юм.
- Замын хөдөлгөөний аюулгүй байдал ба тээврийн хэрэгслийн ашиглалтын журмыг зөрчин үйлдсэн гэмт хэргийн улмаас нас барсан хүний тоо 2012-2013 онд 18.9%-аар өссөн бол 2014 оны эхний 10 сарын байдлаар энэ тоо нь 2013 оныхтой харьцуулахад 26.7%-иар нэмэгдсэн байна. Мандал сумын ослын гол шалтгаан нь согтуугаар жолоо барьсан, хурд хэтрүүлсэн, халтиргаатай замд машинаа зогсоож чадаагүй зэрэг тохиолдлууд байгаа бол Баянгол суманд гарсан замын ослын гол шалтгаан нь урсгал сөрсөн, эсвэл хурд хэтрүүлсэн тохиолдлууд байна.

- Гацууртын төслийн замаар зорчиж буй тээврийн хэрэгслийн ихэнх нь хөнгөн тэрэг байгаа ба төслийн талбайд гарч буй зам тээврийн ослын гол шалтгаан нь урсгал сөрөх, хурд хэтрүүлэх, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ машин жолоодох зэрэг эрсдэлээс үүдэлтэй гэж үзлээ. Эдгээр эрсдэл, мөн дээр нь уг замаар олон тооны хүдэр тээвэрлэх ачааны машин зорчих нөхцлийг хамтатган үзвэл замын аюулгүй байдал нь санаа зовоосон, хүндрэлтэй асуудалд тооцогдохоос ч аргагүй юм. Түүнээс гадна Цагдаагийн газрын статистик мэдээнд харуулснаар Сэлэнгэ аймагт гарч буй ихэнх гэмт хэрэг нь замын хөдөлгөөний аюулгүй ажиллагаа, тээврийн хэрэгсэлтэй холбоотой байв. Гацууртын төслийн хүрээнд хүдэр тээвэрлэх том оврын тээврийн хэрэгслийн асуудлыг тооцон үзэлгүйгээр одоогийн замын хөдөлгөөн, тээврийн хэрэгсэлтэй холбоотой гэмт хэрэг, олон нийтийн аюулгүй ажиллагаа нь дангаараа л төслийн талбайн хувьд ихээхэн хүндрэлтэй асуудал болоод байна. Төслийн талбай дахь замын хөдөлгөөний эрсдэлийг бууруулах, аюулгүй ажиллагаатай холбоотой олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх талаар төрийн байгууллагаас аливаа хөтөлбөр хэрэгжүүлж байгаа эсэх мэдээллийг авах боломжгүй байлаа. Бороогийн төслөөс өнгөрсөн онд замын аюулгүй байдлын талаар компанит ажил зохион байгуулсан байна.
- Мандал сумын ГТХЯ-ын үеэр дурдагдсан гол асуудлын нэг нь Гацууртын төслийн үйл ажиллагааны явцад хүдэр тээвэрлэх ачааны машинаас шалтгаалан Түнхэл багийн замын аюулгүй байдлыг хангах асуудал байсан. Ярилцлагад оролцогчид хүдэр тээвэрлэх замыг сайжруулах, хатуу хучилттай болгох талаар, мөн энэ замаас үүсэж болзошгүй тоосны асуудал, зам дээрх осол зэрэг эрсдэлийн талаар янз бүрийн бодол санаатай байв.
- Архи нь гэмт хэрэг гарах гол нөлөө болж байна. Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 33% нь архи, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ үйлдсэн байгаа талаар 2015 оны 5 дугаар сарын Цагдаагийн газрын мэдээнээс харж болно. Мандал суманд бүртгэгдсэн гэмт хэргийн тал хувь нь (48%) хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг байгаа бол Баянгол суманд гарсан нийт гэмт хэргийн 36% нь замын хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын дүрэм зөрчсөн хэрэг байгааг тус сум Улаанбаатар хот болон ОХУ-ын хилийг холбосон олон улсын замын дагуу байрлаж байгаагаар холбон тайлбарлаж болох юм.



- Орон нутгийн засаг захиргааны байгууллагууд болон цагдаагийн газарт итгэх илтгэл иргэдийн дунд бага байгаа ба сум, баг, өрхийн түвшинд нийт судалгаанд оролцогчдын доод талдаа 60% нь орон нутгийн гэмт хэрэгтэй тэмцэх хүчин чадал "дундаж болон хангалтгүй" байна гэж хариулсан байна. Сум, багийн түвшинд хүний эрхийн эсрэг гэмт хэрэг тэр бүр бүртгэгддэггүй. Энэ нь сумын иргэд хүний эрхийн талаар мэдлэг мэдээлэл бага, хүн бүр эрхээ хэрхэн эдлэх болон зөрчигдсөн үед ямар арга хэмжээ авах ёстойгоо мэддэггүйтэй холбоотой байж болох юм. Суурин газрын судалгаанд оролцогчид хүүхдийн эрх хамгийн ихээр зөрчигдөж түүний дараагаар эмэгтэйчүүдийн эрх зөрчигдөж буйтай санал нийлж байна. Эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл Түнхэл багт судалгаанд хамрагдсан бусад газартай харьцуулахад илүү өндөр гэж тооцогддог. Мандал суманд гарсан гэмт хэргийн мэдээллийг харахад ихэнхи нь орон сууцанд архи уусан үедээ эмэгтэйчүүдийн эсрэг үйлдсэн гэмт хэргүүд байв. Баянгол суманд судалгаанд оролцогчдын 30% нь, харин Мандал суманд 20% нь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг онцолсон ба хүүхдийн хөдөлмөр мал хариулах, бичил уул уурхай эрхлэх буюу модны аж ахуйн компаниудад хөлсний ажил хийх хэлбэрээр явагддаг.

## СОЁЛЫН ӨВ

Энэхүү бүлэгт Гацууртын төслийн бүс нутаг дахь соёлын өвийн суурь нөхцөл байдлыг харуулсан. Суурь судалгаанд багтсан соёлын өвийн төрлүүдэд археологийн ач холбогдол бүхий газрууд, хөшөө дурсгалт газрууд болон соёлын биет бус өвийн үнэт зүйлс орсон болно.

Энэхүү бүлэгт Гацууртын төсөлд зориулан бэлтгэсэн *Соёлын биет бус өвийн судалгааны тайлан*-тай хамтруулан унших хэрэгтэй. Иймд, энэхүү нийгмийн суурь судалгааны тайланд соёлын биет бус өвийн судалгааны тайлангийн гол үр дүнг тусгасан болно.

Соёлын өвийн асуудалтай холбоотой гарч ирсэн гол сэдвүүдэд дараах орно.

- Мандал ба Баянгол сумын судалгаанд оролцогчдын илэрхийлснээр соёлын өвийн тухай мэдээллийн гол эх үүсвэр нь хамаатан садан, гэр бүлийн гишүүд юм. Соёлын өвийн талаарх мэдээллийн хоёр дахь гол эх үүсвэр нь сургууль болон албан бус сургалт юм. Ихэнх хүмүүс гэр бүлээс соёлын өвийн талаар мэдлэг, мэдээллийг олж авч байгаа нь Монгол Улсад баялаг аман түүх уламжлалтай нийцэх боловч орон нутгийн иргэдийн боловсрол, мэдээллийн хэрэгцээг хангах орон нутгийн байгууллагуудын (мэргэжлийн болон материалын аль аль нь) чадавхи дутмаг байгааг илтгэж байна.
- Сэлэнгэ *аймгийн* соёлын өвийн байгууллагуудад орон тооны соёлын өвийн 161 ажиллагсад ажилладаг. *Аймгийн* түвшинд мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байдлаас харахад соёлын төвүүд нь мэргэжлийн үр чадвартай ажилтанаар дутмаг нь ажиглагддаг. Техникийн болон мэргэжлийн сургалтанд хамрагдсан соёлын өвийн мэргэжилтэний хомсдол (ялангуяа дээд мэргэжилтэй) нь зөвхөн Сэлэнгэ *аймагт* бус Монгол Улс даяар тулгарч буй гол асуудал юм.

- Төслийн талбайн орчим байрлах гол биет бүс соёлын өв нь Ноён уулыг (уул) тахиx ёслол юм. Ноён уулын ойр орчим амьдардаг өрхүүд Ноён уулыг социализмын үеэс өмнө тахидаг байсан боловч коммунист дэглэмийн үед (1920-1990-ээд оны үед) уулыг тахиx нь хориотой байсан. Шилжилтийн үед уул нуруудыг тахиx уг санаа дахин сэргэсэн. Ноён ууланд байгаа олон төрлийн овоог<sup>5</sup> тахиx зан үйлийг хийдэг байна. Цаашид бөө удганууд жилд хэд хэдэн удаа тахилга хийхээр уг газарт очдог ба бүс нутагт хийсэн судалгаанаас харахад уг уултай холбоотой хорио цээр, домог байдаг нь тогтоогдсон.
- Төслийн бүсийн эргэн тойронд хийсэн судалгаагаар тухайн газар нутгийн дурсгалууд, газруудыг илрүүлсэн (1925 оноос хойш дундажаар 200 гаруй дурсгалууд олсон). Мандал сумын эргэн тойронд орон нутгийн тусгай хамгаалалттай хоёр газар байгаа нь Зуун Модны гол (гол) болон Ноён уулын газар юм. Мөн улсын хамгаалалттай хоёр газар (Түжийн нарс, Хан хэнтийн улсын тусгай ангилалд хамгаалалттай газар нутаг), мөн 30 орон нутгийн тусгай хамгаалалттай газар байна (төслийн бүтээн байгуулалт эхлэхээс өмнө олон нийтийн хэрэглээнд ашиглагдаж буй Гацууртын уурхайн замыг огтлолцсон хоёр газар нь Зуун Модны гол болон Ноён уул). Эдгээр газрууд хадгалалт, хамгаалалтаас хамааран янз бүрийн байдалтай байна.
- Улсын тусгай хамгаалалтанд авсан Ноён уул нь Гацууртын төслийн уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй бүсийн гадна уурхайн талбайгаас 7км-ийн зайд байрладаг. Гацууртын төслийн уурхайн талбайн байршил нь орон нутгийн иргэдийг Ноён уул руу гарахад нь садаа болохгүй, Ноён уулыг тахиx болон бусад байдлаар ашиглахад нөлөөлөл үзүүлэхгүй юм. Үүнээс гадна, одоогийн нийтийн хэрэглээнд ашиглаж буй зам нь тахилгын газарт саад болохгүй бөгөөд тахилгын газар руу замаас явган хүрч болохоор байгаа.
- Төслийн бүс нутгийн судалгаанд оролцогчид орон нутгийн соёлын өвийн үйл ажиллагаанд дунд зэрэг оролцдог байна. Соёлын өв ач тусаа хэрхэн өгч байна гэж асуухад Хэрх багийн судалгаанд оролцогчдын 42.3% нь, Түнхэл багийн оролцогчдын 36.7% нь "Орон нутгийн соёлын өв суманд ихээхэн ач холбогдолтой" гэж хариулсан. Дунджаар оролцогчдын ихэнх нь соёлын өв ямар ч ач тусаа өгч байгаагүй гэж хариулсан байна. Энэ хариултыг Баянгол сумын оролцогчид илүү хариулж байгаа нь ажиглагдсан ба судалгаанд оролцогчдын талаас илүү хувь (51.1%) нь соёлын өв нь ямар ч ач тусаа өгдөггүй, харин 30.7% нь ач тусаа өгдөг гэж хариулсан байна. Соёлын өвийн ашиг тусыг авч үзэхдээ соёлын өвийн онцлог шинж байдал болон олон нийтийн сэтгэл ханамжийн байдал, мөн түүнчлэн аялал жуулчлал ба жижиг бизнесийн боломжоос орж ирэх орлогоос үүдэлтэй аймаг, сумын нэр хүндийг нэмэгдүүлсэн байдал зэргийг багтаана.

## **ГОЛ ҮР АШИГ, НӨЛӨӨЛӨЛ БОЛОН НӨЛӨӨЛӨЛ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ**

Төслийн нөлөөллийг хэмжиж, үнэлсэний дараа Төсөл болон төслийн нийгмийн харьцаа холбоо, үйл ажиллагаанд нөлөөлөх хүний амь насанд аюул учруулж болзошгүй эрсдэл бүхий томоохон эрсдэлүүдийг дараах байдлаар тодорхойлсон байна :

<sup>5</sup> Овоо гэдэг бол уулын онгон, удган мод, нуур, булаг гэх мэт оюун санааны хувьд ач холбогдолтой байгалийн тогтоцыг тэмдэглэсэн байгууламж юм. Овоо нь орон нутгийн иргэдийн хувьд шүтдэг газар, залбирал үйлдэх мөн байгалийн гамшгийн (гал түймэр, зуд) үед цуглаж, зөвлөлдөх зэрэг олон төрлийн үүрэг гүйцэтгэдэг.



- Шинэ уурхайд ажиллах ажиллагсдын осол, гэмтэл эсвэл амь насанд аюултай байдалд өртөх эрсдэл нэмэгдэх;
- Төслийн бүсийн ажиллагсад, онцгой байдлын ажилтанууд, засгийн газрын агентлаг болон орон нутгийн хүмүүст нөлөөлөх урьдчилан тооцоолоогүй гэнэтийн осол аюулын эрсдэл;
- Гацуурт болон Бороогийн уурхайн байгууламжийг ашиглах явцад орон нутгийн иргэдийн эрүүл мэнд болон аюулгүй байдалд учрах аюул;
- Гацуурт болон Бороогийн уурхай хоорондын нийтийн хэрэглээний зам, мөн төслийн болон нийтийн хэрэглээний зам ашиглах явцад замын хөдөлгөөнөөс үүдэлтэй осол, гэмтэл гарах эсвэл амь насаа алдах эрсдэл.

Эдгээр болзошгүй нөлөөллүүд нь нөлөөлөл бууруулах арга хэмжээ авсаны дараа ч хамгийн ихээр үлдэх болзошгүй нөлөөлөл хэвээр байна.

Энэхүү тайлан боловсруулагдаж дууссаны дараа бичил уурхай эрхлэгчид эгзэгтэй асуудал болж эхэлсэн. Энэхүү асуудалтай холбоотой нэмэлт нөхцөл байдал, дүн шинжилгээ, менежментийн арга хэмжээнүүдийг Хавсралт В-ээс харна уу.

Нөлөөлөл бууруулах арга хэмжээ нь удирдлагын хяналт (тухайлбал, менежментийн төлөвлөгөө, дотоод журмыг боловсруулж, хэрэгжүүлэх), инженерийн хяналт (замын тэмдэг тэмдэглэгээ) болон талуудын оролцоо (мэдээлэл өгөх, зураг төсөл, хамтын шийдэлд хүрэх үйл ажиллагаанд оролцох, хамтран ажиллах боломжийг нь хангах) зэрэг тодорхойлогдсон бүх болзошгүй нөлөөллийг бууруулах олон талт, хосолсон арга хэмжээг санал болгодог. Төслийн бүсэд орон нутгийн тогтвортой хөгжлийн санаачлагыг хэрэгжүүлэх явдлыг дэмжих зэрэг үр ашигтай нөлөөллийг нэмэгдүүлэх боломжууд бас байна.

Төслөөс гарах гол үр ашиг:

- Уурхайн үйл ажиллагааны турш шууд болон шууд бус замаар ажлын байрны боломжууд бий болох;
- Төслийн барилга болон ашиглалтын үе шатанд уурхайн болон ажиллагсдын хэрэгцээ шаардлагыг хангах үйлчилгээ, хангамжаас үүдэн гарах ажлын байр нэмэгдэх;
- Төслийн ашиглалтын үе шатанд орон нутгийн худалдан авалтын үйл ажиллагаанд оролцох боломж нэмэгдэх;
- Төслийн барилга, ашиглалтын үе шатанд татвар, роялти болон бусад төлбөрийн улмаас Улсын болон аймгийн төсөв нэмэгдэх; ба
- Төсөл болон гол оролцогч талуудын түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх орон нутгийн хөгжил тогтвортой болж, бэхжинэ.

Дунд ач холбогдолтой бүхий болзошгүй нөлөөллүүдийн Нөлөөлөл болон бууруулах арга хэмжээний тоймыг доор харуулсан болно. Үүнд: болзошгүй нөлөөлөл, нөлөөлөл буруулах арга хэмжээ, үлдэгдэл нөлөөллийн ач холбогдол, Нийгмийн менежментийн холбогдох төлөвлөгөө, бодлого, журам зэрэг багтана.

**Хүснэгт ES 1.1**

**Нөлөөлөл, нөлөөлөл бууруулах/нэмэгдүүлэх, үлдэгдэл ач холбогдол зэргийн тойм**

Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шинж	Бууруулаагүй үеийн ач холбогдол	Санал болгож буй гол хяналт, нөлөөлөл бууруулах, нэмэгдүүлэх арга хэмжээний тойм	Холбогдох менежментийн төлөвлөгөө & бодлого	Болзошгүй үлдэгдэл ач холбогдол
<b>Хөдөлмөр эрхлэлт (EBRD PR 1, 2)</b>					
Тохирох мэргэжилтэн хангалтгүйн улмаас ажлын байртай холбоотой орон нутгийн иргэдийн хүлээлт биелэгдэхгүй байх эрсдэл	Тодорхой Шууд сөрөг Дунд хугацааны Өргөн хүрээ хамрах	Дунд	<ul style="list-style-type: none"> <li>НМТ-р дамжуулан орон нутгаас давамгайл эрхтэйгээр ажилчин авах бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх.</li> <li>Төслийн бүсэд оршин суух тодорхой хугацаа дээр тулгуурлан орон нутгаас ажилд авах эрхийг бүрдүүлэх.</li> <li>Ажилд авах ажиллагсдын тоо, хугацаа, шаардагдах ур чадварын талаар орон нутгийн иргэдэд ОНХА дамжуулан тогтмол, ойлгомжтой мэдээлж байх.</li> <li>Орон нутгийн иргэдийг ажлаар хангах үүднээс сургалтын байгууллагуудтай хамтран ажиллах, ажлын байрны сургалт явуулах зэрэг ур чадварын сургалтанд хөрөнгө оруула. Төслийн хэрэгцээг хангасан ур чадварыг дэмжих сургалтын төрөл болон сурах шаардлагатай хугацааг хангах үүднээс сургалтын байгууллагуудыг татан оролцуулах.</li> <li>Бороогийн одоогийн/хуучин ажиллагсдыг боломжтой нөхцөлд удирдах албан тушаалд авч ажиллуулах, жишээ нь шинэ ажиллагсдыг сургах гэх мэт.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хөдөлмөр эрхлэлт, сургалтын МТ</li> <li>Туслан гүйцэтгэгчийн МТ</li> <li>Нийгмийн менежмент, хяналт шинжилгээний төлөвлөгөө (НММТ)</li> </ul>	Дунд
<b>Эрүүл мэнд (EBRD PR 1, 4)</b>					
Шинэ уурхайд ажиллах ажиллагсдын осол, гэмтэл эсвэл амь насанд аюултай байдалд өртөх эрсдэл нэмэгдэх	Боломжит Шууд, их сөрөг Богино хугацааны Өргөн цар хүрээтэй	Өндөр	<p>Бороогийн уурхайд хэрэгжүүлж буй арга хэмжээг Гацууртын уурхайд авч хэрэгжүүлэх:</p> <ul style="list-style-type: none"> <li>Ажлын эхний саруудад ажиллагсад болон гэрээт гүйцэтгэгч нарыг зааварчилгаа, сургалт болон удирдамжаар хангаж ажиллуулах, мөн тэдгээрийг давтан сургалтанд тогтмол хамруулах</li> <li>Уурхайн талбай, болзошгүй аюул, мөн ажил хийж гүйцэтгэх хугацаанд гарах аюул, тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд шаардагдах уурхайн арга барилтай танилцаж, сурах сургалтын журам хэрэгжүүлж, ур чадварыг шалгах</li> <li>Шинэ ажил, үйлдвэр, систем тус бүрт эрсдэлийн үнэлгээ хийх</li> <li>Гүйцэтгэгчийн менежментийн шаардлага нь гэрээний хугацаанд зөрчил тус бүрийн хариуд авах арга хэмжээ авах/торгууль тавих зэргээр хөдөлмөр хамгааллын хамгийн доод түвшинг хангасан байх,</li> <li>Гэрээ хийхээс өмнө урьдчилан шалгаж баталгаажуулсан байх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Зааварчилгааны төлөвлөгөө</li> <li>Хөдөлмөр эрхлэлтийн МТ</li> <li>Ажиллагсдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны МТ</li> <li>Туслан гүйцэтгэгчийн МТ</li> <li>Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны хяналт</li> </ul>	Дунд

Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шинж	Бууруулаагүй үеийн ач холбогдол	Санал болгож буй гол хяналт, нөлөөлөл бууруулах, нэмэгдүүлэх арга хэмжээний тойм	Холбогдох менежментийн төлөвлөгөө & бодлого	Болзошгүй үлдэгдэл ач холбогдол
			<ul style="list-style-type: none"> <li>Зааварчилгаа, өдөр тутмын аюулгүй ажиллагааны зааварчилгаа, сар тутмын аюулгүй ажиллагааны гүйцэтгэгчийн удирдлагын уулзалт зэргийг ашиглан гэрээний гүйцэтгэлд хяналт тавих</li> <li>Шинэ материал тус бүр Хор аюулын лавлах мэдээлэлтэй байх, BIOX® байгууламжийн давтан, шинэ сургалтуудыг ажилтнуудад зориулж явуулах, мөн BIOX® байгууламжийн аюулгүй ажиллагааны журам боловсруулах</li> <li>Онцгой байдлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэн тогтмол сургалт явуулах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>шинжилгээний төлөвлөгөө</li> <li>Ажиллах зөвшөөрөл бүхий журмууд</li> </ul>	
Төслийн бүсийн ажиллагсад, онцгой байдлын ажилтанууд, засгийн газрын агентлаг болон орон нутгийн хүмүүст нөлөөлөх урьдчилан тооцоолоогүй гэнэтийн осол аюулын эрсдэл	Боломж бага Шууд, их сөрөг Богино - дунд хугацааны Бага болон дунд хэмжээнд	Өндөр	<p>Бороогийн уурхайд хэрэгжүүлж буй арга хэмжээг Гацууртын уурхайд авч хэрэгжүүлэх:</p> <ul style="list-style-type: none"> <li>Сентеррагийн одоо хэрэгжүүлж буй Хямралын менежментийн төлөвлөгөө, онцгой байдлын төлөвлөгөөг Гацууртын уурхайн нөхцөл байдалд тохируулж боловсруулах</li> <li>Онцгой байдлын үед авах арга хэмжээг онцгой байдлыг хариуцсан байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх</li> <li>Компани цианид худалдан авах, тээвэрлэх, хадгалах, хэрэглэх, устгах үйл ажиллагаандаа олон улсын аж үйлдвэрийн стандартыг хангаж ажиллаж байгааг баталгаажуулахын тулд цианид үйлдвэрлэх, тээвэрлэх, ашиглах явцад хэрэгжүүлдэг олон улсын Цианидын менежментийн кодыг (ICMC) үргэлжлүүлэн мөрдөх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Онцгой байдлын МТ</li> <li>Аюултай материал МТ</li> <li>Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын МТ</li> </ul>	Дунд
		Өндөр	<p>Бороогийн уурхайд хэрэгжүүлж буй арга хэмжээг Гацууртын уурхайд авч хэрэгжүүлэх:</p> <ul style="list-style-type: none"> <li>Тэсэлгээний нөлөөллийг багасгах зорилгоор уурхайн идэвхтэй бүсээс орон нутгийн иргэдийг холдуулах</li> <li>Орон нутгийн иргэдийг орохыг хориглосон бүс рүү зөвшөөрөлгүй орохоос сэргийлж хамгаалалтын ажилтнуудаар хамгаалуулах</li> <li>Бүх орц/гарц, уурхайн талбайн хил хязгаар / хашааны гадна тэмдэг, тэмдэглэгээ байршуулах</li> <li>Уурхайн талбайн ойр орчим, дотор, гаднах аюулгүй ажиллагааны гол асуудлуудын талаар оролцогч талуудад тогтмол мэдээлж байх</li> <li>Уурхайн талбай дээр танилцуулга сурталчилгааны хөтөлбөрийн хүрээнд зочдыг хяналттай, аюулгүй байдлаар үе үе авчрах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны МТ</li> <li>Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөө</li> <li>Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй</li> </ul>	Дунд

Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шинж	Бууруулаагүй үеийн ач холбогдол	Санал болгож буй гол хяналт, нөлөөлөл бууруулах, нэмэгдүүлэх арга хэмжээний тойм	Холбогдох менежментийн төлөвлөгөө & бодлого	Болзошгүй үлдэгдэл ач холбогдол
				ажиллагаа, аюулгүй байдлын МТ	
Гацуурт болон Бороогийн уурхай хоорондын нийтийн хэрэглээний зам дээр, мөн төслийн болон нийтийн хэрэглээний зам ашиглах явцад замын хөдөлгөөнөөс үүдэлтэй осол, гэмтэл гарах эсвэл амь насаа алдах эрсдэл	Тодорхой Шууд, Их сөрөг Дунд хэмжээнд Урт хугацаанд	Өндөр	<ul style="list-style-type: none"> <li>Төслийн ажиллагсад, гэрээт ажиллагсдыг бүгдийг нь хамруулсан, төслийн бүх шатанд тээврийн хэрэгсэл, тоног төрөөмжүүдийг зохицуулах стратеги бүхий Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх</li> <li>Замын аюулгүй ажиллагаа, замын хөдөлгөөний аюулгүй байдлын компанит ажлыг боловсруулж, хэрэгжүүлэх</li> <li>Төсөл хэрэгжүүлэх хугацаанд хайрган замыг ашиглахад Төслийн болон нийтийн хэрэглээний замын хөдөлгөөний явцад хурд хэтрүүлэхээс үүсэх ослыг багасгах</li> <li>Замын ослоос урьдчилан сэргийлэх үүднээс замын тусгай инженерийн хяналтыг боловсруулж, хэрэгжүүлэх</li> <li>Ослыг бууруулах үүднээс одоогийн Бороогийн уурхайн жолоочийн хяналтыг авч хэрэгжүүлэх.</li> <li>Учирч болзошгүй ослыг бууруулах үүднээс Монгол Улсын Засгийн газартай хамтран ажиллах.</li> <li>Ослыг бууруулах үүднээс орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн иргэдийн Замын хөдөлгөөний МТ</li> <li>Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөө</li> <li>Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны МТ</li> </ul>	Дунд
Уурхайн үйл ажиллагааны турш шууд болон шууд бус замаар ажлын байрны боломжууд бий болох	Тодорхой Шууд эерэг Урт хугацааны Дунд хэмжээнд	-	<ul style="list-style-type: none"> <li>Бороо Гоулд компани-д хэрэгжүүлдэг шударга, ил тод ажилд авах үйл ажиллагаа хэрэгжүүлэх</li> <li>Орон нутгийн оюутнууд Монголын уул уурхайн салбарын хэрэгцээг илүү сайн хангахад чиглэсэн сургалтын хөтөлбөрийг сургалтын дотоодын түншүүдтэй хамтран хүргэх</li> <li>Орон нутгаас ажиллах хүч болон сургалтын түншүүдийг сонгох зэрэг шинэчлэгдсэн материалаар ОНХА-г хангах</li> <li>Орон нутгаас давамгайл эрхээр үндсэн ажил авах бодлогыг хэрэгжүүлж, энэхүү бодлогыг гэрээт байгууллагуудад дагаж мөрдүүлэх</li> <li>Орон нутгийн иргэдийг үндсэн болон гэрээт ажилд авах тал дээр сургалтын байгууллага, засгийн газартай хамтран ажиллах</li> <li>Орон нутгийн ажиллагсдыг ажилд бэлдэх, тусгай мэргэжлийн сургалтанд хамруулах, чадавхи дээшлүүлэх зэрэг ажлыг үргэлжлүүлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хөдөлмөр эрхлэлт, сургалтын МТ</li> <li>Хөдөлмөр эрхлэлтийн бодлого</li> <li>Хөдөлмөрийн МТ</li> </ul>	-

Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шинж	Бууруулаагүй үеийн ач холбогдол	Санал болгож буй гол хяналт, нөлөөлөл бууруулах, нэмэгдүүлэх арга хэмжээний тойм	Холбогдох менежментийн төлөвлөгөө & бодлого	Болзошгүй үлдэгдэл ач холбогдол
Төслийн барилга болон ашиглалтын үе шатанд уурхайн болон ажиллагсдын хэрэгцээ шаардлагыг хангах үйлчилгээ, хангамжнаас үүдэн гарах ажлын байр нэмэгдэх	Тодорхой Шууд эерэг Дунд хугацааны Дунд хэмжээнд	-	<ul style="list-style-type: none"> <li>Бизнесийн боломжийг сайжруулах үүднээс орон нутгийн жижиг бизнесүүдийг чадавхижуулахад хөрөнгө оруулалт хийх</li> <li>Гэрээнд бараа, үйлчилгээг орон нутгаас хангахыг урамшуулан дэмжих</li> <li>Жижиг бизнесийн тогтвортой хөгжлийг дэмжих үүднээс орон нутгаас нийлүүлэлт, худалдан авалт хийх боломжийг эрэлхийлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хангамжийн МТ</li> <li>Орон нутгийн хөгжлийн МТ</li> <li>Туслан гүйцэтгэгчийн МТ</li> <li>Гэрээний зүйл анги</li> </ul>	-
Төслийн ашиглалтын үе шатанд орон нутгийн худалдан авалтын үйл ажиллагаанд оролцох боломж нэмэгдэх	Тодорхой Шууд эерэг Дунд хугацааны Дунд хэмжээнд	-	<ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн ханган нийлүүлэгчдийг зохицуулах зорилгоор орон нутгийн худалдан авалтын бодлого, менежментийн төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хангамжийн МТ</li> <li>Орон нутгийн хөгжлийн МТ</li> </ul>	-
Төслийн барилга, ашиглалтын үе шатанд татвар, роялти болон бусад төлбөрийн улмаас Улсын болон аймгийн төсөв нэмэгдэх	Тодорхой Шууд эерэг Дунд хугацааны Дунд хэмжээнд	-	<ul style="list-style-type: none"> <li>Татварын нэмэгдсэн орлого, нийгмийн болон нийтийн үйлчилгээний эрэлт хэрэгцээний өсөлтийг үр дүнтэй, ил тод зохицуулах Засгийн газрын чадавхийг бэхжүүлэх санаачлагуудыг дэмжих.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн хөгжлийн МТ</li> </ul>	-
Ой ашиглагчид ил тод болсноор ойг хууль бусаар ашиглах явдал багассан	Тодорхой Шууд эерэг Урт хугацаанд Бага хэмжээнд	-	<ul style="list-style-type: none"> <li>Сентерра Гоулд Монголия одоогийн харуул хамгаалалтын ажиллах хүч Гацууртын уурхайн орчим тогтмол хамгаалалт хийж мод бэлтгэгчдийн явуулж буй өнөөгийн хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөө</li> <li>Орон нутгийн хөгжлийн МТ</li> </ul>	-
Төсөл болон гол оролцогч талуудын түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх орон	Эерэг Шууд Урт хугацааны Их дунд	-	<ul style="list-style-type: none"> <li>Хэлэлцэж тохиролцсон хөгжлийн төлөвлөгөөний дагуу төслийн сөрөг нөлөөлөлд өртөх орон нутгийн иргэдэд эдийн засгийн нөхцлөө сайжруулах боломжийг бэхжүүлэхэд нь туслах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн хөгжлийн МТ</li> <li>Оролцогч талуудыг</li> </ul>	-

Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шинж	Бууруулаагүй үеийн ач холбогдол	Санал болгож буй гол хяналт, нөлөөлөл бууруулах, нэмэгдүүлэх арга хэмжээний тойм	Холбогдох менежментийн төлөвлөгөө & бодлого	Болзошгүй үлдэгдэл ач холбогдол
нутгийн хөгжил тогтвортой болж, бэхжинэ	Дунд хэмжээнд		<ul style="list-style-type: none"> <li>Төслийн харилцаа холбоо, хэлэлцүүлгийг тогтмолжуулах үүднээс ННҮ-д хавсаргасан Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөөг (ТТОТ) тогтмол шинэчилж байх</li> <li>Бүх ажилчдад кемпийн дотоод журмын шаардлаганд нийцсэн (ажлын байран дээр биеэ авч явах, кемп дотор амьдрахад тавигдах шаардлагууд) зааварчилгаа (дотоодын, орон нутгийн болон гадаадын бүх ажиллагсдыг хамруулан) өгөх</li> <li>Орон нутгийн засаг захиргаа, иргэний нийгмийн байгууллага, орон нутгийн иргэдтэй хамтран орон нутгийн тогтвортой хөгжлийн төслүүдийг боловсруулж, хэрэгжүүлэлт, үр дүн нь уялдаа холбоотой, хариуцах эзэнтэй байгааг баталгаажуулах.</li> </ul>	татан оролцуулах төлөвлөгөө	

## **1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА БА НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ**

### **1.1 ОРШИЛ**

Сентерра Гоулд Инк. (цаашид Сентерра гэх) нь Канадад төвтэй алтны компани бөгөөд Төв Ази, Канад болон дэлхийн бусад зах зээлд алтны орд газруудад үйл ажиллагаа явуулах, хайгуул хийх, хэрэгжүүлэх мөн эзэмших үйл ажиллагаа эрхэлдэг. Үүнд Хэнтийн нурууны хөндийд Улаанбаатар хотоос хойд зүгт 90 км зайд Сэлэнгэ аймагт байрладаг Гацууртын төсөл орно. Сентерра компани нь Гацууртын талбайгаас 52 км зайд байрлах Бороогийн уурхайг өөрийн охин компани болох Бороо Гоулд компаниар (БГК) дамжуулан 100% бүрэн эзэмшдэг. Бороогийн уурхайд олборлолтын ажил 2004-2012 оны хооронд явагдсан бөгөөд үлдсэн хүдрийг боловсруулах ажил явагдаж байна. Гацууртын төсөлд (Гацуурт) Бороогийн уурхайд Гацууртын бага агуулгатай хүдрийг боловсруулах зорилгоор нэмэлт баяжуулах байгууламжийн зураг төслийг зохиох болон барих ажил багтана.

Сентерра Гоулд болон Монгол Улсын засгийн газар хооронд байгуулагдсан Хөрөнгө Оруулалтын гэрээний дагуу тс компани ил уурхайд олборлолт явуулж жилд нэг тонн хүртэл уурхайгаас гарах алтны хүдрийг 10 жилийн туршид боловсруулах болно. Гацууртын өнөөгийн төлөвлөгөөний дагуу тус компани нь олборлолтын эхний 2.5 жилд дунджаар тонн тутамд 2.86 грамм алтны агуулгатай, ойролцоогоор 3.6 сая тонн хүдрийг Бороогийн уурхайн байгууламжинд боловсруулахаар төлөвлөж байна. Энэ хугацаанд Бороогийн байгууламжууд дээр нэмж нэг тоннд 2.92 грамм алтны дундаж агуулгатай нийт 13.5 сая орчим тонн хүдрийг боловсруулах BIOX® үйлдвэрийг байгуулахаар төлөвлөж байгаа. BIOX® процесс нь уламжлалт аргаар алтыг цианидаар уусган баяжуулахаас өмнө боловсруулахад хүндрэлтэй хүдэр ба баяжмалыг холилттой саван дотор бактериар исэлдүүлэх технологийг ашигладаг.

Тус компани нь Гацууртын хүдрийг олборлож одоо байгаа Бороогийн бутлуур руу тээвэрлэж боловсруулахаар төлөвлөж байна. Төслийн гол үзүүлэлтүүд:

- Гацууртын төслөөс жилд нэг тонн алтны хүдрийг ил уурхайн аргаар олборлоно;
- Компанийн 487 ажилтанууд ба 512 гэрээт ажилтанууд (үүнд, хүдэр тээвэрлэлтийн 100, 120 кэмпийн үйлчилгээний болон 120 Хаягдлын далангийн гэрээт ажилтанууд багтана) ажиллана;
- Ил уурхайн тээврийн хэрэгслийн паркд экскаватор/утгуурт экскаватор, өөрөө буулгах хүнд механизм, бульдозер, грейдер, усны машинууд байна;
- Бороогийн уурхайн тээврийг цаашид ашиглаж, жилд 1.75 сая тонн боловсруулах хүчин чадалтай BIOX® үйлдвэрийг барьж байгуулна;
- Бороогийн Хаягдлын далангийн өргөтгөл, цаашдын нэмэлт өндөрлөгөөний барилгын ажил;
- Гацууртын уурхайд усны тунгаагуур, усны урсац өөрчлөх далан, Гацууртын гол дээрх бусад холбогдолтой дэд бүтэц бүхий усны менежментийн дэд бүтцийг сайжруулж, ажиллуулах магадлалтай;
- Нэмэлт цахилгаан, харилцаа холбооны дэд бүтцийг суурилуулах магадлалтай.



Гурван Гол ба Гацуурт компаниуд алтны шороон ордыг тус бүсэд илрүүлж 1991 – 2000 оны хооронд болон 1998 онд олборлосон бөгөөд Каскадиагийн геологичид Гацууртын ордыг нээсэн. Сентерра нь 2004 оноос хойш Гацууртын ордыг Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд ашиглахын тулд нийт 90 орчим төрлийн тусгай зөвшөөрөл, эрх, зөвшөөрлийг авсан. Өнгөрсөн арваад жилийн хугацаанд Сентерра нь байгаль орчны хяналт шинжилгээний арвин мэдээлэл цуглуулж үнэлгээ судалгааны ажлыг хийсэн.

Гэвч Төсөлтэй холбоотой нийгмийн тодорхой мэдээлэл, үнэлгээний ажлууд хомс байгаа учир энэхүү Нийгмийн нөлөөллийн үнэлгээг (ННҮ) одоо ашиглаж буй байгаль орчны мэдээлэлтэй хамтатган боловсруулж БОННҮ-ий олон нийтэд танилцуулах багц бичиг баримт болон төслийн техникийн бус хураангуйг бэлтгэсэн.

Тус төслийн хүрээнд өмнө нь хийгдсэн судалгаануудад 2011 онд хийгдсэн Нийгэм, эдийн засаг, Эрүүл мэнд, Соёлын суурь судалгаа, 2010 онд хийгдсэн Газар ашиглалтын судалгаа болон Техник эдийн засгийн үндэслэл (2005 оны тайлан ба түүний 2006 оны нэмэлт тодотгол) мөн Монгол Улсын холбогдох шаардлагуудын дагуу боловсруулсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (2009 оны тайлан ба түүний 2014 оны нэмэлт тодотгол) зэрэг багтана. Нийгмийн нөлөөллийн үнэлгээг боловсруулах явцад Нийгмийн суурь судалгааны (суурь судалгаа) шинэчилсэн хувилбарыг бэлтгэсэн бөгөөд энэ нь энэхүү бичиг баримтын бүрэлдэхүүн хэсэг болж орж байна (2015 он).

Нийгмийн нөлөөллийн үнэлгээний (ННҮ) ерөнхий зорилго нь Гацууртын төслөөс үүсэж болзошгүй нөлөөллийг тодорхойлж, дүн шинжилгээ хийн, зөвлөмж өгөх мөн тогтвортой хөгжлийн боломжуудыг бодит ажил болгох, сөрөг нөлөөллийг бууруулах явдал юм. Нийгмийн нөлөөллийн үнэлгээнд доорх үйл ажиллагаанд өртөж болзошгүй төслийн нөлөөллийн бүсийн орон нутгийн иргэдийг хамруулж авч хэлэлцсэн байна:

- Гацууртын төслийн уурхайн болон холбогдох үйл ажиллагаанууд;
- Гацуурт ба Бороогийн уурхайн хоорондын төслийн хүдэр тээвэрлэх ачааны машин ба бусад тээврийн хэрэгслийн хөдөлгөөн; ба
- Бороогийн уурхайн талбайд одоо ашиглаж буй болон шинээр барих баяжуулах үйлдвэрийн байгууламжийн барилгын ажил ба ашиглалт.

Нийгмийн нөлөөллийн үнэлгээний хамрах хүрээ нь төслийн барилга, ашиглалт ба олборлолтын дараах уурхайг татан буулгах үе шатуудаас үүсэх нөлөөллийг үнэлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулж санал болгосноор сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах буюу зөвшөөрөгдөх хэмжээнд хэвээр хадгалах болон эерэг нөлөөллийг улам нэмэгдүүлэх явдал юм. Нийгмийн нөлөөллийн үнэлгээ нь Сентеррад холбогдох сонирхогч талуудын оролцоог үр дүнтэй хангах замаар нөлөөлөл, эрсдэл ба бууруулах арга хэмжээний боломжуудын талаархи тодорхой ойлголттой болоход нь дэмжлэг болох зорилготой. Энэ нь Гацууртын уурхайд объектууд барьсны улмаас үүсэх нийгмийн сөрөг үр дагаварыг бууруулахад шаардлагатай арга хэмжээнүүдийг тодорхойлж, баримтжуулан тогтвортой нийгэм, эдийн засгийн үр ашгийг уурхайн үйл ажиллагааны явцад болон хаалтын үйл ажиллагааны дараа хувиарлах боломжийг бий болгох зорилготой. Гацууртын уурхайн бүтээн байгуулалтаас үүсч болзошгүй нийгмийн нөлөөлөл, эрсдэл ба үр дагаварын (компани ба орон нутагт аль алинд нь)



үнэлгээ нь нийгмийн эрсдэлийг бууруулах цогц төлөвлөгөөний мэдээлэл болох ба энэ төлөвлөгөөнд Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөө (ТТОТ) ба Нийгмийн менежмент ба мониторингийн төлөвлөгөөнөөс (НММТ) бүхий Нийгмийн менежментийн хамрах хүрээ ба Нийгмийн менежментийн нарийвчилсан төлөвлөгөө (НМТ) орно.

Төсөл хэрэгжүүлэгчийн хувьд Сентерра нь Гацууртын төслийг хэрэгжүүлэхийн тулд Европын Сэргээн босголт хөгжлийн банкнаас нөхөн төлөгдөх зээл авахыг зорьж байна. Энэхүү нийгмийн нөлөөллийн үнэлгээг ЕСБХБ-ны санхүүжилтийн шаардлагад нийцүүлж боловсруулсан ба үүний дотор Олон улсын үйлдвэрлэлийн сайн туршлага (ОУҮСТ) ба ЕСБХБ-ны 2014 оны Байгаль орчин, Нийгмийн бодлого тэр дундаа ЕСБХБ-ны 1-8 дугаар ба 10 дугаар Гүйцэтгэлийн шаардлагад нийцүүлсэн.

## **1.2 ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ**

Энэхүү тайланд Састайнабилити Ийст Эйжия (Састайнабилити)-ийн ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлагуудад нийцүүлж боловсруулсан ННҮ-г танилцуулж байна. Энэхүү тайланг Сентеррагийн Гацууртын төсөлд (Төсөл) зориулж бэлтгэж буй Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний олон нийтэд танилцуулах багц бичиг баримтийг нарийвчилсан мэдээллээр хангах зорилгоор бэлтгэсэн.

Энэхүү нийгмийн нөлөөллийн үнэлгээний бүрэлдэхүүн хэсэг нь Састайнабилити компанийн Төсөлд зориулж бэлтгэсэн нийгмийн шинэчилсэн суурь судалгаа (НСС буюу суурь судалгаа) юм. Суурь судалгаанд энэхүү тайлангийн нийгмийн нөлөөллийн үнэлгээний бүлгүүдэд харьцуулсан дүн шинжилгээг танилцуулсан байна.

Энэхүү тайлан дараах хэсгүүдээс бүрдэнэ: Танилцуулга (Бүлэг 1); Төслийн танилцуулга (Бүлэг 2); Бодлого, хууль ба захиргааны хамрах хүрээ (Бүлэг 3); Арга зүй (Бүлэг 4); Оролцогч талуудыг татан оролцуулах (Бүлэг 5); Нийгэм эдийн засгийн суурь судалгаа (Бүлэг 6); Нийгмийн нөлөөллийн үнэлгээ (Бүлэг 7); Нийгмийн менежментийн төлөвлөгөө (Бүлэг 8); ба Дүгнэлт (Бүлэг 9) ба Хавсралтуудыг тайлангийн төгсгөлд оруулсан.

## **2. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

### **2.1 БАЙРШИЛ БА ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН**

Гацууртын уурхай нь Улаанбаатар хотоос хойд зүгт 90 км, Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгоноос баруун зүгт 14 км зайд байрлах Хэнтийн нурууны хөндийд оршдог. Түнхэл уурхайн талбайтай хамгийн ойр суурин бөгөөд Гацууртын төслийн талбайгаас зүүн зүгт байрладаг ба 14 км шороон замаар холбогдсон байдаг. Түнхэл нь төмөр замын өртөөтэй ба 110 кВ цахилгаан дамжуулах шугам 25 км дайрч өнгөрдөг. Орон нутгийн газрын гадаргуу нь харьцангуй тэгш гадаргуугаас дунд зэрэг эгц огцом өндөрлөг хүртэл хэлбэлзэнэ. Цэвдэгтэй бүс гэж тодорхойлсон боловч төслийн талбайд цэвдэгтэй газар илрээгүй. Компани нь Гацууртын уурхайн талбай дахь хүдрийг олборлож Бороогийн уурхайн талбай руу тээвэрлэж баяжуулахаар төлөвлөж байна. Бороогийн уурхайн талбай нь Гацууртын уурхайн талбайгаас баруун зүгт 50 км зайд оршино. Бороогийн уурхайн одоо ашиглаж буй баяжуулах байгууламжууд мөн Бороо ба Гацууртыг холбосон зам бүхий төслийн бүрэлдэхүүн хэсгүүд нь Сэлэнгэ аймгийн Баянгол сум хүртэл үргэлжилнэ. Зураг 2.1-д төслийн байршлыг харуулав.

Төсөл нь Хэнтийн нурууны баруун талд орших уулсын дунд оршино. Үүний хөрс, ургамлын бүрхэц нь тал хээр, ойт хээрийн бүсийн хэсэг болно. Гацууртын төслийн талбай нь сийрэг ойн бүрхэвчтэй ба үүнд хус, нарс, шинэс гэх мэт мод байна. Төслийн талбайн дундуур урсах голын хөндий нь далайн түвшнээс дээш ойролцоогоор 1,000 м-д өргөгдсөн бөгөөд ойр орчмын уулс нь 1,300 м-д өргөгдсөн ба хамгийн өндөр оргил нь 2,500 м-д өргөгдсөн байна. Хар шороон хөрс нь голын гольдрил дагуу хурдсанд бөгөөд түүний дээрхи залгаа давхаргад арвин хуримтлагдсан. Цэвдэг бүс нутгийн зарим газруудад түгээмэл тохиолддог.

Өнгөрсөн хугацаанд аллювийн (шороон) ордны олборлолт Гацууртын уурхайн талбайд явагдаж байсан бөгөөд хөндийн гидрологийн төлөв байдал, гадаад төрхийг ихээхэн өөрчилсөн. Гацуурт орчмын газар нь олон тооны өнгөн үхмалууд, аллювийн элсний овоолготой бөгөөд олборлолт явуулах талбай дотор өнгөрсөн хугацаанд хийгдсэн олборлолтын үйл ажиллагааны үр дүнд үүссэн янз бүрийн хэмжээтэй шуудуунууд бий. Ойролцоогоор 2,236 га талбайг хамарсан Гацууртын нийт хайгуулын блокуудаас 146 га орчим талбай нь урьдны олборлолтын үйл ажиллагатай холбоотой эвдрэлд орсон газар гэж үзсэн байна.

#### **Сэлэнгэ аймаг**

Сэлэнгэ аймаг нь Монгол орны уулархаг хойд бүс нутаг болон Орхон, Сэлэнгийн сав газарт оршдог. Аймгийн төв Сүхбаатар хот нь Улаанбаатар хотоос 321 км зайд оршдог бөгөөд хатуу хучилттай зам, төмөр замаар холбогдсон. Сэлэнгэ аймаг нь Монгол Улсын нийт үр тарианы 45%-г бүрдүүлдэг ба 570,000 гаруй толгой мал сүрэгтэй байна. Сүхбаатар хот нь Орос улсын хилийн боомт хүртэлх төмөр зам ба улсын чанартай замын огтолцол дээр байрладаг учраас хөгжлийн гол тэнхлэг болсон байна. 2014 оны байдлаар аймгийн хүн амын тоо 105,253 байв.


#### **Мандал сум**

Мандал сум нь Сэлэнгэ аймгийн төв Сүхбаатар хотоос 220 км зайд, Улаанбаатар хотоос 174 км зайд оршдог. Мандал сум нь 1924 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд төв нь Зүүнхараа юм. Хэрх багийн төв нь Зүүнхараа хотоос 5 км зайд оршдог бол Түнхэл баг нь Зүүнхараагаас зүүн өмнөд

зүгт хучилтгүй замаар 44 км-ийн зайд байрладаг юм. Мандал сум нь 9 багтай, 25,000 хүн амтай байгаа нь Монгол Улсын сумдтай харьцуулахад хамгийн их хүн амтай сум юм. Сум нь нийт 484,373 га газар нутгийн хамарсан бөгөөд үүний ихэнхийг газар тариалангийн зориулалтаар ашигладаг. Үүнээс гадна, сумын нутаг дэвсгэрийн 70% нь ойн сан бүхий газар бөгөөд Мандал сумын аж үйлдвэрийн хоёрдогч гол салбар нь ойн аж ахуй юм. Мандал сум нь жил бүр дунджаар 40 тэрбум төгрөгний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг.

### **Баянгол сум**

Баянгол сум нь 1931 онд үүсгэн байгуулагдсан. Сумын нутаг дэвсгэр нь 197,600 га газар нутгийг хамардаг ба хүн ам нь 5,500 орчим. Хүн амын тоогоороо Баянгол сум нь Сэлэнгэ аймагтаа дөрөвт ордог. Тэрээр Улаанбаатар хотоос 156 км, Дархан – Уул аймгаас 75 км, аймгийн төвөөс 170 км зайд байрладаг. Баянгол сум нь Мандал сумтай адилаар газар тариалангийн нутаг бөгөөд Улаанбаатар, Дархан хот, Сэлэнгэ аймгуудтай хатуу хучилттай замаар холбогдсон бөгөөд Монгол – Орос улсыг холбосон төмөр замын дагуу байрладаг.



**Зураг 2.1 Төслийн байршил**



## 2.2 ТӨСЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮД

Төсөл нь хоёр ил уурхай, Хаягдал чулуулгийн овоолго, хүдрийн тээвэрлэлт, хүдэр баяжуулах үйлдвэр, Хаягдлын аж ахуй, алт боловсруулалтын хэсгээс бүрдэнэ. Төслийг 17 жилийн турш хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд үүний 10 жил үйлдвэрлэл, 9 жил нь олборлолт ба 17 жилийн байгаль орчны хяналт шинжилгээ ба нөхөн сэргээлтийн ажлууд байна. Хүснэгт 2.1-д Төслийн ашиглалтын үе шатанд авч хэрэгжүүлэх томоохон үйл ажиллагаануудыг танилцуулсан ба энэ үе шатны товч тайлбарын харуулав<sup>6</sup>. Төслийн танилцуулгыг бүрэн эхээр нь Техникийн бус хураангуй хэмээх бичиг баримтаас үзэж болно.

### Хүснэгт 2.1 Уурхайн гол бүрэлдэхүүн хэсгүүд ба Гацууртын төслийн ашиглалтын үе шатны арга хэмжээнүүд

Төслийн нэгж	Үйл ажиллагаа
Гацууртын ил уурхай	Тэсрэх бодис ба машин тоног төхөөрөмж ашиглан хүдэр болон хаягдлыг олборлож, гаргаж авах Тэсрч дэлбэрэх бодис хадгалах, ашиглах Ил уурхайн усыг шавхах Хяналт шинжилгээ
Гацууртын овоолго ба далан	Бороогийн уурхайн талбай руу хүдрийг ачиж, тээвэрлэх Хаягдлыг буулгах ба овоолго барих Гадаргын урсацыг цуглуулж, цэвэрлэх Хяналт шинжилгээ хийх
Хүдрийн баяжуулалт (Бороогийн алтны уурхай дээр)	Хүдэр баяжуулах үйлдвэрт хүдрийг буулгаж, нийлүүлэх Материалыг нунтагла, хөвүүлэн баяжуулах Биологийн аргаар хүдрийг исэлдүүлэх (BIOX®) Химийн бодис урвалжийг хадгалах, харьцах, ашиглах Үйлдвэрлэлийн хаягдлыг Хаягдлын аж ахуйд хаях
Хаягдлын аж ахуй (Бороогийн алтны уурхай дээр)	Нэмэлт хаягдал хүлээн авах багтаамжтай болгох зорилгоор даланг өндөрсгөх Инженерийн ба байгаль орчны мониторинг хийх
Уурхайн бусад тоног төхөөрөмж болон дэд бүтэц	Шатахуунтай харьцах, ашиглах, хадгалах Уурхайн гол ба тээвэрлэлтийн зам ашиглах Хог хаягдал ба хаягдал усны менежмент Аюултай бус хог хаягдалыг Бороогийн уурхай руу шилжүүлэх Цахилгаан дамжуулах шугам ашиглах Уурхайн талбайн усан хангамжийг ашиглах Тээврийн хэрэгслийн засварын газар ба төслийн талбайн байгууламж
Гадаргын усны менежмент	Шингэний асгаралтыг тогтоон барих цөөрөм Төслийн талбайн усны сувгийн арчилгаа Хурдас зайлуулах

### 2.2.1 Гацууртын уурхай

#### 2.2.1.1 Уурхай

Гацууртын төсөл нь нийт 9 жил уурхайн үйл ажиллагаа явуулах тооцоотой бөгөөд Гацууртын уурхайн Төвийн ба Гол бүсийн хоёр ил уурхайг ашиглан хүдэр олборлох болно. Төвийн бүсийн ил уурхай нь ойролцоогоор 230 м гүн, Гол бүсийн ил уурхай нь 125 м гүн хүрэх бөгөөд эдгээрийг ил уурхайн олборлолтын уламжлалт аргаар ашиглана. Ойролцоогоор 1 тонн хүдрийг олборлоход 4

<sup>6</sup> Байгаль орчин, нийгмийн техник эдийн засгийн үндэслэл, 2014 оны 2 дугаар сар, SNC-Lavalin.

тонн Хаягдал чулуулаг гаргаж авах харьцаатайгаар 84 сая тонн материалыг Гацууртын уурхайгаас зайлуулах ба тонн тутамд дунджаар 2.83 грамм алтны агуулгатай ойролцоогоор 16.5 сая тонн хүдэр олборлох болно. 67 сая тонн үүссэн Хаягдал чулуулагийг Хаягдал чулуулгийн овоолго (ХЧО)-д хадгалах ба энэ нь Гацууртын голын хажуугийн гол ил уурхайгаас доош байрлах ба уурхайн олборлолт дууссаны дараа нөхөн сэргээгдэнэ. Гацууртын ордоос мөнгөний илэрцтэй алттай хүдэр олборлоно.

Уурхай тасралтгүй 12 цагийн ээлжээр жилд 350 өдөр ажиллаж, эхний жилд өдөрт 53,000 тонн олборлох хүчин чадалтай, удаах жилүүдэд өдөрт 35,000 тонн олборлох хүчин чадалтай ажиллана. Лицензи эзэмшигч нь өөрийн ажиллах хүчээр олборлолтын үйл ажиллагааг явуулахын зэрэгцээ уурхайн тоног төхөөрөмжийн бааз болон тэдгээрийн засвар үйлчилгээг хариуцна.

Эдийн засгийн ашигтай алтыг олборлож дууссаны дараа уурхайн хаалт ба төслийн талбайн нөхөн сэргээлтийг гүйцэтгэх болно.

Гацууртын талбайн байгаль орчны хяналт шинжилгээ ба нөхөн сэргээлтийг төслийн хэрэгжилтийн хугацаанд 17 жилийн турш гүйцэтгэх болно. Үүнд уурхайн олборлолт ба ашиглалтын үе шатны байгаль орчны хяналт шинжилгээ (11 жил), хаалтын үе шатанд 3 жилийн турш хэрэгжүүлэх нөхөн сэргээлтийн ажил ба үүний дараа 5 жилийн турш үргэлжлэх нөхөн сэргээлтийн хяналт шинжилгээ багтана<sup>7</sup>. Шороон ордын олборлох үйл ажиллагааны улмаас өмнө нь эвдрэлд орсон газруудыг Гацууртын төслийн нөхөн сэргээлтийн хөтөлбөрийн хүрээнд нөхөн сэргээх болно.

Хаалтын үйл ажиллагаанд баяжуулах үйлдвэрийн байгууламжийг татан буулгах, хаалтын үе шатны уурхайн талбайн аюулгүй байдлыг хангах ба Хаягдал чулуулгийн овоолго бүхий газрын гадаргын тогтоцийг тогтворжуулах ажлуудыг оруулахаар төлөвлөж байна.

#### 2.2.1.2 Хаягдал чулуулаг

Төвийн бүсийн ил уурхайн өмнө байрлах дан овоолгод хаягдал чулуулагийг хаях болно. Хаягдал чулуулгийг Хүчиллэг урсац үүсэх магадлалтай (ХҮҮБ) болон Хүчиллэг урсац үүсгэхгүй (ХҮҮ) материал гэж ялгаж хаях болно. Хүчиллэг урсац үүсгэж болзошгүй овоолгод ойролцоогоор 9 сая тонн материал байрлуулах бол Хүчиллэг урсац үүсгэхгүй овоолгод 36 сая тонн материал хаяна. Овоолгыг хөндийн өмнөд хэсэгт байрлуулж, өндөр нь 80 метр хүрэх бөгөөд тогтвортой байдлыг хангахуйц аюулгүй ажиллагааны зохих нөхцөлийг хангасан байхаар хийнэ.

Овоолгод хадгалж буй Хүчиллэг урсац үүсгэх магадлалтай чулуулгийг шороогоор бүрж тусгаарлах нь овоолго барих журмын нэгэн гол чухал хэсэг юм. Энэхүү овоолгын өнцөгийг тогтвортой байхаар босгох бөгөөд 20 метрээр өндөргөсгөх тутамд дахин хэлбэрт оруулж налууг 3:1 харьцаатай болгож ургамалжуулах нөхцлөөр хангана. Гол бүсийн ил уурхайгаас гарсан хаягдал материалуудыг бүгдийг хүчиллэг урсац үүсгэх магадлалтай гэж үзсэн бөгөөд олборлож дууссан Төвийн бүсийн ил уурхайн аманд байршуулахар төлөвлөж байна. Хаягдалыг ил уурхайн ёроолд байрлуулснаар чулуулагийг усанд автуулж хүчиллэг урсац үүсэхээс урьдчилан сэргийлэх болно.

#### 2.2.1.3 Ашиглаж буй нөөц

Гацууртын уурхайн талбайд ашиглах цахилгаан эрчим хүчийг Түнхэл тосгоны одоо ашиглаж байгаа 10 кВ-ийн цахилгаан дамжуулах шугамаас хангах болно. Энэ шугамыг 500 кВ цахилгаан дамжуулдаг болгож сайжруулах ба энэ нь Гацууртын уурхайн нэмэлт барилга байгууламжуудыг

<sup>7</sup> Гацууртын төслийн танилцуулга 2015 оны 3 дугаар сар.



цахилгаанаар хангана. Дизель болон бензин шатахуун хадгалах байгууламжуудыг уурхайн засвар үйлчилгээний бүсэд байгуулна. Нэг дизель хадгалах сав ба нэг бензин хадгалах савыг газрын гадарга дээр байрлуулна. Уурхайн засвар үйлчилгээ/ашиглалтын захиргааны барилга ба харуул хамгаалалтын байрийг уурхайн талбайд барина.

#### 2.2.1.4 Зам тээвэр

Хайрган хучилттай 56 км урт замыг Гацуурт ба Бороогийн уурхай хоёрын хооронд байгуулсан. Энэ нь 8 метрийн өргөнтэй нэг эгнээтэй зам бөгөөд зөрж өнгөрөх эгнээ нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор зам дагуу байгуулсан.

Төслийн хүдэр тээвэрлэхэд ашиглах энэхүү зам нь Мандал сумын удирдлагуудын хүсэлтээр 2010 онд Бороо Гоулд компанийн барьсан нийтийн хэрэглээний зам юм. Энэ 56 км зам, 1 гүүрийг зам барилгын 5 өөр компани барьсан (үүнд замыг 5 хэсэгт хувааж тусад нь барьсан) ба үүнийг 5 зөвшөөрлийн бичиг баримт буюу "Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах улсын комиссын акт" тусгасан буюу энэ бичиг баримтад холбогдох журам ба тодорхой шаардлагуудыг тусгасан байна. Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах улсын комиссын акт<sup>8</sup> -д Бороо Гоулд компани нь зам ашиглагч, санхүүжүүлэгч, мөн тухайн замын барилгын ажил ба засвар үйлчилгээний ажил цаг хугацаанд хийгдэж буйг баталгаажуулах үүрэг хариуцлаг бүхий Мандал сумын Засаг даргын тамгын газрын<sup>9</sup> адилаар зам эзэмшигч гэж заасан байна. Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах улсын комиссын актанд замыг хатуу хучилттай болгох заалт байхгүй ч Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны сайдын тушаалын (2012 оны 5 дугаар сарын 30-ны 159 тоот тушаал) дагуу баталсан түр дүрэмд "уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг хатуу хучилттай зам тавьсны дараа гүйцэтгэх ёстой" гэж заасан байдаг. Ийм гадаргуугаас газар ашиглалт, амьжиргаа ба хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй нөлөөллүүдийг Бүлэг 7-д авч хэлэлцэв.

Гацууртад ил уурхайгаас олборлосон бүхий л хүдрийг Төвийн бүсийн ил уурхайн амын ойролцоо байрласан хүдрийн овоолгод зөөж авчирна. Хүдрийн тээвэрлэлтийн үйл ажиллагааг Сентеррагийн ачааны машинуудаар Гацуурт компани гэрээгээр гүйцэтгэнэ (роялти эзэмшигч Чинбатын салбар компани). Хүдрийг жижиг экскаватороор (1м<sup>3</sup>) 40 тонны трактор – трейлерүүдэд ачиж Бороогийн урхайн баяжуулах үйлдвэр лүү нийтийн хэрэглээний замаар тээвэрлэлнэ. Сентерра нь 2010 онд 24 ширхэг Вольво загварын ачааны машиныг 5.3 сая доллараар (НӨАТ орсон) өртөгөөр худалдаж авсан. Уурхай бүрэн хүчин чадлаараа ажиллах үед буюу өдөрт 5 000 тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай үед 28 ачааны машин 12 цагийн ээлжээр тасралтгүй хүдэр тээвэрлэнэ. Гацуурт компани нь нэмж зургаан ачааны машин худалдаж авахыг санал болгосон. Ачааны машинууд нь өдөрт 6 – 7 удаа 54 км замыг туулах болно (энэ дунджаар цагт 6 ачааны машин зөрж өнгөрөх буюу 20 минут тутамд нэг бүрэн ачаатай машин Бороо руу, харин нэг хоосон ачааны машин Гацуурт руу зорчино гэсэн үг юс).

Хүдэр тээвэрлэлтийн ачааны машины баазыг Сентерра эзэмшиж, тээвэрлэлтийг компанийн хяналтан доор Гацуурт компани гүйцэтгэх бөгөөд дараах ажлуудыг хийнэ. Үүнд:

<sup>8</sup> Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах улсын комиссын акт 03/66/2010, Гацуурт ХХК ба Мандал сум, 2010 оны 11 дүгээр сарын 12.

<sup>9</sup> Авто замын тухай хуулийн 3.1.9 -р заалтад "орон нутгийн чанартай авто зам" гэж нийслэл, аймгийн нутаг дэвсгэр дэх сум, дүүрэг, хот, суурин газрыг хооронд нь холбосон авто замыг хэлнэ гэж заасан.

- Тээврийн баазын түлшний хэрэгцээг Бороогийн уурхайн талбайгаас хангах;
- Тээврийн машины засвар үйлчилгээг Бороогийн уурхайн талбайд ихэвчлэн гүйцэтгэнэ;
- Ойролцоогоор 144 ачааны машиныг жолоочоор хангах.

Хүдэр тээвэрлэх гэрээний нөхцөлд жолоочболон засвар үйлчилгээний ажиллагсдыг нэн түрүүн орон нутгаас авах, Сентерра компанийн хөдөлмөрийн бодлогын шаардлагуудад нийцүүлэх ажиллах талаар тусгах болно.

#### 2.2.1.5 Бороогийн уурхайн байгууламжууд

Хүдэр баяжуулах ба Хаягдлын аж ахуйн байгууламжууд болон дэд бүтцийн бусад туслах байгууламжуудыг Бороогийн төслийн талбай дээр үйл ажиллагаа эхлэхээс өмнө барих шаардлагатай болно. Барилгын үе шатанд Бороогийн уурхай дээр BIOX® үйлдвэр бүхий хүдэр баяжуулах шинэ байгууламжууд барихад Сентерра-д 104 сая Америк долларын хөрөнгө оруулах шаардлагатай.

Үйлдвэрлэлийг 10 жилийн хугацаанд өдөрт 5,000 тонн хүдэр боловсруулах бүрэн хүчин чадлаар явуулах болно. Бороогийн уурхайн талбайд байрлах баяжуулах үйлдвэр нь үйл ажиллагааныхаа хоёр дахь жилийн 1-р сард бүрэн хүчин чадалдаа хүрэх бөгөөд 42 тонн/Аи ба 3.7 тонн/Аг-ийг төслийн үйл ажиллагааны хугацаанд үйлдвэрлэх болно.

#### 2.2.1.6 Нөөц ашиглалт

Нэмэлт биологийн исэлдэлтийн BIOX® технологи бүхий Бороогийн уурхайд одоо ашиглаж буй баяжуулах үйлдвэрт шаардлагатай дээд хэмжээг тооцож үзэхэд 8.9 МВатт гэсэн тооцоо гарж байна. Төслийн шаардлага хэрэгцээг хангахын тулд нэмэлтээр 15 Мега вольт ампер, 110-33 кВ хүчин чадалтай трансформатор суурилуулах хэрэгтэй. Бороогийн уурхайн талбайн одоогийн дэд станц нь 15 МВ-ийн трансформаторыг нэмж суурилуулж хүчин чадлыг нэмэгдүүлэн, автомат таслуурыг суурилуулах бөгөөд энэ нь хүчин чадал буурах болон трансформаторийн үйл ажиллагаа тасалдах үед нөөц үүсгүүр болох юм. Түүнээс гадна 6 км урттай, 110 кВ-ийн цахилгаан дамжуулах хоёр дахь шугамыг Бороогийн уурхайн талбайд одоо байгаа цахилгаан шугамтай зэрэгцүүлж тавих бөгөөд шаардлагатай бага вольтийн цахилгаан түгээх системийг баяжуулах үйл ажиллагааг нэмэлт эрчим хүчээр хангах зорилгоор байрлуулана.

Төслийн талбайд цахилгаангүй болсон үед био-исэлдэлтийн реакторуудад ашигладаг том агаар үлээгч төхөөрөмжийн тогтмол үйл ажиллагааг хангах цахилгаан үүсгүүр бүхий гурван ширхэг 650 кВ-н нөөц үүсгүүрээр хангах шаардлагатай.

Бороогийн баяжуулах үйлдвэрт шаардлагатай цэвэр усны нөөцийг уурхайн зүүн зүгт орших Бороо голын хөндийн усны цооногуудаас татаж баяжуулах үйлдвэрийн ус хадгалах савнуудад шахах болно. Цэвэр ус хангамжийн систем нь дунджаар цагт 300 м³ ус дамжуулах хүчин чадалтай.

Одоо ашиглаж буй ундны ус цэвэршүүлэх үйлдвэр нь цэвэр усыг хадгалахаас өмнө цэвэршүүлнэ.

Бохирыг зайлуулахаас өмнө цуглуулж хлоржуулна. Бохир ус цэвэрлэх үйлдвэрээс ялгарсан шингэнийг септикийн талбайд хаяна. Бохирын системийн хүчин чадлыг ажиллагсдын өргөтгөсөн кемпийн болон түр зуурын нэмэлт барилгуудын хэрэгцээг хангах зорилгоор нэмэгдүүлнэ.

#### 2.2.1.7 Хаягдал хадгалах байгууламж

Хаягдал хадгалах байгууламж нь (ХХБ) нь Бороо Гоулд уурхайн талбайд Их Дашир ба Бага Даширын хөндийн бэлчирийн орчимд боловсруулах үйлдвэрээс зүүн зүгт 6 км-ийн зайд байрлана. Анхны ХХБ-н зураг төслийг Голдер Ассосиетэс 2003-аас 2008 оны хооронд боловсруулан барьж байв. Энэхүү байгууламжийн ёроол нь 1.5 мм-ийн зузаантай нягтруулсан шавар суурь давхрагатай бөгөөд түүний урсгалын дээд талын захыг өндөр нягтралтай полиэтилен (ӨНП) хулдаасаар доторлосон. Усны хяналтын цооногийн сүлжээг далангийн доторлогооны материалыг нэвчиж цооног руу орох аливаа усны шүүрэлтийг тодорхойлоход ашиглаж байна. Урсацын дагуух хэд хэдэн усны хяналтын цооногийг хаягдлын далангийн аливаа нэвчилт байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор байрлуулсан. Бороо Гоулд уурхайн төсөл хэрэгжих хугацаанд хяналтын цооногуудад хаягдал хадгалах байгууламжийн далангийн усны шүүрэлт илрээгүй нь байгууламж нь сайн тусгаарлагдсан болохыг илэрхийлж байна.

Бороогийн баяжуулах үйлдвэрт шинээр BIOX® процессийг нэмж байгаатай холбоотойгоор одоо байгаа хаягдал хадгалах байгууламжид нэмэлтээр үүсэх хаягдлыг багтаахын тулд өргөтгөж томсгоно. Одоо буй байгууламжийн зүүн талд шинээр үүр баригдах болно.

#### 2.2.1.8 Байр, кемпийн үйлчилгээ

Төслийн ашиглалтын үе шатанд Гацууртын уурхайн ажиллагсдыг Бороо Гоулд уурхайн одоо байгаа ажиллагсдын байранд байрлуулах бөгөөд Гацууртын уурхайн талбай руу ээлжийн дагуу зөөвөрлөж, буцааж авчрах болно.

400 хүний багтаамжтай барилгын кемпийг Бороогийн уурхайн одоо байгаа байрнуудын зүүн талд байгуулна. Энэхүү кемпэд Бороогийн уурхайн барилга байгууламжийн хажууд менежмент хариуцсан 30 хүний байр барж, 4 хүний багтаамжтай 80 гэр, гал тогоо, хоолны байр ба амралт чөлөөт цаг өнгөрүүлэх байгууламжуудыг барьж байгуулах болно.

Бороогийн уурхайн байнгын кемпийг өргөжүүлэх ажил 2016 онд эхэлж ажиллагсад, удирдлагуудыг байрлуулах болно. Түүнээс гадна, шинээр 4 хүний багтаамжтай гэрүүдийг нэмж барьж, шаардлагатай үед барилгын ажиллагсдыг байрлуулах болно. Бороо Гоулд уурхайн ажил таслалтыг багасгах туршлагын дагуу болон Кемпийн дотоод журмыг мөрдөх явдлыг хангах зорилгоор орон нутгийн ажиллагсад бүхий уурхайн бүх ажиллагсад өөрсдийн ажлын ээлжийн үед кемп дээр байнга байрлах үүрэгтэй.

Уурхайн талбайгаас гадна байрлах аливаа барилгын кемп нь мөн энэ дотоод журмыг мөрдлөг болгоно.

#### 2.2.1.9 Ажиллах хүчин

Төсөл нь 482 байнгын ажилчин авах ба үүнд 116 тоног төхөөрөмжийн оператор, 78 засвар, үйлчилгээний ажилчид, 77 инженер техникийн ажилтнууд багтана.

Нэмж гэрээт гүйцэтгэгчийн ажиллах хүчин шаардлагатай бөгөөд үүнд хүдэр тээвэрлэлт, уурхайн үйлчилгээ (гэр цэвэрлэх, хоол хүнс бэлтгэх) гэрээт гүйцэтгэгчид орно. Эдгээр шууд бус ажлын байр нь 512 хүнийг ажилтай болгох төлөвтэй байгаа нь 160 орчим нь улирлын буюу түр зуурын ажилтан байна (үүнд, нөхөн сэргээлтийн, агуулах ба барилгын ажиллах хүч орно).

Сентерра нь Бороогийн төслийн дагаж мөрдөж буй орон нутгаас (Баянгол ба Мандал сум, тэр дундаа Түнхэл баг) ажилтан авах бодлогыг баримтлах бөгөөд шаардлага хангасан чадвартай,


туршлагатай хүмүүс олдохгүй бол Сэлэнгэ аймгаас хүмүүсийг авч ажиллуулахыг нэн тэргүүнд шаардах болно. Түүнээс гадна, Сентерра нь өөрийн гэрээт гүйцэтгэгч нараас орон нутгийн иргэдээс нэн тэргүүн ажилд авах үүрэг даалгаварыг биелүүлэхийг шаардах болно.

### **2.3 ТӨСЛИЙН НӨЛӨӨЛЛИЙН БҮС**

Гацууртын төсөл нь Монгол Улсын Сэлэнгэ аймагт орших ба уурхайн тусгай зөвшөөрөлтэй талбай нь Мандал суманд оршдог. Хүдэр тээвэрлэлтийн зам ба Бороогийн уурхайн баяжуулах үйлдвэрийн барилга байгууламжууд нь Мандал сумын нутгаас цааш үргэлжилж Гацууртын талбайн баруун зүгт байрлах Баянгол сумын нутгийг хамрана. Зураг 2.2-г үзнэ үү.

Нийгмийн судалгааны бүс нь төслийн бүхий л бүрэлдэхүүн хэсгүүдийн шууд нөлөөлөлд өртөж буй эдгээр сумдыг хамрана (жишээлбэл дээрхи төслийн танилцуулгад тодорхойлсон). Эдгээр сумдад Сэлэнгэ аймгийн Баянгол ба Мандал сумд бөгөөд Зүүнхараа (Мандал сумын төв), Түнхэл баг (Мандал сумын Гацууртын уурхайн талбайд хамгийн ойр суурин газар) ба Баруунхараа (Баянгол сумын төв) орно.





**Зураг 2.2 Төслийн талбайн газрын зураг**

Энэхүү нийгмийн суурь судалгаа нь байгаа мэдээлэл дээр үндэслэн төслийн “судалгааны бүс нутаг” буюу “Төслийн нөлөөллийн бүс”<sup>10</sup>-ийг тодорхойлсон. Нөлөөллийн бүсийг нийгэм, эдийн засаг, соёлын нөхцөл байдал нь шууд буюу шууд бус нөлөөлөлд өртөж болзошгүй газар нутаг гэж тодорхойлсон. Үүнд Сэлэнгэ аймгийн Мандал, Баянгол сумдууд, ялангуяа Түнхэл баг багтсан байна.

байна.

## Хүснэгт 2.2 Төслийн нөлөөллийн бүс

Суурин	Төрөл	Хүн ам	Гацууртын төслийн талбай хүртэлх зай	Бороогийн төслийн талбай хүртэлх зай
Баруунхараа	Сумын төв нь Баянгол	5,594 (1675 өрх)	Сайжруулсан замаар 76.4 км-т	Сайжруулсан, хатуу хучилттай замаар 32.8 км-т
Зүүнхараа	Сумын төв нь Мандал	25,693 (7382 өрх)	Сайжруулсан замаар 39.2 км –т	Сайжруулсан замаар 49.4 км-т
Түнхэл баг	Мандал сумын багийн төв	3,234 (923 өрх)	Сайжруулсан шороон замаар ойролцоогоор 70 км -т (Зүүнхараагаар дамжин явбал) / сайжруулаагүй замаар 18 км-т (Балж голын дагуу явбал)	Сайжруулсан шороон замаар 90 км-т (Зүүнхараагаар дамжин явбал)
Хөдөөгийн малчин өрх	Улирлын чанартай нүүдэлдэг, хагас суурин айл өрхүүд	49 (18 өрх)	Янз бүр (<1 -с 100+км хүртэл)	Янз бүр (<1 -с 100+км хүртэл)

## 2.4 ХУВИЛБАНУУД

### 2.4.1 Төслийн хувилбарууд

Төсөл боловсруулах явцад судалсан боломжит хувилбаруудад замын чиглэл, ажиллах хүчний зохион байгуулалт ба Гацууртын төслийн талбайн усны менежментийн арга орж байв.

#### 2.4.1.1 Замын чиглэл

Сонгосон замын чиглэл нь Сентеррайин Бороо – Гацуурт хоорондын замын төсөвлөсөн гурав дахь чиглэл бөгөөд энэ нь дараах газрын хажуугаар дайран өнгөрнө. Үүнд, Бурхант уулын давааны өмнөд хэсгээр Зуун модны хөндий өнгөрч Тахилт уулын даваа өнгөрсний дараа Ноён уулын өвөр энгэр ба Хөх билүүтийн хөндийгөөр дайран өнгөрч Гацууртын уурхайн талбайд хойд талаас хүрнэ.

Замын БОНБНУ-ий эхний тайланд (2004 онд боловсруулсан) Гацууртын уурхайн талбайд өмнө зүгээс нь хүрэх (Бурхант уулын даваагаар давж, Зуун Модны хөндийд хүрэн Гацууртын уурхайн талбай баруун талаас нь очих зам) замын чиглэлийг тодорхойлжээ. Гэвч өтгөн ой дундуур замын барилгын ажил гүйцэтгэхэд бэрхшээлтэйн улмаас энэ чиглэлийг орхиж Бурхантын давааг өмнөд хэсгээр нь тойрч, Зуун модны хөндийгөөр өнгөрөн Тахилт уулын даваагаар давж, Ноён уулын

<sup>10</sup> Нийгмийн нөлөөллийн үнэлгээнд дараах асуудлыг үнэлсэн: төслийн шууд болон шууд бус бүх нийгмийн нөлөөлөл ба төслийн үйл ажиллагааны мөчлөгийн холбогдох үе шатууд ба Төслөөс шууд болон шууд бус хамааралтай боловч төслийн бүрэлдэхүүн хэсэг бус үйл ажиллагаа буюу байгууламжтай холбоотой үүсэх нийгмийн асуудлууд бөгөөд Төсөл хэрэгжиж буй учраас үүсэх буюу Төсөлд эрсдэл учруулж болзошгүй асуудлыг авч үзсэн.



хойд хэсгээр Хөх Билүүтийн хөндийгөөр дайран өнгөрч Гацууртын уурхайн талбайд хойд талаас нь хүрэх чиглэлээр<sup>11</sup> өөрчилсөн.

Гэвч, археологийн судалгааны үр дүнд энэхүү чиглэлийг өөрчилсөн. Сентерра нь Монгол Улсын Их сургуультай 2005<sup>12</sup> онд хамтарч замын чиглэлийн дагуу судалгаа явуулсан ба үүний үр дүнд 57 археологийн олдворыг илрүүлсэн байна. Эдгээр 57 олдворын аль нь ч Гацууртын уурхайн тусгай зөвшөөрөлтэй талбай, Сентерраийн бусад тусгай зөвшөөрөлтэй талбайд илрээгүй. Хамгийн эцсийн байдлаар сонгосон чиглэлийг археологийн олдворуудод үзүүлэх нөлөөллөөс зайлсхийхийн тулд сонгосон байна.

#### **2.4.1.2 Холбогдох байгууламжууд**

Бороо болон Гацууртын төслийн талбайн холбогдох байгууламжууд болох кемп, захиргаа, засварын газрын хувилбаруудыг судалсан. Төслийн өртөг зардлыг үр ашигтай зарцуулаж, байгаль орчин, нийгмийн нөлөөллийг хамгийн бага хэмжээнд барих зорилгоор Гацууртын уурхайн талбайд аль болох бага үйл ажиллагаа явуулах хэрэгтэй гэж тогтсон. Жишээ нь, баяжуулах үйлдвэрт ашиглагдах аюултай бодис зөвхөн Бороогийн уурхайн талбайд өнөөгийн баталгаатай нөхцөлд байгааг<sup>13</sup> хангах зорилгоор Гацууртын уурхайн талбайд баяжуулахын ямар ч байгууламжийг барихгүй. Түүнээс гадна, ажиллагсдын байрыг Гацууртын уурхайн талбайд огт барихгүй байгаа нь байгаль орчин, нийгмийн нөлөөлөлд өртөгч эмзэг бүлэгт үзүүлэх нөлөөллийг хязгаарлах юм. Үүнд, төслийн ажиллагсад ойр орчмын малчин өрхүүд болон соёлын өвүүдтэй аливаа харилцаанд орох явдал багтана.

#### **2.4.2 Төсөл хэрэгжихгүй байх хувилбар**

Гацууртын төсөл нь 2009 оноос хойш хэрэгжүүлж эхлэх зөвшөөрөл авах шийдвэр гаргуулахаар Монгол Улсын Засгийн газраар хэлэлцүүлүүлж байна. Сентерра нь Төсөл хэрэгжүүлэхгүй байх хувилбарын тооцож үзсэн бөгөөд үүнд хувь эзэмшигчдийн эдийн засгийн шаардлагыг Төсөл хангахын тулд Засгийн газартай роялтийн хувь хэмжээг тохирох хэлэлцээр дээр үндэслэж шийдвэр гаргах болон улсад төлөх роялти, төлбөр тогтоох цаашдын хэлэлцээрүүд орно.

<sup>11</sup> Замын БОНБНУ 2006.

<sup>12</sup> Ноён уулсын Гацууртын хөндийн археологийн судалгааны тайлан. Мандал сум, Сэлэнгэ аймаг: 2005 оны 6 дугаар сарын 16-24 ба 2005 оны 8 дугаар сарын 12-19 (МУИС-н Археологи, Антроплогийн тэнхим).

<sup>13</sup> 2013 оны 7 дугаар сарын 1-ий байдлаар, Бороогийн уурхайн ханган нийлүүлэлтийн сүлжээ нь алт үйлдвэрлэх үйл ажиллагааны цианид үйлдвэрлэх, тээвэрлэх ба ашиглах үйл ажиллагааны олон улсын цианидын менежментийн кодын дагуу аттестатлагдаж гэрчилгээ авсан.

### **3. ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧИН**

#### **3.1 ОРШИЛ**

Энэхүү бүлэгт тус төслийн үйл ажиллагаанд хамаарах нийгмийн хууль тогтоомжийн шаардлагууд болон хууль эрх зүйн орчны талаар авч үзлээ. Олон улсын холбогдох шаардлага, Монгол Улсад мөрдөгдөж буй бодлого, эрх зүйн орчин болон Монгол Улсын нэгдэн орсон зарим олон улсын гэрээ конвенцуудыг энэ бүлэгт багцлан оруулав.

Энэхүү нийгмийн суурь судалгааг Монгол Улсын хууль тогтоомж ба олон улсын нийгэм, эдийн засгийн шаардлагууд тэр дундаа Европын сэргээн босголт хөгжлийн банкны (ЕСБХБ) шаардлагатай нийцүүлж боловсруулсан ба энэ бүлэгт дараах сэдвүүдийг авч үзлээ. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Нийгэм, байгаль орчны хамгаалал, ажиллагсдын эрүүл мэнд, аюулгүй байдал, хөдөлмөрийн удирдлага, зохион байгуулалт болон өмчийн эрхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомжуудын талаар;
- Хүрээлэн буй орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын талаарх стандартууд;
- Монгол Улсын нэгдэн орсон холбогдох олон улсын гэрээ хэлэлцээрүүд;
- Төслийн санхүүжилттэй холбоотой шаардлагууд тус тус орно.

#### **3.2 МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, ЭРХЗҮЙН ОРЧИН**

##### **3.2.1 Хууль тогтоомжийн тойм**

Сүүлийн хэдэн жилийн турш Монголын уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн менежменттэй холбоотой хууль эрхзүй ба захиргааны байгууллагуудын орчин байнга өөрчлөгдөж шинэчлэгдсээр байна. Энэ нь ихэвчлэн сонгуулийн циклтэй холбоотой улс төрийн тогтворгүй байдлаас улбаатай бөгөөд 4 жил тутамд шинээр Засгийн газрыг байгуулж, улмаар шинэ сайдуудыг томилдог нь гадаадын хөрөнгө оруулалт, зохицуулалтанд эзлэх Монголын улсын төрийн өмчийн хэмжээ ба үүрэг хариуцлагын талаар олон нийтийн дунд ширүүн маргаан үүсгэж байна.

Улсын хэмжээнд уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн хууль тогтоомжийг Уул уурхайн яам (УУЯ) ба түүний харьяа агентлаг Ашигт малтмалын газар (АШГ), Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам (БОНХАЖЯ), мөн Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ) зэрэг Засгийн газрын байгууллагууд зохицуулан хэрэгжүүлдэг. Бусад агентлагууд нь дээрх хууль, тогтоомжийн хэрэгжилтэнд нэмэлт үүрэгтэйгээр оролцдог.

УУЯ ба БОНХАЖЯ сүүлийн таван жилийн хугацаанд нилээд шинэчлэгдсэн боловч эдгээр яамдын хүний нөөцийн чадавхи нь уул уурхайн салбарын огцом өсөлтөөс үл шалтгаалан тогтонги байсаар байна. БОНХАЖЯ (хуучнаар Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)) нь өөрийн байгаль орчны үнэлгээний үйл явц, журмаар дамжуулан уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчин ба байгалийн нөөцөд үзүүлэх нөлөөллийг хянадаг. Мөн уурхайн нөхөн сэргээлтийг зохицуулах, байгаль орчны стандартуудыг тогтоох, гүний усны нөөцийн менежментийг хариуцах үүрэгтэй. Улсын хэмжээнд тус яам нь судалгааны ажлууд явуулах үүрэг өгч, газрын зураг хийх,

байгаль орчны асуудлуудын талаар олон нийтэд мэдээлж, байгаль орчинтой холбоотой хандивлагчдын тусламжийг зохицуулах үүргийг хүлээдэг. Түүнчлэн тус яам нь аймаг, сумдад шаардлагатай үед туслалцаа үзүүлж, аудит, хуулийн биелэлт ба байгаль орчны нөхөн сэргээлтийн төлөв байдалд хяналт тавидаг. Уул уурхайн яам нь эрдэс баялгийн бодлого, хууль тогтоомжтой холбоотой хариуцлага үүрдэг бол Ашигт малтмалын газар нь тусгай зөвшөөрөл олгох, зохицуулах үүрэгтэй.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг 2002 онд үүсгэн байгуулсан бөгөөд одоогийн байдлаар ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа ба байгаль орчны асуудлаар холбогдох хяналт шалгалт тавих үүрэгтэй. Үүсгэн байгуулагдахдаа Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь янз бүрийн салбарын яамдуудад тархсан байсан 13 агентлагуудын үүрэг хариуцлагыг орлон гүйцэтгэхээр болсон юм. Ингэж нэгтгэн зохион байгуулагдсан нь хяналт шалгалтын үйл ажиллагаанд нэгдмэл арга зүйтэй болох, давхардлаас зайлсхийж, бизнесийн үйл ажиллагааг удаашруулдаг олон хяналт, шалгалтын тоог бууруулах зорилготой байв.

Улсын түвшний байгууллагуудаас гадна, аймаг, сумын байгууллагууд нь уул уурхайн салбарын менежментэд оролцдог. Жишээлбэл аймгийн байгаль орчны байцаагч нарыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар буюу БОНХАЖЯ томилдог бөгөөд аймгийн Засаг даргатай хөдөлмөрийн гэрээ хийн ажилладаг байна.

### **3.2.2 Монгол Улсын Үндсэн хууль**

Монгол Улс 70 жилийн түүхтэй коммунист дэглэмийг халсны дараахан 1992 онд парламентын засаглал бүхий ардчилсан улс болсон бөгөөд 1992 оны 1 дүгээр сарын 13-нд Монгол Улсын Үндсэн хуулийг шинэчлэн баталсан. Энэхүү хуулинд Монгол Улсын иргэдийн эдлэх эрх, эрх чөлөөг хуульчилсан бөгөөд 16.2-т “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” хэмээн заасан байдаг. Мөн түүнчлэн, Засгийн газрын бүтэц, түүний эрх мэдэл, үүрэг хариуцлагын хуваарилалтын талаар хуульчилсан байна.

### **3.2.3 Засгийн газар**

#### **3.2.3.1 Засгийн газар болон орон нутгийн удирдлага**

Монгол Улс нь парламентын засаглалтай орон бөгөөд төрийн эрх барих дээд байгууллага нь Засгийн газар байна гэж заасан байдаг. Засаг захиргааны нэгжүүдийг төв Засгийн газраас томилсон эрх бүхий албан тушаалтнууд удирдана. Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурал нь парламентын нэг танхимтай бөгөөд 76 УИХ-ын гишүүдээс бүрдэнэ.

Монгол Улсад Улсын Их Хурлыг оролцуулаад дөрвөн шатны захиргаа байдаг. Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана. Улаанбаатар хот нь Монгол Улсын нийслэл бөгөөд Засгийн газрын анхан шатны нэгж нь баг, хороод юм. Нийт 21 аймаг, 330 сумд, 1588 баг, Улаанбаатар хот 9 дүүрэг, 152 хороодтой.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь Үндсэн хуульд зааснаар нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжих бөгөөд захиргааны нэгж бүр өөрийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (ИТХ)-тай байна. Засаг

дарга нь сум, аймгийн түвшинд Засгийн газрыг орон нутагт төлөөлөх төлөөлөл бөгөөд орон нутгийн иргэд нь Иргэдийн төлөөлөгчдийн хурлыг сонгодог, харин ИТХ-ын гишүүд нь ИТХ-ын Тэргүүлэгчдийг сонгодог.

Монгол Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн байх бөгөөд бүх ард түмний сонгуулиар сонгогдоно. Улсын Их хуралд олонхийн саналаар сонгогдсон нам болон эвслээс Ерөнхий сайдад нэр дэвшигчийг тодруулж Ерөнхийлөгч томилдог.

### **3.2.3.2**      Шүүх тогтолцоо

#### **Үндсэн хуулийн шүүх (Үндсэн хуулийн цэц):**

Монгол Улсын Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуулийг зөрчсөн аливаа асуудлыг авч хэлэлцэн шүүнэ. Энэ нь бие даасан, хараат бус байгууллага бөгөөд Үндсэн хуулинд захирагдана.

#### **Дээд шүүх:**

Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд хувь хүн, албан байгууллагын зүгээс хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан хүсэлтэд Монгол Улсын хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах эрхтэй.

#### **Аймаг, нийслэлийн шүүх (давж заалдах шатны шүүх), сум буюу сум дундын, дүүргийн шүүх (анхан шатны шүүх):**

2002 онд батлагдсан Монгол Улсын шүүхийн тухай хуулинд шүүхийн тогтолцооны бүтэц, бүрэлдэхүүний талаар заасан байдаг. Мөн шүүхийн байгууллага болон шүүгчдийн хараат бус байдлын талаар дурдсан байна. Шүүхийн үндсэн тогтолцоо нь Улсын дээд шүүх (хяналтын шатны шүүх), аймаг, нийслэлийн шүүх (давж заалдах шатны шүүх), сум буюу сум дундын, дүүргийн шүүх (анхан шатны шүүх)-ээс бүрдэнэ.

### **3.2.4**      **Хууль тогтоомж**

Төслийн нийгэм, эдийн засгийн асуудалтай холбогдолтой хуулийг авч үзсэн болно.

#### **3.2.4.1**      Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

#### **Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (1998 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөж, 2001, 2006, ба 2012 онуудад нэмэлт өөрчлөлт оруулсан):**

Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай бие даасан хууль 1998 оноос хойш үйлчилж байгаа бөгөөд тус хуулинд 2001 ба 2006 онуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. “Монгол Улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох” тухай Улсын Их Хурлын 38 дугаар тогтоол (2009) ба “Монгол Улсын Засгийн газрын хөтөлбөр” аль алинд нь заасны дагуу Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд шинэчлэл хийх шаардлага гарсан тул 2012 оны 5 дугаар сарын 17-нд уг хуулийн шинэчилэн найруулга Улсын Их Хурлаар батлагдсан байна. Хуулийн хэрэгжилтийг хангах механизм болон байгаль орчны менежментийн арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулахын тулд шинэчилсэн энэхүү Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль нь үнэлгээний хамрах хүрээг өргөжүүлж, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБУ)-г гүйцэтгэх, хэрэгжүүлэх, хянах гэх мэт үнэлгээний шат бүрт холбогдох журмын зохицуулалтыг тусгаж өгсөн. Өөрчлөлт орсон бусад зүйлсд БОНБУ-ий журмуудыг сайжруулах, байгаль орчны стратегийн үнэлгээ, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ ба дүйцүүлэн

хамгааллын асуудал орж байна. Хуулийн олон нийтэд чиглэсэн гол заалтад олон нийтийн оролцооны журам багтах бөгөөд үүнд Төсөл хэрэгжүүлэгч нь янз бүрийн хэлэлцүүлгийн ажлуудыг зохион байгуулж хэлэлцүүлгийн явцад гаргаж тавьсан асуудал, санаа бодлыг төслийн боловсруулалтын шатанд тусгах ёстой хэмээх шаардлагыг тусгасан. БОНБУ-ний тайланг хянаж батлах нь Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны үүрэг бөгөөд ашгийн бус зорилгоор түгээмэл тархацтай ашигт малтмалыг орон нутгийн мэдлийн нутаг дэвсгэрт ашиглах тохиолдолд тухайн аймгийн Засаг даргын Тамгын газар дээрх тайланг батлах үүргийг хүлээхээр тус хуулинд заажээ.

#### 3.2.4.2 Байгаль орчны хамгаалал

**Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995 оны 5 дугаар сараас хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн, 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан):**

Энэхүү хууль нь хүрээлэн буй орчны удирдлагын тогтвортой хөгжлийн зарчмуудыг хуульчилсан ба холбогдох бусад хуулиудад тусгагдсан зарчмууд, тавигдах шаардлагуудыг өргөн хүрээнд тодорхойлсон цогц хууль юм. Мөн, байгалийн баялаг ашигласны төлбөрийн тогтолцоог нэвтрүүлж, төрийн захиргааны олон янзын түвшинд хүрээлэн буй орчны зохицуулалтын талаар хүлээх хариуцлагыг энэ хуулиар хуваарилан заасан байна.

Гацууртын төсөл нь Монгол орны төвийн бүс нутаг буюу Сэлэнгэ аймагт байрладаг. Төслийн үйл ажиллагаа нь Сэлэнгэ аймаг болон сумын удирдлагаас боловсруулж баталсан тогтоол, зохицуулалт хийгээд Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

#### 3.2.4.3 Газар, Газар ашиглалт ба Газар чөлөөлөлт

**Монгол Улсын Үндсэн хууль**

Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна. Үндсэн хуулийн дагуу Монгол Улсын иргэд газар өмчлөх эрхтэй боловч өмчлөх эрхийг гадаадын иргэн, байгууллагад шилжүүлэх эрхгүй. Харин газрыг түрээсээр ашиглуулж болно.

**Газрын тухай хууль (2003 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн, 2006 оны 12 дугаар сарын 22-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан)**

Энэхүү хуулинд "эзэмших", "ашиглах", "газар" хэмээх нэр томъёог дараах байдлаар тодорхойлсон:

- "газар" гэж газрын гадаргуу, түүний дээрх агаарын орон зайг хэлэх боловч ашигт малтмал ордоггүй;
- "газар өмчлөх" гэж тухайн газрыг захиран зарцуулах эрхтэйгээр хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг;
- "газар эзэмших" гэж газрыг гэрээнд заасан зориулалт, нөхцөл, болзлын дагуу хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг;

"газар ашиглах" гэж хуулиар зөвшөөрсөн хүрээнд газар өмчлөгч, эзэмшигчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу газрын аль нэг ашигтай чанарыг нь гаргаж хэрэглэхийг; En

- “газар ашиглах эрхийн гэрчилгээ” гэж гадаад улсын хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн газар ашиглах эрхийг баталгаажуулсан баримт бичгийг тус тус хэлнэ.

Хуульд заасан нөхцөл, журмын дагуу газрыг үндсэн зориулалтаар нь үр ашигтай, зохистой эзэмших, ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, хяналт шинжилгээ хийх талаар тус хуулинд заасан. Хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдалд харшлах, байгаль орчны тэнцвэрт байдлыг алдагдуулах аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх зэрэг зарим үйл ажиллагааг хориглосон заалтууд байдаг. Гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын иргэн, харъяалалгүй хүн тодорхой зориулалт, хугацаа, болзол, гэрээний үндсэн дээр хууль тогтоомжийн дагуу газар ашиглагч байж болно. Газар ашиглалтын төлөвлөгөө болон газар чөлөөлөхтэй холбогдох асуудлыг мөн Газрын тухай хуулиар зохицуулна. Төрийн захиргааны төв байгууллага нь газар ашиглах талаарх төрөөс явуулах нэгдсэн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах болон газар ашиглах, түүний ангиллыг тодорхойлох саналыг Засгийн газарт оруулах эрх эдэлдэг. Мөн түүнчлэн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын эрх үүргийг мөн тус хуулиар зохицуулсан байна. Гацууртын төслийн улмаас ашиг сонирхол нь хөндөгдсөн гуравдагч этгээдтэй холбогдох газар ашиглах, өмчлөх эрхийн талаарх зохицуулалтыг агуулдаг тул Газрын тухай хууль чухал ач холбогдолтой.

#### **Газрын хэвлийн тухай хууль (1988 оны 11 дүгээр сарын 29-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж байна)**

Монгол Улсын Газрын хэвлийн тухай хуулийн зорилт нь тогтвортой хөгжлийн зарчмуудад нийцүүлэн газрын хэвлийг ашиглах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Монгол Улсын Үндсэн хуулинд газрын хэвлий нь гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна гэж заасан байдаг. Газрын хэвлийг ашиглуулахаар олгох ба хэрэв ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөлтэй бол тодорхой шаардлагын дагуу тухайлбал, үр ашигтай хөрсийг хамгаалах, хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагаа явуулах, олборлосон хайрга, бусад материалыг зохистой ашиглах эрхийг тус хуулиар зөвшөөрнө.

##### **3.2.4.4 [Ашигт малтмалын тухай хууль](#)**

Уурхайн бүр мөсөн болон түр хаах үйл ажиллагаатай холбогдох асуудлыг зохицуулах хууль тогтоомжийн талаар 2.4.12 хэсэгт дэлгэрэнгүй дурдав.

#### **Ашигт малтмалын тухай хууль (2006 оны 6 дугаар сарын 26-ны өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж байна)**

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмал эрэх, хайх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

“Ашигт малтмал” гэж геологийн хувьсал, өөрчлөлтийн дүнд газрын гадаргуу, түүний хэвлийд үүсч бий болсон, аливаа хэрэгцээнд ашиглаж болох байгалийн байдлаараа байгаа эрдсийн хуримтлал хэмээн тодорхойлсон бөгөөд газрын тос, байгалийн хий багтдаггүй.

Монгол Улсын газрын гадаргуу болон түүний хэвлийд байгалийн байдлаараа оршиж байгаа ашигт малтмал төрийн өмч мөн бөгөөд төр өмчлөгчийн хувьд ашигт малтмал эрэх, хайх, ашиглах эрхийг бусад этгээдэд олгох эрхтэй. Түүнчлэн, улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь



тогтоосон “стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг” эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр эзэмшиж болох бөгөөд уг хэмжээг төрөөс оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлно. Улсын төсвийн хөрөнгөөр эрэл, хайгуул хийж нөөцийг нь тогтоосон ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тухайн ордыг ашиглах гэрээгээр тодорхойлно.

Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашиглавал төрийн оролцооны хэмжээ 50 хүртэл хувьтай байж болох бөгөөд уг хэмжээг төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлно.

Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад татвар төлөгч хуулийн этгээдэд олгоно.

Ашигт малтмалын нэг тусгай зөвшөөрлийг зөвхөн нэг л удаа хуулийн этгээдэд олгох боловч нэг хуулийн этгээдэд олгох хайгуулын тусгай зөвшөөрлийн тоог хязгаарлахгүй. Нэг тусгай зөвшөөрлөөр олгох хайгуулын талбайн хэмжээ 25 гектараас багагүй, 400 мянган гектараас ихгүй байна.

Ашиглалтын өмнөх үйл ажиллагааг хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон төрийн захиргааны байгууллагын хооронд байгуулсан ашиглалтын өмнөх гэрээгээр зохицуулна. Хайгуулын ажлын явцад ашигт малтмалын орд тогтоогдож түүний нөөцийг нь улсын бүртгэлд бүртгэснээс хойш ордыг ашиглах зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, уурхай барьж байгуулах, бүтээгдэхүүн гаргах хүртэлх үеийг уурхайн ашиглалтын өмнөх үйл ажиллагааны үе гэж үзнэ.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана. Дээр дурьдсан асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран олон нийтийн хэлэлцүүлэг явуулж болно. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон түүний байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий төлөөлөгчийг иргэд дундаасаа сонгон ажиллуулж болно.

#### **3.2.4.5**      [Соёлын өв](#)

##### **Монгол Улсын Үндсэн хууль**

Соёлын өвийн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр бүлгийн 7 дугаар зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасан байдаг.

##### **Соёлын өвийг хамгаалах тухай хууль (2001 оны 6 дугаар сарын 8-ны өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж байна, 2004 онд нэмэлт өөрчлөлт оруулсан)**

Энэ хууль нь биет ба биет бус соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж, хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулах, өмчлөх, эзэмших, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Соёлын чухал ач холбогдол бүхий зүйл гэдэгт эртний хүний оромж, отог бууц, оршин сууж байсан ул мөрийг хадгалсан соёлт давхарга, ашигт малтмал олборлож, боловсруулж, үйлдвэрлэл эрхэлж байсан газар, булш хиргисүүр, бунхан, оршуулга, тахилгын газар, хөшөө чулуу, хадны сүг зураг, бичээс зэрэг археологийн дурсгалууд багтана. Уг хуулиар “биет” болон “биет бус” өвийг ялган авч үзсэн ба биет өв гэдэгт барилга болон эртний үеийн олдворууд зэрэг хөдөлгөөнгүй байгууламж орно.

Ард түмний билэг авъяас, мэдлэг, түршлага, эрдэм ухаан, ур чадварын тодорхой илэрхийлэл болон биет бусаар өвлөгдөн уламжлагдаж ирсэн түүх, угсаатны судлал, ардын билэг, зан үйл, ур хийц, арга барил, дэг сургууль, урлаг, шинжлэх ухааны ач холбогдол бүхий оюуны соёлын үнэт зүйлийг соёлын биет бус өвд хамааруулна. Түүх, соёлын дурсгалт зүйлийг түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдлоор нь хосгүй үнэт, үнэт, ердийн гэж зэрэглэх ба эдгээрийг хамгаалах ажлыг үндэсний, бүсийн (аймгийн) болон орон нутгийн (сумын) түвшинд тогтоож өгсөн байдаг. Түүх, соёлын дурсгалт зүйлийг тухайн орон нутагт нь хадгалах зарчим баримтална.

Үүнээс гадна соёлын болон түүхэн үнэ цэнэ бүхий газруудад хамгаалалтын бүс байгуулах эрхийг энэ хуулиар Засгийн газарт олгожээ. Хамгаалагдсан бүсэд нөлөөлөл үүсгэж болох үйл ажиллагаа явуулахыг хориглодог. Ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах, зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгоход түүх, археологийн мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, түүнээс зөвшөөрөл авна гэж энэ хуулийн 17-р зүйлд заасан байдаг. Эдгээр үйл ажиллагаанууд нь археологийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр үргэлжлэх ёсгүй. Газрын хэвлийг ашиглах явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл газрын хэвлийг ашиглагч нь ажлаа зогсоож энэ тухай сум, дүүргийн Засаг даргап мэдэгдэхийг шаарддаг бөгөөд боломжтой тохиолдолд тэрхүү газрыг хамгаалалтанд авах ёстой. Судалгааны ажил дууссаны дараа малталт хийсэн газрыг сумын Засаг дарга хариуцах ёстой. Түүхэн, шинжлэх ухааны болон соёлын үнэ цэнэтэй зүйлс байрлах газрын газар дээрх болон доорх зүйлсийг улсын хамгаалалтанд авдаг бөгөөд энд байгаа археологийн олдворууд улсын өмч болдог.

### **Соёлын өвийн талаарх нэмэлт заалтууд**

Соёлын өвийг хадгалах, хамгаалах талаарх заалтууд дараах хууль, тогтоомжид мөн тусгагдсан байдаг.

- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал;
- Монгол Улсын үндэсний гадаад бодлогын үзэл баримтлал;
- Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого;
- Төрөөс соёлын талаар баримтлах бодлого;
- Соёлын тухай хууль;
- Эрдэнэсийн сангийн тухай хууль;
- Иргэний хууль;
- Эрүүгийн хууль;
- Төрийн албан ёсны хэлний тухай хууль;
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль;
- Соёлын өвийн тухай Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвенцүүд.

Дээр дурдсан хууль, тогтоомжоос гадна соёлын өвийг хадгалах, хамгаалах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас дараах үндэсний хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж байна. Үүнд:

- Монгол бичгийн үндэсний хөтөлбөр (1995);
- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах үндэсний хөтөлбөр (1999-2005);
- Ардын уламжлалт урлагийг дэмжих үндэсний хөтөлбөр (1999-2006);
- “Морин хуур, уртын дуу” үндэсний хөтөлбөр (2005-2014);
- Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр (2005-2008);
- “Монгол хөөмий” хөтөлбөр (2007-2014);
- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр (2008-2015) орно.

### Олон улсын стандарт ба конвенцүүд

Соёлын өвийн тухай Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гол конвенцүүдийн доор жагсаав.

#### Хүснэгт 3.1 Соёлын өвийн тухай Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвенцүүд

Олон улсын конвенц	Батлагдсан газар орон, огноо	Монгол Улсын нэгдэн орсон огноо
Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай конвенц	Гааг. 1954.05.14	1964
Соёлын үнэт зүйлсийн хууль бүс экспорт, импорт, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай конвенц	Парис. НҮБ-ын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО)-ын Ерөнхий бага хурлын 16 дугаар чуулганаар 1970.11.14-ний өдөр баталсан.	1991
Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах конвенц	Парис. ЮНЕСКО <sup>14</sup> -гийн Ерөнхий бага хурлын 17 дугаар чуулганаар 1972.11.16-ны өдөр баталсан.	1990
Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенц	Парис. ЮНЕСКО-гийн Ерөнхий бага хурлын 32 дугаар чуулганаар 2003.10.17-ны өдөр баталсан.	2005
Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай конвенц	Парис. ЮНЕСКО-гийн Ерөнхий бага хурлын 33 дугаар чуулганаар 2005.10.20-ны өдөр баталсан.	2005

<sup>14</sup> НҮБ-ийн Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага

#### 3.2.4.6 [Эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа](#)

##### **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (1998 оны 5 дугаар сарын 7-ны өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа)**

Олон нийтийн эрүүл мэндийн талаарх тухай энэхүү хууль нь иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах эрхийг хангах, үүнтэй холбогдуулан иргэд, бизнес эрхлэгчдийн эрх үүргийг тодорхойлох, тэдгээрт холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Энэхүү хуульд дараах үйл ажиллагаануудыг зохицуулсан журмуудын дагуу үйл ажиллагаа явуулахыг шаарддаг:

- Өрхийн ундны болон ахуйн хэрэгцээний усны хангамж;
- Агаарын чанар, тухайлбал тоосжилт, бохирдол, утаат манан;
- Хөрсний эрүүл ахуй, хог хаягдлыг зайлуулах, бохир усны цэвэрлэх байгууламж, усны хоолой болон ариун цэврийн байгууламж;
- Эмнэлгийн хог хаягдал зайлуулах, цацраг идэвхт болон химийн хорт бодис;
- Нийтийн хэрэгцээнд орон сууцны болон бусад зориулалтын барилга байгууламжуудыг барих;
- Химийн хорт бодисыг ашиглах, цацраг идэвхийг ионжуулах;
- Доргилт, цахилгаан соронзон орон зай болон радио давтамжийн нөлөөллийн улмаас дуу чимээ бүхий үйл ажиллагааг хүрээлэн буй орчинд явуулах;
- Хүнсний үйлдвэрлэл, хэрэглээ;
- Бүтээгдэхүүн, технологийн импорт орно.

Энэхүү хуулийн хүрээнд бизнесийн байгууллагын хүлээх үүргийг дараах байдлаар тодорхойлсон:

- Бизнестэй холбогдох дүрэм журмын хэрэгжилтийг хангах, тухайлбал хүний нөөцийг сургаж чадавхжуулах; болон
- Хүний эрүүл мэнд, байгаль орчинд хортой нөхцлийн талаар холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагад мэдээлэх.

#### 3.2.4.7 [Хөдөлмөрийн тухай хууль](#)

##### **Монгол Улсын хөдөлмөрийн тухай хууль (1999 оны 5 дугаар сарын 14-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж, 2012 оны 12 дугаар сарын 13-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан):**

Энэ хууль нь хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажилтан, ажил олгогчийн нийтлэг эрх, үүрэг, хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн ганцаарчилсан ба хамтын маргаан, хөдөлмөрийн нөхцөл, удирдлага, хяналт болон хууль тогтоомж зөрчөгчид хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж хүйсийн харилцан эрх тэгш байдлыг хангахад оршино.

Энэхүү хуулийн дагуу ажилтан нь аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хөдөлмөрийн нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, өөрөө болон төлөөллийн байгууллагаараа дамжуулан эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор эвлэлдэн нэгдэх, тодорхой нөхцөлд ажил хаялт зарлах, тэтгэвэр, тэтгэмж авах, нийгмийн даатгал, нас

барсны тэтгэмж, мөн хөдөлмөрийн ба хамтын гэрээ, хэлэлцээрт заасан бусад эрх, хөнгөлөлт эдлэх эрхтэй.

Хөдөлмөрийн харилцаанд үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, боловсрол шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлах, хязгаарлах, давуу байдал тогтоохыг хориглосон хэдий ч тодорхой төрлийн ажилд эмэгтэйчүүдийг хөдөлмөр эрхлэхийг хориглосон асуудлыг дүрэм журмаар тусгайлан зохицуулсан байдаг. Жирэмсэн болон хүүхэдтэй эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахыг хатуу хориглосон бөгөөд эмэгтэйчүүд жирэмсний амралт авах эрхтэй. Гурваас доош насны хүүхэдтэй эхчүүдэд хүүхэд асрах хугацааны чөлөө авах эрх олгох бөгөөд чөлөө авсан ажилчдад ажил олгогч ажилдаа эргэн орох бололцоог олгоно. Ажиллагсдын эрхийг хамтарсан гэрээ хэлэлцээрээр хамгаалах бөгөөд эдгээр хэлэлцээрийг мэргэжилтнүүд, эдийн засгийн салбар болон бүс нутаг, сум, аймаг, нийслэлийн түвшинд тус тус байгуулна. Хөдөлмөрийн аливаа хамтын маргааныг Хөдөлмөр эрхлэлтийн арбитрын шүүхээр зохицуулах бөгөөд хувь хүний хөдөлмөрийн маргааныг шүүх болон комиссоор дамжуулан зохицуулна. Ажил олгогчийн ажлын байранд ажиллаж буй гэрээт гүйцэтгэгч ажилтнуудын өмнөөс ажил олгогчийн үүрэх хариуцлагын тухайд Хөдөлмөрийн тухай хуулинд "ажилтан" ба "ажил олгогч" хооронд үүсэх харилцааг зохицуулсан байдаг. Ажилтан гэдгийг энэ тохиолдолд (Хөдөлмөрийн хуулийн 3.1.2) ажил олгогчтой "хөдөлмөрийн гэрээ" байгуулан ажиллаж байгаа иргэнийг гэж ойлгоно. Үүнийг гэрээт гүйцэтгэгч нарыг хамруулан ойлгож болно учир нь эдгээр нь тодорхойлолтынхоо дагуу ажил олгогчоос ажил олгож байгаа билээ.

### 3.2.5 Монгол Улсын байгаль орчин, эрүүл мэнд болон аюулгүй ажиллагааны стандартууд

**Error! Reference source not found.**-д Гацууртын төслийн үйл ажиллагаанд мөрдлөг болгон 6 аримтлах холбогдох байгаль орчин, эрүүл мэнд болон аюулгүй ажиллагааны стандартуудыг нэгтгэн харуулав. Эдгээр стандартууд нь холбогдох үйл ажиллагааг Монгол Улсын төрөөс тогтоосон шаардлагад нийцүүлэн явуулах нөхцлийг хангана.

#### Хүснэгт 3.2 Гацууртын төслийн үйл ажиллагаанд хамааралтай нийгэм, байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны стандартууд

No	Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны талаарх стандартууд
1	MNS (ISO) 5667-1:2002 Усны чанар. Дээж авах. 1 дүгээр хэсэг. Дээж авах хөтөлбөр боловсруулах заавар
2	MNS 900:2005 Байгаль орчин. Хүний эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйд тавигдах шаардлагууд, чанарын хяналт.
3	MNS (ISO) 5667-2:2001 Усны чанар. Дээж авах. 2 дугаар хэсэг. Дээж авах аргачлалын заавар.
4	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээж авах. 3 дугаар хэсэг. Дээж авах бэлтгэл болон хадгалалтын зөвлөмж.
5	MNS (ISO) 5667-4:2001 Усны чанар. Дээж авах. 4 дүгээр хэсэг. Байгалийн болон хиймэл нуураас дээж авах заавар
6	MNS (ISO) 5667-10:2001 Усны чанар. Дээж авах. 10 дугаар хэсэг. Хаягдал уснаас дээжлэлт хийх удирдамж.
7	MNS (ISO) 5667-11:2000 Усны чанар. Дээж авах. 11 дүгээр хэсэг. Гүний уснаас дээж авах зөвлөмж.
8	MNS (ISO) 5667-13:2001 Усны чанар. Дээж авах. 13 дугаар хэсэг. Хаягдал ус, бохир ус цэвэрлэх байгууламжаас дээжлэлт хийх заавар.



No	Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны талаарх стандартууд
9	MNS (ISO) 11083:2001 Байгаль орчин. Усны чанар. Хром тодорхойлох (VI)- 1,5-дифенилкарбазид ашигласан спектрометрийн арга.
10	MNS 5032:2001 Усны чанар. Хортой хүнд металл тодорхойлох. Рентген флуоресценцийн арга.
11	MNS (ISO) 11923:2001 Усны чанар. Умбуур бодисыг шилэн судалт шүүлтүүрээр шүүж тодорхойлох.
12	MNS 4943:2000 Усны чанар. Хаягдал ус.
13	MNS (ISO) 4889:1999 Усны чанар. Усны цахилгаан дамжуулах чанарыг тодорхойлох.
14	MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага
15	MNS 4420:1997 Ундны зориулалттай ус. Мөнгөн ус тодорхойлох. Атом шингээлтийн спектрометрийн арга.
16	MNS 4430:2005 Ундны зориулалттай ус. Төмрийн агуулгыг тодорхойлох арга.
17	MNS 2573:1978 Байгаль орчны хамгааллын стандартын систем. Усан мандал. Усны чанарын үзүүлэлтүүд.
18	MNS 4431:2005 Ундны зориулалттай ус. Нитритын агуулгыг тодорхойлох арга.
19	MNS 4288:1995 Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи түвшинд тавих үндсэн шаардлага.
20	MNS 4217:1994 Ундны зориулалттай ус. Ундны усанд нитратын нийт агуулгыг тодорхойлох арга.
21	MNS 0899:1992 Унд ахуйн зориулалттай усны төвлөрсөн хангамжийн эх булгийг сонгох журам ба эрүүл ахуйн шаардлага.
22	MNS 3935:1986 Ундны зориулалттай ус. Хээрийн шинжилгээний аргад тавих ерөнхий шаардлага
23	MNS 3936:1986 Ундны зориулалттай ус. Хээрийн шинжилгээний аргачлалууд
24	MNS 3900:1986 Ундны зориулалттай ус. Амт, өнгө, үнэр, булингарыг тодорхойлох арга.
25	MNS 0017-1-1-10:1979 Ус ашиглалт, хамгаалалт. Нэр томьёо, тодорхойлолт
26	MNS 0017-1-1-14:1980 Усан мандал. Ус ашиглалтын ангилал. Ерөнхий шаардлагууд
27	MNS 4423:1997 Ундны зориулалттай ус. Хуурай үлдэгдлийг тодорхойлох арга
28	MNS 4079:1988 Усны чанарын нэр томьёо, тодорхойлолт.
29	MNS 0017-2-3-16:1988 Байгаль хамгаалал. Агаар мандал. Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам
30	MNS 3384:1982 Агаар мандал. Дээжлэлт хийх ерөнхий шаардлага.
31	MNS 3383:1982 Агаар мандал. Бохирдлын эх үүсвэр. Нэр томьёо, тодорхойлолт
32	MNS 4990:2000. Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдал. Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага
33	MNS 5885:2008 Агаарын бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага.
34	MNS (ISO) 4225:2001 Агаарын чанар. Нийтлэг үндэслэл. Тайлбар толь.
35	MNS 5365:2004 Агаарын чанарын ерөнхий асуудал. Нарийн ширхэгтэй тоосыг тодорхойлох арга.
36	MNS 0017-0-0-06:1979 Байгаль орчныг хамгаалах стандартын систем
37	MNS 3473:1983 Хүрээлэн буй орчин. Газар, газар ашиглалт, нэр томьёо, тодорхойлолт
38	MNS 5002:2000 Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдал. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
39	MNS 5003:2000 Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдал. Шуугиан хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага.
40	MNS 12.1.009:1985 Ажлын байрны аюулгүй байдал. Шуугиан. Орон сууц, иргэний барилгын шуугианы байж болох түвшин.
41	MNS 12.1.06:1988 Ажлын байрны аюулгүй байдлын стандарт систем. Хэт өндөр дуу. Аюулгүй байдалд тавигдах ерөнхий шаардлагууд.
42	MNS 12.4.005:1985 Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдал. Шуугианаас хамгаалах арга хэрэгсэл, аргачлал. Ангилал





No	Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны талаарх стандартууд
43	MNS 12.1.017:1988 Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдал. Хэт өндөр дуу. Ажлын байрны шуугианы даралт хэмжих аргачлал.
44	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлагууд
45	MNS-3384:82 Агаар мандал. Дээжлэлт хийхэд тавигдах ерөнхий шаардлагууд
46	MNS-4048:88 Агаар мандал. Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга.

Засгийн газрын тохируулагч агентлаг Стандартчилал хэмжилзүйн газар (СХЗГ) стандартуудыг боловсруулж батална. Монгол Улсын Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хууль 2003 онд батлагдсан ба стандартчилал, тохирлын үнэлгээний эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулна. Стандартуудыг олон улсын ISO стандартад нийцүүлж боловсруулсан бөгөөд дээрх хүснэгтэд MNS (ISO) хэмээн тэмдэглэсэн болно.

### 3.3 ОЛОН УЛСЫН СТАНДАРТУУД БА ЗЭЭЛДЭГЧДИЙН ШААРДЛАГУУД

#### 3.3.1 Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрүүд

Олон улсын гэрээнд гарын үсэг зурсан талууд тэдгээр гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор хууль тогтоомж боловсруулан баталдаг. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнүүдэд нийцүүлж Монгол Улсын Засгийн газар үндэсний хууль тогтоомжуудад зохих заалтуудыг тусгасан бөгөөд хэрэв Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө. Төсөлд холбогдох гэрээнүүдийн талаарх хураангуйг тайлангийн дараах хэсгүүдээс үзнэ үү.

##### 3.3.1.1 [Хөдөлмөрийн харилцаа ба ажиллагсдын эрх](#)

Монгол Улс нь Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-д 1968 онд анх гишүүнээр элсэн орсон ба ОУХБ-ын дараах конвенцид нэгдэн орсон. Үүнд:

- Албадан хөдөлмөр эрхлэлтийн тухай, 1930 (No. 29), 2005.03.15-нд нэгдэн орсон;
- Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай, 1948 (No. 87), 1969.06.03-нд нэгдэн орсон;
- Зохион байгуулах, хамтарсан хэлэлцээр хийх эрх, 1949 (No.98), 1969.06.03-нд нэгдэн орсон;
- Тэгш шан хөлс олгох тухай, 1951 (No. 100), 1969.06.03-нд нэгдэн орсон;
- Эхчүүдийг хамгаалах тухай (шинэчилсэн), 1952 (No. 103), 1969.06.03-нд нэгдэн орсон;
- Албадан хөдөлмөрийн тухай, 1957 (No. 105), 2005.03.15-нд нэгдэн орсон;
- Алагчилахгүй байх (ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай, 1958 (No. 111), 1969.06.03-нд нэгдэн орсон;
- Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай, 1964 (No. 122), 1976.11.24-нд нэгдэн орсон;
- Газар доор буюу уурхайд ажиллагсдын насны доод хязгаарын тухай, 1965 (No. 123) Насны доод хязгаар: 18 нас, 1981.12.03-нд нэгдэн орсон;

- Үйлдвэрийн газарт ажиллагсдын төлөөлөгчдийн эрхийг хамгаалах болон тэдэнд олгогдох бололцооны тухай, 1971 (No. 135), 1996.10.08-нд нэгдэн орсон;
- Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай, 1973 (No. 138) Хөдөлмөрийн насны доод хязгаар: 15 нас, 2002.12.16-нд нэгдэн орсон;
- Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний хэрэгжилтийг дэмжих гурван талт зөвлөлдөөний тухай, 1976 (No. 144), 1998.08.10-нд нэгдэн орсон;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, 1981 (No. 155), 1998.02.03-нд нэгдэн орсон;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай, 1983 (No. 159), 1998.02.03-нд нэгдэн орсон.

#### 3.3.1.2 Мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл

**Ази, Номхон далайн бүс нутгийн мал аж ахуйн үйлдвэрлэл, эрүүл мэндийн хороог байгуулах гэрээ (2007 оны 5 дугаар сарын 8-ны өдрөөс Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байна)**

Тус хороо нь мал аж ахуйн хөгжлийг дэмжих, үндэсний болон бүс нутгийн мал аж ахуйн хөтөлбөрүүдийг боловсруулах, мал аж ахуйн үйлдвэрлэлийг салбарын хэмжээнд дэмжих, жижиг фермер, хөдөө орон нутгийн иргэдийн хоол хүнсний тэжээллэг чанарын түвшин болон амьдралын стандартыг дээшлүүлэх зорилтуудыг тавьсан байна.

#### 3.3.1.3 Аюултай бодис

**Зарим аюултай химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх урьдчилан мэдээлж зөвшилцөх журмын тухай Роттердамын конвенц (2001 оны 3 дугаар сарын 8-ны өдрөөс Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байна):**

Энэхүү конвенц нь хүний эрүүл мэнд болон байгаль орчинд аюултай химийн бодисыг тус конвенцид нэгдэн орсон орнуудын зүгээс хориглосон болон онцгой хязгаарласан пестицит болон үйлдвэрийн химийн бодистой холбогдох асуудлыг хамаарна. Түүнээс гадна урьдчилан мэдээлж зөвшилцөх сайн дурын журамд хавсаргасан химийн бодисын жагсаалтын нэрсийг конвенцэд нэгдэн орсон талууд боловсруулсан бөгөөд энэхүү жагсаалтад тулгуурлан химийн бодисыг импортлохтой холбогдсон шийдвэрүүдийг мэдээлэх боломжтой юм.

**Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенц (Монгол Улсад 2004 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөс мөрдөгдөж байна):**

Энэхүү конвенц нь хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинг удаан задардаг органик бохирдуулагчийн био-хуримтлалд өртөн эрсдэх, эх газрын болон далай тэнгисийн экосистемд хуримтлагдахаас хамгаалах зорилготой.

#### 3.3.1.4 Журмууд

**Монгол Улсын нутагт археологи, палеонтологийн хайгуул, малтлага, судалгаа хийх журам:**

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар бүлгийн 27.8-д “Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, газар тариалан эрхлэх, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулна” гэж заасан. Энэ хуулийн заалтыг биелүүлэх журам боловсруулсан бөгөөд археологийн судалгаа нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 05 сарын 18-ны өдрийн 222 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт “Монгол Улсын нутагт археологи, палеонтологийн хайгуул, малтлага, судалгаа хийх журам”-ын дагуу явагдах ёстой.

**Хог хаягдал булах, устгах зориулалтын байгууламж, төвлөрсөн цэгийн төрөл, тэдгээрт тавигдах шаардлага, хог хаягдал булах, устгах үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны тухай журам:**

Хог хаягдлын тухай хуулийн 8.4.1-д зааснаар хог хаягдлын талаар сум, дүүргийн Засаг дарга нь сум, дүүргийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу хог хаягдлыг устгах цэг болон хог хаягдал хадгалах түр цэгийн байршлыг тогтоох бүрэн эрхтэй. Түүнээс гадна сумын Засаг дарга нь байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ буюу байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний дүгнэлтэнд үндэслэж газар ашиглах зөвшөөрлийг өгөх бөгөөд үүнийг газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулж тухайн газар барилга байгууламж барихад тохиромжтой эсэхийг шийднэ. Улмаар Хог хаягдал булах, устгах зориулалтын байгууламж, төвлөрсөн цэгийн төрөл, тэдгээрт тавигдах шаардлага, хог хаягдал булах, устгах үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны тухай журам нь Байгаль орчны сайдын 2006 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 404 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан.

**Агаарын чанарын мэдээлэл гаргах журам:**

Агаарын тухай хуулийн 9.1.4-д зааснаар аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу дотоод хяналтыг явуулах үүрэгтэй. Түүнээс гадна аж ахуйн нэгж байгууллага нь агаарын бохирдлын эх үүсвэрийн дотоод хяналтын болон холбогдох бусад тайлан, мэдээг мэргэжлийн албаны орон нутаг дахь салбарт гаргаж өгөх ёстой (Агаарын тухай хуулийн 9.1.5). Энэ тохиолдолд агаарын чанарын асуудал эрхэлсэн мэргэжлийн алба нь Ус, цаг уур, орчны шинжилгээний газар бөгөөд түүний орон нутаг дахь салбар нь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв юм. Аж ахуйн нэгж байгууллагууд нь агаарын чанарын мониторингийн мэдээг Байгаль орчны сайдын 1996 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Агаарын чанарын мэдээлэл гаргах журам”-ын дагуу бэлтгэж хүргүүлэх үүрэгтэй.

**Аж ахуйн нэгж байгууллагын дотоод хяналт шалгалтын журам:**

Энэ журмыг Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 311 дугаар тогтоолын хавсралтаар баталсан. 3.7.11-р дугаар заалтад дотоод хяналт шалгалтаар хүний амь нас, эрүүл мэнд, нийгэм болон хүрээлэн буй орчны аюулгүй байдалд шууд буюу шууд бусаар ноцтой аюул, хор хохирол учруулж болохуйц нөхцөл байдал үүссэн нь тогтоогдвол түүнийг арилгах арга хэмжээг нэн даруй авч, эрх бүхий байгууллагад мэдэгдэх шаардлагатай хэмээн

тусгасан байдаг. Түүнчлэн 4.1.2-д аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөлөлд хяналт шалгалт хийхээр заажээ.

**Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам:**

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын энэхүү журмыг 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-05 дугаар тушаалын хавсралтаар баталсан. Тус журмын 1.6-р зүйлд зааснаар тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байгаль орчны төлөв байдлын өөрчлөлт, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх, сөрөг нөлөөллийн эрчим, цар хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг тогтоох ажиглалт, хэмжилт, дээжлэлт хийх байршил, давтамж, хариуцах этгээд, шинжилгээний арга, шаардагдах зардлыг тооцож тусгана.

**Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам:**

Энэхүү журмыг Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 308 дугаар тогтоолын хавсралтаар баталсан ба журмын зорилго нь бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг зохицуулах явдал юм. Энэ журам нь ус, цацраг идэвхт элемент агуулсан хүдэр, газрын тос, байгалийн хийгээс бусад төрлийн ашигт малтмалыг бичил уурхайн хэлбэрээр олборлох үйл ажиллагаанд хамаарна. Сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал гаргасан шийдвэрээ иргэдэд зарлан мэдэгдэж, хэрэгжилтэд нь хяналт тавих үүрэгтэй (2.4-р зүйл). Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь дүрэм, заавар, удирдамж, маягт, аюулгүй ажиллагааны дүрмийг баталж нөхөрлөлийн гишүүдэд байгаль орчны болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар чадваржуулах сургалт явуулж, дэмжлэг үзүүлэх эрх, үүрэгтэй байна.

### **3.4 ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ШААРДЛАГУУД**

Энэхүү нийгмийн нөлөөллийн үнэлгээг Төсөлд санхүүгийн зээл олгох магадлалтай олон улсын санхүүгийн байгууллагууд (ОУСБ)-ын холбогдох нийгмийн шаардлагуудыг (2014 оны 5 дугаар сар) хангах зорилгоор мөн гүйцэтгэсэн юм. Түүнээс гадна энэхүү бичиг баримтыг боловсруулахад ашигласан удирдамж бичиг баримтуудад дараах орно:

- Нийгмийн нөлөөллийн үнэлгээ: Төслийн нийгмийн нөлөөллийн үнэлгээ (2015 оны 4 дүгээр сар) ба менежмент хийх заавар. Олон улсын нөлөөллийн үнэлгээний холбоо
- Орон нутгийн хөгжлийн удирдамж (2012). Олон улсын уул уурхай ба металлын зөвлөл
- Хөгжиж буй зах зээлд бизнес явуулж буй компаниудад зориулсан оролцогч талуудыг татан оролцуулах, сайн туршлагыг нэвтрүүлэх гарын авлага (2007 оны 5 дугаар сар). Олон улсын санхүүгийн корпораци
- Сайн туршлагын тэмдэглэл, Хувийн хэвшлийн салбарын нийгмийн олон янз байдлын асуудлыг авах үзэх нь (2003 оны 12 дугаар сар). Олон улсын санхүүгийн корпораци

Европын сэргээн босголт хөгжлийн банк нь сайн банкны үйл ажиллагаа явуулах зарчмаа дагаж мөрдөх үндсэн тохиролцооны дагуу “өөрсдийн төрөл бүрийн үйл ажиллагаандаа байгаль орчинд халгүй, тогтвортой хөгжлийг дэмждэг”. ЕСБХБ-наас энэхүү хөгжлийг хэрхэн дэмжих талаарх арга замуудыг ЕСБХБ-ны Байгаль орчны бодлогод тусгасан байдаг (Бодлого). ЕСБХБ-наас тус бодлого буюу энэхүү бодлогод тусгагдсан үндсэн зарчим, зорилтуудыг хэрэгжүүлэх талаар авсан нэг тодорхой алхам нь тус банкнаас санхүүжүүлсэн бүхий л төслүүдийн байгаль орчин, нийгэм эдийн засгийн үнэлгээг санхүү, эдийн засаг, хууль эрх зүй ба техникийн дэвшилт судалгааны хамтаар хийх, мөн төслийг банкны Захирлуудын зөвлөлөөр батлагдсаны дараа зохих мониторингийн ажлыг хийх нөхцлийг хангасан явдал юм.

ЕСБХБ нь анхны Байгаль орчны бодлогоо 1991 онд баталсан бөгөөд түүнээс хойш уг бодлогыг шинэчлэн баталсаар яваа билээ. 2014 оны 5 дугаар сард тус бодлогыг дахин шинэчилж Байгаль орчин, нийгмийн бодлого болгож өөрчилснөөр тус банкнаас санхүүжүүлж буй Төсөл нь нийгэм, байгаль орчны хувьд тогтвортой байдлыг хангах үүргээ дахин баталсан юм. Тус бодлогод зааснаар ЕСБХБ-наас санхүүжилт авахын тулд дараах 10 Гүйцэтгэлийн шаардлагыг хангасан байх ёстой:

- ГШ 1: Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, асуудлын үнэлгээ ба менежмент
- ГШ 2: Хөдөлмөр эрхлэлт ба ажиллах нөхцөл
- ГШ 3: Нөөцийн үр ашигтай хэрэглээ, бохирдлоос сэргийлэх ба хянах
- ГШ 4: Эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа
- ГШ 5: Газар чөлөөлөх, албадан нүүлгэн суурьшуулах ба эдийн засгийн хохирол амсах
- ГШ 6: Биологийн олон янз байдлыг хадгалах, байгалийн амьд нөөцийг тогтвортой ашиглах
- ГШ 7: Нутгийн уугуул иргэд
- ГШ 8: Соёлын өв
- ГШ 9: Санхүүгийн зуучлагчид
- ГШ 10: Мэдээллийг танилцуулах, талуудын оролцоо

### **3.5 СЕНТЕРРА КОМПАНИЙН БОДЛОГО**

Сентерра компани нь 2004 оноос хойш Торонтогийн хөрөнгийн бирж дээр албан ёсоор бүртгэгдсэн бөгөөд Гацууртын төслийг 100% бүрэн эзэмшдэгийн хувьд бүхий үйл ажиллагаандаа Баримтлах зарчмыг удирдлага болгодог. Дээд шатандаа Сентерра компани нь Захирлуудын ёс зүйн дүрмийг баримталдаг бөгөөд компанийн засаглалыг үр дүнтэй хэрэгжүүлэх мөн Зөвлөлийн үйл ажиллагаа удирдлагуудаас хараат бус байх зорилгоор тодорхой туршлага, журмуудыг авч хэрэгжүүлсэн.

Тус компанийн зорилго бол хувьцаа эзэмшигч нарт ашигтайгаар ажиллахын зэрэгцээ явуулж буй үйл ажиллагаандаа компанийн нийгмийн хариуцлагын тэргүүлэх туршлагыг хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа юм. Үүнд дараах аргаар хэрэгжүүлнэ:

- Өөрийн үйл ажиллагаа явуулж буй орнуудын Уул уурхайн салбарын ил тод байдлын санаачлагад (УУСИТБС) нэгдэх: Монгол ба Киргизстан;
- Дэлхийн Тайлагналын санаачлагаар дамжуулан олон нийтэд танилцуулах. Үүндээ G3 индекс ба Уул уурхай ба металлын хавсралтыг ашиглах;
- Дэлхийн Алтны зөвлөлийн зөрчилдөөнгүй алтны стандартыг авж хэрэгжүүлэх; мөн
- Алт олборлогч ба цианидын ачаа илгээгч/тээвэрлэгчийн хувьд Цианидын менежментийн олон улсын стандарт болох Цианидын кодоод нэгдэн орсон.

Компанийн үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн иргэдтэй харьцах харилцаанд удирдлага болгодог компанийн бодлогод Сентерра Гоулд компанийн хариуцлалгын стандартууд (2012 оны төсөл хэлбэрээр буй) орно. Сентерра Гоулд компанийн хариуцлалгын стандартуудад гол асуудлуудын талаар хүлээх хариуцлагыг<sup>15</sup> тодорхойлсон байдаг ба Сентеррагийн төслүүд ба үйл ажиллагаанууд нь тодорхойлсон эрсдэл бүхий бүс ба бизнесийн хөдөлгөгч хүч зэргийг үнэлж доорхи Хүснэгт 3.3-д заасан үүрэг хариуцлагыг биелүүлэхийг шаарддаг.

### Хүснэгт 3.3 Сентеррагийн компанийн хариуцлагын стандартууд

#### Эрүүл, аюулгүй ажиллах орчин

**Ажилтны эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа** Ажилтан, гэрээт гүйцэтгэгч, борлуулагч ба зочин бүр гэртээ аюулгүй, эрүүл харих болно. Компани нь бусад компаниуд дундаа ажлын байрны аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйг хангаж, хор аюулыг тэглэх тал дээр тэргүүлэгч байх үүрэг хүлээсэн.

#### Байгаль орчны хариуцлага

**Байгаль орчин ба нийгмийн нөлөөллийн үнэлгээ** Төслийн талбайн байгаль орчин, нийгмийн өнөөгийн нөхцөл байдлыг ойлгох явдал нь төслийн төлөвлөлт, амжилттай хэрэгжилтийн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Сентерра нь Төсөлтэй холбогдолтой шийдвэр гаргахдаа БОННУ-ий хүрээнд олж авсан үнэн бодит мэдээлэл дээр тулгуурладаг ба энэ нь компанид байгаль орчин, нийгмийн болзошгүй нөлөөллийг бууруулахын хамт олон нийтэд нийгмийн ашиг түс хүргэх боломж олгоно.

**Биологийн олон янз байдал ба экосистемийн үйлчилгээ** Сентерра нь биологийн олон янз байдлын хадгалалт хамгаалалтад дэмжлэг үзүүлдэг бөгөөд уурхайн үйл ажиллагааны бүхий л хугацаанд газар ашиглалтын төлөвлөлтийн цогц арга хэмжээг авж хэрэгжүүлдэг. Бид орон нутгийн оролцогч талуудтай хэлэлцэж бидний үйл ажиллагаанаас биологийн олон янз байдал ба экосистемийн үйлчилгээнд үзүүлэх нөлөөллийг бууруулж, арилгахын тулд, буюу боломжтой тохиолдолд, орон нутгийн экосистемийг сайжруулж, холбогдох эдийн засгийн хөгжлийг дэмжих боломжийг тодорхойлж ажилладаг.

**Усны менежмент** Сентерра нь үйл ажиллагаа нь усны хүртээмжээс хамааралтай, усны нөөц ба экосистемийн хувьд мэдрэг бүс нутагт газарт үйл ажиллагаа явуулдаг. Бид орон нутгийн усны нөхцөл байдал, эрэлт хэрэгцээний ойлголттой болж усны нөөцийн аюулгүй, үр ашигтай, тогтвортой менежмент ба хамгааллыг хангах үүрэг хүлээсэн.

**Хүдрийн хаягдал ба эрдсийн хаягдлын менежмент** Сентерра нь байгаль орчинд хариуцлагатай байдлаар үйл ажиллагаа явуулж, эрдсийн хаягдал, баяжуулах үйлдвэрийн хаягдал ба холбогдох усны нөлөөллийг бууруулахын хамт ойр орчмын олон нийт болон усны хагалбарыг хамгаалдаг.

**Хаалтын төлөвлөгөө** Сентерра нь нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтнүүд болон оролцогч талуудтай уурхайн бүсийг газар ашиглалтын боломжит хэлбэрт оруулж нөхөн сэргээх, ус, хөрсийг хамгаалах, амьдрах чадвартай баялаг экосистем болгож, олон нийтэд урт хугацааны эерэг үр нөлөө авчрах уурхайн хаалтын төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх талаар хамтарч ажилладаг.

<sup>15</sup> Сентеррагийн стандартуудын ном, төсөл 2012 оны 4 дүгээр сар.





## Уур амьсгалын өөрчлөлт ба эрчим хүч

Сентеррагийн үйл ажиллагааны зорилго нь уурхайн ашиглалт болон хаалтын дараах уур амьсгалын нөхцөл байдлын талаархи ойлголт болон төлөвлөлт дээр суурилдаг. Эрчим хүч, ус зэрэг нөөц баялагийн ашиглалт маань хүрээлэн буй орчинд нөлөөлж болзошгүй учир бид өөрсдийн хэрэглээг багасгаж, ашиглаж буй байгалийн нөөцөнд үзүүлэх нөлөөллийг бууруулах замаар ажилладаг.

## Компанийн хариуцлага

### Оролцогч талуудын зураглал ба оролцоог хангах

Ашиг сонирхол бүхий олон нийтгүйгээ итгэлцэл дээр суурилсан харилцаа үүсгэх нь Сентеррагийн бизнесийн амжилтанд нэн чухал юм. Энэ нь бидэнд төслийн талбайд үйл ажиллагаа явуулахад орон нийтийн дэмжлэг авах боломж, хайгуулын төсөл хэрэгжүүлэх боломж зэргийг олгож, оролцогч талуудын хэрэгцээг ойлгон, хариу арга хэмжээ авахад бидэнд тусалдаг. Бид тодорхой арга барилын дагуу оролцогч талуудыг тодорхойлж, тэднийг уурхайн үйл ажиллагааны бүхий л хугацаанд татан оролцуулах үүрэг хүлээнэ. Ингэхдээ, соёл, хэлний хэрэгцээ ба харилцааны ил тод байдал дээр анхаарах болно.

### Газар ашиглах боломж ба нүүлгэн суурьшуулалт

Сентерра нь газар ашиглах тал дээр шийдвэр гаргахад орон нутгийн иргэдийн чухал үүрэг гүйцэтгэдэг гэдгийг ойлгож, уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө чөлөөтэй, мэдээлэлтэй шийдвэр гаргах нутгийн уугуул иргэдийн эрхийг хүлээн зөвшөөрч байна. Бид өөрсдийн үйл ажиллагааны бүс орчмын орон нутгийн иргэдийг нүүлгэн суурьшуулах явдлыг багасгаж, нүүлгэн суурьшуулалтын нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөлөл, байгаль орчны нөлөөллийг бууруулах зорилгоор нөлөөлөлд өртсөн иргэдтэй хамтарч ажилладаг.

### Олон нийтийн хөгжил

Сентерра нь өөрийн бизнесийн амжилтыг бидний үйл ажиллагаатай холбоотой орон нутгийн иргэдийн сайн сайхан байдал, нийгэм эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх бидний чадвартай холбоотой гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Бид үйл ажиллагаагаараа дамжуулан Сентеррагийн үйл ажиллагаанаас хамааралтай байхаас зайлсхийхийг зэрэгцээ эдийн засгийн хөдөлгөгч хүч болж, тогтвортой амжиргааг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулахыг зорьж байна.

### Хүний эрх ба аюулгүй байдал

Сентерра нь олон улсад тунхагласан хүний эрхийн хамгааллыг хүндэтгэж дэмждэг ба хүний эрх зөрчсөн явдалд оролцохгүй байхыг зорьдог<sup>16</sup>.

### Бичил уурхай

Сентерра нь бичил уурхайн үйл ажиллагааг нийгэм эдийн засгийн хөгжилд чухал хувь нэмэр оруулж байгааг хүлээн зөвшөөрдөг. Үүний хажуугаар, тэдгээр нь эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, орон нутгийн иргэдийн аюулгүй байдал, байгаль хамгаалал, ажлын байрны нөхцөл ба засгийн газрын ашиг орлого зэрэг чиглэлээр орон нутгийн иргэдийг ихээхэн эрсдэлд оруулж байна. Сентерра нь үйл ажиллагаандаа уул уурхайн сайжруулсан стандартыг хэрэгжүүлдэг ба бид орон нутгийн төлөөлөл, засаг захиргаатай орон нутгийн иргэдийн тогтвортой хөгжлийг дэмжих талаар хамтарч ажилладаг.

## Шударга байдал

### Бизнесийн ёс зүй ба ил тод байдал

Сентерра нь ёс зүйтэй, ил тод байдлаар үйл ажиллагаа явуулж, өөрсдийн үйл ажиллагаандаа үнэнч шударга байдал ба үл ялгаварлах хандлагыг хэрэгжүүлж оролцогч талуудад итгэл үнэмшил төрүүлдэг.

<sup>16</sup> Сентерра Гоулд Инк нь Дэлхийн Алтны зөвлөлийн Зөрчилдөөнгүй алтны стандартыг (2013 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар хөндлөнгийн аудитын дүгнэлтээр мөрдөгдөж буйг баталгаажуулсан) авч хэрэгжүүлсэн. Үүнд *Хүний эрх ба Аюулгүй байдлын сайн дурын зарчмууд* буюу Сайн дурын зарчмуудын шаардлагуудтай нийцсэн системүүд орно.

## 4. АРГАЗҮЙ

### 4.1 НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮЙЛ ЯВЦЫН ТОЙМ

Нөлөөллийн үнэлгээ нь санал болгож буй төслөөс орон нутгийн хүн амын нийгэм, эдийн засаг, эрүүл мэндийн орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийг тодорхойлж, үнэлдэг. Тэрээр сөрөг нөлөөллөөс зайлсхийж, бууруулах, мөн эерэг боломжийг нэмэгдүүлэх зорилгоор нөлөөлөл бууруулах арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлдэг.

Үнэлгээний ерөнхий аргазүйг доорх Зураг 4.1-т тоймлон үзүүлээ. Энэ нь ННҮ яаж олон нийтийн хувьд үр дүнг тодорхойлох, зайлсхийх, бууруулах болон сайжруулах тал дээр анхаарч байгааг онцлон харуулж байгаа бөгөөд төслийн эхэнд нэг удаагийн хийх ажил гэхээсээ илүү төслийн нийт хугацаанд тогтмол давтагдах үйл явц юм.

Үнэлгээний аргазүйг дараах байдлаар нэгтгэв.

#### Зураг 4.1 Үнэлгээний аргазүй

##### **Ерөнхий үнэлгээ**

Бүлэг 2 Төслийн танилцуулга хэсэгт нөлөөлөлд өртөгч болон байгалийн нөөцөд үзүүлж болзошгүй ноцтой нөлөөлөлд хүргэх магадлалтай үйл ажиллагаа болон нөлөөллийн зэргийг тодорхойлсон. Төслийн төлөвлөгөө, шийдвэр гаргалт ба төслийг сайжруулах үйл ажиллагааг Төсөл хэрэгжүүлэх явцад тодорхойлогдсон нөлөөллүүдийн зохицуулалтыг үнэлэхдээ өөрчлөн сайжруулдаг.

##### **Оролцогч талуудыг татан оролцуулах**

Бүлэг 5-д тодорхойлсноор, төслийн төлөвлөлтийн явцад хууль эрхзүйн шаардлагыг хангаж, оролцогч талуудын саналыг харгалзан үзсэн, одоогийн байгаа мэдээ баримтын эх сурвалж, шинжээчдийг тодорхойлсон зэргийг баталгаажуулах үүднээс үнэлгээний үйл ажиллагааны явцын турш үргэлжилнэ.

##### **Суурь мэдээлэл цуглуулах**

Бүлэг 6-д тайлбарласнаар, төслийн талбай, ойр орчмын бүсийн өнөөгийн төлөв байдал ба хууль эрхзүйн шаардлагуудыг тогтоож, хянаж үзэх, болзошгүй нөлөөлөлд өртөгч тал ба байгалийн нөөцийг тодруулна.

##### **Нөлөөллийн үнэлгээ ба нөлөөллийг бууруулах**

Үнэлгээний тодорхой шалгуурын дагуу тодорхойлсон нөлөөлөлд өртөгч болон байгалийн нөөцөд үзүүлж болзошгүй нөлөөллийн зэрэг, эрчмийг урьдчилан тооцож үнэлэх; урьдчилж таамагласан аливаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах буюу нөхөн төлөх болон эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг боловсруулж танилцуулах, мөн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авсны дараах үлдэгдэл нөлөөллийн эрчмийн талаар мэдээлнэ. Энэхүү үе шатыг Бүлэг 7-д тайлбарласан.

##### **Нэгтгэл**

Менежментийн төлөвлөгөөний хүрээнд тодорхой хугацаа, хариуцлагын дагуу хэрэгжүүлэх үүрэг даалгавар болгон ашиглах нөлөөллийг бууруулах арга хэмжээг Төсөлд нэгтгэх зохион байгуулалттай арга зүйг боловсруулна.

##### **Тайлагналт**

Техникийн бус хураангуйг багтаасан нөлөөллийн үнэлгээний үр дүнг танилцуулна.

### 4.2 НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ (ННҮ) ҮЕ ШАТ

#### 4.2.1 Ерөнхий үнэлгээ

Ерөнхий үнэлгээ нь үнэлгээний цар хүрээ, хугацаа, анхаарах зүйлсийг тодорхойлж, нөлөөлөлд өртөх магадлалтай этгээдийг тогтоож, нөлөөллийн үр дүнд авч болзошгүй арга хэмжээг тогтоосноор үнэлгээ, менежментийн дараагийн үе шатуудын үзүүлэлтүүдийг тогтооно. Ерөнхий үнэлгээ нь үнэлгээний зорилгыг тодорхойлж, үнэлгээний явцад шаардлагатай суурь материалыг

тодорхойлохоос эхэлнэ. Судлагдах шаардлагатай төслийн үйл ажиллагаа нь (техникийн хамрах хүрээ), хамрагдах ёстой газар зүйн бүс (орон зайн хамрах хүрээ), Төсөл хэрэгжих цаг хугацаа (цаг хугацааны хамрах хүрээ) зэргийг тодорхойлно. Гол оролцогч талууд, өөр нэмэлт сонголтуудыг тогтоосон байна.

ННҮ-ний **техникийн хамрах хүрээг** Төслийн танилцуулганд оруулсан байна. Техникийн хамрах хүрээ нь уурхай, түүнтэй холбогдолтой дэд бүтэц болон олборлолт, барилга, ашиглалт ба уурхайн хаалттай холбоотой бусад холбогдох үйл ажиллагааг хамардаг. Төслөөс үзүүлж болзошгүй нөлөөлөл, холбогдох нийгэм, эдийн засгийн бүрэлдэхүүн хэсгүүдийг Суурь судлагаанд тодорхойлсон байна.

ННҮ -н **орон зайн хамрах хүрээ нь** төслийн нөлөөлөлд өртөж болох бүс нутгийг нарийвчлан харуулсан. Болзошгүй нөлөөллийн бүсийн нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал, нөлөөлөлд өртөгч, нөлөөлөл зэрэг нь өөрчлөгдөж болно. Анхдагч, хоёрдогч нөлөөлөлд өртөх тогтмол бус ажиллах хүч зэрэг асуудлыг мөн харгалзан авч үзсэн. Тодорхой нөөц/нөлөөлөлд өртөгчид үзүүлж болзошгүй нөлөөллийг тус бүрээр буюу нөлөөллийн бүлгүүдийн орон зайн хамрах хүрээг нөлөөллийн үнэлгээнд дэлгэрэнгүй тусгаж өгсөн.

Үнэлгээний **цаг хугацааны хамрах хүрээ** нь төслийн үе шатуудад дараах байдлаар тодорхойлогдсон байна:

- Төслийн барилгын үе шат;
- Төслийг ашиглалтад оруулах үе шат,
- Төслийн ашиглалтын үе шат; ба
- Төслийг татан буулгах үе шат.

Нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа нь төслийн барилгын үе шатанд эхэлж, ашиглалтын үе шаттай зэрэгцэн явахаар тусгасан болно.

#### **4.2.2 Талуудын оролцоо**

Хэлэлцүүлгийн гол зарчим нь холбогдох оролцогч талууд төслийн төлөвлөлтийн талаар бүрэн мэдээлэлтэй байх байдлыг баталгаажуулж, шаардлагатай үед оролцогч талуудын санал бодлыг харгалзан үзэж ННҮ-нд тусгахад оршино. Зорилго нь ННҮ-ний үйл явцийн найдвартай, ил тод байдлыг хангаж, асуудал гарвал бүрэн хэмжээнд харгалзан авч үзэн, ННҮ-ний үйл явцыг зохих түвшинд дэлгэрэнгүй байлгахыг зорино.

Олон нийттэй хийх хэлэлцүүлгийг Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу болон Сентеррагийн байнгын хэлэлцүүлэг хийх, оролцогч талуудыг татан оролцуулах шаардлагын дагуу (хэлэлцүүлгийн талаарх нарийвчилсан мэдээллийг ННҮ-ний 5-р бүлгээс харна уу) төслийн БОНБНҮ-ний үйл явцаар дамжуулан хийсэн. Хэлэлцүүлгийг төлөвлөж, Төсөлд тусгайлан зориулж боловсруулсан Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөөний хүрээнд хийж гүйцэтгэсэн.

#### **4.2.3 Суурь мэдээлэл цуглуулах**

Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын суурь танилцуулга нь төслийн нөлөөлөлд ихээхэн өртөх магадлалтай бүх өртөгч, байгалийн нөөцийн талаар мэдээлэл өгнө. Үүний зэрэгцээ, үнэлгээ хийхэд ашигласан суурь нөхцөлүүдийг тайлбарлаж, суурь мэдээллийн орхигдолын дүн шинжилгээ

хийхэд шаардлагатай байсан нэмэлт мэдээллийг хаанаас олж болох талаар тэмдэглэсэн. Суурь мэдээлэл нь дараах зорилгуудыг хангах нарийвчилсан мэдээлэл өгөх болно:

- Төслийн бүтээн байгуулалтанд өртөж болзошгүй бүсийн нийгэм, эдийн засгийн гол нөхцөл байдлыг тодорхойлох;
- Болзошгүй нөлөөллийг урьдчилан таамаглаж, үнэлэхэд шаардлагатай мэдээлэл өгөх;
- Нөлөөлөл бууруулах зохих арга хэмжээ боловсруулах талаар мэдээлэх; ба
- Ирээдүйн нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийг үнэлэх жишгийг тодорхойлж, түүнийг бууруулах арга хэмжээний үр ашгийг үнэлэх.

Суурь судалгаа нь дөрвөн түвшний мэдээллийг цуглуулсан – аймаг, сум, бага болон иргэд. Аймаг, сум, багийн түвшинд цуглуулсан мэдээлэл нь Түнхэл багт онцгой анхаарал хандуулж, Сэлэнгэ аймгийн Баянгол, Мандал сумдын эдийн засаг, нийгмийн гол шалгуур үзүүлэлтүүдийг харуулсан. 2015 оны 4 – 5-р саруудад хийсэн суурь судалгаа нь өрхийн асуулга, гол талуудтай хийсэн ярилцлага (ГТХЯ) болон зорилтот бүлгийн хэлэлцүүлэг (ЗБХ) зэргийг анхан шатны мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийхэд ашигласан. Өрхийн судалгаанд оролцуулахаар 400 айл өрхийг сонгосон. Суурин газрын өрхийн 1%, хөдөөгийн өрхийн 10% нь судалгааны хүн амын оновчтой төлөөллийг хангаж чадна гэж тодорхойлсон байна (суурь судалгааны аргачлалын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт А-с үзнэ үү). ГТХЯ-ыг нийт 32 хувь хүнтэй ярилцлага хийх зааварчилгааг ашиглан хийсэн. 7-10 хүнтэй, 13 зорилтот бүлгийн хэлэлцүүлгийг тодорхой сэдвээр хэлэлцүүлэг явуулах зааварчилгааны дагуу хийсэн. ГТХЯ болон ЗБХ-ийг нийгэм эдийн засгийн тодорхой сэдвийг гүнзгийрүүлэн судлах зорилгоор орон нутгийн иргэд, сумын албан хаагчид, бизнес эрхлэгчид, иргэний нийгмийн төлөөлөлтэй хийсэн болно.

Өрхийн асуулгаар цуглуулсан мэдээллийг нийгмийн судалгааны SPSS статистик шинжилгээний програм ашиглан боловсруулсан. Төслийн бүсийн одоогийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор их хэмжээний хоёрдогч мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийн, нягтлан шалгасан баримт бичгийн жагсаалтыг Хавсралт-аар хүргүүлсэн. Хавсралт А-д суурь судалгааны лавлах материал, Оролцогч талуудыг татан оролцуулах ба мэдээлэл цуглуулах төлөвлөгөө, Харилцаа холбооны протокол зэрэг суурь судалгааны арга зүйн талаар дэлгэрэнгүй мэдээлэл орсон.

#### 4.2.4 Болзошгүй нөлөөллийн үнэлгээ ба бууруулах арга хэмжээ

Нөлөөллийн үнэлгээний аргазүй нь тогтоогдсон нөлөөлөл, тэдгээрийн нийт үлдэгдэл ач холбогдолыг шинжих боломж олгодог. Төслийн нийгмийн нөлөөлөл, нөлөөллийг бууруулах санал болгож буй арга хэмжээнүүдийг Бүлэг **Error! Reference source not found.**-д тодорхойлсон.

Төлөвлөсөн нөлөөллийг үнэлэх аргачлал нь нөлөөллийн ерөнхий ач холбогдолоос хамааран нөлөөллийн шинж байдал, төрөл, өөрчлөгдөх боломжийн зэрэг, түүний цар хүрээ, нөөц / өртөгчийн шинж чанарын өөрчлөгдөх байдлыг харгалзан үздэг. Төлөвлөгдөөгүй нөлөөллийг "үр дагавар" гэж нэрлэдэг нөлөөллийн ач холбогдолыг ашиглан үнэлдэг ба магадлалын үзэл баримтлал, нөлөөлөл тохиолдсон магадлалыг харуулдаг. Аль ч тохиолдолд, нөлөөлөл бууруулахаас өмнөх болон дараах нөлөөллийн ач холбогдолыг үнэлдэг. Бууруулах арга хэмжээ авсны дараа үлдэх нөлөөллийг үлдэгдэл нөлөөлөл гэж нэрлэнэ.

Нөлөөллийн үнэлгээ нь дөрвөн асуултанд хариу өгдөг давтагдах үйл явц юм:

1. **Таамаглал** – төслийн улмаас орон нутгийн иргэдэд юу тохиолдох вэ?
2. **Үнэлгээ** – энэ нь үйл явдалд нөлөөлөх үү? Энэ нь хэр чухал, ноцтой вэ?
3. **Нөлөөлөл бууруулах үйл явц** – хэрэв энэ нь ноцтой бол, энэ тал дээр юу хийж болох вэ?
4. **Үлдэгдэл нөлөөлөл** – нөлөөлөл бууруулсаны дараа ноцтой хэвээр байна уу?

Хэрэв үлдэгдэл нөлөөлөл ноцтой байвал цаашид дахин нөлөөллийг бууруулах арга хээжээ авч болно, эсвэл нөлөөллийг эргэн үнэлж төслийн боломжит түвшин хүртэл бууруулах (ALARP).

#### 4.2.4.1 [Нөлөөллийг урьдчилан мэдэх](#)

Нөлөөллийн ач холбогдлыг тодорхойлоход шаардлагатай дараах хоёр үе шат байдаг:

- **Нөлөөллийн хэмжээ** нь; нөлөөлөл хэр зэрэг том, өргөн хүрээтэй, эсвэл үр ашгийн зэргийг харуулдаг. Нөлөөллийн цар хүрээ нь дараах олон асуудлуудаас бүрдэнэ:
  - Нөлөөллийн бүсийн хэмжээ (газарзүйн хамрах хүрээ, тархалт);
  - Нөлөөлөлд өртсөн хүмүүсийн тоо;
  - Нөлөөлөл тохиох магадлал; ба
  - Нөлөөллийн үргэлжлэх хугацаа, давтамж, өөрчлөгдөх боломж.
- **Нөлөөллийн шинж чанар;** нөлөөллийн шинж чанарыг дараах байдлаар тодорхойлсон:
  - Нарийн төвөгтэй, эсвэл ховор;
  - Нөлөөлөл бууруулж, менежмент хийх хүндрэлтэй эсвэл хялбар байдал;
  - Эргэж хуучин байдалдаа орох боломжгүй байдал;
  - Оролцогч талуудын хүлээн зөвшөөрөх байдал; ба
  - Өртөгчийн эмзэг мэдрэмтгий байдал.

Нийгмийн нөлөөллийн хувьд нөлөөлөлд өртсөн хүмүүсийн ойлголтийг анхаарч үзэх нь чухал. Нөлөөллийн ач холбогдолын үнэлгээ нь дээрх хоёр хувьсагчийн хосолсон бүтээгдэхүүн юм. Урьдчилан таамаглал нь зураг төслийн салшгүй нэг хэсэг болох сөрөг нөлөөлөл бууруулах арга хэмжээг тооцож авч үздэг. Таамаглал нь хамрах хүрээ, итгэлийн хязгаар, магадлалаар илэрхийлэгдэх нөлөөллийн тохиолдол, цар хүрээний аливаа тодорхой бүс байдлыг харгалзан үздэг.

#### 4.2.4.2 [Нөлөөллийн хэмжээ](#)

Нөлөөллийн хэмжээг тодорхойлохдоо олон тооны шалгуурыг ашигласан. Нөлөөллийг анхнаас нь тэдгээрийн шинж чанар, төрөл, эргэн өөрчлөгдөх боломж зэргийн дагуу ангилна. Шинж чанар нь эерэг буюу сөрөг байна, төрөл нь нөлөөлөл шууд, шууд бус, хоёрдогч буюу хуримтлагдсан эсэхээс хамаарна; мөн эргэн өөрчлөгдөх боломж нь нөлөөлөлд өртсөн нөөц/нөлөөлөлд өртөгч нөлөөлөлд өртөхөөс өмнөх байдалдаа эргэж буцаж орох чадавхийг илэрхийлэнэ. Эдгээр нэр томъёоны тодорхойлолтыг Зураг 4.2-д харуулав.

## Зураг 4.2 Нөлөөллийн шинж чанар, төрөл болон эргэн өөрчлөгдөх боломж

### Нөлөөллийн шинж чанар

- *Сөрөг* – суурь нөхцөлтэй харьцуулахад сөрөг өөрчлөлт гарч, хүсэмгүй хүчин зүйл шинээр бий болох (тухайлбал, төслийн бүсэд замын хөдөлгөөн нэмэгдэх).
- *Эерэг* – суурь нөхцөлтэй харьцуулахад сайжирч, хэрэгтэй хүчин зүйл шинээр бий болох (тухайлбал, эдийн засгийн үр ашиг).

### Нөлөөллийн төрөл

- *Шууд* – төслийн төлөвлөсөн үйл ажиллагаа, нөлөөлөлд өртөх орчин хоёрын хоорондын шууд харилцаанаас үүсэх нөлөөлөл (жишээ: дуу шуугиан нэмэгдэх)
- *Шууд бус* – төслийн улмаас үүссэн бусад үйл ажиллагааны нөлөөлөл (жишээ: тухайн бүсэд уурхайтай холбоотойгоор өөр бизнесууд бий болох)
- *Хоёрдогч* – хүрээлэн буй орчинтой харицахад үүсэх шууд буюу шууд бус нөлөөллийн улмаас үүсэх нөлөөлөл.
- *Хуримтлагдсан* – бусад нөлөөллүүдтэй хамт төслийн ижил төрлийн нөөц/нөлөөлөлд өртөгчдөд нөлөө үзүүлэх нөлөөллүүд (гуравдагч талын ирээдүйн давхацсан, эсвэл төлөвлөсөн үйл ажиллагааг багтаасан).

### Өөрчлөгдөх боломж

- *Өөрчлөгдөх боломжтой* – байгалийн нөөц/ нөлөөлөлд өртөгчдөд үзүүлэх нөлөөлөл нь төслийн үйл ажиллагааны дараа шууд эсвэл тодорхой хугацааны дараа арилах нөлөөлөл.
- *Өөрчлөгдөхгүй* – нөөц/ нөлөөлөлд өртөгчдөд үзүүлэх нөлөөлөл нь төслийн үйл ажиллагаа зогссоны дараа ч удаан хугацаагаар арилахгүй байх нөлөөлөл. Нөлөөлөл бууруулах арга хэмжээ авсан ч эргэж хуучин хэвэндээ буцаж орохгүй байх нөлөөлөл.

Зарим нэг нөлөөллийн өөрчлөгдөх цар хүрээг нь шалгуур үзүүлэлтэнд үндэслэн тодорхойлоход хүндрэлтэй, буюу шалгуур үзүүлэлт нь тогтоогдоогүй нөхцөлд мэргэжлийн дүгнэлтийг ашиглан үнэлэнэ.

Хүснэгт 4.1-д хэмжээ, хугацаа, эрчийг үнэлэн бага, дунд, их зэрэглэлээр нөлөөллийн хэмжээ ба мэдрэмтгий байдлыг харуулав. Нийгэм, эдийн засаг, нийгмийн болон эрүүл мэндийн нөлөөллийн хувьд нөлөөлөлд өртөгчийн мэдрэмтгий байдлын зэрэг нь хувь хүний өөрчлөлтөнд дасан зохицох чадвар, амьжиргаа, эрүүл мэндээ хамгаалах чадвар дээр тулгуурласан. Энэ үнэлгээнд "мэдрэмтгий" гэсэн нэр томъёог ашиглахдаа сонирхогч талуудын (буюу "оролцогчдын бүлэг") огцом өөрчлөлт, эдийн засгийн хямралыг даван туулах, тэвчин гарах чадвар гэж тодорхойлсон ойлголтыг тайлбарлах гэж хэрэглэсэн.

### Хүснэгт 4.1 Нөлөөллийн хэмжээ, мэдрэмжийн үнэлгээ

Үнэлгээ	Хэмжээний тодорхойлолт	Мэдрэмтгий байдлын тодорхойлолт
<b>Маш бага</b>	Нийгмийн суурь мэдээллээс бараг ялгагдахгүй, орон нутгийн иргэдэд сөргөөр ноцтой нөлөөлөхгүй, зөвхөн богино хугацаанд, тодорхой хэсэг газарт үзүүлэх нөлөөлөл.	Дасан зохицох шаардлагагүй
<b>Бага</b>	Богино хугацаанд тавгүй байдал үүссэн ч амьдралын хэв маяг, чанарт удаан хугацааны нөлөөлөл үзүүлэхгүй. Нөлөөлөлд өртөгчид өөрчлөлтөнд амархан дасан зохицож, амьдралын нөлөөлөлд өртөхөөс өмнөх хэв маягаа хадгалж чадна.	Нөлөөлөлд өртсөн нийгэм, эдийн засгийн хөрөнгө нь өөрийн нөөц, эдийн засаг, соёл, нийгмийн үнэ цэнийн хувьд чухал ач холбогдолгүй гэж үзэж байгаа. Нөлөөлөлд өртөгчид эдгээр өөрчлөлтүүдийг шингээж, амьжиргааны хэв маягаа хэвээр хадгалах хангалттай чадавхтай.



Үнэлгээ	Хэмжээний тодорхойлолт	Мэдрэмтгий байдлын тодорхойлолт
<b>Дунд</b>	Амьжиргаа, амьдралын чанарт үзүүлэх анхдагч, хоёрдогч нөлөөлөл. Нөлөөлөлд өртөгчид өөрчлөлтөнд хүндээр дасан зохицож, өмнөх амьдралын хэв маягаа зөвхөн эдийн засгийн нүүлгэн суурьшуулалтын нөхөн төлбөр бүхий дэмжлэг тусламжтайгаар л хадгалах боломжтой.	Нөлөөлөлд өртсөн нийгэм, эдийн засгийн хөрөнгө нь амьжиргаа, бусад зүйлийн хувьд орон нутгийн ач холбогдолтой. Нөлөөлөлд өртөгчдийн өөрчлөлт шингээж, амьжиргаагаа дэмжих чадвар, хөрөнгө хязгаарлагдмал.
<b>Өндөр</b>	Өргөн хүрээтэй, олон талт анхдагч болон хоёрдогч нөлөөлөл нь буцааж нөхөн сэргээх боломжгүй байх магадлалтай. Нөлөөлөлд өртөгчид өөрчлөлтөд дасан зохицох, өмнөх амьдралын хэв маягаа хадгалан үргэлжлүүлэх боломжгүй.	Нөлөөлөлд өртсөн нийгэм, эдийн засгийн хөрөнгө нь үндэсний болон олон улсын хууль тогтоомжоор тусгайлан хамгаалагдсан, амьжиргаа, бусад зүйлийн хувьд бүс нутгийн болон үндэсний хэмжээнд ач холбогдолтой. Нөлөөлөлд өртөгчид сөрөг нөлөөллийг шингээж, амьжиргаагаа дэмжих чадвар, хөрөнгөгүй.

#### 4.2.5 Үнэлгээний ач холбогдол

Үнэлгээний дараагийн үе шат нь нөлөөллийн хэмжээний талаарх мэдээллийг нийгэмд ач холбогдол бүхий байдлаас нь тайлбарлаж, төслийн талаарх өөрийн ойлголтыг тодорхойлохдоо тухайн асуудалд онцгой анхаарал хандуулах ёстойг шийдвэр гаргагчид, оролцогч талуудад ойлгуулах явдал юм. Энэ үе шатыг "ач холбогдолын үнэлгээ" гэж нэрлэнэ.

ННҮ-ий ач холбогдолын албан ёсны тодорхойлолт байдаггүй. ННҮ-ний мэргэжлийн багийн үзэж байгаагаар ННҮ нь аливаа нөлөөлөл тусдаа болон бусад нөлөөллийн хамт БОННҮ-ний тайланд тусгагдаж төслийн хүрээнд шийдвэр гаргахдаа харгалзан авч үзэх нь ач холбогдолтой байна.

Үүнтэй холбогдуулан, үнэлгээнд бодит дүгнэлт шаардлагатай гэдгийг онцолж, тухайн дүгнэлт нь үйл явцад оролцогч талуудаас хамаарч өөр өөр байж болно гэдгийг хүлээн зөвшөөрч байна. ННҮ-д танилцуулсан нөлөөллийн үнэлгээ нь үнэлгээний багийн дүгнэлт дээр тулгуурласан бөгөөд хууль эрхзүйн стандарт, олон улсын сайн туршлага, оролцогч талуудын үзэл бодлыг харгалзсан болно.


Стандартгүй, эсвэл ач холбогдолынхоо зэрэглэлийг тогтооход ашиглах мэдээлэл хангалттай бус тохиолдолд ач холбогдолыг үнэлэхдээ нөлөөллийн хэмжээ, нөлөөлөлд өртсөн нөөц эсвэл нөлөөлөлд өртөгчдийн ач холбогдол, чанарыг (зарим тохиолдолд хүмүүс, мэдрэмтгий байдал хувьд) харгалзан үзсэн. Нөөц, нөлөөлөлд өртөгсдийн чанар, ач холбогдолыг дүгнэхдээ түүний орон нутгийн, бүс нутгийн, үндэсний болон олон улсын зориулалт, орон нутаг, өргөн олон нийт дэх түүний ач холбогдол, экосистемийн үйл ажиллагаа, эдийн засгийн үнэ цэнэ зэргийг харгалзан үзсэн. Айл өрх, олон нийт, өргөн хүрээний нийгмийн бүлэг зэрэг нөлөөлөлд өртөгсдийн мэдрэмтгий байдлыг үнэлэхдээ тэдний өөрчлөлтөнд үзүүлэх хариу үйлдэл, дасан зохицох чадвар, нөлөөллийн үр дагаврыг зохицуулах чадвар зэргийг харгалзан үзсэн болно.

Гол оролцогч талууд болзошгүй нөлөөлөлд анхаарал хандуулснаар ач холбогдолыг нь багаас дунд зэрэг болгон өсгөх боломжтой гэсэн ойлголтыг нийгэм, эдийн засаг, эрүүл мэндийн нөлөөллийн ач холбогдолын үнэлгээнд онцолсон. Хүний хүчин зүйлээс хамааралтай нийгэм, нийгэм-эдийн засгийн нөлөөллийн ач холбогдол нь хувьсасчуудтай байна. Эдгээр хувьсагчид нь дараах хүчин зүйлээс үүдэлтэй байна:

- Бүлэг/олон нийт/хүн амыг бүрдүүлэх хувь хүмүүсийн болзошгүй нөлөөлөлд хариу үзүүлэх олон янз арга зам;
- Одоогийн нөхцөл байдал, нөлөөллийн шинж чанар, хэрхэн нөлөөлөх талаар урьдчилан бий болсон ойлголт; ба
- Орон нутгийн хүрээнд нөлөөллийн үр дагаварын эмзэг байдлын түвшин (нас, хүйс, эдийн засгийн байдал, боловсролын түвшин зэргээс үүдэлтэй).

Болзошгүй нөлөөллийн үнэлгээ, шинж чанар нь Зураг 4.3–т харуулсан шалгуур үзүүлэлт дээр суурилсан. Нийгмийн ухааны мэдлэг, ижил төрлийн төслүүдийн туршлага дээр үндэслэсэн мэргэжлийн дүгнэлт хийхдээ тухайн шалгуур үзүүлэлтүүдийг ашигласан болно. Энэ үнэлгээ нь тухайн орон нутгийн хүмүүс болон олон нийт уул уурхайн салбарт ерөнхийд нь болон ийм төрлийн уурхайн асуудлуудад хэрхэн хандаж байсан өмнөх туршлагыг харгалзан хийгдсэн.

Нөлөөллийн хэмжээ, мэдрэмтгий байдлыг хамтад нь нөлөөлөл ач холбогдолтой эсэх, ач холбогдолтой бол ямар түвшинд байгааг үнэлэх зорилгоор хослуулан ашигласан. Зураг 4.1-д энэхүү зарчмыг харуулсан байна.



**Зураг 4.3 Ач холбогдолын үнэлгээ**

Төслийн үе шат тус бүрт байгалийн нөөц, нөлөөлөлд өртөгсөд (хүмүүс)-өд их хэмжээний нөлөөллийг тодорхойлж үнэлсэн. Төслийн үе шатуудад (уурхайн барилгын ажил/олборлолт болон хаалт) явагдах төслийн үйл ажиллагаанаас үүсэх нөлөөллийг үнэлсэн. Байгалийн нөөц, нөлөөлөлд өртөгчдөд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг дараах гурван дэд бүлгүүдэд дэс дараалалтайгаар тайлбарласан байгаа:

- **Нөлөөллийн хэлэлцүүлэг** – нөлөөлөл бууруулах арга хэмжээг нэгтгэхээс өмнө төслийн үйл ажиллагаанаас үүсч болзошгүй нөлөөлөл болон урьдчилсан мэдсэн нөлөөллийн (ач холбогдолын үнэлгээг хамруулан) эх үүсвэрийн талаар хэлэлцүүлэг хийх. Тодорхой сэдэвтэй хамааралтай аливаа аргазүйг танилцуулсан;
- **Нөлөөлөл бууруулах үйл ажиллагааг нэгтгэх** – нөлөөлөл бууруулах гол арга хэмжээг авч хэрэгжүүлж, нөлөөлөл бууруулах өөр нэмэлт хувилбаруудыг авч хэлэлцэх; ба
- **Үлдэгдэл нөлөөллийн ач холбогдол** – үлдэгдэл нөлөөлөл (бага, дунд болон их ) -ийн ач холбогдлыг харуулах.

Хүснэгт 4.2, Хүснэгт 4.4-дад төслийн бүсийн байгалийн нөөцөд (ээрэг ба сөрөг) үзүүлэх нөлөөллийн хэмжээ, ач холбогдлыг тодорхойлоход хэрэглэгддэг онцлог шинж чанаруудын хураангуйг харуулсан.

#### Хүснэгт 4.2 Нөлөөний үнэлгээний тодорхойлолт

Шинж чанар	Байдал	Тодорхойлолт	Шалгуур	
Хэмжээ (шууд / шууд бус)	Эерэг	Их	Суурь нөхцөл их хэмжээгээр сайжирсан. Сайжруулалт нь илт ажиглагдсан. Оролцогч талуудын хүсэлтээр нэлээд тодорхой арга хэмжээ авах.	
		Их дунд	Суурь нөхцөл илэрхий сайжирсан. Зарим сайжруулалт ажиглагдсан. Оролцогч талуудын хүсэлтээр дундаас дээгүүр арга хэмжээ авах.	
		Бага дунд	Суурь нөхцөл хэмжигдэхүйц сайжирсан. Өөрчлөлт нэн даруй ажиглагдахгүй. Оролцогч талуудын хүсэлтээр дунд зэрэг арга хэмжээ авах.	
		Бага	Суурь нөхцөл бага хэмжээгээр сайжирсан. Өөрчлөлтийг хэмжиж, ажиглах боломжгүй.	
	Сөрөг	Их	Нөлөөлөлд өртөгсдийг нийлээд муутгаж, хор хөнөөл учруулсан. Нөхөн сэргээх боломжгүй. Асуудал нь оролцогч талуудад салшгүй ач холбогдолтой. Тогтоосон хязгаарыг ихэвчлэн давсан.	
		Их дунд	Нөлөөлөлд өртөгсдийг илт муутгаж, хор хөнөөл учруулсан. Нөхөн сэргээх боломж хязгаарлагдмал. Асуудал нь оролцогч талуудад зарим талаараа ач холбогдолтой. Тогтоосон хязгаарыг нь хааяа давсан.	
		Бага дунд	Нөлөөлөлд өртөгсдийг хэмжигдэхүйц муутгаж, хор учруулсан. Нөхөн сэргээх боломж сайтай. Асуудал бага зэрэг эмзэг. Тогтоосон хязгаарыг ховор давсан.	
		Бага	Нөлөөлөлд өртөгсдийг бага хэмжээнд муутгаж, багахан хор учруулсан. Бүрэн нөхөн сэргээх боломжтой. Асуудал эмзэг биш, хэмжигдэхүйц өөрчлөлт байхгүй. Тогтоосон хязгаарыг давахгүй.	
			Үргэлжилсэн асуудлууд	Давтамжтай асуудлууд
Хугацаа Давтамж	Богино хугацааны Бага давтамжтай	Дөрвөн жилээс бага	Жилд 1-с цөөн тохиолдоно	
	Дунд	Дөрвөн жилээс их ,төслийн хаалтын үе шат дуустал;	Жилд 1-с илүү ба 10-с цөөн тохиолдоно	



Шинж чанар	Байдал	Тодорхойлолт	Шалгуур
			төслийн нийт хугацаанд (17 жил).
	Урт хугацааны Өндөр давтамжтай	Төслийн нийт хугацаанд, төслийн хаалтын үе шат дууссаны дараа ч үлдэх.	Жилд 10-с илүү тохиолдоно
			Нийгэм-эдийн засгийн
Орон зайн хүрээ	Бага	Төслийн бүс дотор	
	Дунд зэргийн	Бүс дотор	
	Их хэмжээний	Бүсийг давсан	

#### 4.2.6 Нөлөөллийн ач холбогдолын тодорхойлолт

Нөлөөллийг хэр зэрэг ач холбогдолтой болохыг харуулахдаа нөлөөллийн хэмжээ, үргэлжлэх хугацаа, орон зайн хамрах хүрээ зэргийг тодорхойлсон. Нөлөөллийн хэмжээг тогтооход ашигладаг шалгуурыг харуулсан матриксыг Хүснэгт 4.3-д үзүүлэв.

#### Хүснэгт 4.3 Болзошгүй нөлөөллийн ач холбогдолын үнэлгээний тодорхойлолт

Хэмжээ	Хугацаа	Орон зайн хүрээ		
		Бага	Дунд	Их хэмжээний
Их	Удаан /их	Их	Их	Их
	Дунд	Дунд	Их	Их
	Богино/бага	Дунд	Дунд	Их
Ихээс дунд	Удаан /их	Дунд	Дунд	Их
	Дунд	Бага	Дунд	Дунд
	Богино/бага	Бага	Low	Дунд
Багаас дунд	Удаан /их	Бага	Дунд	Дунд
	Дунд	Бага	Бага	Дунд
	Богино/бага	Их бага	Бага	Бага
Бага	Удаан /их	Их бага	Бага	Бага
	Дунд	Их бага	Их бага	Бага
	Богино/бага	Их бага	Их бага	Их бага

Нөлөөллийн хэмжээ, үргэлжлэх хугацаа, орон зайн хамрах хүрээ болон магадлалыг үнэлэх нь төслийн нөлөөллийг бууруулахад зориулан боловсруулсан менежментийн төлөвлөгөөнүүдэд чухал юм. Төсөлд зориулан бэлдсэн Нийгмийн менежментийн төлөвлөгөөнд менежментийн төлөвлөгөөнүүдийг танилцуулсан байгаа.

#### Хүснэгт 4.4 Магадлалын үнэлгээний тодорхойлолт

Магадлал	Хувь	Уул уурхайн салбарт тохиолдох давтамж
Тодорхой	> 75%	Ихэнхи уурхайд тохиолддог
Болзошгүй	50% - <75%	Олон уурхайд тохиолддог
Магадлалтай	25% - <50%	Зарим уурхайд тохиолддог

<b>Магадлал багатай</b>	<25%	Цөөн тооны уурхайд тохиолддог
-------------------------	------	-------------------------------

#### 4.2.7 Нөлөөлөл бууруулах арга хэмжээ

Нөлөөллийн үнэлгээг Төсөлтэй холбоотой шийдвэр нь байгаль орчин, нийгэмд үзүүлж болзошгүй нөлөөллийн бүрэн ойлголттойгоор хийгдсэн гэдгийг баталгаажуулахаар боловсруулсан. ННҮ-ний чухал алхам нь төслөөс нөлөөлөл бууруулах тал дээр авах арга хэмжээнүүдийг тодорхойлох явдал юм. Оролцогч талуудын саналыг оруулах явдал нь талуудын үзэл бодол болон нөлөөллийн эх үүсвэрт анхаарал хандуулсан нөлөөлөл бууруулах илүү нарийвчлалтай, зохистой арга хэмжээнүүдийг боловсруулах боломж бүрдүүлж байгаа бөгөөд оролцогч талуудын үзэл бодол, саналыг хүлээн авч тусгаагүйгээс “үйл ажиллагаа явуулах нийгмийн лиценз”-ээ алдаснаар нэр хүнд хохирох эрсдэлд хүргэж болзошгүй.

Нөлөөлөл бууруулах үйл ажиллагаа нь зарим тохиолдолд төслийн салшгүй нэг хэсэг байдаг бол нөлөөлөл бууруулах бусад арга хэмжээ нь ННҮ-ний явцад тодорхойлогддог. ННҮ нь тогтмол байнгын үйл явц бөгөөд хаана их хэмжээний нөлөөлөл үүсэж болохыг тодорхойлж, төслийн багтай хамтран тухайн нөлөөллийг ALARP түвшинд бууруулах техник, эдийн засгийн үндэслэлтэй арга хэмжээнүүдийг тодорхойлж, боловсруулна. Эдгээр арга хэмжээнүүдийг төслийн багтай зөвшилцөн, төслийн төлөвлөгөөнүүд болон Нийгмийн менежментийн төлөвлөгөөнд ойлгомжтой, зөвөөр илэрхийлэгдсэн үүрэг хариуцлага байдлаар тусгасан. Их хэмжээний нөлөөлөл илэрсэн тохиолдолд нөлөөлөл бууруулах дараах сонголтуудыг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ.

- **Эх үүсвэрээс зайлхийх** – нөлөөллийн эх үүсвэрийг арилгах;
- **Эх үүсвэр дээр нь бууруулах** – нөлөөллийн эх үүсвэрийг бууруулах ;
- **Багасгах** – эх үүсвэр болон нөлөөлөлд өртөгчдын хоорондын нөлөөллийг бууруулах;
- **Нөлөөлөлд өртөгчдөд дээрх бууруулах** – нөлөөлөлд өртөгчдөд дээрх нөлөөллийг бууруулах;
- **Засаж залруулах** – тохиолдсоны дараа хохирлыг залруулах; ба
- **Нөхөн төлөх/Дүйцүүлэн хамгаалах** – бодитоор солих буюу ижил чанар, үнэтэй өөр эх үүсвэрээр орлуулах.

Нөхөн төлөх/дүйцүүлэн хамгаалах нь хамгийн эцсийн арга хэмжээ юм. Нөхөн төлөх/дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ нь нөлөөллийг аянд нь хүлээн зөвшөөрөхүйц хэмжээнд болгохгүй буюу өмнө дурьдсан шатлалын дагуу нөлөөлөл бууруулах бусад арга хэмжээ авахгүй байх шалтгаан болохгүй.

#### 4.2.8 Үлдэгдэл нөлөөллийн үнэлгээ

Нөлөөлөл бууруулах арга хэмжээг зөвшөөлсөний дараа ННҮ-ний баг нь төслийн үйл ажиллагаа болон зураг төсөлд багтсан нөлөөлөл бууруулах тал дээр төслийн хүлээсэн цаашдын үүрэг хариуцлагатай холбоотойгоор нөлөөллийг дахин эргэж үнэлсэн. Тухайн үйл явц нь нөлөөлөл байж болох харьцангуй бага түвшинд болсон гэж тооцтол удаан хугацаагаар үргэлжилсэн.

Их хэмжээний үлдэгдэл нөлөөллийг нийт ач холбогдол талаасаа ННҮ-д тгайлбарласан байгаа. Багаас илүү ач холбогдолтой гэж тооцсон нөлөөллийг ННҮ-д нарийвчлан тусгасан; зарим тохиолдолд үнэлгээнд авч хэлэлцсэн нөлөөлөл бууруулах хувилбарууд, сонгосон/ татгалзсан шалтгаануудыг оруулсан.

Үлдэгдэл нөлөөллийн ач холбогдлын зэргийг Төсөлтэй холбоотой шийдвэр гаргах, холбогдох нөхцөлүүдийг боловсруулахад тухайн нөлөөлөлд өгч байгаа ач холбогдлоос хамаарна гэж ННҮ-ний баг үзэн Зураг 4.4.-д тайлбарласан.

#### **Зураг 4.4 Ач холбогдлын зэргийн тодорхойлолт**

Төсөлтэй холбоотой шийдвэр гаргагчид аливаа **их хэмжээний үлдэгдэл нөлөөллийн** (ээрэг, сөрөг байхаас үл хамааран) бодит ач холбогдлыг бусад байгаль орчин, нийгэм, эдийн засгийн зардал, үр ашигтай харьцуулахдаа баталгаа болгох зорилгоор харгалзан авч үздэг; нөхцөл байдал дээр сөрөг нөлөөлөлд хяналт шинжилгээ хийгдэж, үр ашгийг бүрэн хүртэж байгаа эсэхийг баталгаажуулна.

**Дунд зэргийн үлдэгдэл нөлөөлөл нь** шийдвэр гаргах явцад ач холбогдол багатай ч нөлөөлөл бууруулах, хянан шинжлэх тал дээр анхаарал хандуулах шаардлагатай, сөрөг нөлөөллийг хүлээн зөвшөөрөгдөх түвшинд нь байлгаж, эерэг нөлөөллийг хүртэж буйг баталгаажуулах зорилгоор боломжит бүх аргыг ашиглах шаардлагатай.

**Бага зэргийн нөлөөлөл нь** шийдвэр гаргагчдын сонорт хүргэгдэх хэдий ч шийдвэр гаргах явцад бараг нөлөөлөхгүй; нөлөөлөл бууруулахдаа энгийн сайн туршлагын арга хэмжээг авч хэрэгжүүлэн, хяналт шинжилгээг хийхдээ нөлөөлөл зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрэхгүй байх тал дээр анхаарна.

#### **4.2.9 Хуримтлагдах нөлөөлөл**

Дараах асуудлууд дээр үндэслэн хуримтлагдах нөлөөллийг үнэлсэн:

- Тус бүсэд бусад төслүүдтэй холбоотой барилгын үйл ажиллагаанууд давхар явагдаагүй; ба
- Байгалийн нөөц, нөлөөлөлд өртөгчдөд төсөлтэй хамтаар хуримтлагдах нөлөөлөл үзүүлж болох ирээдүйд төлөвлөгдөж буй бүтээн байгуулалт.

#### **4.2.10 Тодорхой бус байдалд анхаарлаа хандуулах нь**

Эцэслэн гаргасан зураг төсөл, өөрчлөгдөшгүй орчинтой байгаа хэдий ч нөлөөллийг баттайгаар урьдчилан тааварлах боломжгүй. Нөлөөллийг чанарын үнэлгээ, экспертийн дүгнэлт бүхий тоон аргачлал зэрэг олон арга ашиглан урьдчилсан таамаглаж болно. Эдгээр аргыг ашиглан өнөөгийн нөхцөл байдалд гарч болох өөрчлөлтүүдийг тодорхой хэмжээнд нарийвчлан таамаглаж, чанарын холбогдох стандартуудтай харьцуулалт хийх боломжтой. Таамаглал дэвшүүлсэн тохиолдолд таамаглах үйл ажиллагаанаас урган гарах тодорхой бус байдлын талаар танилцуулах ёстой.

ННҮ-г боловсруулж байх хугацааны зураг төслийн үйл явцад тодорхой бус байдал урган гарч ирж болно. Зураг төслийн нь хийгдэж байх үе, эсвэл зураг төсөл эцэслэн боловсруулагдаж байгаа үед нөлөөлөл үнэлэх явцад тодорхой бус байдал үүсэх нь зайлшгүй. Энэхүү тодорхой бус байдал нь ННҮ-гээр илэрч гарч ирсэн эсэхийг тодруулах хэрэгтэй. Иймд, болзошгүй үлдэгдэл нөлөөллийн уламжлалт төсөөллийг ашигласан нөлөөлөл бууруулах арга хэмжээг менежментийн төлөвлөгөөнд оруулах ерөнхий хандлагыг санал болгож байна.



#### **4.2.11 Нийгмийн менежментийн төлөвлөгөө**

ННҮ-нь уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө дэвшүүлсэн урьдчилан таамаглал дээр үндэслэгдэж боловсруулагдсан тул тодорхой хяналт (эсвэл нөлөөлөл бууруулах арга хэмжээ) хийх шаардлагатай болзошгүй нөлөөлөл нь мөн адил таамаглал дээр туулгуурлагдсан байгааг анхаарах нь чухал. Тухайн хяналтуудыг хэрэгжүүлэхгүй тохиолдолд ННҮ нь төслийн шийдвэр гаргагч нарын аргачлалын хувьд үнэ цэнэгүй болно гэсэн үг. Нөгөө талаас, нөлөөлөл бууруулах эсвэл менежментийн тодорхой арга хэмжээнүүдийн үр ашиг тодорхойгүй байх боломжтой учир нөлөөллийг төслийн үйл ажиллагааны явцад хянаж байх хэрэгтэй.

Болзошгүй нөлөөллийг тодорхойлж, нөлөөлөл бууруулах арга хэмжээнүүдийг боловсруулан, ННҮ-д тусгасны дараа тэдгээрийн хэрэгжилтийг хангахын тулд төслийн хамрах хүрээ, төлөвлөгөөнд нэгтгэж өгөх нь чухал ач холбогдолтой юм. Эдгээрийг амжилттай хэрэгжүүлэх зорилгоор нөлөөлөл бууруулах үйл ажиллагаа, эсвэл багц арга хэмжээтэй холбоотой хариуцлагыг цохон, цаг хугацааг тодруулж, тайлагнах хугацааг хуваарилан тодотгож өгнө.

Нөлөөлөл бууруулах үйл ажиллагааны суурь болох төслийн Нийгмийн менежментийн төлөвлөгөө (НМТ) нь энэхүү үнэлгээнээс гарсан зөвлөмжийг ажил хэрэг болгох хэрэгсэл нь юм. Төслийн бичиг баримтыг олон нийтэд танилцуулах явцад төслийн НМТ-ний ерөнхий бүдүүвчийг боловсруулж, танилцуулсан, харин нарийвчилсан НМТ-г барилгын үе шатны өмнө боловсруулах болно.

#### **4.2.12 Олон нийтэд тайлагнах, мэдээлэл танилцуулах**

Энэхүү ННҮ-г төслийн холбогдолтой орон нутгийн иргэд бүхий оролцогч талуудад ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага, Гацууртын төслийн Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөөнд тусгасан үйл явцын дагуу танилцуулах болно.

### **4.3 МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ**

Энэхүү Нийгмийн нөлөөллийн үнэлгээний тайланг бэлтгэхдээ ашигласан гол мэдээллийг дараах эх сурвалжуудаас авсан болно:

- Гацууртын төслийн Нийгэм эдийн засгийн суурь судалгаа (2015 оны 6-р сар), Састэйнабилити Ийст Эйжия.
- Гацууртын уурхайн нөлөөллийн бүс, Мандал, Баянгол сумдын Нийгэм – эдийн засаг, эрүүл мэнд, соёлын суурь судалгааны тайлан (Монгол Улсын Нийгмийн хөгжлийн төв, 2011 оны 11-р сар).
- Сентерра компанийн стандартуудын лавлах ном (Төсөл, 2012).
- Компанийн нийгмийн хариуцлагын чиглэлээр Монгол Улсад хийгдэж буй үйл ажиллагааны тойм (BGC, 2014).
- Бороо Гоулд ХХК-ийн орон нутагт оруулсан хөрөнгө оруулалтын үнэлгээ, 2006 оны 11-р сарын байдлаар (Сургалтын үнэлгээ, судалгааны хүрээлэн, 2012).
- Гацууртын төслийн тойм танилцуулга (БГК, 2015 оны 3-р сар).
- Гомдол барагдуулах менежмент, стандарт V.1 (Сентерра, 2014 оны 1-р сар).
- Гацууртын төслийн газрын менежментийн судалгаа (Бодлого судлалын төв, 2011).

- Зам хүлээн авах улсын комиссын акт (Мандал сумын Засаг даргын тамгын газар, 2010).
- Гацууртын төслийн ТЭЗҮ (Байгаль орчин, нийгмийн) (SNC Lavalin, 2014 оны 2-р сар).
- Бороогийн уурхайн хаалтын үе шатны нөлөөллийн үнэлгээ (Ситрус, 2014).
- Сентерра компанийн баримтын хуудас, ажлын зааварчилгаа (2011).
- Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөө (2012, 2015 онд шинэчлэгдсэн).
- Төслийн бүрэлдэхүүн хэсгийн БОНБНҮ-үүд:
  - BIOX® үйлдвэрийн БОНБНҮ (Натур Фрэйндли ХХК, 2010).
  - Гацууртын уурхайн БОНБНҮ (Натур Фрэйндли ХХК, 2009), Гацууртын уурхайн БОНБНҮ-ний тодотгол (Эко Трейд ХХК, 2014).
  - Гацууртын төслийн хүдрийн тээврийн замын БОНБНҮ (Газар Эко ХХК, 2006).

## **5. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫГ ТАТАН ОРОЛЦУУЛАХ**

### **5.1 ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮЙЛ ЯВЦ**

Сентерра компанийн хэлэлцүүлэг болон оролцогч талуудыг татан оролцуулах ажлын зорилго нь аливаа үйл ажиллагааг эхлэхээс өмнө нөлөөлөлд өртсөн иргэдэд холбогдох мэдээллийг цаг тухайд нь, ойлгомжтой танилцуулах явдал юм. Энэ нь оролцогч талуудад өөрсдийн үзэл бодол, саналаа илэрхийлэх боломжийг олгож, Сентерра компанийг тэдний санал бодол, асуудлыг анхааран, хариу үйлдэл хийх боломжийг олгодог үйл ажиллагаа юм. Сентерра нь оролцооны дараах үр дүнтэй гол зарчмуудыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байна.

- Зорилтот бүлгийн оролцогч талуудын хэрэгцээнд тохирсон, хялбар ойлгомжтой хэл болон хэлбэрээр ач холбогдол бүхий мэдээллээр хангах;
- Хэлэлцүүлэг болон шийдвэр гаргах үйл ажиллагааны мэдээллийг урьдчилан хүргэх;
- Оролцогч талуудад хялбар хүрэх боломжтой байршил болон арга замыг ашиглан мэдээллийг түгээх;
- Орон нутгийн иргэдийн уламжлал, хэл соёл, боломжит хугацаа, шийдвэр гаргах үйл явцыг хүндэтгэн үзэх;
- Хоёр талын аль алинд нь үзэл бодол, мэдээлэлээ солилцож, сонсгох, өөрсдийн асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэх боломжийг олгох хоёр талт яриа хэлэлцээр явуулах;
- Эмэгтэйчүүд, эмзэг болон/эсвэл цөөнхийн бүлгийг оруулсан төлөөллүүдийн үзэл бодлыг оруулах;
- Айлган сүрдүүлэх буюу дарамтаас ангид үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- Хүмүүсийн санал, гомдолыг барагдуулах ил тод механизм; ба
- Төсөл, хөтөлбөрийг боловсруулахдаа оролцогч талуудын санал бодлыг тусгаж, тэдэнд эргээд тайлагнах<sup>17</sup>.

Гацууртын төсөл нь төслийн бүсийн ойр орчимд ажиллаж, амьдарч байгаа орон нутгийн иргэд болон Засгийн газрын агентлаг, хэлтсүүдтэй хэлэлцүүлэг хийж, судалгаа явуулах зэргээр ажиллаж байсан хорь гаруй жилийн түүхтэй юм. 1997-2006 оны хооронд Сентерра нь өмнө үйл ажиллагаа явуулж байсан болон охин компаниудаар дамжуулан Монгол Улс дахь хайгуулын төслүүд дээр 50 сая ам.доллараас илүүг зарцуулсан нь 1998 онд Гацууртын алтны үндсэн ордыг илрүүлэхэд хүргэсэн байна. Гацууртын алтны үндсэн ордын техник, эдийн засгийн үндэслэлийн (ТЭЗҮ) судалгааг 2005 онд хийсэн. Монгол Улсын Эрдэс баялгийн шинжээчдийн зөвлөл гэгдэх эрх бүхий байгууллага нь 2007 онд Гацууртын төслийн Геологийн нөөцийн тайлан, 2008 онд ТЭЗҮ-ийн тайланг тус тус батласан юм. Геологийн нөөц нь 2010 онд болон 2013 оны 12-р сард тус тус нэмэгдэж, энэхүү шинэчилсэн нөөцийн мэдээг Эрдэс баялгийн шинжээчдийн зөвлөл баталсан байна. 2014 оны 4-р сард Эрдэс баялгийн шинжээчдийн зөвлөлийн баталсан ТЭЗҮ-ийн шинэчилсэн хувилбарыг боловсруулсан. 2015 оны 1-р сард УИХ нь Гацууртын ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд гэж тодорхойлсон тогтоол баталсан байна. Одоогийн байдлаар, Ерөнхий сайдын захирамжаар томилсон ажлын хэсэг холбогдох яам, төрийн

<sup>17</sup> Сентерра Гоулд компанийн Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөө (2012).

байгууллага, мэргэжлийн холбоо, эрдэмтэн, судлаачидтай хамтран нарийвчилсан судалгаа, дүн шинжилгээг хийж байна. Үүнд олон нийттэй хэлэлцүүлэг хийх ажлын хэсэг бас багтсан байна.

Төслийн бүрэлдэхүүн хэсгүүдэд зориулсан БОНБНУ-ний баримт бичгийг боловсруулах явцдаа Монгол Улсын Засгийн газрын шаардлагын дагуу олон нийттэй хэлэлцүүлэг хийх ёстой ба үүнд Сентерра компанийн хэлэлцүүлэг хийх үйл явц орно. Гацууртын төсөл нь 2004 оноос хойш үйл ажиллагаатай уурхай жишгээр зохицуулагдаж ирсэн ба төслийн боловсруулагдсан БОНБНУ тус бүрт (Бүлэг 4.3-д жагсаасны дагуу) зориулж хуулийн дагуу хэлэлцүүлэг зохион байх шаардлагатай байсан. Гацууртын төслийн бүсэд хийсэн тодорхой чиглэлийн (хууль ёсны бүс) судалгаануудыг боловсруулах явцад хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж, олон нийтийн дараах доор тайлбарласан асуудлуудыг ил болгосон байна. Зарим нэг асуудлуудыг Сентерра компани, олон нийтийн гишүүд, мөн холбогдох байгууллагууд хамтран удаан хугацаанд шийддэг байхад бусад асуудлууд нь шинээр урган гарч ирдэг байна.

Олон нийттэй зөвлөлдөж, мэдээллийг танилцуулах анхны төлөвлөгөөг 1999 онд Бороо Гоулд төсөлд зориулан боловсруулсан. Энэхүү баримт бичиг нь Гацууртын төслийг зөвхөн дурьдсан бөгөөд гол анхаарлаа хандуулаагүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Энэ үед, орон нутгийн оролцогч талуудын гол анхаарал татсан асуудал нь хөдөлмөр эрхлэлт, боловсрол, тээвэр, эмнэлгийн барилга байгууламж зэрэг байсан юм.

2010 оны Газар ашиглалтын судалгаа нь дараах олон нийтийн асуудлуудыг гаргаж ирсэн:

- Ноён ууланд олдсон булшуудыг авран хамгаалах үйл ажиллагаа (Сентерра компанийн хариу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ: Санамсаргүй олдворын журмыг боловсруулж, уурхайн тусгай зөвшөөрөлтэй талбайн гаднах бүсийг харуулсан зураглал хийсэн);
- Уурхайн лицензийн талбайд (Сентерра компанийн хариу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ: Түнхэл багт усны хоёр худаг гаргасан) малын бэлчээрийн усны хүртээмжийг өөрчлөх;
- Хүүхдийн зуслан алдагдах (Сентерра компанийн хариу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ: зуслан эзэмшигчдэд нөхөн төлбөр өгч, 2011 онд шинэ барилга байгууламж барьсан); ба
- Бүс нутгийн бусад уурхайн тусгай зөвшөөрөлтэй талбай (Сентерра компанийн хариу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ: хамтын хэлэлцүүлэгт зориулж алтны шороон ордны хуучин уурхай ба одоогийн хууль бус уурхайнуудын (дараа нь ямар байсан) зураглал хийсэн).

Судалгаанд оролцогчид Гацууртын уурхайн нөхөн сэргээлтийг аль болох орчны анхны байдалд нь хүргэх ёстой гэдэг санаагаа илэрхийлсэн байна<sup>18</sup>.

2015 онд хийж гүйцэтгэсэн Биет бүс соёлын өвийн судалгаа<sup>19</sup> нь уул уурхай, мал аж ахуй, эрчимжсэн мал аж ахуй зэрэг хамт оршин тогтнож байгаад анхаарлаа хандуулах хамтарсан хуралдаан зохион байгуулах г.м. малчид, иргэд, Сентерра компани хоорондын харилцаа холбоог тогтмол бэхжүүлэх шаардлагатай гэж илэрхийлж, энэхүү сэдвийн хүрээнд олон нийтийн үзэл бодлыг олж илрүүлсэн.

<sup>18</sup> Газар ашиглалтын судалгаа, Бодлого судлалын төв 2010.

<sup>19</sup> Монгол Улсын Шинжлэх ухааны академийн харъяа Түүх, археологийн хүрээлэн (МУШУА, ТАХ), 2015.

## **5.2 ӨМНӨ ХИЙЖ БАЙСАН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫГ ТАТАН ОРОЛЦУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ**

Ойролцоогоор 1997 оноос хойш, дээр дурдсанчлан, Гацууртын төслийн талаар орон нутгийн төрийн болон бусад оролцогч талуудтай харилцаа холбоо тогтоох, хэлэлцүүлэг хийх ажлуудыг зохион байгуулж байсан. Үүнтэй холбоотойгоор, Бороо Гоулд уурхай дээр Сентерра компани оролцогч талуудыг татан оролцуулах үйл ажиллагааг зохион байгуулж, үүндээ нэг төрлийн гол оролцогч талуудыг олон удаа татан оролцуулсан байна. Сентерра компани нь төслийн бүсэд хийсэн оролцогч талуудыг татан оролцуулах үйл ажиллагааны урт удаан жилийн түүхтэй бөгөөд их хэмжээний оролцогч талуудтай харилцаа холбоо тогтоож байсан байна. Одоогийн хийж буй дотоодын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон Нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ боловсруулах явцдаа (ННҮ-г 2015 онд хийсэн) талуудыг байнга татан оролцуулж байсан. Төслийн Нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээтэй холбоотой оролцогч талуудыг татан оролцуулах дөрвөн тусдаа үе шат байна:

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний суурь судалгааны оролцогч талуудыг татан оролцуулах үе шат (дууссан);
- Нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний суурь судалгааны оролцогч талуудыг татан оролцуулах үе шат (дууссан);
- БОННҮ-г хэлэлцүүлж, олон нийтэд танилцуулах үе шат (хийгдэж байна); ба
- БОННҮ-г олон нийтэд танилцуулах үе шат дууссаны дараа болон төслийн үйл ажиллагааны хугацаанд талуудыг байнга татан оролцуулна.

Натур Фрейндли ХХК-нь Гацууртын төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний оролцогч талуудыг татан оролцуулах үйл ажиллагааг 2014 онд хийсэн ба дараах үндсэн үйл ажиллагааг тусгасан байна. Үүнд:

- Орон нутгийн малчид, иргэдтэй хийх уулзалт;
- Орон нутгийн засаг захиргааны (иргэдийн хурал, багийн) төлөөлөгч ба удирдлагуудтай хийх уулзалт;
- Монгол Улсын УИХ-ын гишүүд, Засгийн газрын сайдууд, албан тушаалтанууд, орон нутгийн иргэд, олон нийтэд нэр хүнд бүхий иргэдийг Гацууртын төслийн талбайд зочлуулж, туршлага судлуулах;
- Олон нийтийн мэдээллийн төвүүд дээр хийх уулзалтууд;
- Баримтат хуудас, сонины нийтлэл, хэвлэлийн материалуудыг тараах; ба
- Засгийн газрын хамтарсан ажлын хэсгийн хуралдаан дээр танилцуулга хийх.

ННҮ-ний суурь судалгааны хээрийн ажлын (2015 оны 4 – 5 саруудад хийсэн) үеийн оролцогч талуудыг татан оролцуулах үйл ажиллагааны гол анхаарал хандуулсан ажил нь оролцогч талуудаас мэдээлэл, санал бодлыг нь цуглуулах явдал байлаа. Нийгмийн суурь судалгааны өмнө гол дотоод, гадны оролцогч талуудтай хамтран урьдчилсан үнэлгээний хэлэлцүүлэг хийсэн байна. Баримт бичгийн анхан шатны хяналт хийж, төслийн нөлөөллийн бүсийг үнэлэх зорилгоор компанийн болон Зээлдүүлэгчийн гол төлөөллүүдтэй Улаанбаатар хот дах Сентерра компанийн

төв оффис, түүнчлэн төслийн талбай дээр уулзалт зохион байгуулсан ба олон нийтийн дунд анхан шатны хэлэлцүүлэг зохион байгуулах замаар дотоодын гол оролцогч талуудын оролцоог хангасан. 2015 оны 4-5 дугаар сарын үед хийсэн нийгмийн суурь судалгааны хүрээнд өрхийн асуумж судалгаа, гол талтай хийх ярилцлага, зорилтот бүлгийн хэлэлцүүлэг зэргийг ашиглан төслийн оролцогч талуудыг өргөнөөр оролцуулсан. Энэхүү суурь судалгааны үе шатанд оролцогч талуудыг татан оролцуулах гол зорилтууд нь:

- Дараагийн үе шатуудад үүсэх болзошгүй нөлөөлөл, асуудлуудыг тодорхойлох;
- Төсөлтэй холбоотой оролцогч талуудыг тодорхойлох;
- Суурь судалгаанд хамааралтай мэдээллийг тодорхойлж, олж авах;
- Санал болгож буй Төсөл дээр оролцогч талуудын санал бодлыг сонсож, үнэлгээний явцад эдгээр саналыг анхаарч үзэх; ба
- Болзошгүй нөлөөллийг зохицуулах, бууруулах арга хэмжээг боловсруулах тал дээр эдгээр арга хэмжээнд гол үүрэгтэй оролцогч талуудын санал бодлыг нь тусгах.

### **5.3 ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХ ЯВЦ**

Сентерра компаниас өөрийн төслийн үйл ажиллагааны болзошгүй нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдэд ач холбогдолтой, хүртээмжтэй мэдээллээр хүргэх үүрэг амлалтандаа хүрэхийн тулд олон нийтэд танилцуулах төслийн материалыг боловсруулсан байна. Үүнд дараах орно:

- Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу БОНБНҮ-г танилцуулах;
- Оролцогч талуудад (үүнд: Сентерра компанийн ажлын хамтарсан хэсгүүд, төрийн байгууллагууд, УИХ-ын гишүүд, олон нийтийн удирдагчид, Орон нутгийн хөгжлийн сангийн түнш болон үр шим хүртэгчид, сум, багийн иргэдийн хурлууд<sup>20</sup>) зориулсан илтгэлүүд;
- 2011 онд Сентерра компанийн олон нийтэд зориулан гаргасан гарын авлагаас гадна Зүүнхараа, Баруунхараа болон Түнхэл багт байрлах Сентерра компанийн мэдээллийн төвүүдээр дамжуулж орон нутгийн иргэдэд танилцуулах газрын зураг, хэвлэмэл материалууд. Хэлэлцүүлэг уулзалтын үеэр босгож ирсэн орон нутгийн иргэдийн санаа зовоосон гол асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор энэхүү гарын авлага (буюу “мэдээллийн хуудас”)-ыг боловсруулж, хавтаслан Гацууртын төслийн бүс нутгийн олон нийтэд тараасан. Энэхүү гарын авлагын гол сэдвүүдэд Сентерра компанийн танилцуулга, Монгол Улс дахь хариуцлагатай уул уурхайн санаачлага, Орон нутгийн хөгжлийн сан болон компанийн эдийн засгийн бусад хөрөнгө оруулалтууд, уул уурхай, тусгай зөвшөөрөлтэй холбоотой хэрэгцээт мэдээлэл, байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллүүд болон нөхөн сэргээлтийн ажил зэрэг орсон байна; ба
- Орон нутгийн сар тутмын хэвлэл (Хараа сонин)-г Баянгол, Мандал сумдууд болон Түнхэл багийн иргэдэд тараадаг.

<sup>20</sup> Хамгийн сүүлд боловсруулсан, Гацууртын төслийн танилцуулга (2015 оны 3-р сарын 3)



Нийгмийн нөлөөллийн үнэлгээний нэг хэсэг болох БОННУ-ний олон нийтэд танилцуулах багцийн олон нийтэд танилцуулах ажлын хүрээнд хийсэн үйл ажиллагааны дэлгэрэнгүйг Гацууртын төслийн Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөөнд тусгасан.

#### **5.4 ХЭРЭГЖИЖ БУЙ ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦООНЫ ҮЙЛ ЯВЦ**

Сентерра компани нь өөрийн гол оролцогч талуудтай хамтын ажиллагааны харилцаа холбоогоо хадгалж үлдэхийн тулд Оролцогч талуудыг татан оролцуулах үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Үр дүнтэй харилцаа холбоо нь компанийн зорилт ба үүнд:

- Компани болон орон нутгийн иргэдийн хооронд итгэлцэл дээр түшиглэсэн харилцааг дахин бий болгох;
- Компанийн удирдлага болон орон нутгийн засаг захиргааны хооронд итгэлцэл, ойлголцлын харилцааг бэхжүүлэх;
- Компани болон орон нутгийн иргэдийн хооронд бий болсон аливаа нэг хурцадмал байдлыг зөөлрүүлэх;
- Компанийн үйл ажиллагааны талаар буруугаар танилцуулах аливаа оролдлогыг урьдчилан харж, таслан зогсоох;
- Нөлөөллийн бүсийн иргэдийн амьжиргааны түвшинг сайжруулах тал дээр компанийн оруулах хувь нэмрийг дэмжих;
- Баримт, нотолгоонд тулгуурласан илтгэл, танилцуулга ашиглан шинэ технологи, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэхтэй холбоотой аливаа асуудлыг намдаах;
- Компанийн дотоод харилцаа холбоог сайжруулахын улмаар үйл ажиллагааны үр ашгийг бүхэлд нь нэмэгдүүлэх<sup>21</sup>.

Сентерра компани нь тогтвортой үр дүнд хүргэх оролцооны тогтолцоо, арга барилыг боловсруулах, эдгээр арга хэмжээг авах үүрэг бүхий ажилтнуудыг татан оролцуулах замаар компанийн хариуцлагын зорилгод хүрэхэд чадавхиа тогтвортой нэмэгдүүлнэ. Компанийн ололт амжилтанд компанийн засаглал, удирдлагын үйл ажиллагааг бэхжүүлэх зэрэг багтсан байна.

Сентерра компанийн хэрэгжүүлж буй оролцооны үйл ажиллагааг үр ашигтай болгох чухал механизм нь 2010 оны 6-р сард байгуулсан хамтарсан ажлын хэсэг юм. Энэхүү ажлын хэсгийн зорилго нь олон нийтийн харилцааг дэмжих, орон нутгийн хөгжлийг дэмжих, тогтвортой ажлын байр бий болгох, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгаль орчныг нөхөн сэргээлтийн ажлыг явуулах зэрэг харилцан ашигтай хамтын ажиллагааны нөхцөлийг Гацууртын төслийг боловсруулах явцад бүрдүүлэх юм. Хамтарсан ажлын хэсэг нь Гацууртын төслийн хаалтын үе шат хүртэл ажиллах ба энэхүү ажлын хэсэг нь Баянгол, Мандал сумдын орон нутгийн засаг захиргаа болон иргэдийн хурлын төлөөллөөс (талуудын төлөөлөгчдийн тоо тэнцүү байх) бүрдсэн байна. Талууд нь хамтарсан ажлын хэсгийн гишүүн болох нэр дэвшигчээ сонгож, хамтарсан хуралдаанаар батлуулна. Хамтарсан ажлын хэсгийн уулзалтуудыг улиралд нэгээс доошгүй удаа

---

<sup>21</sup> Сентерра компанийн оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөө (2012)

Бороогийн ба Гацууртын уурхайн талбай эсвэл Улаанбаатар хот дахь Сентерра компанийн оффис дээр ээлжлэн зохион байгуулж байна.<sup>22</sup>

Компанийн засаглал, удирдлагын оролцооны ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн:

- Улаанбаатар хотод байрлан ажиллах Олон нийттэй харилцах үйл ажиллагааны менежер, Олон нийттэй харилцах үйл ажиллагааны зөвлөх; мөн Зүүнхараа, Баруунхараа сумдад болон Түнхэл багт байрлан ажиллах олон нийттэй харилцах үйл ажиллагааны ажилтнуудыг томилсон.
- "Компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч"-ийн үүрэг хүлээх ахлах менежерийг томилсон.
- Олон нийттэй харилцах болон орон нутгийн хөгжлийн үйл ажиллагааг хоёуланг нь хариуцах Хэвлэл мэдээллийн харилцаа хариуцсан менежерийг томилсон.
- Олон нийттэй харилцах ажилтнуудын Улаанбаатар хотын төв оффист сар бүр зохион байгуулагддаг үйл ажиллагааны байнгын шинэчлэгдэх бүртгэлийг хянаж дүгнэх уулзалтуудыг тогтмолжуулсан.
- Сар тутам Улаанбаатар хот болон төслийн талбайн ажиллагсдын дунд чухал ач холбогдол бүхий олон нийттэй харилцах үйл ажиллагааны талаарх мэдээлэл солилцох уулзалтуудыг зохион байгуулдаг.

---

<sup>22</sup> Компанийн нийгмийн хариуцлагын чиглэлээр Монгол Улсад явуулж буй үйл ажиллагаанууд БГК, 2014).

## **6. НИЙГМИЙН СУУРЬ СУДАЛГААГААР ТОДОРХОЙЛСОН АСУУДЛУУД**

Энэхүү бүлэгт 4-р хэсэгт товч тодорхойлсон аргачлалыг ашиглан хийсэн төслийн нийгэм эдийн засгийн суурь судалгааны талаар авч үзсэн ба Хавсралт А-д нарийвчилсан мэдээллийг багтаасан байгаа.

### **6.1 ХҮН АМ ЗҮЙ**

#### **6.1.1 Оршил**

Энэ бүлэгт төслийн нөлөөллийн бүсийн хүн амын гол үзүүлэлт, нас хүйсийн харьцаа, хот хөдөөгийн хүн амын динамик, шилжилт хөдөлгөөн, боловсрол, бичиг үсэг тайлагдсан байдал, яс үндэс болон шашин шүтлэг зэрэг хүн ам зүйн асуудлуудын талаар авч үзэв.

#### **6.1.2 Ашигласан тоо мэдээлэл**

Энэхүү нийгмийн суурь судалгааг 2012 – 2015 онуудын тоо мэдээлэлд тулгуурлан боловсруулсан болно. Үндэсний статистикийн хороо, хүн ам, байрны тооллого, аймаг, сумдын Засаг даргын тамгийн газрын статистикийн хэлтэс зэргийн тайлангаас хоёрдогч тоо мэдээллүүдээ авав. Анхдагч мэдээллийн эх сурвалжид гол талтай хийсэн ярилцлага, орон нутгийн иргэдтэй зохион байгуулсан зорилтот бүлгийн хэлэлцүүлгийн тэмдэглэл, өрхийн судалгааны үр дүн зэргийг ашигласан болно.


Энэ бүлэгт ороогүй хүснэгт, зурагнуудыг Хавсралт Г хэсгээс үзнэ үү.

#### **6.1.3 Хүн амын шилжилт хөдөлгөөн**

3 сая хүн ам 1.6 сая орчим хавтгай дөрвөлжин километр газар нутагт тархан суурьшсан байдал нь Монгол Улсыг дэлхийд хамгийн бага нягтшилтай хүн амтай улсын тоонд оруулсан. Улсын нийт хүн амын 4 орчим хувь (3.6%) нь Сэлэнгэ аймагт амьдардаг. Улсын дунджаар нэг сум 4,700 кв.м нутаг дэвсгэрт 3,000 хүн амтай байхад Сэлэнгэ аймгийн нэг сум дунджаар 4,900 хүн ам 2,400 кв.м нутаг дэвсгэр дээр амьдарч байна. Улсын дунджаар нэг баг 600 хүн амтай, 1,000 кв.м нутаг дэвсгэртэй байхад Сэлэнгэ аймгийн нэг баг дунджаар 1,500 хүн ам 700 кв.м нутаг дэвсгэр дээр амьдарч байна<sup>23</sup>. Сэлэнгэ аймгийн хүн ам харьцангуй их байгаа байдал нь тээврийн дэд бүтэц (Транс-Сибирийн төмөр зам дайран өнгөрдөг), зах зээлд ойр байдагтай болон Монгол Улсын үр тарианы ургацын 40% орчмыг бүрдүүлдэг газар тариалангийн үржил шимтэй газартай байгаатай холбоотой юм.

2014 оны байдлаар, Сэлэнгэ аймагт 105,300 хүн амтай байгаагаас 5.3% Баянгол сумын, 24.4 % Мандал сумын иргэд эзэлж байна. Монгол Улсын хүн амын нягтшил нь 2.0 хүн/кв.м байна. Харин Сэлэнгэ аймагт нэг кв.м нутаг дэвсгэрт 2.5 хүн ноогдож байхад Баянгол суманд 2.8 хүн, Мандал суманд 5.3 хүн ноогдож байна. Мандал сум нь Монгол Улсын хэмжээнд хамгийн олон хүн амтай сум бөгөөд тус суманд 25,600 хүн амьдарч байна. Сүүлийн 3 жилийн хугацаанд Монгол Улсын хүн ам тогтвортой өсч байгаа бол Сэлэнгэ аймгийн хүн ам тооны хувьд өсч байгаа хэдий ч (тодорхой хүн амын хэсэг нь) жилийн дундаж өсөлтийн хурд нь улсын дундажтай харьцуулахад буурч байна.

<sup>23</sup> УСХ (2015). Сэлэнгэ аймаг Статистикийн товчоон, Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, хуудас 14, Улаанбаатар



**Зураг 5.1 Хүн амын жилийн дундаж өсөлт, улс, аймаг, сумын түвшинд**

Сэлэнгэ аймгийн хүн амын өсөлт буурч байгаа нь аймгийн хэмжээнд хүн амын хэлбэлзэл их, хүн амын хотжих хөдөлгөөн ихэссэнтэй (хөдөө нутгаас сум, аймгийн төв рүү мөн бүс нутгаас нийслэл Улаанбаатар хот руу шилжих хөдөлгөөн) холбон тайлбарлаж болно. Өрхийн судалгаагаар Баянгол, Мандал сумдын судалгаанд оролцсон нийт өрхийн 80-аас илүү хувь нь тухайн сумын уугуул өрх, 20 орчим хувь нь шилжин ирсэн өрх гэсэн үр дүн гарсан. Судалгаанд оролцсон сумын шилжин ирсэн өрхийн 85.7% нь шилжин ирсэн бүртгэлтэй, харин үлдсэн хувь нь тухай сумандаа бүртгэлгүй байна. Бүртгэлгүй айл өрхүүд нь улсын сургууль, эмнэлэг, нийгмийн даатгал, тэтгэвэр, улсын ба хүүхдийн тэтгэмж зэрэг нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байх зэрэг олон бэрхшээлтэй тулгардаг. Бүртгэлгүй айл өрхүүд орон нутгийн сонгуульд оролцож чаддаггүй бөгөөд дээр дурьдсан нийгмийн үйлчилгээнүүдийг өөр газраас хүртэх сонирхолтой учир шилжилт хөдөлгөөнөө бүртгүүлдэггүй байж болох юм.

Хүснэгт 5.1-д үзүүлснээр Сэлэнгэ аймгийн шилжилт хөдөлгөөн илэрхий гадагшаа чиглэх хандлагатай байгаа учир аймагт шилжин ирсэн хүний тоо 2012 оноос хойш буурсан байна. Энэ хандлагийг Зураг 5.1-д (дээрх) үзүүлснээр суурин газраас зайдуу Баянгол суманд хүн амын хэлбэлзэл их байгаа (2012 онд -3.4%, 2013 онд 2.9% ба 2014 онд -0.1%) бол төв суурин газар болох Мандал сумын хүн амын тоо тогтмол өсч байна. Тухайлбал, Мандал сумын нийт хүн амын 70.3% нь сумын төвд оршин суудаг<sup>24</sup>.

**Хүснэгт 5.1 Сэлэнгэ аймгийн шилжилт хөдөлгөөний байдал, 2012 – 2014 он**

Шилжилт хөдөлгөөн	2012	2013	2014
Шилжин ирсэн хүн ам	1,789	1,690	1,430
Шилжин явсан хүн ам	2,600	3,548	3,129
Цэвэр шилжилт	-811	-1,858	-1,699
Цэвэр шилжилтийн коэффициент (%)	-18.5	-35.5	-37.3

Шилжилт хөдөлгөөний талаар сумын албан тушаалтнуудай хийсэн ярилцлагын явцад Сэлэнгэ аймгийн шилжилт хөдөлгөөний бууралтын шалтгааныг тэд шилжин ирэгсэд бэлчээр ашиглахад

<sup>24</sup> Мандал сумын статистикийн тайлан, 2013.

бэрхшээлтэй тулгардаг, бэлчээрийн даац хэтэрснээс үүдэлтэй газрын талхлагдал үүссэн зэргээс болж хүмүүсийн шилжин ирэх сонирхол буурсантай холбоотой гэж тайлбарлав<sup>25</sup>. Баянгол сумын зорилтот бүлгийн хэлэлцүүлэгт оролцогчид мал сүргийн тоо өсч, бэлчээрт үзүүлэх нөлөөлөл нэмэгдэж, газар ашиглалтын маргаан гарах нь ихсэж байгаа нь шилжиж ирсэн малчдын тоо нэмэгдэж байгаатай холбоотой (жишээлбэл хөдөө орон нутагт шилжин ирэгсэд) гэж хариулсан (Жишээлбэл шилжиж ирсэн малчид, газар тариалан эрхлэгчдийн хооронд, мөн шилжин ирсэн малчид болон нутгийн малчдын хооронд)<sup>26</sup> нь цуглуулсан тоон мэдээлэл (Хүснэгт 5.2-г үзнэ үү), албаны хүмүүсийн санал бодлоос өөр байна. Тиймээс, бодит байдал дээр шилжин ирэгсдийн тоо буурч байгаа боловч бэлчээрийн доройтол, газар ашиглалтын маргааны гол эх үүсвэр болсон гадны малчид шилжин ирэх нь ихэссэн гэсэн ойлголт орон нутгийн иргэдийн дунд байсаар байна (6.6 Газар ашиглалт ба байгалийн нөөц хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү).

### Хүснэгт 5.2 Хот, хөдөөгийн хүн амын хувийн жин, 2012, 2014 он<sup>27</sup>

Аймаг, сум	2012			2014		
	Нийт	Хувь		Нийт	Хувь	
		Хот	Хөдөө		Хот	Хөдөө
Хүн ам						
Үндэсний түвшин	2,809,693	67.2	32.8	2,937,927	66.4	33.6
Сэлэнгэ аймаг	104,282	29.5	70.5	105,253	33.8	66.2
Баянгол сум	5,438	-	-	5,594	66.6	33.4
Мандал сум	25,689	-	-	25,693	69.0	31.0
Өрх						
Үндэсний түвшин	768,263	63.7	36.3	823,412	65.3	34.7
Сэлэнгэ аймаг	29,416	28.6	71.4	30,040	31.2	68.8
Баянгол сум	1,590	-	-	1,675	65.0	35.0
Мандал сум	7,322	-	-	7,382	70.3	29.7

Тэмдэглэл: "хот" гэдэг ангилалд аймаг, сум, багийн төвийн оршин суугчдыг ойлгоно.

#### 6.1.4 Хүн амын нас, хүйсийн бүтэц

Монгол Улс 1990-ээд оны төрөлтийн тогтвортой бууралтын<sup>28</sup> нөлөөгөөр харьцангуй залуу, эдийн засгийн идэвхитэй хүн амтай<sup>29</sup> болж байна. Улсын хэмжээнд нийт хүн амын гуравны хоёр нь хөдөлмөрийн насны хүн ам байна. Улсын хэмжээнд, 20 – 29 насны залуучууд, 0 – 4 насны хүүхдийн эзлэх хувь хамгийн өндөр байна. Сэлэнгэ аймгийн хүн амын 27.2% нь 0 – 14 насны хүүхдүүд, 66.6% нь хөдөлмөрийн насны хүн ам (15 – 59 настай), харин үлдсэн 6.2% нь 60-аас дээш насны ахмадууд байна. Үүний адилаар, Баянгол, Мандал сумдад хөдөлмөрийн насны хүн ам 66.2% ба 67.2% тус тус байна. Мандал сумын хөдөлмөрийн насны хүн амын дунд 20 – 24 насны залуучууд зонхилж байна. Баянгол сумын хүн амын насны хамгийн том бүлэг нь 0 – 4 насны хүүхдүүд байгаа нь суманд төрөлтийн коэффициент нэмэгдэж байгааг харуулж байна. Дээр үзүүлсэн зураглалаас харахад Мандал суманд тулгарч буй гол бэрхшээл нь сумын залуучуудад зориулж техник мэргэжлийн, боловсролын, эдийн засгийн боломжуудыг бүрдүүлж, ажлын байраар хангах явдал

<sup>25</sup> Мандал сумын Засаг даргын орлогч ба сумын ХАА-н мэргэжилтэнтэй хийсэн ярилцлага.

<sup>26</sup> Баянгол сумын төвийн иргэдийн төлөөлөлтэй хийсэн Зорилтот бүлгийн хэлэлцүүлэг

<sup>27</sup> Засаг даргын Тамгын газар (2015). Сэлэнгэ аймгийн 2014 оны нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд, Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар.

<sup>28</sup> Төрөлтийн коэффициент; Монгол Улсад 2013 онд ойролцоогоор (1,000 хүнд) 22.66 байсан. 2000 онд 19.9 байснаа, 1990 онд 32.6 болж өссөн байна. Төрөлтийн нийт коэффициент нь 1,000 хүн тутам жилд ноогдох төрөлтийн тоо.

<sup>29</sup> Худалдааны эдийн засаг. 2015. [www.tradingeconomics.com/mongolia](http://www.tradingeconomics.com/mongolia).

юм. Баянгол суманд тулгарч буй гол бэрхшээл нь боловсролын салбарын дэд бүтэц, ялангуяа цэцэрлэг, бага, дунд сургууль, эмнэлгийн анхан шатны үйлчилгээгээр хангах явдал байв.

Хамгийн сүүлд явагдсан улсын хүн ам, орон сууцны тооллогын (2010 онд явуулсан) тайлангаас харахад Сэлэнгэ аймгийн хүйсийн харьцаа нь (100 эрэгтэй хүнд ногдох эмэгтэй хүний тоо) 103.6 хүрсэн нь өмнөх тооллоготой харьцуулахад 0.9 оноогоор буурсан үзүүлэлттэй байна. Хүйсийн харьцаа нь нас ахих тусам огцом буурдаг байна. Үүний шалтгааныг эрэгтэйчүүдийн нас баралт эмэгтэйчүүдийнхтэй харьцуулахад өндөр байдагтай холбон тайлбарлаж болох юм. Жишээлбэл, 70 бол түүнээс өндөр настай ахмад настнуудын дунд хүйсийн харьцаа нь 73.4 хүртэл буурдаг. Баянгол сумын хүн амын хүйсийн харьцаа нь 106.6 (эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс олон байна) байгаа бол Мандал суманд 97.7 (эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү олон) байгаа ба энэ харьцаа сүүлийн арван жилийн туршид тогтмол байна.

Сүүлийн 3 жилийн хугацаанд Сэлэнгэ аймгийн хэмжээнд гэрлэлтийн тоо нэмэгдэж гэр бүл салалтын тоо буурсан үзүүлэлттэй байна. Сэлэнгэ аймагт нийт эхчүүдийн 89.5% нь гэрлэсэн байгаа нь улсын дундаж үзүүлэлтээс бага зэрэг өндөр байна. Үүний эсрэг, энэхүү хугацааны турш Баянгол, Мандал сумдад гэрлэлт, гэр бүл салалтын үзүүлэлт аль аль нь өссөн байна. Баянгол, Мандал сумдын гэр бүл салалтын өндөр түвшинтэй холбоотойгоор үүсэх гол эрсдэл нь өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо нэмэгдэх явдал юм. Эмэгтэйчүүд толгойлсон өрх (эдийн засгийн нөөц ашиглахтай холбоотой жендерийн зөрүүгээс үүдэлтэй) нь эрэгтэйчүүд толгойлсон өрхөөс илүү эмзэг байдаг. Статистикийн мэдээнээс харахад, Мандал сумын өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо 2012 онд 134 байснаас 2013 онд 167 болж 33 өрхөөр нэмэгдсэн нь энэхүү эрсдэл бодит байдал дээр байсаар байгааг харуулж байна. Энэ хугацаанд Түнхэл багт 11 өрх толгойлсон эмэгтэй нэмэгдсэн байгаа нь<sup>30</sup> энэхүү зураглал нь багт мөн ажиглагдаж байгааг харуулж байна.

### **6.1.5 Боловсрол ба бичиг үсэг тайлагдсан байдал**

Монгол Улсын 1990-ээд оны шилжилтийн үед төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцооны ачаар бичиг үсэг тайлагдсан байдал, боловсрол эзэмшилт зэрэг нь өндөр түвшинд байсан боловсролын салбар нь томоохон бэрхшээлтэй тулгарсан. Шилжилтийн эхэн үеийн эдийн засгийн хүндрэлүүд нь сургуулийн байруудыг арчилж, хадгалах, хичээлийн хөтөлбөр боловсруулах, боловсролын үйлчилгээ үзүүлэх зэрэгт сөргөөр нөлөөлсөн. Өнөөгийн боловсролын системд тулгарч байгаа гол асуудлууд нь (i) өнөөгийн бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн уялдаа холбоо, чанар муу (ii) багшлах ур чадвар муу (iii) боловсролын тогтсон стандартгүй (iv) сургуулиудын сурах, заах орчин муу (v) залуучуудын хэрэгцээнд нийцсэн техник мэргэжлийн боловсрол олгох зэрэг юм. Эдгээр бэрхшээлээс үл хамааран Монгол Улсын бичиг үсэг тайлагдсан байдал 98%-тай, нийт хүн амын 90-ээс дээш хувь нь дунд сургуульд суралцсан байна<sup>31</sup>.

<sup>30</sup> Үндэсний Статистикийн хороо (2015). Сэлэнгэ аймгийн Статистикийн эмхтгэл, 2014, Монгол Улсын Статистикийн газар, хуудас 153, Улаанбаатар

<sup>31</sup> НҮБ-ын Хүүхдийн сан, Монгол Улсын статистик. [www.unicef.org](http://www.unicef.org).





## **Монгол, Австрали улсуудын боловсролын тогтолцооны харьцуулалт:**

Монгол Улсын боловсролын тогтолцоог сайн ойлгуулахын тулд Австрали улсын боловсролын тогтолцоотой (олон улсын нөхцөл байдал) харьцуулах нь зүйтэй.


Монгол, Австрали улс хоёулаа боловсролын 12 жилийн тогтолцоотой. Хоёр улсад хоёуланд нь сургуульд орох албан ёсны нас нь 6 нас. Монгол Улсын Засгийн газар 2008 онд бага, дунд сургуулийг боловсролын 12 жилийн тогтолцоонд шилжүүлсэн. Энэхүү тогтолцоонд 2016 онд бүрэн шилжиж дуусна. Монгол Улсад бага боловсрол нь 6 жил, бүрэн бус дунд боловсрол нь 3 жил, бүрэн дунд боловсрол нь 3 жилийн турш үргэлжилдэг. Австрали улсад бага боловсрол нь 7 жил, ахлах сургуулийн боловсрол нь 5 жилийн турш үргэлжилдэг. Монгол Улсын техник мэргэжлийн боловсролын (1 – 2.5 жил) дэд салбар нь бүрэн дунд техник мэргэжлийн сургалт, дээд сургуулийн бүрэн дунд боловсролын дараах дипломтой хөтөлбөр зэргээс бүрдэнэ. Австрали улсын муж тус бүр техник мэргэжлийн болон нэмэлт боловсролын тогтолцоотой. Эдгээр нь дээд боловсрол шаардлагагүй ажилд ажиллах мэргэжилтэн бэлддэг. Монгол Улсын дээд боловсролыг коллеж, дээд сургууль, их сургуулиудад олгодог. Дээд боловсролын бакалаврын сургалт нь ихэнхдээ 4 – 5 жил, эрүүл мэндийн боловсрол нь 6 жил үргэлжилдэг байна. Магистрын сургалт нь 1 – 2 жил, докторын сургалт нь 3 – 4 жил тус тус үргэлжилдэг. Үүний нэгэн адил, Австрали улсын дээд боловсрол нь гэрчилгээ, диплом, холбогдолтой эрдмийн зэргийг тус тус олгодог байна\*.

\*32

Өрхийн судалгаанд оролцогсдын 91.1% нь боловсрол эзэмшсэн, үлдсэн 8.9% нь ямар ч боловсролгүй/бичиг үсэг тайлагдаагүй байсан. Судалгаанд оролцсон нийт өрхийн 12% нь бага боловсролтой, 12.3% нь бүрэн бус дунд боловсролтой, ойролцоогоор 40% нь техник мэргэжлийн боловсролтой, үлдсэн 13% нь дээд боловсролтой байв. Хүснэгт 5.3-д харуулсанчлан төслийн бүсийн хүн ам боловсролын түвшнээр ерөнхийдөө өндөр байна (техник мэргэжлийн болон дээд боловсрол эзэмшсэн хүн ам нь 50%-аас их байв). Судалгаанд оролцсон малчин өрхүүдийн (нийт судалгаанд оролцсон өрхийн 14%) ихээхэн хувь нь бага боловсролтой байв. Ямар нэгэн боловсрол эзэмшээгүй хүн амын ихээхэн хувь (11%) нь Түнхэл багт байгааг нь багийн ихэнхи айл өрхүүд багийн төвийн сургуулиас алслагдсан байдагтай холбон тайлбарлаж болох юм. Энэ нь оршин суугчдын гол асуудал болоод байгаа ба Хүснэгт 5.3-с харахад Түнхэл багийн хүн амын боловсролын түвшин Хэрх баг, Мандал ба Баянгол сумдын боловсролын түвшнээс доогуур байна. Боловсролын хүртээмж тааруу байгаа явдал нь үр хүүхдийн амьдралд төдийгүй ядуурлыг буруулах, хувь хүний болон эдийн засгийн хөгжилд муугаар нөлөөлөх зэрэг урт хугацааны уршигтай. Түнхэл багийн иргэд боловсролын түвшнээр доогуур байгаа учир аливаа эдийн засгийн болоод хөдөлмөр эрхлэлтийн боломжуудыг хүртэх чадвараар дутмаг байж болох юм. Зураг 5.2-д төслийн бүсийн боловсролын түвшнийг харуулав.

<sup>32</sup> Монгол, Австрали улсуудын боловсролын тогтолцооны харьцуулалт. 2013.

<http://www.ukessays.com/essays/education/comparison-between-mongolian-and-education-essay.php#ixzz3h4LV2rJ7>



**Зураг 5.2 Төслийн бүсийн боловсролын түвшин**

Судалгаанд оролцсон нийт өрхүүдийн 6 – 18 насны хүүхдүүдийн 3.4% нь сургуулиас завсардсан байна. Сургуулиас завсардсан хүүхдүүдийн тоо жигдхэн байв, тухайлбал Мандал суманд 4.1%, Түнхэл багт 3.1%, Хэрх багт 5% тус тус байна. Сургуулиас завсардсан хүүхдүүд ихэвчлэн малчдын хүүхдүүд бөгөөд малчдын хүүхдүүдийн 6.5% нь сургуулиас завсардсан бол малчин бус өрхүүдийн хүүхдүүдийн дөнгөж 1.2% нь сургуулиас завсардсан байна. Малчдын хүүхдүүдийн сургуулиас завсардаж буй гол шалтгаан нь гэр бүлдээ мал маллахад нь туслах, өөрийн болон эцэг эхчүүдийн боловсрол эзэмших сонирхолгүй байдал, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг юм. Сургуулиас завсардсан хүүхдүүдийн зөвхөн 3 нь албан бус боловсрол эзэмшүүлэх хөтөлбөрт хамрагдсан байна. Боловсролын хөтөлбөрийг алслагдсан айл өрхүүд, сургуулиас завсардсан боловч цаашид боловсрол үргэлжлүүлэн эзэмших хүсэлтэй хүүхдүүдэд зориулан хэрэгжүүлдэг. Эдгээр хөтөлбөрийн багш нарыг ихэвчлэн аймгийн төвөөс авчирдаг. Ийм хөтөлбөрийг голчлон хандивлагч байгууллагууд (НҮБ-ын Хүүхдийн сан<sup>33</sup>, Дэлхийн банк<sup>34</sup>) Монгол Улсын Засгийн газартай хамтран санхүүжүүлдэг.

**Хүснэгт 5.3 Судалгаанд оролцогсдын боловсролын түвшин, хувь<sup>35</sup>**

Боловсролын түвшин	Сум		Баг			Өрх		Нийт
	Баянгол	Мандал	Түнхэл	Хэрх	Бусад	Малчин	Суурин	
Боловсролгүй	8.4	9.2	11.0	7.0	8.7	8.5	9.1	8.9
Боловсролтой	91.6	90.8	85.0	93.0	91.3	91.5	90.9	91.1
Бага	11.3	13.2	12.8	12.5	12.3	14.0	11.8	12.5

<sup>33</sup> [www.unicef.org/education/mongolia](http://www.unicef.org/education/mongolia).

<sup>34</sup> [www.worldbank.org/projects](http://www.worldbank.org/projects).

<sup>35</sup> Састайнабилити Ийс Эйжия ХХК, 2015. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, 2015.

Бүрэн бус дунд	15.6	10.5	11.7	10.6	14.2	9.8	13.5	12.3
Бүрэн дунд	44.5	39.6	38.4	40.9	44.3	41.9	41.1	41.4
Техник мэргэжлийн/коллеж	10.1	13.1	12.8	12.8	10.7	11.0	12.6	12.0
Дээд боловсрол	10.1	14.4	13.3	16.2	9.8	14.8	11.9	12.9
<b>Нийт</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Хариулагсдын тоо</b>	<b>416</b>	<b>773</b>	<b>383</b>	<b>359</b>	<b>447</b>	<b>399</b>	<b>790</b>	<b>1,189</b>

### 6.1.6 Яс үндэс

Монгол Улсад 20 мянган ястан үндэстэн байдаг ч энэ нь үймээн самуун, зөрчил маргааны шалтгаан болдоггүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Монгол Улсын угсаатны гол бүлэг болох халхчууд (75% орчим) Монгол Улс даяар тархан суурьшсан байна. Угсаатны бүлгүүдийг ерөнхийд нь халх монгол, баруун монгол буюу ойрд, зүүн-хойд монгол (буриад), түрэг хэлтэн (казак, хотон, тува) хэмээн дөрвөн тусдаа дэд бүлэгт хуваадаг юм. Хэл шинжлэлийн хувьд Монгол Улс нь нийтлэг, хүн амын 90% орчим нь монгол хэлний хэд хэдэн төстэй аялгаар ярьдаг бөгөөд олонхи болох халхчуудын ярьдаг халх монгол аялгаар ярьж хэлэлцдэг байна.

*Халх гэдэг нэр томьёог арван зургадугаар зууны дунд үеэс эхлэн хэрэглэж ирсэн бөгөөд Монгол Улсын төв хэсгийн өндөр уул, тал нутгаар нутаглах нүүдэлчдийг нэрлэдэг байв. Хорьдугаар зуунд тэд улсын төв болон зүүн бүсийн ихэнх хэсэгт тархан суурьшсан байна. Халх монгол хэл нь албан ёсны хэл учир түүнийг сургуулиудад зааж, албан хэрэг эрхлэхэд ашигладаг. Бичгийн хэл нь Улаанбаатрын бүсийн халх аялга дээр суурилсан ба монгол бичгийг 1941 – 1946 онуудын хооронд кирилл үсгээр солих явцад Орос улсын кирилл үсгийг халх аялгад тохируулан өөрчилсөн байна.<sup>36</sup>*

2010 оны хүн амын тооллогоор улсын хэмжээнд гаргасан шиг Сэлэнгэ аймгийн яс үндэстний бүтцийг гаргасан байна. Өмнө хийгдсэн тооллоготой харьцуулахад баяд, хотон, урианхай, дөрвөд хүмүүсийн тоо (эдгээрийн ихэнхи нь баруун аймгаас шилжин ирсэн) нэмэгдсэн ч казак, торгууд, буриад хүмүүсийн тоо бага зэрэг буурсан байна. Хүн амын сургалт судалгааны төвийн (ХАССТ) 2010 онд хийсэн “Дотоодын шилжилт хөдөлгөөний судалгаа”-ны тайлангаас харахад шилжилт хөдөлгөөн (баруун бүсийн аймгуудаас төвийн бүс рүү, тэр дундаа Сэлэнгэ аймаг руу шилжих хөдөлгөөн) урсгал нь төслийн бүсийн орчимд ихээхэн илэрсэн бөгөөд энэ нь улсын хэмжээний шилжилт хөдөлгөөний хандлагатай тохирч байна. Тухайлбал, баруун аймгийн айл өрхүүд санхүүгийн боломжтой болсон үедээ Улаанбаатар хот руу нүүх зорилготой замдаа түр хугацаагаар Сэлэнгэ зэрэг газарт суурьшдаг байна. Ийнхүү Сэлэнгэ аймгийг сонгосон гол шалтгаан нь баруун аймгуудын олон айл өрхүүд нь Сэлэнгэ аймагт тэднийг түр хугацаанд дэмжиж тэтгэх нийгэм дэхь гэр бүлийн бат хэлхээ холбоотой байдаг явдал юм.

*Баруун монголоос гаралтай казак нь Түнхэл багийн хоёр дахь хамгийн том ястан ба ойролцоогоор 336 хүн тоологдсон (3,400 хүн тоологдсон халхууд хамгийн том ястныг бүрдүүлж байна). Социализмын үед казакчуудыг мод боловсруулах үйлдвэр рүү ажиллуулахаар цөлдөг байсан нь Түнхэл багт казак хүн ам олон байгааг тайлбарлаж байгаа. Үүний зэрэгцээ, цэргээс халагдахдаа казак цэргүүд нутаг руугаа буцалгүй Түнхэл багт суурьшдаг байжээ. Казакчууд исламын шашинтай ба Түнхэл багт ислам шашны сүм байдаг.*  
Састэйнабилити Ийст Эйжия ХХК, Гацууртын төслийн бүсийн биет бус соёлын өвийн этнографийн тайлан

<sup>36</sup> Роберт Л. Вондер, Андре Матлэс Савада, редактор. Монгол Улс: Улсын судалгаа. Вашингтон: Конгрессын номын сангийн ЗГХА, 1989.

Монгол Улсад 6 сар буюу түүнээс дээш хугацаагаар амьдарч буй гадаадын иргэдийн тоо 2000 оноос хойш улсын хэмжээнд 3 дахин нэмэгдсэн байна. Бүгд Найрамдах Хятад ард улсын иргэдийн тоо хамгийн их байгаа (нийт гадаад иргэдийн 91.2%) ба хятадуудыг барилга, бүтээн байгуулалтын төслүүд дээр ажиллуулж байгаатай холбоотой энэ тоо өссөн байна.<sup>37</sup> 2010 оны улсын хүн амын тооллогоор 16,320 гадаад иргэд Монголд албан ёсоор бүртгэлтэй байсан ба үүний дөнгөж 0.3% нь Сэлэнгэ аймагт амьдардаг байна. Сэлэнгэ аймагт 6 буюу түүнээс дээш сараар амьдарч буй гадаад иргэдийн тоо 2000 оныхтой харьцуулахад 98 хүнээр нэмэгдсэн нь аймгийн хүн амын хэмжээтэй харьцуулахад ялимгүй бага тоо юм.

### **6.1.7 Шашин шүтлэг**

Монголчууд эрт дээр үеэс бөө мөргөлтэй байсан ба энэ нь дэлхий ертөнцийг “мөнх хөх тэнгэр”-ийн хүчин доорхи бүхэл органик зүйл гэж үздэг итгэл үнэмшил юм. Гэвч 13 дугаар зуунд төвдөөс гаралтай буддын шашин өргөн нэвтэрсэн байна. Хорьдугаар зууны эхэн үед Монгол Улсад хэдэн зуун буддын сүм хийд байсан. 1921 оны Ардын хувьсгалын дараа Монгол Улсад социалист дэглэм тогтож, шашин шүтлэгийг хориглон, 1930-аад оны улс төрийн цэвэрлэгээний үед улсын хэмжээнд байсан сүм хийдүүдийг устгасан байна. Коммунист дэглэмийн үед шашингүй үзлийг сурталчилж, сүм хийдийг хаасан бөгөөд бөөгийн зан үйл ихээхэн алдагдсан байна. 1945 – 1990 онуудын хооронд зөвхөн нэг хийдийг (Улаанбаатар хотын Гандан хийд) үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн байсан. 1990-ээд онд эхэлсэн ардчилсан хувьсгал шашин шүтэх эрхийг сэргээсний үндсэн дээр 100 гаруй сүм хийд дахин үүд хаалгаа нээсэн. Ислам шашинтай казакуудыг шашинаа шүтэхийг зөвшөөрсөн бөгөөд Монгол Улсын баруун хязгаарт Сунни ислам шашин шүтдэг цөөнх нь ихэвчлэн казакууд юм. Сүүлийн хэдэн арван жилийн турш бөөгийн зан үйл мөн дахин сэргэж эхэлсэн байна.

Монгол Улсын нийт хүн амын талаас илүү хувь нь буддын шашинтай (Хүснэгт 5.4-г үзнэ үү) ч айл өрхүүдийн амьдралд шашин томоохон үүрэг гүйцэтгэдэггүй болох нь илэрхий байна. 15 ба түүнээс дээш насны нийт хүн амын 61.4% орчим нь шашин шүтдэг гэж хариулсан бөгөөд хүн амын талаас илүү (53%) хувь нь буддын шашин шүтдэг байна. Эрэгтэйчүүдийг бодвол эмэгтэйчүүд илүүтэйгээр (8.5%-р илүү) шүтлэгтэй байна.

Сэлэнгэ аймгийн нийт хүн амын 44.0% нь шашин шүтдэг гэж хариулсан нь улсын дундажаас 17.4%-р бага байна. Хүйсээр харьцуулж үзэхэд эмэгтэйчүүдийн 48.9% нь шашин шүтлэгтэй байгаа нь эрэгтэйчүүдтэй харьцуулахад 9.7%-р илүү байна. Шашин шүтлэгийн төрлөөр нь нарийвчлан задлахад 38.8% нь буддын шашинтай, 1.9% нь ислам шашинтай, 0.8% нь бөө мөргөлтэй, 2.1% нь христийн шашинтай бол үлдсэн 0.4% нь бусад шашин шүтдэг байна. Өрхийн судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь тодорхой нэгэн шашны бүлэгт хамаардаг гэж хариулсан нь аймгийн статистик мэдээтэй тохирч байна. Хэрх багийн судалгаанд оролцсон хүмүүс хамгийн ихээр шашин шүтдэг буюу 70.3%-тай байгаагаас ихэнхи (85%-с илүү) нь буддын шашин шүтдэг байна. Буддын шашин нь Баянгол суманд хамгийн түгээмэл тархсан бөгөөд шашин шүтлэгтэй хүмүүсийн 92.3% нь буддын шашин шүтдэг байна.

<sup>37</sup> Үндэсний статистикийн газар (2012). 2010 оны Хүн ам, орон сууцны тооллогын дүн, Сэлэнгэ аймаг, Монгол Улсын Үндэсний статистикийн газар, 52 хуудас, Улаанбаатар.

**Хүснэгт 5.4 15 буюу түүнээс дээш насны хүн амын шашин шүтлэгийн статус, хувь**

Шашин	Улсын түвшин (%)			Сэлэнгэ аймаг (%)		
	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй
Шашин шүтлэггүй	38.6	42.9	34.4	56.0	60.8	51.1
Шүтлэгтэй	61.4	57.1	65.6	44.0	39.2	48.9
Будда	53.0	49.4	56.4	38.8	34.9	42.7
Ислам	3.0	3.1	3.0	1.9	1.8	2.1
Бөө	2.9	2.7	3.1	0.8	0.7	0.8
Христ	2.2	1.6	2.7	2.1	1.4	1.9
Бусад	0.4	0.4	0.4	0.4	0.4	0.4

Өрхийн судалгаагаар буддын шашин шүтдэг иргэдийн 20-оос илүү хувь нь өөрийн номын багш, ламтай гэж (Хүснэгт 5.5-г үзнэ үү) гарсан байна. Энэ үзүүлэлт нь малчдын дунд хамгийн өндөр байна (30.7%). Судалгаанд оролцогсдын хийдэг шашны зан үйлийн тоонд амьдралын бэрхшээл тулгарах, сэтгэл гутрах, өөртөө итгэх итгэлээ алдах, томоохон шийдвэр гаргах үедээ оюун санааны хамгаалалт хайх, номын багш, ламаас зөвөлгөө авах, ариун дагшин газарт (сүм/хийд/исламын сүм) очиж мөргөх зэрэг багтана. Үүнээс гадна, шашин шүтлэгтэй хүмүүсийн 95-с дээш хувь нь орон нутгийн иргэд тэдний шашин шүтлэгийг хүлээн зөвшөөрдөг, төслийн бүсийн ойр орчимд шашин шүтлэгт хүлээцтэй хандаж, ялгаварлан гадуурхадаггүй гэдгийг цохон тэмдэглэсэн байна (улсын хэмжээнд мөн адил).

**Хүснэгт 5.5 Судалгаанд оролцогсдын шашин шүтлэг, шашин шүтлэгийн төрөл ба хувиар<sup>38</sup>**

Шүтлэгтэй	Сум		Баг			Өрх	
	Баянгол	Мандал	Түнхэл	Хэрх	Баянгол	Мандал	Түнхэл
Шашин шүтдэг хүн амын %	47.4	59.6	50.0	70.3	48.3	58.9	53.7
Өөрсдийн багш-ламтай хүн амын %	21.9	24.7	28.8	22.9	20.8	30.7	20.1
Будда	92.3	85.3	81.7	89.2	90.3	89.3	86.4
Ислам	4.6	2.7	1.7	3.6	4.2	1.3	4.3
Бөө	0.0	2.7	6.7	0.0	0.0	1.3	2.1
Христ	3.1	9.3	10.0	7.2	5.6	8.0	7.1

**6.1.8 Дүгнэлт**

Энэхүү нийгмийн суурь судалгааны явцад хүн ам зүйн хэд хэдэн гол асуудлуудыг хөндөж гаргаж ирсэн. Бодит байдал дээр шилжин ирэгсдийн тоо буурч байгаа (статистик мэдээллийн дагуу) ч бэлчээрийн доройтол, газар ашиглалтын маргааны гол шалтгаан болох гадны малчид шилжин ирэх нь ихэссэн гэсэн ойлголт орон нутгийн иргэдийн дунд байсаар байна. Мандал, Баянгол сумдад шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлаас гадна хүн ам зүйн бүтэцтэй холбоотой бэрхшээлүүд тулгарч байна. 20 – 24 насны залуучууд ихтэй Мандал суманд тулгарч буй гол бэрхшээл нь залуучуудад зориулсан техник мэргэжлийн, боловсрол, эдийн засгийн боломж бүрдүүлэх, ажлын байраар хангах явдал юм. Бага насны хүүхдүүд ихтэй Баянгол сумын гол бэрхшээл нь цэцэрлэг, бага, дунд сургууль, эмнэлэгийн анхан шатны үйлчилгээ зэрэг шаардлага хангасан байгууламжаар хангах явдал юм.

<sup>38</sup> Састайнабилити Ийст Эйжия ХХК, 2015. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, 2015.

Баянгол, Мандал сумдын гэр бүл салалтын өндөр түвшинтэй холбоотойгоор үүсэх гол эрсдэл нь өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо нэмэгдэх явдал юм. Эмэгтэйчүүд толгойлсон өрх (эдийн засгийн нөөц ашиглахтай холбоотой жендерийн зөрүүгээс үүдэлтэй) нь эрэгтэйчүүд толгойлсон өрхөөс илүү эмзэг байдаг. Статистикийн мэдээ нь Мандал сумын өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо 2012 онд 134 байснаас 2013 онд 167 болж 33 өрхөөр нэмэгдсэнийг харуулж байна. Энэ хугацаанд Түнхэл багт 11 өрх толгойлсон эмэгтэй нэмэгдсэн байгаа нь энэхүү зураглал нь багт мөн ажиглагдаж байгаа харуулж байна.

Түнхэл багийн иргэдийн боловсролын түвшин доогуур байгаа учир эдийн засгийн болоод хөдөлмөр эрхлэлтийн аливаа боломжуудыг хүртэх чадвараар дутмаг байж болох юм. Түнхэл багийн боловсролын ерөнхий түвшин Мандал, Баянгол сумд болон Хэрх багийн боловсролын түвшнээс доогуур байгаа нь тус багийн хувьд хамгийн гол асуудал юм. Боловсролын хүртээмж тааруу байгаа байдал нь үр хүүхдийн амьдралд төдийгүй ядуурлыг буруулах, хувь хүний болон эдийн засгийн хөгжилд муугаар нөлөөлөх зэрэг урт хугацааны уршигтай.



## **6.2 НИЙГМИЙН БҮТЭЦ**

### **6.2.1 Оршил**

Энэ хэсэгт нийгмийн бүтэц, тэр дундаа нийгмийн бүтцийн өөрчлөлт, хандлага, өнөөгийн нөхцөл байдлын улсын дундаж үзүүлэлтийг Сэлэнгэ аймаг, Мандал, Баянгол сумд ба Түнхэл багийн үзүүлэлтүүдтэй харьцуулсан байна. Энэхүү тайлан нь нийгмийн хөгжил, улс төрийн түүх, иргэдийн нийгэм-улс төрийн оролцоо ба сонгогдсон улс төрчдийн үнэлгээ, шийдвэр гаргах албан ба албан бус үйл явц, нийгмийн байгууллагуудын өнөөгийн байр суурь зэрэг сэдвүүдийг тусгайлан авч үзсэн.

### **6.2.2 Ашигласан тоо мэдээлэл**

Суурь судалгааг 2012 – 2015 онуудын тоо мэдээлэлд тулгуурлан боловсруулсан болно. Үндэсний статистикийн хороо, хүн ам, байрны тооллого, Сэлэнгэ аймаг, Баянгол, Мандал сумдын Засаг даргын тамгийн газрын статистикийн хэлтэс зэргийн тайлангаас хоёрдогч тоо мэдээллүүдээ авав. Төслийн бүсэд хийсэн өрхийн түүвэр судалгаа, зорилтот бүлгийн хэлэлцүүлэг (ЗБХ), гол талуудтай хийсэн ярилцлага (ГТХЯ) зэргийн үр дүнг ашиглан анхдагч мэдээллээ цуглуулсан.

### **6.2.3 Нийгмийн бүтэц ба түүний үүрэг**

#### **6.2.3.1 Төрийн тогтолцоо**

Монгол Улс нь Их хурлын (парламент) гишүүд бүх нийтийн сонгуулиар 4 жил тутам сонгогдож гардаг парламентын засаглалтай улс юм. УИХ нь 76 суудалтай ба Ерөнхийлөгчийн сонгууль 4 жил тутам явагддаг. Нэг танхимтай парламентын хууль тогтоох замаар Засгийн газрын эрх зүйн салбарын бүтцийн өөрчлөлтийг хийсэн Монгол Улсын 4 дэх Үндсэн хууль нь 1992 онд батлагдсан юм. Энэхүү үндсэн хууль нь 6 бүлэгтэй. Үүнд: Төрийн бүрэн эрхт байдал, Хүний эрх болон эрх чөлөө, Засгийн газрын бүтэц, Засаг захиргааны болон нутаг дэвсгэрийн нэгж, Үндсэн хуулийн цэц болон Нэмэлт өөрчлөлт. Монгол Улсын төр нь гүйцэтгэх, шүүх, хууль тогтоох байгууллагуудаас бүрддэг ба эдгээр байгууллагуудын эрх мэдэл, сонгогдох үйл явцыг Хүснэгт 6.6<sup>39</sup>-д харуулсан.

<sup>39</sup> <http://globaledege.msu.edu/countries/mongolia/government> болон <http://mongolianembassy.us/about-mongolia/government-and-politics/#.VZI6j2BzWS0> –с авав.

**Хүснэгт 5.6 Төрийн байгууллагуудын эрх мэдэл, сонгогдох үйл явц**

	Тайлбар	Гол эрх мэдэл	Сонгогдох үйл явц	Сонгуулийн давтамж
<b>Гүйцэтгэх</b>	Засгийн газар нь Монгол Улсын гүйцэтгэх дээд байгууллага бөгөөд Ерөнхий сайд тэргүүлдэг.	Ерөнхийлөгч билэгдэлийн чанартай ч Монгол Улсын төрийн тэргүүний үүрэг гүйцэтгэдэг байна. Ерөнхий сайд Монгол Улсын 21 аймаг/нийслэлийн Засаг дарга нарыг томилдог.	Ерөнхийлөгч нь хоёр удаа улирах эрхтэйгээр олонхийн саналаар сонгогдож гардаг ба Ерөнхий сайд УИХ-аас сонгогдоно.	4 жил
<b>Шүүх</b>	Үндсэн хуулинд зааснаар Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүгчдийг сонгож, тэдний эрх ашгийг хамгаалж ажилладаг. Дээд шүүх нь шүүхийн хамгийн дээд байгууллага юм. Шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс нэрийг нь дэвшүүлж, УИХ-аар хэлэлцэгдэн Ерөнхийлөгч томилдог.	Шүүхийн дээд байгууллага	Дээд шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс нэрийг нь дэвшүүлж, Ерөнхийлөгч томилдог.	Урт хугацааны томилгоо
<b>Хууль тогтоох</b>	Монгол Улсын Парламент нь Улсын Их Хуралд хамаарагддаг төрийн эрх барих дээд байгууллага юм. УИХ нь Ерөнхий сайд, Засгийн газрын сайд нарын томилгоог баталдаг.	Засгийн газартай хамтран шинэ хууль боловсруулж, улмаар өргөн барих, жилийн төсвийг батлах, мөн дайн зарлах эрхтэй.	Нэг танхимд УИХ нь сонгуулийн 26 тойргоос шууд сонгогдсон 48 гишүүнтэй ба 28 гишүүн нь нийт саналын намын хувийн харьцаан дээр үндэслэн сонгогддог.	4 жил

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь Засгийн газрын төв болон өөрөө удирдах хосолсон зарчим дээр үндэслэн зохион байгуулагдсан байна. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг, сум, багт байрладаг Иргэдийн төлөөлөгчдийн хурал (ИТХ) гэж нэрлэдэг. Аймаг, нийслэлийн ИТХ нь дөрвөн жилийн хугацаатай сонгогддог. Сум, дүүргийн ИТХ-ын эрх мэдлийг тодорхойлох нь "Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яам, агентлаг, ИТХ-аас дээд шатны болон бусад эрх бүхий төрийн байгууллагууд, шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан хуулийн дагуу болон бүрэн эрхийнхээ хүрээнд тодорхойлсон нийгэм, эдийн засаг, зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэх, шийдвэр гаргах эрхтэй."<sup>40</sup> Аймаг, сум, томилогдсон ИТХ үүргийг дараах байдлаар нэгтгэж болно:

- Засаг даргын үйл ажиллагааг батлах, хянах, үнэлэх;

<sup>40</sup> Иргэдийн төлөөлөгчдын хурлын үүрэг хариуцлага: <http://www.khural.mn/en-us/n/8xyy>

- ИТХ-аар батлагдсан хууль тогтоомж, шийдвэрийн Засаг даргын хэрэгжилтэнд хяналт, үнэлэх;
- Нийгэм, эдийн засгийн хөгжлийн стратегийг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах;
- Төсвийг хэлэлцэх, нэмэлт өөрчлөлт оруулах, батлах мөн хэрэгжилтийн тайланг хэлэлцэн батлах;
- Төсвийн бус орлоготой Орон нутгийн хөгжлийн санг бүрдүүлж, хяналт тавих;
- Бүс нутгийн стратегийг орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн стратегитай уялдуулах;
- Хуулийн хүрээнд төлбөр, хураамж ноогдуулах;
- Газар ашиглалтын менежментийн төлөвлөгөө, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг батлах; ба
- Орон нутгийн өмчлөлийн эрхийг баталгаажуулах.

#### 6.2.3.2 Улс төрийн түүх

1921 оны Монгол Улсын хувьсгалаас эхлэн Ардчилсан хөдөлгөөн бий болсон үе буюу 1990-ээд оны Зөвлөлт холбоот улс унах хүртэл Монгол Улсын Засгийн газар Зөвлөлтийн тогтолцоог загварчилсан бөгөөд Коммунист нам буюу Монгол Ардын Хувьсгалт Нам (МАХН) удирдаж байсан. 1990 оны ардчилсан хувьсгал Монголд засаглалын олон намын системийг бий болгосон ба Азид коммунизмаас шилжсэн анхны улс болсон. 1990 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөнд Ерөнхийлөгч, хууль тогтоох байгууллага, сөрөг хүчний намуудыг үүсгэн бий болгох арга замуудыг оруулж өгсөн байна. Монгол Ардын хувьсгалт нам (МАХН) нь 1990 оны анхны олон намын тогтолцоот сонгуульд 85% -ийн суудал авч байсан бол Ардчилсан нам (АН) нь 1996 онд ихэнхи суудлыг авах хүртлээ ялалт байгуулаагүй байна. 1993 оноос хойш Монголд 6 удаагийн Ерөнхийлөгчийн сонгууль болсон ба МАХН нь 3 удаагийн сонгуульд, АН нь бас 3 удаагийн сонгуульд ялалт байгуулж байсан байна. Монголд байгаа улс төрийн гол намууд:

- Өмнө нь МАХН байсан Монгол ардын нам (МАН);
- Шинээр бий болсон Монгол ардын хувьсгалт нам (МАХН) МАН-ын бүлгээс тасарч гарч 2010 онд байгуулагдсан;
- 2000 онд ардчилсан хувьсгалт намууд нэгдэх замаар үүсгэн байгуулагдсан Ардчилсан Нам; ба
- 2000 онд байгуулагдсан Иргэний Зориг, Ногоон нам (ИЗНН).

2004 – 2008 оны хооронд МАХН болон АН-ын эвсэл Засгийн газрыг удирдаж байсан. МАН болон АН-ын хооронд байгуулагдсан эвслийн Засгийн газар дахин 2008 – 2012 оны хугацаанд байгуулагдсан. 2012 оноос хойш өөр бас эвслийн Засгийн газар гарч ирсэн (доор байгаа мэдээллийг үзнэ үү). Дараагийн сонгууль 2016 онд болно.

#### 6.2.3.3 Одоогийн засгийн газар

2012 оны 6 дугаар сард Монгол Улсын УИХ-ын сонгууль 6 дахь удаагаа зохион байгуулагдсан ба АН – 27, МАН – 24, МАХН – МҮАН эвсэл – 17; ИЗНН - 4; бие даан нэр дэвшигч – 2; MGP – 1; болон

гурав дахь хүчний эвсэл<sup>41</sup> – 1 суудлыг авсан. Ихэнхи суудлыг авсан АН шинэ эвсэлийн Засгийн газрыг байгуулсан ба шинэ МАХН болон Монголын Үндэсний Ардчилсан Нам (МҮАН) хамтран байгуулсан “Шударга ёс” эвслийг сонгосон. Энэхүү эвслийн Засгийн газар улс орны эдийн засгийг эргэлтэнд оруулж, гадаадын хөрөнгө оруулалтын уур амьсгалыг наашлуулах зорилготой “Шийдлийн Засгийн газар” гэж нэрлэгдсэн байна<sup>42</sup>. Одоогийн Засгийн газар хоорондоо зөрчилдөөнтэй байгаа ба 2014 оны сүүлээр Норовын Алтанхуягын оронд шинэ Ерөнхий сайд (Чимэдийн Сайханбилэг) эргэлзээгүйгээр сонгогдон гарч ирсэн. Сайханбилэг нь эдийн засгийг дахин сэргээж, мухардалд орсон Оюу Толгой төслийн өргөтгөлийн хөрөнгө оруулалтын гэрээг шийдвэрлэх (тогтоол нь гадаадын хөрөнгө оруулагчдад эерэг сэтгэгдэл төрүүлэх болно), илүү тогтвортой орчныг бий болгох зорилгоор чухал ач холбогдолтой хууль эрхзүйн шинэчлэлийг хийх байх гэж найдаж байна. Гэсэн хэдий ч, улс төр, олон нийтийн ухамсарт төдийгүй Сайханбилэгийн үүсгэн бий болгосон тогтвортой байдал үргэлжлэн тогтвортой байж чадах эсэх гэсэн бодолд 2016 оны сонгууль аль хэдийн нөлөөлж эхэлсэн байна.<sup>43</sup>

#### 6.2.3.4 Сэлэнгэ аймгийн сонгууль

Сэлэнгэ аймагт болсон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дүр зураг нь улсын хэмжээнд болсон сонгуулийн үр дүнтэй (Хүснэгт 6.7) ойролцоо байна. Сонгуулийн үр дүнг доор харуулснаар, Монголын хөдөө орон нутагт болдог сонгуултай ижилхэн Сэлэнгэ аймгийн иргэд ихэвчлэн томоохон хоёр намын (МАН, АН-ын) төлөө буюу МАН-нд илүү санал өгдөг байна. Мандал суманд МАН-ын 16 гишүүн, АН-ын 13 гишүүн, 1 Шударга ёс эвсэлийн (МАХН болон МҮАН) гишүүн, 1 бие даан нэр дэвшигч зэргээс бүрдсэн нийт 31 ИТХ-ын төлөөлөгч байдаг. Баянгол суманд нийт 27 ИТХ төлөөлөгчид байдаг ба эдгээр төлөөлөгчдийн 19 нь МАН-аас, 7 нь АН-аас сонгогдсон. Нэг төлөөлөгч нь шинээр бүрдсэн МАХН-аас гарч ирсэн байна.

#### Хүснэгт 5.7 Сүүлийн гурван удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүн, 2005, 2009 ба 2013 он<sup>44</sup>

Нэр дэвшигчид	Нэр дэвшсэн намууд	Санал өгөх			
		Улсын дундаж		Selenge level	
		Too	%	Too	%
2005					
Н. Энхбаяр	МАХН	497,491	53.4	16,986	49.5
М. Энхсайхан	Эх орон-Ардчилсан эвсэл	186,646	20.1	6,480	18.9
Б.Эрдэнэбат	Эх орон нам	105,497	11.3	3,071	8.96
Б.Жаргалсайхан	Бүгд найрамдах нам (БНН)	128,784	13.8	7,730	22.5
2009					
Ц.Элбэгдорж	Ардчилсан нам	562,718	51.2	20,422	50.2
Н.Энхбаяр	МАХН	520,948	47.4	20,197	49.6
2013					
Ц.Элбэгдорж	Ардчилсан нам	622,794	50.9	20,377	47.2
Б.Бат-Эрдэнэ	МАН	520,380	42.5	17,900	41.4
Н.Удвал	Шинэ МАХН	80,563	6.5	4,233	9.8

Өрхийн судалгаанд оролцогчдын (65%) ихэнх нь аль нэг улс төрийн намд харъяалагддаггүй гэж хариулсан байна. Улс төрийн намуудыг үндэсний болон орон нутгийн түвшинд дэмждэг эсэх

<sup>41</sup> Монгол Улсын 1992 – 2012 оны сонгуулийн үр дүн, хуудас 300 – 301.

<sup>42</sup> <http://mongolianembassy.us/about-mongolia/government-and-politics/#.VZI6j2BzWS0>.

<sup>43</sup> 2015 оны 8 сарын байдлаар одоогийн эвслийн засгийн гээээр хэд хэдэн өөрчлөлтийг хийсэн байна. АН (эвслийн олонхи) нь 2016 сонгуулийн бэлтгэл ажил болгон эвслийн Засгийн газрын зарим сайдуудыг сольсон байна.

<sup>44</sup> Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо. [http://www.qec.gov.mn/presidential\\_election/309/40](http://www.qec.gov.mn/presidential_election/309/40).

асуултанд, Мандал сумаас судалгаанд оролцогчдын 63% нь ямар нэгэн улс төрийн намыг дэмждэггүй гэж хариулсан бол 28% нь мэдэхгүй гэсэн байна. Харин Баянгол сумын судалгаанд оролцогчдын 53% нь аль нэг улс төрийн намыг дэмждэггүй гэсэн бол 37% нь мэдэхгүй байна гэж хариулсан байна. Үлдсэн 10 орчим хувь нь аль нэг намын үнэнч гишүүн байна. Сонгогчдын оролцоо, боловсрол, хандлагын талаарх Азийн сангийн 2009 оны тайланд Монголын улс төрийн намууд ихэнхи сонгогчдынхоо санаа бодлыг тодорхойлж чаддаггүй бөгөөд Монголчууд намууд болон нэр дэвшигчдийн байр суурь, үзэл бодлын талаарх ойлгоц дутмаг учраас нам, нэр дэвшигчдийг сонгоход хүндрэлтэй байдаг<sup>45</sup>. Өрхийн судалгааны дээрхи үр дүнг ингэж тайлбарлаж болно.

Сонгууль өгөх насны хүмүүсийн тоо өсч байгаа хэдий ч Монгол Улсад, ялангуяа Сэлэнгэ аймагт нь сонгогчдын оролцоо буурч байна. 1992 оноос хойших сонгууль бүрт сонгогчдын оролцоо буурсан үзүүлэлттэй байна. Хүснэгт 6.8-д харуулснаар, 1992 оны УИХ-ын сонгуульд оролцогчдын хувь 97,05%-тай байснаа, цаашдаа тогтвортойгоор буурч 2012 онд дөнгөж 65,25%-тай болсон байна. Сонгогчдын оролцоо өндөр байснаа буурч байгаа нь сонгуульд оролцох боломж олгож буй шинэ ардчилсан буюу шилжилтийн нийгэмд энгийн хандлага юм. 1992 оноос хойш Сэлэнгэ аймаг болон улсын хэмжээнд сонгогчдын оролцоо тогтмол буурсан байна. Улс төрийн идэвхгүй байдал, сонгогчдын оролцоо муу байдгийг Засгийн газар иргэдийн хүсэл эрмэлзлийг анхаардаггүй учир иргэд улс төрөөс ангид байхыг илүүд үздэг<sup>46</sup> гэж монголчуудын дийлэнх нь ойлгодогтойгоор холбон тайлбарлаж болох юм. Өрхийн судалгаанд оролцогчдын ихэнхи нь улс төрийн нэр дэвшигчид, улс төрийн намууд итгэдэггүй, сонгуулийн үйл явц нь шударга бус явагддаг гэж үзэж байгаа учраас сонгуульд идэвхигүй оролцдог гэж тайлбарласан байна. Мөн, судалгаанд оролцогчдын зарим нь албан ёсны бичиг баримт байхгүйн улмаас сонгуульд оролцдоггүй гэсэн хэдий ч энэ үнэхээр идэвхгүй байдал уу, (өөрөөр хэлбэл, тэд бүртгүүлэх сонирхолгүй) сонгуульд албаар оролцохгүй байна уу эсвэл бүртгэлийн үйл явц хүндрэлтэй байна уу гэдгийг тогтоож чадахгүй байсан.

#### **Хүснэгт 5.8 Сонгогчдын оролцоо, 1992, 1996, 2000, 2004, 2008, 2012<sup>47</sup>**

Он	Улсын хэмжээнд		Сэлэнгэ аймаг	
	Бүртгэгдсэн сонгогчдын тоо	Сонгогчдын оролцоо (%)	Бүртгэгдсэн сонгогчдын тоо	Сонгогчдын оролцоо (%)
1992	1,085,200	95.6	44,288	97.1
1996	1,147,300	92.1	49,351	91.2
2000	1,247,000	82.4	54,052	80.8
2004	1,329,800	81.8	52,199	82.1
2008	1,542,600	76.5	60,945	74.2
2012	1,840,800	67.3	69,407	65.3


Баянгол, Мандал сумдын судалгаанд оролцогчдын ихэнхи нь үндэсний, аймаг, сумын түвшний аль алинд нь улс төрийн нөхцөл байдлыг "хүлээн зөвшөөрөшгүй" гэж дүгнэсэн байна. Монголчуудын 60% нь Засгийн газрын үйл ажиллагаанд сэтгэл дундуур байдаг нь Засгийн газар иргэдийн асуудлыг тоодоггүй гэсэн ойлголтоос үүдэлтэй сэтгэл ханамжгүй байдал бөгөөд энэ нь Азийн сангийн судалгааны үр дүнтэй нийцэж байна. (өөрөөр хэлбэл, энэ нь тодорхой асуудалд

<sup>45</sup> Азийн сан. 2009. Монгол Улс дахь сонгогчдын боловсрол судалгаа.

<sup>46</sup> Азийн сан. 2009. Монгол Улс дахь сонгогчдын боловсрол судалгаа.

<sup>47</sup> Эх үүсвэр: [http://www.qec.gov.mn/presidential\\_election/309/40](http://www.qec.gov.mn/presidential_election/309/40) Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо

бус, ерөнхий сэтгэл ханамжгүй байдал юм).<sup>48</sup> Энэ нь олон нийтийн дунд улс төрийн нөхцөл байдлын талаар одоогийн бага хувь нэмэр оруулах нь бүх хүчин зүйл болдог. Сэтгэл ханамжгүй байдлын түвшин Баянгол сумтай харьцуулахад Мандал суманд өндөр байна. Харин эсрэгээрээ, судалгаанд оролцогчдын гуравны нэг орчим хувь нь (Зураг 6.3-г үзнэ үү) улс төрийн нөхцөл байдлыг “дунд зэрэг” гэж дүгнэсэн байна. Энэ доогуур үзүүлэлтт нь эдийн засгийн тогтворгүй байдал, Ерөнхий сайд өөрчлөгдсөн зэрэг сүүлийн үеийн улс төр, эдийн засгийн тогтворгүй байдлаас үйлдэлтэй байж болох юм. Эдгээр хүчин зүйлс нь хүн ам улс төрийн нөхцөл байдалд анхаарлаа бага хандуулдагт нөлөөлж байна.




**Зураг 5.3 Улс орны өнөөгийн улс төрийн нөхцөл байдлын талаарх ойлголт, сумдаар (%)**

Судалгаанд оролцогчдын тал хувь нь нэр дэвшигчийн хувь хүний зан чанар дээр үндэслэн саналаа өгдөг гэсэн бол судалгаанд оролцогчдын 30 орчим хувь нь (Зураг 6.4) намын мөрийн хөтөлбөр, хөгжлийн бодлогыг харгалзан үзэж санал өгдөг гэж хариулсан байна. Үүнээс гадна, нэр хүндтэй, хүндлэгдсэн нэр дэвшигч сумын ЗДТГ-ын удирдах албан тушаалд томилогддог гэж бодож байгаа эсэх асуултыг өрхийн судалгаанд хамрагдсан хүмүүсийн санал бодлыг үнэлэх зорилгоор асуусан. Баянгол сумын нийт судалгаанд оролцогчдын 41.5% нь “тохирсон нэр дэвшигчид сонгогдож чаддаг” гэсэн бол 21.5% нь “намын харьяаллаар албан тушаалд томилогддог” гэж хариулжээ. Харин, Мандал сумын хувьд судалгаанд оролцогчдын 43.2% нь “тохирсон нэр дэвшигчид сонгогдож чаддаг” гэсэн бол 26.1% нь тохирсон нэр дэвшигчийг сонгож “огт чаддаггүй” гэж хариулжээ. Эдгээр нь хариулагчдын дийлэнх хувь нь “тохирсон сайн нэр дэвшигчид сонгогддог” гэж бодож байгаа ч бас санал нь тооцогддоггүй, шийдвэр гаргахад тэдний нөлөөлөл байхгүй байна гэж боддог хүчтэй цөөнх байгааг харуулж байна.

<sup>48</sup> Азийн сан. 2009. Монгол Улс дахь Сонгогчдын боловсрол судалгаа.





**Зураг 5.4 Судалгаанд хамрагдсан хүмүүсийн санал өгөх үндэслэл, хувиар, сумаар**

### 6.2.4 Төрийн байгууллагууд

Монгол Улсын засаг захиргааны анхдагч нэгж нь аймаг юм. Үндэсний түвшний төрийн байгууллагууд аймгийн түвшинд ажилладаг.<sup>49</sup> Орон нутгийн засаг захиргааны бүх шатанд Засаг дарга нь гол албан тушаалтан юм. Засаг дарга нар Засгийн газрын төлөөлөгчид бөгөөд холбогдох дээд шатны Засаг даргад шууд тайлагнадаг. Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны ИТХ-аар нэр дэвшигдэж, Ерөнхий сайдаар томилогддог байна. Аймагт Засаг дарга, Засаг даргын орлогч, дараах хэлтэсүүд байдаг. Үүнд: Засаг даргын тамгын газар; Хууль эрх зүйн хэлтэс; Үйлдвэр, худалдаа, хөдөө аж ахуйн хэлтэс, Байгаль орчны хэлтэс, Санхүү, эдийн засгийн бодлогын хэлтэс; Нийгмийн бодлогын хэлтэс зэрэг. Үүний зэрэгцээ, Засаг даргын удирдлаган дор байгаль орчин, хөдөө аж ахуйн хэлтэс зэрэг олон байгууллагууд байдаг.

Засаг захиргааны хоёр дахь нэгж нь сум, дүүрэг юм. Монгол Улсын дундаж сум нь 4200 км<sup>2</sup> талбай, ойролцоогоор 5000 гаруй хүн амтай. Ихэнх сумын санхүүжилтийг Засгийн газраас хийдэг. Дундаж сумын Засаг даргын тамгын газар нь ойролцоогоор 5-10 албан хаагчидтай, үүн дотор: Засаг дарга; Засаг даргын орлогч; Засаг даргын тамгын газрын дарга; Нийгмийн хөгжлийн мэргэжилтэн (боловсрол, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хариуцсан); Хөдөө аж ахуйн мэргэжилтэн, Байгаль орчны мэргэжилтэн, Нийгмийн ажилтан (ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлт болон нийгмийн халамж үйлчилгээ хариуцсан); мөн Үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн.



Монгол Улсын засаг захиргааны гурав дахь буюу хамгийн бага нэгж нь баг буюу хороо юм. Уг нэгж нь баг/хорооны Засаг дарга, Иргэний бүртгэл мэдээллийн ажилтан, хэсгийн ахлагч нараас бүрддэг. Баг/хорооны Засаг даргын үүрэг хариуцлагын талаар хууль тогтоомжид заасан байдаг. Баг нь Засаг захиргааны тухай болон Төсвийн тухай хуулиар зохицуулагддаг өөрийн төсөвтэй байдаг. Сумын ЗДТГ сум, орон нутгийн төсвийг захиран зарцуулах, зохицуулах эрх мэдэлтэй, баг нь урсгал зардал, тэтгэмж, шилдэг ажилтан, шилдэг иргэн, шилдэг татвар төлөгчдийн шагнал зэрэг тодорхой төсвийг захиран зарцуулдаг<sup>50</sup>.

<sup>49</sup> <http://zasag.mn>.

<sup>50</sup> 9-р багийн төрийн байгууллагуудын төлөөлөлтэй хийсэн ГТХЯ, Мандал сум.


Төслийн бүс болох Сэлэнгэ аймаг 17 сум, 56 багт хуваагддаг. Мандал сум 9 багтай ба 42 төрийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Баянгол сум 3 багтай бөгөөд суманд 5 төр захиргааны байгууллага, 5 нийтийн үйлчилгээний байгууллага байна.

Зураг 6.5 дээр төслийн бүсийн төрийн байгууллагуудад итгэх итгэлийн түвшинг харуулсан. Мандал сумын судалгаанд оролцогсдын 36.7%, Баянгол сумын судалгаанд оролцогчдын 43.3% нь сумын ЗДТГ-т итгэдэг гэж хариулсан байна. Ерөнхийдөө, иргэд төр захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд сэтгэл хангалуун биш байдаг учраас төрийн байгууллагуудад итгэх итгэл бага байдаг. Судалгааны бүсэд байрлах хоёр сумын аль алинд нь улс төрийн намуудад итгэдэггүй гэсэн хариулт өндөр байна. Баянгол суманд улс төрийн асуудал хуваагдмал байгаа ба улс төрийн намуудын алинд ч итгэдэггүй бас итгэдэг хүмүүс байна. Харин эсрэгээрээ, Мандал суманд улс төрийн намуудын тухай үзэл бодол нь ерөнхийдөө сөрөг байна. Судалгаанд хамрагдсан хоёр суманд сумын ЗДТГ, сумын ИТХ –д итгэх итгэлийн түвшин өндөр байгаа ба улс төрийн намууд, ТББ-уудад итгэх итгэл бага байна. Баянгол, Мандал сумдын судалгаанд оролцогчдын хариултууд нь төрийн байгууллагуудын итгэлцэлийн түвшинтэй ерөнхийдөө нийцэж байна.



### Зураг 5.5 Судалгаанд оролцогчдын байгууллагуудад итгэх хувь, сумаар

Зураг 6.6 дагуу Мандал сумын судалгаанд оролцогчдын дийлэнх нь "авлигад автсан" болон "иргэдийнхээ амьдралд үр дүнтэй уялдаа холбоо байхгүй" зэрэг нь сумын захиргааны байгууллагын үйл ажиллагаанд гол асуудал болж байна гэж хариулсан байна. Баянгол сумын судалгаанд оролцогчид сумын захиргааны байгууллагын үйл ажиллагааны гол дутагдалыг жагсаахдаа: судалгаанд оролцогсдын 28.6% нь "төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл муу", 27.6% нь "авилгад автсан" гэсэн байна. Эдгээр үзэл бодол нь энэхүү бүлгийн дээр дурдсан улс орны улс төрийн нөхцөл байдалд иргэд сэтгэл дундуур байгаатай нийцэж байна.



### Зураг 5.6 Сумын захиргааны чиг үүрэгт сэтгэл дундуур байгаа гол асуудлууд

#### 6.2.5 Нийгэм, улс төр, соёл, эдийн засгийн байгууллагууд

Төслийн бүсэд нилээд тооны нийгэм, эдийн засгийн байгууллагууд байна. Сэлэнгэ аймгийн бизнесийн бүртгэлд эдийн засгийн бүх салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа эдийн засгийн байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн салбарын талаар мэдээлэл багтсан байна. 2015 оны эхний 3 сарын байдлаар, Сэлэнгэ аймагт бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо 2.758 хүрсэн ба шинээр 72 аж ахуйн нэгж бүртгэгдэж, 6 аж ахуйн нэгж татан буугдсан байна. Шинээр бүртгэгдсэн аж ахуйн нэгжийн дөрөвний нэг нь хувийн болон хязгаарлагдмал хариуцлагатай компаниуд (ХХК) байна. Харин эдгээр аж ахуйн нэгжийн 66.7% нь төрийн бус байгууллагууд, олон нийтийн байгууллагууд, шашны байгууллагууд болон аж үйлдвэр байв.

**Хүснэгт 5.9 Бүртгэгдсэн аж ахуйн нэгжүүдийн тоо, 2015 оны 4 сарын байдлаар<sup>51</sup>**

Сумдын нэр	Хувийн компани (ХХК)	Банк бус санхүүгийн байгууллага	Хоршоо	Төрийн өмчид компани	Байгууллагын салбар	Төрийн үйлчилгээний байгууллага (сургууль, амьсгал)	ТББ	Шашны байгууллага	Сан	Нийт
Аймаг	1,544	236	157	14	372	222	160	21	32	2,758
Мандал	331	53	22	2	44	39	23	4	7	525
Баянгол	61	6	12	1	24	6	7	3	1	121

Нилээд тооны орон нутгийн ТББ-ууд, иргэний нийгмийн болон олон нийтийн байгууллагууд Сэлэнгэ аймагт идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Үүнд: Үйлдвэрчний эвлэл; Иргэний нийгмийн холбоо; Ажил олгогч эздийн холбоо; Нийгмийн түншлэлийн сүлжээ; Эмэгтэйчүүдийн, Залуучуудын, Ахмадын, Оюутны холбоо; Хүүхдийн байгууллага, Улаан загалмай, Орон нутгийн зөвлөл. Хүн амын тоотой харьцуулахад энэ нь нилээд өндөр тоо юм. Бүртгэлтэй Иргэний нийгмийн байгууллагууд олон байгаа ч бүгд идэвхтэй бус эсвэл зорилтот салбартаа үр дүнтэй ажиллаж чадахгүй байна.

**Хүснэгт 5.10 Сэлэнгэ аймагт бүртгэлтэй төрийн бус байгууллагуудын (ТББ) жагсаалт**

	Чиглэл	ТББ-уудын тоо
1	Байгаль орчин	17
2	Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд	6
3	Ахмадууд	3 (бас сум бүрт салбарууд байдаг)
4	Хүний эрх	8
5	Мэргэжлийн холбоод	5
6	Спорт, эрүүл мэнд	8

Орон нутгийн ИНБ-ын санхүүжилтийн гол эх үүсвэр нь гишүүнчлэлийн хураамж, орон нутгийн аж ахуйн нэгж, хувь хүмүүс, төслийн (өөрөөр хэлбэл, тодорхой чиглэлээр эсвэл газар зүйн бүсчлэлээр хөгжлийг дэмжих олон улсын буюу дотоодын санхүүжилттэй хөтөлбөрүүд) хандив, тусламж байдаг. Иргэний нийгмийн байгууллагуудад (ИНБ) тулгардаг нийтлэг бэрхшээл нь үйл ажиллагаа явуулах өөрийн оффис/ажлын байр дутагдалтай, иргэдийн оролцоо дутмаг, ажилтнуудын чадавхи сул, санхүүжилт хангалтгүй зэрэг байдаг. Энэ нь ихэнхи байгууллагуудыг эрх мэдэл багатай учраас үйл ажиллагаагаа бусдад хүргэх, санхүүжилтээ зохицуулах буюу байгууллагаа үр дүнтэй хөгжүүлэх чадавхи байхгүйгээс амжилттай үйл ажиллагаа явуулж чадахгүйд хүргэдэг. Доорх байгаа ишлэлээс харахад, төслийн бүсийн иргэд, олон нийтийн ИНБ-уудад итгэх итгэл, тэднийг хүлээн зөвшөөрөх байдал муу байна. Үүн дээр нэг тайлбар хэлэхэд, иргэдийн ИНБ-уудын үйл ажиллагааны талаарх ойлголт бага, мөн өөрийн үйл ажиллагааны зорилт, үр дүнгийн талаар нийтэд мэдээлдэггүй, харилцдаггүй, тайлагнадаггүйн улмаар энэ салбарийн талаар ихэвчлэн буруу ойлголтой байдаг.

<sup>51</sup> Сэлэнгэ аймгийн статистикийн хэлтэс

*"Мандал суманд 20 гаруй иргэний нийгмийн байгууллага байдаг боловч орон нутгийн иргэдийн дунд нэр хүнд муутай, хүлээн зөвшөөрөгдөх байдал муу байна."*

Мандал сумын ИТХ-ын даргатай хийсэн ярилцлага

## **6.2.6 Албан болон албан бус шийдвэр гаргах үйл явц**

Монголд албан болон албан бус шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоо чухал ач холбогдолтой юм. Албан ёсны шийдвэрийг (жилд 4 удаа)<sup>52</sup> сум, багийн ИТХ-ын үер суманд жилд хоёр удаа, багт жилд гурван удаа гаргадаг. ИТХ гишүүдийн үндсэн үүрэг, хариуцлага нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих; иргэдтэй зөвлөлдөх, тэднийг үйл ажиллагаандаа татан оролцуулах, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх явдал юм.

Хууль тогтоох үйл явцад иргэдийг татан оролцуулах арга замууд байдаг. Сумын ИТХ хүрээнд сум бүрт байгуулагдсан иргэдийн танхимаар дамжуулан иргэд төрийн үйлчилгээ, хуулийн төсөл дээр санал өгөх боломжтой. Засгийн газрын гол зорилго нь хэт төвлөрлийг сааруулах явдал юм. Төвлөрлийг сааруулах хэрэгжилтийн механизм бүхий Төсвийн тухай шинэчилсэн хуулиар (2012 он) дамжуулан энэхүү зорилгод хүрэх боломжтой юм. Энэхүү хуульд орон нутгийн засаг захиргаанд орон нутгийн хөгжилд түлхүү хяналт тавихад нь үр дүнтэй байх аргыг тусгасан Орон нутгийн хөгжлийн сангийн талаар танилцуулсан байна. Уг сан нь орон нутгийн иргэдийг орон нутгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход оролцох, багийн хурлууд дээр орон нутгийн хөгжлийн төслүүд дээр санал/зөвлөмжөө өгөх боломжийг олгодог. Гэсэн хэдий ч, орон нутгийн хөгжлийн сангаар дамжуулан хэрэгжих төслүүдийн эцсийн шийдвэрийг сумын ИТХ гаргана. Уг хуульд тусгагдснаар, сумын сонгогдсон ИТХ-ын гишүүд "Иргэний танхим"-ын хурал, хэлэлцүүлгээр дамжуулан иргэдийг хүлээн авч, уулзах, иргэдээс ирсэн санал, хүсэлт дээр тулгуурлан судалгаа хийх, орон нутгийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор сум/багийн Засаг дарга нартай хамтран ажиллах зэрэг нэмэлт үүрэг хүлээсэн байна.

Багийн ИТХ-ын гишүүд шийдвэр гаргах түвшинд багийн иргэдийг төлөөлдөг бөгөөд иргэдийн эрх ашиг, сонирхолыг хамгаалах, иргэдээс санал, хүсэлтийг хүлээж авах, орон нутгийн хөгжлийн төслүүдийг танилцуулах зэрэг ажлуудыг хийдэг. Багийн ИТХ-ын гишүүд иргэдийн нэрийн өмнөөс ухуулга сурталчилгаа явуулах бүрэн эрхтэй. Ерөнхийдөө, багийн иргэдийн хурлын шийдвэр гаргах явцад иргэдийн оролцоо маш бага байна. Өрхийн судалгаанд оролцогчдын оролцооны байдлыг асуухад Баянгол, Мандал сумдын бусад багийн судалгаанд оролцогчдын 55% нь, Түнхэл багийн судалгаанд оролцогчдын 67% нь, Хэрх багийн судалгаанд оролцогчдын 66% нь оролцдог гэж хариулсан байна. Тэдний дуу хоолой ямар ч шийдвэрт нөлөөлдөггүй гэсэн ойлголт иргэдийн дунд (ялангуяа малчид) байдаг учраас уулзалтуудад муу оролцдог. Өрхийн судалгаанд оролцогчдоос дуу хоолой нь багийн уулзалтуудад хүрдэг эсэхийг асуухад Баянгол сумын судалгаанд оролцогчдын тал нь, Мандал сумын судалгаанд оролцогчдын гуравны хоёр нь "Багийн уулзалтын үеэр/шийдвэр гаргах явцад тэдний санал бодлыг хэзээ ч сонсдоггүй" гэж хариулсан байна. Цаашилбал, үндэслэлтэй шийдвэр гаргах, үр дүнтэй оролцоог идэвхжүүлэхийн тулд мэдээлэл хангалтгүй байгаа нь багийн түвшинд асуудал болж байна гэж тодорхойлсон.

<sup>52</sup> Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, 23.2-р зүйл.

"Багийн иргэдийн төлөөлөгчдийн хурал нь институцлагдсан байгууллага биш гэхдээ хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг. Ерөнхийдөө, багийн иргэдийн оролцоо бага байдаг учир нь тэдний оролцоог дэмжсэн хөшүүрэг байхгүй, оролцоо нь нөлөөлөлгүй гэж иргэд боддог. Багийн засаг даргад мэдээлэл түгээх ямар ч төсөв байхгүй учраас мэдээлэл түгээлт бага байна. Мөн өрхтэй тулж ажилладаг хэсгийн ахлагч нарт ч төсөв байдаггүй. Багийн засаг даргад тулгарч буй гол бэрхшээлүүд: 1) Хязгаарлагдмал төсөв/санхүүжилт, 2) Ихээхэн хэрэгцээтэй байдаг ч Засаг даргын албанд машин байхгүй, 3) Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх ямар ч хөшүүрэг байдаггүй."

Мандал сумын Багийн засаг даргатай хийсэн ярилцлага

"Малчдын дуу хоолой шийдвэр гаргах түвшинд хүрдэггүй. Мэдээлэл түгээх үйл явц нь сайн биш."

Мандал сумын малчидтай хийсэн ЗБХ

"Мэдээлэл нь хангалттай түгдэггүй. Бидэнд хангалттай мэдээлэл өгдөггүй."

Мандал, Баянгол сумдад хийсэн ЖДҮ-ийн бүлэгтэй хийсэн ЗБХ

"Багийн хурал жилд 2-3 удаа зохион байгуулагддаг. Хуралд ихэвчлэн нийт багийн иргэдийн 20% нь л оролцож байна. Энэ нь ирцийн түвшин ерөнхийдөө бага байдаг гэсэн үг."

Мандал сумын багийн Засаг даргатай хийсэн ярилцлага

Зорилтот бүлгийн хэлэлцүүлэг, өрхийн судалгаанд оролцсон ихэнхи оролцогчид багийн хурлаар хэлэлцсэн асуудлууд нь тэдний амьдралд хамааралгүй байдаг гэж хариулсан байсан. Мөн зорилтот бүлгийн хэлэлцүүлэг, гол талтай хийсэн ярилцлагын оролцогчид багийн хурлаар хэлэлцсэн гол асуудлууд дээр санал өгөх боломж байдаггүй гэж мэдээлж байна. Орон нутгийн засаг захиргаа иргэдийн асуудлыг сонирхдоггүй, тэдний дуу хоолойг сонсдоггүй гэж иргэд боддог учрыг энэ нь бас тайлбарлаж байна. Багийн Засаг дарга/багийн хурлын дарга нарын иргэдийн асуудлыг шийдэх, хурлыг үр дүнтэй зохион байгуулах үр чадвар дутмаг байдлаас болсон байж болох (Засаг захиргааны энэ түвшинд чадавхи сул) бөгөөд энэ нь тусгаарлагдмал, идэвхгүй байдалд хүргэх болно (дээрх "шилтгээ"-д дурьдагдсан байгаа).

#### **Хүснэгт 5.11 Таны амьдралтай холбоотой асуудлуудыг багийн хурлаар хэлэлцдэг эсэх, сум багаар**

	Сум		Баг			Өрх	
	Баянгол	Мандал	Түнхэл	Хэрх	Бусад	Малчид	Суурин
Дандаа	10.9	13.4	13.4	11.5	12.6	14.2	11.7
Заримдаа	24.1	12.6	13.4	12.4	22.5	13.4	18.2
Хааяа	22.6	19.3	21.3	16.8	22.5	23.6	18.9
Огт үгүй	42.3	54.7	52.0	59.3	42.4	48.8	51.1

Багийн нийтийн хурлын иргэдийн оролцооны түвшин хангалтгүй байгаа хэдий ч сум, багаас зохион байгуулдаг олон нийтийн арга хэмжээнд (олон нийтийн болон соёлын арга хэмжээ, бусад үйл ажиллагаа) иргэдийн оролцоо харьцангуй сайн байна. Тухайлбал, Мандал сумын судалгаанд хамрагдсан иргэдийн 75.1% нь, Баянгол сумын судалгаанд хамрагдсан оролцогчдын 71% нь баг, сумаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцдог гэж хариулсан ба одоогийн албан ёсны механизмаар үр дүнд хүрснээс хамаагүй илүү оролцуулах боломж байгааг харуулж байна.

#### **Түнхэл багийн одоогийн нөхцөл байдал ба сум болох хүсэл**

Түнхэл багт зохион байгуулагдсан зорилтот бүлгийн хэлэлцүүлэг, Гол талуудтай хийсэн ярилцлаганд оролцогчдын тодорхойлж байгаагаар багийн гол асуудал нь Түнхэл багийн статусыг сумын статус болгон өөрчлөх хүсэлтэй байгаа явдал юм. Энэхүү өөрчлөлтийг хийх болсон шалтгаан нь:



- Түнхэл баг нь Монгол Улсын олон сумдын хүн амаас их буюу ойролцоогоор 3500 хүн амтай байгаа нь Түнхэл багийн сумын хэмжээнд хүргэж болно гэсэн үг юм.
- Түнхэл багийн иргэдэд үйлчилгээ үзүүлэх нийгмийн дэд бүтэц хангалтгүй ба хэрэв сум болчихвол санхүүжилтийг илүү ихээр (боловсрол, эрүүл мэнд, зам гэх мэт) хүртэх боломжтой. Түнхэл нь сумын статустай болвол шийдвэр гаргах илүү эрх мэдэлтэй, бие даасан байдалтай, төсөвтэй болох учир хүн ам олонтой, алслагдсан газарт тохирно гэдэгт итгэдэг.
- Одоогоор бүх асуудлыг Мандал суманд хэлэлцэж, эцсийн шийдвэрийг гаргадаг байна. Түнхэл багийн иргэд асуудал гарвал ялангуяа, эрүүл мэндийн шинжилгээ хийлгэх, зөвшөөрөл авах, жирэмсний асуудлаар Мандал сум руу явах шаардлагатай болдог бөгөөд энэ нь өндөр өртөгтэй, үр ашиггүй байдаг байна. Иргэдийн зүгээс багийн статусыг сум болгон өөрчлөх замаар шийдвэрлэж болно гэж үзэж байгаа.

Түнхэл нь сум болбол төсвийн орлого талаасаа ач холбогдолтой байх (үүнд: Гацууртын төслийн баялагийн орлогоос боломжит хуваарилалт) бөгөөд төсвийн томоохон хувийг хүлээн авах болно. Багууд төсвийн зарцуулалт, хувиарлалт дээр ямар ч эрх мэдэл байхгүй ба сум болбол Түнхэл төсөв дээр хяналт тавих боломжтой болно.

Түнхэл багийн ИТХ сум болох оролдлогыг дэмжсэн санал өгсөн боловч энэ хүсэлт нь сумын ИТХ түвшинд буцаагдсан ба энэ шатанд ямар нэгэн ахиц гаргаагүй байна.

### 6.2.7 Халамж/орлогын тусламж үйлчилгээний хүртээмж

Халамжийн талаарх мэдлэг маш бага байдаг. Мандал сумын судалгаанд оролцогчдын 62.8% нь, Баянгол сумын судалгаанд оролцогчдын 60.6% нь суманд хэрэгжиж буй халамжийн төсөл, хөтөлбөрийн талаар мэдээлэлгүй байна. Мандал, Баянгол сумын судалгаанд оролцогчдын ойролцоогоор 25% нь Засгийн газраас 2010 оноос хойш хэрэгжүүлж буй "малжуулах хөтөлбөр"-ийн<sup>53</sup> талаар мэдээлэлтэй байсан. Малжуулах төсөл, ЖДҮ-дэд зориулсан жижиг тэтгэлэгийн төслүүдийн үр ашгийг иргэд түлхүү хүртэж байгаа нь иргэдэд эдгээр хөтөлбөрүүдийн мэдээлэл сайн хүрсэн байна гэж тайлбарлаж болох юм.

#### Хүснэгт 5.12 Амьжиргаа сайжруулах, ашиг орлогыг нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн хүртээмж (%)

Төсөл, хөтөлбөр	Мандал		Баянгол	
	Төсөл хөтөлбөрийн талаарх ойлголт	Хөтөлбөрийн үр шим хүртсэн байдал	Төсөл хөтөлбөрийн талаарх ойлголт	Хөтөлбөрийн үр шим хүртсэн байдал
Өрхийн амьжиргаа, чадавхийг сайжруулах хөтөлбөр	16.3	9.2	15.9	19.4
ЖДҮ дэмжих төсөл	18.6	6.2	20.5	3.2
Малжуулах төсөл	25.2	13.8	28.0	16.1
Сумын хөгжлийн сан	13.2	3.1	18.9	9.7
Ажил эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	14.7	9.2	18.2	0.0
Ногоон алт төсөл	14.7	0.0	15.2	0.0
Бусад	2.3	16.9	0.0	16.1
Мэдэхгүй	<b>62.8</b>	<b>47.7</b>	<b>60.6</b>	<b>35.5</b>

### 6.2.8 Нийгэмд эмэгтэйчүүдийн эзлэх байр суурь

#### 6.2.8.1 Гэр бүл дэх эмэгтэйчүүдийн үүрэг хариуцлага, хувь нэмэр


1990-ээд оны шилжилтийн үеэс хойш Монгол Улсын нийгмийн хандлагад өөрчлөлт бий болсны нэг нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гэр бүлийн үүрэгт өөрчлөлт юм. Өрхийн судалгаанд оролцогчдоос гэр бүлийн гол тэжээгч хэн байх нь зүйтэй вэ гэж асуусан. Баянгол сумын нийт судалгаанд оролцогчдын 54.7% нь, Мандал сумын судалгаанд оролцогчдын 53.4% нь эхнэр, нөхөр хоёул гэр бүлийн гол тэжээгч гэж хариулсан байна. Харин эсрэгээрээ, Баянгол сумын

<sup>53</sup> Засгийн газрын шийдвэр # 197. Эх үүсвэр: <http://www.legalinfo.mn/annex/showPrint/2699>.

судалгаанд оролцогчдын 40.9% нь, Мандал сумын судалгаанд оролцогчдын 35.1% нь гэр бүлийн гол тэжээгч нь эр хүн/нөхөр гэж хариулсан байна. Үлдсэн оролцогчид (маш цөөхөн хүн) гэр бүлийн гол тэжээгч нь эмэгтэйчүүд гэж үздэг.

Гэрийн ажилд эмэгтэйчүүдийн үүргийн талаар Мандал, Баянгол сумдын иргэдийн ойлголт, хандлага ялгаатай байгааг өрхийн судалгаагаар бас тогтоосон. Мандал сумын судалгаанд оролцогчид уламжлал ёсоор гэрийн ажилд эмэгтэйчүүд давамгайлдаг гэж үзэж байгаа ч эрэгтэйчүүдийн оролцоонд илүү нээлттэй байгааг харахад сонирхолтой юм. Мандал сумын нийт оролцогчдын талаас илүү хувь нь дэлгүүр явах, угаалга, хоол хийх, хүүхэд, өвчтэй хүн, өндөр настанг асрах, хүүхдүүдээ усанд оруулах, гэрийн даалгавараа хийхэд нь туслах зэрэг ажлыг эр хүн/нөхөр хийж болно гэж үзсэн. Гэхдээ, Мандал сумын оролцогчид хувцас угаах, индүүдэх, гэр цэвэрлэх, шал угаах зэрэг гэрийн бусад ажлыг эрэгтэйчүүдэд хийх нь тохиромжгүй гэж үзсэн. Харин эсрэгээрээ, Баянгол сумын судалгаанд оролцогчдын дийлэнх нь дээр дурьдсан гэрийн ажлыг эрэгтэйчүүдэд хийх нь тохиромжгүй гэж үзсэн бөгөөд Баянгол сумын иргэд гэр доторх/өрхийн үүрэг хариуцлаганд эмэгтэйчүүд илүү давамгайлах хэрэгтэй гэж боддог байна. Магадгүй, хоёр сумдын иргэд хоорондын ялгаатай байдал нь Мандал сум нь суурин газар учир хүн ам ихтэйгээс гадна жендэрийн үүрэг хатуу тогтсон бус шинэлэг, нээлттэй байгаагаар холбоотой байж болох юм.


Судалгаанд хамрагдсан сумдын дийлэнх оролцогчид орон сууцны засварын ажил, цахилгааны хэрэгслийн засвар, унаа техникийн засвар зэрэг асуудлуудыг эмэгтэйчүүд биш эрэгтэйчүүд хийвэл илүү тохиромжтой гэж хариулсан байна.



**Зураг 5.7 Эрчүүдийн хийж болох гэрийн ажлууд, Баянгол сумаар (%)**

Өрхийн санхүүтэй холбоотой шийдвэр гаргалт нь гэр бүлийн гишүүдийн эрх тэгш байдлыг хангах үндсэн үзүүлэлтийн нэг юм. Зураг 6.8-д харуулснаар, Баянгол сумын судалгаанд оролцогчдын 70.1% нь, Мандал сумын судалгаанд оролцогчдын 56.6% нь санхүүгийн холбогдолтой шийдвэр гаргахад эхнэр, нөхөр хоёр хоёулаа тэнцүү оролцдог гэж хариулсан. Баянгол сумын судалгаанд оролцогчдын нилээд хэсэг шийдвэр гаргалт нь хамтын үүрэг хариуцлага гэж үзсэн ч өрхийн

эрэгтэй/эмэгтэй хүний үүрэг хариуцлага дээр хатуу байр суурьтай байгаа нь сонирхолтой байсан. Харин, Мандал сумын судалгаанд оролцогчид санхүүгийн шийдвэр гаргалтанд эмэгтэйчүүд тэгш байдал бага байгаа ч ийм төрлийн ажилд тэд нар илүү хариуцлагатай ханддаг гэж үзсэн. Өсөн нэмэгдэж байгаа хотжилтын үед эмэгтэйчүүдийн өрхийн үүрэг роль нь өөрчлөгдөж байна.



**Зураг 5.8 Өрхийн санхүүтэй холбоотой шийдвэрийг хэн гаргадаг вэ (%)**


#### 6.2.8.2 [Гэр бүлийн хүчирхийллийн асуудал](#)

Өрхийн судалгааны жендэрийн эмзэг асуудлын талаар асуулга оруулж эхнэр, нөхөр хоёроор бөглүүлсэн. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг тодорхойлох асуултанд Баянгол сумын судалгаанд оролцогчдын 92.7% нь, Мандал сумын судалгаанд оролцогчдын 85.5% нь охид гэр бүлийн хүчирхийлэлд өртөмтгий гэж хариулсан байна. Харин, Баянгол сумын судалгаанд оролцогчдын 54.5% нь, Мандал сумын судалгаанд оролцогчдын 58.1% нь хөвгүүд өртөмтгий гэж тодорхойлсон. Эдгээр хариултууд орон нутгийн түвшний гэр бүлийн хүчирхийллийн бодит байдлыг төлөөлж чадахгүй ч гэр бүлийн хүчирхийллийн анхдагч хохирогчийн таларх ойлголтыг илүү гаргаж харуулсан байна.

Өрхийн судалгаагаар “таны оршин сууж буй газар сүүлийн 12 сарын хугацаанд гэр бүлийн хүчирхийлэл хэр олон гарсан бэ” гэсэн асуултанд Баянгол сумын оршин суугчдын 76%, Мандал сумын оршин суугчдын 77.9% нь гэр бүлийн хүчирхийллийн хэрэг гардаггүй гэж хариулжээ. Дээрх статистик мэдээгээр гэр бүлийн хүчирхийлэл бага байна гэж харагдаж байгаа боловч энэ асуудал бодит байдал дээр илүү нарийн ээдрээтэй бөгөөд 2010 онд хийсэн судалгаагаар 3 эмэгтэй тутмын нэг нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болдог Монгол Улсад гэр бүлийн хүчирхийлэл үнэн хэрэгтээ түгээмэл гэсэн дүгнэлт хийсэн байна.<sup>54</sup> Энэхүү сэдвийг хэлэлцэхээс цээрлэдэг учир (өрхийн судалгааны хариултаас харахад) гэр бүлийн хүчирхийллийг ихэвчлэн дуугүй өнгөрөөдөг байна. Үүнээс гадна, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн эрх, мэргэжлийн байгууллагын үүрэг хариуцлагын талаар байгууллага болон нийгмийн түвшинд мэдлэг мэдээлэл дутмаг байна. Үнэн хэрэгтээ, нийт 288 судалгаанд оролцсоноос, Баянгол сумын оролцогчдын дөнгөж 56.4%, Мандал сумын оролцогчдын 61% нь иймэрхүү төрлийн үйлдлийг хориглосон хууль байдаг гэдгийг мэднэ гэж хариулжээ. Гэвч, судалгаанд оролцогчид хууль тогтоомжид тусгагдсан заалт, эрхийн талаар мэдэхгүй гэж хариулсан байна. Эмэгтэй оролцогчид хүчирхийллийн төрөл, болзошгүй

<sup>54</sup> Хүчирхийллийн эсрэг Үндэсний төв, 2010, Монголын гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийн хэрэгжилт

хохилогчдын талаар ойлголт, мэдээлэлтэй байх хэрэгтэйг сануулж байгаа нь Гэмт хэргийн талаархи бүлэгт тусгасантай уялдаж байна.




**Зураг 5.9 Гэр бүлийн хүчирхийлэлд илүү өртдөг хохирогчид (%)**

## 6.2.9 Шилжин ирсэн ажиллагсад/гадныханд хандах хандлага

Хөдөө орон нутгаас хот суурин газар руу явагдах шилжилт хөдөлгөөний улмаас Монгол Улсын хүн амын байршил, тархалт 1990 оноос хойш эрчимтэй өөрчлөгдөж байна. Монгол Улсын нийт хүн амын гуравны нэг буюу нийт өрхийн 63.7% нь хот, суурин газруудад төвлөрсөн байна. Харин, үлдсэн 36.6% нь хөдөө орон нутагт амьдардаг байна. Монгол Улсын хөдөө орон нутгийн иргэд, малчид ган, зуд зэрэг байгалийн хүнд хэцүү гамшгийн улмаас Улаанбаатар хот болон төвийн бүс рүү шилжих нь ихэссэн бөгөөд ялангуяа 1990-ээд оны эдийн засгийн шилжилтийн дараах үед энэ шилжилт хөдөлгөөн нэмэгдсэн байна. 2000 оноос хойш бусад аймаг, сумдаас Сэлэнгэ аймаг руу ирэх шилжилт хөдөлгөөн нэмэгдэж, аймаг доторх шилжилт хөдөлгөөний хувь 2009 – 2010 оны хооронд буюу зудын дараах хоёр жилд хамгийн өндөр байсан. Үүнээс хойш, Сэлэнгэ аймаг доторх шилжилт хөдөлгөөний тоо буурсан (шилжих хөдөлгөөний талаар Бүлэг 6.1-т буюу “Хүн ам зүй” хэсэгт дэлгэрэнгүй тусгасныг үзнэ үү) байна.

Өрхийн судалгааны явцад гадны ажиллагсад, шилжин ирэгсэдэд буюу "гадныханд" орон нутгийн иргэд хэрхэн ханддаг талаар тодруулж асуух нь чухал байсан. Мандал сумын нийт судалгаанд оролцогчдын 50.6% нь өөр аймаг, сумдаас ирсэн шилжин ирэгсэдэд эерэг ханддаг гэж хариулсан байна. Арван хүн тутмын нэг нь тэд нарт таагүй ханддаг гэсэн бол 21.7% нь өөрсдийн санал бодлоо илэрхийлээгүй. Баянгол сумын хувьд судалгаанд оролцогчдын 44.1% нь шилжин ирэгсэд, гадныханд таагүй ханддаг гэж хариулсан байна. Судалгаанд оролцогчдын эерэгээр хариулсан шалтгааныг нь тодруулахад нийт оролцогчдын тал хувь нь сумын хүн ам (ерөнхийдөө сайн зүйл гэж үзэх) нэмэгдэнэ гэж үзсэн. Нэмж хэлэхэд, судалгаанд оролцогчид бас гадныхан орон нутагт их зүйлийг хийдэг, мөн шинэ хүмүүстэй танилцана гэж дурдсан байна. Таагүй ханддаг шалтгааныг тодруулахад бэлчээр, ус зэрэг байгалийн нөөцийн хомсдол үүсэх, гадныхан аюултай байдаг, орон нутагт ажлын байр багасна гэж (Хэсэг 6.6 буюу Газар ашиглалт, байгалийн нөөцийн хэсгээс дэлгэрэнгүйг үзнэ үү) хариулсан байна. Баянгол сумын судалгаанд оролцогчдын 84.9% нь

бэлчээр, ус зэрэг байгалийн нөөц хомсдох учраас таагүй ханддаг гэж хариулсан нь анхаарал татаж байна.



**Зураг 5.10 Шилжин ирэгсэд буюу “гадныханд” хандах хандлага, хувиар, сумаар**

## 6.2.10 Дүгнэлт

Энэхүү бүлэгт тусгасан зарим гол асуудал, нийгмийн бүтцийг судлах явцад төрийн байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн сэтгэл дундуур байгаагийн улмаас тэдгээр байгууллагуудад итгэх итгэлийн түвшин бага байна гэж дүгнэсэн. Мандал, Баянгол сумдад аль алинд нь намууд хамгийн найдваргүй байгууллагаар тодорсон. Хоёр сумын иргэдийн өөрийн сумын ИТХ, Засаг даргын тамгийн газарт итгэх итгэл нь өнөдөр байгаа бөгөөд улс төрийн хөдөлгөөн, ТББ-уудад хамгийн бага итгэдэг байна. Судалгаанд хамрагдсан ихэнх хүмүүс (65%) ямар нэг улс төрийн намд харъяалагдадгүй, сонгогчдын зөвхөн 10% нь тухайн намын үнэнч гишүүн гэж дурьдсан. 1992 оноос хойш Сэлэнгэ аймаг болон улсын хэмжээнд сонгогчдын оролцоо тогтмол буурсан байна. Улс төрийн идэвхгүй байдал, сонгогчдын оролцоо муу байдгийг Засгийн газар иргэдийн хүсэл эрмэлзлийг анхаардаггүй учир иргэд улс төрөөс ангид байхыг илүүд үздэг гэж монголчуудын дийлэнх нь ойлгодогтойгоор холбон тайлбарлаж болно юм. Өрхийн судалгаанд оролцогчдын ихэнхи нь улс төрийн нэр дэвшигчид, улс төрийн намууд итгэдэггүй, сонгуулийн үйл явц нь шударга бус явагддаг гэж үзэж байгаа учраас сонгуульд идэвхигүй оролцдог гэж тайлбарласан байна. Сэтгэл ханамжгүй байдлын түвшин Баянгол сумтай харьцуулахад Мандал суманд өндөр байна. Авлигын талаар олон нийтийн ойлголт нь Мандал, Баянгол суманд улс төрийн нөхцөл байдад бухимдах гол эх үүсвэр болоод байна.

Багийн иргэдийн дуу хоолой ямар ч шийдвэрт нөлөөлдөггүй, ИТХ-аас иргэддээ мэдээлэл муу хүрдэгийн улмаас иргэдийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох оролцоог хязгаарладаг гэсэн ойлголт бүхий бэрхшээлүүдтэй төслийн бүсийн багууд тулгараад байна. Түнхэл багийн гол асуудал нь баг-аа сумын статустай болгож өөрчлөх хүсэл юм. Түнхэл нь сум болбол (Гацууртын төслөөс олох байгалийн баялгийн орлогын боломжит хуваарилалт) төсвийн орлого талаас нь ач холбогдолтой байх болно. Сумын хувьд Түнхэл төсвийн томоохон хувийг хүлээн авч, илүү бие

даасан статустай байх болно. Энэхүү албан ёсны хүсэлт нь сумын түвшинд дэмжигдээгүй ба цаашдаа хэр зэрэг урагштай байх нь тодорхойгүй байна.

Иргэний нийгмийн ихэнхи байгууллагууд эрх мэдэл багатай учраас үйл ажиллагаагаа бүсдэд хүргэх, санхүүжилтээ зохицуулах буюу байгууллагаа үр дүнтэй хөгжүүлэх чадавхгүйгээс амжилттай үйл ажиллагаа явуулж чадахгүйд хүрдэг. Төслийн бүсэд халамж/орон нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулах таслүүдийн талаарх мэдээлэл маш бага байдаг. Ийм учир, Мандал сумын судалгаанд оролцогчдын 62.8% нь, Баянгол сумын судалгаанд оролцогчдын 60.6% нь суманд хэрэгжиж буй халамжийн төсөл, хөтөлбөрийн талаар мэдээлэлгүй байна. Тухайн сумдад хамгийн ихээр танигдсан төсөл нь Засгийн газраас хэрэгжүүлж буй "малжуулах хөтөлбөр" байв.

Мандал сумын нийт судалгаанд оролцогчдын 50.6% нь өөр аймаг, сумдаас ирсэн шилжин ирэгсдэд эерэг ханддаг гэж хариулсан бол, Баянгол сумын судалгаанд оролцогчдын 44.1% нь шилжин ирэгсэд, гадныханд таагүй ханддаг гэж хариулсан байна. Судалгаанд оролцогчдын эерэгээр ханддаг гэж хариулсан шалтгааныг нь тодруулахад нийт оролцогчдын тал хувь нь шинэ хүмүүстэй танилцана, сумын хүн ам нэмэгдэж, шилжин ирэгсэд орон нутагт их зүйлийг хийнэ гэж дурдсан байна. Таагүй ханддаг шалтгааныг тодруулахад бэлчээр, ус зэрэг байгалийн нөөцийн хомсдол үүсэх, гадныхан аюултай байдаг бөгөөд орон нутагт ажлын байр багасна гэж хариулсан байна.



## **6.3 ЭДИЙН ЗАСАГ**

### **6.3.1 Оршил**

Энэ бүлэгт Сэлэнгэ аймаг, Мандал ба Баянгол сумдын орон нутгийн эдийн засгийн асуудлууд болох орон нутгийн төсөв, үнэ ханш, эдийн засгийн салбарыг бүрдүүлэгч хөдөө аж ахуй, аж үйлдвэр, уул уурхай, мал аж ахуй зэргийн хөгжил, мөн хөгжиж буй зах зээл, амьжиргаа, өрхийн орлогын талаар дэлгэрэгүй өгүүлэх болно.

### **6.3.2 Ашигласан тоо мэдээ**

Суурь судалгааг 2012 – 2015 онуудын тоо мэдээлэлд тулгуурлан боловсруулсан болно. Үндэсний статистикийн хороо, хүн ам, байрны тооллого, Сэлэнгэ аймаг, Баянгол, Мандал сумдын Засаг даргын тамгийн газрын статистикийн хэлтэс зэргийн тайлангаас хоёрдогч тоо мэдээллүүдээ авав. Төслийн бүсэд хийсэн өрхийн түүвэр судалгаа, зорилтот бүлгийн хэлэлцүүлэг (ЗБХ), гол талуудтай хийсэн ярилцлага (ГТХЯ) зэргийн үр дүнг ашиглан анхдагч мэдээллээ цуглуулсан.

Энэ бүлэгт оруулаагүй зарим нэг хүснэгт болон зургийг Хавсралт Г-ээс харна уу.


### **6.3.3 Орон нутгийн эдийн засаг, төсөв**

Сүүлийн 3 жилд Монгол Улсын эдийн засгийн өсөлт нь дэлхийн эдийн засгийн удаашралт, үндэсний буюу засгийн газрын бодлого өөрчлөгдсөнтэй холбоотойгоор буурсан байна. Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) нь 2012 онд 12.3%-тай байсан бол 2013 онд 11.6%, 2014 онд 7.8% болтлоо буурчээ. Харин нэг хүнд ногдох ДНБ нь 2012 онд 5,876,800 төгрөг (3,939 ам. доллар)<sup>55</sup> байсан бол 2013 онд 6,614,100 төгрөг (4,563 ам доллар), 2014 онд 7,403,400 төгрөг (4,512 ам. доллар) болж нэмэгджээ. Энэ өсөлт нь уул уурхайн салбарын хөгжилтэй шууд холбоотой юм. Үндэсний ДНБ-ий өсөлтийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар задалж харахад 2014 оны байдлаар уул уурхай, олборлох салбар - 24.2%, санхүү болон даатгалын үйл ажиллагаа - 22.9%, тээвэр, агуулахын үйл ажиллагаа - 20.9%, хөдөө аж ахуй - 14.5%-ийн өсөлттэй байв.

2014 онд Сэлэнгэ аймаг нь үндэсний ДНБ-ий 2.7%-ийг, төвийн бүс нь ДНБ-ий гаруй 20%-г бүрдүүлж байна. ДНБ-ний хэмжээгээр төвийн бүсийн 7 аймгаас Сэлэнгэ аймаг эхэнд байгаа боловч төвийн бүсийн ДНБ-д оруулж буй хувь нь 2012 онд 25.5%, 2013 онд 23%, 2014 онд 21.6% болтол буурчээ. Тус аймгийн ДНБ-ийн 45.5%-ийг аж үйлдвэр (уул уурхайг багтаасан), 27.7%-ийг хөдөө аж ахуй, 26.7%-ийг үйлчилгээний салбар эзэлж байна.

Сэлэнгэ аймгийн 1990 - 2014 онуудын орон нутгийн төсвийн орлого, зарлагад дүн шинжилгээ хийж үзэхэд орон нутгийн төсвийн санхүүжилтийн эх үүсвэр хүрэлцээгүй, орон нутгийн төсөв байнгын алдагдалтай явж иржээ. Харин 2012 оноос хойш байдал эерэгээр өөрчлөгдөж байна. Энэ нь 2012 онд Засгийн газрын төсвийн төвлөрлийг сааруулах шинэ бодлоготой холбоотой. Жишээ нь, "Орон нутгийн хөгжлийн сан"-г аймаг, сум, багийн түвшинд үүсгэн бий болгож, орон нутгийн иргэдийн хэрэгцээний санд төвлөрүүлэхэд нь туслан чиглүүлэх. 2014 онд төсвийн нийт орлого өмнөх оноос 14.3%-иар өсч, төсвийн нийт орлогын ихэнхи хувь болох 78.4%-ийг тусламжийн орлого, 20%-ийг татварын орлого, үлдсэн 3%-ийг татварын бус орлого, хөрөнгийн орлого, өмнөх оны үлдэгдэл тус тус эзэлж байна.

<sup>55</sup> Дэлхийн банкны Атласын аргаар тооцсон байдлаар



**Зураг 5.11 Сэлэнгэ аймгийн орон нутгийн төсөв (сая төгрөгөөр), 1990-2014 он**

Сэлэнгэ аймаг, Баянгол, Мандал сумдын орон нутгийн төсвийн орлого, зарлагыг Хүснэгт 5.13-д сумдаар харуулав. Мандал сум бусад сумтай харьцуулахад орон нутгийн төсвийн орлого, зарлагаараа нэгдүгээрт, аймгийн төв болох Сүхбаатар сум хоёрдугаарт жагсаж байна.

**Хүснэгт 5.13 Сум, аймгийн төсвийн орлого, зарлага, мян. төгрөгөөр, 2014<sup>56</sup>**

	Орон нутгийн төсвийн нийт орлого		Орон нутгийн төсвийн нийт зарлага	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Баянгол	101,534,600	107,707,200	711,695,800	622,534,800
Мандал	471,228,400	802,650,000	2,783,432,800	2,186,853,600
Аймгийн төсөв	13,046,898,000	13,441,348,900	17,797,596,300	16,191,103,400
<b>Нийт</b>	<b>15,646,283,700</b>	<b>16,759,288,600</b>	<b>33,613,130,800</b>	<b>28,391,305,900</b>

### 6.3.4 Үнэ ба инфляц

Монгол Улсын инфляцийн түвшин 2012 онд 14%, 2013 онд 12.5%, 2014 онд 11% тус тус болж буурсан нь дээрхи онуудад болсон уул уурхайн салбарын удаашрал, засгийн газрын санхүүгийн бодлоготой холбоотой юм. Инфляцийн түвшинг бүлгээр задалбал, хүнсний бүтээгдэхүүн хамгийн өндөр өсөлттэй, ялангуяа махны үнийн өсөлт (сүүлийн 5 жилд эрс нэмэгдсэн) хамгийн өндөр байна. Улсын хэмжээнд, өрхийн хэрэглээний зардалын 16%-ийг махан бүтээгдэхүүн дангаар эзэлдэг буюу мах, махан бүтээгдэхүүн нь өрхийн хэрэглээнд хамгийн өндөр хувийг эзэлдэг байна. Махны үнэ эрс нэмэгдсэн нь хамгийн сүүлд болсон зудын (2009 – 2010 онуудад) улмаас хангалт буурсан, эдийн засгийн ерөнхий өсөлттэй холбоотой юм.

*ЗБХ-ийн үеэр Мандал сумын малчид огцом нэмэгдэж буй өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн талаар санаа зовж байгаагаа илэрхийлсэн. Харин тэдний зардаг сүүний үнэ хэвээрээ байгаа тул орлогоороо бусад бараа бүтээгдэхүүн авахад маш их хүндрэлтэй байгаа ажээ. Малчид өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний зах зээлийн үнэнд сэтгэл хангалуун бус байна. Жил бүр, 55 сая литр хуурай сүү бусад орноос импортлогдож байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд 1 литр сүүний үнэ огт өөрчлөгдөөгүй. Харин бусад барааны үнэ (жишээ нь: малын тэжээл, гүрил) өссөн байна"*


ЗБХ, Мандал сумын малчин

Сэлэнгэ аймгийн хэрэглээний үнийн индекс (ХҮИ) 2010 - 2014 онуудын хооронд жил бүр өссөн дүнтэй байна. Бүтээгдэхүүний үнийн өсөлтийг төрлөөр нь авч үзэхэд хамгийн их өсөлттэй бараа бүтээгдэхүүн нь хүнсний бүтээгдэхүүн (ялангуяа мах); архи; тамхи болон дагалдах бүтээгдэхүүн;

<sup>56</sup> Сэлэнгэ аймгийн ЗДТГ, 2014. Сэлэнгэ аймгийн нийгэм эдийн засгийн үзүүлэлт, 2014 он

хувцас, даавуу бараа; орон сууц, ус, цахилгаан, түлш, боловсролын үйлчилгээ байна. Зураг 5.12-д Сэлэнгэ аймгийн 1994 – 2014 онуудын хоорондох хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтийг харуулсан байна. Хүнсний бүтээгдэхүүний 2012 оны үнийг 2014 оныхтой харьцуулахад хонины мах 15.2%, гурил 14.5%, цагаан будаа 33%, элсэн чихэр 5.5%-иар тус тус өссөн байна. Мандал суманд зарагдаж буй бүтээгдэхүүний үнэ Сэлэнгэ аймгийн дундажтай адил байхад Баянгол сумд төмсний үнэ аймагт хамгийн бага, харин цагаан будааны үнэ хамгийн өндөр байна. Бусад сумтай харьцуулахад, Баянгол суманд мах, шатахууны үнэ өндөр байна. Энэ нь Баянгол сумын суурин хүн амын (ялангуяа, Мандал сумтай харьцуулахад бага) тоо харьцангуй учир зах зээлийн өрсөлдөөн байхгүй ба бараа нийлүүлэгчид үнээ өндрөөр тогтоодогтой холбоотой.

Өрхийн судалгаанд оролцосон нийт өрхийн гуравны хоёр нь өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ хэт өндөр гэж хариулсан байна. Сүүлийн хэдэн жилд бараа бүтээгдэхүүний үнэ маш ихээр огцом нэмэгдсэн нь өрхийн гол асуудлын нэг болсон хэмээн судалгаанд оролцсон өрхийн 85% гаруй нь тэмдэглэсэн. Түүнчлэн, бараа бүтээгдэхүүний чанар муу, зах зээлийн өргөн сонголтгүй зэрэг нь өрхийн хувьд нэмэлт бэрхшээл болдог. Сэлэнгэ аймгийн дэд бүтэц (төмөр зам, автомашины зам) нь харьцангуй сайн хэдий ч шинэ бараа бүтээгдэхүүний хүртээмж сумдад нилээд ялгаатай байдаг. Ялангуяа, аймаг, сумын төвөөс нилээд алслагдмал орших илүү өрсөлдөөнтэй, илүү сайн хангамж, хүртээмж сайтай дэлгүүрүүд байх хандлагатай Түнхэл багийн хувьд энэхүү хандлага тод ажиглагддаг.



**Зураг 5.12 Сэлэнгэ аймгийн гол нэрийн бүтээгдэхүүний үнийн судалгаа, 1997 – 2014 он**

### 6.3.5 Хөдөө аж ахуй

Сэлэнгэ аймгийг Монгол Улсын газар тариалангийн үндэсний үйлдвэрлэлийн гол бүс гэж үздэг. 2014 онд улсын хэмжээнд хураасан нийт төмсний 28.1%, хүнсний ногооны 31.2%, үр тарианы 47.3%, тэжээлийн ургамлын 21%,<sup>57</sup> бэлтгэсэн өвсний 13%-ийг Сэлэнгэ аймгийн газар тариалангийн үйлдвэрлэл дангаараа үйлдвэрлэсэн байна. Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2014 онд өмнөх жилийнхтэй харьцуулахад төмс 27%, хүнсний ногооны 7.3%-иар ургац буурсан үзүүлэлттэй, харин тариа буудай, малын тэжээлийн ургацын хэмжээ 90.7%-иар нэмэгджээ. Мөн сумдын хэмжээнд ногооны ургацын хэмжээ буурсан боловч Баянгол суманд 20.6%, Мандал суманд 12.5%-иар тус тус өсчээ.

<sup>57</sup> Хадлан нь тусгайлан тариалсан газар бол малын тэжээл нь байгалийн өвснөөс гарган авдаг байна.

Сэлэнгэ аймгийн газар нутаг нь Монгол Улсын бусад аймагтай харьцуулахад үржил шим ихтэй байгаа нь жил бүр ихээр хураадаг үр тариа, хүнсний ногооны ургацаар батлагдаж байгаа юм. 2014 онд улсын хэмжээнд нэг га талбайгаас дунджаар 16.5 центнер<sup>58</sup> үр тариа хураан авч байхад Сэлэнгэд 17.2 центнер, улсын хэмжээнд 122.3 центнер төмс хураан авсан бол Сэлэнгэд 154.3 центнер төмс хураан авсан нь нэг га талбайгаас хураан авсан төмсний дундаж хэмжээгээр бусад аймгуудаас хамгийн өндөр байна.

Өрхийн судалгаанд оролцсон нийт өрхийн 70% нь газар тариалан эрхлэх боломжтой гэж хариулсан. Баянгол сумаас судалгаанд оролцогсдын гуравны хоёр нь газар тариалан эрхлэх боломжтой ч мэргэжлийн зөвлөгөө авах боломжгүй гэж тэмдэглэсэн. Фермийн газар тариалангийн арга, технологийн талаар зөвлөгөө авах боломжгүй гэж хариулсан хүмүүсийн тоо Мандал сумтай харьцуулахад Баянгол суманд их байна. Түнхэл багийн судалгаанд оролцогсдоос газар тариалан эрхлэх боломжтой эсэхийг лавлахад боломжтой, заримдаа эсвэл боломжгүй гэдэг хариултуудад ижил тоотой хариулт өгсөн байна. Түнхэл багийн иргэдийн 75% нь газар тариалангийн талаар мэргэжлийн зөвлөгөө авч чадахгүй байгаа нь тэднийг үйл ажиллагаагаа амжилттай явуулахад нь бэрхшээл үүсгэдэг гэж үздэг. Малчин, суурин иргэдийн хариултыг харьцуулахад нэг их ялгаа байхгүй байна. Ерөнхий судалгааны дүнгээс харахад өрхүүд газар тариалан эрхлэх (орлого олох үндсэн эх үүсвэр, орлогын эх үүсвэрээ төрөлжүүлэх зорилгоор) тал дээр асуудалгүй байгаа хэдий ч газар тариаланг амжилттай эрхэлж, арвин ургац авахад нь дэмжлэг бага, хязгаарлагдмал байдагт сэтгэл дундуур, бухимдалтай байдаг байна.

Гэсэн хэдий ч, Сэлэнгэ аймгийн оршин суугчдын 70%-д газар тариалангийн тохиромжтой газар хуваарилах нь гол асуудал юм. Судалгаанд оролцогсдын 28% нь газар эзэмших өргөдөл гаргах, материал бүрдүүлэх явц нь төвөгтэй гэж үздэг бол 20% нь газар авахад маш их өрсөлдөөнтэй гэсэн хариулт өгсөн байна. Малчдын ажлын онцлогоос хамаараад суурын газрын оршин суугчдыг бодвол тэдэнд газар тариалан эрхлэх хангалттай газар байхгүй гэдгийг ойлгож хүлээн зөвшөөрсөн байдаг нь тодорхой юм.

### 6.3.6 Мал аж ахуй ба мал сүрэг

Сэлэнгэ аймгийн малын тоо 2013 онд өмнөх оныхоос 0.7%-иар өссөн бол 2014 онд өмнөх оныхоос 12%-иар өсч 1,471,700 толгойд хүрээд байна. Хонь, ямаа, үхрийн тоо нэлээд өссөний зэрэгцээ, хонин сүрэг нийт малын 47.5%, ямаан сүрэг 33.7%-ийг тус тус эзэлж байгаа нь тус аймагт бог мал сүргийн үндсэн хэсгийг бүрдүүлж буйг илтгэж байна. Монгол Улсын нийт багийн малын дундаж тоо 28,100 байхад Сэлэнгэ аймгийн нийт баг дунджаар 23,500 мянган толгой малтай байна (2013 оны байдлаар). Мандал сум нь Монгол Улсын нийт 330 сумын хэмжээнд үхрийн тоогоороо 10-р байранд жагсаж байна.

#### Хүснэгт 5.14 Мал аж ахуйн үзүүлэлтүүд, Сэлэнгэ, сонгосон сумдаар, 2014<sup>59</sup>

	Малын тоо (мянган толгой)			Үүнээс: 2014 онд				
	2012	2013	2014	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
<i>Сум</i>								
Баянгол	123,500	128,900	140,900	-	7,300	17,900	71,700	44,000
Мандал	100,800	106,100	115,900	600	11,000	30,000	38,200	36,600
<b>Аймгийн дүн</b>	<b>1,305,600</b>	<b>1,314,200</b>	<b>1,471,700</b>	<b>600</b>	<b>79,800</b>	<b>196,600</b>	<b>698,900</b>	<b>495,900</b>

<sup>58</sup> Центнер гэдэг нь массын нэгж бөгөөд зуун кг (100кг) тэнцүү юм.

<sup>59</sup>Сэлэнгэ аймгийн ЗДТГ, 2014. Сэлэнгэ аймгийн нийгэм эдийн засгийн үзүүлэлт, 2014 он.

Малын даатгалд хамрагдах байдал Сэлэнгэ аймагт бага байна. Сэлэнгэ аймгийн нийт малын 3.4 хувь нь малын индексжүүлсэн даатгалд хамрагдсан нь 21 аймгаас 17-рт, нийт мал бүхий өрхийн 4.7 хувь нь даатгалд хамрагдсан нь 16-рт орж байгаа нь даатгалд хамрагдалт хангалтгүй байгааг илтгэж байна. Сэлэнгэ аймагт малын даатгалд бага хамрагддаг шалтгаан нь Монголын бусад аймгуудтай харьцуулахад Сэлэнгэ аймаг бэлчээр сайтай тул ерөнхийдөө малынхаа төлөө санаа зовох шаардлаггүй (зуд мэтийн байгалийн аюул) гэсэн ойлголт малчдын дунд өргөн тархсан байдаг. Ерөнхийдөө, даатгал ба түүний үр өгөөжийн талаар мэдлэг багатай (зуд, гал түймэр, ган гачиг, байгалийн гамшиг г.м.) байдаг байна.

Сэлэнгэ аймгийн малтай нийт өрхийн 21.8%, малчин өрх болон мал бүхий иргэдийн (хөдөө малтай суурин өрх) 10.6% нь Мандал сумын иргэд байгаа нь аймагтаа хамгийн өндөр хувийг эзэлж байна. Баянгол сум нь Сэлэнгэ аймагтай хамгийн их малчинтай сум бөгөөд Мандал, Баянгол сумд аймагтай хамгийн их малтай сумдын тоонд орж байна. Сэлэнгэ аймагт 2013 онд малчин өрх ба малчдын тоо өмнөх оноос бага зэрэг (0.1%, 0.4% тус тус) буурсан бол 2014 онд малчин өрхийн тоо 1.8%-иар, малчдын тоо 3.1%-иар бага зэрэг өссөн байна.

Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ сум бүрт харилцан адилгүй байдаг. Өнгөрсөн жил (2014 - 2015) Мандал сум адуу, үхэр, ямааны арьс/ширийг 20-27% үйлдвэрлэсэн. Эдгээрийг зах зээл дээр нэг нэг тус бүрийг дундажаар 1.024, 6.205, болон 21,754 төгрөгөөр зарж болно.

### **6.3.7 Аж үйлдвэр**

Сэлэнгэ аймгийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2014 онд сайжирч өмнөх онтой харьцуулахад 40%-иар өсчээ. Уул уурхайн үйлдвэрлэл нь аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн 82.9%-ийг дангаараа бүрдүүлж байна. Уул уурхайн үйлдвэрлэлд төмрийн хүдрийн үйлдвэрлэл (80.1%) тэргүүлэх үүрэгтэй байна. Түүнчлэн, хүнсний үйлдвэрлэл өмнө оныхоос 93.7%-иар, барилгын материалын үйлдвэрлэл 79.4%-иар тус тус өссөн амжилттай. Аж үйлдвэрийн гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг гол нэр төрлөөр задалбал хамгийн их өсөлттэй үйлдвэрлэл нь цемент (2.2 дахин) болон архи, спирт (2 дахин) байгаа бөгөөд төмрийн хүдэр (56.7%), нүүрс (44.2%), зүсмэл (26.1%), шохой (12.8%), тоосго (8.7%) зэрэг уул уурхай, барилгын материалын үйлдвэрлэл, гурил (92%), талх (38.1%) зэрэг хүнсний үйлдвэрлэл ч мөн өсчээ.

Сэлэнгэ аймгийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийн үйлдвэрлэл сумдад харилцан адилгүй байна. Мандал сумын аж үйлдвэрийн бүтээгдэхүүн нь 2013 онд 21.4%-иар өссөн бол 2014 онд 93.3%-иар өсчээ. Мандал суманд үйлдвэрлэл ихээр өссөн нь Түнхэл багийн мод боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа, Мандал сумын төвд архи, ундааны үйлдвэрлэл ихэссэнтэй холбоотой. Цаг агаарын байдлаас хамаараад мод бэлтгэх зөвшөөрөл олгодог бөгөөд 2014 онд цаг агаар тааламжтай байсан тул олон тооны зөвшөөрөл олгогдсон байна. Цаг агаарын тааламжтай улиралд үр тариа, өвс, бусад ногоо тарианы их хэмжээний ургац авч Мандал сумын архи, ундааны үйлдвэрт тушаах буудайн хэмжээ нэмэгддэг байна. Харин, Баянгол сумын аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэр буурчээ. Тухайлбал, 2013 онд өмнөх оноос 20.1%-иар өссөн боловч 2014 онд 38.9%-иар буурчээ. Баянгол сумын үйлдвэрлэл багасах гол шалтгаан нь суман дахь алт олборлолт буурсантай холбоотой.



"Сумын ирээдүйн хөгжилд том хувь нэмэр оруулах салбаруудад дараах орно:

- Хөдөө аж ахуй (ялангуяа, мал аж ахуйн ферм болон сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл);
- Барилга байгууламж;
- Ургамалын тосны үйлдвэрлэл;
- Рапсын үрээс дизель гаргаж авах."

ГТХЯ, Баянгол сумын засаг дарга

### 6.3.8 Уул уурхай

Сэлэнгэ аймагт 34 төрлийн ашигт малтмалын 96 орд газар илрээд байна. Сүүлийн үед илрээд байгаа Баянгол, Ерөө голын гүний хагарлын дагуу байрлах алтны үндсэн болон шороон орд газрууд аймгийн уул уурхайн хөгжлийн гол хөшүүрэг болоод байна. Сэлэнгэ аймаг нь 450 сая орчим тонн хүдэртэй төмрийн орд, 107 сая тонн нүүрстэй орд, 10 тонн хүдэртэй алтны шороон орд, 56 тонн хүдэртэй алтны үндсэн орд болон их хэмжээний шохой чулуун ордтой бөгөөд байгалийн баялгийн хувьд Монгол Улсын хамгийн баян аймгийн нэг гэж тооцогддог. Аймгийг Монгол Улсын эдийн засагт стратегийн ач холбогдолтой бүс нутаг гэж үзэж байна.

Сэлэнгэ аймагт уул уурхайн хэд хэдэн томоохон үйлдвэрлэл үйл ажиллагаагаа явуулж байна. Жишээ нь, Бороо Гоулд алтны уурхай нь Сэлэнгэ аймгийн нийт алтны үйлдвэрлэлийн 40% -ийг, Болд-Төмөр-Ерөө гол ХХК нь Монгол Улсын экспортолсон төмрийн нийт хүдрийн 80% гаруйг үйлдвэрлэсэн тул аймгийн уул уурхайн үйлдвэрлэл нь улсын хэмжээнд чухал ач холбогдолтойг харуулж байна.

2012 оны байдлаар хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 137 аж ахуй нь 254,800 га талбайд, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 167 аж ахуй нэгж нь 1,931,100 га талбайд үйл ажиллагаагаа явуулж байна. Одоогийн байдлаар, хайгуул, олборлолтыг геологийн зураглал ашиглан явуулж байна. Дээр дурдсан ашиглалт, хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн 50 орчим хувьд 1: 200000 масштабтай байрзүйн газрын зургыг улсын төсвийг ашиглан боловсруулсан байна. Үүнээс гадна, хиймэл дагуулын зураглалыг гадаадын хөрөнгө оруулалтаар боловсруулж байна.

Сэлэнгэ аймаг нь ашигт малтмалын нөөцийн ашиглалтын бүс нутгийн шинж чанартай хоёр гол бодлогыг боловсруулахаар ажиллаж байна. Үүнд:

- *Орон нутгийн онцлогтой дэд бүтцийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх дараах уурхайн томоохон төслүүдийг дэмжих бодлого баримтлан:*
  - Баянгол Хустайн бүсэд Төмөртэй төмрийн хүдрийг олборлон, баяжуулж боловсруулах төсөл;
  - Мандал сумын Гацууртын алтны ордын төсөл;
  - Баянгол сумын Их таширын алтны үндсэн ордын төсөл;
  - Түшиг сумын молибдены ордын төсөл;
  - Улаан овоон нүүрсийг баяжуулан экспортлох төсөл.
- "Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай" хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Сэлэнгэ, Ерөө, Хараа, Орхон голын эх болон Туул голын сав дагуу хамгаалалтын бүс тогтоох; хуучин ашиглалт явуулж байсан Их алт Толгойт, Харганат гол, Сангийн голуудыг



аймгийн тусгай хамгаалалтанд авч Аймагийн ИТХ-ын тогтоол шийдвэр гарган уг газарт нөхөн сэргээлт хийж хаягдалгүй иж бүрэн ашиглах бодлого баримтлан ажиллаж байна.

Төслийн бүсийн орон нутгийн иргэд, уул уурхайн компаниудын хоорондын харилцаа холбоо ерөнхийдөө муу байдаг. Өрхийн судалгаанд оролцогчдоос Хэрх багийн малчид (77%), Мандал сумын иргэд (66%) уул уурхайн томоохон төслүүдийн талаар арай илүү ойлголттой байдаг (жишээ нь Монгол Улсын уул уурхайн салбарын талаарх өргөн ойлголт). Судалгаанд хамрагдсан суурин өрхийн дийлэнх нь Бороо Гоулдыг нэрлэсэн байхад малчин өрхийн хувьд Бороо Гоулдээс гадна Таван толгойг нэрлэжээ. Ерөнхийдөө, малчдын өдөр тутмын аж амьдрал нь уурхайн хайгуул, олборлолт зэрэг байгалийн нөөцөд суурилсан салбарынхантай илүү нягт холбоотой байдаг тул уул уурхайн төслүүдийн талаар суурин газрын иргэдээс илүү мэдээлэлтэй байдаг. Энэ мэтчилэн харахад, төслийн бүсэд уул уурхайн үйл ажиллагааны талаарх ойлголт дутмаг байдаг. Уул уурхайн салбарын талаарх Баянгол, Мандал сумдын иргэдийн ойлголт дутмаг байгаа нь орон нутагт сүүлийн 15 жилийн турш мал аж ахуй нь хөдөлмөр эрхлэлтийн гол салбар, амьжиргааны гол эх үүсвэр харин газар тариалан нь эдийн засгийн болон хөдөлмөрийн хоёрдогч эх үүсвэр байсантай холбоотойгоор тайлбарлаж болно. Уул уурхай нь аймаг, сумын эдийн засагт асар их хувь нэмэр оруулж байгаа ч аймаг, сумдын түвшинд томоохон ажил олгогч биш учир орон нутгийн иргэдийн анхаарлаас ангид байдаг.

Өрхийн судалгааны хариултуудаас харахад уурхайн компаниас орон нутгийн иргэдийн амьжиргаанд үзүүлэх нөлөөллийн талаар өөр өөр ойлголттой байсан. Мандал сумаас илүү Баянгол сумын судалгаанд оролцогчид уул уурхайн салбар хөгжсөнөөр илүү цалинтай болж амьжиргаа дээшилнэ гэдэгтэй санал нийлж байна. Гэсэн хэдий ч, асуултанд "мэдэхгүй" гэсэн хариултыг Баянгол сумын иргэд түлхүү өгч байсан. Суурин газрын болон малчин айл өрхийн өгсөн хариултыг харьцуулахад нэг их ялгаа байгаагүй (ойролцоогоор тэн хагас нь дээрх мэдэгдэлтэй санал нийлж байна). Эдгээр хариултууд нь уул уурхайгаас үзүүлж болзошгүй ашиг болон нөлөөллийн талаар орон нутгийн түвшинд мэдлэг багатай байгааг нотлож байна. Мөн төслийн талбайд олон тооны "аялдан дагалдагч" буюу санал бодол, үзэл баримтлал нь байнга өөрчлөгддөг хэсэг бүлэг хүмүүс байдгийг харуулж байна.

Талуудын үр дүнтэй оролцооны талаар ерөнхий ойлголт дутмаг байгааг өрхийн судалгааны үр дүн харуулж байна. "Уул уурхайн бүтээн байгуулалтын бүх үе шатанд талуудыг үр дүнтэй татан оролцуулах ёстой" гэсэн мэдэгдэлтэй санал нийлж байна уу гэсэн асуултанд судалгаанд оролцогсдын тавны нэг нь тэрний талаар огт мэдэхгүй гэж хариулсан байна. Баянгол, Мандал сумд болон багууд мөн малчин, суурин өрхийн хооронд хариултын ялгаа байхгүй (50%-иар хуваагдсан) байна.

Өрхийн судалгаанд оролцогсдын дийлэнх нь уул уурхайн салбараас эерэг нөлөөлөл үүснэ гэдэгтэй санал нийлжээ: орон нутгийн эдийн засаг сайжирна; ажлын байр нэмэгдэнэ; орон нутгийн иргэдийн амьжиргаа, халамж сайжирна; орон нутгийн хөгжлийн төслүүдийн хөрөнгө оруулалт нэмэгдэнэ. Сум, баг, малчин, суурин газрын өрхүүдийн хариултуудын хооронд энэ асуудал дээр чухал ялгаа байхгүй байна.

*"Бороо Гоулд компани нь нийт ажиллах хүчнийхээ 80% -ийг орон нутгаас бүрдүүлсэн байна. Үүний нэгэн адил, орон нутгийн иргэд нь Гацууртын төслөөс шинэ ажлын байр, ханган нийлүүлэгчийн шинэ боломж дээр өндөр хүлээлттэй байна."*

ГТХЯ, Аймагийн ЗДТГ, Бодлого төлөвлөлтийн газар

Уул уурхайтай холбоотой эрсдэлийн талаар (ерөнхийд) асуухад судалгаанд оролцогчдын 50% гаруй нь дараах сөрөг нөлөөг нэрлэсэн: усны нөөцийн хүртээмж; амьдрах орчны доройтол, орчны агаарын чанарын доройтол; тоосжилт. (усны хүртээмжийг одоогоор асуудал гэж авч үзэхгүй байгаа хэдий ч оролцогсод уул уурхайн эхлэхээр ийм асуудал болно гэдэгт итгэж байна., Хэсэг 6.6.5 Байгалийн нөөц -ийг харна уу.)); амьдрах орчны доройтол, орчны агаарын чанарын бууралт, болон тоос шороо нэмэгдэнэ.

Тодруулсан уурхайн сөрөг нөлөөллүүдийн тоонд дараах асуудлуудыг багтаасан байна:

- Усны нөөцийн хүртээмж, амьдрах орчны доройтол, агаарын чанарын доройтол, тоосжилт нэмэгдэнэ зэрэг сөрөг нөлөөлөлтэй гэж Хэрх багийн судалгаанд оролцогсдын 90% нь хариулжээ.
- Түнхэл багийн судалгаанд оролцогсдын 65% нь хамгийн гол асуудал нь газар ашиглалт, газрын доройтол гэж тодорхойлсон.
- Мандал сумын малчид усны чанарын талаар хамгийн их санаа зовж буйгаа илэрхийлсэн хариултыг өгч байсан.
- Мандал сумын төвийн судалгаанд оролцогсдын 48% нь амьдрах орчны доройтол нь гол асуудал болж байна гэсэн бөгөөд тэд тухайн бүс нутагт хэрэгжиж буй уул уурхай төслүүдийг зогсоосноор энэ асуудлыг шийдвэрлэж болно гэж үзсэн.

### 6.3.9 Банк санхүү

Олон арван жилийн туршид энэ салбард өөрчлөлт гарсан бөгөөд өнөөдрийн байдлаар, Монгол Улсад Хаан, Голомт, Худалдаа, хөгжлийн банк зэрэг томоохон гол үйлчилгээ үзүүлдэг банкаас гадна нийгмийн хөгжлийн, бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг банк зэрэг нийлээд нийт 13 банк байна.

"Монгол Улсын хүн амын дөрөвний нэг нь малчин ..... тээврийн дэд бүтэц нь бараг хөгжөөгүй, алслагдмал газарт үйлчилгээ хүргэдэг зэргийг харгалзан үзвэл санхүүгийн үйлчилгээний хүртээмж харьцангуй сайн юм. Банкны гэлтгүй өөр ямар ч үйлчилгээ хүргэхэд бэрх хэдий ч, Монгол Улсын иргэдийн 80% гаруй нь албан ёсны банкинд данстай ба банкны үйлчилгээний хүртээмж нь хөрш орнууд болох Хятад, ОХУ, Казакстан зэрэгтэй харьцуулахад маш сайн байна. Монгол Улс нь энэхүү үзүүлэлтээрээ Зүүн Азийн бага, дунд орлоготой орнуудтай харьцуулахад Эрүүл мэндийн даатгалаас бусад бүх салбараараа тэргүүлдэг бөгөөд дебет картын үйлчилгээ нь зарим талаараа хөгжингүй оронтой эн зэрэгцэж байдаг. Дөрвөн хүн дутмын нэг нь зээлтэй байна; банкинд хадгаламжийн данстай эмэгтэйчүүдийн тоо нь эрэгтэйчүүдийнхээс 10%-иар илүү байгаа нь Хойд Америк болон Европын орнуудтай ойролцоо үзүүлэлттэй байна. Ялангуяа, санхүүгийн үйлчилгээнд хамрагдах боломж муутай, бага боловсролтой, бага орлоготой, хөдөө орон нутгийн иргэдийг оролцуулан тооцоход маш өндөр үзүүлэлттэй байна. "

ЕвроМони тайлан, 2014 оны 7 дугаар сар<sup>60</sup>

Сэлэнгэ аймгийн хэмжээнд нийт 67 банкны байгууллага бүртгэлтэй байна. Үүнд:

- 31 Хаан банк,
- 27 Төрийн банк,

<sup>60</sup> Евро Мони тайлан. 2014. Монгол Улсын банкны салбрын гэрэлт ирээдүй. [www.euromoney.com](http://www.euromoney.com).

- 3 Хас банк,
- 2 Голомт банк,
- 2 Капитал банк,
- 2 Худалдаа хөгжлийн банкууд байна.

Сэлэнгэ аймгийн санхүүгийн салбарын мэдээллийг Хүснэгт 6.15-д харуулав. Нийт бэлэн мөнгөний хэмжээ 2014 онд өмнөх оныхоос 11.2%-иар буурчээ. Энэ нь Монголын эдийн засаг ерөнхийдөө хумигдаж, өрхийн мөнгөний урсгалд нөлөөлж буйг харуулж байна. Үүнээс гадна, аймгийн хэмжээнд зээл 16%-иар, хугацаа хэтэрсэн зээл 47%-иар, чанаргүй зээл 60%-иар (хуулийн заалтыг зөрчсөн зээл) өссөн байхад хадгаламжийн тоо дөнгөж 10.9%-иар өссөн байна. Энэ тоо баримт нь олон өрхөд зээл авч, эргэн төлөхөд нь хүндрэл учирч байгаагийн тод жишээ тул нийгмийн чухал асуудал болоод байна. Аймгийн хэмжээнд хадгаламжийн тоо бага байгаа нь энэхүү асуудлыг улам бүр нэмэгдүүлж байгаа юм.

Зээлийн байгууллага, зээл авах иргэдийн тоо аль аль нь нэмэгдсэн байна. Улсын хэмжээнд нэг сумын зээлийн өрийн үлдэгдэл дунджаар 6,974,900 төгрөг байгаа бол Сэлэнгэ аймгийн сумын дундаж 9,695,700 төгрөг байна. Энэ нь Сэлэнгэ аймгийн иргэд зээл төлөх чадвартай гэдэгтэй итгэлтэй байгаа, эсвэл худалдан авч буй үл хөдлөх хөрөнгө нь улсын дундажтай харьцуулахад илүү өндөр үнэтэй байгааг харуулж байгаа юм.


#### **Хүснэгт 5.15 Банкны салбарын үзүүлэлтүүд, сая төгрөг, Сэлэнгэ аймаг, 2012 – 2014<sup>61</sup>**

Үзүүлэлт	Он			Өсөлт %
	2012	2013	2014	2014/2013
Бэлэн мөнгө	2,561.0	4,852.5	4,309.4	-11.2
Нийт зээл:	114,827.0	16,4827.0	191,373.0	16.1
Хугацаа хэтэрсэн	1,078.0	1,529.2	2,247.9	47.0
Чанаргүй зээл	717.0	1,061.9	1,706.5	60.7
Үндсэн хөрөнгө	2,525.0	3,000.2	3,229.3	7.6
Нийт актив:	21,284.0	174,761.0	201,050.0	15.0
Харилцах	17,858.0	15,530.0	17,228.0	10.9
Хугацаатай хадгаламж	21,172.0	26,745.0	34,746.0	29.9
Хугацаагүй хадгаламж	10,293.0	12,578.0	11,720.0	-6.8
Өөрийн хөрөнгө	11,643.0	15,356.0	21,798.0	42.0
Нийт пассив	109,641.0	159,406.0	179,252.0	12.4
Ашиг/алдагдал	11,643.0	15,356.0	21,798.0	42.0
Нийт орлого	21,001.0	26,526.0	35,223.0	32.8
Хүүний орлого	19,025.0	22,987.0	32,193.0	40.0
Нийт зардал	9,358.0	11,170.0	13,425.0	20.2
Хүүний зардал	3,110.0	4,520.7	5,062.0	12.0
Зээлийн эрсдэлийн сан	103.0	27,024.0	1,363.2	-95.0

Харин улсын хэмжээнд нэг сумын хадгаламжийн дундаж хэмжээ 2,918,600 төгрөг байгаа бол Сэлэнгэ аймгийн сумын дундаж 2,313,100 төгрөг байна. Мандал сум нь аймагтаа хамгийн их хадгаламжтай байна. Нэг өрхийн хадгаламжийн дундаж нь улсын хэмжээнд 1,998,300 төгрөг байхад Сэлэнгэ аймагт 1,322,700 төгрөг байгаа ба энэ үзүүлэлтээр 21 аймгаас 20-рт жагсаж байна. Энэ нь Сэлэнгэ аймагт хадгаламж үүсгэхээсээ илүүтэйгээр үл хөдлөх хөрөнгө худалдан авдагийг харуулж байна. Сэлэнгэ аймгийн айл өрхүүд мөнгөө үл хөдлөх хөрөнгө болгож, хадгаламжийн

<sup>61</sup> Сэлэнгэ аймгийн ЗДТГ, 2014. Сэлэнгэ аймгийн нийгэм эдийн засгийн үзүүлэлт, 2014 он.

хуримтлал бага үүсгэж байгаа нь эдийн засгийн уналтанд бэлтгэл муу байгааг харуулж байна. Жишээ нь, зуд тохиолдох үед Сэлэнгэ аймгийн бага хадгаламжтай айл өрх хүнд хэцүү үеийг даван туулахдаа өрөнд унах магадлалтай юм.



**Зураг 5.13 Банкны салбарын хөрөнгө ба эх үүсвэр, сая. төгрөгөөр, 2009 – 2014 он<sup>62</sup>**

Сэлэнгэ аймгийн зээлийн түвшин өндөр байдгийг эс тооцвол сум, багийн иргэдийн хувьд зээл авах шалгуурыг хангахад маш хүндрэлтэй байдаг талаар ЗБХ-ийн үеэр илэрхийлсэн. Чанаргүй, хугацаа хэтэрсэн зээлийн түвшин өндөр байдаг гэсэн дээрх дүгнэлттэй нийцэж байгаа бөгөөд зээл авсан өрхүүдэд зээлийн өндөр хүүг төлөхөд хүндрэлтэй байна гэж цохон тэмдэглэсэн юм.

*Орон нутгийн өрхийн амьжиргаа нь тэтгэвэр, хүүхдийн тэтгэмж, амьжиргааны бүтээгдэхүүний орлогоос хамаарч байна. Банкны үйлчилгээ нь маш их хүнд сурталтай. Банкнаас зээл авахад хүндрэлтэй байдаг. Мөн зээлийн хүү нь маш өндөр байна. "*

ЗБХ, Мандал сумын иргэд

*"Бидэнд барьцаалах хөрөнгө байхгүй тул банкнаас зээл авахад хүндрэлтэй байдаг."*

ЗБХ, Мандал сумын ЖДҮ

#### 6.3.9.1 Зээл, санхүү

Дээр дурьдсан хэсэгт иргэд ерөнхийдөө банкуудад итгэдэг гэдгийг харуулсан. Судалгаанд оролцсон өрхүүдийн 70%-иас илүүтэй нь айл өрхөд найдвартай, санхүүгийн үйлчилгээ шаардлагатай болох үед хувь хүнд бус банкинд хандана гэж хариулсан байна. Айл өрхүүд нь зээлийн барьцаанд цалин, тэтгэвэр, мал, эд хөрөнгийг байршуулах хандлагатай байна. Баянгол суманд зээл авахдаа мал, цалинг барьцаалах нь хамгийн түгээмэл байхад Мандал суманд үл хөдлөх хөрөнгөө барьцаалах нь түгээмэл байна.

Судалгаанд оролцсон өрхүүдийн 60% гаруй нь өрх, өрхийн гишүүдэд гэнэтийн бэрхшээл тохиолдоход хамаатан саданд, 20% нь банканд, 10% гаруй нь орон нутгийн захиргаанд, 10% хүрэхгүй нь найз нөхөддөө хандана гэж хариулжээ. Энэ асуултын хариултанд сум хооронд, өрх хоорондын ялгаа бага байна. 70% орчим нь туслалцаа, дэмжлэг авч чаддаг гэж хариулсан бөгөөд үүнээс мөнгөн (50% гаруй), сэтгэл санааны (20% гаруй) болон материалаг туслалцаа (20% орчим) авдаг гэжээ. Нэг удаагийн тусламжийн дундаж хэмжээ 400,000-650,000 төгрөг гэсэн мэдээлэл байна. Айл өрхөд гэнэтийн бэрхшээл, хүндрэл тохиолдоход амьжиргаагаа залгуулах

<sup>62</sup> Сэлэнгэ аймгийн ЗДТГ, 2015. Сэлэнгэ аймгийн нийгэм эдийн засгийн үзүүлэлт, 2014 он

дараах нийтлэг арга хэмжээг авдаг гэж хариулсан байна: малаа зарж, борлуулах, хөлсний ажил хийх, сумын захиргаанаас дэмжлэг хүсэх. Зарим хэсэг нь нэмэлт орлого болгож жижиг бизнес эрхлэнэ (гар хийцийн эсгий гутал, хүнсний ногоо, зөгийн бал, талх үйлдвэрлэх); гар аргаар байгалийн нөөц олборлоно гэж хариулжээ. Мандал сумтай харьцуулахад Баянгол суманд засаг захиргаанаасаа дэмжлэг хүсэх нь илүү түгээмэл байгаа нь нийгмийн жижиг бүтэц нь хоорондоо илүү дотно итгэлт харьцаа үүсгэдэгтэй холбоотой байж болох юм.

### **6.3.10 ЖДҮ ба эдийн засгийн шинэ боломж**

1992 оны эхээр зах зээлийн эдийн засагт шилжсэнээр хөдөө орон нутагт бизнес эрхлэх боломж илүү болсон байна. Сэлэнгэ аймагт, тухайлбал өсөж буй ЖДҮ-ийн тоонд модны үйлдвэрлэл, жимс, ногоо бүхий хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, эмийн үйлдвэрлэл, хана болон дулаалгын материалын үйлдвэрлэл гэх мэт орно. ЖДҮ-ийн өсөлт нь Засгийн газрын хөтөлбөрт ажлын хүрээнд 2013 онд ЖДҮ-д хөнгөлөлттэй зээл олгож эхэлсэнтэй холбоотой юм. "Нэг сум, нэг бүтээгдэхүүн" нэртэй хөтөлбөр нь тухайн орон нутагт өрсөлдөх чадвартай, сумын "брэнд" бүтээгдэхүүн (жишээ нь Мандал сумын хувьд зөгийн бал үйлдвэрлэл дээр нь анхаарч байна) гаргах зорилготой юм. Бүтээгдэхүүнүүдийг төрлөөр харьцуулахад 21% нь талх үйлдвэрлэл, 56% нь нарийн боов, бялуу, сүүн бүтээгдэхүүн зэрэг хүнсний үйлдвэрлэл, 33% нь оёдол ба гар урлалын модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл байна.

2014 оны жилийн эцсийн байдлаар Сэлэнгэ аймгийн хэмжээнд татвар төлөгч 1,925 аж ахуйн нэгж байснаас 1,530 хязгаарлагдмал хариуцлагатай компани, 237 бүрэн бус нөхөрлөл, 158 хоршоо байна. Үүнээс, зөвхөн 121 аж ахуйн байгууллага нь тогтвортой үйл ажиллагаа эрхэлж байгаа нь ЖДҮ-ийн салбарт уналт үүссэнтэй холбоотой. Сумдын жижиг дунд үйлдвэрлэлээс 3,558,402 мянган төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсний 52%-ийг аймгийн төв Сүхбаатар сум, 12%-ийг Мандал сум, үлдсэн хувийг бусад сумдын үйлдвэрлэл эзэлж байна. Тэдгээрийн 31.4% нь талх нарийн боов, 20.7% нь мод, модон материал боловсруулах, 14% нь сүү боловсруулах, 9.1% нь барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байна.

Судалгаанд оролцсон өрхүүдээс төлөвлөж буй шинэ бизнесийг одоогийн явуулж буй бизнесийн ашгаар санхүүжүүлэх боломжтой эсэхийг тодруулахад өрхүүдийн 30%-аад нь боломжтой гэсэн хариулт өгчээ. Тодруулбал, Баянгол сумын өрхийн 35%, Мандал сумын 31.6% нь боломжтой гэж хариулжээ. Харин, Түнхэл багийн өрхүүдийн хувьд боломжтой гэсэн хариултын хувь хамгийн бага буюу 27.5% байна. Өөрөөр хэлбэл, ЖДҮ-ийн эздийн гуравны нэг нь одоо эрхэлж буй бизнесийн орлогийг ашиглан шинэ бизнесийн эхлүүлэх боломжгүй гэж хариулсан байна. Энэ нь дээр дурьдсанчлан төслийн бүсэд маш олон тооны тогтворгүй/амжилтгүй ЖДҮ байгаатай холбоотой байж болох юм.

### **6.3.11 Өрхийн орлого**


2014 онд Монгол Улсын нэг өрхийн сарын дундаж орлого нь 974,400 төгрөг байв. Өрхийн түүвэр судалгаагаар нэг өрхийн сарын дундаж орлого нь Баянгол суманд 1,039,000 төгрөг, Мандал сумд 1,359,500 төгрөг байна гэж гарсан байна. Хэрх багийн нэг өрхийн сарын дундаж орлого нь (991,600 төг) Түнхэл багийн нэг өрхийн сарын дундаж орлогоос 340,000 орчим төгрөгөөр доогуур байна. Төслийн бүсэд байрлах өрхүүдийн дундаж орлого нь Монгол Улсын дундажаас бага зэрэг



өндөр байгаа нь Сэлэнгэ аймаг нь Монгол Улсын хөдөө аж ахуйн гол зангилаа байгаатай холбоотой юм.

Зураг 6.14-аас харахад малчин өрхийн дундаж орлого (1,446,600 төгрөг) байгаа нь төслийн бүс дах суурин өрхийн орлогоос 217,000 төгрөгөөр өндөр байгаагаас гадна малчид бусад оролцогч талуудаас хандив, тусламж 3 дахин илүү хүртдэг байна. Үүний шалтгаан нь хөдөөгийн малчид эдийн засгийн уналтад хамгийн ихээр өртдөг учир илүү тусламж шаардлагатай гэж боддог хот суурийн газрын чинээлэг иргэдээс хандив, тусламж илүү үзүүлдэгтэй холбоотой байж болох юм.

Өрхийн судалгаанд оролцсон өрхүүдийн сарын дундаж орлогыг 20.4%-ийг нь цалин, 38.6%-ийг нь тэтгэвэр, тэтгэмж, 41%-ийг нь бусдын хандив, тусламж (бэлэн мөнгө болон бусад тусламж) бүрдүүлж байна. Баянгол, Мандал сумдын өрхийн орлогын эх үүсвэр харилцан адилгүй байна. Тодруулбал, Баянгол сумын хувьд тэтгэвэр, тэтгэмж (65.3%) өрхийн орлогод хамгийн өндөр хувь оруулж байхад Мандал сумын хувьд бусдын хандив, тусламж (41.7%) өрхийн орлогод чухал байр суурь эзэлж байна. Бүлэг 4.1 Хүн амзүй бүлэгт тайлбарласнаар малчин өрхийн сарын дундаж орлогын 44%-ийг мөнгөн орлого 56%-ийг бусдын хандив, тусламж эзэлж байхад суурин өрхүүдийн орлогын 65.3%-ийг мөнгөн орлого, 35%-ийг хувийг бусдаас үнэгүй авсан зүйлс бүрдүүлж байна.



**Зураг 5.14 Төслийн бүсэд байрлах өрхүүдийн дундаж орлого**

Өрхийн судалгаанд оролцсон 10 өрх тутмын нэг нь байгалийн баялаг болох таана, хөмүүл, зээр, гөрөөс зэргийг өрхийн хэрэглээнд (ашиг олох зориулалтаар бус) хэрэглэдэг гэж хариулжээ. Баянгол сумын өрхийн судалгаанд оролцогсдын 18.1%, Мандал сумын 7.8% нь ингэж хариулсан байна. Мандал сум нь Баянгол сумыг бодвол илүү хотожсон сум учир эдгээр байгалийн баялгийг цуглуулахад илүү хол явах болдогтой холбоотойгоор энэхүү ялгааг тайлбарлаж болно. Эдгээр



төрлийн байгалийн баялгийг ашиглах тал дээр хөдөөний малчин, суурин айл өрхийн хооронд ямар ч ялгаа алга байна.

### 6.3.12 Технологи

Сүүлийн жилүүдэд Сэлэнгэ аймгийн сумд хооронд, Улаанбаатар Сэлэнгэ аймгийн хооронд шинэ мэдээллийн шинэ технологи эрчимтэй нэвтэрч байна. Үүрэн телефон буюу гар утас хэрэглэгчдын тоо эрчимтэй өсөхийн зэрэгцээ суурин телефон хэрэглэгчдийн тоо буурсаар байна. Монгол Улс нь 2004 он хүртэл 78 Мб/с багтаамжтай интернетийн нэг гарцтай байсан бол одоо 11.2 Гб/с багтаамжтай 6 гарцтай болсон нь 2004 оноос хойш өндөр хурдаар нэмэгдсэн байна. Интернетийн байнгын хэрэглэгчдийн тоо 2009 – 2010 онуудад огцом өсч 1,000 хүнд ногдох хэрэглэгчийн тоо 72 хүрсэн нь интернетийн хүчин чадал нэмэгдэж, үйлчилгээний үнэ тариф буурч, хөдөө орон нутагт интернетийн сүлжээ, үйлчилгээ хүрээгээ тэлсэнтэй холбоотой байна. Уг үзүүлэлт нь цаашдаа ч эрчимтэй өсөх хандлагатай байна.

2010 оны хүн ам, орон сууцны тооллогоор Сэлэнгэ аймгийн нийт хүн амын 73.6% нь үүрэн телефон ашигладаг, аймгийн нийт хүн амын 17.7% нь гэртээ интернеттэй гээн үзүүлэлттэй байв. Баянгол, Мандал сумдын (ойролцоогоор 74% нь гар утас ашигладаг гэж бүртгэгдсэн байна) үүрэн телефон ашиглагчдын тоонд онцын ялгаа байна. Тэгсэн хэдий ч, Мандал сумын хүн амын 21.6% гэртээ интернет хэрэглэдэг байхад Баянгол сумын зөвхөн 11.5% нь интернет хэрэглэж байх жишээтэй. Энэхүү ялгааг дараах байдлаар тайлбарлаж болно: Баянгол сум нь Мандал сумтай харьцуулахад суурин газрын хүн амын тоо цөөн, хөдөө нутгийн хүн ам ихтэй, хотжилт багатай зэрэг байдагтай холбоотой байж болох юм. 2012 оны эцсийн байдлаар, Сэлэнгэ аймагт кабелийн телевиз ашиглагчдын тоо 2,630 байснаа 2014 онд 1.8 дахин өсч 4,661 өрх кабелийн телевиз хэрэглэж эхэлсэн байна <sup>63</sup>.

#### Хүснэгт 5.16 Үүрэн телефон, гэрийн интернет ашиглагчдын хүн амд эзлэх хувийн жин<sup>64</sup>

	Үүрэн телефон ашигладаг хүн амын хувийн жин	Гэртээ интернеттэй хүн амын эзлэх хувийн жин
Сүхбаатар	80.3	32.8
Баянгол	74.0	11.5
Мандал	74.5	21.6
<b>Аймгийн дундаж</b>	<b>73.6</b>	<b>17.7</b>

### 6.3.13 Амьжиргааны түвшин

Монгол Улсад ядуурлын түвшин нь 29.8% байна. Өрөөр хэлбэл, 837,600 орчим хүн буюу 10 хүн тутмын 3 нь зайлшгүй шаардлагатай хүнсний болон хүнсний бус хэрэглээний зүйлийг худалдан авах чадваргүй байна гэсэн үг<sup>65</sup>. Ядуурлын түвшин Улаанбаатар хотод хамгийн бага буюу хүн амын 23% байгаа бөгөөд төслийн бүс багтах төвийн аймгуудын ядуурлын түвшин 26.3% байна. ҮСХ-ны тайлангийн мэдээгээр Мандал сумын ядуурлын түвшин нь 29.8% (7,259 хүн) байгаа нь

<sup>63</sup> [www.1212.mn](http://www.1212.mn).


<sup>64</sup> ҮСХ (2012). . Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын нэгдсэн дүн, Сэлэнгэ аймаг, ҮСХ, Улаанбаатар.

<sup>65</sup> ҮСХ, 2012. Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын нэгдсэн дүн.


Баянгол сумтай (29.1% буюу ойролцоогоор 1,429 хүн) харьцуулахад бага зэрэг өндөр байна<sup>66</sup>. Хэрх ба Түнхэл багуудад ядуурлын түвшин нь сумын дундажтай ойролцоо байна.

Ядуурлын гүнзгийрэлт нь ядуурлын түвшнээс доогуур амьдарч буй хүн амын хувийг харуулдагаараа ядуу хүмүүсийн тархалтын талаарх мэдээллийг өгдөг. Төвийн аймгуудын ядуурлын гүнзгийрэлт 7.8%-тай байгаа нь тухайн бүсийн ядуу гэж ангилагдсан хүн ам нь ядуурлын түвшнээс дунджаар 7.8%-иар догуур орлоготой байна гэсэн үг. Амьдралын хамгийн өндөр түвшин Улаанбаатар хотод ажиглагдаж байсан ба хамгийн бага нь зүүн аймгуудад, дараа нь төв аймгуудад ажиглагдсан байна. Ер нь залуу, бага боловсролтой, ажилгүй, олон хүүхэдтэй өрх ядуу байх хамгийн их магадлалтай байдаг. Ядуурлын зураглал нь тухайн бүс нутгийн амьжиргааны түвшинг графикаар харуулах хамгийн сайн арга юм. Зураг 5.1515-аас харахад Сэлэнгэ аймгийн ядуурлын түвшин улсын дундажтай ойролцоо байна.

#### А. Аймаг



#### В. Сум



**Зураг 5.15 Ядуурлын зураглал, аймаг, сумаар, 2010 он<sup>67</sup>**

Төслийн бүсийн орон байрыг төрлөөр судлахад өрхийн судалгаанд Баянгол сумаас оролцогсдын 59%, Мандал сумын 28.8% нь гэрт амьдардаг нь харагдаж байна. Энэ нь Мандал сум Баянгол сумыг бодоход харьцангуй ихээр хотожсон суурин газар гэдэг нь харагдаж байна. Түнхэл багийн өрхийн дийлэнх нь (78.3%) ердийн байшинд амьдарч байна. Түнхэл багийн иргэдийн байшинд амьдрах гол шалтгаан нь тэд башингийн гол түүхий эд болох модтой ойр байдагтай холбоотой. Хэрх багийн айл өрхийн 50%-иас бага нь байшинд амьдарч байна. Ерөнхийдөө, иргэдийн амьдрах нөхцөл нь Хэрх багаас илүүтэйгээр Түнхэл багт сайн байна. Үүний адил, Мандал сумын амьдралын нөхцөл Баянгол сумаас илүү байна. Тухайлбал, Мандал сумын өрхийн гуравны нэг, Баянгол сумын 9%, Түнхэл багийн 22.2%, Хэрх багийн 40.9% нь гэр нь шалгүй гэж хариулжээ.

Өрхийн судалгаанд оролцсон өрхийн дийлэнх нь (90% гаруй) нь байшингаа өөрсдөө барьсан байна. Байшин барих дундаж үнэ нь Баянгол сумд 10.5 сая төгрөг, Мандалд 17.5 сая төгрөг байсан юм. Багийн хувьд, Түнхэлд 16.5 сая төгрөг, Хэрх багт 16 сая төгрөг байна.

<sup>66</sup> УСХ, НҮБ Хөгжлийн хөтөлбөр, 2012, Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын нэгдсэн дүнд тулгуурлан ядуурлыг тодорхойлох.

<sup>67</sup> УСХ, НҮБХХ, 2012. Монголын 2010 оны ХАОСТ-суурилсан ядуурлын зураглал, Улаанбаатар

### 6.3.14 Дүгнэлт

Анхдагч, хоёрдогч мэдээллийн дүн шинжилгээний явцад төслийн бүсийн өрхүүдийн гол асуудал нь бараа, үйлчилгээний үнэний огцом өсөлт юм байна гэж тодруулсан.

Түүнчлэн, бараа бүтээгдэхүүний чанар муу, зах зээлийн өргөн сонголтгүй зэрэг нь өрхөд нэмэлт асуудал болдог байна. Энэ нь ялангуяа сүм, аймгийн төвөөс алслагдмал байрладаг Түнхэл багт хурцаар мэдрэгдэж байна. Эдгээр асуудлууд төслийн бүсийн өрх айлууд зээлээс хамааралтай амьдарч, зээлээ эргэн төлөхдөө бэрхшээлтэй учирч байгааг баталж байна (төслийн бүсийн иргэдийн хадгаламж бага байгаа явдал нь үүний тод жишээ юм).

Төслийн бүсийн өрх айлууд өндөр ургац авч илүү ашигтай газар тариалан, үр дүнтэй ногооны ферм эрхлэхэд шаардлагатай мэргэжлийн туслалцаа, технологи, мэдлэг дутагдалтай, хязгаарлагдмал байдагт сэтгэл гонсгор явдаг байна. Түүнээс гадна, төслийн бүсийн малчид малаа даатгалд хамруулах нь бага байгаагийн шалтгаан нь Монголын бусад аймгуудтай харьцуулахад Сэлэнгэ аймаг бэлчээр сайтай тул ерөнхийдөө малынхаа төлөө санаа зовох шаардлаггүй (зуд мэтийн байгалийн аюул) гэсэн ойлголт малчдын дунд өргөн тархсан байдагтай холбоотой байж магадгүй. Ерөнхийдөө, даатгал ба түүний үр өгөөжийн талаар мэдлэг багатай (зуд, гал түймэр, ган гачиг, байгалийн гамшиг г.м.) байдаг байна.

Өрхийн судалгааны үр дүн нь уул уурхайн компанийн талаар өөр өөр хандлагатай байсан. Мандал сумаас илүү Баянгол сумын судалгаанд оролцогчид уул уурхайн салбар хөгжсөнөөр илүү цалинтай болж амьжиргаа дээшилнэ гэдэгтэй санал нийлсэн байна. Тэгсэн хэдий ч, Мандал сумаас илүүтэйгээр Баянгол сумын иргэд ихэнхдээ “мэдэхгүй” гэж хариулсан байна. Хот суурин газрын болон малчин айл өрхийн судалгаанд оролцогчдын хариултуудыг харьцуулахад нэг их ялгаа байгаагүй (ойролцоогоор тэн хагас нь дээрх мэдэгдэлтэй санал нийлж байна гэжээ). Эдгээр судалгаанд оролцогсод нь ерөнхийдөө уул уурхайн салбар, түүний үйл ажиллагаа, уул уурхайтай холбоотой үр ашиг болон болзошгүй нөлөөлөл, эрсдэлийн талаар мэдлэг багатай байгаа нь үүгээр нотлогдож байна гэж хэлж болно. Мөн төслийн талбайд олон тооны “аялдан дагалдагч” буюу санал бодол, үзэл баримтлал нь байнга өөрчлөгддөг бөгөөд олон нийтийн дунд санал бодлоо илэрхийлэх сонирхолгүй хэсэг бүлэг хүмүүс байдгийг харуулж байна.

## **6.4 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ**

### **6.4.1 Оршил**

Тайлангийн энэ бүлэгт ажиллах хүч, хөдөлмөрийн оролцоо, ажил эрхлэлт, ажилгүйдэл, гол салбарын ажиллагсад, ажлын байрны нөхцөл болон цалин орлого зэрэг төслийн бүсийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлуудын талаар авч үзнэ.

### **6.4.2 Ашигласан тоо мэдээлэл**

Суурь судалгааг 2012 – 2015 онуудын тоо мэдээлэлд тулгуурлан боловсруулсан болно. Үндэсний статистикийн хороо, хүн ам, байрны тооллого, Сэлэнгэ аймаг, Баянгол, Мандал сумдын Засаг даргын тамгийн газрын статистикийн хэлтэс зэргийн тайлангаас хоёрдогч тоо мэдээллүүдээ авав. Төслийн бүсэд хийсэн өрхийн түүвэр судалгаа, зорилтот бүлгийн хэлэлцүүлэг (ЗБХ), гол талуудтай хийсэн ярилцлага (ГТХЯ) зэргийн үр дүнг ашиглан анхдагч мэдээллээ цуглуулсан.

Энэ бүлэгт оруулаагүй зарим нэг хүснэгт болон зургийг Хавсралт Г-ээс харна уу.

### **6.4.3 Ажиллах хүч ба хөдөлмөрийн оролцоо**


Бүлэг 6.1 Хүн ам зүйн бүлэгт дурьдсанаар Монгол Улсын хөдөлмөрийн насны хүн ам тогтвортойгоор өсч байгаа ба 2010 онд нийт хүн амын 69%-д хүрсэн байна. Монгол Улс 1.2 сая гаруй эдийн засгийн идэвхтэй хүн амтай бөгөөд үүний 3% (35,900 хүн) нь Сэлэнгэ аймагт оршин суудаг байна. Сүүлийн 3 жилийн хугацаанд Сэлэнгэ аймгийн хөдөлмөрийн насны хүн ам нь 5.6%-иар өссөн. Гэхдээ бодит байдал дээр Сэлэнгэ аймагт хөдөлмөрийн насны хүн амын зөвхөн 54.1% нь эдийн засгийн идэвхтэй байна. Ялангуяа, Сэлэнгэ аймагт ажиллах хүчний оролцооны түвшин сүүлийн жилүүдэд тогтмол буурч байна. 2012 оны мэдээлэлтэй харьцуулахад 2014 онд ажиллах хүчний оролцооны түвшин<sup>68</sup> 11.2%-иар буурч, ажил эрхлэлт 4.2%-иар өссөн байна. Ажиллах хүчний оролцоо муу, эдийн засгийн үйл ажиллагаа ховор байгаа нь хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны боломжид сөргөөр нөлөөлж буй Монгол Улсын сүүлийн жилүүдийн эдийн засгийн удаашралтай холбоотой юм. Үүнээс гадна, шинээр бизнэс эхлүүлэх санхүүжилтийн хүртээмж муу, бизнесээ амжилттай эрхлэх техник мэргэжлийн үр чадвар дутмаг зэргээс үүдэн хөдөлмөрийн оролцоонд бэрхшээл тулгардаг гэж өрхийн судалгаанд оролцогчид хариулж байсан (Бүлэг 6.4.8 Шинээр үүсэж буй ажлын байр хэсгээс харна уу).

Хүйсийн харьцааг авч үзэхэд ажиллах хүчний эмэгтэйчүүдийн оролцоо 48.7%-тай байгаа нь эрчүүдээс (59.1%) доогуур байна. Эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн түвшин 91.3%-тай байгаа нь эрчүүдийнхээс (88.5%) илүү өндөр байна. Эдийн засгийн үйл ажиллагааны оролцоотой холбоотой эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын ялгаа нь өндөр хэвээр байгаа ба энэ ялгаа нь сүүлийн хэдэн жилүүдэд бага зэрэг буурсан ч аймаг хэмжээнд буурна гэсэн таамаглал харагдахгүй байна.

Сэлэнгэ аймгийн нийт эдийн засгийн идэвхтэй хүн амын 29.4%, нийт ажил эрхэлж байгаа хүн амын 30.9% нь Мандал суманд байна. Эдгээр зураглалаас харахад Мандал сум нь Сэлэнгэ аймгийн ажил эрхлэлтэнд чухал үүрэг гүйцэтгэж байна. Ач холбогдол бүхий үндэсний үйлдвэрлэл хөгжсөн

<sup>68</sup> Ажиллах хүчний оролцооны түвшин нь хөдөлмөрийн насны хүн амын тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоод хуваасантай тэнцэх хэмжээ.

Монгол Улсын хамгийн том сум болох Мандал сумын ажиллах хүч нь аймгийн нийт ажиллах хүчний гуравны нэг хувийг эзэлж байна.




**Зураг 5.16 Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйсээр, Сэлэнгэ аймаг, 2012-2014**

#### 6.4.4 Хөдөлмөр эрхлэлт

Одоогийн байдлаар Монгол Улсад сая гаруй ажиллагсад байгаагийн 3% нь (32,200 хүн) Сэлэнгэ аймагт оршин сууж байна. Сэлэнгэ аймгийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2012 оноос хойш тогтмол буурч байна. 2012 онд 94%, 2013 онд 91%, 2014 онд 89.8% тус тус болж буурсан. Хувийн хэвшлийн ихэнх компаниудын ажлын байрны нөхцөл нь хангалттай сайн ч цалин бага учир тогтвортой ажиллах хүч дутмаг гэж Сэлэнгэ аймгийн Хөдөлмөрийн хэлтсээс мэдээлсэн<sup>69</sup>. Жижиг дунд үйлдвэрлэгчид (ЖДҮ) хүмүүсийг дараах салбаруудад ажиллуулдаг. Үүнд: зоогийн газар, худалдаа үйлчилгээ – 50%, газар тариалан – 30%, фермийн аж ахуй (үхэр, гахай, зөгий, шувуу) – 10 – 15%, үлдсэн хувь нь барилгын материал (блок, тоосго, шаваас) болон хүнс, мод модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл багтана. Аймгийн хамгийн том ЖДҮ нь 200 гаруй ажилчинтай, жилд 1.5 тэрбум төгрөгийн борлуулалт хийдэг байна. Хамгийн бага ЖДҮ нь 10-аас доош ажилчинтай, жилд 200 саяас доош төгрөгийн борлуулалт хийдэг байна.

<sup>69</sup> ГТХЯ, Хөдөлмөрийн хэлтэс, Засаг даргын тамгын газар, Сэлэнгэ аймаг, Састэйнабилити Ийст Эйжиа ХХК, 2015.



**Зураг 5.17 Сэлэнгэ аймгийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин, 2012–2014 он<sup>70</sup>**

Монгол Улсад нийт 183,600 төрийн албан хаагчид байдгаас 5,700 буюу 3.1% нь Сэлэнгэ аймагт ажиллаж байна. Энэ нь (2012 онд 5,074, 2013 онд 5,248, 2014 онд 5,693 ажиллагсад) төрийн байгууллагын ажил эрхлэлтийн тогтвортой өсөлтийг харуулж байна. Монгол Улсын эдийн засгийн ерөнхий уналттай (хөрөнгө оруулалтын байдал, эдийн засгийн өсөлт удааширсан) холбоотойгоор хувийн хэвшлийн хөдөлмөр эрхлэлт буурсан байна. Үүний зэрэгцээ, төрийн байгууллагын хөдөлмөр эрхлэлтийн өсөлтийг төвлөрлийг сааруулах замаар төрийн үйлчилгээг үзүүлэх тухай Монгол Улсын Засгийн газрын чиг баримтлал, хүн амын өсөлт зэрэгтэй холбон тайлбарлаж болно.

Мандал суманд архи ундааны үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, газар тариалан зэрэг чиглэлийн хувийн хэвшлийн хөдөлмөр эрхлэлт хамгийн түгээмэл байна. Мандал сумын аж үйлдвэрийн гол дэмжигч нь сумын нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх төмөр замын сүлжээ юм. Сумын гол ажил олгогч газрууд нь хариуцлагатай хязгаарлагдмал компани (ХХК) – 41.3%, хувийн бизнес (бэлчээрийн мал аж ахуйг оруулан) – 29.4%, төрийн байгууллага – 13.5% ба үлдсэн 10% нь хоршоолол болон холбоод<sup>71</sup> гэж өрхийн судалгааны үр дүнгээр гарсан. Энэхүү судалгааг хийж байх явцад ийм төрлийн статистик мэдээлэл Баянгол суманд харамсалтай нь байгаагүй.

Өрхийн судалгаанд оролцогчдын 51.6% буюу сумын хэмжээнд Баянгол сумын 43.3%, Мандал сумын 56.7% нь тодорхой орлого бүхий ажил хөдөлмөр эрхэлдэг байна. Түнхэл, Хэрх багийн нийт судалгаанд оролцогчдын 50% гаруй нь хөдөлмөр эрхэлдэг (орлого олох албан болон албан бус ажил) байна. Нийтдээ суурин газрын өрхүүдийн 51.5%, малчин өрхийн 51.9% нь орлого олох үйл ажиллагаа эрхэлдэг байна. Өрхийн судалгаанд оролцсон хүмүүсийн 40% гаруй нь хувийн бизнест, 33% нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид харин үлдсэн 15.2% нь төрийн байгууллагад ажиллаж байна. Судалгааны үр дүнг сум тус бүрээр задлан харуулбал, Баянгол сумын 67.5% нь хувийн бизнест, 21.4% нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид, үлдсэн 10.3% нь төрийн байгууллагад

<sup>70</sup> Сэлэнгэ аймгийн ЗДТГ, 2014. Сэлэнгэ аймгийн нийгэм эдийн засгийн үзүүлэлт, 2015

<sup>71</sup> Сэлэнгэ аймгийн ЗДТГ, 2014. Сэлэнгэ аймгийн нийгэм эдийн засгийн үзүүлэлт, 2014.



ажилладаг байхад Мандал сумын 38.9% нь хувийн бизнест, 38.9% нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид, 17.2% нь төрийн байгууллагад ажиллаж байна.

#### **Төслийн бүсийн бичил уурхай ба хөдөлмөр эрхлэлт**

"Сумын төвөөс зүүн хойшоо 38 км байрладаг Ноёт ууланд (Ноён уул биш) хоёр хоршоолол ажилладаг. Бидний ихэнх нь одоогийн байдлаар ямар ч ажилгүй байгаа учир хагас цагаар ажиллах ажил хайх, мөнгө олох зорилгоор бусдад тусалж сумын төв дээр байна. Бичил уурхайн ихэнх ТББ-ууд Бороогийн уурхайн талбай болон орлого нэмэгдүүлэх төслүүдийг сонирхож байгаа. Бороогийн уурхайн талбайд бичил уурхай эрхлэгчээр (Бороогийн албан ёсны ажилтан болохгүйгээр) ажиллах хүсэлтэй байна. "Нинжа" (хувиараа гар аргаар алт олборлох)-аар ажиллах нь бидний эрүүл мэндэд муугаар нөлөөлдөг учир урт хугацаанд энэ маягаар ажиллах боломжгүй гэдгийг бид ойлгож байгаа боловч ажилгүй байснаас бичил уурхай буюу нинжаг илүүд үзэж, Бороогийн уурхайн талбайд ажиллах сонирхолтой байна. Бид ил уурхайд нинжа болж ажиллахыг хүсч байна."

Бичил уурхайн ЗБХ, Хэрх баг

"Бичил уурхайчид өөр ажил хайдаг ч ажил олоход хэцүү байдаг."

Бичил уурхайн ЗБХ, Хэрх баг

"Бид бодит орлогогүй тул өрхийн хэрэгцээгээ хангаж чаддаггүй. Ноёт ууланд зөвхөн 2 хоршоолол ажилладаг ба бусад нь огт ажиллахгүй байгаа нь 2 шалтгаантай: 1) Ноёт ууланд ямар ч хайгуулын ажил хийгдээгүй тул хүдрийн хэмжээ, нөөц тодорхойгүй. 2) бичил уурхай нь жижиг хэмжээтэй ч гэсэн маш их өртрөгтэй учир их хэмжээний хөрөнгө оруулалт шаарддаг. Одоогоор, бичил уурхайчид ямар ч ажилгүй, орлогогүй байна. Ноёт уулнаас өөр бичил уурхайн зориулалттай газар байхгүй. Ноднин жил бид Бороогийн уурхайн талбайд ажиллах хүсэлтээ сумын захиргаанд гаргасан хэдий ч одоог хүртэл шийдээгүй байгаа. Сумын захиргаа Бороогийн уурхайн талбайг Баянгол сумын нутаг дэвсгэр дээр оршдог тул зөвхөн Баянгол сумын бичил уурхайчид л тэнд ажиллах ёстой байж болзошгүй гэж хариулсан."

Бичил уурхайн ЗБХ, Хэрх баг

"Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас шилжих шилжилтийн үед ажилгүйгүйдэл, мэргэжил багатай болон мэргэжилгүй ажиллагсдын тоо асар их өссөнөөр Монгол Улсад бичил уурхайн салбар хөгжих хамгийн том түлхэц болсон. Түүнчлэн, Монголын эрс тэс уур амьсгал, 1992 – 2002 онуудад болсон зудын үед их хэмжээний малаа алдаж орлогын эх үүсвэргүй болсон малчид бичил уурхайчид болсон. Олон өрх айлын байнгын болон түр зуурын орлогын нэмэлт эх үүсвэр нь бичил уурхайн салбар болсон байна. Бичил уурхайн хөгжлийн гол түлхэц нь ашигт малтмалын өндөр үнэ (мал аж ахуй гэх мэт бусад хөдөлмөр эрхлэлтийн орлоготой харьцуулахад); албан ёсны мэргэжилгүйн улмаас том хэмжээний уурхай болон бусад салбарт хөдөлмөрлөх боломж муу; ядуурал; бусад мэргэжилтэй харьцуулахад орлого их олох боломжтой (бичил уурхайчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 57%-аар илүү орлого олдог); нэмэлт орлого олох боломжтой /улирлын чанартай ажил эрхлэх боломжтой; гэр бүлээ дэмжиж хүүхдээ сургуульд явуулах боломж нэмэгдсэн зэрэг бусад олон шалтгаантай байна.<sup>72</sup> 2010 оны 4-р сард Монгол Улсад бичил уурхайн салбарыг хуульчлан албан ёсны болгох төсөл нь УИХ-ын олонхийн саналаар дэмжигдсэн. Энэ хуулийн дагуу бичил уурхайчид газар эзэмшин, тогтмол үйл ажиллагаа явуулж тогтмол орлоготой болох боломжтой. Үүний зэрэгцээ, бичил уурхайчдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, нийгмийн халамж, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулсан байна. Гэсэн хэдий ч бодит байдал дээр, бичил уурхайчдыг Засгийн газар болон орон нутгийн иргэд дэмждэггүй, нийгэмд хүлээн зөвшөөрдөггүй, хууль сайн үйлчилдэггүй гэх мэт бэрхшээлтэй асуудлууд байсаар байна.

Дээрх мэдээлэл болон зорилтот бүлгийн хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн дүгнэснээр ядуурлаас үүдэлтэй бичил уурхайн салбарт нөлөөлөх хэд хэдэн төрлийн хүчин зүйлс байгаа нь тодорхой байна. Бичил уурхай нь өрхүүдийг байнгын орлоготой, тогтмол ажлын байртай байлгах боломж олгодог. Монголчуудын заримынх нь хувьд, өөр хөдөлмөр эрхлэх эсвэл албан ёсны уурхайн компанид ажиллах боломжгүй (ур чадваргүй болон санхүүгийн боломжгүйтэй холбоотой) байдаг тул бичил уурхайг хууль ёсны мэргэжил гэж үздэг, ялангуяа бичил уурхайн хоршоололд хамрагдсан ажиллагсад ашиг орлого олж, бие даан ажиллах боломжтой юм. Бичил уурхай нь Гацууртын уурхайн бүтээн байгуулалттай холбоотой гол асуудал болсон учраас үүнийг нарийн цогц удирдлагын арга барилаар шийдвэрлэх шаардлагатай.

#### **6.4.5 Орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэх**

Өрхийн судалгааны явцад урган гарч ирсэн гол асуудлын нэг нь өрхүүдийн орлого төрөлжүүлэх стратегийн ач холбогдол байв. Төслийн бүсийн өрхийн эрсдэлээ удирдах гол арга нь төрөлжүүлэх

<sup>72</sup> Сэстайнабилити Ийст Эйжиа. 2014. Монголын уул уурхайн салбарын байгаль орчин нийгмийн стратегийн тайлан.

стратеги юм. Ихэнх өрхүүд орлогоо нэмэгдүүлэхийн тулд бичил уурхай, газар тариалан, мал аж ахуй (дээрх шигтгээг харна уу) болон албан бус үйлдвэрлэл, үйлчилгээ зэрэг олон төрлийн үйл ажиллагааг эрхэлж байгаа нь харагдсан.

#### 6.4.5.1 Газар тариалан

Судалгаанд оролцсон өрхүүдийн бараг дөрөвний нэг нь өрхийн хэрэглээнд зориулан газар тариалан эрхэлж, орлогын эх үүсвэрээ төрөлжүүлсэн байна. Судалгаанд оролцсон нийт өрхийн 22.7% нь тариалангийн газартай бөгөөд үлдсэн хэсэг нь газраа бусадтай хамтран ашиглаж (гэр бүлийн газрыг хамтран ашиглах нь нийтлэг), түрээслэдэг байна. Сумдын хэмжээнд, Баянгол сумын судалгаанд оролцсон өрхийн 21%, Мандал сумын өрхийн 23.4% нь тариалангийн талбайтай байв. Өрхийн хэрэглээний тариалангийн дундаж талбай нь Баянгол суманд 5,500 кв.м, Мандал суманд 7,500 кв.м байна. Баянгол суманд сүүлийн 12 сард тариалангийн талбайтай өрхийн 80.8% нь үр тариа, ногоо тариалж, дунджаар 360 кг ургац авсан ба ихэнх өрх нь хураан авсан ургацаа өрхийн хэрэглээнд зарцуулсан байна. Мандал сумын өрхийн 69.2% нь тариалангийн талбайдаа үр тариа, хүнсний ногоо тариалж, 873 кг ургац хураан авсан бөгөөд 23.3% нь хураан авсан ургацаа борлуулсан бол үлдсэн хэсэг нь өрхийн хэрэглээндээ зарцуулсан байна. Нэг өрхийн тариалангийн үйл ажиллагаанаас олсон дундаж орлого нь 1,875,000 байв. Үндсэндээ, айлууд газар тариаланг өрхийн хэрэглээндээ зориулж эрхэлдэг тул борлуулах ургац нэмэлтээр тариалах шаардлага байдаг учир газар тариалангийн үйл ажиллагаанаас өрх нь харьцангуй бага орлого олдог юм. Хураан авсан ургацаа зарахад орон нутгийн засаг захиргаанаас зөвшөөрөл авах, татвар төлөх шаардлагатай зэрэг бэрхшээлүүд гардаг талаар судалгаанд оролцсон өрхүүд тэмдэглэж байсан. Эдгээр бэрхшээлүүд нь олон өрхийн сонирхлыг бууруулсан байна.

Түнхэл багийн судалгаанд оролцсон өрхийн 25% нь тариалангийн газар эзэмшдэг бөгөөд талбайн хэмжээ дунджаар 11,026 кв.м байгаа нь Хэрх багийнхтай (2,199 кв.м) харьцуулахад 5 дахин их байна. Түнхэл багийн тариалангийн газартай өрхийн дийлэнх буюу 87% нь сүүлийн 12 сарын турш үр тариа, хүнсний ногоо тариалж, нэг өрх дунджаар 778.7 кг ургац хураан авч өрхийн хэрэглээнд түлхүү хэрэглэсэн байна. Хэрх багийн өрхийн тариалангийн дундаж талбай хэдийгээр бага боловч хураан авсан ургацынхаа 40 орчим хувийг борлуулж, нэг өрх дунджаар 2,606,000 төгрөгийн орлого олжээ.

#### 6.4.5.2 Мал аж ахуй

Баянгол сумын судалгаанд оролцсон өрхийн 75.4%, Мандал сумын өрхийн 51.5% нь сүүлийн 12 сарын хугацаанд мал аж ахуй эрхэлж байсан байна. Багийн хэмжээнд авч үзвэл Түнхэл багийн судалгаанд оролцсон өрхийн 44%, Хэрх багийн өрхийн 67.6% нь мал аж ахуй эрхэлсэн гэж хариулсан байна. Энэхүү статистик мэдээллээс Мандал сум илүү суурин хүн амтай, Баянгол сумын суурин хүн ам харьцангуй бага байгаа нь харагдаж байна.

#### **Төслийн бүсийн мал аж ахуй болон орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэхэд гарах бэрхшээл**

Өнгөрсөн онд төслийн бүсийн малчдын тоо бага зэрэг өссөн байна. Сэлэнгэ аймагт 2012 – 2013 онуудад малчдын тоо 0.4 хувиар буурч, 7,710 гэж бүртгэгдэж байсан бол 2013 – 2014 онуудад малчдын тоо эргээд 3.1 хувиар өсч, 7,952 болжээ. 2013 оны байдлаар Мандал суманд малчдын тоо 2.1 хувиар өссөн бол Баянгол суманд 2.3 хувиар буурсан байна. Зорилтот бүлгийн хэлэлцүүлгийн үеэр Сэлэнгэ аймаг нь баруун аймгуудтай харьцуулахад үржил шим сайтай бэлчээртэй, зах зээлд ойрхон тул Монгол Улсын баруун бүсээс малчид ихээр шилжин ирдэг гэж дурьдсан байна. Гэхдээ энэхүү төсөөлөл нь бодит



байдалтай нийцэхгүй байгаа бөгөөд Бүлэг 6.1-т дурьдагдсан шилжилт хөдөлгөөний статистик мэдэллийн дагуу төслийн бүсэд шилжин ирэх малчдын тоо бага байна.

Төслийн бүсийн малчдад учирч буй бэрхшээлийг тайлбарлах явцад тэдний ашиг орлогын асуудлыг хөндөх шаардлагатай, учир нь малчдын малын тоо өссөний улмаас бэлчээрийн даац хэтрэхэд хүрнэ. Тиймээс, төслийн бүсийн бэлчээрийн газар их хэмжээгээр доройтож, үржил шимгүй болсон байна. Түүнчлэн тус бүс нь Монгол Улсын газар тариалангийн хамгийн том нутаг тул тариаланчид, малчдын хооронд газрын өрсөлдөөн их байдаг нь асуудлыг улам бүр хүндрүүлдэг.

Зорилтот бүлгийн хэлэлцүүлэгт оролцсон малчид уул уурхай (болон бусад) салбарт ажиллах үр чадвар дутмаг, ажилласан туршлага байхгүй, англи хэлний мэдлэг байхгүй учир мал аж ахуйгаас гадна орлогын эх үүсвэрээ төрөлжүүлэх боломжгүй байдаг талаар илэрхийлсэн. Тэд зөвхөн мал аж ахуй эрхлэх л (ашиг орлогоо нэмэгдүүлэхийн тулд тэд малын тоо толгойг өсгөх, эсвэл малын бүтээгдэхүүний нэгж ашгийг нэмэгдүүлэх) боломжтой. Мал аж ахуйтай холбоотой асуудал нь баруун аймгаас шилжин ирэх малчдын өсөлттэй холбоотой гэж бодох нь амар боловч Монгол Улсын мал аж ахуйг тойрсон төвөгтэй асуудлуудыг (газар ашиглалт, байгалийн нөөцтэй холбоотой асуудлуудыг Бүлэг 6.6 Газар ашиглалт, байгалийн нөөц-д дэлгэрэнгүй тайлбарласан байна) цаашид нягт судлах шаардлагатайг харуулж байна.

### 6.4.5.3 Албан бус үйлдвэрлэл, үйлчилгээ

Судалгаанд оролцогчдын Баянгол сумын зөвхөн нэг өрх, Мандал сумын 8 өрх албан бус үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэдэг гэж хариулсан байна. Баянгол сумын уг өрх нь худалдааны бизнес эрхэлдэг. Мандал сумын өрхийн хувьд тэдний 3 нь худалдаа наймаа эрхэлдэг, 2 нь цайны газар, нэг нь гутал засвар, нэг нь оёдлын цех ажиллуулдаг, үлдсэн нэг нь мужаан хийдэг байна. Эдгээр бизнес эрхлэгчдийн ердөө л 60% нь орлогын албан татвар төлдөг. Орон нутгийн олон эмэгтэйчүүд оёдол/гоёлын үйлчилгээ болон эсгий хийх, цагаан идээ үйлдвэрлэх, тахиа, гахайны аж ахуй эрхлэх зэргээр орлого олдог байна.

### 6.4.6 Цалин, хөлс

Монгол Улсын хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагсдын сарын дундаж цалин 796,600 төгрөг байгаа бөгөөд эрэгтэйчүүдийн дундаж цалин (859,700 төгрөг) байгаа нь эмэгтэйчүүдийн цалингаас (733,300 төгрөг) өндөр байна. Өөрөөр хэлбэл, эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн дундаж цалингийн 85.2%-тай тэнцэхүйц цалин авч байна<sup>73</sup>. Сэлэнгэ аймгийн нийт ажиллагсдын дундаж цалин 693,300 төгрөг байгаа нь үндэсний дунджаас 103,300 төгрөгөөр доогуур байна. Хүйсийн хувьд авч үзвэл эмэгтэйчүүдийн дундаж цалин 625,000 төгрөг, эрэгтэйчүүдийн дундаж цалин 654,400 төгрөг байна. Хэдийгээр, эмэгтэйчүүдийн цалин эрэгтэйчүүдийнхээс 4.5%-иар доогуур байгаа боловч үндэсний дундажтай харьцуулахад цалингийн зөрүү харьцангуй бага байна.

Судалгаанд оролцогчдын сарын дундаж цалин 397,200 төгрөг байна. Судалгаанд оролцогчдын сарын дундаж цалин<sup>74</sup> сумаар нь харьцуулж үзэхэд Мандал суманд 412,200 төгрөг, Баянгол суманд 360,200 төгрөг байв. Сарын 500,000-с дээш төгрөгийн цалинтай оролцогчдын хувь Мандал суманд (22.3%) өндөр байхад 300,000 мянган төгрөг хүртэлх цалинтай оролцогчдын хувь Баянгол (74.2%) суманд нэлээд өндөр байв. Харин багийн хувьд, Хэрх багийн дундаж цалин 407,600 төгрөг байгаа нь Түнхэл багийн дундаж цалин болох 386,900 төгрөгөөс өндөр байна.

<sup>73</sup> УСХ (2015). Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2014, хуудас 59, Улаанбаатар.

<sup>74</sup> Монгол Улсын 2012 оны статистикийн эмхэтгэлийн мэргэжсэн ажиллагчдын сарын дундаж цалингийн хамгийн бага нь газар тариаланч (360,800 төгрөг) авдаг бөгөөд хөдөө аж ахуйн (224,500 төгрөг) салбар нь хамгийн бага цалинтай салбар байна.

#### 6.4.7 Ажлын нөхцөл

Баянгол сумын судалгаанд хамрагдагсдын 81% нь “энгийн” нөхцөлд, 17.1% нь “хүнд” нөхцөлд ажилладаг гэж хариулсан бол Мандал сумын судалгаанд хамрагдагсдын 52% нь “энгийн”, 23.5% нь “хүнд”, 10 орчим хувь нь “эрүүл мэндэд хортой буюу аюултай” нөхцөлд ажилладаг гэжээ. Түнхэл багийн гол ажил олгогч болох модны аж ахуй нь бие махбодийн хүч чадал шаарддаг салбар учир тус багийн судалгаанд оролцогчдын 35% нь “хүнд”, 7% нь “хортой буюу аюултай” нөхцөлд ажилладаг гэсэн байна. Харин, Хэрх багаас судалгаанд оролцогчдын 12.6% нь “хүнд”, 10% нь “хортой буюу аюултай” нөхцөлд ажилладаг гэжээ.

Судалгаанд оролцсон нийт өрхүүдийн ажлын нөхцлийн талаарх ойлголтыг малчин, суурин өрх гэж зааглан авч үзвэл оролцогчдын ихэнх нь “энгийн” ажлын нөхцөл гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа ч ойролцоогоор 20% нь ийм төрлийн нөхцөлийг “хүнд” гэж тодорхойлсон байна. Хэдийгээр, мал аж ахуй нь хичнээн биеийн хүчний ажил боловч малчид ерөнхийдөө ажиллах нөхцлөө хүнд, хэвийн бус эсвэл аюултай гэж үздэггүй байна.

#### Хүснэгт 5.17 Судалгаанд оролцогчдын ажлын нөхцлийн талаар ойлголт<sup>75</sup>

	Ажлын нөхцөл байдал						Хариулагчдын тоо
	Сайн	Энгийн	Хүнд	Хортой	Аюултай	Мэдэхгүй	
Сум							
Баянгол	1.7	81.2	17.1	-	-	-	117
Мандал	12.3	52.2	23.5	3.4	6.3	2.2	268
Баг							
Түнхэл	7.3	46.3	35	4.1	3.3	4.1	123
Хэрх	11.8	64.6	12.6	3.1	7.1	0.8	127
Бусад	8.1	71.1	17.8		3		135
Өрх							
Малчин	8.3	63.6	19.8	3.3	4.1	0.8	121
Суурин	9.5	59.8	22.3	1.9	4.5	1.9	264
Бүгд	9.1	61.0	21.6	2.3	4.4	1.6	385

#### 6.4.8 Шинээр бий болж буй ажлын байр

2013 онд Сэлэнгэ аймагт 1,686 ажлын байр шинээр нэмэгдсэн бол 2014 онд 1,548 болж 8.2%-иар буурчээ. Мандал суманд энэхүү чиг хандлага нь адилхан бөгөөд 2014 онд шинээр 262 ажлын байр бий болсон нь өмнөх оныхоос 3.3%-иар буурсан байна. Харин Баянгол суманд 93 ажлын байр шинээр нэмэгдсэн нь өмнөх оныхоос 17.7%-иар илүү байна. Харин зорилтот бүлгийн хэлэлцүүлэгт оролцогчид нь Мандал суманд Баянгол сумаас илүү ажлын байрны боломж бий гэж тодорхойлж байсан. Энэ нь Мандал сум эдийн засгийн хувьд харьцангуй идэвхитэй бүс тул Баянгол сумаас илүү эдийн засгийн боломж бий гэсэн ойлголттой холбоотой юм. Мандал, Баянгол сумдад бий болсон улирлын чанартай ажлын ихэнх байр нь барилга (ялангуяа, Мандал суманд), хөдөө аж ахуйн салбарт байна.<sup>76</sup>

Сэлэнгэ аймгийн байршил нь Улаанбаатар хот болон ОХУ-тай ойр байдаг, мөн сумдуудын хоорондын дэд бүтэц сайнтайн улмаас айл өрхүүд ЖДҮ-ийг хөгжүүлэх, худалдаа арилжаа эрхлэх

<sup>75</sup> Сэстайнабилити Ийст Эйжиа. 2015. Гацууртын төслийн нийгмийн суурь судалгааны тайлан, Өрхийн судалгаа.

<sup>76</sup> Гол талтай хийсэн ярилцлага, Сэлэнгэ аймгийн Статистикийн хороо.

боломжтой байдаг гэж хариулж байсан. Эдийн засгаа хөгжүүлэх боломж байгаа хэдий ч ажилгүйдлийн түвшин өндөр, аймгийн ашигтай байршил, харьцангуй сайн тариалангийн талбай зэрэг давуу талаа ашиглах үйл ажиллагаа дутагдалтай байна. Энэ нь боловсон хүчний техник, мэргэжлийн үр чадвар, туршлага дутуу, эд материал, тоног төхөөрөмжийн хүртээмж муу, худалдан авах чадваргүй, аливаа бизнес эхлүүлэхэд шаардлагатай санхүүгийн хөрөнгөгүйтэй холбоотой хэмээн судалгаанд оролцогч өрхүүд үзэж байна. Жишээ нь айл өрхүүд арилжааны зориулалттай хүнсний ногоо/үр тариа тарих газартай хэдий ч газар тариалан амжилттай эрхлэхэд шаардлагатай трактор/үр суулгагч машин зэрэг тоног төхөөрөмж, технологийн ноу-хаугүй байна.

*"Баянгол суманд ихээхэн ажиллах хүч байгаа ба ихэвчлэн Баянгол сумын орон нутгийн иргэдээс (80%) бүрдэнэ. Гацууртын төслийг ирээдүйд ажлын байр бий болгох боломжтой, хурдацтай өсөх боломжтой салбар гэсэн хүлээлт орон нутгийн иргэдийн дунд өндөр байна. "*


Гол талуудтай хийсэн ярилцлага, Баянгол сумын ЗДТГ

#### **6.4.9 Ажилгүйдэл**

Монгол Улсын хэмжээнд нийт 95,700 ажилгүй иргэд байгаагийн 3.9% (3,700) нь Сэлэнгэ аймагт байдаг<sup>77</sup>. Албан ёсоор 2012 онд Сэлэнгэ аймгийн хэмжээнд ажил идэвхтэй хайж буй ажилгүй иргэдийн тоо 2,480 байсан бол 2014 онд 3,679 болж 67.4%-иар өсчээ. Аймгийн хэмжээнд нийт бүртгэлтэй байгаа эдийн засгийн идэвхигүй иргэдийн 67% нь ажилгүй, 23.4% нь сурагчид, 9.7% нь хөдөлмөрийн чадваргүй иргэд байна. Улсын хэмжээнд эмэгтэй ажилгүй иргэдийн түвшин эрэгтэйчүүдийнхээс ямагт өндөр байдаг ба Сэлэнгэ аймагт 2012 – 2013 онуудад энэ чиг хандлага нь адилхан байна. Албан ёсоор ажилгүй гэж бүртгэгдсэн эмэгтэйчүүдийн хувь их байгаагийн шалтгаан нь эрэгтэйчүүд нь ажилд зуучлах албанд хандахаас илүүтэйгээр албан бус сүлжээг (танил, найз нөхөд) ашиглан ажилд орохыг илүүд үздэгтэй холбоотойгоор тайлбарлаж болно. Энэхүү ерөнхий хандлага нь Сэлэнгэ аймагт 2012 – 2013 онуудад илэрхий байсан хэдий ч 2014 онд ажилгүй эрэгтэйчүүдийн тоо (11.4%) эмэгтэйчүүдийнхээсээ (8.7%) илүү байв. 2014 онд ажилгүй гэж бүртгүүлсэн эрэгтэйчүүдийн тоо нэмэгдсэн шалтгаан нь Хөдөлмөрийн яамны шинэ бүтцэнд өөрчлөлт орж, орон нутгийн түвшинд хөдөлмөр эрхлэлт/ажилгүйдлийн талаарх мэдээлэл түгээх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх бодлогын хүрээнд сумдад хөдөлмөрийн хэлтэс шинээр байгуулагдсантай холбоотой юм.

<sup>77</sup> YCX (2015). Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2014, хуудас 53-55, Улаанбаатар.





**Зураг 5.18 Ажилгүйдлийн түвшин, нийт хүн ам болон хүйсээр, Сэлэнгэ, 2012 - 2014 он<sup>78</sup>**

Ажилгүйдэл нь төслийн бүсийн гол асуудлуудын нэг юм. Иргэд цалин багатай, хар бор ажлаас (гудамж шүүрдэх, цэвэрлэх гэх мэт) татгалзаж, хэн нэгний дор ажиллахаасаа илүүтэйгээр өөрийн бизнесийг эхлүүлж, бие даан ажиллахыг илүүд үздэг болохыг гол талтай хийсэн ярилцлага, зорилтот бүлгийн хэлэлцүүлгийн үеэр дурьдаж байсан. Ялангуяа, эрэгтэйчүүд ийм төрлийн ажлаас татгалзах нь их байдаг тул төслийн бүсэд тэдний ажилгүйдлийн түвшин эмэгтэйчүүдийнхээс их байна. Сэлэнгэ аймгийн боловсролтой залуучуудын дунд ажилгүйдлийн түвшин өндөр байгаа нь гол асуудал болж байна. Төслийн бүсэд мэргэжлээрээ ажиллах боломж хомс байгаа учир ажилгүйдлийн түвшин өндөр байна. Одоогоор олдож байгаа ажил нь түр зуурын болон/эсвэл улирлын чанартай тул иргэд найдвартай, тогтмол орлоготой байж чаддаггүй талаар гол талуудтай хийсэн ярилцлага, зорилтот бүлгийн хэлэлцүүлгийн оролцогчид тэмдэглэж байсан.

"Суманд ойролцоогоор 9,000 орчим хөдөлмөрийн насны хүмүүс байдаг ба тэдний 5,000 орчим тогтмол ажлын байртай байна. Үлдсэн хүмүүсийн хувьд тодорхой бус байдаг. Байнгын ажлын байр бий болгох талаар орон нутгийн иргэд хүсэлтээ байнга илэрхийлдэг. Сумын засаг захиргаа нь бүх улиралд ажиллах боломжтой, хүнсний ногоо, үр тариа хадгалах зоорь, хүлэмж барих тал дээр ногоочид/газар тариаланчдыг дэмжих бодлого явуулж байна "

ГТХЯ, Мандал сумын Засаг даргын орлогч

"Насны байдлаас болоод (маш олон залуучууд байдаг) хүн бүрт хангалттай ажлын байр байхгүй."

ЗБХ, Мандал сумын төвийн иргэд

"Залуучуудад зориулсан ажлын байр ер байдаггүй. Ажилгүй залуучууд их байдаг бөгөөд тэд ажлын боломж хайн өөр тийш нүүж явах явдал их байна."

ГТХЯ, Түнхэл багийн дарга

Сэлэнгэ аймгийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэд буюу ажил идэвхтэй хайж буй иргэдийн боловсролын түвшинг судалж үзэхэд ихэнхи нь бүрэн дунд боловсролтой байна. Өөрөөр хэлбэл, идэвхтэй ажил хайж буй нийт иргэдийн талаас илүү (65%) хувь нь бүрэн дунд боловсролтой байна. Энэ нь аймгийн хэмжээнд харьцангуй боловсролтой ажиллах хүчин байгааг илтгэж байна.

<sup>78</sup> YCX, 2015. Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2014, хуудас 55.



Түүнчлэн, ажлын байрны боломж бий болгох, цаашид техник мэргэжлийн үр чадварын сургалт зохион байгуулах эрэлт хэрэгцээ байгааг харуулж байна.

**Хүснэгт 5.18 Бүртгэлтэй ажилгүйчүүдийн хувийн жин, боловсролын түвшингээр, Сэлэнгэ, 2012-2014 он<sup>79</sup>**

Боловсролын түвшин	2012	2013	2014
Дээд	23.3	17.9	18.3
Тусгай дунд	3.9	4.8	4.9
Бүрэн дунд	62.2	63.5	65.0
Мэргэжлийн	9.6	11.3	11.5
Боловсролгүй	1.0	0.2	0.2
Нийт	100.0	100.0	100.0
Ажилгүй иргэдийн тоо	687	842	823

Судалгаанд оролцсон нийт иргэдийн 44% нь ажлын байр байхгүй байгааа учир идэвхтэй хайдаггүй (ажилгүй байхыг илүүд үзсэн), харин 31% нь тэтгэвэрт гарсан, 11.4% нь бүтэн цагаар суралцдаг тул ажил хайдаггүй гэсэн байна. Судалгаанд оролцогчдыг сумаар авч үзэхэд, Баянгол сумын 55%, харин Мандал сумын 37% нь ажлын байрны хомсдлоос ажилгүйдлийн түвшин өндөр байна гэж хариулсан.

Түнхэл багт хийсэн зорилтот бүлгийн хэлэлцүүлгийн үеэр ажилгүйдэл нь ялангуяа залуу эрчүүдийн дунд хамгийн чухал асуудал болж буй талаар дурьдсан байсан. Залуу эрчүүд ажил хайж нутгаасаа нүүж явдаг нь цаашид сумын иргэдийн гэр бүлийн тогтворгүй байдал, нийгмийн хөдөлгөөний динамикийн өөрчлөлтөнд хүргэж болзошгүй. Уг асуудал нь Түнхэл багт хурцаар тавигдаж байгаа ч залуучуудын гадагшаа чиглэсэн шилжилт хөдөлгөөн (ихэвчлэн Улаанбаатар хот руу чиглэсэн) нь төслийн бүс төдийгүй Монгол Улсын нийтлэг хандлага болсон байна.

#### 6.4.10 Дүгнэлт

Нийгмийн суурь судалгаагаар ажил эрхлэлттэй холбоотой хэд хэдэн гол сэдвүүд тодорхой гарч ирж байна. Төслийн бүсэд шинээр бий болж буй ажлын байр ерөнхийдөө бага байна. 2013 – 2014 онуудын хооронд Мандал сумаас илүүтэйгээр Баянгол суманд шинэ ажлын байр бий болсон байна. Тодруулбал, Баянгол суманд ажлын байр 17.7% (буюу 93 шинэ ажлын байр)–иар өссөн байхад Мандал суманд шинээр бий болж буй ажлын байр 3.3%–иар багассан байна. Төслийн бүсэд ажилгүйдэл чухал асуудал болоод байна. Сэлэнгэ аймгийн боловсролтой залуучуудын гол асуудал нь ажилгүйдэл болсон байна. Залуучуудын ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлтийн боломж хомс байгаа нь Түнхэл багийн орон нутгийн иргэдийн хамгийн том асуудал юм. Төслийн бүсэд ажилгүйдэлийн өндөр түвшин нь мэргэжлээрээ ажиллах боломж хомс байгаатай холбоотой байна. Гол талуудтай хийсэн ярилцлага, зорилтот бүлгийн хэлэлцүүлгийн оролцогчид бэлэн байгаа ажлын ихэнх байр нь түр зуурын болон/буюу улирлын чанартай байдаг учраас хүмүүс тогтмол орлоготой байх боломжгүй байдаг гэж тодорхойлж байсан.

Хөдөлмөр эрхлэлтийн хувьд, Мандал сумын иргэд худалдаа үйлчилгээ, хөдөө аж ахуйн салбарт түлхүү ажиллаж байгаа бол Баянгол сумын бүрэн дунд боловсролтой иргэдийн ихэнх мал маллаж байна. Төслийн бүсийн боловсрол багатай хүн ам амьдардаг Түнхэл багт сарын дундаж цалин хамгийн бага байна. Төслийн бүсийн өрхүүдийн эрсдэлээ удирдах чухал арга зам нь орлого

<sup>79</sup> Сэлэнгэ аймгийн ЗДТГ, 2014. Сэлэнгэ аймгийн нийгэм эдийн засгийн үзүүлэлт, 2014.

төрөлжүүлэх стратеги юм. Ихэнх өрхүүд орлогоо нэмэгдүүлж, гэр бүлээ тэжээхийн тулд олон төрлийн үйл ажиллагааг эрхэлж байгаа нь харагдсан. Малчид уул уурхайн (болон бусад) салбарт ажиллахад шаардлагатай англи хэлний ур чадвар, ажлын туршлага болон бусад ур чадвар дутмаг учраас мал маллахаас өөр ажил хийж чадахгүй гэдгээ мэддэг гэж тайлбарлаж байсан.

## **6.5      НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ**

### **6.5.1      Оршил**

Энэ хэсэгт төслийн нөлөөллийн бүсийн нийгмийн бүтэц, тэр дундаа нийгмийн бүтцийн өөрчлөлт, хандлага, өнөөгийн нөхцөл байдал ба одоо байгаа дэд бүтцийн хүрэлцээ болон нийгмийн дэд бүтцийн хангамж болон хэрэглээний талаар авч үзэв. Энэ хэсгийн агуулга нь Сэлэнгэ аймгийн зорилтот сум, багуудын боловсрол, эрчим хүч, усан хангамж, хаягдал усны менежмент, ариун цэвэр, хатуу хог хаягдлын менежмент, тээврийн дэд бүтэц, харилцаа холбоо ба шуудангийн үйлчилгээний талаар голчлон авч үзэв.

### **6.5.2      Ашигласан тоо мэдээлэл**

Суурь судалгааг 2012 – 2015 онуудын тоо мэдээлэл болон дараах хоёрдогч мэдээллийн эх сурвалжид тулгуурлан боловсруулсан болно. Үүнд: үндэсний хэмжээний статистикийн мэдээ ба аймаг, сумдын Засаг даргын тамгийн газрын статистикийн хэлтэс зэргийн авав. Төслийн бүсэд хийсэн өрхийн түүвэр судалгаа үр дүнг ашиглан судалгаанд оролцсон 400 өрхийн нийгмийн дэд бүтэц тухайлбал дэд бүтэц ба хэрэглээний түвшний статистикийн талаархи анхдагч мэдээллээ цуглуулсныг энэхүү бүлэгт ашиглав. Түүнээс гадна, зорилтот бүлгийн хэлэлцүүлэг (ЗБХ), гол талуудтай хийсэн ярилцлага (ГТХЯ) зэргийг явуулж төслийн нөлөөллийн бүс дэх нийгмийн дэд бүтцийн асуудлуудыг судалсан бөгөөд цуглуулсан чанарын судалгааны мэдээг энэхүү хэсэгт ашигласан.

### **6.5.3      Боловсрол**

Монгол Улсын боловсролын өнөөгийн тогтолцоо нь ЗХУ-ын үед нэвтрүүлж байсан тогтолцоо дээр тулгуурласан байдаг. Коммунизмын үед шашны боловсролоос татгалзаж, иргэний, анхан шатны боловсрол заавал эзэмших болсон нь бичиг үсэг тайлагдалтын түвшинг 98% болгож өсгөсөн ба ардчилсан шилжилтийн үеэс хойш энэ түвшин өндөр хэвээр байна. Олон улсын стандартад нийцсэн боловсролыг бүгдэд хүртээмжтэй болгох Монгол Улсын Засгийн газрын хүчин чармайлтын үр дүнд боловсролын тогтолцоо хувьсан өөрчлөгдсөөр байна.<sup>80</sup> Уг тайлангийн Бүлэг 6.1: Хүн ам зүй-д дурьдснаар Монгол Улсад боловсролын түвшин ерөнхийдөө өндөр байгаа ч боловсролын салбарт цаашдын шаардлагыг хангах боловсролын шинэ барилга байгууламж барих, хуучирсан техник тоног төхөөрөмжийг шинэчлэх, засах зэрэг асуудлууд тулгарч байна. Боловсролын тогтолцоо нь дараах шатлалаас бүрдэнэ:

- Сургуулийн өмнөх боловсрол буюу цэцэрлэг (2 – 6 насныхан);
- Бага боловсрол – 1 – 5-р анги (6 – 11 насныхан);
- Суурь боловсрол – 6 – 9-р анги (12 – 15 насныхан); болон
- Дунд боловсрол – 10 – 12-р анги (16 – 18 насныхан).

Сургуулийн насны буюу 6-аас 16 нас хүртэлх хүүхдүүд ерөнхий боловсролыг заавал эзэмших ёстой ба дараа нь сургууль завсардах эсвэл дунд сургуулийн төгсөх ангийн хоёр жилийн боловсролыг мэргэжил үйлдвэрлэл сургалтын төвд үргэлжлүүлэн сурч төгсөж, мэргэжил эзэмшиж

<sup>80</sup> Монгол ОУБ (2011), [Монгол Улсын боловсролын салбар, олон улсын сайн дурын байгууллагуудын үүрэг](#).

болно. Их, дээд сургуульд элсэн орохын тулд 12-р ангиа заавал төгссөн байх шаардлагатай. Мэргэжлийн үйлдвэрлэл сургалтын төв (МҮСТ)-д 10 – 12-р анги ерөнхий боловсрол, 2 жил техникийн мэргэжил эзэмшиж ба богино хугацааны (2 долоо хоногоос 6 сар хүртэл) мэргэжлийн сургалтанд сууж (16 наснаас) мэргэжил эзэмшиж болно. Дээд боловсролыг (18 наснаас) Монгол Улсын 101 их дээд сургууль, коллежид олгодог ба хувийн их дээд сургуулиудын тоо нэмэгдэж байна.

Аймаг, сум, багийн боловсролын байгууламж, нөөцийг тэдгээрийн нийт хүн амд тооцож улсын төсвийн хөрөнгөөр Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас санхүүжүүлдэг. Монгол Улс малчин өрх бүхий хөдөөгийн өрхүүдэд боловсролын үйлчилгээг хүргэх зорилгоор хичээлийн жилд зарим сумын малчдын хүүхдүүдийг дотуур байраар хангадаг.

Сэлэнгэ аймагт одоогоор нийт 38 цэцэрлэг, 35 дунд сургууль үйл ажиллагаа явуулж байна. Мандал суманд 7 цэцэрлэг, 6 сургууль, 1 МҮСТ байна. Баянгол суманд 2 цэцэрлэг, нэг сургууль байна. Хүн амын тоо өсөн нэмэгдэж байгаа ч бүх шатны боловсролын байгууллагуудын тоо тогтвортой хэвээр байгаа нь эдгээр байгууламжуудын ачаалалыг ихэсгэж байна.

#### 6.5.3.1 Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ

Цэцэрлэгийн барилга байгууламжийн хувьд малчдын хүүхдүүдэд зориулж явуулын гэр цэцэрлэг бүхий бүтээлч ажлыг эхлүүлж байгаа хэдий ч улсын хэмжээнд цэцэрлэгийн байгууламжийн хүртээмж тулгамдсан асуудал хэвээр байна гэж НҮБ-ын Хүүхдийн сан тэмдэглэжээ.<sup>81</sup> Сургуулийн өмнөх боловсролд улсын, хувийн цэцэрлэгүүд, сургуулийн өмнөх боловсролд дүйцсэн хөтөлбөрөөр үйл ажиллагаа явуулдаг хувилбарт сургалтууд зэрэг багтана. Төслийн бүс буюу Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2014 – 2015 оны хичээлийн жилд 244 багштай, 7,394 хүүхэдтэй 38 цэцэрлэг ажиллаж байна. Аймгийн хэмжээнд нийт хүүхдүүдийн ихэнх нь (91%) сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байна.

Мандал суманд 7 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаагаас 6 нь улсын, 1 нь хувийн цэцэрлэг байна. Баянгол суманд 2 цэцэрлэг байгаагаас улсын 1 цэцэрлэг, хувийн 1 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байна. Орон нутгийн хэрэгцээг хангахын тулд цэцэрлэгийн үйлчилгээг нэмж хүргэх хүчин чармайлт гаргаж байгаа ч төслийн бүсийн сумдад сүүлийн хоёр жилд шинэ цэцэрлэг баригдаагүй байна (доорх шигтгээг харна уу).

"Суманд шинэ цэцэрлэгийн барилгын ажлын тендерийг (350 сая төгрөгийн өртөг бүхий) аймагт шалгаруулсан байна. Тендерт оролцогч нь 2 жилийн өмнө ажлаа эхлэсэн боловч төсөв хүрэлцээгүй гэсэн шалтгаанаар цэцэрлэгийн барилгыг одоог хүртэл дуусгаагүй байна. Энэ жил цэцэрлэгийн барилгын ажлыг дуусгахаар нэмэлтээр аймгийн төсөвт суулгасан."

Баянгол сумын ЗДТГ-ын Төрийн сангийн төлөөлөгчтэй хийсэн ярилцлага

"Мандал суманд цэцэрлэгийн хэд хэдэн барилга баригдаж байна. Үүнд: а) Улсын төсвийн хөрөнгөөр барьж байгаа 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга; б) Улсын төсвийн хөрөнгөөр (740,0 сая төгрөг) барьж байгаа 60 хүүхдийн "Нархан" цэцэрлэгийн өргөтгөлийн ажил (барилгын ажил 80% -тай байна); в) Улсын төсвийн хөрөнгөөр (913,7 сая төгрөг) барьж байгаа Хэрх багийн 75 хүүхдийн цэцэрлэг (барилгын ажил 80% -тай); г) Улсын төсвийн хөрөнгөөр (350 сая төгрөг) барьж байгаа Тарни багийн цэцэрлэгийн өргөтгөлийн ажил (барилгын ажил 30% -тай)."

Мандал сумын статистикийн эмхэтгэл

<sup>81</sup> [http://www.unicef.org/mongolia/media\\_11903.html](http://www.unicef.org/mongolia/media_11903.html).

Мандал суманд 1,442 хүүхдүүд (эмэгтэй хүүхэд - 49.6%), Баянгол суманд 416 хүүхдүүд (эмэгтэй хүүхэд - 48.5%) сургуулийн өмнөх боловсролд нийт хамрагдав. Цэцэрлэгт хамрагдаж байгаа малчдын хүүхдийн тоо маш бага бөгөөд нийт хүүхдүүдийн дөнгөж 3.7%-тай байна. Алслагдмал байдал, өвөлдөө хүрч очиход бэрхшээлтэй байдаг зэргээс хамааран зөвхөн зун цэцэрлэгт явдагыг эс тооцвол дийлэнх малчдын хүүхдүүд цэцэрлэгт явж чадахгүй байна. Гэвч улсын цэцэрлэгүүд ихэнхдээ зун ажилладаггүй учир малчдын хүүхдүүд цэцэрлэгт явахад хүндрэлтэй. Иймд хувилбарт сургалтын хөтөлбөр бий болсон (Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд заасны дагуу (2008)) байна. Уг хөтөлбөрт ээлжийн анги, нүүдлийн анги, явуулын багш нар багтдаг. Зуны улиралд малчид, хөдөө орон нутгийн иргэдийн хүүхдүүдэд цэцэрлэгт явах боломж олгох үүднээс цэцэрлэгийн "нүүдлийн анги"-ийг ажиллуулдаг (түр хугацаанд).

"Зун малчдын 86 хүүхэд гэр цэцэрлэгийн хувилбарт боловсролын хөтөлбөрт хамрагдсан."  
Баянгол сумын төрийн өмчит цэцэрлэгийн захиралтай хийсэн ярилцлага

"Түнхэл багийн цэцэрлэг нь зун малчдын 20 хүүхдэд зориулж гэр цэцэрлэгийг ажиллуулдаг."  
Түнхэл багийн төрийн өмчит цэцэрлэгийн захиралтай хийсэн ярилцлага

Баянгол, Мандал сумдад цэцэрлэгийн багш-хүүхдийн харьцаа нь аймгийн дунджаас өндөр байна. Зураг 5.19-т үзүүлснээр сумын дундаж (Баянгол, Мандал) нэг багшид 33.3 хүүхдүүд ногдож байхад аймгийн дундаж 30.3 байна. Баянгол суманд багш-хүүхдийн харьцаа 34.7 байгаа ба энэ нь аймгийн дунджаас 4.4 пунктээр дээгүүр, улсын дунджаас бага зэрэг (1.1%) өндөр байна.



**Зураг 5.19 Төслийн бүсийн цэцэрлэгийн багш-хүүхдийн харьцаа, 2014/2015 он<sup>82</sup>**

Мандал болон Баянгол сумдын цэцэрлэгийн ирц ойролцоогоор 87%-тай ба үлдсэн хүүхдүүдийн 13% нь цэцэрлэгийн хүчин чадлаас хамааран цэцэрлэгт явж чадахгүй байна. Эдгээр хүүхдүүдийг гэр бүлийн гишүүд нь хардаг байна. Баянгол сумын нийгмийн бодлогын ажилтантай хийсэн ганцаарчилсан ярилцлагын үед дараах зүйлийг онцлон тэмдэглэсэн. Үүнд: "Баянгол суманд 0 – 5 насны нийт 733 хүүхэд байгаагаас цэцэрлэгийн насны зөвхөн 336 хүүхэд л улсын цэцэрлэгт явдаг байна. Улсын цэцэрлэг 275 хүүхэд хүлээж авах хүчин чадалтай ч цэцэрлэг нь хүчин чадлаасаа

<sup>82</sup> Сэлэнгэ аймгийн Боловсролын хэлтэс, 2015, Боловсролын үзүүлэлтүүд.

илүү хүүхдийг багтаасан байна. 49 хүүхэд хувийн цэцэрлэгт явж байгаа бол үлдсэн 93 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байна." Багийн цэцэрлэгийн хүртээмжийн судласан бөгөөд зорилтот бүлгийн хэлэлцүүлгийн үеэр (ЗБХ) цэцэрлэг хүчин чадлаасаа илүү хүүхдэд үйлчилж байгаа ч багийн хүүхдүүдийг цэцэрлэгийн үйлчилгээнд хангалттай хамруулж чадахгүй байна гэж дурьдаж байсан. (ЗБХ-т дурьдагдсан хэсгийг үзнэ үү). Энэ нь төслийн ойр орчмын өрхийн хүүхдүүд бага насны хүүхдэд нэн шаардлагатай боловсролыг авч чадахгүй байгаа бөгөөд дараагийн шатны боловсролд хангалттай бэлтгэгдэж чадахгүй байна гэсэн үг юм.

"Цэцэрлэгийн ангиудын багтаамж хэтэрсэн. 2-р багийн дунд зөвхөн 3 цэцэрлэг байдаг. Энэ нь хангалттай биш."

Мандал сумын багийн хэсгийн ахлагч нартай хийсэн бүлгийн ярилцлага

### 6.5.3.2 Бага, бүрэн бус дунд, бүрэн боловсрол

Бага, бүрэн бус дунд, бүрэн дунд боловсрол олгодог сургуулиудын дийлэнх нь улсын сургуулиуд байдаг. 2014 оны байдлаар Сэлэнгэ аймгийн хэмжээнд 35 сургууль нийт 17,502 хүүхэд, 983 үндсэн багштайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр 35 сургуулийн 32 нь улсын сургууль, үлдсэн нь хувийн сургууль юм.

2014-2015 оны хичээлийн жилийн байдлаар 2,139 хүүхэд (Мандал суманд 566 хүүхэд, Баянгол суманд 117 хүүхэд) шинээр 1-р ангид элсэн орсон байна. Нийт 456 сурагчид (Баянгол сумаас 6 хүүхэд) албан бус боловсролд хамрагдаж байна. (Хэсэг 6.5.3.4-т Албан бус боловсрол). Аймгийн хэмжээнд бичиг үсэгт тайлагдаагүй 63 хүн байна (хүүхэд, насанд хүрэгч); албан бус боловсролын хөтөлбөр хангалттай ирцтэй байх шаардлагатай байдаг учир энэ тоо нь 2013 онтой харьцуулахад 17 хүнээр буурсан байж болох юм.

### Хүснэгт 5.19 Элсэн орсон ба төгссөн байдал, 2012-2015 оны хичээлийн жилд <sup>83</sup>

Сургуулийн байршил	1-р ангид элсэгчдийн тоо			Дунд ангиа төгссөн байдал (9-р анги)			Ахлах ангид элсэн орсон байдал (10-р анги)		
	2012 / 2013	2013 / 2014	2014 / 2015	2012	2013	2014	2012	2013	2014
Аймгийн хэмжээнд нийт	1,694	1,849	2,139	2,230	1,834	1,981	1,816	1,515	1,562
Мандал	491	520	566	613	510	498	506	411	39
Баянгол	78	71	117	117	83	105	81	68	78

Наснаас хамааран сургуулийн ирц буурсан байна. Аймгийн хэмжээнд сургуулийн насны 26,378<sup>84</sup> хүүхэд байгаагаас 2014-2015 оны хичээлийн жилд 17,502 хүүхэд бага, дунд, ахлах ангид, 456 хүүхэд албан бус боловсролд хамрагдаж байна. Эдгээр хүүхдүүдийн 48.2% нь бага ангид, 30.6% нь дунд ангид, үлдсэн 21.2% нь ахлах ангид суралцаж байна. 2014-2015 оны хичээлийн жилд аймгийн хэмжээнд сургуульд хамрагдалтын түвшин 99.9%-тай байна. Сургуулиас завсардсан хүүхдийн тоо 2004-2007 онуудад тогтвортойгоор буурч байна.

<sup>83</sup> Боловсролын үзүүлэлтүүд, Сэлэнгэ аймгийн статистикийн эмхэтгэл.

<sup>84</sup> Сэлэнгэ аймгийн 5-аас 19 настай хүүхдүүдийн тоо



**Хүснэгт 5.20 Төслийн бүсийн зарим нэг сургуулийн үзүүлэлт (бага, дунд, ахлах), 2012-2015<sup>85</sup> оны хичээлийн жилд**

	2012/2013	2013/2014	2014/2015
<b>Хамрагдалт</b>			
Сэлэнгэ аймаг	17,817	17,580	17,502
Мандал сум	4,782	4,701	4,697
Баянгол сум	839	834	809
<b>Үндсэн багш нарын тоо</b>			
Сэлэнгэ аймаг	958	964	983
Мандал сум	235	234	243
Баянгол сум	43	43	43
<b>Дотуур байранд амьдардаг сурагчдын тоо</b>			
Сэлэнгэ аймаг	1,230	1,131	1,114
Малчдын хүүхдүүд <sup>86</sup>	-	-	831

Сумдад бүх шатны сургууль байдаг. Мандал сумын төвд 3 сургууль, Хэрх, Түнхэл баг тус бүрт 1 сургууль байдаг. Мандал сумын бага, дунд, ахлах сургуульд 6 – 17 насны 4,776 хүүхэд (98.4%) хамрагдаж байна. Мандал сумын нийт сурагчдын 49.7% нь бага, 29.6% нь дунд, 20.7% нь ахлах ангид сурдаг байна. Баянгол суманд нэг сургууль байдаг ба нийт 809 хүүхэд сурдаг. 6 – 17 насны хүүхдийн 98.4% нь сургуульд хамрагддаг ба нийт сурагчдын 48% нь бага, 32.2% нь дунд, 19.7% нь ахлах ангид суралцаж байна.

Мандал сумын хоёр сургууль дотуур байртай (нэг нь Хэрх багт байдаг бол нөгөө нь Минжинхангай багт байрладаг). 2014 – 2015 оны хичээлийн жилд нийт 122 хүүхэд энэ хоёр дотуур байранд байрласан байна. Энэ хоёр байрын багтаамж аль алинд хэтэрсэн бөгөөд Хэрх багийн ахлах сургуулийн дотуур байр нь малчдын хүүхдийн ердөө 42%-г байрлуулж байгаа бөгөөд Минжинхангай багт мөн адил ойр орчмын сургуулийн хүүхдүүдийг байрлуулснаас багтаамж хэтэрсэн байна (хэвийн багтаамж нь 80 хүүхэд зориулсан). Баянгол сумын сургуулийн дотуур байранд 2014 – 2015 оны хичээлийн жилд нийтдээ 138 хүүхэд байсан байна. Баянгол сумын дотуур байрны барилга нь 130 хүүхэд багтаах чадалтай бөгөөд 2014-2015 оны хичээлийн жилд 138 хүүхэд байрласан байна. Түүнээс гадна дотуур байранд суух шаардлагатай малчны хүүхдүүдийн нийт тоо Баянгол суманд 165 байв. Дээр дурьдсанчлан зорилтот бүлгийн хэлэлцүүлгийн хэсгээс доорхи шигтгээнд үзүүлсэн хэсэгт дотуур байрны байгууламж байхгүй учраас төслийн нөлөөллийн бүсэд тулгарч буй асуудал мөн бөгөөд дотуур байр байгаа газарт хүчин чадал хэтэрснээс хэт дүүргэлттэй байна.

"Түнхэл багт сургуулийн дотуур байр байдаггүй. Тиймээс, хөдөөнүн малчдын хүүхдүүдэд сургуульд сурахад зарим нэг бэрхшээл тулгардаг. Дотуур байр байхгүй улмаас малчдын хүүхдүүд хичээлийн жилийн хугацаанд хамаатан садан, найз нөхдийнхөө гэрт байрлан, сургуульд сурдаг."


Түнхэл багийн ХАМО-ын бүлэгтэй хийсэн зорилтот бүлгийн хэлэлцүүлэг

Хүйсийн харьцааны ялгаа сургуульд, ялангуяа бага шатны боловсролын түвшинд байна. Мандал, Баянгол сумдад эрэгтэй хүүхдүүд бага ангид давамгайлж байна. Гэвч Зураг 6.20-т харуулснаар

<sup>85</sup> Сэлэнгэ аймгийн Боловсролын хэлтэс, 2015, Боловсролын үзүүлэлтүүд


<sup>86</sup> 2012/2013 болон 2013/2014 оны хичээлийн жилүүдийн малчдын хүүхдүүдийн тоон мэдээлэл байхгүй байна.

сумдад ахлах ангид шилжин суралцагчдын дунд хүйсийн харьцаа өөрчлөгдсөн байна. Хөвгүүдээс олон охид ахлах ангид сурч байна. Энэ нь эрэгтэй хүүхдийн сургууль завсардалттай холбоотой байж болох юм (гэр бүлд туслах зорилгоор малчин болох, ерөнхий боловсролын сургуулийн оронд техник мэргэжлийн боловсролын сургалтанд хамрагдах, ажил хийх). Бага болон дунд сургуулийн элсэлтүүдэд хүйсийн ялгаа их байна. 2014-2015 оны хичээлийн жилийн байдлаар дунд ангиас (9-р анги) ахлах ангид (10-р анги) шилжигсдийн хувь буурсан байна. Энэхүү шилжилтийн явцад (10-р ангид суралцагчид) эмэгтэй сурагчдын хувь эрэгтэй сурагчдаас илүү их байна. Жендэрийн энэхүү ялгаатай байдал нь цаашдын боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх боломжинд нөлөө үзүүлэхүйц үзүүлэлт болох юм. Дунд ангид эмэгтэй сурагчид илүү сурч байгаа нь эмэгтэйчүүд цаашид илүү боловсрол (дээд болон мэргэжлийн) олж авах, илүү дээр ажилд орох, мөн орлого олох боломжтой болж болох юм.



**Зураг 5.20 Сургуульд хамрагдалтын хүйсийн харьцаа, 2014-2015 оны хичээлийн жилд, сумдаар**

2014 – 2015 оны хичээлийн жилийн байдлаар, Мандал сум хамгийн их анги дүүргэлттэй буюу нэг ангид 34.3 сурагч байна. Энэ нь аймгийн дундаж үзүүлэлтээс 7.3 пунктээр их байгаа ба нэг ангийн дүүргэлт нь бараг арван сурагчаар илүү байна. Баянгол сумын дундаж анги дүүргэлт нь 29.7 байгаа ба аймгийн дундаж үзүүлэлтээс 9.3 пунктээр бага ч одоогийн анги дүүргэлт нь 7 сурагчаар илүү байна.



**Зураг 5.21 Сургуулийн анги дүүргэлт, 2014-2015 хичээлийн жилд (өдрийн ангийн сурагчид)<sup>87</sup>**

2014 – 2015 оны хичээлийн жилийн эхэнд Сэлэнгэ аймгийн нэг багшид ногдох сурагчдын харьцаа 17.8 байгаа нь өмнөх онтой харьцуулахад бараг 1 сурагчаар буурсан байна. Мандал суманд энэ харьцаа нь 19.3-тай байгаа нь аймгийн дундаж үзүүлэлттэй харьцуулахад 1.5 пунктээр өндөр, Баянгол сумтай харьцуулахад бага зэрэг өндөр байна. Хөдөөгийн алслагдсан багийн сургуулиуд суурин газрын сургуультай харьцуулахад нэг багшид ногдох сурагчдын тоогоор цөөн байна. Эдгээр тоон мэдээллийн дагуу бага ангиудад энэхүү тоо нь өндөр байна. Бага боловсрол эзэмшигчдын хувь (Мандал суманд нэг багшид ногдох сурагчдын тоо 28.1, Баянгол суманд нэг багшид ногдох сурагчдын тоо 33.3 байна) хамгийн өндөр хувитай байна. Энэ нь дээр дурьдсан тоон үзүүлэлттэй нийцэж байгаа бөгөөд Бага боловсрол эзэмшигчдын хувь дунд боловсрол эзэмшигчдын хувиас их байгааг харуулж байна. Баянгол сумын төвийн иргэд боловсролын байгууллагуудын талаар хийсэн зорилтот бүлгийн хэлэлцүүлгийн үеэр "сумын сургуульд бага ангийн багш дутагдалтай байна" гэж дурьдсан нь статистик мэдээллийг батласан.

**Хүснэгт 5.21 Ерөнхий боловсролын сургуулиудын багш-сурагчийн харьцаа, хичээлийн жилээр<sup>88</sup>**

	Нэг багшид оногдох сурагчдын тоо		
	2012-2013	2013-2014	2014-2015
<b>Улсын дундаж</b>	<b>18.5</b>	<b>18.3</b>	<b>18.4</b>
<b>Төвийн бүсийн дундаж</b>	<b>17.7</b>	<b>17.9</b>	<b>17.4</b>
Сэлэнгэ аймаг	18.6	18.2	17.8
Мандал сум	20.3	20	19.3
- Түнхэл баг <sup>89</sup>	-	-	18.9
- Хэрх баг <sup>90</sup>	-	-	16.5
Баянгол сум	19.5	19.3	18.8

<sup>87</sup> Сэлэнгэ аймгийн Боловсролын хэлтэс, 2015, Боловсролын үзүүлэлтүүд

<sup>88</sup> Сэлэнгэ аймгийн статистик эмхэтгэл, Боловсролын үзүүлэлтүүд

<sup>89</sup> 2012/2013 болон 2013/2014 онуудын хичээлийн жилийн мэдээлэл байхгүй байна.

<sup>90</sup> 2012/2013 болон 2013/2014 онуудын хичээлийн жилийн мэдээлэл байхгүй байна.

"Жил бүр ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн 40 орчим хувь нь их дээд сургуульд ордог. Үлдсэн төгсөгчид сумын мэргэжил боловсролын сургалтын коллежид сурдаг байна."

Мандал сумын Нийгмийн бодлогын мэргэжилтэн/нийгмийн ажилтан

#### 6.5.3.3 Техник мэргэжлийн болон дээд боловсрол

Төслийн бүсэд техник мэргэжлийн боловсролын сургалтын хүртээмж хязгаарлагдмал ба үйл ажиллагаа явуулж буй сургалтын төв нь ихэвчлэн эрэгтэй оюутнуудад сургалт явуулдаг. Аймгийн хэмжээнд Мандал суманд нэг техник мэргэжлийн сургалтын төв байна. 2014 – 2015 оны хичээлийн жилд уг техник мэргэжлийн сургалтын төвд 395 оюутан сурсан байна (**Error! Reference source not found.**-ийг үзнэ үү). Нийт сурагчдын (24.2%) 135 оюутан нь эмэгтэй оюутнууд байна. Элсэгчдийн тоо өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад 9.5%-иар нэмэгдсэн байна<sup>91</sup> Энэхүү техник мэргэжлийн сургууль нь барилгын салбарын мэргэжлүүдэд илүүтэй анхаарал хандуулсан бөгөөд эдгээр нь илүү эрэгтэй хүний мэргэжлүүд юм. Эмэгтэй оюутнуудын ихэнх нь тогооч, оёдолчин, үсчин, барилгын засал чимэглэгч, фермерийн аж ахуй эрхлэгчээр суралцдаг бол эрэгтэй оюутнууд голдуу ерөнхий механикч, хүнд ачааны машины механикч, өрлөгчин, гагнуурчин, сантехникч зэрэг мэргэжлээр суралцаж байна.

#### **Хүснэгт 5.22 Мандал сумын мэргэжлийн боловсролын сургалтын төвийн оюутнуудын тоо, мэргэжлээр, 2015<sup>92</sup>**

№	Мэргэжил	Нийт оюутнууд	Эмэгтэй	Эмэгтэй (%)
1	Тогооч	61	49	80.3
2	Оёдолчин	32	32	100.0
3	Барилгын засал чимэглэгч	54	28	51.9
4	Өрлөгчин	6	1	16.7
5	Механикч	63	0	-
6	Хүнд даацын машины механикч	44	0	-
7	Гагнуурчин	59	0	-
8	Сантехникч	17	0	-
9	Тариаланч	15	4	26.7
10	ХАА-н фермер	20	6	30.0
11	Ойжуулагч	8	6	75.0
12	Үсчин	11	9	81.8
13	Машинист, тракторын жолооч	5	0	-
<b>Нийт</b>		<b>395</b>	<b>135</b>	<b>34.2</b>

#### 6.5.3.4 Албан бус боловсрол

Боловсролын тухай хуулийн 17.2-р зүйлийн дагуу Монгол Улсын Засгийн газрын тогтоол № 116 (1997)-оор "Албан бус боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг баталсан. Албан бус боловсролын тогтолцоо нь албан ёсны тогтолцоог дэмжиж дараах албан бус сургалт болон амьдрах ур чадварын боловсролын хөтөлбөрөөс бүрддэг. Үүнд:

- Бичиг үсэг тайлагдалтын анхан, дунд, гүнзгий шатны сургалт;

<sup>91</sup> Сургуульд хамрагдалтын талаарх мэдээлэл байхгүй байна.

<sup>92</sup> Мэргэжлийн боловсролын сургалтын төв, 2014-2015, Мандал сумын статистик эмхэтгэл, 2015.

- Сургуулиас завсардсан хүүхэд залууст зориулсан хувилбарт боловсрол (бага, дунд, ахлах ангийн боловсрол) нь ерөнхий боловсролын гэрчилгээ авах зорилготой үдээс хойш/оройн анги, богино хугацааны сургалтын ангиудиад бүрдэнэ;
- Амьдрах ур чадвар олгох сургалт (амьдрах ухаан, эрүүл мэнд болон бусад).

Сэлэнгэ аймагт ерөнхий боловсролын сургуулийг түшиглэсэн албан бус боловсролын 15 төв нь голчлон зохион байгуулдаг. Боловсролын томоохон хөтөлбөрүүд нь бичиг үсэгт тайлагдах болон боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтуудад төвлөрдөг байна. Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2014 – 2015 оны хичээлийн жилд 63 хүн бичиг үсгийн хөтөлбөрт оролцож, 456 нь дүйцсэн хөтөлбөрт хамрагдсан байна. Энэ хичээлийн жилд дүйцсэн хөтөлбөрт шинээр 81 хүүхэд элсэн орсны 42% буюу 34 хүүхэд нь огт сургуульд сурч байгаагүй, үлдсэн 58% нь сургууль завсардсан хүүхдүүд байлаа. Албан ёсоор сургуульд сурч байгаагүй, эсвэл сургуулиас завсардаж байгаагийн гол хүчин зүйлс нь амьжиргааны түвшин доогуур, олон хүүхэдтэй (ядуурал) нь улмаас хүүхдүүд ажил хийх; аймаг, сумын сургуулиас хол зайд амьдрах, дотуур байр хомсдолтой байх; өнчин, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, асаргаа муутай (архичин гэр бүл, бичил уурхайчид)<sup>93</sup> хүүхдүүд юм. Түүнээс гадна, өрхийн судалгаагаар гэр бүлдээ туслах зорилгоор малчин болдог нь хөвгүүдийн сургуулиас завсарддаг гол шалтгаан гэж гарсан байна. Охидын сургуулиас завсарддаг, сургуульд сурдаггүйн гол шалтгаан нь өвчин юм.

#### **Хүснэгт 5.23 Боловсролын дүйцсэн хөтөлбөрт хамрагдсан суралцагчдын тоо, 2014/2015<sup>94</sup>**

	Бага ангид	Дунд ангид	Ахлах ангид
<b>Аймаг</b>	<b>106</b>	214	136
Мандал	15	29	38
Баянгол	1	20	-

### **6.5.4 Эрчим хүч, дулаан**

#### **6.5.4.1 Эрчим хүчний хангамж**

Эрчим хүч нь улсын эдийн засаг, улс орны тогтвортой хөгжил, олон нийтийн амьдралын чанарт шууд нөлөөлдөг дэд бүтцийн чухал ач холбогдолтой салбар юм. Монгол Улсад төр одоог хүртэл эрчим хүчний бүх үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийг удирдаж байна. Сүүлийн жилүүдийн эдийн засгийн огцом өсөлтийн улмаас эрчим хүчний эрэлт хэрэгцээ нь нийлүүлэлтийг давж, одоогоор Монгол Улс өөрийн газар зүйн болон цаг уурын хүндрэлтэй холбоотойгоор асар их хөрөнгө оруулалт шаардлагатай эрчим хүчний барилга байгууламжийг барих асуудалтай тулгараад байна.

Сэлэнгэ аймгийн ихэнхи дэд бүтэц нь социализмын үед харьцангуй хөгжсөн байсан учир цахилгаан эрчим хүчний хангамж ерөнхийдөө сайтай гэж тооцогдож ирсэн билээ. Сэлэнгэ аймгийн 17 сумын төв цахилгаан эрчим хүчинд холбогдсон боловч энэхүү төвлөрсөн эх үүсвэрийг бүгд хүртэж чадахгүй байна. Сэлэнгэ аймгийн нийт өрхийн 24.5% нь уламжлалт сууц, гэрт, 74.6% нь орон сууцанд, 0.9% нь бусад төрлийн байшинд амьдарч байна.<sup>95</sup> Аймгийн хэмжээнд 684 өрх нь цахилгаан эрчим хүчгүй байгаа нь өмнөх тооллогын үетэй харьцуулахад 2.8 пунктээр буурсан

<sup>93</sup> <http://www.mongoleducation.mn/modules.php?ss=4&id=192> Сэлэнгэ аймагт судалгаа хийгдээгүй байна.

<sup>94</sup> Сэлэнгэ аймгийн нийгэм, эдийн засгийн статистикийн эмхэтгэл, 2014.

<sup>95</sup> Аймаг, сум, багийн түвшинд эрүүл ажлын байр, сургууль бий болгох аймгийн хөтөлбөрийн баримт

үзүүлэлттэй байна. Тухайлбал гэрэл цахилгаангүй өрхийн 81.4% нь гэрт амьдардаг буюу алслагдмал/хөдөө оршин суудаг байна.

Дархан – Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ (ДСЦТС) ХК нь Сэлэнгэ аймгийн бүх суманд үйл ажиллагаа явуулдаг ба аймаг/сумын төвийн бүх аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн хэрэглэгчдийг эрчим хүчээр хангадаг. ДСЦТС ХК нь 74,000 км<sup>2</sup> нутгийг хамарсан 3,466 аж ахуйн нэгж, байгууллага болон 40,810 айл өрхөд цахилгаан эрчим хүч түгээдэг. 2001 оноос хойш төвийн бүсэд борлуулсан эрчим хүчний үнэ нь 1.5 дахин, орон сууцны халаалтын тариф 1.65 дахин, өрхийн халаалтын тариф 2.5 – 3.75 дахин өссөн байна.<sup>96</sup>

Мандал сумын эрчим хүчний гол эх үүсвэр нь Зүүнхараагийн дэд станц юм. Энэхүү дэд станц нь төвийн эрчим хүчний системийн 110 квт-ын шугамаас ДСЦТС-ээр дамжуулан авч 110, 35, 6 квт болгон түгээдэг байна. 2009 – 2012 оны хооронд Мандал сумын Түнхэл багт эрчим хүчний дэд станц баригдсан.

Гол талуудтай хийсэн ярилцлагуудын үеэр аймгийн эрчим хүчний дэд бүтцийн хүртээмж, хамрах хүрээний талаарх ойлголт нь сум, багийн бодит байдалтай нийцэхгүй байгаа нь харагдсан. Аймгийн эрх баригчид аймгийн хэмжээнд эрчим хүчний дэд бүтэц нь ерөнхийдөө сайн гэж байсан бол сумын хэмжээнд эрчим хүчний хангамж нь хүрэлцээ муутай, нийлүүлэлт нь монополь тогтсон, үнэтэй байна гэж байсан.

*Сэлэнгэ аймгийн дэд бүтэц бусад аймгуудтай харьцуулахад сайн, дэд бүтцийн ихэнхи асуудлыг социализмын үед шийдвэрлэсэн байна. Ерөө болон Хүдэр сумдын дэд бүтэц сайн хөгжөөгүй ч ихэнхи сумдууд автозамтай, цахилгаан эрчим хүчний сүлжээнд холбогдсон байгаа."*

Сэлэнгэ аймгийн Хөгжлийн бодлогын хэлтсийн даргатай хийсэн ярилцлага


*"Мандал сум эрчим хүчний нэг эх үүсвэртэй, тэр нь монополь тогтсон. Дархан/Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээнээс хамааралтай байдаг ч үйлчилгээ нь төдийлөн сайн биш. Сумын төвийн зарим газрууд одоог хүртэл эрчим хүчээр хангагдаагүй байгаа. Жишээ нь: 3, 7-р багийн зарим иргэд цахилгаангүй байна."*

Мандал сумын Засаг даргын орлогчтой хийсэн ярилцлага

Дээр дурьдсан дээр нэмж хэлэхэд, хөдөөгийн малчин өрхүүд төвлөрсөн эрчим хүчнээс цахилгаан авах нь багсаж, харин нарны буюу салхины эрчим хүчний төвлөрсөн бус, жижиг эх үүсвэрийг ихээр хэрэглэх хандлагатай байна. Гэхдээ Зураг 5.22–т үзүүлснээр малчид төвлөрсөн хангамжийн системд холбогдох нь аажмаар нэмэгдэж байна. Аймгийн статистикийн мэдээгээр, төвлөрсөн цахилгаан эрчим хүчний сүлжээнд малчин өрх хамгийн бага холбогдсон байна. Зураг 5.22–т үзүүлснээр Мандал сумын малчин өрхийн дөнгөж 16.3% (2,310 малчин өрхийн 376) нь төвлөрсөн цахилгаан эрчим хүчинд холбогдсон байна. Харин эсрэгээрээ, Баянгол сумын малчин өрхийн (586 малчин өрхийн 397)-ийн 67.7% нь төвлөрсөн эрчим хүчний эх үүсвэрт холбогдсон нь малчид хагас суурин амьдралын хэв маягаар амьдрах нь ихэссэн, буюу эрчим хүчний төвлөрсөн эх үүсвэрт холбогдох нь ихэсэн/төвлөрсөн эх үүсвэр нь ойрхон болж байгаа зэрэгтэй холбоотой байж магадгүй.

<sup>96</sup> Эрчим хүчний Засаглалын үнэлгээ, 2012.






**Зураг 5.22 Төвлөрсөн эрчим хүчний эх үүсвэрээс цахилгаан авч буй малчин<sup>97</sup> өрхийн тоо**

Зураг 5.23-т алслагдсан хөдөө орон нутагт болон сумын төвд амьдарч байгаа өрхийн эрчим хүчний эх үүсвэрийн өрхийн судалгааны үр дүнг танилцуулж байна. Өрхийн судалгаанд оролцогчдын дийлэнх нь (Мандал сумын судалгаанд хамрагдсан өрхийн 57.5% нь, Баянгол сумын судалгаанд хамрагдсан өрхийн 55.1% нь) төвийн эрчим хүчний системээс цахилгаан хэрэглэж байгаа бол Баянгол сумын судалгаанд оролцогчдын 21.5% нь, Мандал сумын судалгаанд оролцогчдын 39.9% нь сэргээгдэх эрчим хүч ашигладаг байна. Нарны эрчим хүчний систем нь судалгаанд хамрагдсан газруудад тархсан ба ялангуяа малчид болон Баянгол сумын иргэд хэрэглэдэг байна. Бусад багуудтай харьцуулахад Түнхэл баг нь дизелийн эрчим хүчний эх үүсвэрээс хамааралтай байна. Мандал сумын судалгаанд хамрагдсан өрхийн 19.5% нь төвлөрсөн бус дизель цахилгаан станцийн эрчим хүч хэрэглэдэг гэж хариулсан байна. Зарим сум, багийн төвүүд нь дизель цахилгаан станцаар ашиглан эрчим хүчээр хангадаг ч энэ нь жилийн турш ажилладаггүй (зөвхөн өвлийн сарууд болох 10-р сараас 4-р сарын хооронд) байна. Эдгээр нь дизель цахилгаан станц хэвийн ажиллаж байгаа үедээ өдөрт 4 – 5 цаг цахилгаан эрчим хүч нийлүүлдэг байна. Дизель цахилгаан станц нь техник, эдийн засгийн хувьд үр ашиггүй ба үйл ажиллагааны зардал өндөртэй байдаг байна.

<sup>97</sup> Энэ нь өөрсдийгөө малчин гэж үздэг бүхий л өрхүүдэд хамаатай (алслагдмал, хагас суурин газруудад оршин суудаг).



**Зураг 5.23 Өрхийн хэрэглэдэг цахилгааны эх үүсвэрийн төрөл, сум, багаар, хувиар**

#### 6.5.4.2 Дулаан хангамж

Дулаан хангамж нь Монгол Улсын үндсэн чухал үйлчилгээний нэг боловч энэ нь хүн бүрт ялангуяа Мандал, Баянгол сумдын иргэдэд хүртээмжтэй биш байна. Сумдын одоогийн халаалтын систем нь голдуу (i) жижиг зуух; ба (ii) сургууль, дотуур байр, эмнэлэг, орон нутгийн засаг захиргааны барилга, зарим орон сууцыг халаахад ашигладаг төвлөрсөн болон төвлөрсөн бус нүүрсэн галлагаат зуух зэргээс бүрдэнэ.

Өрхийн халаалтын ихэнх хэсэг нь төвлөрсөн сүлжээнээс хараат бус байна. Баянгол (98.5%), Мандал (88.8%) сумын ихэнхи өрхүүд халаалтаа уламжлалт аргаар мод/нүүрс/аргалыг ашиглан хийдэг. Баянгол сумын судалгаанд оролцогчдын зөвхөн 0.7% нь, Мандал сумын судалгаанд оролцогчдын 2.7% нь төвлөрсөн халаалтын системд холбогдсон байна. Төвлөрсөн халаалтын систем өртөг өндөртэй, төвлөрсөн халаалтгүй орон сууцанд амьдардаг өрхийн тоо их байгаатай холбоотойгоор нүүрс/мод/аргалын хэрэглээ өндөр байна. Ихэнх өрхүүд хоол хийхдээ мод, нүүрс хэрэглэдэг гэж хариулсан байна. Харин судалгаанд хамрагдсан Баянгол сумын өрхийн 68.6% нь аргал хэрэглэдэг гэж мэдээлсэн нь сонирхолтой байлаа. Аргал нь түлээ, нүүрстэй харьцуулахад илч багатай ба түүнийг ядуу, нийгмийн байр суурь доогуур өрхүүд хэрэглэж байна. Энэ нь Баянгол суманд мод, нүүрс худалдаж авахад өрхийн орлого хангалтгүй, эсхүл аргал хэрэглэх нь иргэдийн дунд илүү түгээмэл зэрэгтэй холбоотой байх гэж үзэж байна.

#### 6.5.5 Усан хангамж

Монгол Улсын хэмжээнд цэнгэг усны нөөцийн эзлэх хувь маш бага (ойролцоогоор 1.5%) ч зарим бүсэд газрын доорх болон гадаргын усны эх үүсвэрийн хэт ашиглалт, чанарын шаардлага хангаагүй усны хангамж, цэвэрлэх байгууламж зэрэг нь Монгол Улсад тулгамдаад байгаа гол асуудлууд юм. Эдгээр нь усны нөөцийн менежментийн хангалтгүй бодлого, тогтолцоогоос гадна хурдацтай өсөж буй хотжилт, уур амьсгалын өөрчлөлт, өсөн нэмэгдэж буй уул уурхайн үйл ажиллагаа зэргээс шалтгаалж байна. Монгол Улсад тулгарч буй гол асуудал нь хөдөө орон нутагт

ус болон цэвэрлэх байгууламжийн үр дүнтэй үйлчилгээг хүргэх явдал юм. Монгол Улсын хөдөөгийн хүн амын ойролцоогоор гуравны хоёр нь ус болон цэвэрлэх байгууламжийн үйлчилгээг хүртэж чаддаггүй байна. Түүнчлэн, аймгийн төвүүдийн бохир ус цэвэрлэх байгууламжийн ихэнх нь хүчин чадлаараа ажилладаггүй. Үүний зэрэгцээ, Монгол Улсын цаг уурын эрс тэс нөхцөлд ажиллаж чадах тоног төхөөрөмжийн техникийн өндөр стандарт барилгын ажлын богино улирал, олон улсын зах зээлээс хол байгаа байдал зэрэг нь олон улсын стандартыг хангасан дэд бүтцийн барилга угсралт, засвар үйлчилгээний ажил маш үнэтэй болгож байна. Жишээлбэл, өвлийн улиралд усны шугам хоолойн сүлжээний өргөтгөлийг хихэд төвөгтэй байдаг учир нь усны шугам хоолойг хүйтэн улиралд тохирсон тусгай нөхцлийн (гүн, тусгаарлагч) дагуу тавих хэрэгтэй.<sup>98</sup>

#### 6.5.5.1 Аймаг, сумдын усан хангамж

Монгол Улс усны нөөцөө тогтмол хянадаг. 2012 оны усны нөөцийн тооллого (Хүснэгт 5.24)–оор Сэлэнгэ аймагт 4,582 усны нөөц бүртгэгдсэн ба үүний 3,188 (69.5%) нь инженерийн хийцтэй гүний худаг, 376 (8.2%) нь өрөмдлөгийн худаг байна. Баянгол сумын усны хангамжийг гүний болон өрөмдлөгийн худгууд хангадаг бол Мандал суманд байгалийн голын усны нөөц давамгайлж байна. Баянгол суманд 147 усны нөөц бүртгэгдсний 56 өрөмдлөгийн худаг, 53 инженерийн хийцтэй гүний худаг байна. Харин Мандал суманд 182 усны нөөц бүртгэгдсэнээр 23 нь өрөмдлөгийн худаг, 15 нь булаг, 127 нь гол, горхи байна. Аймгийн статистикийн мэдээгээр, аймгийн хэмжээнд 32 булаг ширгэсэн байна. Эдгээр булаг ширгэсэн нь хүний (мод бэлтгэх, усны хэрэглээ) болон байгаль орчны (ган) хүчин зүйлээс хамаарч байна. Түнхэл багт 16 жижиг гол, горхи Түнхэл гол руу цутгаж, эргээд Хараа голд нийлдэг байна. Мандал, Баянгол сумдын гол усны эх үүсвэрийг дараах газрын зургаар харуулж байна.


#### **Хүснэгт 5.24 Усны эх үүсвэрийн тооллогын дүн, 2014<sup>99</sup>**

Сум	Өрөмдлөгийн худаг	Инженерийн хийцтэй худаг	Булаг	Нуур	Гол горхи	Цэвэрлэх байгууламж	Рашаан	Цооног	Богино яндант худаг	Услалтын систем	Бүгд
Баянгол	56	53	12	-	10	2	1	-*	11	2	147
Мандал	23	-*	15	1	127	2	3	6	-*	5	182
<b>Аймгийн дүн</b>	<b>376</b>	<b>3,188</b>	<b>198</b>	<b>40</b>	<b>589</b>	<b>8</b>	<b>18</b>	<b>6</b>	<b>127</b>	<b>32</b>	<b>4,582</b>


\*- Мэдээлэл байхгүй.

<sup>98</sup> НҮБХХ <http://www.mn.undp.org/content/mongolia/>.

<sup>99</sup> Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ЗДТГ, Байгаль орчин, аялал жуучлалын хэлтэс.



**Зураг 5.24 Баянгол сумын усны эх үүсвэр**



**Зураг 5.25 Мандал сумын усны эх үүсвэр**

#### 6.5.5.2 Өрхийн ундны усны эх үүсвэр ба хэрэглээ

Төслийн бүсийн ундны усны гол эх үүсвэр нь хамгаалалтгүй болон хамгаалагдсан (бохирдлоос) худаг, гол горхи, булаг, зөөврийн ус түгээх цэг зэрэг байна. Хэрэглэгч хоорондын өрхийн ундны усны хангамж нь ерөнхийдөө төстэй ба ихэнх өрхүүдийн усны гол эх үүсвэр болсон хамгаалагдсан худгыг ашигладаг байна. Хамгаалагдсан худаг Мандал сумаас (46%) илүүтэй Баянгол (66%) сумын төвд их түгээмэл байдаг байна. Мөн Мандал сумтай (16%) харьцуулахад Баянгол (23%) сумын усны гол эх үүсвэр нь хамгаалалтгүй худаг (хамгаалагдсан худгыг бодвол илүү бохирдох эрсдэлтэй) юм байна. Түнхэл, Хэрх багууд бүхий Мандал сумын иргэд Баянгол сумын иргэдээс илүүтэйгээр байгалийн голын ус ашигладаг байна. Ус хангамжийн төрлийн хувьд малчин болон суурин өрхүүдийн хооронд ямар ч ялгаа байхгүй. Цас/мөс хайлуулан ус гаргаж авдаг, хөршийн худгаас ус авдаг өрх байхгүй байна. Төслийн бүсэд төвлөрсөн системээс ундны ус авдаг өрх цөөн байдаг нь Монгол Улсын гол бэрхшээл болж байгаа төвлөрсөн усны дэд бүтэц хангалтгүй байгааг тодотгож байна.

#### **Хүснэгт 5.25 Ундны усны гол эх үүсвэр, судалгаанд хамрагдсан сум, баг (%)**

		<b>Сум</b>		<b>Баг</b>			<b>Өрх</b>	
		Баянгол	Мандал	Түнхэл	Хэрх	Бусад	Малчин	Суурин
Төвлөрсөн	Халуун, хүйтэн ус	0.0	0.8	0.8	0.8	0.0	0.8	0.4
	Зөвхөн хүйтэн ус	0.0	0.8	0.8	0.8	0.0	0.8	0.3
Худаг	Хамгаалагдсан	65.9	46.4	48.8	42.9	64.9	53.8	52.8
	Хамгаалалтгүй	23.2	15.7	10.9	16.8	25.8	15.4	19.7
Зөөврийн ус түгээх цэг		5.1	13.3	14.0	13.4	5.3	10.7	10.4
Булаг, гол горхи		5.8	23.0	24.7	25.3	4.0	18.5	16.4
Цас, мөс		0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0

#### **6.5.6 Бохир ус, цэвэрлэх байгууламж болон хатуу хог хаягдлын менежмент**

Төслийн бүсийн бохир ус, цэвэрлэх байгууламжийн үйлчилгээнд дараах багтана:

- Сумын төвийн орон сууцны хорооллын бохир усны төвлөрсөн систем;
- Сум, багийн гэр хорооллын хатуу хог хаягдлын нэгдсэн цэг;
- Сум, багийн халуун усны газар;
- Хөдөөний малчид болон гэр хорооллын өрхүүдийн задгай жорлон зэрэг орно.

Төслийн бүсийн судалгаанд хамрагдсан ихэнх өрхүүд өөрсдийн барьсан задгай жорлонтой байдаг. Гэр сууцанд амьдардаг өрхүүд гаднаа бие засах газартай. Өрхийн судалгаагаар Баянгол сумын судалгаанд хамрагдсан өрхийн 96.6% нь, Мандал сумын судалгаанд хамрагдсан өрхийн 92.7% нь гаднаа бие засах газартай гэж хариулсан байна. Баянгол сумын үлдсэн 3.7% нь, Мандал сумын үлдсэн 3.5% нь бие засах тогтсон газаргүй байна. Эдгээрийн дийлэнх нь хөдөөгийн буюу гэр хорооллын өрхүүд байна.

Хатуу хог хаягдлыг цуглуулж зайлуулах, гудамж талбайн гэрэлтүүлгийг арчилж ажиллуулах, мод тарих/ ногоон байгууламжийг сайжруулах замаар отын орчинг сайжруулах зэрэг хог хаягдалын менежментийн үйлчилгээг төрийн болон хувийн байгууллагууд хариуцан хийдэг байна. Сэлэнгэ



аймгийн хэмжээнд төв суурин газруудад нийт 3 тохижилт үйлчилгээний газар байдаг ба аймгийн төвд хог хаягдал тээвэрлэх зориулалттай 5 машин ажиллаж байна. Үүнд: Сүхбаатар сумын тохижилт үйлчилгээний газар, Мандал сумын "Мандал сүлжээ" ХХК, Сайхан сумын тохижилт үйлчилгээний газар байна. Тохижилт үйлчилгээний газрууд нь хогийг хог булах цэгт хүргэж өгдөг. Эдгээр газруудын ажлын зохион байгуулалт ерөнхийдөө муу байна.

Мандал суманд хатуу хог хаягдлын 4 төв цэг байдаг ба тэдгээрийн нэг нь сумын төвд (21 га газар талбайтай) байдаг. Нийт 9 хатуу хог хаягдал тээвэрлэдэг машинтай бөгөөд 7 нь хот тохижилтын албанд, 1 машин нь Түнхэл багт, 1 нь Хэрх багт байдаг байна. Эдгээр 9 тээврийн хэрэгслийн зургааг нь 2014 онд хог хаягдлын системийг сайжруулах оролдлого хийсний илрэл болгож шинээр худалдан авсан байна. Мандал сумын статистикийн мэдээллээс харахад 2014 онд 30,751 тонн хог хаягдлыг нийт 756 аж ахуйн нэгж, 3,975 айл өрхөөс цуглуулсан бөгөөд төвлөрсөн хогын цэгт тээвэрлэсэн. 2014 онд 11 га талбайн хог хаягдлын ажил (хог хаягдлыг шатаах) зохион байгуулсан. Нийт хатуу хог хаягдлыг 73.6% нь гэр ахуйн хог хаягдал, 26.4% нь үйлдвэрийн хог хаягдал юм. 262.4 га хэмжээтэй зориулалтын бүс газраас 970 тонн хог хаягдал цуглуулсан (хог хаягдал цуглуулах албан ёсны цэг биш байна) байна.

Өрхийн судалгаагаар судалгаанд оролцсон нийт өрхийн талаас илүү хувь нь (ялангуяа, гэрт амьдардаг өрхүүд) хог хаягдлаа орон нутгийн захиргаанаас зааж өгсөн хог хаягдалын зориулалтын цэгт хаядаг байна. Орон нутгийн иргэд хатуу хог хаягдлыг хог хаягдлын зориулалтын цэгээс гадуур булах/шатаах хандлагатай байдаг.

### 6.5.7 Харилцаа холбоо, шуудангийн үйлчилгээ

Сэлэнгэ аймгийн бүх сумд үүрэн холбооны сүлжээтэй, шилэн кабелиар интернэтэд холбогдсон ба олон сувгийн кабелийн телевизтэй байна. Төслийн бүсэд Үндэсний оператор, Мобиком, Скайтел, Юнител, Жи-Мобайл зэрэг 5 үүрэн телефоны операторууд үйл ажиллагаа явуулдаг. Гар утасны үйлчилгээний хүртээмж нь хөдөө орон нутагт үүрэн телефоны операторуудын сүлжээний хамрах хүрээ, хүчин чадал, орон нутгийн хүрээлэн буй орчин, газар зүйн байрлал, иргэдийн хэрэгцээ, шаардлага, худалдан авах чадвар зэрэг олон хүчин зүйлээс хамаарч байна.


Улс орны техник, технологийн хөгжлөөс шалтгаалан цахилгаан мэдээ, шуудан, баримт бичиг хүргэх үйлчилгээний эрэлт хэрэгцээ бага байгаа хэдий ч буухиа шуудангийн эрэлт хэрэгцээ одоог хүртэл байсаар байна. Харилцаа холбооны технологийн салбарын хүртээмж жил бүр өсөн нэмэгдэж байна. Хүснэгт 5.26 үзүүлснээр үүрэн холбооны утас, компьютер, интернэт-ийн өдөр тутмын хэрэглээ өсч, иргэд шаардлагатай мэдээллийг шууд хүртэж байна.

**Хүснэгт 5.26 Харилцаа холбоо, шуудангийн үйлчилгээ, Сэлэнгэ аймаг, жилээр**

	2012	2013	2014
Шуудангийн салбаруудын тоо	8	5	7
Телефон утасны хэрэглэгчдийн тоо (бүгд)	1,674	1,491	1,505
Үүнд			
Байгууллага	335	313	302
Аж ахуйн нэгж	211	189	208
Айл өрх	1,128	989	995
Телефон ярианы хэмжээ (сая минут)	221,1637	126,7947	665,095
Цахилгаан мэдээ	335	318	350
Интернетиин сүлжээнд холбогдсон сумын тоо	2	4	5
Интернетиин үйлчилгээний газрын тоо	2	4	5
Интернет хэрэглэгчдийн тоо	338	440	609




Түүнээс гадна, Зураг 5.26-аас харахад гар утасны хэрэглэгчдийн тоо телефон утасны хэрэглэгчдийн тоотой харьцуулахад маш өндөр байна. Үүнээс гадна, судалгаанд оролцогчид шаардлагатай тохиолдолд интернет ашигладаг гэдгийг Зураг 5.26-д харуулж байна. Мандал суманд арай цөөн хүн интернэт ашигладаг нь зарим багийн (өөрөөр хэлбэл Түнхэл) алслагдсан байршилтай холбоотой байх магадлалтай юм.



**Зураг 5.26 Харилцаа холбоо, шуудангийн үйлчилгээний хүртээмж, 2015, сумаар, хувиар**

Төслийн бүс болох Мандал, Баянгол сумдын ихэнх иргэд нь радио сонсохоос илүүтэйгээр телевизор үздэг байна. Энэ нь төслийн бүсийн өрхүүд мэдээ мэдээлэл, үзвэр үйлчилгээний талаарх мэдээллийг телевизороос олж авдаг бөгөөд энэ нь төслийн бүсэд нутгийн иргэдтэй харилцах хамгийн үр дүнтэй арга байж болохыг харуулж байна.



**Зураг 5.27 Радио, телевизийн хэрэглээ, 2015, сумаар, хувиар**

## 6.5.8 Зам тээврийн дэд бүтэц

### 6.5.8.1 Зам, тээвэр

Монгол Улсын авто замын сүлжээ нь 1929 оноос хөгжиж эхлэсэн. Мянганы замын босоо тэнхлэг нь Сэлэнгэ аймгаар дамжин өнгөрдөг (Улаанбаатраас Орос хүртэлх) байна. Сайжруулсан авто замын нийт урт 9,428 км бөгөөд үүний 340 км урттай зам Сэлэнгэ аймгийн нутгаар дайран өнгөрдөг байна. Сэлэнгэ аймагт Мянганы замын энэ хэсгээс гадна улсын болон орон нутгийн чанартай 1,101.4 км зам байдаг. Төслийн бүсийн гол замуудыг доор байгаа газрын зурагт үзүүлсэн байна. Энэхүү газрын зурагт үзүүлснээр Гацууртын төлөвлөгдсөн Төсөл нь Мандал, Баянгол сумдын хатуу хучилттай авто зам, төмөр зам зэрэг замын гол дэд бүтэцтэй ойрхон байна.

#### **Гацууртын тээврийн зам**


*Хайрган хучилттай 56 км урт тээврийн замыг Гацууртын ба Бороо Гоулд уурхайн уурхайн талбайн хооронд барьсан. Энэ нь 8 м нэг шугамтай зам бөгөөд эсрэг чиглэлд зөрөх шугам нь замын дагууд тээврийн хэрэгслийн хөдөлгөөн аюулгүй зөрж өнгөрдөг байхаар байрлуулсан. Төслийн хүдэр тээвэрлэхэд ашиглах энэхүү зам нь олон нийтийн хэрэглээний зам бөгөөд үүнийг Бороо Гоулд компани Мандал сумын удирдлагад 2010 онд барьж өгсөн. Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах улсын комиссын акт<sup>100</sup> - д Бороо Гоулд компани нь зам ашиглагч бөгөөд санхүүжүүлэгч, мөн замын Мандал сумын Засаг даргын тамгын газрын<sup>101</sup> адилаар зам эзэмшигч гэж заасан бөгөөд ЗДТГ нь замын барилгын ажил ба засвар үйлчилгээний ажил хугацаанд явагдах байдлыг хариуцна гэжээ. Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах улсын комиссын актд замыг хатуу хучилттай болгохыг заагаагүй боловч үүнийг сайжруулсан шороон зам хэвээр байлгах болно. Уг зам дээр зүг чигийн тэмдэг бий боловч хурдны хязгаарын тэмдэг тэмдэглэгээ үгүй юм.*

<sup>100</sup> Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах улсын комиссын акт 03/66/2010, Гацуурт ХХК ба Мандал сум, 2010 оны 11 дүгээр сарын 12.

<sup>101</sup> Авто замын тухай хуулийн 3.1.9 -р заалтад "орон нутгийн чанартай авто зам" гэж нийслэл, аймгийн нутаг дэвсгэр дэх сум, дүүрэг, хот, суурин газрыг хооронд нь холбосон авто замыг хэлнэ гэж заасан.



**Зураг 5.28 Төслийн бүсийн авто болон төмөр замын дэд бүтцийн зураг, Баянгол сум**



**Зураг 5.29 Төслийн бүс нутгийн авто болон төмөр замын дэд бүтцийн зураг, Мандал сум**

#### 6.5.8.2 Замын хөдөлгөөн ба тээврийн хэрэгслийн эзэмшил

1998 онд Монгол Улсын хэмжээнд 36,700 тээврийн хэрэгсэл бүртгэгдсэний 23,800 нь хувийн эзэмшлийнх байна. 2008 оны байдлаар бүртгэлтэй тээврийн хэрэгслийн тоо 105,000 болон өссөн (бараг гурав дахин) ба 78,500 нь хувийн машин байсан. Нийтийн тээврийн тогтолцоо харьцангуй муутай Монгол Улсад эдийн засгийн өсөлтийн улмаас хувийн машин эзэмшигчдын тоо огцом өссөн байна. Хүснэгт 5.27-д 2014 оны тооллогоор бүртгэгдсэн аймаг, сумын тээврийн хэрэгслийн тоог харуулсан байна. Сүүлийн жилүүдэд Сэлэнгэ аймагт тээврийн хэрэгсэлийн тоо бас огцом өсч байна. 2014 оны тээврийн хэрэгслийн үзлэгийн статистик тоон мэдээнээс харахад 7,090 тээврийн хэрэгсэл аймагт бүртгэгдсэн байна.<sup>102</sup> Энэ тоо 2013 онтой харьцуулахад 340 тээврийн хэрэгслээр өссөн байна. Тээврийн хэрэгсэлийн тоогоор Мандал сум нь Сүхбаатар сумын (аймгийн төв) дараа 2-р байранд орсон байна. Харин Баянгол сум нь аймгийн хэмжээнд 5-р байранд орсон байна.

Мандал суманд хэрэгжсэн замын төслүүдийг доор харуулав.

- Хэрх баг хүртэлх зам – 2011 онд, 167.8 сая төгрөг;
- Нүхэн гарц – 2011 онд, 800.0 сая төгрөг;
- Түнхэл уулын бэлээс Хэрх баг хүрэх зам – 2013 онд, 480 сая төгрөг.

#### **Хүснэгт 5.27 Техникийн үзлэгт орсон тээврийн хэрэгслийн тоо<sup>103</sup>**

Аймаг, сум	2012	2013	2014	Тээврийн хэрэгслийн төрөл					
				Зорчигч суудлын машин	Ачааны машин	Автобус	Тусгай хэрэгцээний	Мотоцикл	Чиргүүл
Улсын хэмжээнд	345,473	384,864	437,677	303,724	96,581	20,650	16,722	-	-
Төвийн бүс	39,757	44,509	47,811	27,750	13,270	2,549	4,242	-	-
Сэлэнгэ	6,677	6,750	7,090	3,682	2,928	318	162	-	-
Мандал	-	-	2,724	1,265	1,154	-	-	264	41
Баянгол	-	-	688	319	315	-	-	51	3

Төслийн бүс орчмын замын хөдөлгөөний эрчмийг судлах зорилгоор Гацууртын төслийн хүдрийн тээврийн зам дагуух хоёр байршилд замын хөдөлгөөнийг судласан (Зураг 5.30-г харна уу).


Байршил 1: Зүүнхараагийн эргэлтийн огтлолцол дээр (УБ-ын замаас 29.3 км-т)

Байршил 2: Бороо голын баруун талын гүүрний ойролцоох уулзвар дээр (УБ-ын замаас 11.2 км-т).

<sup>102</sup> Сэлэнгэ аймгийн нийгэм-эдийн засгийн статистик мэдээ, 2014


<sup>103</sup> Монголын статистикийн жилийн тайлан, 2014.





**Зураг 5.30 Замын хөдөлгөөний судалгаа хийсэн байршил**

Дээр дурьдсан тээврийн хэрэгслийн эзэмшлийн статистик мэдээлэл болон цуглуулсан мэдээллээс харахад Гацууртын хүдрийн тээврийн замын хөдөлгөөний ихэнхи нь хөнгөн тээврийн хэрэгслийн буюу жижиг ачааны машин хөдөлгөөн байна. Бороо голын баруун гүүрний ойролцоох уулзвар болох байршил 2 дээр ихэнх замын хөдөлгөөн ажиглагдсан. Энэ нь Бороогийн уурхайн талбай, мөн Гацууртын уурхайн талбай, Зүүнхараагаас хойд зүг рүү чиглэсэн Улаанбаатар хот хүртэлх зам учир өндөр байж болох магадлалтай юм.




**Зураг 5.31 Гацууртын тээврийн зам дагуух замын хөдөлгөөний тооллого**

Доорх хүснэгтэнд хоёр байршлийн замын хөдөлгөөний дундажийг харуулсан байна. (ЗХ нь Зүүнхараа, УБ нь Улаанбаатар хотын хатуу хучилттай авто замын чиглэлээс Байршил 2-н баруун тийш хүртэлх). Замын ихэнх хөдөлгөөн нь Улаанбаатар хотоос Зүүнхараа хүртэлх замын чиглэлд өдрийн цагт болж байсан бол эсрэг чиглэлд тээврийн хэрэгсэлүүд голдуу шөнийн цагт явж байсан. Эсрэг чиглэлд, өдрийн өөр цагуудад харьцангуй бага тээврийн хэрэгсэл явдаг байна. Энэхүү чиглэлийн замын хөдөлгөөний ихэнхийг Зүүнхараа/ УБ-ын хатуу хучилттай авто замын чиглэлд зорчиж буй тээврийн хэрэгсэлүүд эзэлж байгаа нь энэхүү чиглэлийн замын хөдөлгөөнийг нэмэгдүүлж байна гэж үзвэл үндэслэлтэй юм.

#### Хүснэгт 5.28 Өдөр болон шөнийн аялалын чиглэл

	ЗХ-аас УБ руу	ЗХ-аас Гацуурт руу	Гацууртаас ЗХ руу	Гацууртаас УБ руу	УБ-аас ЗХ руу	УБ-аас Гацуурт руу
<b>Өдөр</b>	44	4	2	13	70	19
<b>Шөнө</b>	24	2	2	6	55	5
<b>24 цагийн дундаж</b>	<b>34</b>	<b>3</b>	<b>2</b>	<b>9</b>	<b>63</b>	<b>12</b>


Доорхи зургаар судалгааны явцад (Байршил 1, 2-т) хоёр чиглэлийн замын хөдөлгөөний хугацааг тээврийн хэрэгслийн дундаж тоотой харуулж байна. Энэ зурагт замын хөдөлгөөний оргил цаг болох 2 цагаас 23 цаг хүртэлх хугацаанд замын хөдөлгөөнд оролцсон бүх төрлийн машиныг харуулсан ба Байршил 2 (Зүүнхараагийн уулзвар) болон Байршил 1 (Бороогийн уулзвар) аль алинд оройн 7 цагийн үед 32 – 34 машин тус тус явж байсныг харуулж байна.



**Зураг 5.32 Байршил тус бүрээр замын хөдөлгөөний дундаж тоог зорчих цагаар харуулав**



Замын ихэнх хөдөлгөөн нь өдрийн цагт явагддаг ба 2 цагаас 23 цагийн хооронд хамгийн ачаалалтай байгаа нь харагдаж байна. Том оврын ачааны машин болон автобусууд өглөөний 9-10 цагуудад илүү явдаг нь ажиглагдав. Тээврийн хэрэгслүүдийн Гацуурт руу чиглэсэн хөдөлгөөн шөнийн цагаар нилээдгүй байсан хэдий ч нийт замын хөдөлгөөний багахан хувийг эзэлж байгаа нь сонирхолтой байв. Түүнчлэн Зураг 5.33-т Гацууртын уурхайн талбай руу шөнийн цагаар явж байгаа хэд хэдэн ачааны машинуудын тоог харуулсан байна. Ялангуяа, Зуунхараагаас том оврын ачааны машинууд, Улаанбаатар хотоос жижиг ачааны машинууд их явдаг байна. Энэ нь ажлын дараа ажиллагсад гэр рүүгээ буцах, хууль бусаар мод үйлдвэрлэх, уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй зорчих иргэдтэй холбоотой байж магадгүй.



**Зураг 5.33 Гацууртын уурхайн талбай хүртэлх замын хөдөлгөөн**

#### Гацууртын хүдрийн тээврийн замын эзэмшил, засвар үйлчилгээ

Гацууртын хүдрийн тээврийн зам нь Бороо Гоулд компани болон Мандал сумын ЗДТГ хоорондын гэрээний дагуу захиалгаар 2010 онд барьж дуусгасан нийтийн хэрэглээний зам юм. Бороо Гоулд компанийн санхүүжилтээр таван өөр барилгын компани 55 км зам болон 1 гүүрийг барьж байгуулсан байна. Авто замын тухай хуульд (Зүйл 14.1) зааснаар орон нутгийн замын (өөрөөр хэлбэл Гацууртын хүдрийн тээврийн зам) эзэмшигч нь аймгийн Засаг дарга буюу энэ тохиолдолд Сэлэнгэ аймгийн эрх бүхий байгууллага юм.

Замын ашиглалт, засвар үйлчилгээг, замын эзэмшигч (Сэлэнгэ аймгийн эрх бүхий байгууллага) хариуцна. Авто замын тухай хуулийн 14.2.3-р зүйлд авто замын эзэмшигч "авто зам, замын байгууламжийг барьж байгуулах засвар, арчлалт хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсны үндсэн дээр ажил зохион байгуулах, техникийн хяналт хийх, гүйцэтгэлийг санхүүжүүлнэ" гэжээ. Үүнээс гадна Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, аймаг/сумын Засаг дарга нь авто замын байгууламжийн засвар, арчлалт, хамгаалалттай холбоотой хуулийн хэрэгжилтийг хариуцна.

Тухайн хуулийн замын аюулгүй байдалтай холбогдолтой 17-р зүйлд зам ашиглагч, эзэмшигчийн замын аюулгүй ажиллагааны хариуцлагыг тусгасан байна.

#### 6.5.8.3 Төмөр замын тээвэр

Хатуу хучилттай цөөхөн замтай, далайд гарцгүй Монгол Улсын хувьд төмөр зам нь аялалын чухал ач холбогдолтой юм. Монгол Улсын хойд хөрш болох Оросын холбооны улс болон урд хөрш болох Бүгд Найрамдах Хятад улсыг холбосон, хөгжлийн гол тэнхлэг болсон төмөр замын (Транс Сибирийн төмөр зам) 345 км зам нь Сэлэнгэ аймгийн нутгаар (нийт 1,810 км төмөр зам) дайран өнгөрдөг. Энэхүү төмөр зам нь Орос улсын Наушки өртөө болон Хятад улсын Эрээн хоттой холбогдсон байна. Түүнчлэн, Транс-Монголын төмөр зам гэж нэрлэгддэг Улаанбаатар төмөр зам нь Мандал сумын Түнхэл багаар дамжин өнгөрч Сэлэнгэ аймгийн гол өртөөнүүдтэй холбогдсон байна. Сүхбаатар сум нь Монгол Улсын төмөр замын гол төв юм. Улаанбаатар төмөр зам нийгэмлэг нь Сэлэнгэ аймгийн төмөр замын тээврийг шууд удирдан явуулдаг. Хүснэгт 5.29-д 2014

онд тээвэрлэсэн ачаа, ачааны эргэлт, зорчигчийн тоо зэрэг төмөр замын зарим үзүүлэлтийг харуулж байна.

#### Хүснэгт 5.29 Төмөр замын тээврийн гол үзүүлэлтүүд, аймгаар, 2014<sup>104</sup>

2014	
Тээвэрлэсэн ачаа (мянган, \$)	
Сүхбаатар хилийн боомт	83,267,300
Алтанбулаг хилийн боомт	130,862,700
Ачааны эргэлт (мянган, \$)	
Сүхбаатар хилийн боомт	832,67,300
Алтанбулаг хилийн боомт	130,862,700
Зорчигчдын тоо	
Орон нутгийн зорчигч	349,734
Гадаадын зорчигч	106,406

#### 6.5.8.4 Нийтийн тээвэр

Нийтийн тээврийн үйлчилгээг судалгааны хүрээнд дараах байдлаар гурав ангилна.

- Хот хоорондын тээвэр;
- Сум/баг хооронд болон суурин газрын хүн амын тээвэр;
- Хот доторх тээвэр.

Сэлэнгэ аймгийн нийтийн тээврийн үйлчилгээнд авто болон төмөр замын тээвэр гэсэн хоёр хэлбэр ашиглагдаж байгаа бөгөөд иргэдийн өргөн хэрэглэдэг нийтийн тээвэр бол галт тэрэг юм. Төмөр замын тээвэр нь Баянгол, Мандал сумдын төвөөс гадна Түнхэл багаар дамжин Улаанбаатар хот, Сэлэнгэ аймаг хооронд зорчигч тээвэрлэх үйлчилгээ хийдэг. Үүнээс гадна, Улаанбаатар хотоос Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум орох (аймгийн төв) галт тэрэг өдөр бүр 10.50-д хөдөлж, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумаас Улаанбаатар хот руу 21.00 цагт буцдаг байна. Хот хоорондын бусад тээвэр нь өөр өөрийн хувиартай байна.

#### Хүснэгт 5.30 Төмөр замын зорчигчдын билетийн үнэ, төгрөг

Билетийн үнэ	Насанд хүрэгч			Хүүхэд		
	Нийтийн	Плацкард	Купе	Нийтийн	Плацкард	Купе
Сэлэнгэ аймгаас УБ орох галт тэрэг	7,000	13,000	38,500	2,000	7,200	18,100
Зүүнхараа-гаас УБ орох галт тэрэг	4,200	8,200	22,700	1,300	4,700	12,100
Баруунхараа-гаас УБ орох галт тэрэг	4,700	9,700	28,500	1,400	6,200	15,400
Түнхэл багаас УБ орох галт тэрэг	3,200	6,900	20,300	900	4,600	10,800
Баруунхараа-гаас Зүүнхараа орох галт тэрэг	1,300	1,400	2,600	400	400	700

Зам тээвэр нь зэргэлдээ аймаг, сумдын төв болон хилийн боомт хоорондын нийтийн тээврийн үйлчилгээг хийж гүйцэтгэдэг байна. Орон нутгийн иргэдийн хүсэлт, хэрэгцээ дээр үндэслэн 2013 оны 11-р сараас эхлэн Улаанбаатар хот, Сэлэнгэ аймгийн төв хооронд том оврын автобусны

<sup>104</sup> Аймгийн статистикийн эмхэтгэл, 2014.

үйлчилгээг нэвтрүүлж эхэлсэн байна. Энэхүү чиглэлд одоогийн байдлаар, 2 автобус өдөр бүр үйлчилж байна.<sup>105</sup> Улаанбаатар хот Зүүнхараа (Мандал сум) хооронд нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэгч компаниуд галт тэрэгний билетний үнэ, хууль бүс тээвэрлэлт нэмэгдсэнтэй (билетний хулгай, билетгүй зорчигч, хулгайн тээвэрлэлт)<sup>106</sup> холбоотой зарим нэг бэрхшээлтэй тулгарч байна.

Мандал, Баянгол сумдад микро автобус, таксины үйлчилгээ үзүүлдэг хувь хүмүүс байдаг. Мандал, Баянгол сумдын нэг удаагийн таксины үнэ өдрийн цагаар ойролцоогоор 500 – 1000 төгрөг, оройн цагаар үнэ өсч 1000 төгрөг болдог байна.

**Хүснэгт 5.31 Сэлэнгэ аймгийн төвөөс сумд болон Улаанбаатар руу явах нийтийн тээврийн үнэ, төг**

	Үнэ, төгрөг
УБ хотоос Сүхбаатар сум (аймгийн төв) очих/буцах билетний үнэ (Том оврын автобус)	12,000
УБ хотоос Сүхбаатар сум (аймгийн төв) очих/буцах билетний үнэ (микро автобус)	7,000
Мандал сум дотор Хэрх багаас ирэх/буцах билетний үнэ	1,000
Мандал сум дотор Түнхэл багаас ирэх/буцах билетний үнэ	7,000
УБ-аас Зүүнхараа очих/буцах билетний үнэ (такси)	15,000
УБ-аас Баянгол сум очих/буцах билетний үнэ (такси)	10,000 – 15,000
Түнхэл багт очих/буцах билетний үнэ (такси)	зөвхөн төмөр замаар явна

### 6.5.9 Дүгнэлт

Төслийн бүсийн нийгмийн дэд бүтэцтэй холбоотой хэд хэдэн гол асуудлуудыг тодорхойлсон байна. Цэцэрлэгийн байгууламжийн хүчин чадлыг нэмсэн ч Мандал, Баянгол сумдын аль алинд нь цэцэрлэгийн ирц ойролцоогоор 87% байгаа ба хүүхдүүдийн үлдсэн 13% нь цэцэрлэгийн хүчин чадлаас хамааран цэцэрлэгт явж чадахгүй байна. 2014 – 2015 оны хичээлийн жилд дунд ангиас (9-р анги) ахлах анги (10-р анги) руу дэвшин орсон сурагчдын хувь буурсан ба эмэгтэй сурагчдын хувь эрэгтэй сурагчдын хувиас илүү их байна. Жендэрийн энэ ялгаатай байдал нь боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх цаашдын боломжинд нөлөө үзүүлэхүйц үзүүлэлт болсон байна. Эмэгтэй сурагчид илүүтэйгээр бүрэн дунд боловсрол олж авч байгаа нь эмэгтэйчүүдэд цаашдын боловсрол (дээд болон мэргэжлийн) олж авах, илүү сайн ажилд орж, илүү орлого олох боломжийг олгох юм. Төслийн бүсэд техник мэргэжлийн сургалт хязгаарлагдмал, үйл ажиллагаа явуулж байгаа сургалтын төвүүд нь уламжлал ёсоор ихэвчлэн эрэгтэй оюутнуудад зориулж эрэгтэйчүүдийн мэргэжлийн чиглэлийн сургалтуудыг явуулдаг. Аймгийн хэмжээнд зөвхөн Мандал суманд нэг техник мэргэжлийн сургалтын төв байна. Энэхүү техник мэргэжлийн сургууль нь эрэгтэй давамгайлсан мэргэжил болох барилгын салбарын мэргэжлүүдэд илүүтэй анхаарал хандуулсан байна.

Төслийн бүсийн ундны усны гол эх үүсвэр нь худаг, гол горхи, булаг, зөөврийн ус түгээх цэг зэрэг байна. Баянгол суманд хамгаалалтгүй худгаас ус авч ашиглах нь Мандал сумаас илүү байна (хамгаалалттай худгыг бодвол бохирдлын эрсдэл өндөр). Сумын төвийн оршин суугч өрхийн дийлэнх нь төвийн төвлөрсөн эрчим хүчний сүлжээнд холбогдсон ба Мандал сумын судалгаанд хамрагдсан өрхийн 21.5% нь, Баянгол сумын судалгаанд хамрагдсан өрхийн 39.9% нь сэргээгдэх эрчим хүч ашигладаг гэж хариулсан байна. Нарны эрчим хүчийг судалгаанд хамрагдсан газар

<sup>105</sup> Авто зам, тээврийн хэлтсийн тайлан, Сэлэнгэ аймаг.

<sup>106</sup> Авто зам, тээврийн хэлтсийн тайлан, Сэлэнгэ аймаг.

нутгийн малчид, Баянгол сумын иргэд нилээд хэрэглэж байна. Түнхэл баг бусад багийг бодвол төвлөрсөн бус дизель станц илүү хэрэглэдэг байна. Мандал сумын судалгаанд хамрагдсан өрхийн 19.5% нь зөвхөн 10-р сараас 4-р сарын хооронд ажилладаг төвлөрсөн бус дизель станцыг эрчим хүчний гол эх үүсвэр гэж хариулсан байна. Дулаан хангамж нь Монгол Улсад чухал шаардлагатай үйлчилгээ боловч энэ нь хүн бүрт ялангуяа хөдөө орон нутгийн иргэдэд хүртээмжтэй биш байна. Сумдын дулааны одоогийн систем нь голдуу (а) жижиг зуух; ба (б) төвлөрсөн болон төвлөрсөн бус нүүрсэн галлагаат уурын зуухнаас бүрддэг. Ихэнх өрхүүд халаалтын төвлөрсөн сүлжээнд холбогдоогүй байдаг.

Төслийн бүсийн өрхүүд мэдээ, мэдээлэлийг радионоос илүүтэй телевизороос олж авдаг ба энэ нь орон нутгийн иргэдтэй харилцах хамгийн үр дүнтэй арга гэдэг нь харагдаж байна. Тээврийн хэрэгсэл, төмөр зам нь нийтийн тээврийн үйлчилгээнд ашигладаг хамгийн түгээмэл хэлбэр бөгөөд төмөр замын тээвэр нь нийтлэг. Төмөр замын тээвэр нь Баянгол, Мандал сумд, Түнхэл багаар дамжан Сэлэнгэ аймаг, Улаанбаатар хот хооронд зорчигч тээвэрлэдэг.

## 6.6 ГАЗАР АШИГЛАЛТ БА БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАЛТ

### 6.6.1 Оршил

Энэхүү бүлэгт төслийн ойролцоох талбайн газар эзэмшил, өмчлөл, ашиглалт болон байгалийн баялгийн ашиглалттай холбоотой асуудлууд тусгагдсан ба эдгээр асуудлуудыг аймгийн хэмжээнд болон Мандал, Баянгол сумдын хэмжээнд ялангуяа Түнхэл багийн айл өрхүүдийн хувьд голчлон авч үзэх болно.

### 6.6.2 Ашигласан тоо мэдээлэл

Тайлангийн энэ хэсгийг нийт 4 түвшний (*аймаг, сум, баг ба айл өрх*) өгөгдөл, мэдээлэлд үндэслэн боловсрууллаа. Мэдээллийг Сэлэнгэ аймгийн улсын болон арилжааны байгууллагуудаас авсан ба үүнд, Мандал, Баянгол сум болон Түнхэл, Хэрх багийн төрийн байгууллагууд, мөн бусад байгууллагуудын төлөөлөгчид буюу гол талуудтай хийсэн ярилцлага (ГТХЯ), орон нутгийн олон айл өрхүүдтэй зохион байгуулсан зорилтот бүлгийн ярилцлага (ЗБЯ)-ын үр дүнг ашигласан болно.

Аймгийн түвшний судалгааг дараах бичиг баримтуудын шинжилгээнд үндэслэн боловсруулав. Үүнд:

- Монгол Улсын статистикийн эмхтгэл 2014;
- Газрын нэгдмэл сангийн тайлан 2013;
- Сэлэнгэ аймгийн 2014 оны статистикийн эмхэтгэл

Орон нутгийн (сум ба багийн түвшин) мэдээллийг голчлон Сэлэнгэ аймгийн жилийн тайлан эмхэтгэл, холбогдох төрийн байгууллагуудаас гаргасан тайланд хийсэн судалгаа зэрэг эх үүсвэрээс авсан болно.

Дээрх байгууллага, нийгмийн бүлгүүдтэй хийсэн ГТХЯ ба ЗБЯ-ын тэмдэглэлийг аймаг, сум, багийн түвшний газар ашиглалт ба байгалийн нөөцийн талаарх асуудлыг тодорхойлоход ашиглалаа.

Өрхийн түүвэр судалгааны үр дүнг SPSS програм ашиглан боловсруулж үр дүнг холбогдох мэдээлэл, асуудлыг танилцуулахад ашиглав.

### 6.6.3 Газар ашиглалт

#### 6.6.3.1 Газар ашиглалт ба зориулалт

Монголчууд газрыг эрт дээр үеэс нийтээрээ уламжлан ашиглаж ирсэн бөгөөд социализмын үед ч энэ уламжлал алдагдалгүй малчдын дунд хадгалагдсаар ирсэн юм. Энэ утгаараа монгол өв соёл нь “нүүдэлчдийн амьдрал”-тай салшгүй холбоотой ба цаашлаад газар ашиглалт нь нийгэм эдийн засаг болоод байгаль орчны хувьд ихээхэн чухал асуудалд тооцогдоно. Сүүлийн жилүүдэд мал маллагаа ба монголчуудын газар ашиглах хэв маягт нилээд чухал өөрчлөлтүүд орсон бөгөөд доорх байдлаар ерөнхийд нь тоймолж болох юм.<sup>107</sup>

Сүүлийн 80 жилд хөдөө орон нутаг дахь монголчуудын аж амьдралд өвөрмөц бөгөөд чухал шилжилт өөрчлөлтүүд орсон байдаг. 1950-аад оны сүүл хүртэл нэгдэлжих (хамтралын аж ахуйн үе) хөдөлгөөн эрчимтэй явагдсан ба хөдөө орон нутгийн ард иргэдийн аж амьдрал голчлон мал маллагаанд

<sup>107</sup> Юптон К. ба бусад. 2013. Олон нийт, газар нутаг ба бэлчээрийн уламжлалт аж ахуй: Социализмын дараах төв Ази дахь хүрээлэн буй орчин ба нийгэм. Монгол Улсад зориулсан тайлан. Леверулам Итгэл судалгааны төслийн буцалтгүй тусламж F/00 212/AI, 2010 – 2012.


суурилсан байв. Нэгдэлжих хөдөлгөөн 1950 оны сүүл 1960-аад оны үед бүрэн дуусаж 30 гаруй жилийн турш хэрэгжсэн ч 1990 оны нийгэм эдийн засгийн шилжилт хөдөлгөөний улмаас нэгдлийн аж ахуйг бүрэн халсан юм. Уг шилжилтийн явцад хамтын нэгдэлжих хөдөлгөөн болон социалист нийгмийн төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийг бүрэн өөрчилж хувийн өмчид тулгуурласан зах зээлийн эдийн засагт шилжсэн байна.”

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн системд шилжих гол суурь нь үл хөдлөх хөрөнгө ба газар эзэмших, олгох, чөлөөлөх болон газрын эрх шилжүүлэх талаарх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудал байв. Монгол Улсын Үндсэн хууль (1992), Газрын тухай хууль (2002), Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль (2003), Иргэний хууль (1992) ба холбогдох журмуудад заасан газартай холбоотой заалтуудыг энэ тайлангийн 3 дугаар бүлэгт орууллаа. Газрын тухай хуулинд<sup>108</sup> нутаг дэвсгэрийг хөдөө аж ахуйн газар, хот тосгон, бусад суурины газар, зам, шугам сүлжээний газар, ойн сан бүхий газар, усны сан бүхий газар болон тусгай хэрэгцээний газар гэсэн үндсэн ангилалд хуваан ашиглахаар заасан байдаг.

Сэлэнгэ аймгийн газар нутгийн хэмжээ нь 4 сая га бөгөөд энэ нь Монгол Улсын нийт талбайн 2.6 хувийг эзэлнэ. Сэлэнгэ аймгийн нийт газар нутгийн 12% (484,373 га)-ийг Мандал сум, 4.8% (197,628 га)-ийг Баянгол сум эзэлдэг. Сэлэнгэ нь Монгол Улсын хөдөө аж ахуйд суурилсан аймгуудын нэг юм. Тодруулбал аймгийн нутаг дэвсгэрийн тал хувийг хөдөө аж ахуйн зориулалтаар ашигладаг бол гуравны нэг нь (37.3%) ойн сан бүхий газар, 10.2% нь улсын тусгай хэрэгцээний газар бөгөөд үлдсэн нь хот суурин, зам тээвэр, дэд бүтэц болон усан сан бүхий газар юм. Мандал сумын хувьд газрын ихэнхи хэсгийг (ойролцоогоор гуравны хоёрыг) ойн зориулалтаар ашигладаг бол Баянгол сумын 80%-ийг аж ахуйн зориулалтаар ашигладаг. Баянгол сумын нутаг дэвсгэрийн 13% нь ойн сан бүхий газар ба энэ нь Мандал сумынхтай харьцуулахад маш бага байгаа юм. Зураг 5.34-т Гацууртын төслийн бүсийн ойр орчмоор олгогдсон уул уурхайн (ашиглалт/хайгуулийн тусгай зөвшөөрөлтэй) зориулалттай газрыг харуулав.

<sup>108</sup> <http://www.legalinfo.mn/law/details/216?lawid=216>.





**Зураг 5.34 Гацууртын төслийн орчим уул уурхайн зориулалтаар олгогдсон газрууд**

#### 6.6.3.2 Тусгай хамгаалалттай газар

Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ нь сүүлийн 20 жилийн дотор ихээр нэмэгдэж улсын нийт талбайн 18%-ийг эзлэх болсон. Олон улсын гэрээ, конвенцийн хүрээнд хамгаалагдсан газар, улсын тусгай хамгаалалттай газар, орон нутгийн тусгай хамгаалалттай газар, шувуудад чухал газар ба цаашид хамгаалахаар төлөвлөсөн газар зэрэг хэд хэдэн төрлийн хамгаалалттай газрууд байдаг. Тусгай хамгаалалттай газрын хэмжээг нэмсэн хэдий ч тухайн газарт амьдардаг ургамал амьтныг хамгаалах, нөөцийг болон даацыг нэмэгдүүлэх тал дээр авч буй арга хэмжээ нь төдийлөн хангалтгүй байна. 2009 онд батлагдсан “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” (Урт нэртэй хууль) хуулийн дагуу усан болон ойн сан бүхий газраас дотогш 200 метрт байсан нийт 200 гаруй олборлолтын ба хайгуулын лицензийг Монгол Улсын Засгийн газар цуцалсан. Уг хуулийн дагуу гаргасан жагсаалтаас зарим уул уурхайн төслүүдийг гаргах тухай өөрчлөлтийг саяхан хийсэн бөгөөд үүнд нь Гацууртын уурхай хамрагдсан тул төслийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулах болсон юм.

Улсын тусгай хэрэгцээний газрын ангилалыг доорх хүснэгтэд харуулав. Сэлэнгэ аймгийн газар нутгийн 10%-ийг энэ ангилалын газар эзлэх ба эдгээрт хэд хэдэн улсын тусгай хамгаалалтай болон 50 гаруй орон нутгийн тусгай хамгаалалттай газрууд ордог байна<sup>109</sup>.

Монгол Улсын Газрын тухай хуулинд (2002) улсын тусгай хэрэгцээний газар нутагт дараах ангилалын газрууд орхоор заасан байдаг. Үүнд:

- улсын тусгай хамгаалалттай газар;

<sup>109</sup> <http://www.legalinfo.mn/law/details/216>.




- улсын хилийн зурвас газар;
- улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар;
- гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар;
- шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай;
- аймаг дундын отрын бэлчээр;
- улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай (зуд гэх мэт байгалийн гамшиг тохиолдсон үед).
- бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай;
- чөлөөт бүсийн газар.
- цөмийн төхөөрөмж барих, ашиглах зориулалтаар олгосон газар орно.

Мандал суманд орон нутгийн тусгай хамгаалалттай газрын 2 нь тусгай зөвшөөрөлтэй газрын хойд болон баруун хойд талд байрлаж байна. Гацууртын төслийн хүрээнд төлөвлөж буй тээврийн зам нь эдгээр орон нутгийн тусгай хамгаалалттай газруудыг дайран өнгөрөхөөр байгаа юм (Хүснэгт 5.32 ба Зураг 5.35-г үзнэ үү). Дээрх 2 газар нь аймгийн нутаг дэвсгэрт бүрэн багтаж байгаагийн хувьд аймгийн засаг захиргаа тухайн газрын менежментийг хариуцах үүрэгтэй.

**Хүснэгт 5.32 Орон нутгийн тусгай хамгаалалттай 2 газар нь Гацууртын төслийн хүдэр тээвэрлэхээр санал болгож буй замтай огтлолоцсон байдал<sup>110</sup>**

Газрын нэр	Сум	Хамгаалалтын түвшин	Хамгаалалтанд авсан шалтгаан	Талбай, га
Зуун модны гол	Мандал	аймгийн	Байгалийн үзэсгэлэнт газар	647,700
Ноён уул	Мандал	аймгийн	Соёлын өв (эртний булш) бүхий газар, ховор ургамал	2,052,400

<sup>110</sup> Сэлэнгэ аймгийн тусгай хамгаалалттай газрын жагсаалт, 2007.



**Зураг 5.35 Төслийн талбайд байрлах орон нутгийн тусгай хамгаалалттай 2 газрын байршил**

#### 6.6.3.3 Хөдөө аж ахуй ба бэлчээр

Монголчууд цөл хээр, эсвэл үржил шимт ойт хээрийн бүс хэмээн ялгалгүйгээр байгалийн бүхий л бүс, бүслүүрт малаа улирлын чанартайгаар бэлчээр сэлгэн малладаг<sup>111</sup> ба Гацууртын төсөл орчмын талбай нь ойт хээрийн бүсэд<sup>112</sup> хамрагдаж байна. Монгол Улсын Үндсэн хууль ба Газрын тухай хуулинд бэлчээр нь нийтийн эдэлбэрийн газар ба задгай бэлчээрийн газрыг өмчлүүлэх боломжгүйгээр<sup>113</sup> гэж хуульчилсан байдаг. Гэсэн хэдий ч хуулиндаа өвөлжөөний газрыг (өвөлжөө, хаваржааны бууц) малчдад эзэмшүүлэхээр заасан байдаг ба ингэснээр тухайн өвөлжөөний газрыг зуны хугацаанд өөр малчид ашиглахаас хамгаалан өвлийн улиралд ашиглах боломжоор хангаж өгдөг. Зун, намарын бэлчээрийг имй хамгаалалтад хамруулах боломжгүй байдаг учраас нээлттэй ашигладаг.

<sup>111</sup> Бэлчээрийн сэлгээ гэдэг нь тодорхой зуны болон өвлийн бэлчээрт хүмүүс малтайгаа улирлын чанартай нүүхийг хэлнэ.

<sup>112</sup> Жамсранжав, С. 2009. Монгол Улсын бэлчээрийн тогтвортой менежмент: Малчдын бүлгийн үүрэг оролцоо.


<sup>113</sup> <http://www.legalinfo.mn/law/details/216>.

Газрын тухай хуулийн дагуу нийтийн эдэлбэрийн газарт дараах газрууд орно:

- бэлчээр, бэлчээр дэх уст цэг, хужир мараа бүхий газар;
- хот, тосгон, бусад суурины нийтийн эдэлбэрийн газар;
- зам, шугам сүлжээний газар;
- ойн сан бүхий газар;
- усны сан бүхий газар.

Монгол Улсын хуулиар газрыг бэлчээр, ЖДҮ, тариалан эрхлэх, ойн болон бичил уурхайн зэрэг олон зориулалтаар ашиглах боломжтой.<sup>114</sup> Малчид задгай бэлчээрийг зөвхөн ашиглах эрхтэй ба харин өмчлөх, эзэмших эрхгүй (малчид өрхийн хэрэгцээнд газар өмчлөн авах эрхтэй). Сумын захиргаа малчдад өвөлжөөний газрыг эзэмших эрхийн гэрчилгээг олгох эрхтэй ч тухайн газарт орчмын задгай бэлчээрийг оруулдаггүй. Хөдөө аж ахуй болон ЖДҮ-ийн зориулалтаар газрыг өмчлөх, эзэмших боломжтой ба энэ тохиолдолд холбогдох газрын татвар, төлбөрийг төлөх ёстой.


Сэлэнгэ аймгийн хөдөө аж ахуйн газар нутгийн ихэнхи нь бэлчээр (нийт хөдөө аж ахуйн газрын 79%), тариалан (нийт хөдөө аж ахуйн газрын 15%) болон хадлангийн (нийт хөдөө аж ахуйн газрын 6%) газрын зориулалтаар ашиглагддаг. Сэлэнгэ аймгийн хэмжээнд хөдөө аж ахуйн газар нутагтай холбоотой үүссэн хамгийн том асуудал нь бэлчээрийн талхлагдалт юм. Үүний шалтгаан болсон хэд хэдэн нөлөөлөх хүчин зүйл байгаа. Хамгийн том нөлөөлөх хүчин зүйл бол малчид болон мал бүхий иргэд ерөнхийдөө малын тоо толгойгоо маш их хэмжээгээр нэмсэн асуудал юм (2011-2014 оны хооронд малын тоо нийт 14%-иар өссөн, Мандал ба Баянгол сумдын малын тоо толгойн өсөлтийг Зураг 5.36-д харуулав). Мандал суманд малын тоо толгой 2013 оны байдлаар (2014 оны мэдээлэл байхгүй боловч Бороо Гоулд компаний Мандал суман дахь олон нийттэй харилцах ажилтны өгсөн мэдээллийн дагуу Мандал суман дахь малын тоо 2014 онд ойролцоогоор 9%-аар өсжээ) 5% өссөн байна. 2014 онд Баянгол сумын малын тоо 9%-аар өсжээ. Түүнээс гадна ГТХЯ-ийн үеэр Сэлэнгэ аймгийн ИТХ-ийн зөвлөх тус аймагт уул уурхай (уул уурхайн компани ба бичил уурхай эрхлэгчид) болон газар тариалангийн зориулалтаар ашиглаж байгаа газрын талбай ихэссэнтэй холбоотойгоор бэлчээрийн талбай мөн багасч хомсдсон талаар мэдээлсэн юм. Бэлчээрийн талбай багассан нь малчид ургамлын гарц сайтай бэлчээрийн төлөө ихээр тэмцэлдэх шалтгаан болоод байна.



<sup>114</sup> <http://www.legalinfo.mn/law/details/216>.

**Зураг 5.36 Малын тоо толгой, аймаг ба сумдаар, 2011 – 2014 <sup>115</sup>**

Хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн яамнаас хийсэн судалгаанаас харахад Сэлэнгэ аймгийн 100га бэлчээрийн талбай тутамд ногдох хонин толгойн тоо<sup>116</sup> нь 2014 оны байдлаар 146 бөгөөд энэ нь улсын дунджаас хоёр дахин их юм <sup>117</sup>. Энэ нь улсын дунджаас хоёр дахин илүү (Энэ нь жил ирэх тутам өссөөр байна. Зураг 5.37-г үзнэ үү) байгаа нь малын тоо, мөн бэлчээрийн даацын хэмжээ нэмэгдэж байгаатай холбоотой ба цаашлаад байгалийн нөөцийн төлөөх иргэдийн тэмцэл ихэсч болзошгүйг харуулж байгаа юм.



**Зураг 5.37 100 га бэлчээрт оногдох хонин тоо толгой, улсын дундаж, 2014 <sup>118</sup>**

Сэлэнгэ аймгийн 2014 оны тайланд дурдсанаар улсын болон аймгийн хэмжээнд малын тоо толгой өссөнийг эс тооцвол 2011 оноос хойш Сэлэнгэ аймагт малчдын тоо (нутгийн малчин өрх ба шилжин ирсэн малчид) буурсан байна (Хүснэгт 5.333 харна үү). Энэ нь шилжин ирсэн малчдын улмаас бэлчээрийн даац хэтэрч талхлагдахад хүрсэн (Бүлэг 4.1 Хүн ам зүй-д дурдсан) гэсэн зорилтод бүлгийнхний (малчдын) илэрхийлсэн санаанаас зөрж байгаа юм.

Зураг 5.38-д төслийн талбай дах судалгаанд хамрагдсан малчин өрхүүдийн байршил, ойролцоох дэд бүтэц, хүн амын төвлөрөл болон алслагдмал газруудыг харуулав.


<sup>115</sup> Сэлэнгэ аймгийн 2014 оны статистикийн товчоон, хуудас 369; Мандал сумын нийгэм эдийн засгийн статистикийн танилцуулга, 2014, хуудас 55, Хүснэгт 28; Нийгэм эдийн засгийн үндсэн үзүүлэлт, 2014.

<sup>116</sup> Малыг хонин толгойгоор илэрхийлэх нэгж буюу бэлчээрийн даацыг илэрхийлэхэд хэрэглэдэг. Хонин толгойд шилжүүлэх итгэлцүүр нь: 1 тэмээ 5 хонин толгой; 1 морь 7 хонин толгой; 1 үхэр to 6 хонин толгой; 1 хонь 1 хонин толгой; ба 1 ямаа 0.9 хонин толгой байна (жишээ нь 1 тэмээ + 10 ямаа + 1 үхэр = 5 + 9 + 6 = 20 хонин толгойтой тэнцэнэ).

<sup>117</sup> Өрхийн тооллого, 2009 он, хуудас 1.

<sup>118</sup> [http://www.mofa.gov.mn/new/index.php?option=com\\_content&view=article&id=114&Itemid=207](http://www.mofa.gov.mn/new/index.php?option=com_content&view=article&id=114&Itemid=207).





### Зураг 5.38 Төслийн талбай дах судалгаанд хамрагдсан малчин өрх

Баянгол ба Мандал сумдын бэлчээрийн талхлагдалтыг багасгах зорилгоор орон нутгийн захиргаанаас шилжин ирсэн малчдын тоог бууруулах арга хэмжээ авсан нь малчдын тоо буурахад нөлөөлсөн байж болох юм. Орон нутгийн засаг захиргаанаас авсан хамгийн гол арга хэмжээний нэг нь малын хөлийн татварыг нэмэгдүүлсэн явдал байв. Тодруулбал 2014 оны 12 дугаар сарын 15-нд Мандал сумын ИТХ-ын даргын тушаалаар шилжин ирсэн малчдад ногдуулах бэлчээр ашиглалтын төлбөрийн журмыг баталсан байна<sup>119</sup>.

### Хүснэгт 5.33 Малчин өрхийн тоо, аймаг ба сум, 2010 – 2013 <sup>120</sup>

	2010	2012	2013
Сэлэнгэ аймаг	4,187	4,056	4,047
Мандал сум	493	489	485
Баянгол сум	454	403	387

Дараах төлбөрийг шилжин ирсэн малчдад ногдуулахаар сумын Засаг даргын тамгын газраас шийдвэр гаргасан. Үүнд:

- Зөвшөөрөлгүй шилжин ирэх болон отроор түр буудаллах тохиолдолд: Хоногт нэг хонинд 250 төгрөг;

<sup>119</sup> Мандал сумын ИТХ-ын тэргүүлэгчийн 256-р шийдвэр.

<sup>120</sup> Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2014, хуудас 376; Мандал сумын нийгэм-эдийн засгийн статистикийн танилцуулга, 2014, хуудас 62; Нийгэм-эдийн засгийн үндсэн үзүүлэлт, 2014.



- Албан ёсоор шилжин ирэх тохиолдолд: 1 хонинд 4,000 төгрөгийн төлбөрийг тус тус ногдуулахаар шийдвэрлэсэн байна.

Шилжин ирэгсэд нь эхлээд сумын төвд ирж суурьшаад дараа нь малаа нүүлгэн авчирч сумын төвийн малын тоо толгойг маш ихээр гэнэт нэмэгдүүлэн уг журмыг мөрдөхгүй зугтдаг талаар малчид зорилтот бүлгийн хэлэлцүүлгийн үеэр дурдаж байв. Уг журам нь зөвшөөрөлгүй шилжин ирэгсдийн тоог түрхэн зууртаа багасгаж байгаа хэдий ч бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх болон талхлагдалтыг бууруулахад үр дүнгээ өгч байгаа эсэхэд дүгнэлт хийхэд хараахан эрт байгаа юм. Дээр дурдсан бэлчээрийн даац хэтэрсэн болон бэлчээрийн талхлагдалт ихсээд буй асуудал нь шилжин ирэгсдийн тоо нэмэгдэхээс илүүтэйгээр харин нутгийн малчид өөрсдөө малын тоо толгойгоо өсгөж буй явдалтай холбоотой байна.

*"Шилжин ирж буй ихэнх өрхүүд нь баруун аймгуудаас ямар нэгэн албан ёсны зөвшөөрөлгүйгээр (татвар төлбөр төлөхгүй) ирдэг. Бэлчээрийн талбай хэт талхлагдсан нь сумын хэмжээнд бэлчээрийн менежмент муу бөгөөд бэлчээрийн газрын хуваарилалтын талаар сумын Засаг даргын зүгээс огт ажил хийгээгүйтэй холбоотой. Гэсэн хэдий ч 7 дугаар сарын 15-аас хойш сумын засаг захиргаанаас хонин толгойн тоонд тулгуурлан бэлчээрийн хуваарилалтыг хийхээр шийдвэрлээд байна."*  
Мандал сумын малчдын бүлэгтэй хийсэн зорилтот бүлгийн уулзалтын үеэр өгсөн мэдээлэл

Дээр дурдсанчлан Мандал сум нь Баянголтой харьцуулахад ойн сан бүхий болон хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглагддаг газар нутаг багатай. Цаашлаад бэлчээрийн газар ихтэй тул Баянгол сум нь харьцангуй их малтай. Мандал суманд шилжин ирсэн малчдын хувьд эзэнгүй бэлчээр олоход хүндрэлтэй байдаг бөгөөд бэлчээрийн хомсдол нь газрын маргаан гарахад хүргэдэг.<sup>121</sup> Мандал болон Баянгол сумдын бэлчээрийн талхлагдалттай холбоотойгоор малчдын дунд, мөн малчид болон тариаланчдын дунд үүсдэг газрын маргааны тухай доорх хүснэгтэд үзүүлэв (Мандал суманд нийтлэг үүсдэг газар ашиглалтын маргааны талаар доорхи шигтгээнээс үзнэ үү).

*"Намрын улиралд хадлан бэлдэх үеэр бэлчээр ашиглалтын талаар хадланчид болон малчдын дунд маргаан гарах нь түгээмэл байдаг. Эдгээр үүсдэг маргаанаас дурдвал малчид зуслангаасаа намаржаандаа гарах үед тэдний мал нь тариаланчдын хадланд нөөцөлсөн талбайг иддэг асуудал байна."*

Мандал сумын малчдын бүлэгтэй хийсэн ЗБХ-ийн үеэр өгсөн мэдээлэл

*"Малчид задгай бэлчээр эзэмших эрхгүй байдаг нь тариаланчид болон малчдын дунд гарах маргааны гол эх үүсвэр болдог. Жишээлбэл хадланчид, тариаланчид талбайгаа хашаалж өөрсдийн тарьсан ургацаа хамгаалан талбайдаа жилийн турш мал оруулах боломжгүй болгодгоос бэлчээрийн талбайг улам бүр багасгаж бусад бэлчээрт ирэх ачааллыг нэмэгдүүлдэг."*

Гацууртын төслийн тээврийн зам дагуу амьдардаг малчидтай хийсэн ЗБХ-ийн үеэр өгсөн мэдээлэл

Өрхийн судалгаанаас харахад ихэнх (60% гаруй нь) бэлчээр ашиглалттай холбоотой үүсдэг сум, баг болон айл өрхийн түвшний газрын маргаан нь хөрш зэргэлдээ малаа бэлчээдэг малчдын хооронд үүсдэг. Нутгийн болон шилжин ирсэн малчид хоорондын газрын маргаан нь Баянгол сумтай (16%) харьцуулахад Мандал суманд (38%) илүү байна. Энэ нь Мандал суманд бэлчээрийн газар харьцангуй бага байгаатай холбоотой. Харин Баянгол суманд малчид болон тариаланчдын дунд газрын маргаан (30% орчим) илүүтэйгээр гардаг байна.

<sup>121</sup> Мандал сумын нийгмийн ажилтантай хийсэн ярилцлага (ГТХЯ).

**Хүснэгт 5.34 Газрын маргаанд оролцсон талууд, судалгаанд хамрагдагсдын эзлэх хувь<sup>122</sup>**

	Сум		Баг			Өрх	
	Баянгол	Мандал	Түнхэл	Хэрх	Бусад	Малчин	Суурин
Ойролцоо нутагладаг малчдын хооронд	67.9	58.1	62.5	55.2	66.7	59.0	62.7
Сумын уугуул ба өөр сумын отрын малчдын хооронд	16.1	37.9	41.1	34.3	17.5	29.5	32.2
Малчид болон уул уурхайн компанийн хооронд	5.4	9.7	8.9	10.4	5.3	1.6	8.5
Малчид болон тариаланчдын хооронд	30.4	12.1	7.1	16.4	29.8	0.0	19.5
Бусад	1.8	2.4	1.8	3.0	1.8	1.6	3.4

Тайлбар: Нэгээс дээш хариулттай асуулт тул нийлбэр нь 100% болохгүй

Бэлчээртэй холбоотой маргаан гарах давтамж нь янз янз байдаг. Судалгаанд оролцогчдын гуравны нэг нь (33.4%) энэ төрлийн маргаан сар бүр гардаг хэмээн хариулсан байна. Мандал суманд гардаг бэлчээр ашиглалттай холбоотой маргаан нь бэлчээрийн талбай бага байгаагаас буюу нэмэлт мал бэлчээрлүүлэх боломжгүйн улмаас үүсдэг. Малчин өрхийн 30% гаруй нь улирлын чанартай тариалангийн болон хадлангийн ажлын улмаас маргаан үүсдэг гэж хариулжээ (Хүснэгт 5.35 харна уу). Монгол Улсын Газрын тухай хуульд зааснаар орон нутгийн засаг захиргаа нь газрын маргааныг шийдвэрлэх ёстой. Сэлэнгэ аймгийн ИТХ-аас 2013 оны 6 дугаар сард "Малчид болон тариалан эрхлэгчдийн хамтын тогтвортой ажиллагааг хангах тухай" журмыг баталсан. Уг журмын хэрэгжилтийн талаар 2014 оны 9 дүгээр сард Хушаат, Орхон ба Баруунбүрэн сумдуудад орон нутгийн (багийн) засаг захиргаа, малчид болон тариалан эрхлэгчдийн дунд гурван талт уулзалт хийсэн. Улмаар малчид болон тариаланчдын дунд үүсдэг газрын маргаан нь 30-50% буурсан үзүүлэлт гарсан бөгөөд баталсан журам нь газрын маргааныг эерэгээр шийдвэрлэхэд үр дүнгээ үзүүлж байгааг харуулж байгаа юм.<sup>123</sup>

**Хүснэгт 5.35 Бэлчээртэй холбоотой маргаан гарах давтамж**

	Сум		Баг			Өрх	
	Баянгол	Мандал	Түнхэл	Хэрх	Бусад	Малчин	Суурин
Тогтмол (сар бүр)	19.2	33.4	28.1	28.8	38.5	28.0	28.1
Заримдаа (улиралдаа нэг)	26.4	25.8	26.0	22.2	31.7	30.8	23.8
Ховор/ Ер гардаггүй (жилдээ нэг)	54.4	40.8	45.9	49.0	29.8	41.2	48.1

Газрын маргааныг шийдвэрлэхээр дараах арга хэмжээнүүдийг авсан. Үүнд, Мандал суманд шилжин ирсэн малчдад нэмэлт татвар ногдуулах, Сэлэнгэ аймгийн бүх сумдад малчид болон тариалан эрхлэгчдийн хооронд газрын маргааныг шийдвэрлэх журмыг батлан хэрэгжүүлэх ажлууд багтсан байна. Орон нутгийн засаг захиргаанаас газрын маргааныг шийдвэрлэх тал дээр

<sup>122</sup> Састэйнабилити Ийст Эйжия. 2015. Гацууртын төслийн нийгмийн суурь судалгааны тайлан, Өрхийн судалгаа.

<sup>123</sup> <http://mofa.gov.mn/selenge/images/tailanguud/11-%20%20.pdf>.

нилээд арга хэмжээ авдаг ч орон нутгийнхан багийн дарга болон бусад албан газар мэдэгдэхээсээ өмнө өөрсдөө асуудлаа шийдвэрлэхийг илүүд үздэг. Хамгийн түгээмэл газрын маргааныг шийдвэрлэх арга хэмжээ нь засаг захиргааны хамгийн доод түвшин буюу багийн даргадаа өргөдөл гаргах юм. Баянгол сумын иргэд (Мандал сумын иргэдийн 40%, Баянгол сумын иргэдийн 60% нь) аливаа маргааныг дотооддоо шууд шийдвэрлэхийг илүүд үздэг. Мандал суманд Баянгол сумтай харьцуулахад засаг захиргаандаа өргөдөл гарган асуудал шийдвэрлэх нь илүү байгаа нь Мандал суманд бэлчээр ашиглалттай холбоотой маргаан илүү их гардагтай холбоотой байж болзошгүй.

### Хүснэгт 5.36 Бэлчээр ашиглалттай холбоотой маргааныг шийдвэрлэх нийтлэг аргууд<sup>124</sup>

	Сум		Баг			Өрх	
	Баянгол	Мандал	Түнхэл	Хэрх	Бусад	Малчин	Суурин
Арга хэмжээ авдаггүй	11.7	11.1	9.8	12.2	11.7	6.0	14.1
Харилцан хоорондоо тохирдог	60.0	40.0	32.8	47.3	58.3	50.7	43.8
Багийн Засаг дарга зохицуулдаг	16.7	21.5	23.0	20.3	16.7	19.4	20.3
Сумийн захиргаа зохицуулдаг	8.3	12.6	16.4	9.5	8.3	11.9	10.9
Бусад	0.0	2.2	0.0	2.7	1.7	1.5	1.6
Мэдэхгүй	3.3	12.6	18.0	8.1	3.3	10.4	9.4

Сумын түвшинд шилжин ирсэн малчдын дунд бэлчээрийн менежментийн талаарх ойлголт өөр өөр байдаг. Дээр дурдсанчилан орон нутгийн албаныхан болон малчин өрхүүд газар ашиглалтын талаар журам боловсруулж шилжин ирсэн малчдын тоог хязгаарлахыг хүсдэг. Өрхийн судалгаанд хамрагдагсдын ихэнх нь буюу сумын түвшинд оролцогчдын 40-55%, багийн түвшинд 30-56%, өрхийн түвшинд 45-47% нь шилжин ирсэн малчдын эсрэг ямар нэг журам батлах шаардлагагүй хэмээн тус тус хариулсан байна. Дээр дурдсан газрын маргааны асуудлаар судалгаанд оролцогчдын 21% нь (Мандал), 9% нь (Баянгол) бэлчээр ашиглахад айл өрхүүд тусгайлан зөвшөөрөл авах шаардлагатай гэдэгтэй санал нэгтэй байна хэмээн хариулсан байна.

### Хүснэгт 5.37 Шилжин ирэгсэдтэй холбоотой бэлчээрийн менежмент асуудлууд<sup>125</sup>

	Сум		Баг			Өрх	
	Баянгол	Мандал	Түнхэл	Баянгол	Мандал	Малчин	Суурин
Тусгай арга хэмжээ шаардлагагүй	55.4	39.9	29.6	46.4	55.8	47.3	44.8
Хөрш малчидтай зөвлөлдөх	24.1	22.0	22.2	22.6	23.3	24.7	21.9
Сум багийн захиргаанд мэдэгдэж албан ёсоор зөвшөөрөл авах	8.9	21.4	18.5	23.8	10.0	18.3	15.6

Тайлбар: Нэгээс дээш хариулттай асуулт тул нийлбэр нь 100% болохгүй.

Газрын тухай хуулинд бэлчээрийг нийтээр ашиглахаар заасан байдаг. Уг заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн заалттай таарч байгаа хэдий ч шийдвэр гаргах түвшинд эргэлзээтэй асуудлуудыг

<sup>124</sup> Састэйнабилити Ийст Эйжия. 2015. Гацууртын төслийн нийгмийн суурь судалгааны тайлан, Өрхийн судалгаа.

<sup>125</sup> Састэйнабилити Ийст Эйжия. 2015. Гацууртын төслийн нийгмийн суурь судалгааны тайлан, Өрхийн судалгаа.

үүсгэдэг. Жишээлбэл нутгийн малчид сум дотроо нүүдэллэхэд асуудал үүсдэг. Тухайн өрх нь сумандаа бүртгэлтэй байгаа ч газар эзэмших буюу өмчлөх эрхийн гэрчилгээгээ аваагүй эсвэл сунгуулаагүй үед асуудал гарах нь бий. Одоогийн байдлаар айл өрхүүдэд бэлчээрийн газрыг дахин хуваарилах албан ёсны дүрэм, журам байхгүй байна. Өрхийн судалгаанаас харахад газрыг дахин хуваарилан ашиглах асуудлыг сум болон багийн түвшинд малчин өрхүүд өөрсдөө зохицуулдаг. Эдгээр тохиолдлуудын талаас илүү хувьд нь арга хэмжээ авдаггүй буюу асуудлыг шийдвэрлэж чаддаггүй байна. Өрхийн судалгааны үр дүнгээс харахад багийн засаг захиргаа нь малчин өрхүүдийн асуудлыг шийдвэрлэхэд илүү их үүрэг гүйцэтгэдэг бол сумын захиргаа ихэвчлэн суурин өрхүүдийн асуудлыг шийдвэрлэдэг хэмээн хариулжээ.

#### 6.6.3.4 Бичил уурхай эрхлэгчид

Сэлэнгэ аймгийн уул уурхайн хайгуулын болон ашиглалтын ихэнх (78% орчим нь) лиценз нь алтны төслүүдэд олгогдсон байдаг.<sup>126</sup> Энэ нөхцөл байдал бусад аймаг, сумдын бичил уурхай эрхлэгчдийн анхаарлыг татдаг. Монгол Улсад 10-аад жилийн өмнөөс эдийн засгийн шилжилт болон цаг уурын гамшигт үзэгдлийн улмаас үүссэн ажилгүйдэлтэй холбоотойгоор бичил уурхайчид ихээр нэмэгдсэн.<sup>127</sup> Бичил уурхай эрхлэгчид нь цалин багатай хөдөө орон нутгийн иргэд, албан хаагчид, зуданд малаа алдсан малчид, мөн ихэнх тохиолдолд албан ёсны орлогогүй иргэд байдаг (бичил уурхай эрхлэгчдийн талаар Бүлэг 6.4.4 Хөдөлмөр эрхлэлт-д мөн тусгасан болно)<sup>128</sup> ба тэд албан ёсны хайгуулын лиценз бүхий уул уурхайн компаниудын эзэмшдэг Төсөл хэрэгжиж байгаа болон хэрэгжихээр төлөвлөгдөж байгаа газруудад үйл ажиллагаа илүүтэйгээр эрхлэх сонирхолтой байдаг. Алтны бичил уурхайн хувьд (төслийн талбай дах хамгийн түгээмэл бичил уурхайн төрөл) тэдний үйл ажиллагаа эрхэлдэг газар нь алтны илэрцээс шалтгаалаад шороон орд (усан сан бүхий газартай ойр), эсвэл алтны үндсэн орд (ойн бүсэд илүү түгээмэл байдаг) дагуу байдаг. Энэхүү төслийн талбайд бичил уурхай эрхлэгчид, орон нутгийн засаг захиргаа болон уул уурхайн компаниудын хооронд үүсч буй газар ашиглалтын хамгийн гол ганц маргаан нь бичил уурхайн асуудал байна.

#### **Бичил уурхай эрхлэгчид, засаг захиргаа болон уул уурхайн компаниудын хоорондох газрын маргаан**

*"Бичил уурхай эрхлэгчид ихэнхдээ уул уурхайн компаниудийн лицензийн талбайд үйл ажиллагаа явуулах сонирхолтой байдаг. Тэд аль хэдийнээ Ноён уулыг ухаж эхэлсэн бөгөөд тухайн газар бичил уурхайчдын үйл ажиллагааны улмаас нэгэнт хөндөгдөөд байна. Төрийн байгууллагууд бичил уурхайн үйл ажиллагааг хянах үйл ажиллагааг сайжруулах, бичил уурхайчдын хандлагыг өөрчлөх, сургалт зохион байгуулах, бичил уурхайтай холбоотой хууль, дүрэм, журмыг тодруулах тал дээр арга хэмжээ авах шаардлагатай."*

Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын даргатай хийсэн ярилцлага (ГТХЯ)

*"Бид (бичил уурхайчид) урд нь Бороо Гоулд уурхайн хайгуулын лицензит талбайд харьяалагддаг байсан газарт үйл ажиллагаа явуулдаг байсан ба уг газар Бороогийн эзэмшилд байх үед орон нутгийн захиргаа болон Бороо Гоулд компаниас аман зөвшөөрөл авсан байсан. Харин одоо энэ талбай нь Сэлэнгэ Минерал" компанийн эзэмшил болсон. Бид орон нутгийн захиргаанаас үйл ажиллагаа эрхэлж болно гэсэн ямар нэг албан зөвшөөрөл байхгүй тул энэ компанитай маргаантай байгаа."*

Баянгол сумын бичил уурхайчидтай хийсэн ЗБХ-ийн үеэр өгсөн мэдээлэл

<sup>126</sup> Усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах судалгааны эмхэтгэл, 2012, хуудас 210.

<sup>127</sup> [http://sam.mn/info\\_en.php?url=intro](http://sam.mn/info_en.php?url=intro).

<sup>128</sup> Кейн И., Шлегер А. Али, Кэмп С., МакИнтир Д., Маккенна Н., Лекнэр А., Далайбуян А., Лахири-Датт К., Булович Н. (2015). Монголын хариуцлагатай уул уурхай: Эерэг оролцоог нэмэгдүүлэх, Тогтвортой ашигт малтмалын институт: Брисбан. хуудас 68.

Швейцарийн хөгжлийн агентлагаас 2005 онд Тогтвортой бичил уурхай төслийг бичил уурхай эрхлэгчдийн чадавхийг бэхжүүлэх зорилгоор хэрэгжүүлж эхэлсэн.<sup>129</sup> Монгол Улсын Засгийн газар 2010 оны 12 дугаар сард “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг баталсан<sup>130</sup> ба уг журмын дагуу бичил уурхайчдын үйл ажиллагаанаас үүссэн газрын маргааныг орон нутгийн засаг захиргаанд шилжүүлж холбогдох оролцогч талуудын дунд гэрээ байгуулан шийдвэрлэхээр заасан байдаг. Түүнчлэн энэ журмын дагуу бичил уурхайчдын нөхөрлөл, уул уурхайн компани болон орон нутгийн засаг захиргааны хооронд гурван талт гэрээ эсвэл бичил уурхайчдын нөхөрлөл ба орон нутгийн засаг захиргаа хоорондоо хоёрлосон гэрээ байгуулах замаар бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж болох юм. Тогтвортой бичил уурхай (ТБУ) төслийн дэмжлэг болон дээр дурдсан журмын хүрээнд Сэлэнгэ аймгийн орон нутгийн удирдлагаас бичил уурхайн асуудлыг зохицуулах боломж бүрдэж эхэлсэн ба уурхай бүхий сумдад бичил уурхайчдын нөхөрлөлүүдийг одоогоор байгуулаад байна.

Мандал сумын айл өрхийн 60% нь буюу 4,228 хүн бичил уурхай эрхэлдэг ба тэдний 228 нь албан ёсны бүртгэлтэй 30 бичил уурхайн нөхөрлөлийн гишүүд юм (30-100 гишүүдтэй 3 том ТББ ба 3-10 гишүүдтэй 27 жижиг нөхөрлөл үйл ажиллагаа явуулж байна).<sup>131</sup> Мандал суманд бичил уурхай эрхэлдэг хүмүүсийн тоо их байгаа ч бичил уурхайчдын нөхөрлөл, уул уурхайн компани болон орон нутгийн засаг захиргаатай хийсэн гурван талт гэрээ тэр бүр бий болоогүй байна. Сэлэнгэ Минерал хайгуулын компани, орон нутгийн удирдлага болон бичил уурхайчдын хооронд үүссэн дээр дурдсан маргаан нь гурван талт гэрээг тэр бүр байгуулан хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээлийн нэг жишээ юм. Цаашлаад Бороо Гоулд уурхайн төсөл эхэлснээс хойш бичил уурхайчид, сумынхан болон Бороо Гоулд компанийн хооронд гэрээ байгуулах эсэх талаар талууд удаан ярилцаж байгаа бөгөөд Бороо Гоулд компанийн зүгээс ямар нэг тохиролцоонд хүрэх тал дээр түдгэлзсэн байр суурьтай байна<sup>132</sup>.

Гацууртын төсөлтэй холбоотой бичил уурхайн нэмэлт нөхцөл байдал, дүн шинжилгээг Хавсралт В-ээс харна уу. Бичил уурхайн нөхцөл байдал нь Гацууртын төслийн нийгмийн суурь судалгаа хийж (2015 оны 4 – 5 дугаар сар) байх үеийг бичил уурхай эрхлэгчид өөр хэлбэрээр гарч ирсэн 9 дүгээр сартай харьцуулбал өөрчлөгдсөн байна. Тийм учир, цаашид нөхцөл байдалд/суурь мэдээлэл, нөлөөлөлд дүн шинжилгээ хийж, үр ашигтайгаар зохицуулах менежментийн арга хэмжээ, компанийн хүлээсэн үүрэг хариуцлагыг тодорхойлох зорилгоор бичил уурхайн талаарх асуудлыг тусад нь (Хавсралт В) авч хэлэлцсэн. Менежментийн арга хэмжээнүүдийг Гацууртын төслийн Нийгмийн менежментийн төлөвлөгөөнд бас оруулсан байна.

#### **6.6.4 Газар өмчлөл ба эзэмшил**

Дээр дурдсанчилан Сэлэнгэ аймгийн газар нутгийн талыг нь малчид болон тариаланчид хөдөө аж ахуйн зориулалтаар ашигладаг ба багахан хэсэгт нь бичил уурхай эрхлэгчид үйл ажиллагаа явуулдаг. Тус аймгийн нутаг дэвсгэрийн гуравны нэгийг ой сан бүхий газар эзэлдэг ба энэхүү

<sup>129</sup> [http://sam.mn/info\\_en.php?url=intro](http://sam.mn/info_en.php?url=intro).

<sup>130</sup> <http://mram.gov.mn/images/stories/mram/UUSH/BichilUurhai/regulation.pdf>.

<sup>131</sup> Тогтвортой бичил уурхай төсөл, 2011. Бичил уурхай эрхлэгчдийн амьжиргааны түвшний суурь судалгаа. хуудас 186.

<sup>132</sup> Сэлэнгэ аймгийн Уул уурхайн бодлогод аймгийн бичил уурхайчидтай холбогдолтой дараах зүйлсийг оруулсан байна:

“Зүйл 3.1.3. Бичил уурхайчид нөхөрлөл хэлбэрээр хууль эрхзүйн хүрээнд ажиллаж байгааг баталгаажуулах.

Эх сурвалж: [http://www.selenge.gov.mn/index.php?option=com\\_content&view=category&layout=blog&id=46&Itemid=111](http://www.selenge.gov.mn/index.php?option=com_content&view=category&layout=blog&id=46&Itemid=111)

газрыг ойн нөхөрлөл болон ой ашиглагчдын бүлгүүд албан ёсны зөвшөөрөлтэйгөөр ашигладаг. Түүнчлэн, Мандал сумын ойн сав бүхий газрын ихэнхийг (64%) мөн ой ашиглагчдын бүлэг харин Баянгол сумын дийлэнх газрыг (80%) хөдөө аж ахуйн зориулалтаар малчид, тариаланчид болон бичил уурхай эрхлэгчид ашигладаг байна.<sup>133</sup>

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулинд (Бүлэг 6.6.3.3 Хөдөө аж ахуй ба бэлчээр бүлгийг харна уу) өрхийн болон аж ахуйн зориулалтаар газар өмчлүүлэхээр заасан байдаг.<sup>134</sup> Мандал суманд 2015 оны 5 дугаар сарын байдлаар 194 иргэд нийт 36 га газрыг, Баянгол суманд 478 иргэд 33 га газрыг тус тус өмчилж аваад байна. Мандал сумтай харьцуулахад Баянгол суманд харьцангуй олон иргэд газар өмчилж авсан нь тус суманд газрын нөөц их байгаатай холбоотой.

### Хүснэгт 5.38 Сэлэнгэ аймагт газар өмчилсөн байдал, 2015 оны 5 дугаар сарын байдлаар <sup>135</sup>

	Өмчлөл	
	Иргэдийн тоо	Өмчлөлд олгосон газрын талбай, га
Сэлэнгэ аймаг	2,845	405.83
Мандал сум	194	36.03
Баянгол сум	478	33.46

Өрхийн судалгаанаас харахад иргэд өрхийн зориулалтаар газрыг хөдөө газраас илүүтэйгээр суурин газар буюу сум, багийн төвүүдэд өмчлөн авч байгаа нь харагдаж байгаа ба нийт өмчлүүлсэн газрын 75-99% нь сумын төвд байрлаж байна (Хүснэгт 5.39 ба Зураг 5.39-г харна уу).<sup>136</sup> Малчид газрыг мал маллах зэрэг хөдөө аж ахуйн зориулалтаар илүүтэй ашиглаж байгаа бол сумын суурин иргэд дэд бүтэц, зах зээлтэй ойр тул газраа ногоо тарих, хураасан ногоогоо зарах зэргээр ашиглаж газраас үр шим хүртэж байна. Аймгийн хэмжээнд Хэрх сумын иргэд бусад аймаг сумдын газарт хамгийн ихээр (22%) өрхийн зориулалтаар газар ашигладаг. Энэ нь Түнхэл сумтай харьцуулвал тус сум нь бусад аймаг, сумдуудтай холбогдоход буюу хүрч очиход амар байршилтай байгаатай холбоотой байж болзошгүй бөгөөд Түнхэл ба илүү алслагдмал хөрш зэргэлдээ багууд сумд руу хүрэх нь илүү хүндрэлтэй байдаг.

### Хүснэгт 5.39 Өрхийн зориулалтаар өмчилж авсан иргэдийн газрын байршил

	Сум		Баг			Өрх	
	Баянгол	Мандал	Түнхэл	Хэрх	Бусад	Малчин	Суурин
Сумын төв	98.6	85.5	92.8	76.3	97.6	86.2	91.8
Аймгийн төв	1.4	2.2	1.4	1.7	2.4	3.1	1.4
Бусад сум, аймаг	2.7	10.9	2.9	22.0	2.4	9.2	7.5

Тайлбар: Нэгээс дээш хариулттай асуулт тул нийлбэр нь 100% болохгүй.


<sup>133</sup> <http://land.eic.mn/TaLandInventory>; <http://baruunkharaa.gov.mn>; Мандал сумын 2014 оны нийгэм-эдийн засгийн статистик танилцуулга, 2014.

<sup>134</sup> Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 4.1-р зүйл.

<sup>135</sup> Сэлэнгэ аймгийн статистикийн товчоон, 2015 оны 5 дугаар сар, хуудас 46.

<sup>136</sup> Састэйнабилити Ийст Эйжия. 2015. Гацуурт төслийн нийгмийн суурь судалгааны тайлан, Өрхийн судалгаа.





**Зураг 5.39 Газрыг өрхийн зориулалтаар ашиглаж байгаа хүмүүсийн эзлэх хувь (%)**

Баянгол суманд 47% байхад Мандал сумын иргэдийн 72% нь бэлчээрийн газар буюу өвөлжөө, хаваржааны газраа эзэмших гэрчилгээ аваагүй байна. Энэ нь Мандал сум Баянгол сумтай харьцуулахад бага газар нутагтай, мөн газрын хүрэлцээ бага байгаа асуудлыг шийдвэрлэхээр орон нутгийн удирдлагаас авч буй газар олголтын бодлоготой холбоотой юм (Хүснэгт 5.40-г харна уу). Судалгаанд хамрагдагсдын талаас дээш хувь нь бэлчээрийн газар буюу өвөлжөө, хаваржааны газраа эзэмших гэрчилгээ аваагүй байна. Тодруулбал Түнхэл багийн 69%, Хэрх багийн 71%, Мандал сумын 70% ба Баянгол сумын 50% нь бэлчээр газраа эзэмших гэрчилгээ аваагүй байв.

Монгол Улсын хэмжээнд газар эзэмших болон өмчлөх эрх авах нь нэлээд түгээмэл бөгөөд чухал асуудал болоод байна. Уламжлал ёсоор ялангуяа малчин өрхийн хувьд албан ёсоор газар эзэмших нь түгээмэл байгаагүй юм. Судалгаанд оролцогчдын ихэнх нь сум болон багийн түвшинд орон нутгийн удирдлагаас газар эзэмшүүлэх, өмчлүүлэх эрх олгох үйл явц нь хэт зохион байгуулалт муутай байдаг тул газар эзэмших зөвшөөрөл хүсэх сонирхол нь буурдаг талаар дурдаж байв. Харин сумын газрын албаныхан өмчлүүлж, эзэмшүүлэх боломжтой газар бага байгаа тул газар олгох шийдвэр гаргахад хүндрэлтэй байдаг талаар дурдсан (доорх хүснэгтийг харна уу) юм.

"Газрын албаныхан одоогийн байдлаар нийт 5,700 гаруй газар өмчлөх хүсэлтийг (2003-2012 онд хүлээн авсан) шийдвэрлэхээр ажиллаж байгаа юм. 2013 онд Газрын алба нь нийт 3,000 иргэдээс өргөдөл хүлээн авсан бөгөөд эдгээр хүсэлтийн ихэнхийг нээлттэй хаалганы өдөрлөгөөр хүлээж авсан байна. Сумын газрын нөөц хязгаарлагдмал болсон тул 2014 оноос хойш Газрын алба газар өмчлөх хүсэлт хүлээж авахаа больсон ба харин урьдын хүлээж авсан газрын асуудалтай холбоотой өргөдлүүдээ шийдвэрлэхээр ажиллаж байгаа юм. 2014 онд Газрын алба нь газар эзэмших 200 гаруй хүсэлт хүлээж авсан (өмнөх жилийнхтэй харьцуулахад 15-20% нэмэгдсэн) бөгөөд ирээдүйд өргөдлийн тоо нэмэгдэх хандлагатай байна."

Мандал сумын Газрын албаны мэргэжилтэнтэй хийсэн ярилцлага (ГТХЯ)

**Хүснэгт 5.40 Нутгийн иргэдийн газар эзэмшиж, ашиглаж буй байдал<sup>137</sup>**

	Сум		Баг			Өрх	
	Баянгол	Мандал	Түнхэл	Хэрх	Бусад	Малчин	Суурин
Албан ёсны гэрээтэй	22.7	11.7	12.5	13.3	19.9	17.4	15.0
Үе дамжин нутаглаж ирсэн	21.1	11.2	13.5	9.5	19.9	20.2	12.4
Нэгдлийн үеэс нутаглаж ирсэн <sup>138</sup>	1.6	0.5	1.0	1.0	0.7	0.9	0.9
Малын хашаа хувьчилж авсан	7.0	2.3	2.1	2.9	6.4	4.6	3.9
Худаг гаргуулж эзэмшиж байгаа	3.1	0.9	1.0	1.0	2.8	3.7	0.9
Тариалангийн газар байдаг	1.6	3.7	5.2	2.9	2.1	2.8	2.6
Зөвшөөрөлгүй	46.9	71.5	68.8	70.5	51.8	55.0	65.7

Тайлбар: Нэгээс дээш хариулттай асуулт тул нийлбэр нь 100% болохгүй..

**6.6.5 Байгалийн нөөц ашиглалт**

Сэлэнгэ аймаг нь манай орны ус, ашигт малтмал, бэлчээр, ой зэрэг байгалийн баялаг ихтэй газар нутгийн нэгд зүй ёсоор тооцогддог. Хуулийн дагуу байгалийн нөөц баялаг ашиглагч бүр төлбөр, татвар төлөхөөр заагдсан<sup>139</sup> ба иргэд, нөхөрлөлийн гишүүд болон компаниуд зэрэг бүхий л этгээдүүд дээрх төлбөр, татварын төлөх ёстой. Сар бүр сумын удирдлагынхан байгалийн нөөц ашигласан төлбөрийг төсвийн орлого болгон цуглуулж энэхүү орлогыг байгаль хамгаалал болон байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулдаг (Хүснэгт 5.41-р хүснэгтийг харна уу).

**Хүснэгт 5.41 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль хамгаалалд зарцуулагдах төлбөрийн хувь, хэмжээ (Монгол Улсын бүх сумдад)<sup>140</sup>**

Байгалийн баялгийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төрөл	Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хувь, хэмжээний доод хязгаар (нийт орлогын дүнгээс хувиар)
Ойн нөөц (гуалин, түлшний мод) ашигласны төлбөрийн орлого	85%
Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	50%
Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	35%
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого	15%
Газрын нөөцийн төлбөрийн орлого	15%

Газар ашигласны төлбөрийг голчлон малчдын бэлчээр ашигласны төлбөр, тариалангийн болон хадлангийн газрын төлбөр бүрдүүлж байна. Эдгээр төлбөрийг дараах хувь, хэмжээгээр тооцон ногдуулдаг.<sup>141</sup> Үүнд:

<sup>137</sup> Састэйнабилити Ийст Эйжия. 2015. Гацуурт төслийн нийгмийн суурь судалгааны тайлан, Өрхийн судалгаа.

<sup>138</sup> Монгол Улсад социалист нийгмийн үед байсан хөдөө аж ахуйн нэгдэл.

<sup>139</sup> Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль (2012).

<sup>140</sup> Law on Natural Resource Usage Fee (2012).


<sup>141</sup> Газрын төлбөрийн тухай хууль (1997).

- Нэг хонин толгойд ногдуулах бэлчээрийн газрын төлбөрийн хязгаар 0,01-0,03 хувь;
- Эзэмшиж, ашиглаж байгаа нэг га тариалан, хадлангийн газрын төлбөрийн хязгаар 0,01-0,03 хувь;
- Бусад зориулалтаар газар ашиглахад ногдуулах төлбөр (ерөнхийлөн оруулав).

Дээрх хүснэгтэд харуулсанчилан нийт төлбөрийн ердөө 15% нь байгаль орчны хамгаалалд зарцуулагддаг байна.

#### 6.6.5.1 Бэлчээрийн газар

Энэ бүлэгт дурдсанчилан Сэлэнгэ аймгийн газар нутгийн ихэнх хэсэг нь буюу 79% нь хөдөө аж ахуйн газар бөгөөд эдгээр газрыг малчид, тариаланчид, хадланчид голдуу ашигладаг. Өрхийн судалгаанд оролцогчдоос өвөлжөө, хаваржааны бэлчээр ба бэлчээрийн хүрэлцээний талаар бодлоо хэлэхийг хүссэн. Судалгаанд оролцсон Мандал сумын иргэдийн зөвхөн гуравны нэг нь (судалгаанд хамрагдагсдын 39%) тухайн суманд бэлчээр хангалттай байдаг гэж хариулсан бол Баянгол сумын хувьд гуравны хоёр нь (судалгаанд хамрагдагсдын 66%) мөн хариултыг өгсөн юм. Энэ нь дээр дурдсанчилан Мандал сумын газар нутгийн ихэнх хувийг ойн сан бүхий газар эзэлдэг тул бэлчээрийн газрын хүрэлцээ муу байдаг (жишээлбэл Түнхэл багийн судалгаанд хамрагдсан хүмүүсийн гуравны хоёр нь бэлчээрийн газар олддоггүй хэмээн хариулсан), цаашлаад малын тоо өсөхийн хэрээр бэлчээрийн төлөөх тэмцэл ихсэх шалтгаан болж байна (Зураг 5.40-р зургийг харна уу).



**Зураг 5.40 Өвөлжөө / хаваржааны бэлчээрийн хүртээмж<sup>142</sup>**

Ихэнх малчид өвөлжөө, хаваржааны газартай ч дээр дурдсанчилан уг газраа эзэмших эрхийн гэрчилгээгээ аваагүй байдаг тул газрын төлбөр тэр бүр төлдөггүй. Газар эзэмших гэрчилгээ албан ёсоор аваагүй ч өөрсдийн бэлчээргүй айл өрхүүд нийтийн эзэмшлийн бэлчээрийг дээр үеэс үнэ төлбөргүй уламжлан ашигласаар ирсэн байдаг.<sup>143</sup> Энэ нь тухайн газар нутгийн байгаль орчны

<sup>142</sup> Састэйнабилити Ийст Эйжия. 2015. Гацуурт төслийн нийгмийн суурь судалгааны тайлан, Өрхийн судалгаа.

<sup>143</sup> Монгол Улс дахь бэлчээрийн газрын ашиглалт, түүхэн ба эрх зүйн зохицуулалт.

хамгаалалд газрын төлбөрийн орлогоос зарцуулах шаардлагатай төлбөрийн хувь хэмжээнд нөлөөлж байна (доорх кейс судалгааг харна уу). Дээр тайлбарласанчлан газрын төлбөрөөс бүрдүүлсэн орлогын ердөө 15%-ийг байгаль хамгаалал, нөхөн сэргээлтэнд зарцуулахаар байгаа ба газар өмчлөх, эзэмших эрхээ бүртгүүлээгүй, улмаар газрын төлбөр төлөхгүй байгаа нь байгаль хамгааллын арга хэмжээнд сөрөг үр дагавар авчирч болзошгүй.

Сэлэнгэ аймгийн ойн сан бүхий газрын хэмжээ нь 2014 оны байдлаар 1.5 сая га буюу Монгол Улсын нийт ойн сан бүхий газрын 10.7%-ийг эзэлж байгаа ба энэ нь аймгийн нийт газар нутгийн 37.3%-ийг хамарч байна. Мандал сумын нийт газар нутгийн ихэнхийг (64%), ялангуяа Баянгол (13%) сумтай харьцуулахад Түнхэл багийн газар нутгийн дийлэнх хувийг ойн сан бүхий газар эзэлдэг. Ойн нөөцийг нутгийн малчид, суурин иргэд (түлээ модны чиглэлээр жижиг, дунд бизнес эрхлэгчид), бичил уурхай эрхлэгчид болон мод бэлтгэгч нөхөрлөлийнхөн ашигладаг ба үүнд, түлээ мод, самар, ургамал, жис жимсгэнэ зэрэг ойн дагалдах нөөц ашиглаж байна. Эдгээр нөөцийг ашиглах зөвшөөрлийг холбогдох байгууллагууд олгодог. Ойн нөхөрлөл тухайн нөөцийг хариуцаж (газар эзэмших эрхийн гэрчилгээний дагуу) байгаа тохиолдолд хэрэглэгчид тус нөхөрлөлөөс зөвшөөрөл авч, холбогдох төлбөрийг төлөх ба эсвэл ойн бүтээгдэхүүнийг нөхөрлөлөөс шууд худалдан авах боломжтой. Хэрэв тухайн газар нь сумын засаг захиргаанд хамаарагддаг бол ойн нөөц ашигласны төлбөрийг сумын захиргаанд төлнө.

Ойн нөхөрлөлүүд нь ойн нөөцийг ашиглах давуу эрхтэй хувьд гуалин, шургааг, дүнз зэрэг ойн нөөцөөс гадна самар, жимс, ургамал зэрэг өөр бусад ойн дагалт баялгийг өөрийн эзэмшиж буй газраасаа авч ашиглах эрхтэй байдаг. Түүнчлэн өөрийн эзэмшиж буй газрыг хадгалах, хамгаалах, ойн цэвэрлэгээг гүйцэтгэх үүргийг хүлээдэг. Үүнд,

- Хамгаалах: зөвшөөрөлгүй мод бэлтгэх, ойн түймрээс хамгаалах;
- Цэвэрлэх: үхжиж унасан хуурай мод, гишүү, мөчир зэргийг цэвэрлэж зарж ашиглах;
- Хадгалах: мод суулгах зэрэг орно.

"Ойн тухай хуулийн дагуу мод бэлтгэдэг компаниудад тавигддаг гол шаардлагын нэг нь эргүүлэн мод тарих юм. 100 м3 мод бэлтгэх бүрт 3 га газарт мод нэмж тарих ёстой. Улмаар ойн аж ахуй эрхэлдэг компаниуд байгаль орчин хамгаалах болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулах шаардлагатай. Аймгийн ИТХ уг төлөвлөгөөний арга хэмжээ болон зардлыг баталдаг." Сэлэнгэ аймгийн Байгаль орчны газрын даргатай хийсэн ярилцлага (ГТХЯ)

#### 6.6.5.2 Ашигт малтмалын нөөц

Сэлэнгэ аймаг нь ашигт малтмалын нөөцөөр баялаг нутаг тул Монгол Улсын эдийн засагт чухал стратегийн бүс нутаг юм. Ашигт малтмалын нөөцөд 450 сая тонн төмөр, 107 сая тонн нүүрс, 10 тонн алтны шороон орд, 56 тонн алтны үндсэн орд мөн шохойн чулуу орно.<sup>144</sup> Эдгээр нөөцийн гол ашиглагчид нь уул уурхайн компаниуд болон бичил уурхай эрхлэгчид бөгөөд 2011 оны байдлаар тус аймагт 197 компани идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна.<sup>145</sup> Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын ихэнх нь (78.6% нь) алтны хайгуулын болон олборлолтын лиценз эзэмшиж байгаа ба түүнчлэн барилгын материалын (15.2%), нүүрсний (2.4%) болон төмрийн (3.8%) ордуудад лиценз олгогдсон байна.

<sup>144</sup> [http://selenge.gov.mn/index.php?option=com\\_content&view=article&id=949:2014-02-17-04-47-13&catid=46:uu&Itemid=111](http://selenge.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=949:2014-02-17-04-47-13&catid=46:uu&Itemid=111).

<sup>145</sup> Усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах судалгааны эмхэтгэл, 2012, хуудас 210.

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам (4.6.3-р хэсэг буюу Газар ашиглалт хэсэгт дурдсан)-ын дагуу үйл ажиллагаа явуулахаар олон тооны бичил уурхайн нөхөрлөлүүд байгуулагдсан. Сэлэнгэ аймгийн хэмжээнд 1,300 бичил уурхайчид үйл ажиллагаа явуулж байгаа ба эдгээрээс 500 бичил уурхайчид 32 бичил уурхайн нөхөрлөлд нэгдсэн байна. Зарим нөхөрлөлүүд уул уурхайн компаниудын лицензийн талбайд үйл ажиллагаа явуулах сонирхолтой байдаг. Дээр дурдсан журам нь бичил уурхайн зориулалтаар байгуулагдсан баяжуулах цехийн үйл ажиллагааг мөн зохицуулдаг ба энэхүү цехийг бичил уурхайчид болоод орон нутгийн олон нийтэд үзүүлэх химийн аюултай бодисын нөлөөллийг бууруулах зорилгоор байгуулсан юм.

*"Хоёр бага оврын алт баяжуулах цех байдгийн нэг нь хувийн буюу "Сүрлэг Мандал" нөхөрлөлийн эзэмшилд байдаг. Хоёр дахь цехийг Чехийн засгийн газар болон Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгээр байгуулсан бөгөөд одоогийн байдлаар тус цехийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ нь батлагдаагүй тул үйл ажиллагаа явуулахгүй байна. Нутгийн бичил уурхай эрхлэгчдийн олборлосон алтыг эдгээр цехэд цианид болон мөнгөн ус мэтийн ямар нэгэн химийн бодис хэрэглэлгүй гравитацийн аргаар баяжуулан боловсруулдаг. Эрх зүйн орчин бүрдээгүйн улмаас саяхныг хүртэл ихэнх бичил уурхайчдын нөхөрлөл нь хайгуулын болон олборлолтын лицензгүйгээр үйл ажиллагаа явуулж байсан."*

Мандал сумын байгаль орчны мэргэжилтэнтэй хийсэн ярилцлага (ГТХЯ)

#### 6.6.5.3 Гадаргын усны нөөц

Сэлэнгэ аймгийн усан сан бүхий газрын тооллогыг Сэлэнгэ аймгийн Байгаль орчны газраас 2011 онд хийж дуусгасан.<sup>146</sup> Аймгийн нийт гадаргын усны нөөцийн гуравны хоёрыг (68.6%) гол мөрөн бүрдүүлдэг. Монгол Улсын хувьд чухалд тооцогддог аймгийн хамгийн том голуудад Сэлэнгэ, Орхон, Ерөө, Хараа голууд орно. Дараагийн хамгийн түгээмэл гадаргын усны нөөц нь булаг (нийт бүртгэлтэй усны нөөцийн 25.1%), нуур (3.2%) ба рашаан (3.1%) юм.


Гацууртын төслийн талбай нь Баянгол, Мандал сумын нутаг дэвсгэрт буюу Хараа-Ерөө голын сав газарт байрлаж байна. Хараа-Ерөө голын сав газрыг Хараа-Ерөө голын сав газрын захиргаа (ХЕГСГЗ) хариуцдаг ба энэхүү сав газрын захиргаа нь Монгол Улсын хувьд харьцангуй шинэлэг ойлголт бөгөөд 2012 онд батлагдсан Усны тухай хуулийн хүрээнд байгуулагдсан. Уг сав газрын захиргааны гол үүрэгт гол мөрний сав газруудыг хамгаалах, усны бохирдлыг хянах, гүний болон гар худгийн усны нөөцийг хянах буюу Хараа-Ерөө голын сав газрын ус ашиглалтын хяналт шинжилгээг удирдах зэрэг ажлууд орно. ХЕГСГЗ нь Гацууртын төслийн талбай (Хараа голын эхэнд) дахь гүний усны цооногт усны тоолуурыг суурилуулсан байна<sup>147</sup>.

Мандал сумын хувьд нийт гадаргын усны нөөцийн 88%-ийг голын ус, харин үлдсэн нөөцийг булаг, рашаан бүрдүүлдэг. Мандал суманд 2011 оны байдлаар 145 гадаргын усны эх үүсвэр буюу 127 гол, 15 булаг, 3 рашаан бүртгэгдсэн байна (Зураг 5.41-г харна уу).

<sup>146</sup> Сэлэнгэ аймгийн Байгаль орчны газар. 2015. Сэлэнгэ аймгийн усны нөөцийн жагсаалт.


<sup>147</sup> Хараа-Ерөө голын сав газрын захиргааны даргатай хийсэн ярилцлага (ГТХЯ)-ын үеэр авсан мэдээлэл.





**Зураг 5.41 Мандал сумын гадаргын усны нөөц**

2011 онд бүртгэгдсэн байдлаар Баянгол суманд 10 гол, 12 булаг, 1 рашаан байна (Зураг 5.42-г харна уу).



**Зураг 5.42 Баянгол сумын гадаргын усны нөөц**




Сум болон багийн түвшинд төслийн талбайн иргэдээс судалгаанд хамрагдагсдын ихэнх нь (ойролцоогоор 65% нь) усны нөөцийг эрх тэгш ашиглах боломжтой байдаг хэмээн хариулсан байна.

*"Мал усалгаа болон ундны усандаа бид булгийн ус хэрэглэдэг. Ундны усаа мал услахаасаа өмнө булгаас авдаг."*

Гацууртын тээврийн зам дагуу амьдардаг малчдын бүлэгтэй хийсэн ЗБЯ-ын үеэр өгсөн мэдээлэл

*"Бичил уурхайчид ундны усаа малчдын гар худгаас авдаг. Алт боловсруулах талбайд хүдэр баяжуулах хоёр цех байдаг ба боловсруулалтанд хэрэглэдэг усаа голоос татдаг. Усны тоолуураар ашиглаж буй усны тоо хэмжээг хянадаг ч усны чанарын хяналт шинжилгээг явуулдаггүй."*

Баянгол сумын бичил уурхайчидтай хийсэн ЗБЯ-ын үеэр дурдагдсан мэдээлэл



#### **Зураг 5.43 Усны нөөцийг эрх тэгш ашиглаж байгаа эсэх талаарх асуултанд өрхүүдийн хариулсан байдал (%)<sup>148</sup>**

Судалгаанд хамрагдагсдын ихэнх нь (бүх оролцогчдын 90-95%) олон нийтийн дунд ус ашиглалтын тал дээр бараг маргаан гардаггүй хэмээн хариулжээ. Малчин өрхүүдтэй харьцуулахад суурин газар ус ашиглалттай холбоотой илүү их маргаан үүсдэг (Зураг 5.43-г харна уу) байна. Ус ашиглалттай холбоотой маргаан бага гардаг, мөн усны нөөцийг харилцан тэгш эрхтэй ашигладаг зэргээс авч үзвэл төслийн талбайд бусад бүс нутагтай харьцуулахад усны нөөцийн хомсдол байхгүйг харуулж байгаа юм.

Гэсэн хэдий ч Бүлэг 6.3 Эдийн засаг-т тайлбарласанчлан өрхийн түвшинд усны хомсдол гол асуудал биш ч уул уурхайн үйл ажиллагааны улмаас усны нөөц багасах, бохирдох зэрэг сөрөг нөлөөллүүд үүсч энэ нь яваандаа хүндрэлтэй асуудал болж болзошгүй талаар судалгааны үеэр өрхийн гишүүд дурдаж байв. Судалгаанд харагдагсдын ихэнх нь (59-74%) одоогийн байдлаар ундны ус хангалттай байгаа гэж хариулсан бол үлдсэн нь ус хэт хатуулагтай тул ундны хэрэгцээнд тохиромжгүй (Баянгол сумын бүх багийн хувьд), эсвэл уул уурхайн үйл ажиллагааны (Мандал сумын Түнхэл баг) улмаас бохирдсон хэмээн хариулсан. Энэ нь ялангуяа Түнхэл багийн хэмжээнд

<sup>148</sup> Састэйнабилити Ийст Эйжия. 2015. Гацуурт төслийн нийгмийн суурь судалгааны тайлан, Өрхийн судалгаа.

усны бохирдол нийгмийн хамгийн чухал асуудлуудын нэг болж эхлээд байгаагийн илрэл юм. Мөн түүнчлэн Хараа – Ерөө голын сав газрын захиргаатай хийсэн ярилцлагын үеэр усны чанарын асуудал улам бүр чухалд тооцогдож эхлээд байгаа талаар онцолж байв. Ялангуяа жижиг гол, булгийн ус ихээр бохирдсон нь мал аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой бөгөөд энэ асуудлаас үүдэн Хараа-Ерөө голын сав газрын захиргаа нь Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт ус бохирдуулагчдын бүртгэлийг хийж эхэлсэн байна. Үүнд, Хараа-Ерөө голын сав газарт голын ус бохирдуулах үйл ажиллагаа явуулж болзошгүй компаниудыг тодорхойлох ба ойролцоогоор 900 гаруй компаниуд тоологдохоор байгаа юм.

"Хөрсний бохирдлын улмаас усны чанар муудсан. "Усны барилга ХХК" усны чанарын судалгаа хийсэн ба судалгааны үр дүнгээр усны бохирдлын шалтгаан болон нөлөөллийг тодорхойлсон байна. Усны чанартай холбоотойгоор а) сумын зүгээс усны нөөцийг хамгаалах тал дээр ямар ч арга хэмжээ аваагүй, мөн б) гэр хорооллын иргэд хөрсний бохирдлын улмаас бохирдсон худгийн ус хэрэглэж байгаа нь асуудал юм."

Мандал сумын орлогч Засаг даргатай хийсэн ярилцлага (ГТХЯ)

#### Хүснэгт 5.42 Усны хэрэглээтэй холбоотой үүсдэг маргааны давтамж (өрхүүдийн мэдээлснээр), (%)<sup>149</sup>

	Сум		Баг			Өрх	
	Баянгол	Мандал	Түнхэл	Хэрх	Бусад	Малчин	Суурин
Дандаа	2.3	3.7	5.1	3.5	1.4	2.5	3.5
Хаяадаа	3.0	5.4	2.6	7.1	4.1	2.5	5.5
Үгүй	94.7	90.9	92.3	89.4	94.5	95.0	90.9

Сумын байгаль орчны асуудал хариуцсан нэгж усны бохирдлыг хянах, харин лиценз эзэмшигч компани нь жилдээ дор хаяж хоёр удаа усны хяналт шинжилгээ хийх ёстой ч усны чанарын хяналт шинжилгээ тэр бүр хийгддэггүй. Бичил уурхай эрхлэгчид нь (Ерөө, Хүдэр, Бугант сумдад) усны хяналт шинжилгээ явагддаггүй, ус ашиглалтанд хяналт бага тавигддаг газруудаас ус хэрэглэдэг тул голын усыг химийн бодисоор их хэмжээгээр бохирдуулж байна. Айл өрхүүдийн зөвхөн 6-14% нь унданд хэрэглэж буй усныхаа чанарыг хянадаг хэмээн хариулсан. Айл өрхүүд ундны ус авч буй худгаа ажиглах маягаар л хянадаг. Харин Төмөр замын газрын худгаас ус ашиглаж буй иргэд тус байгууллага өөрсдийн худгийн усанд чанарын хяналт шинжилгээ хийдэг байх гэсэн таамаглалтай байдаг. Иймээс айл өрхүүдийн хийж буй усны хяналт шинжилгээг албан бус гэж үзэж болох юм.

#### Хүснэгт 5.43 Судалгаанд хамрагдагсдын дунд ундны усны чанараа шалгадаг хүмүүсийн эзлэх хувь

	Сум		Баг			Өрх	
	Баянгол	Мандал	Түнхэл	Хэрх	Бусад	Малчин	Суурин
Тийм	6.3	11.3	9.7	13.9	5.9	11.1	8.8
Үгүй	93.7	88.7	90.3	86.1	94.1	88.9	91.3

Бусад орон нутгийн адилаар өрхийн судалгаанд оролцогчдын тал нь малаа нэг эх үүсвэрээс усалж, харин өөрсдийн ундны усаа өөр эх үүсвэрээс авдаг гэж хариулсан байна. Өрхийн судалгааны үеэр ихэнх оролцогчид (89-96%) зун, хавар, намрын улиралд малаа гол, булгаас

<sup>149</sup> Састэйнабилити Ийст Эйжия. 2015. Гацуурт төслийн нийгмийн суурь судалгааны тайлан, Өрхийн судалгаа.

усалдаг бол өвлийн улиралд гар худаг ашигладаг гэж хариулж байв. Энэ нь бүх улирлын турш мал болон хүн амын амьжиргаанд хангалттай ус байдгийг харуулж байгаа юм. Үйлдвэрийн зориулалтаар ус ашиглаж буй тохиолдолд өдөрт 50м<sup>3</sup>-аас бага ус ашигладаг компаниуд аймгийн Усны газраас зөвшөөрөл авах ёстой. Хэрэв түүнээс их ус ашиглах бол Хараа-Ерөө голын сав газрын захиргаагаар ус ашиглах дүгнэлт гаргуулан аймгийн Байгаль орчны газартай ус ашиглах гэрээ байгуулах шаардлагатай. Тариалан эрхлэгчдийн хувьд ус ашиглах нөхцөл нь мөн өөр байдаг. Голоос шууд ус татаж ашиглаж байгаа тохиолдолд ихэнх тариалан эрхлэгчдийн ашиглаж буй усны хэмжээнд хяналт тавьдаггүй тул тэд ихэвчлэн гол, мөрний ойролцоо тариалан эрхэлдэг. Ус ашиглах зөвшөөрөл олгох үйл явц болоод төлбөрийн ялгаа их тул бохирдуулагч этгээдийг олоход болон хариуцлага тогтооход бэрхшээлтэй байдаг. Сав газрын захиргаа ус ашиглах зөвшөөрөл олгох үйл явцад оролцсоноор устай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд түлхэц болж байгаа ч нөөц, чадавхийг бэхжүүлэх шаардлагын улмаас хяналт шинжилгээний ажил удаашралтай явагдаж байна.

### **6.6.6 Дүгнэлт**

Газар ашиглалт болон байгалийн нөөцтэй холбоотой олон чухал асуудлуудыг дурдаж болохоор байна. Үүнд, төслийн талбайд хамааралтай хамгийн гол асуудал нь бэлчээрийн даац хэтрэх, үүнээс үүдэлтэйгээр бэлчээр талхлагдаж буй хүндрэлийг нэрлэж болно. Бэлчээр талхлагдах асуудлын гол шалтгаан нь малчид болон мал бүхий иргэд 2011-2014 оны хооронд малын тоо толгойгоо 14%-иар нэмэгдүүлсэнтэй холбоотой. ЗБХ-ийн үеэр бэлчээрийн даац хэтэрсэн шалтгааныг шилжин ирэгсэдтэй ерөнхийдөө холбон тайлбарлаж байгаа хандлага ажиглагдсан ч шилжин ирэгсдийн тоо харьцангуй бага байгаа, эсрэгээрээ уугуул малчдын малын тоо ихээр өссөн нөхцөл байдлыг тооцон үзвэл бэлчээр талхлагдах асуудлыг шилжин ирэгсэдтэй холбон тайлбарлах нь өрөөсгөл ойлголт юм. Мандал болон Баянгол сумдад бэлчээрийн даац хэтэрснээс тухайн бүс нутгийн зарим хэсэгт малчдын хооронд, мөн малчид, тариаланчдын хооронд газрын маргаан үүсэх шалтгаан болоод байна. Бэлчээрийн газрын маргаан гарах давтамж нь өөр өөр байгаа ба судалгаанд оролцогчдын гуравны нэг нь сар бүр газрын маргаан гардаг талаар мэдээлж байв. Мандал суманд бэлчээр ашиглалттай холбоотой газрын маргаан хамгийн их гарч байгаа нь Баянгол сумтай харьцуулахад тухайн суманд бэлчээрийн талбай харьцангуй бага, улмаар энэ нь бэлчээрийн даац хэтрэхэд хүргэсэнтэй холбоотой юм.

Малчдын ихэнх нь өвөлжөө, хаваржааны газраа эзэмшдэг ч тэр бүр газар эзэмших эрхийн гэрчилгээгээ аваагүй, улмаар газрын төлбөр төлдөггүй байна. Энэ нь газрын төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн хэмжээнд сөргөөр нөлөөлөх юм. Учир нь холбогдох журмын дагуу газрын төлбөрийн орлогын 15%-ийг байгаль хамгаалалд зарцуулахаар заасан ба газар эзэмших эрхээ бүртгүүлэн газрын төлбөрөө төлөхгүй байгаа нь энэ зориулалтаар зарцуулагдах орлого багасахад нөлөөлж болзошгүй байна. Судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь өвөлжөө, хаваржааны газраа эзэмших эрхийн гэрчилгээгээ аваагүй байгаа нь ажиглагдлаа. Үүнд, судалгаанд оролцогчдоос Түнхэл багийн 69%, Хэрх багийн 71%, Мандал сумын 70%, Баянгол сумын 50% орчим нь газар эзэмших гэрчилгээгээ аваагүй хэмээн хариулсан байна.

Түүнчлэн, судалгаанд оролцогчдын ихэнх нь ус ашиглалтын талаар орон нутгийнхны дунд маргаан гардаггүй талаар мэдэгдэж байв. Ус ашиглалтын талаар маргаан бага гардаг, мөн усыг

эрх тэгш ашиглах боломжтой зэргээс харвал Төсөл хэрэгжих бүс нутагт усны хүрэлцээтэй холбоотой асуудал (Монгол орны бусад бүс нутагтай харьцуулахад) байхгүй байгааг харуулж байгаа юм. Одоогоор өрхийн хэрэгцээний устай холбоотой асуудал үүсээгүй байгаа ч цаашдаа уул уурхайн төслийн улмаас усны нөөц, чанарт нөлөөлөл бий болж болзошгүй байна. Энэ нь уул уурхайн төслөөс үүсэж болзошгүй сөрөг нөлөөллийн талаар айл өрхүүдийн илэрхийлсэн гол асуудлуудын нэг байв. Энэ нь ирээдүйд ямар нэгэн бодит нөлөөллөөс үл хамааран усны бохирдол ялангуяа Түнхэл багийн хувьд гол асуудал болох төлөвтэй байгааг харууллаа.

## **6.7 ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА БА АЮУЛГҮЙ БАЙДАЛ**

### **6.7.1 Оршил**

Энэ бүлэгт төслийн бүсийн орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал ба аюулгүй ажиллагааны талаарх суурь нөхцөл байдлыг танилцуулах ба эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийн тогтолцоо, гэмт хэрэг болон нийгмийн дэг журмыг (мөн хүний эрхийн асуудлыг оруулан) авч үзнэ.

### **6.7.2 Ашигласан тоо мэдээ**

Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны талаарх энэхүү бүлэгт 4 түвшний (аймаг, сум, баг, өрхийн) мэдээлэлд хийсэн дүн шинжилгээг багтаалаа. Үүнд, Сэлэнгэ аймгийн төрийн болон үйлчилгээний байгууллагууд, Мандал, Баянгол сумдууд болон Түнхэл, Хэрх багуудын төрийн байгууллагууд, Үндэсний статистикийн мэдээллийн цахим хуудаснаас авсан хоёрдогч мэдээлэл, мөн уг сэдвийн хүрээнд орон нутгийн гол талуудтай хийсэн ярилцлага, мөн олон нийтийн бүлгүүдтэй хийсэн зорилтот бүлгийн хэлэлцүүлгийн мэдээллийг ашиглалаа. Түүнчлэн өрхийн судалгааны хүрээнд цуглуулсан мэдээллийг ашиглав.

### **6.7.3 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ ба стандарт**

#### **6.7.3.1 Монгол Улсын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний менежментийн тогтолцоо ба стандарт**

Монгол Улсын эрүүл мэндийн тогтолцоонд социализмын үеэс хойш томоохон шинэчлэлүүд хийгдсээр ирсэн. Монгол Улсын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний давуу тал нь сайн бэлтгэгдсэн боловсон хүчин, үйлчилгээний хэрэгцээ болон орон нутгийн нөхцөл байдлаа ойлгож мэдсэн байдал, стратегийн төлөвлөгөө, төвлөрсөн бус менежмент, мэдээллийн хүрэлцээ, ил тод байдал болон эрүүл мэндийн үйлчилгээний удирдлага, зохион байгуулалтад эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн оролцоо хангагдсан байдал зэрэгт юм. Харин эрүүл мэндийн салбарт тулгардаг бэршээлүүдэд орчин үеийн технологи, оношлогооны техник, багаж хэрэгслэлийн дутагдалтай байдал, буруу оношлогоо, эрүүл мэндийн үйлчилгээний системийн хүнд суртал, эмчилгээ ба урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хуваарилдаг хүний болон санхүүгийн нөөцийн үр ашиггүй байдал, газар зүйн байршил болоод санхүүгийн хүндрэлээс хамааран үйлчлүүлэгчдэд хүрч үйлчилж чадахгүй байх зэрэг асуудлууд ордог.<sup>150</sup>

Монгол Улсад эрүүл мэндийн үйлчилгээг засаг захиргааны нэгж тус бүрээр хүргэдэг ба хуулийн дагуу Монгол Улсын иргэн бүр эрүүл мэндийн үйлчилгээнд бүртгүүлж жил бүр үзлэгт хамрагдах шаардлагатай байдаг. Эрүүл мэндийн үйлчилгээг улсын болон хувийн хэвшлийн салбарын үйлчилгээгээр дамжуулан бага, дунд, дээд гэсэн гурван шатанд олон нийтэд хүргэж байгаа<sup>151</sup> ба дийлэнхийг нь эрүүл мэндийн улсын байгууллагуудаар дамжуулан хүргэж байна.<sup>152</sup>

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг төвлөрсөн бус байдлаар буюу аймгийн түвшинд эхийн эрүүл мэнд, хүүхдийн эрүүл мэнд, халдварт өвчин, халдварт бус өвчин гэсэн дөрвөн үндсэн чиглэлээр

<sup>150</sup> Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Монгол Улс. 2012. Эрүүл мэндийн үйлчилгээний бүтэц, Монгол Улс.

<sup>151</sup> Эрүүл мэндийн салбарын 2006 – 2015 он хүтрэлх стратегийн мастер төлөвлөгөө.

<sup>152</sup> Дэлхийн эрүүл мэндийн байгууллага ба Эрүүл мэндийн яам, Монгол Улс. 2012. Эрүүл мэндийн үйлчилгээний тогтолцоо, Монгол Улс.

тусламж, үйлчилгээ үзүүлэхээр зохион байгуулсан байдаг. Үндсэн багцад эрүүл мэндийг дэмжих, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчилгээ хийлгэх үйлчилгээ багтдаг ба анхан шатанд эдгээр үйлчилгээг үнэ төлбөргүй хүргэдэг. Нэмэлт багцад хэвтүүлэн эмчлэх болон амбулаторийн үйлчилгээ зэрэг дунд ба дээд шатанд авч болох тусламж, үйлчилгээ багтах ба мөн түргэн тусламж, урт хугацааны эмчилгээ хийлгэх үйлчилгээ үзүүлдэг. Дунд болон дээд шатны үйлчилгээ нь үндэсний эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжигддэг бөгөөд өвчтөн өөрөө 10-15%-ийн даатгалын мөн төлөх шаардлагатай байдаг. Халдварт өвчний хяналт, аюулгүй, цэвэр усан хангамж, эрүүл ахуй, эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн боловсрол олгох, өвчнөөс урьдчилан сэргийлэх, орчны эрүүл мэнд зэрэг хүн амд чиглэсэн үйлчилгээг бага болон дунд шатанд мөн хүргэдэг. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд ХДХВ/ДОХ зэрэг урт хугацааны эмчилгээ мөн багтсан байдаг (Хүснэгт 5.44-г харна уу).

Багийн туслах эрүүл мэндийн ажилтан, эсвэл эмч нар нь дунд шатны эрүүл мэндийн ажилтны түвшинд бэлтгэгдсэн байдаг ба өөрийн гэртээ ажиллаж амьдран малчин гэр бүл, олон нийтэд эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг. Багийн эмч нар сумын эрүүл мэндийн төвөөс цалинждаг. 2011 оны байдлаар 1,058 багийн эмч сумын эрүүл мэндийн төв, сумын эмнэлэгт ажиллаж байсан бөгөөд 10,000 хүн тутамд сум, өрхийн эрүүл мэндийн төвийн 3.4 эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх эмч нар ногдож байв. Мөн 2011 онд 1,677 эмч 3,069 эмнэлгийн ор бүхий 1,184 хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байсан байна. Ерөнхийдөө Монгол Улсад эрүүл мэндийн ажилтнуудын тоо олон байдаг ч эмч болон сувилагчийн тоог харьцуулвал сувилагчийн тоо багатай байдаг. Эрүүл мэндийн сургуулиуд сургалтын төлбөрийн орлогоос санхүүждэг тул тэд аль болох өндөр төлбөр төлөх оюутнуудыг ихээр төгсгөснөөс улсын хэмжээнд сувилагчид ногдох эмчийн тоо нь харьцангуй өндөр болсон байна. Мөн эмч нар хөдөө орон нутагт ажиллах сонирхолгүй байдгаас эмч нарын тоо хот суурин газарт өндөр байгаа ба Улаанбаатар хотод 10,000 хүн амд ногдох эмчийн тоо нь орон нутагтай харьцуулахад 1.5 дахин их байгааг холбогдох мэдээллээс харж болно.<sup>153</sup>

Монгол Улсад Европ болон бусад хөгжиж буй орнуудтай харьцуулахад эмнэлгийн дундаж тоо хоёр дахин илүү байгаа ч 1998 оноос хойш буурсан байна. Монгол Улсад хэвтэн эмчлүүлэгчдэд ногдох эмнэлгийн орны тоо буурсан ч 10,000 хүнд 68.1 байгаа нь мөн харьцангуй өндөр тоо юм (2011 оны хамгийн сүүлийн үеийн статистик дээр үндэслэсэн).<sup>154</sup> Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх дундаж хоногийн тоо 1990 онд 12.3 хоног байсан бол 2011 онд 8.1 хоног болж буурсан байна. 2011 оны байдлаар 10,000 хүнд ногдох хэвтэн эмчлүүлэх болон амбулаторийн эмчилгээ хийлгэсэн өвчтөний тоо тус тус 2,491.6 ба 6,187.2 байв. Амбулаторийн болон хэвтэн эмчлүүлэгчдийн тоо нийслэл хотод хөдөө орон нутгаас их байдаг нь Улаанбаатар хотод хүн амын төвлөрөл өндөр, мөн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж илүү байдагтай холбоотой.

Монгол Улсын хэмжээнд хувийн хэвшлийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийн тоо 2005 онд 683 байсан бол 2011 онд 1,184 болж ихэсчээ. Ихэнх нь 10-20 ортой болон/ эсвэл амбулаторийн эмчилгээ хийдэг эмнэлэг байна. Мөн сүүлийн жилүүдэд эрүүл мэндийг дэмжих, ХДХВ/ДОХ, гэр бүлийн хүчирхийлэл, хар тамхи, архины хэт хэрэглээний асуудлаар олон нийтийн

<sup>153</sup> Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Монгол Улс. 2012. Эрүүл мэндийн үйлчилгээний тогтолцоо, Монгол Улс.

<sup>154</sup> Дэлхийн эрүүл мэндийн байгууллага ба Эрүүл мэндийн яам, Монгол Улс. 2012. Эрүүл мэндийн үйлчилгээний тогтолцоо, Монгол Улс.



мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулдаг чадавхитай ТББ-уудын тоо нэмэгдэж байна.

#### Хүснэгт 5.44 Монгол Улсад үзүүлж буй эрүүл мэндийн үйлчилгээний тойм, 2012<sup>155</sup>

Үйлчилгээ үзүүлж буй байгууллага	Үзүүлэх үйлчилгээ
<b>Анхан шат – улсын санхүүжилттэй</b>	
Багийн эрүүл мэндийн ажилтан (орон нутаг)	Өөрийн гэртээ ажиллаж амьдардаг бэлтгэгдсэн дунд шатны эрүүл мэндийн ажилтан дараах эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлдэг. Үүнд, өрхөөр явж үзлэг хийх, жирэмсний болон төрсний дараах тусламж үйлчилгээ, эрүүл мэндийг дэмжих боловсрол олгох, өвчний хяналт, урьдчилан сэргийлэх болон халдварт өвчний хяналт тавих, сумын эмнэлгийн удирдамжийн дагуу зарим тохиолдолд үзлэг хийх, зайлшгүй шаардлагатай эмээр хангах, олон нийтийн эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг орно.
Сумын эрүүл мэндийн төв ба сум дундын эмнэлэг (орон нутаг)	Орны дундаж тоо 15-30; Эмч (анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх эмч, өрхийн эмч, ерөнхий эмч), сувилагч, эх баригч, болон туслах ажилтнууд 24 цагийн турш үйлчилгээ үзүүлдэг. Үүнд, эрүүл мэндийг дэмжих боловсрол олгох, урьдчилан сэргийлэх үйлчилгээ (жишээ нь, дархлаажуулалт болон шинжилгээ), өвчний ажиглалт, халдварт өвчний хяналт тавих, эмийн жор бичих зэрэг амбулаторийн үйлчилгээ, мөн эх барих, жижиг мэс засал, оношлогоо шинжилгээ, түргэн тусламж зэрэг хэвтүүлэн эмчлэх үйлчилгээ мөн гэрээр үзлэг хийх, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээ, өвчин намдаах тусламж, нөхөн сэргээх тусламж үйлчилгээ зэрэг орно.
Өрхийн эрүүл мэндийн төв (суурин газрууд)	Ажлын цагаар ажиллах өрхийн эмч, сувилагч ажилтнуудаас бүрддэг. Урьдчилан сэргийлэх тусламж (жишээ нь, тарилга, хорт хавдрын шинжилгээ), өвчний ажиглалт, халдварт өвчний хяналт шинжилгээ, оношлогоо шинжилгээ, айл өрхөд очиж үзлэг хийх, онцгой байдлын буюу гэнэтийн тусламж (хязгаарлагдмал), нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээ, өвчин намдаах тусламж зэрэг амбулаторийн үйлчилгээ, мөн нөхөн сэргээх тусламж үйлчилгээ орно.
<b>Хоёрдогч шат (10%-ийг өвчтөн төлөх шаардлагатай)</b>	
Дүүргийн эмнэлэг	Эмч сувилагч, эх баригч, туслах ажилтан 24 цагийн турш ажилладаг 200-300 ортой эмнэлэг. Үзүүлэх үйлчилгээнд дотор, мэс засал, эх барих, эмэгтэйчүүд, сэтгэл судлал ба сэтгэцийн үзлэг, арьс өнгө, мэдрэлийн үзлэг, мөн эмийн жор бичих зэрэг амбулаторийн үйлчилгээ, түүнчлэн оношлогооны шинжилгээ (рентген болон ЭХО гэх мэт), түргэн тусламж, олон нийтийн эрүүл мэндийн үйлчилгээ орно.
17 аймгийн эмнэлэг	Эмч (мэргэшсэн болон ерөнхий), сувилагч, эх баригч, туслах ажилтан 24 цагийн турш ажилладаг ба 50,000-100,000 хүнд үйлчилдэг 105-500 ортой эмнэлэгтэй. Нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламж үйлчилгээнд дотор, мэс засал, эх барих, эмэгтэйчүүд, сэтгэл судлал ба сэтгэцийн үзлэг, арьс өнгө, мэдрэлийн үзлэг эмийн жор бичих зэрэг амбулаторийн үйлчилгээ, оношлогоо шинжилгээ (рентген болон ЭХО гэх мэт), мөн түргэн тусламж, олон нийтийн эрүүл мэндийн үйлчилгээ орно.
<b>Гуравдагч шат (15%-ийг өвчтөн төлөх шаардлагатай)</b>	
Бүсийн оношлогоо эмчилгээний төв (нийт 4 эмнэлэг)	Нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламж үйлчилгээнд дотор, мэс засал, эх барих, эмэгтэйчүүд, сэтгэл судлал ба сэтгэцийн үзлэг, арьс өнгө, мэдрэлийн үзлэг, эмийн жор бичих зэрэг амбулаторийн үйлчилгээ, мөн оношлогоо шинжилгээ ба түргэн тусламж орно.
Улсын төв эмнэлэг (нийт 3 эмнэлэг)	Нарийн мэргэжлийн эмчилгээний онцлогоос хамааран өөр өөр байх ба зүрх судасны мэс засал, мэдрэлийн мэс заслын, бүдүүн нарийн гэдэсний мэс засал, цусны ба халдварт өвчин, сэтгэцийн эрүүл мэнд, наркологи, уламжлалт анагаах ухаан, эх ба хүүхдийн эрүүл мэндийн эмчилгээ орно. Мөн хоёрдогч шатанад үзүүлж чадаагүй бусад нарийн мэргэжлийн эмчилгээ, хэвтүүлэн эмчлэх болон амбулаторийн үйлчилгээ, оношлогоо шинжилгээ, яаралтай тусламж ордог.
<b>Хувийн салбар (үйлчилгээний төлбөрийг төлөх шаардлагатай)</b>	
Төв эмнэлэг	Шүдний болон уламжлалт анагаах ухааны мэргэшсэн амбулаторийн үйлчилгээ

<sup>155</sup> Эрүүл мэндийн яам, 2005

Хувийн эмнэлэг	Дотор, эх барих, эмэгтэйчүүд, мэдрэлийн эмчийн үзлэг гэх мэт мэргэшсэн эмнэлэг
Сувилал	Нөхөн сэргээх ба уламжлалт анагаах ухааны эмнэлгийн үйлчилгээ

#### 6.7.3.2 Төслийн бүс дэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ ба стандарт

Сэлэнгэ аймагт ойролцоогоор 1,113 мэргэжилтэн бүхий 98 эрүүл мэндийн байгууллага байдаг ба ихэнх эрүүл мэндийн байгууллагууд нь аймгийн төв (Сүхбаатар) болон Мандал суманд төвлөрсөн байдаг. Эдгээр нь:

- Аймгийн төв Сүхбаатарт хоёрдогч шатны үйлчилгээ (дотор, мэс засал, эх барих, эмэгтэйчүүд, сэтгэл судлал ба сэтгэцийн үзлэг, шүд, арьс өнгөний болон мэдрэлийн системийн үзлэг, эмийн жор бичих зэрэг амбулаторийн тусламж үйлчилгээ, оношлогоо шинжилгээ [рентген болон ЭХО] эрүүл мэндийн яаралтай тусламж үйлчилгээ гэх мэт түргэн тусламж болон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг).
- Хоёрдогч шатны нарийн мэргэжлийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх 7 өрхийн эрүүл мэндийн төв нь Сүхбаатар (4) ба Мандал (3) сумдад байрладаг.
- Сэлэнгэ аймгийн 14 сум 6 багт байрлах эрүүл мэндийн 20 төв, нэг аймгийн эмнэлгээс Сайхан, Мандал, Хөтөл сумдын иргэд анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг авдаг.
- Хөдөө орон нутгийн өндөр настангууд (55-аас дээш настай эмэгтэй, 60-аас дээш настай эрэгтэй хүмүүсийг өндөр настанд тооцно) нөхөн сэргээх болон уламжлалт анагаахын эмчилгээг хувийн сувилалуудаас үнэгүй авдаг. Мандал суманд (Түнхэл баг) хувийн, харин Баянгол суманд олон нийтийн сувилал байдаг.
- Сэлэнгэ аймгийн төвд болон Мандал сумын эмнэлэгт төрөхийн өмнөх ба дараах тусламж, үйлчилгээ эхчүүдэд үзүүлдэг эмэгтэйчүүдийн төвүүд байдаг.
- Сэлэнгэ аймгийн төв ба Мандал суманд шүд, нэгдсэн уламжлалт анагаах ухааны ба орчин үеийн анагаах ухааны чиглэлээр мэргэшсэн 11 хувийн эмнэлэг байдаг.

Аймаг, сумын түвшинд хүн амыг тухайн хот суурины төвлөрлийн байдлаас хамааран анхан, хоёрдогч шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээгээр хангадаг. Монгол Улсын эрүүл мэндийн нийт байгууллагуудын 4% нь Сэлэнгэ аймагт байрлаж байна. Мандал сум нь 25,693 хүн амтай ба тус суманд 1 сум дундын эмнэлэг, 3 өрхийн эрүүл мэндийн төв, 1 сумын эрүүл мэндийн төв, 1 сувилал, 2 хувийн хэвшлийн эмнэлэг гээд 9 эрүүл мэндийн байгууллагатай. Баянгол суманд 2 түргэн тусламжийн төв ба лаборатори бүхий сумын эрүүл мэндийн төв 1, өндөр настны (нийт 19 эрүүл мэндийн ажилтнуудтай) сувиллын газар 1 байдаг. Түнхэл багт анхан шатны эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг 1 эрүүл мэндийн төв байдаг. Австрийн Засгийн газрын хөрөнгөөр баригдсан бөгөөд ахмад настны хувийн сувилал мөн Түнхэл багт байдаг байна. Энэ сувилалд уламжлалт анагаах ухаан, орчин үеийн анагаах ухааны хосолсон үйлчилгээг үзүүлдэг (зөвхөн ахмад настанд бус). Баянгол сум ба Түнхэл багт эмэгтэйчүүдийн төрөхийн өмнөх болон төрсний дараах тусламж үйлчилгээ үзүүлдэг төв байдаггүй тул эхчүүд Мандал сумын эмнэлэгт очиж төрдөг.

**Хүснэгт 5.45 Эрүүл мэндийн байгууламжуудын тоо, аймгийн ба сумын түвшний эмнэлгийн ор ба эрүүл мэндийн ажилтны тоо, 2014<sup>156</sup>**

	Улсын дундаж	Сэлэнгэ аймаг	Мандал сум	Баянгол сум
Эрүүл мэндийн байгууллагын тоо	2,706	98	9	3
Эмч	9,300	189	36	3
Эмийн санч	1,611	15	3	-
Эрүүл мэндийн ажилтан (сувилагч, эх барих эмч, багийн туслах эмч болон бусад туслагч нар)	18,317	545	114	11
Бусад эмнэлгийн ажилчид	-	370	84	5
Эмнэлгийн орны тоо	20,576	624	115	12
Нэг эмчид ногдох хүмүүсийн тоо	310	547	490	-
Нэг сувилагчид ногдох хүмүүсийн тоо	263	366	195	-

Сэлэнгэ аймгийн хүн ам сүүлийн жилүүдэд ихэссэнтэй холбоотой эмч нарын тоо мөн тогтмол нэмэгдэж байна. 2014 онд 2013 онтой харьцуулахад эмчийн тоо 7-оор (3.7%) өссөн хэдий ч энэ хэмжээгээр эмнэлгийн орны тоо нэмэгдэхгүй байгаа юм. Орны тоо мөн үеийнхээс 3-аар буурсан байна. Эмчийн тоо нэмэгдсэн ч өвчтөнүүдийн тоо 10% гаруй өссөн нь тооны харьцааг тэнцвэржүүлсэн. Тиймээс Сэлэнгэ аймгийн эмч нарын тоо нэмэгдсэн хэдий ч эрэлт хэрэгцээг хангахуйц хангалттай бус байна.

Улсын дунджаар 10,000 хүн амд ногдох эмчийн тоо 32.3, сувилагчийн тоо 38.1 байгаа юм. Энэ нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллага [ДЭМБ]-аас гаргасан хамгийн доод хэмжээ буюу 10,000 хүн амд тус бүр 23 эмч, сувилагч, эх баригч ногдох шаардлагатай харьцуулахад өндөр байна.<sup>157</sup> Мандал суманд 10,000 хүн амд 20.4 эмч, 51.4 сувилагч байхад Сэлэнгэ аймагт 18.3 эмч, 27.3 сувилагч байдаг. Эдгээр тоо нь Мандал суманд эмч ихээхэн дутагдалтай ч сувилагч харьцангуй их байдаг байхад Баянгол суманд ДЭМБ-аас гаргасан шалгуур дооод үзүүлэлт болон улсын дунджаас хамаагүй бага байгааг харуулж байна. Дээрх үзүүлэлтээс харахад эрүүл мэндийн ажилтнуудын тоо хангалтгүй байгаа нь төслийн талбайн хувьд чухал асуудлуудын нэг болж байна. Үүнийг баталгаажуулан ГТХЯ болон ЗБХ-ийн үеэр (доорх хүснэгтэд харуулсанчлан) оролцогчид эрүүл мэндийн тусламж, эмч, үйлчилгээний хүртээмж дутагдалтай байгаа талаар онцлон тэмдэглэсэн юм.

"Баянгол сумын эмнэлгийн ажилтнууд Баянгол сумын оршин суугчид болон жуулчид гээд ойролцоогоор 1,570 хүнд үйлчилж байна. Баянгол сум нь ОХУ-ын хилийн дагуу байршилтай тул маш их өвчтөн (аялал жуулчлалын, авто замын осол гэх мэт) хүлээн авдаг. Үйлчилгээний эрэлт хэрэгцээг хангах хэмжээний мэргэжлийн чадавх Баянгол суманд дутмаг байна. Хөдөө орон нутаг ба сумын төвийн эмнэлэг, мөн сум дундын эмнэлэгт эмч нар дутагдалтай байгааг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй юм."

Баянгол сумын Эрүүл мэндийн төвийн дарга (ГТХЯ)

"Сэлэнгэ аймгийн сумдад эмнэлгийн мэргэжилтнүүдийн тоо дутагдалтай байгаа бөгөөд нийт аймгийн хүн амын хэрэгцээг хангасан үйлчилгээ үзүүлэхэд 9 нэмэлт эмч хэрэгтэй байгаа юм."

Сэлэнгэ аймгийн Нийгмийн халамжийн хэлтэс

<sup>156</sup> Сэлэнгэ аймгийн тайлан, 2014; Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2014.

<sup>157</sup> Дэлхийн эрүүл мэндийн байгууллага. 2015. Эрүүл мэндтэй холбоотой МХЗ-д хүрэх – Хөдөлмөрийн нөөц хэрэгтэй. [www.who](http://www.who).

Эмч нарын тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа хэдий ч орон нутагт мэргэжилтнүүд дутагдсаар л байна. Баянгол сумын Эрүүл мэндийн төвийн даргын мэдэгдсэнээр мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байгаа тул мэргэжилтнүүд өөрсдийн үр чадварыг төрөлжүүлж олон чиглэлийн үйлчилгээ үзүүлэх шаардлага гардаг. Жишээ нь, 1 эмч түргэн тусламжийн сургалтанд (улсын зардлаар), 2 сувилагч, 1 эмч эмчлэх эрх авах буюу эмч болох (өөрийн зардлаар) сургалтад суусан. Эмэгтэйчүүдийн эмч дутагдалтай байдаг ба энэ төрлийн үйлчилгээний эрэлт хэрэгцээ өндөр байгаа тул сум одоогийн байдлаар нэг эмчийг эмэгтэйчүүдийн эмчээр бэлтгэх төлөвлөгөөтэй байгаа юм.

Төвдийн уламжлалт анагаах ухаанд үндэслэсэн Монголын уламжлалт анагаах ухааны эм, эмчилгээ нь (Хүснэгт 5.46-г харна уу) 20-р зууны дунд үеэр хавчигдан бараг устсан ч одоо албан ёсоор хүлээн зөвшөөрөгдөн дахин сэргэж эхлээд байна. Монголын уламжлалт анагаах ухаан нь дээр үеэс ихэвчлэн гэр бүлийн хүрээнд дамжиж ирсэн уламжлал юм. Баянгол сумын Эрүүл мэндийн төвд уламжлалт эмчилгээ үзүүлдэг тасаг байдаг ба ер нь монголчууд уламжлалт анагаахын эмчилгээнд хамрагдах нь түгээмэл байдаг. Түүнчлэн Баянгол сумын иргэдтэй хийсэн ярилцлага (ГТХЯ)-ын үеэр энэ төрлийн эмчилгээ хийлгэх нь иргэдийн дунд маш түгээмэл байдаг талаар дурдаж байв.<sup>158</sup> Хүснэгт 5.46-д харуулсанчлан Монгол Улсад улсын болон хувийн эмнэлгүүд уламжлалт анагаах ухааны эмчилгээг ихээр санал болгодог ба энэ төрлийн эмчилгээ нь ихэвчлэн орчин үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ дутмаг алслагдмал хөдөө орон нутгийн газруудад илүү түгээмэл байдаг.

#### Хүснэгт 5.46 Монголын уламжлалт эрүүл мэндийн үйлчилгээ


Уламжлалт үйлчилгээ үзүүлэгч	Үзүүлсэн үйлчилгээ
Аймаг, дүүргийн ерөнхий эмнэлэг, эрүүл мэндийн төв, поликлиник	Ихэнх дүүргийн эмнэлэг нь уламжлалт анагаах ухааны тасагтай байдаг ба аймгийн эмнэлэгт мөн уламжлалт анагаахын эмчилгээ хийлгэхээр хэвтүүлэн эмчлүүлэх өвчтөнд зориулсан ор байдаг.
Бүсийн оношлогоо, эмчилгээний төв (аймгууд)	Улаанбаатар хотын ихэнх улсын хэмжээний эмнэлэг нь уламжлалт анагаахын чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг.
Уламжлалт анагаах ухааны чиглэлээр хэвтүүлэн эмчлэх ба амбулаторийн үйлчилгээ үзүүлэх эмнэлэг	Уламжлалт анагаах ухааны 10 жижиг эмнэлэг байдаг ба эдгээр нь 10-20 ортой. Улсын эрүүл мэндийн төвүүдэд харьяалагддаг, эсвэл ойролцоо үйл ажиллагаа явуулдаг 35 уламжлалт анагаах ухааны амбулаторийн эмнэлэг байдаг.
Улсын мэргэжлийн эмнэлэг	Улсын төрөлжсөн уламжлалт анагаах ухааны эмнэлэг нь 100 хэвтэн эмчлүүлэх өвчтөн хүлээж авах ба мөн өдөрт 40-50 амбулаторийн үзлэг хийх хүчин чадалтай.
Уламжлалт анагаах ухааны эмнэлэг, сувилал	Нийт 82 хувийн уламжлалт анагаах ухааны эмнэлэг байдгийн 63 нь Улаанбаатар хотод байдаг. Сувилал болон рашааны тоо нь тодорхой бус байна. Уламжлалт эмчилгээнд массаж, төрөл бүрийн бумба, хэт ягаан туяа ба хэт авианы долгион, цахилгаан гэрлийн эх үүсвэр, ионжуулалтын зэргээр эмчлэх гэх мэтийн физик эмчилгээ орох бөгөөд зүү, төөнүүр тавих, саун, талст дээр алхах, ургамал, эмийн эмчилгээ, хоолны дэглэм баримтлах болон бусад эмчилгээ ордог.

Жил бүр Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулдаг "Нээлттэй хаалганы өдөр" арга хэмжээний үеэр аймгийн эрүүл мэндийн байгууллагууд эрүүл мэндийн үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлдэг. Сумдад байдаггүй мэргэжлийн эмч нар сумын иргэдийн эрүүл мэндийн

<sup>158</sup> ГТХЯ буюу Баянгол сумын Эрүүл мэндийн төвийн даргатай хийсэн ярилцлага. Харамсалтай нь суурь судалгааны үеэр судалгааны багийнхан эдгээр үйлчилгээг үзүүлдэг эмч нартай уулзаж мэдээлэл авч чадаагүй.

үзлэгийг хийхээр аймгийн эмнэлэгээс ирж оролцдог. Энэхүү арга хэмжээнд иргэд өргөнөөр оролцдоггоос харвал мэргэшсэн мэргэжлийн эмч нарын болон эрүүл мэндийн үнэгүй үйлчилгээний эрэлт хэрэгцээ их байгааг харуулж байна.

Сум, баг, өрхийн түвшинд эрүүл мэндийн үйлчилгээний сонголтыг харахад өрхийн судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь сумын эрүүл мэндийн төв болон уламжлалт анагаах ухааны оточ нарын аль нэгт нь ханддаг байна (Зураг 5.44-г харна уу). Малчин өрх болон суурин өрхүүдийн хооронд ямар ч ялгаа байхгүй байв. Баянгол сумын судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь (54%) сумын эрүүл мэндийн төвд хандаж эрүүл мэндийн үйлчилгээ авдаг. Баянгол сумын судалгаанд хамрагдагсдын 84% нь эрүүл мэндийн үйлчилгээ хангалттай (өөрөөр хэлбэл тэд шаардлагатай үед үйлчилгээ авч чаддаг) буюу тэдэнд хүртээмжтэй байдаг гэж боддог. Мандал сумын ялангуяа Хэрх ба Түнхэл багийн судалгаанд хамрагдагсад уламжлалт анагаах ухааны эмчилгээг илүүд үздэг. Энэ нь хувь хүний сонголт, мөн эдгээр газар нутагт уламжлалт анагаах ухааны эмч илүү хялбар олддог, хүртээмжтэй байдагтай холбоотой байж болох юм. Мандал сумын судалгаанд хамрагдагсдын 80% гаруй нь эрүүл мэндийн үйлчилгээ тэдэнд хангалттай хүртээмжтэй байдаг гэж хариулсан байна.



**Зураг 5.44 Эрүүл мэндийн үйлчилгээний сонголт (сум, баг, ба өрхийн түвшинд) <sup>159</sup>**

**Хүснэгт 5.47 Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж (%)**


	Сум		Баг			Өрх	
	Баянгол	Мандал	Түнхэл	Хэрх	Бусад	Малчин	Суурин
Хүртээмжтэй	84.1	80.9	79.1	82.4	84.2	84.5	80.8
Хүртээмжгүй	15.9	19.1	20.9	17.6	15.8	15.5	19.2

Энэ хэсэгт дурдсан Монгол Улсын эрүүл мэндийн салбарт тулгарч буй гол бэрхшээлүүдийг улам бататган, өрхийн судалгаанд оролцогчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой хүндрэлүүдийн гол шалтгааныг нэрлэсэн байна (Зураг 5.45-ыг харна уу). Үүнд:

<sup>159</sup> Састэйнабилити Ийст Эйжия. 2015. Өрхийн судалгаа

1. Иргэдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар муу.
2. Эмнэлэгт очих ямар ч цаг байдаггүй.
3. Эмнэлэгүүд дэндүү хол байрладаг.

Эдгээр судалгааны үр дүнг олон нийтэд үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагуудын талаарх өмнөх тайлбартай нэгтгэн харвал Түнхэл багийн иргэд бусад газруудтай харьцуулахад орчин үеийн анагаах ухааны эмчилгээнээс илүү уламжлалт анагаах ухааны эмчилгээг сонгодог нь эмнэлэг хүрэх зай, зардал, тээврийн хэрэгслийн олдоцтой холбоотой. Суурин өрхүүд өмнө дурдсан эмнэлэг хүрэх зай, эмнэлэгт очих цаг хугацаа гардаггүй зэрэг нь тэдний хувьд эмнэлгийн үйлчилгээтэй холбоотой хүндрэл байсан бол малчин өрхүүдийн хувьд эмнэлгийн үйлчилгээний зардал, эрүүл мэндийн даатгал байдаггүй зэрэг нь хүндрэлтэй байдаг хэмээн хариулсан юм.



**Зураг 5.45 Иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдахгүй байгаа шалтгаан<sup>160</sup>**

Зураг 5.45-т харуулсан үр дүнг ГТХЯ, ЗБХ-ийн мэдээлэлтэй нэгтгэн дүн шинжилгээ хийж үзвэл сум ба багийн түвшний эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой дараах хүндрэлүүдийг онцолж болохоор байна. Үүнд:

- Эрүүл мэндийн үйлчилгээний чанар муу;
- Нүд, шүд, чих, хамар хоолойн зэрэг мэргэшсэн эмч дутмаг;
- Сум/өрхийн эмнэлгийн эмч нарын чадвар муу;
- Эм хангалтгүй байдаг; болон
- Үйлчилгээний хүнд суртал орж байна.

<sup>160</sup> Састэйнабилити Ийст Эйжия. 2015. Өрхийн судалгаа





"Эрүүл мэндийн үйлчилгээний чанар суманд маш муу байдаг. Эмнэлгийн орны тоо хангалтгүй бөгөөд хэрэгтэй эмийг өвчтөнүүд өөрсдөө авчрах шаардлага гардаг. Сум, өрхийн эмнэлгийн эмч нарын үр чадвар сайн биш байна. Жишээ нь олон хүн буруу оношлогоо ба эмчилгээний улмаас нас барсан. Сумын эмнэлэгт нүд, шүд, чих, хамар хоолойн эмч байдаггүй."

Мандал сумын төвийн иргэдтэй хийсэн ЗБХ

"Сумын эмнэлгүүд хүнд суртал ихтэй. Сумын эмнэлэгт хангалттай ор байдаг ч иргэд нь эмнэлэгт хэвтэж эмчлүүлэхэд хүндрэл гардаг. Өвчтөнийг өөрөө эм, тариагаа авчрахыг хүсдэг нь хүндрэлтэй байдаг."

Мандал сумын малчидтай хийсэн ЗБХ

"Эрүүл мэндийн үйлчилгээ нь хүн болгонд хүртээмжтэй байдаггүй. Эмнэлгийн ор болон мэргэжлийн эмч дутмаг байна. Оношлогоо, эмчилгээний тоног төхөөрөмж мөн хангалттай биш байдаг."

Мандал сумын ЖДҮ-ийн төлөөлөлтэй хийсэн ЗБХ

Монгол Улсад улсын эмнэлэг, эрүүл мэндийн төвөөс үзүүлдэг нийтлэг үйлчилгээний нэг нь орон нутгийн иргэдэд хөнгөлөлттэй эм олгох үйлчилгээ юм. Иргэд "Эрүүл мэндийн даатгалын сангаас зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх журам"-ын дагуу 132 төрлийн эмийг 93% хүртэл хөнгөлөлттэй үнээр улсын болон хувийн эмийн сангаас худалдан авах боломжтой ба эрүүл мэндийн даатгалд (заавал болон сайн дурын үндсэн дээр аль аль нь) хамрагдсан байх ёстой.<sup>161</sup> Гэсэн хэдий ч бодит байдал дээр дурдсан эмүүд нь орон нутгийн иргэдэд хүртээмж багатай байдаг нь сумын ба багийн эрүүл мэндийн даатгалын төсөв бага байдагтай холбоотой. Төсвийн асуудлаас шалтгаалан иргэд хүссэн эмээ хөнгөлөлттэй үнээр авах боломжгүй болох тохиолдлууд гардаг ба улмаар орон нутгийн иргэд, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчдийн хоорондын маргааны шалтгаан болдог. Тэр дундаа эрүүл мэндийн даатгал төлдөг хүмүүс даатгалынхаа үр ашгийг хүртэж чадахгүй байгаадаа сэтгэл хангалуун бус байдаг. Малчид уг асуудлыг онцлон дурдаж байсан бөгөөд малчдын хувьд эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой тулгардаг гол бэрхшээл нь эрүүл мэндийн даатгалд хамрагдаж чаддаггүй асуудал хэмээн мэдээлж байсантай нь харьцуулвал сонирхол татаж байна. Эдгээр хөнгөлөлттэй эмийн хүртээмж бага байгаа нь зөвхөн сум, багийн түвшний асуудал биш бөгөөд үндэсний хэмжээний асуудал юм.

"Сумын эрүүл мэндийн төв нь төсвийн хязгаарлагдмал байдлаас шаалтгаалан хөнгөлөлттэй үнээр эм авах жорыг тэр болгон олгодоггүй. Энэ зориулалтаар сард 420,000 төгрөг зарцуулдаг ба үүнийг эрүүл мэндийн төвүүд нь хүнд өвчтөнүүдэд эхэлж зарцуулах төлөвлөгөөтэй байдаг."

Баянгол сумын Эрүүл мэндийн төвийн дарга

"Малчдад хөнгөлөлттэй үнээр эм авах боломж олддоггүй".

Баянгол сумын малчдын бүлэгтэй хийсэн ЗБХ

## 6.7.4 Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоо

Социализмын үед эрүүл мэндийн үйлчилгээг улсаас санхүүжүүлдэг байв. Ажиллагсдыг холбогдох сургалтуудад амжилттайгаар хамруулсан, эмнэлгийн байгууламжийн тоо нэмэгдсэн, хүн амын эрүүл мэндийн ерөнхий байдал сайжирсан зэрэг эерэг үр дүн гарсан ч эрүүл мэндийн салбарт олон бэрхшээлүүд тулгарсаар байна. 1990-ээд оны дунд үед эрүүл мэндийн салбарт шинэчлэл хийж эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, өвчнөөс урьдчилан сэргийлэх, сайжруулах тал дээр анхаарлаа хандуулсан бол сүүлийн 15 жилийн хугацаанд эдийн засгийн хөгжилтэй уялдуулан эрүүл мэндийн байдал болон өвчний тархалтыг судлах асуудлыг сайжруулахад

<sup>161</sup> Эрүүл мэндийн даатгалын зөвлөл, шийдвэр #02, 2012.


голчлон анхаарч ажилласан. Нас баралтын хамгийн гол шалтгаан нь халдварт бус өвчин болон гадны нөлөөлөл байна. Монгол Улсад амьсгалын болон хоол боловсруулах тогтолцооны өвлөл нь хамгийн түгээмэл бөгөөд хот суурин газарт гадны нөлөөллөөр (гэмтэл) өвчлөл үүсэх нь элбэг бол хөдөө орон нутагт шээсний замын өвчлөл зонхилж байна.

Сэлэнгэ аймгийн хүн амын дундаж наслалт 2014 оны байдлаар 2012 онтой харьцуулахад 1 жилээр өсч 69.6 жил болсон бөгөөд энэ нь улсын дунджаас илүү өндөр байна. Сэлэнгэ аймагт 2015 оны эхний 5 сарын байдлаар 631 хүүхэд төрсөн нь 2014 оны мөн сарынхтай харьцуулахад 10%-иар бага байгаа юм. Баянгол сумын эрүүл мэндийн төв төрөх тасаггүй тул 2014 онд гэртээ төрсөн 1 хүүхдийг эс тооцвол эхчүүд энэхүү суманд төрөөгүй шалтгааныг тайлбарлаж болох юм.

#### Хүснэгт 5.48 Аймаг, сумын түвшний төрөлт ба нас баралтын тоо<sup>162</sup>

Аймаг, сум	2012	2013	2014	2015
<b>Төрөлт</b>				
Сэлэнгэ	774	772	874	787
Мандал	231	249	338	288
Баянгол	0	0	0	0
<b>Нас баралт</b>				
Сэлэнгэ	238	204	218	195
Мандал	63	49	61	59
Баянгол	9	5	9	5

Аймгийн хэмжээнд нас баралтын тоо 2014 оныхтой харьцуулахад 23-аар буурсан. Мандал суманд нас баралтын тоо 23-аар, Баянгол суманд 4-өөр тус тус буурсан байдлаас харвал сумын хэмжээнд нас баралтын тоо мөн буурах хандлага ажиглагдаж байна. Аймгийн статистикийн мэдээллээс харахад нас баралтын гол шалтгаан нь зүрх судасны өвчин (40%), хорт хавдар (22%) байна. Зураг 5.46-д үзүүлснээр 2014 онд Монгол Улсад нас баралтын гол шалтгаан нь зүрх судасны өвчин (34.4%), хорт хавдар (24.3%) байв.<sup>163</sup>



**Зураг 5.46 Сэлэнгэ аймаг дахь нас баралтын гол шалтгаан <sup>164</sup>**

<sup>162</sup> Сэлэнгэ аймгийн тойм 2015 оны 5 дугаар сар, хуудас 33 – 35.

<sup>163</sup> Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2014, хуудас 114.

<sup>164</sup> Сэлэнгэ аймгийн эрүүл мэндийн салбарын статистикийн танилцуулга, 2014.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум нь ОХУ-тай хиллэддэг бөгөөд Баянгол, Мандал сумууд нь Улаанбаатар - Сүхбаатар - Наушки (ОХУ-ын хилийн боомт) хотыг холбосон олон улсын зам дагуу байрладаг. Энэ байрлал нь аялал жуулчлал, худалдааны зорилгоор зорчих орон нутгийн болон олон улсын олон худалдаачид, жуулчдыг татдаг. Мөн Сэлэнгэ аймаг нь маш өвөрмөц газар ашиглалтын бүтэцтэй (хөдөө аж ахуйн газар 50%, ойн сан бүхий газар 37% байдаг тул энэ нутагт бэлчээр болон жимс жимсгэнэ, самар, мод ашиглах сонирхолтой иргэд олон байдаг) бөгөөд тус аймаг нь ашигт малтмалаар баялаг тул бичил уурхайчдын анхаарлыг их татдаг. Хүн амын төвлөрөл их байгаа тул энэ нь янз бүрийн халдварт өвчин тархах шалтгаан болж болзошгүй юм. Аймгийн хэмжээнд 2014 оны байдлаар халдварт өвчний халдвар аван бүртгэгдсэн хүмүүс 6.8%-иар нэмэгдсэн бөгөөд одоогийн байдлаар халдварт өвчний тохиолдлын 60%-ийг бэлгийн замаар дамжих халдвар (БЗХӨ), 25%-ийг сүрьеэ, 2%-ийг гепатит С вирусын халдвар, үлдсэн 13.5%-ийг бусад халдварт өвчний тохиолдлууд эзэлж байна.

**Хүснэгт 5.49 Аймаг, сумын түвшний халдварт өвчний тохиолдол, өвчилсөн хүмүүсийн тоогоор**

	2012	2013	2014	2015
<b>Бүх халдварт өвчин</b>				
Сэлэнгэ	395	411	345	370
Мандал	75	76	67	61
Баянгол	12	17	10	4
<b>Бэлгийн замын халдварт өвчин</b>				
Сэлэнгэ	122	180	203	219
Мандал	20	20	38	40
Баянгол			1	
<b>Гепатит</b>				
Сэлэнгэ	140	99	16	8
Мандал	36	20	1	
Баянгол	2	8	-	-
<b>Сүрьеэ</b>				
Сэлэнгэ	110	105	103	93
Мандал	17	21	24	17
Баянгол	10	8	9	4

Аймаг, сумын түвшинд бэлгийн замын халдварт өвчин хамгийн их байгаа ба аймгийн түвшинд нийт халдварт өвчний тохиолдлын 59%-ийг, сумын түвшинд 66%-ийг бэлгийн замын халдвар эзэлж байна. Мандал сумын бүх халдварт өвчний тохиолдлын гуравны хоёр нь БЗХӨ байгаа нь тус суманд хүн ам их төвлөрсөн, мөн бичил уурхайчид болон бусад эдийн засгийн боломж хайн шилжин ирэгсэд хамгаалалтгүй бэлгийн харилцаанд орж байгаатай холбоотой. 2015 оны 5 дугаар сарын байдлаар сүрьеэгийн тохиолдол аймаг (25%), Мандал (28%) болон Баянгол сумдуудад буурсан байна. Баянгол сумын нутагт бүртгэгдсэн халдварт өвчний 4 тохиолдол нь бүгд сүрьеэ байв. Монгол Улсын хэмжээнд Сэлэнгэ аймаг нь 10,000 хүн тутамд бүртгэгдсэн сүрьеэгийн халдварын тоогоороо хамгийн өндөр байна.<sup>165</sup> Энэ нь ашигт малтмалын нөөц ихтэй Сэлэнгэ аймагт олон тооны бичил уурхайчид орон зайн хувьд хязгаарлагдмал газар доор хүнд хүчир ажил

<sup>165</sup> Улсын эрүүл мэндийн статистикийн мэдээлэл, 2014.

эрхэлдэгтэй холбоотой байж болзошгүй юм. Цаашлаад эмчилгээ хийлгэлгүйгээр хязгаарлагдмал орчинд үргэлжлүүлэн ажиллах нь уг өвчний тархах шалтгаан болж болзошгүй. Энэ бүлгийн хүмүүс нь эрүүл мэндийн үйлчилгээ авдаггүй, эсвэл ямар нэгэн эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүйн улмаас сүрьеэ өвчнөө эмчлүүлэхгүй байх эрсдэлтэй юм.

**Бичил уурхай ба сүрьеэ**

"Сүрьеэгийн тархалт нь аймаг, сумын түвшинд ялангуяа Баянгол суманд маш өндөр байна. Энэ нь сүрьеэгийн халдвартай хүмүүс эрүүл мэндийн хувьд эмзэг, сул хүмүүстэй хамт урт удаан хугацаагаар агааргүй орчинд (далд) ажилладаг нь сүрьеэгийн халдвар тархах шалтгаан болдог байж болзошгүй. Жил бүр Эрүүл мэндийн төв нь рентгений төхөөрөмж авчирч, орон нутгийн иргэдэд үнэгүй үзлэг хийдэг. Тус төвийн лаборатори нь цэрний шинжилгээ хийх хүчин чадалтай хэдий ч цэр болон бусад шинжилгээнд (биохимийн шинжилгээ, цусны шинжилгээ, шээсний шинжилгээ, В, С маркер болон бусад) шаардлагатай химийн урвалж байдаггүй."

Баянгол сумын Эрүүл мэндийн төвийн даргатай хийсэн ярилцлага (ГТХЯ)


Түнхэл багт зохион байгуулсан ЗБХ-ийн үеэр хэлэлцсэн бас нэг гол асуудал нь шороон замын тоосжилтоос үүсэх эрүүл мэндийн нөлөөллийн асуудал байв. Хэлэлцүүлэгт оролцогчид тоосноос шалтгаалж амьсгалын замын өвчин тусах эрсдэл нэмэгддэг гэж үзэж байна. Түнхэлд амьсгалын замын өвчин их байгааг тодорхойлох бололцоогүй, мөн дээрх амьсгалын замын өвчний эрсдэлийг үнэн хэрэгтээ замын тоосжилттой холбон үзэх боломжгүй юм. Алс хол байрлалтай Түнхэл багийн оршин суугчдын ихэнх нь шороон замаа хатуу хүчилттай болгох хүсэлтэй байгаа талаар энд тэмдэглэх нь чухал. Тоос, түүнтэй холбоотой үүсэх эрүүл мэндийн асуудал, нөлөөлөл нь багийн хөгжил, тэр дундаа Гацууртын уурхайн хөгжилтэй холбоотой өргөн хүрээтэй асуудал бөгөөд цогцоор шийдвэрлэх шаардлагатай юм.

### **6.7.5 Замын хөдөлгөөн ба зам тээврийн осол**

Замын хөдөлгөөний аюулгүй байдал ба тээврийн хэрэгслийн ашиглалтын журмыг зөрчин үйлдсэн гэмт хэргийн улмаас нас барсан хүний тоо 2012-2013 онд 18.9%-иар өссөн байна. Түүнчлэн 2014 оны эхний 10 сарын байдлаар энэ тоо нь 2013 оныхтой харьцуулахад 26.7%-иар нэмэгдсэн бол 2013-2014 онд зам тээврийн ослоор бэртэж гэмтсэн хүний тоо 17.4% нэмэгдсэн байна.<sup>166</sup>

Монгол Улсын замын хөдөлгөөний аюулгүй байдал доогуур байгаа шалтгаанд дараах асуудлууд орно:

<sup>166</sup> Замын засвар, тээврийн аюулгүй байдал, Хурдны замын зөвлөх эдийн засагч – Энхтөр Б., 2013.



## Зураг 5.47 Зам тээврийн ослын гол шалтгаан <sup>167</sup>


Дээрх статистикаас дараах дүгнэлтийг хийж болно:

- Зам тээврийн ослын ихэнх нь (99.6%) хувь хүний буруугаас болдог.
- Зам тээврийн ослын 97% нь жолоочийн буруугаас болдог.

Мандал, Баянгол сумын статистикийн мэдээнээс харахад зам тээврийн ослын дийлэнх нь бэртэл гэмтэлд хүргэдэг<sup>168</sup>.


<sup>167</sup> Замын засвар, тээврийн аюулгүй байдал, Хурдны замын зөвлөх эдийн засагч – Энхтөр Б., 2013.

<sup>168</sup> Сэлэнгэ аймаг, Баянгол ба Мандал суманд зам тээврийн осол гарах шалтгаан ба нөхцөл байдал, 2014.



**Зураг 5.48 Баянгол ба Мандал суманд зам тээврийн ослын улмаас гарсан гэмтэл ба нас баралт, тоогоор**

Мандал сумын ослын гол шалтгаан нь согтуугаар жолоо барьсан, хурд хэтрүүлсэн, халтиргаатай замд машинаа зогсоож чадаагүй (тормоз ажиллаагүй) зэрэг тохиолдлууд байгаа бол Баянгол суманд гарсан замын ослын гол шалтгаан нь урсгал сөрсөн, эсвэл хурд хэтрүүлсэн тохиолдлууд байна.




**Зураг 5.49 Баянгол ба Мандал суманд гарсан зам тээврийн ослын гол шалтгаан, тоогоор**

Баянгол, Мандал суманд гарсан зам тээврийн ослын статистик мэдээг ослын төрлөөр ангилан харвал автомашин мөргөлдсөн тохиолдол хамгийн их байна:

- Баянгол – 61% ба Мандал – 38%;
- Машин онхолдох: Баянгол – 34% ба Мандал – 21%; мөн



- Явган зорчигч дайрсан тохиолдол: Мандал – 31%.



### Зураг 5.50 Баянгол ба Мандал суманд гарсан зам тээврийн ослын төрөл, тоогоор

Мандал сумын ГТХЯ-ын үеэр дурдагдсан гол асуудлын нэг нь Гацууртын төслийн үйл ажиллагааны явцад хүдэр тээвэрлэх ачааны машинаас шалтгаалан Түнхэл багийн замын аюулгүй байдлыг хангах асуудал байв. Түнхэл багийнхантай адилаар ярилцлагад оролцсон Мандал сумын гол талууд нь засмал зам тавилгүйгээр шороон замаар хүдэр тээвэрлэсэн тохиолдолд замын тоос эрүүл мэндэд нөлөөлж, мөн замын аюулгүй ажиллагааны асуудал доройтож болзошгүй талаар дурдаж байв. Нөгөө талаар ЗБХ-ийн үеэр уг замын нөхцлийг сайжруулан хатуу хучилттай болговол хүмүүс хурд хэтрүүлэх нь ихэсч ослын тоо нэмэгдэх нөлөөлөл үүсэх талаар дурдсан эсрэг бодолтой оролцогчид мөн байв.

#### Замын хөдөлгөөн ба Гацууртын төсөл

"Гацууртын төслийг хэрэгжүүлэх үед зам тээврийн ачаалал нэмэгдэж 8-10 минут тутамд ачаа тээвэрлэж буй нэг зорчисноос осол ихсэх магадлалтай. Замын нөхцөл, тэмдэглэгээ, урсгалыг сайжруулахгүйгээр хүдрийн тээвэрлэлтийг эхлүүлэх боломжгүй.

Мандал сумын Цагдаагийн газрын дарга

Дээр дурдсан авто замын осол, аюулгүй ажиллагаатай холбоотой мэдээлэл, мөн Цагдаагийн газраас мэдээлсэн гэмт хэргийн тоо (доор дурдсан) болон замын хөдөлгөөний ачаалал (Хэсэг 6.5.8.2 Замын хөдөлгөөн ба тээврийн хэрэгсэл эзэмшиж буй байдал хэсгийг харна уу)-ын талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийн үзвэл хэд хэдэн асуудлыг онцлон авч үзэж болохоор байна. Гацууртын төслийн замаар зорчиж буй тээврийн хэрэгслийн ихэнх нь хөнгөн тэрэг байгаа ба төслийн талбайд гарч буй зам тээврийн ослын гол шалтгаан нь урсгал сөрөх, хурд хэтрүүлэх, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ машин жолоодох зэрэг эрсдэлээс үүдэлтэй гэж үзлээ. Эдгээр эрсдэл, мөн дээр нь уг замаар олон тооны хүдэр тээвэрлэх ачааны машин зорчих нөхцлийг хамтатган үзвэл замын аюулгүй байдал нь санаа зовоосон, хүндрэлтэй асуудалд тооцогдохоос ч аргагүй юм.

Түүнээс гадна Цагдаагийн газрын статистик мэдээнд харуулснаар Сэлэнгэ аймагт гарч буй ихэнх гэмт хэрэг нь замын хөдөлгөөний аюулгүй ажиллагаа, тээврийн хэрэгсэлтэй холбоотой байв. Харин сумын түвшинд замын хөдөлгөөний аюулгүй ажиллагаа, тээврийн хэрэгсэлтэй холбоотой

гэмт хэргийн нийт гарсан гэмт хэргийн тоонд эзлэх хувь Мандал сумтай (5%) харьцуулахад Баянгол суманд (31%) илүү байгаа юм. Уг тооны зөрүү нь Улаанбаатар хот болон ОХУ-ын хилийг холбосон засмал замаас эдгээр сумдууд хэр алслагдсан байгаатай холбоотой байх магадлалтай. Гацууртын төслийн хүрээнд хүдэр тээвэрлэх том оврын тээврийн хэрэгслийн асуудлыг тооцон үзэлгүйгээр одоогийн замын хөдөлгөөн, тээврийн хэрэгсэлтэй холбоотой гэмт хэрэг, олон нийтийн аюулгүй ажиллагаа нь дангаараа л төслийн талбайн хувьд ихээхэн хүндрэлтэй асуудал болоод байна. Төслийн талбай дахь замын хөдөлгөөний эрсдэлийг бууруулах, аюулгүй ажиллагаатай холбоотой олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх талаар төрийн байгууллагаас аливаа хөтөлбөр хэрэгжүүлж байгаа эсэх мэдээллийг авах боломжгүй байлаа. Бороогийн төслөөс өмнө нь замын аюулгүй ажиллагааны талаар олон нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэх ажлууд хийгдэж байсан байна.

### **6.7.6 Гэмт хэрэг ба нийгмийн дэг журам**

1961 оны Эрүүгийн хуульд зааснаар нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг хэмээн үзэж байв. Социализмын үед Монгол Улсад тухайн үйлдэл нь хуулийн заалт зөрчсөн ч "нийгэмд аюултай үйлдэл" биш бол гэмт хэрэг гэж үздэггүй байсан ба төрийн болон социалист нийгмийн өмчийн эсрэг үйлдсэн гэмт хэрэг нь хувийн хүмүүсийн эсрэг гэмт хэргээс илүү ноцтойд тооцогдож байлаа. 1980-аад оны сүүл үед хамгийн түгээмэл гэмт хэрэг нь хулгай, төрийн өмчийг шамшигдуулах, дамын наймаа, насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн гэмт хэрэг, хоол хүнс, эм зэрэг бүтээгдэхүүн шамшигдуулан дамлаж зарах, автомашин дамлаж зарах зэрэг байв. Хот суурин газарт насанд хүрээгүй хүүхдүүдийн танхайрал, зэрлэг балмад авир гаргах асуудал нь эрх баригчдын хувьд мөн санаа зовоосон хүндрэлийн нэг байлаа. Энэ асуудлуудын ихэнх нь гэр бүл салалт, амьжиргаа нь хоосорсон айл өрхүүдийн амьдралаас үүдэлтэй байв.<sup>169</sup>

Нийгэм өөрчлөгдсөнтэй холбоотойгоор 1990-ээд оноос хойш орчин үеийн гэмт хэргийн шинж байдал мөн өөрчлөгдсөн байна. Хар тамхины наймаа, мөнгө угаах, мөрийтэй тоглоом, оюуны өмчийн хулгай, цахим гэмт хэрэг, хүний наймаа зэрэг дэлхий дахинд ихэссэн гэмт хэрэг мөн Монголд нэмэгдсэн.

Сэлэнгэ аймгийн төв Сүхбаатар суманд нэг цагдаагийн хэлтэс, Сайхан, Мандал сумдад тус тус нэг (нийлээд хоёр) сум хоорондын хэлтэс байна. Нийт цагдаагийн ажилтнуудын 59.4% нь дээд боловсролтой, 6% нь тусгай агентлагт суралцсан бөгөөд үлдсэн 34.6% дунд боловсролтой. Мандал сумын нутагт орших сум хоорондын хэлтэс нь Мандал, Баянгол, Түнхэл сумдууд, Хэрх баг ба Төв аймгийн хоёр сумын хүн амд үйлчилдэг.<sup>170</sup>

Архи нь гэмт хэрэг гарах гол нөлөө болж байна. Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 33% нь архи, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ үйлдсэн байгаа талаар 2015 оны 5 дугаар сарын Цагдаагийн газрын мэдээнээс харж болно. Өмнөх жилүүдтэй харьцуулахад гэмт хэрэг 4.8% буурсан байна. Мандал суманд гэмт хэргийн тоо 20.2%-иар өсч, Баянгол суманд 41.7%-иар буурчээ. Нийгмийн суурь судалгааны багийнхан гэмт хэргийн шалтгаан, төрөл ялгааны талаар мэдээлэл авах боломжгүй байсан бөгөөд Мандал суманд Цагдаагийн хэлтэс байдаг нь Баянгол сумаас илүү гэмт хэргийг мэдээлэх, бүртгэх боломжийг бий болгосон, иймдээ ч Мандал суманд гэмт хэргийн тоо

<sup>169</sup> [http://www-rohan.sdsu.edu/faculty/rwinslow/asia\\_pacific/mongolia.html](http://www-rohan.sdsu.edu/faculty/rwinslow/asia_pacific/mongolia.html).


<sup>170</sup> <http://www.selenge.gov.mn>.

өндөр харагдаж байж болзошгүй. Айл өрхүүд Мандал суманд байрлах хамгийн ойр Цагдаагийн газраас зайтай амьдарч байгаа тул төслийн талбайд гарсан гэмт хэргийг дутуу мэдээлж болзошгүй байна.

**Хүснэгт 5.50 Аймаг сумын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, 2015 оны 5 дугаар сарын байдлаар<sup>171</sup>**

	Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо		
	2013	2014	2015
Сэлэнгэ аймаг	315	331	315
Мандал сум	89	71	89
Баянгол сум	Мэдээлэл байхгүй	24	14

Аймгийн түвшинд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 35% нь өмчлөх эрхийн эсрэг, 39% нь хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг, 2% нь олон нийтийн аюулгүй байдлын эсрэг, 6% замын хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг, 18% нь бусад гэмт хэрэг байна. Сэлэнгэ аймгийн хэмжээнд хүчирхийллийн улмаас 57 хүн нас барсан байна. 8 хүн амиа хорлосон, 3 хүн бусдын гарт амь үрэгдсэн, үйлдвэрлэлийн ослоор 6, зам тээврийн ослоор 14, ба бусад ослоор 26 хүн тус тус амь эрсэдсэн байна.




**Зураг 5.51 Аймгийн хэмжээнд гарсан гэмт хэргийн бүтэц, 2015 оны 5 дугаар сарын байдлаар**

Мандал суманд бүртгэгдсэн гэмт хэргийн тал хувь нь (48%) хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг байгаа бол Баянгол суманд гарсан нийт гэмт хэргийн 36% нь замын хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын дүрэм зөрчсөн хэрэг байгааг тус сум Улаанбаатар хот болон ОХУ-ын хилийг холбосон олон улсын замын дагуу байрлаж байгаатай холбон тайлбарлаж болох юм. ОХУ-ын хил хүртэл замын ачаалал нь худалдаа, наймаа эрхлэгчид болон амралтаараа зугаалж буй жуулчидтай холбоотойгоор маш их байдаг бөгөөд энэхүү замын хөдөлгөөн нь намар, зуны улиралд улам нэмэгддэг талаар Мандал суманд байрладаг сум


<sup>171</sup> Сэлэнгэ аймгийн тойм, 2015 оны 5 дугаар сар, хуудас 37 – 39.

хоорондын Цагдаагийн хэлтсийн дарга дурдаж байв. Өдөрт 80-100 тээврийн хэрэгсэл (хил рүү явж байгаа болон буцаж байгаа нийт тээврийн хэрэгсэл) явдаг. Замын хөдөлгөөний ачаалал их үед буюу оргил үедээ нэг талдаа өдөрт 100-150 тээврийн хэрэгсэл (өөрөөр хэлбэл 2 талдаа нийт 300 тээврийн хэрэгсэл) зорчдог байна.



**Зураг 5.52 Сумын хэмжээнд гардаг гэмт хэргийн бүтэц, 2015 оны 5 дугаар сарын байдлаар**

Судалгаанд оролцогчид сүүлийн 2 жилийн хугацаанд сум, баг, өрхийн түвшинд хамгийн их давтагдаж гарсан гэмт хэргийг жагсаахад Баянгол, Мандал сумдад дээрэм, хулгай, аллага болон осол хамгийн нийтлэг гэмт хэрэгт орж байв. Түнхэл багийнхан согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг үйлдэх нь их (ойролцоогоор 30%), мөн дээрэм, хулгай, осолтой холбоотой гэмт хэрэг элбэг гардаг гэж хариулсан байна.



**Зураг 5.53 Сум, багийн хэмжээнд сүүлийн 2 жилд гарсан гэмт хэргийн бүтэц<sup>172</sup>**

Өрхийн судалгаанд хамрагдагсдын ихэнх нь (ойролцоогоор 92%) гэмт хэргийн хохирогч болж байгаагүй байна. Харин Баянгол сумаас судалгаанд оролцогчдын 70% нь, Мандал сум болон Түнхэл, Хэрх багаас оролцогчдын 75% нь гэмт хэргийн хохирогч болж байсан ч цагдаад мэдээлээгүй, учир нь тэд цагдаад мэдэгдсэн ч хохирлоо барагдуулж алдагдлаа тооцуулах боломжгүй мөн ямар нэгэн нөхөн төлбөр авахгүй тул шаардлагагүй гэж үзжээ. Гэмт хэргийг бүх тохиолдолд мэдээлж бүртгүүлдэггүй талаарх энэхүү мэдээлэл нь төслийн талбайд гэмт хэргийг мөн мэдээлдэггүйгээс харьцангуй бага гэмт хэрэг гарсан статистик мэдээ байгаа талаарх өмнөх дүн шинжилгээтэй нийцэж байгаа юм.

Судалгаанд хамрагдагсад "Та орон нутгийн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа болон чадавхид ямар үнэлгээ өгөх вэ?" асуултанд сумын (ойролцоогоор 65%), багийн (ойролцоогоор 60%) болон өрхийн (ойролцоогоор 60%) түвшинд орон нутгийн гэмт хэрэгтэй тэмцэх хүчин чадал нь "дундаж болон хангалтгүй" гэж хариулсан байна. Эдгээр тоо орон нутгийн засаг захиргааны ба цагдаагийн байгууллагад олон нийтийн итгэх итгэл доогуур байдаг талаарх ойлголттой таарч байгаа юм.

Гэмт хэрэгтнүүдийн хүн ам зүйн талаарх мэдээллийг харахад 14% нь эмэгтэй, 8% хүүхдүүд, үлдсэн нь эрэгтэйчүүд байна. Гэмт хэрэгтнүүдийн 44.2% архи, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг үйлдсэн, мөн ихэнх гэмт хэргийг 18-аас доош насны хүмүүс үйлдсэн байдаг. Энэ нь ажлын байрны хомсдол болон залуучуудад зориулсан өөр үйл ажиллагаа (архи ууж гэмт хэрэг үйлдэхээс өөр) байдаггүйтэй холбоотой эсэх нь тодорхойгүй байна. Эсвэл цагдаагийн ажилтанууд залуу хүүхдүүдийн үйлдсэн гэмт хэрэгт илүү анхаарал тавин бүртгэдэг байж болох юм.


Сум, багийн түвшинд хүний эрхийн эсрэг гэмт хэрэг тэр бүр бүртгэгддэггүй. Энэ нь сумын иргэд хүний эрхийн талаар мэдлэг мэдээлэл бага, хүн бүр эрхээ хэрхэн эдлэх болон зөрчигдсөн үед ямар арга хэмжээ авах ёстойгоо мэддэггүйтэй холбоотой байж болох юм. Мөн өрхийн судалгаанд хамрагдагсдын ихэнх нь (57-70%) нь хүний эрх зөрчсөн тодорхой тохиолдлын тухай сонсоогүй гэж хариулсан байна. Хүний эрхийн тухай ойлголт багатай байгаа ч судалгаанд оролцогчидтой энэ талаар ярилцахад сум, багийн төвийн суурин газарт амьдарч буй оролцогчид сум, баг, өрхийн түвшинд ихэвчлэн хүүхдийн эрхийг зөрчсөн тохиолдол их (Мандал, Баянгол сумдад судалгаанд оролцогчдын ойролцоогоор 65%, багийн түвшинд 66% нь энэ хариултыг өгсөн) гардаг гэдгийг онцолж байв. Хүүхдийн эрхээс гадна мөн оролцогчдын ойролцоогоор 47-60% нь сум, баг, өрхийн түвшинд эмэгтэйчүүдийн эрх зөрчигддөг талаар мэдээлсэн байна. Энэ нь хэвийн асуудал бөгөөд Монгол Улсад гэр бүлийн хүчирхийллийг нийгмийн асуудал бус гэр орны дотоод асуудал гэж үздэгтэй холбоотой. Түнхэл багт эмэгтэйчүүдийн эрхийг хөндсөн гэр бүлийн хүчирхийлэл бусад газартай харьцуулахад өндөр байна (Зураг 5.54-ийг харна уу).

Мандал суманд гарсан гэмт хэргийн мэдээллийг харахад ихэнхи нь орон сууцанд архи уусан үедээ эмэгтэйчүүдийн эсрэг үйлдсэн гэмт хэргүүд байгаа<sup>173</sup> ба гэмт хэргийн хохирогчдын 28.8% нь эмэгтэй, 8.7% хүүхдүүд, үлдсэн 62.5% нь эрэгтэй байна. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид нь ихэвчлэн гэмт хэрэг үйлдэгчтэйгээ хамт амьдардаг тул тухайн дарангуйллын орчноос холдож чадахгүй улам их хохирол амсдагаараа бусад гэмт хэргийн хохирогчдоос ялгаатай. Мөн хохирогч нь хүүхэдтэй, эсвэл гэмт хэрэг үйлдэгчээс орон байрны хувьд хамааралтай бол цаашид нөхцөл

<sup>172</sup> Састэйнабилити Ийст Эйжия. 2015. Гацуурт төслийн нийгмийн суурь судалгааны тайлан, Өрхийн түүвэр судалгаа.

<sup>173</sup> Мандал сумын нийгэм-эдийн засгийн статистик мэдээний танилцуулга, 2014.

байдал нь улам даамжирч төвөгтөй болдог.<sup>174</sup> Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд хохирогч болон гэмт этгээд хоорондоо эвлэрсэн тохиолдолд хэргийг хэрэгсэхгүй болгох талаар заасан байдаг тул Монгол Улсын шүүхээр олон гэр бүлийн хүчирхийллийн тохиолдлыг хэрэгсэхгүй болгосон байдаг.



**Зураг 5.54 Төслийн талбайд эрх нь зөрчигдөж буй хүн амын гол бүлгүүд, тоогоор (Судалгаанд оролцогчдын бодлоор)**

Өрхийн судалгаа болон ЗБХ-ийн үеэр хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд нь ажилтнуудаа хууль бусаар илүү цагаар албадан ажиллуулдаг талаар дурдаж байв. Баянгол сумын уг судалгаанд хамрагдагсдын 43% нь харин Мандал суманд 42% нь энэ талаар мэдээлсэн. Баянгол суманд судалгаанд оролцогчдын 30 гаруй хувь нь, харин Мандал суманд 20 гаруй хувь нь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг онцлон дурдаж байв. Хүүхдүүд мал маллах (өрх, гэр бүлийн гишүүд нь төлбөр цалин төлдөггүй), бичил уурхайн болон ойн аж ахуйн компаниудад цалин хөлстөй ажиллан хөдөлмөр эрхлэх нь элбэг байдаг.

Өрхийн судалгаанд хамрагдагсдын ихэнх нь (ойролцоогоор 55%) орон нутагт аюулгүй байдал хэцүү хүнд асуудал биш боддог. Түүнээс гадна оролцогчдын дийлэнх нь (70%) олон нийтийн аюулгүй байдалтай холбоотой ямар нэгэн хэрэг тохиолдлын тухай сонсож байгаагүй гэж хариулсан байна. Олон нийтийн аюулгүй байдлын талаар санаа зовдог гэж хариулсан үлдсэн хэсэг нь сум, багийн түвшинд архидалт, ажилгүйдэл их байдаг тул аюулгүй байдалдаа санаа зовдог гэж хариулжээ. Үүнийг бататган Баянгол сумын өрхийн судалгаанд хамрагдагсдын бараг 55% нь ажилгүйдэл олон нийтийн аюулгүй байдалд муугаар нөлөөлнө гэж үзсэн бол Мандал сумын судалгаанд хамрагдагсдын мөн талаас их хувь нь архидалт олон нийтийн аюулгүй байдалд сөрөг нөлөөтөй гэж үзсэн байна. Баянгол суманд ажилгүйдлийн түвшин их бөгөөд ажил олдох боломж муу гэсэн ерөнхий ойлголт байдаг нь ихэнх судалгаанд оролцогчдыг суманд олон нийтийн аюулгүй байдал, ажилгүйдэл нь санаа зовоосон асуудал гэж хариулахад хүргэсэн байж болзошгүй. Харин Мандал сум нь санхүүгийн боломж илүү өндөртэй хүн ам бүхий томоохон хот

<sup>174</sup> Гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх арга замууд /Гарын авлага/, 2003.



суурин тул иргэд мөнгөө архинд зарцуулах нь их байдгаас судалгаанд оролцогчид архидалт, олон нийтийн аюулгүй байдлын асуудлыг санаа зовоосон асуудал хэмээн үзсэн байж болзошгүй юм.

орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалтай холбоотой асуудалд мөн бичил уурхайн асуудлыг оруулсан байв. Бичил уурхайчид мөнгөн үс ба бусад химийн бодис (энэ нь дугуй шатаах зэргээс үүсэх) хэрэглэн хортой хог хаягдал үүсгэж буй асуудал, мөн ажлын аюултай орчин (далд хонгил ухах) нь өөрсдөд нь болоод ойр орчмын орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна. Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газрын дарга бичил уурхайн талаар "Бичил уурхайчид цианид, мөнгөн үс зэрэг химийн аюултай бодис ашиглан алт олборлож байгаа нь үндэсний аюулгүй байдалд заналхийлж буй асуудал юм" хэмээн дурдсан. Энэ нь үндэслэлгүй асуудал биш юм. Тайлангийн энэ хэсэгт (мөн тайлангийн бусад хэсэгт) тайлбарласаны дагуу бичил уурхайчидтай холбоотой орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын асуудал нь маш төвөгтэй бөгөөд бичил уурхайн салбарын хууль эрх зүйн орчин бүрдэх эхлэл тавигдаж холбогдох хүндрэлтэй асуудлуудыг дөнгөж шийдвэрлэж эхлээд байгаа юм.

### **6.7.7 Дүгнэлт**

Төслийн бүсийн орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалтай холбоотой гол асуудлуудыг дараах байдлаар нэгтгэн дүгнэж болох юм. Төслийн талбайд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх ажилчдын тоо хангалтгүй байна. Ялангуяа, Мандал суманд эмч нар хүрэлцээгүй, харин сувилагчид харьцангуй хангалттай байгаа бол Баянгол суманд ажиллаж буй эмч, сувилагч нарын тоо Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын стандартаас бага, мөн эмчийн тоо улсын дундажаас доогуур байгаа юм. Эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотойгоор айл өрхүүд эрүүл мэндийн үйлчилгээ муу, эмнэлэгт очиж үйлчлүүлэх цаг гардаггүй, эмнэлэг хүртэлх зай хол байдаг (чухал байдлаар нь эрэмбэлэв) гэсэн хүндрэлүүдийг дурдаж байв. Улсын статистиктай адилаар төслийн талбай дахь нас баралтын гол шалтгаан нь зүрх судасны өвчин болон хавдар байна. 2014 оныхтой харьцуулвал аймгийн түвшинд халдварт өвчний тоо 6.8%-аар өссөн байгаагаас бэлгийн замын халдварт өвчний тохиолдол нийт халдварын дунд хамгийн дээгүүр орсон байв. Сэлэнгэ аймагт бүртгэгдсэн сүрьеэний тохиолдол улсын хэмжээнд хамгийн өндөр байгаа нь тус аймагт бичил уурхайчид их байгаатай холбоотой байж болзошгүй. Бичил уурхайчдын ихэнх нь газар доор битүү хязгаарлагдмал орчинд ажилладаг тул сүрьеэний халдвартай хүмүүс өөр бусад эмзэг, сул биетэй хүмүүст халдвар тараах нөхцөл бүрддэг.

Түнхэл багт зохион байгуулсан ЗБХ-ийн үеэр оролцогчид шороон замаас үүдэлтэй тоос орон нутгийн иргэдийн эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй асуудлыг хөндсөн ба тоосноос шалтгаалан амьсгалын замын өвчлөл нэмэгдэх магадлалтай талаар дурдаж байв. Түнхэлд амьсгалын замын өвчин их байгааг тодорхойлох бололцоогүй, мөн дээрх амьсгалын замын өвчний эрсдэлийг үнэн хэрэгтээ замын тоосжилттой холбон үзэх боломжгүй юм. Алс хол байрлалтай Түнхэл багийн оршин суугчдын ихэнх нь шороон замаа хатуу хүчилттай болгох хүсэлтэй байгаа талаар энд тэмдэглэх нь зүйтэй. Тоос, түүнтэй холбоотой үүсэх эрүүл мэндийн асуудал, нөлөөлөл нь багийн хөгжил, тэр дундаа Гацууртын уурхайн хөгжилтэй холбоотой өргөн хүрээтэй асуудал бөгөөд цогцоор шийдвэрлэх шаардлагатай юм.

Замын хөдөлгөөний аюулгүй байдал ба тээврийн хэрэгслийн ашиглалтын журмыг зөрчин үйлдсэн гэмт хэргийн улмаас нас барсан хүний тоо 2012-2013 онд 18.9%-аар өссөн бол 2014 оны эхний

10 сарын байдлаар энэ тоо нь 2013 оныхтой харьцуулахад 26.7%-иар нэмэгдсэн байна. Мандал сумын ослын гол шалтгаан нь согтуугаар жолоо барьсан, хурд хэтрүүлсэн, халтиргаатай замд машинаа зогсоож чадаагүй зэрэг тохиолдлууд байгаа бол Баянгол суманд гарсан замын ослын гол шалтгаан нь урсгал сөрсөн, эсвэл хурд хэтрүүлсэн тохиолдлууд байна. Гацууртын төслийн замаар зорчиж буй тээврийн хэрэгслийн ихэнх нь хөнгөн тэрэг байгаа ба төслийн талбайд гарч буй зам тээврийн ослын гол шалтгаан нь урсгал сөрөх, хурд хэтрүүлэх, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ машин жолоодох зэрэг эрсдэлээс үүдэлтэй гэж үзлээ. Эдгээр эрсдэл, мөн дээр нь уг замаар олон тооны хүдэр тээвэрлэх ачааны машин зорчих нөхцлийг хамтатган үзвэл замын аюулгүй байдал нь санаа зовоосон, хүндрэлтэй асуудалд тооцогдохоос ч аргагүй юм. Түүнээс гадна Цагдаагийн газрын статистик мэдээнд харуулснаар Сэлэнгэ аймагт гарч буй ихэнх гэмт хэрэг нь замын хөдөлгөөний аюулгүй ажиллагаа, тээврийн хэрэгсэлтэй холбоотой байв. Гацуурт төслийн хүрээнд хүдэр тээвэрлэх том оврын тээврийн хэрэгслийн асуудлыг тооцон үзэлгүйгээр одоогийн замын хөдөлгөөн, тээврийн хэрэгсэлтэй холбоотой гэмт хэрэг, олон нийтийн аюулгүй ажиллагаа нь дангаараа л төслийн талбайн хувьд ихээхэн хүндрэлтэй асуудал болоод байна. Төслийн талбай дахь замын хөдөлгөөний эрсдэлийг бууруулах, аюулгүй ажиллагаатай холбоотой олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх талаар төрийн байгууллагаас аливаа хөтөлбөр хэрэгжүүлж байгаа эсэх мэдээллийг авах боломжгүй байлаа. Мандал сумын ГТХЯ-ын үеэр дурдагдсан гол асуудлын нэг нь Гацууртын төслийн үйл ажиллагааны явцад хүдэр тээвэрлэх ачааны машинаас шалтгаалан Түнхэл багийн замын аюулгүй байдлыг хангах асуудал байсан. Ярилцлагад оролцогчид хүдэр тээвэрлэх замыг сайжруулах, хатуу хучилттай болгох талаар, мөн энэ замаас үүсэж болзошгүй тоосны асуудал, зам дээрх осол зэрэг эрсдэлийн талаар янз бүрийн бодол санаатай байв.

Архи нь гэмт хэрэг гарах гол нөлөө болж байна. Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 33% нь архи, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ үйлдсэн байгаа талаар 2015 оны 5 дугаар сарын Цагдаагийн газрын мэдээнээс харж болно. Мандал суманд бүртгэгдсэн гэмт хэргийн талаас бага хувь нь хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг байгаа бол Баянгол суманд гарсан нийт гэмт хэргийн гуравны нэг нь замын хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын дүрэм зөрчсөн хэрэг байгааг тус сум Улаанбаатар хот болон ОХУ-ын хилийг холбосон олон улсын замын дагуу байрлаж байгаатай холбон тайлбарлаж болох юм. Сум, баг, өрхийн түвшинд судалгаанд оролцогчид нь орон нутгийн гэмт хэрэгтэй тэмцэх хүчин чадал "дундаж болон хангалтгүй" байна гэж хариулсан байна. Сум, багийн түвшинд хүний эрхийн эсрэг гэмт хэрэг тэр бүр бүртгэгддэггүй. Энэ нь сумын иргэд хүний эрхийн талаар мэдлэг мэдээлэл бага, хүн бүр эрхээ хэрхэн эдлэх болон зөрчигдсөн үед ямар арга хэмжээ авах ёстойгоо мэддэггүйтэй холбоотой байж болох юм. Эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл Түнхэл багт судалгаанд хамрагдсан бусад газартай харьцуулахад илүү өндөр гэж тооцогддог. Мандал суманд гарсан гэмт хэргийн мэдээллийг харахад ихэнхи нь орон сууцанд архи уусан үедээ эмэгтэйчүүдийн эсрэг үйлдсэн гэмт хэргүүд байв. Баянгол суманд судалгаанд оролцогчдын 30 гаруй хувь нь, харин Мандал суманд 20 гаруй хувь нь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг онцолсон ба хүүхдийн хөдөлмөр мал хариулах, бичил уул уурхай эрхлэх буюу модны аж ахуйн компаниудад хөлсний ажил хийх хэлбэрээр явагддаг.

## 6.8 СОЁЛЫН ӨВ

### 6.8.1 Оршил

Энэхүү хэсэгт Гацууртын төслийн бүс нутаг дахь соёлын өвийн суурь нөхцөл байдлыг харуулсан. Суурь судалгаанд багтсан соёлын өвийн төрлүүдэд археологийн ач холбогдол бүхий газрууд, хөшөө дурсгалт газрууд болон соёлын биет бус өвийн үнэт зүйлс орсон болно.

Энэхүү хэсгийг Гацууртын төсөлд зориулан бэлтгэсэн *Соёлын биет бус өвийн судалгааны тайлан*-тай хамтруулан унших хэрэгтэй. Иймд, энэхүү нийгмийн суурь судалгааны тайланд соёлын биет бус өвийн судалгааны тайлангийн гол үр дүнг тусгасан болно.

### 6.8.2 Ашигласан тоо мэдээ

Суурь судалгаанд ашиглагдсан мэдээллийн хугацаа нь 2012 оноос 2015 оны хооронд хэлбэлзэнэ. Энэхүү хэсгийг боловсруулахад ашигласан хоёрдогч мэдээллийн гол эх үүсвэрт дээр дурьдсан Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн Гацууртын төсөлд зориулан боловсруулсан “Биет бус соёлын өвийн судалгаа”-ны тайлан, мөн түүнчлэн Ноён уулын ойр орчмын талаарх Монголын археологийн албан ёсны мэдэгдэл<sup>175</sup>, төслийн бүсэд хийсэн биет соёлын өвийн тайлангууд, байршил болон бусад мэдээлэл орсон. Анхан шатны мэдээллийг ганцаарчилсан ярилцлага, зорилтот бүлгийн хэлэлцүүлэгт оролцсон хүмүүс болон төслийн нөлөөллийн бүс нутгийн өрхийн дунд хийсэн өрхийн судалгаанд хамрагдагсдаас цуглуулсан ба энэ сэдвийн хүрээнд хийгдсэн Соёлын биет бус өвийн судалгаанаас авсан.

Энэ хэсэгт багтаагүй нэмэлт мэдээллийг (фото зураг, хүснэгт, зураг, дүн шинжилгээ гэх мэт) анхан шатны баримт бичгээс авч болно.

### 6.8.3 Соёлын өвийн нөхцөл байдал

#### 6.8.3.1 Монгол Улсын соёлын өвийн тойм

Монгол Улс нүүдлийн уламжлалаас улбаатай түүх, соёлын баялаг ихтэй орон гэдгээрээ танигдсан. Монгол Улсын соёл уламжлалд нөлөөлж буй нийгмийн өөрчлөлт, даяарчлал, хурдацтай хөгжиж буй хотжилтын нөлөөлөл улам нэмэгдэж байна. Энэхүү хурдацтай өсөлтийн үед соёлын өвийн хамгаалалтын асуудлыг хэрхэн тэнцвэржүүлэх нь улс орны өмнө тулгамдаж буй ноцтой сорилтуудын нэг болж байна.

Суурь судалгаанд авч үзсэн соёлын өвийн төрлүүд нь:

- Археологийн дурсгалт газрууд гэдэгт хүний үйл ажиллагаатай эсвэл эзлэн түрэмгийлэлтэй холбоотой эртний буюу түүхийн ач холбогдолтой бие цогцос, мөн ихэвчлэн газар доорхи баялагыг оролцуулдаг ба үүний дотор гадаргуу дээр байх эд өлгийн зүйлс эсвэл бүтцийн үлдэгдэл зэрэг багтдаг. Бас эртний булш, эртний суурин газар болон эдгээрийн гадна орчинд бутарсан шаазан эдлэл зэрэг ордог байна.
- Дурсгалт газрууд гэдэгт олон нийтийн ашиг сонирхол болон / эсвэл түүхэн ач холбогдол бүхий газрууд дээрх барилга байгууламж болон шашны дурсгалт газрууд орно.

<sup>175</sup> Ноён уулын ойр орчмын талаарх Монголын археологийн албан ёсны мэдэгдэл, 2012 <http://news.gogo.mn/r/83991>



- Биет бус соёлын өвийн үнэ цэнэ бүхий зүйлсүүд болон газрууд гэдэгт орон нутгийн иргэдийн зан заншил, нүүдлийн мал аж ахуй, ардын домог гэх мэт орчин үеийн хүн амын оюун санааны болон соёлын амьдралын нэг хэсгийг бүрдүүлж байгаа биет бус соёлын өвийн үнэ цэнэ бүхий зүйлс болон газрууд орно. Биет бус соёлын өвд бүс нутгийн буюу хүн амын онцлог болон нийгмийн нягтралыг тодотгосон уламжлал, ёс заншил, итгэл үнэмшлийг хэлнэ. Биет бус соёлын өвийн үнэ цэнэ бүхий газруудад ихэвчлэн соёлын өвийн уламжлалт хэлбэрийг агуулсан түүх дурсгалын хөшөө, археологийн ба түүхэн газар нутаг ордог ба мөн түүнчлэн тэдгээрт ургамал, амьтны аймаг болон ялангуяа экологийн бүс нутаг зэрэг байгалийн шинжийг харуулсан газар нутгийг оруулж болно. Биет бус соёлын өвийн үнэ цэнэ бүхий газрууд нь ялангуяа Монгол Улсын хууль тогтоомжоор хамгаалагдаагүй.

### Археологийн ач холбогдол бүхий газрууд:

Монгол Улс баялаг түүхтэй учраас улс орон даяар хэдэн зуун мянган хараахан олж илрүүлээгүй археологийн дурсгалт газрууд байж болно гэж таамаглах нь үндэслэлтэй боловч эдгээр таамаглал үндэслэлтэй эсэхийг баталгаажуулах аргачлалыг үргэжлүүлэн ашиглах шаардлагатай. Монгол дахь гол археологийн нөөцийг дараах байдлаар тоймлон үзүүлэв:

### Хүснэгт 5.51 Археологийн мэдэгдэж буй нөөцийн он цагийн хураангуй

Соёлын эрин үе	Зуун	Газар нутгийн төрөл	Газар зүйн байршил, хэмжээ (мэдэгдсэн газрууд)
Палеолитийн доод үе	800,000-100,000 жилийн өмнөх үе	Чулуун зэвсэг	Баянхонгор аймаг, Өмнөговь аймаг, Баян-Өлгий аймаг
Палеолитийн дунд үе	100,000-40,000 жилийн өмнөх үе	Хэд хэдэн жижиг малчдын хот болон суурин газар	Баянхонгор аймаг, Өмнөговь аймаг, Өвөрхангай аймаг
Палеолитийн дээд үе	100,000-40,000 жилийн өмнөх үе	Ихэвчлэн чулуун зэвсэг хийж байсан газар нутаг	Булган аймаг, Хэнтий аймаг, Өвөрхангай аймаг
Чулуун зэвсгийн дунд үе	12,000-8,000 жилийн өмнөх үе	Ихэвчлэн чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн газар нутаг	Монгол орны ихэнхи бүс нутагт
Шинэ чулуун зэвсгийн үе	8,000-3,000 жилийн манай эриний өмнөх үе	Олон төрлийн чулуу, чулуу	Монгол орны ихэнхи бүс нутагт
Хүрлийн үе	МЭӨ 2000 –с эхлэсэн	Хүрэл хайлуулах үйл ажиллагааны үлдэгдэл, хавтан булш, булш хиргисүүр, буган чулуу, хадны зураг	Монгол орны бүх нутгаар
Чандмань соёлын үе	Төмрийн эхэн үед	Өвөрмөц овог аймгийг харуулсан тусгай булш	Увс аймгийн Улаангом сумын ойр Чандмань уул
Пазырыкийн соёлын үе	МЭӨ 2-6-р зуунд	Сайхан урласан эд өлгийн зүйлстэй булшууд	Монгол орны Алтайн уул нурууд
Хүннүгийн үе	МЭӨ 3-р зуун	Булшууд (дээдсийн болон энгийн), том хот суурин болон хадны зураг	Монгол орны бүх нутгаар
Түрэгийн үе	МЭ 6-10-р зуунд	Эзэн хаан болон жирийн иргэдэд зориулан барьсан дурсгалын хөшөө цогцолбор, эртний бичвэртэй чулуун эдлэл, уран баримлын барилгууд, чулуун	Хэнтийн уул нуруудаас Алтай хязгаар хүртэл өргөн тархсан.

		болон бусад бүрэлдэхүүн хэсгүүдэд байх уран зураг болон бичээс, мөн түүнчлэн оршуулгын газар, булш	
--	--	--	--

Тайлбар: МЭӨ-манай эриний өмнөх, МЭ –манай эриний.

### Палеонтологийн нөөц:

Монгол Улс археологийн баялагтайгаас гадна палеонтологийн арвин нөөцтэй юм. Монгол Улсад дэлхий даяар алдаршсан олон палеонтологийн газрууд байдаг. Байшин цав, Хуурай цав, Амтгай, Өрлөв худаг болон Шар цав зэрэг палеонтологийн газруудад амьтны (тухайлбал үлэг гүрвэл) болон 145 сая жилийн өмнө байсан Месозойк эриний Эртний Цэрдийн галавын үеийн харуулсан ургамлын хувьсалыг харуулж байна. Үлэг гүрвэлийн чулуужсан яс болон бусад үлдэгдэл Төв Азийн бүс нутагт олдсон нь Хойд Америкт тархан амьдарч байсан "нугасан хошуутай" үлэг гүрвэлийн бүлийн шилдэг нь болох Hadrosauridae үлэг гүрвэлүүдийн тархалтын төв байсан гэдгийг баталж байна. Их хэмжээний чулуужсан яс Монголын геологийн хэсэгт хадгалагдан үлдсэн байгаа нь (жишээлбэл дөрөвдөгч үе гэдэг нь 2.4 сая жилийн өмнөөс одоог хүртэлх) энэ хугацаанд амьдарч байгаа зүйлийн дасан зохицол, хувьсалын талаар ойлголт өгөхөөр байна.

### Соёлын биет бус өв:

Археологийн арвин өвтэйгээс гадна монголчууд ЮНЕСКО-гийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үндэсний дуу хөгжим, дархны урлаг, хэл, шашны зан үйл, нүүдлийн мал аж ахуй, морь сургах болон бусад үндэсний спорт зэргийг багтаасан соёлын биет бус өвийн баялагтай. Монгол Улсын соёлын өвийг хамгаалах асуудлыг зохицуулсан хуулиуд байдаг хэдий ч соёлын биет бус өвийг бүхэлд нь авч үзсэн тодорхой хууль тогтоомж эсвэл акт байдаггүй. Харин 2001 онд батлагдсан "Соёлын өвийг хамгаалах тухай" хууль нь гол хууль эрх зүйн акт болж байна.

ЮНЕСКО-д бүртгэлтэй үндэсний соёлын биет бус өвд:

- Уламжлалт морин хуурын урлаг (2003);
- Монголын уртын дуу (2005);
- Монголын хөөмийн урлаг (2010);
- Уламжлалт үндэсний баяр-Наадам (2010);
- "Шонхорын ан" буюу Бүргэдийн ангийн ёс заншил (2010).

Цаашдаа яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн ЮНЕСКО-гийн жагсаалт:

- Уламжлалт ардын бүжиг – биелгээ (2009);
- Монголын ардын тууль (2009);
- Монголын уламжлалт цуур хөгжмийн урлаг (2009);
- Лимбээр тоглож уламжлалт ардын уртыг дууг үзүүлэх арга барил- удаан амьсгал (2011);
- Монголын уламжлалт гэр хийц хийх заншил (2013);
- Монгол бичиг (2013);

- Шагай харваа – 2014.

ЮНЕСКО-гийн дэлхийн баримтат өвийн жагсаалтад:

- Ганжуур эргэх 9 эрдэнийн чулуу (2013);
- Алтан товч: Алтан түүх (2011);
- Монголын Ганжуур Данжуур (2011).

Эцэст нь Монгол дахь дэлхийн байгалийн өвийн газруудын ЮНЕСКО-гийн жагсаалтанд дараах газрууд орсон. Үүнд:

- Увс нуурын ай сав газар (2002);
- Орхоны хөндийн соёлын дурсгалт газар (2004);
- Алтайн хадны зургийн цогцолбор (2011).

#### 6.8.3.2 Монгол Улсын соёлын өвийн захиргаа

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам нь улс орны соёлын өвийн асуудлыг хариуцан ажилладаг. Харин Монгол Улсын Шинжлэх ухааны академийн харъяа Археологийн хүрээлэн (ШУААХ) болон Монгол Улсын Шинжлэх ухааны академийн харъяа Угсаатан зүй, түүхийн хүрээлэн (ШУАУЗХ) соёлын өвийн чухал зүйлсийн хамгаалах судалгаа, баримтжуулах ажлыг гүйцэтгэдэг гол байгууллагууд юм. Монгол Улсын Шинжлэх ухааны академийн гол зорилго нь нийгмийн тогтвортой хөгжлийн зорилтод хүрэхэд чиглэгдсэн олон улсын хэмжээнд чадвартай, онолын судалгаа шинжилгээний байгууллагуудын сүлжээгээр бий болсон Монголын шинжлэх ухааны төв байгуулах юм.

#### 6.8.4 **Соёлын биет өв<sup>176</sup>**

Одоогийн байдлаар Монгол Улсад биет соёлын өвийн газруудын ач холбогдлыг үнэлэх тодорхой стандартчилсан удирдамж эсхүл арга барил байхгүй байна. Төслийн бүс нутагт хийсэн судалгаагаар тухайн газар нутгийн дурсгалууд, газруудыг илрүүлсэн (1925 оноос хойш дундажаар 200 гаруй дурсгалууд олсон). Мандал сумын эргэн тойронд орон нутгийн тусгай хамгаалалттай хоёр газар байгаа нь Зуун Модны гол (гол) болон Ноён уулын газар юм. Мөн улсын хамгаалалттай хоёр газар (Түжийн нарс, Хан хэнтийн улсын тусгай ангилалд хамгаалалттай газар нутаг), мөн 30 орон нутгийн тусгай хамгаалалттай газар байна (Гацууртын замыг огтлолцсон хоёр газар нь Зуун Модны гол болон Ноён уул). Эдгээр газрууд хадгалалт, хамгаалалтаас хамааран янз бүрийн байдалтай байна.

Баянгол сумын хүрээнд Соёлын өвийн тооллогыг 2014 онд хийж соёлын өвийн бүх зүйлсийг бүртгэсэн ба биет бус соёлын өвийн талаар анхаарч байна. Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Гацууртын уурхайн ашиглалтын талбайд саяхан (2015 он) хийсэн судалгаагаар


<sup>176</sup> **ЕСБХБ-ны гүйцэтгэлийн шаардлагууд:**

Соёлын биет болон биет бус өвийн талаарх ЕСБХБ-ны бодлого нь ГШ 8-д тусгагдсан бөгөөд энэхүү ГШ 8-ын зорилтууд:

- Соёлын өвийг хамгаалах, хадгалах ажлыг дэмжих,
- төслийн үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс соёлын өвийг хамгаалахдаа нөлөөллийг шат дараатай бууруулах арга замыг ашиглах,
- бизнесийн үйл ажиллагаанд соёлын өвийг ашигласнаас олох үр ашгийг тэнцүү хуваах явдлыг дэмжих,
- хэрэв боломжтой бол соёлын өвийн тухай ойлголт, үнэлэмж бахархлыг түгээн дэлгэрүүлэх асуудлууд болно.



Монголын үеийн (12 – 18 зуун) соёлын биет өв бүхий таван (5) газрыг илрүүлсэн байна. Монгол Улсын Шинжлэх ухааны академиас эдгээр газруудыг цаашид судалсаны хэрэггүй гэсэн зөвлөмж гарсан байна. Соёлын өвийн гол газруудын байршилыг Зураг 5.55-д үзүүлэв. Соёлын өвийн нөөцийн аюулгүй байдлыг хангах зорилгоор тайлбаруудыг оруулаагүй.



### Зураг 5.55 Гацууртын төслийн нөлөөллийн бүсэд байрлах соёлын биет өв газар

Сэлэнгэ аймаг нь аймгийн хамгаалалтанд авсан дараах ариун дагшин газруудтай:

**Ноён уул:** Мандал сумын нутагт орших Ноён уул нь байгаль, түүх, соёлын чухал ач холбогдолтой уул нурууд юм. 1924 онд Ноён уул орчмын газраас авчирсан археологийн олдворууд одоо Санкт-Петербург хотын Улсын Эрмитаж музейд хадгалагдаж байна. Ноён уулын өв, эртний түүх болон соёлын тухай хамгийн сүүлийн үеийн шинжлэх ухааны судалгааг 2006 онд хийсэн байна. Ноён уулын ойр орчмын нутагт 500 танигдсан эртний булшнууд байдаг. Ноён уулын ойр орчмын нийт талбай нь 90,000 га газарт байршдаг бөгөөд үүнээс Мандал суманд 80,000 га газар, Төв аймгийн Борнуур, Батсүмбэр сумуудад үлдсэн 10,000 га газар нь хамаарч байна. Ноён уул нуруудын газарт байрлах Ноён уул соёлын өвийн гол дурсгалт газруудтай тухайлбал "Гурван найзын агуй", "Их мандал", "Ширхэнцэг уул", "Бичигт хад"-тай ойр байрладаг. 1920 онд үндэсний ач холбогдол бүхий газруудын талаарх орон нутгийн иргэдийн мэдлэг дээр тулгуурлан Эрмитажий судлаачид археологийн судалгаануудыг явуулж, Сүжигтэй гэдэг газраас Монгол Улсын Хүннүүгийн үеийн соёлын өвийн олдворуудыг малтан гаргаж авсан. Зураг 5.56-д Ноён уулаас малтаж гаргаж авсан зарим олдворуудыг харуулсан байгаа.

Ноён уул улсын тусгай хамгаалалттай газар нь Гацууртын төслийн уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн гадна төслийн талбайгаас 7 км-ийн зайд байрладаг. Гацууртын төслийн байршил нь олон нийтийн Ноён уул руу гарах гарцыг хаагаагүй, Ноён уулыг тахилга болон бусад зорилгоор ашиглах боломжинд нөлөөлөл үзүүлээгүй байна. Үүнээс гадна, зам ч гэсэн тахилгын газруудад саад учруулдаггүй бөгөөд замаас тухайн газар руу явган алхаад хүрэх боломжтой (Зураг 5.55-д соёлын өв бүхий газруудын байршлийг Гацууртын төсөл болон замтай харьцуулан харуулсанаар гадна уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хил хязгаар болон замын Ноён уултай харьцуулан харуулсан байна).



**Зураг 5.56 1926-1927 оны Ноён уулнаас олдсон археологийн олдворууд<sup>177</sup>**

**Ардын хувьсгалын өлгий Алтанбулаг** суманд хувьсгалын музей, манай улсын анхны бага сургууль, анхны банкны болон Шүүхийн байшин, Дөрвөлжин сүм, Ардын журамт цэргийн анхны байшин зэрэг түүх, дурсгалын газрууд байрладаг. 2013 онд Алтанбулаг музейн Ардын Засгийн газрын байрыг сэргээн засварлагдсан.<sup>178</sup>


**Амарбаясгалант хийд** нь Баруунбүрэн сумын нутагт байрлах Бүрэнхаан уулын хойморт байрлана. Хийдийг Манжуурын засгийн газрын бодлогоор монголчуудын дунд шарын шашныг дэлгэрүүлэх зорилготой байгуулагдсан байна. Security cameras have been installed to better preserve the site.

<sup>177</sup> Ноён уулын ойр орчмын талаарх Монголын археологийн албан ёсны мэдэгдэл, 2012 <http://news.gogo.mn/r/83991>

<sup>178</sup> Сэлэнгэ аймгийн Боловсрол, соёлын газар.

**Улсын тусгай хамгаалалттай** 65,549 га бүхий **Тужийн нарс** байгалийн цогцолбор газар нь Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Шаамар сумдын нутагт байрладаг бөгөөд гал түймрийн аюул, ашиг хонжоо хайгчдын гарт өртөн нилээд сүйджээ. Сүүлийн жилүүдэд 7 500 орчим га талбайд нөхөн сэргээлт хийсний үр дүнд 40-50% нь байгалийнхаа аясаар сэргэн ургажээ. Тужийн нарс нь байгалийн зүй тогтоцын хувьд өвөрмөц бөгөөд Сибирийн их тайгын зүүн өмнөд төгсгөл, Хэнтийн нурууны салбар уулсын үргэлжлэл болдог.

Тогтвортой аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх замаар төрөлжсөн эдийн засгийн өсөлтийн гол хүчин зүйл нь Монголын соёлын өвийн болон байгалийн өвөрмөц газрууд юм. Гэхдээ эдгээр газрууд нь зохицуулалт хийгдээгүй уул уурхайн ашиглалт болон удирдлага хангалтгүй сул байсан зэргийн золиос болсон. Орон нутгийн иргэд, айлчлагчдын тусын тулд орон нутгийн төрийн байгууллагаас гаргасан соёлын өвийн газруудын тогтвортой менежмент нь Монгол Улсын хэмжээнд гол асуудал болоод байна. Төслийн бүс нутгийн судалгаанд оролцогчид орон нутгийн соёлын өвийн зорилго, үйл ажиллагаанд дунд зэрэг оролцдог гэж хариулсан байна. Соёлын өв ач тусаа хэрхэн өгч байна гэж асуухад Хэрх багийн судалгаанд оролцогчдын 42.3% нь, Түнхэл багийн оролцогчдын 36.7% нь "Орон нутгийн соёлын өв суманд ихээхэн ач холбогдолтой" гэж хариулсан. Дунджаар оролцогчдын ихэнх нь соёлын өв ямар ч ач тусаа өгч байгаагүй гэж хариулсан байна. Энэ хариултыг Баянгол сумын оролцогчид илүү хариулж байгаа нь ажиглагдсан ба судалгаанд оролцогчдын талаас илүү хувь (51.1%) нь соёлын өв нь ямар ч ач тусаа өгдөггүй, харин 30.7% нь ач тусаа өгдөг гэж хариулсан байна.



**Зураг 5.57 Сумын соёлын өвийн ач тусын талаарх өрхийн судалгаанд хамрагдсан оролцогчдын хариулт, хувиар**

### 6.8.5 Соёлын биет бүс өв

2010 онд Монголын соёлын өвийн үндэсний тооллогыг явуулсан бөгөөд чухал ач холбогдолтой соёлын өвийн жагсаалтыг гаргав. Энэ тооллого нь 2015 онд шинэчлэгдэхээр төлөвлөгдөж байгаа. Сэлэнгэ аймгийн<sup>179</sup> соёлын биет бүс өвийн дараах гол үйл ажиллагаанууд байна:

<sup>179</sup> Аймгийн ИТХ-ын зөвлөх



- Сэлэнгэ аймаг 4 жилд нэг удаа маш нарийн зан үйл, ёс заншилтай **5 Хан уулын тахилгын ёслолыг** зохион байгуулдаг. Шүшлэгтэй уул нуруудыг тахихтай холбоотой олон элемент байдаг ба судар унших, урлагийн тоглолт, ардын урлаг, ардын дуу, ардын мэдлэг, домог, ерөөл, магтаал, тууль зэргийг хуваалцах байдлаар хадгалагдаж хөгжиж байдаг.
- **Ноён уулын тахилга** (дээр дурьдсан 5 Хан уулын тахилгатай холбоогүй) болдог. Ноён уулын ойр орчим амьдардаг өрхүүд Ноён уулыг социализмын үеэс өмнө тахидаг байсан гэжээ<sup>180</sup>. Шилжилтийн үед уул нуруудыг тахих уг санаа дахин сэргэсэн. Ноён ууланд байгаа олон төрлийн овоог<sup>181</sup> тахих зан үйлийг хийж байна. Цаашид бөө удганууд жилд хэд хэдэн удаа тахилга хийхээр уг газарт очдог ба бүс нутагт хийсэн судалгаанаас харахад уг уултай холбоотой хорио цээр, домог байдаг нь тогтоогдсон. Гацууртын төслийн уурхайн бүсийн биет бус соёлын өвийн угсаатан зүйн судалгааны тайланд (Састэйнабилити Ийст Эйжия ХХК ба Түүх, археологийн хүрээлэн, Монгол Улсын Шинжлэх ухааны академийн хамтран гүйцэтгэсэн) Ноён уулыг тахих зан үйл нь уян хатан буюу уулын тогтсон тодорхой газарт хийх албагүй байдаг гэж тодорхойлсон. Тухайлбал “өнгөрсөн үед Ноён уулыг өвөр талаас нь буюу Балж уулын талаас нь шүтдэг байсан боловч ойрын үед тэнд уурхайн үйл ажиллагаа [Сентеррагийн төслүүдтэй холбоогүй] эхэлснээс үүдэн уг зан үйл тасалдаж уулын хойд талд нь шүтлэгийн зан үйлийг үйлдэж байна”. Гацууртын тээврийн зам баригдсанаар уул руу орон нутгийн иргэд болон төслийн үйл ажиллагааны хүрээнд хүмүүс хүрэх мөн ууланд сүсэглэж мөргөх боломжийг олгосон. Замын ойролцоо одоогоор мэдэгдээж буй сүсэглэж мөргөдөг хоёр газар бий. Эхнийх нь эртнээс оршиж байсан газар бөгөөд зам барьснаар энэ газар хүрэхэд дөхөм болгосон. Хоёр дахь газарт зам барьсны ачаар хүрэх боломжтой болсон (тээврийн зам барихаас өмнө зан үйл үйлддэггүй байсан).

“Тиймээс [Ноён уултай холбоотой] зарим цээр байдаг нь ажиглагдсан. Жишээлбэл нутгийн уугуул иргэд хэлэхдээ Ноён уул орчмын ой модонд хэд хэдэн удаа гал түймэр гарсан боловч азаар энэ нь Ноён уул хүрээд гэнэт цас бороо орсноор зогссон гэв. Энэ нь хүмүүс Ноён уулыг хэрхэн шүтэж биширдэг мөн энэ уул нь сөрөг нөлөөлөл, үйл явдлаас хэрхэн хамгаалдагийн илрэл юм”.

Састэйнабилити Ийст Эйжия ХХК & Монголын ШУ-ны академийн харьяа Түүх, археологийн хүрээлэн хамтран гүйцэтгэсэн *Гацууртын уурхайн талбайн бүсэд биет бус соёлын өвийн талаарх угсаатны зүйн тайлан*

<sup>180</sup> Састэйнабилити Ийст Эйжия ХХК & Монголын ШУ-ны академийн харьяа Түүх, археологийн хүрээлэн, 2015.

Гацууртын уурхайн талбайн бүсэд биет бус соёлын өвийн талаарх угсаатны зүйн тайлан, Монгол Улсын Сэлэнгэ аймгийн Мандал сум.

<sup>181</sup> Ихэвчлэн уулын онгод сахиус болон шүтлэгтэй мод, нуур эсвэл булаг зэргийн сүнслэг ач холбогдолтой байгалийн бие махбодийг тэмдэглэж энэхүү овоог (овоо гэж нэрлэдэг) бүтээдэг байна. Овоо нь орон нутгийн хүрээнд байгалийн гамшигийн (гал түймэр, зуд) үед залбирал, мөрдлөг хийх шашны мөргөлийн газар болгон ашиглах зэргээр олон үүргийг бий болгож байсан.



**Зураг 5.58 Мөргөлчид өглөө эртлэн Ноён уулын тахилгын ёслолд ирж байгаа нь, 2015 оны 6 дугаар сар<sup>182</sup>**



**Зураг 5.59 Ноён уулан дээр бөө нарын шинээр босгосон овоо<sup>183</sup>**

<sup>182</sup> Ibid.

<sup>183</sup> Састэйнабилити Ийст Эйжия ХХК & Монголын ШУ-ны академийн харъяа Түүх, археологийн хүрээлэн, 2015. Гацууртын уурхайн талбайн бүсэд биет бус соёлын өвийн талаарх угсаатны зүйн тайлан, Монгол Улсын Сэлэнгэ аймгийн Мандал сум.





**Зураг 5.60 Ноён уулын орой болох Хатан овоо тахилгын газар<sup>184</sup>**

- **Эвт модны наадам** – Уг наадмыг буриад хүмүүстэй (ОХУ-аас) хамтран хоёр жилд нэг удаа зохион байгуулдаг юм. Энэ наадам нь хилийн бүс нутагт энх тайван, эв найрамдалтай харилцааг дэмжих, соёлын үйл ажиллагаа, туршлагаа хуваалцах зорилготой ОХУ болон Монгол Улсын аль нэгэнд нь зохион байгуулдаг. Наадмыг зохион байгуулах газар нь хоёр улсын хүрээнд харилцан адилгүй өөр өөр байдаг. Монгол Улсад зохион байгуулах үед Сэлэнгэ аймагт дандаа хийдэггүй.
- **Ээж мод** - Жил бүр Монголын сүсэгтэн олон 4-р сарын 1-нд ирж Ээж модыг тахиж, мөргөдөг.<sup>185</sup> Ээж модын тахилгын ёслолыг Сүхбаатар сумын Ээж модны газарт үйлддэг.
- **Хаврын баяр** – Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд хавар болгон уламжлал болгон хаврын арга хэмжээг тэмдэглэж Хаврын баярыг аймгийн ЗДТГ-аас зохион байгуулдаг байна.
- **Сумын соёл, эдийн засгийн үйл ажиллагаа**,<sup>186</sup> жил бүр болдог бөгөөд энэхүү арга хэмжээний үеэр сум тус бүр өөрийн сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, соёл, урлаг, аялал жуулчлалын ажил үйлчилгээний хүртээмжийг дэвшүүлэх, эдийн засгийн чадамжийг нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор өөрийн сумын танилцуулгыг хийдэг.

<sup>184</sup> Ibid

<sup>185</sup> Сэлэнгэ аймгийн долоон гайхамшиг.

<sup>186</sup> [http://www.selenge.gov.mn/index.php?option=com\\_content&view=article&id=1240:2014-06-30-01-54-38&catid=104:sus&Itemid=162](http://www.selenge.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=1240:2014-06-30-01-54-38&catid=104:sus&Itemid=162).



- **Ургацын баярыг** жил бүрийн 11-р сард Сэлэнгэ аймгийн хүмүүс нь өөрийн аймгийг Монгол Улсын хөдөө аж ахуйн гол бүс болох байр суурийн үүднээс ургац хураалтын ажлыг тэмдэглэдэг.
- **Гонгорын бумбын тахилга, Цам харайх** зан үйл зэрэг нь Амарбаясгалант хийд дээр жил бүрийн 7 сард болж өнгөрдөг. Гонгорын бумбын тахилга нь зөвхөн Баруунбүрэн суманд байрлах Амарбаясгалант хийдэд болдог. Гонгорын бумбыг “баяжихын бумба” гэдэг багаад бумбыг бүтээлгэснээр буян хишиг арвижиж, эд хөрөнгөөр элбэг дэлбэг болдог ажээ.
- **“Бид Сэлэнгийн үр сад” наадмыг** аймгийн Засаг даргын А/357 тоот захирамжийн дагуу амжилттай зохион байгууллаа. Энэхүү наадам нь хүүхэд өсвөр үеийнхэнд ардын урлагийн өв санг эзэмшүүлэх өвлүүлэх, тэдний авъяас чадварыг хөгжүүлэх, үндэсний ёс заншлаараа бахархах урлаг, гоо зүйн хүмүүжлийн олгох зорилготой.

Үүний зэрэгцээ, биет бус соёлын өвийг хамгаалах дараах үндэсний хөтөлбөрүүд аймаг даяар хэрэгжиж байна:

- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах үндэсний хөтөлбөр;
- Орон нутгийн үндэсний урлагыг дэмжих хөтөлбөр;
- Сонгодог урлаг; ба
- Морин хуур – Уртын дуу.

Биет бус соёлын өвийг хадгалж үлдэхийн тулд энэ нутгийн иргэдэд ач холбогдолтой байлгаж байнга шинэчилж нэг үеэс хойч үедээ залгамжилж байх ёстой. Дээр дурьдсан үйл ажиллагаанууд нь соёлын дурсгалын хадгалалт хамгаалалтыг дэмжих нэг механизм бөгөөд үүнийг мэдлэг, ур чадвар, утга учрыг дамжуулах замаар хэрэгжүүлнэ. Энэ нь Монгол Улсад цаашдаа тасралтгүй үргэлжилж хөгжих, ач холбогдлыг нь ойлгох шаардлагатай биет бус өвийн олон янзын өөр өөр хувилбарыг бататгаж хамгаалах зорилготой. Эдгээр үндэсний хөтөлбөрүүдэд оролцох олон нийтийн оролцооны түвшинг тодорхойлох боломжгүй байв.

#### 6.8.5.1 Соёлын өв хариуцсан байгууллага

Ардчилсан нийгэм рүү шилжсэний дараа 1990 онуудад соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын улсын хөрөнгө оруулалт эрс буурсан байна. Санхүүжилт буурснаар соёлын байгууллага, барилга байгууламжууд маш хурдан муудсан байна. Энэ нь хөдөө орон нутагт соёлын өвийн мэдлэгийн алдагдал, түүнчлэн ажилтануудын их хэмжээний халгаа сэлгээ, боловсон хүчний хомсдол зэрэгт хүргэх алслагдсан газар нутгаас хот суурин газар руу явагдах хүн амын шилжилт хөдөлгөөнөөс үүдэлтэй.

Сэлэнгэ аймагт хүн амд соёлын үйлчилгээ үзүүлдэг дараах соёлын байгууллагууд байдаг:

- 21 соёлын төв;
- 2 нийтийн номын сан;
- 1 аймагийн музей;
- 1 соёл мэдээллийн төв;

- 6 сумын номын сан; ба
- 32 сургуулийн номын сан.<sup>187</sup>

2014 онд Засгийн газар сумын хөрөнгө оруулалтаар барьсан аймаг ба сумын соёлын төвүүдийг сэргээн засварлалтын хөтөлбөр эхлүүлсэн бөгөөд энэ хөтөлбөрийг эхлүүлэх нь 2015 оны 5-р сарын 1-ний өдөр соёлын өвийн улсын тооллогоо эхлэх өдөртэй давхцсан байна.


Соёлын өв нь мэргэжлийн болон мэргэжлийн бус хөдөлмөр эрхлэлтийн чухал эх үүсвэр юм. Сэлэнгэ аймгийн соёлын өвийн байгууллагуудад орон тооны соёлын өвийн 161 ажиллагсад ажилладаг. Аймгийн түвшинд мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байдлаас харахад соёлын төвүүд нь мэргэжлийн үр чадвартай ажилтнаар дутмаг нь ажиглагддаг. Техникийн болон мэргэжлийн сургалтанд хамрагдсан соёлын өвийн мэргэжилтний хомсдол (ялангуяа дээд мэргэжилтэй) нь зөвхөн Сэлэнгэ аймагт бус Монгол Улс даяар тулгарч буй гол асуудал юм. Аймгийн соёлын төвүүд 65 ажилтантай бөгөөд тэдний 42% нь мэргэжлийн бус ажилчид (өөрөөр хэлбэл, соёлын өвийн мэргэжлийн үр чадвар байхгүй) юм байна. Аймгийн сургуулийн номын сан 2 мэргэжлийн, 7 тусгай мэргэжлийн, 23 мэргэжлийн бус нийт 32 ажилтантай байна. Гэсэн хэдий ч, салбарт мэргэжлийн үр чадвар дутагдаж байна. Техникийн болон мэргэжлийн сургалтанд (үүнд докторын зэрэгтэй мэргэжилтэн багтана) хамрагдсан соёлын өвийн мэргэжилтний хомсдол нь гол асуудал болоод байна. Соёлын өвийн нөөцийн тусгай мэргэжлийн, мэргэжлийн мэргэжилтнүүдийн тоо бага байгаа нь тухайн жилд археологи, палеонтологийн газруудад судалгаа, түүнчлэн талбайн шаардлагатай<sup>188</sup> малталт зэргийг хэр их хэмжээний газарт хийж байгаатай шууд холбоотой байдаг. Сэлэнгэ аймгийн соёл, урлагийн байгууллагуудад тулгарч буй энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд, соёл урлагийн их сургуульд элсэн орох сурагчдын тоог жил бүр 2-3 оюутанаар нэмж байна. Цаашид мэргэжилтнүүд дутмаг байдлыг арилгах тулд, 2003 оноос хойш Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас санхүүжүүлдэг 3-аас 21 хоногийн мэргэжлийн сургалтанд музей, номын сангийн захирал, дарга зэрэг соёл, урлагийн нийт 17 ажилтанг хамруулж байна.

#### 6.8.5.2 Соёлын өвийн талаархи орон нутгийн иргэдийн санал бодол

Төслийн бүсэд соёлын өвийн ач холбогдол, хамгаалалт, хариуцлагын талаархи санал ялгаатай байна. Соёлын өвийн хамгаалалт, менежментийн талаар орон нутгийн санал бодлыг тодорхойлох явцдаа, өрхийн түүвэр судалгаа нь Баянгол сумын судалгаанд оролцогчдын 57.6%, Мандал сумын судалгаанд оролцогчдын 51.6% нь соёлын өв төрийн хамгаалалтад аюулгүй байх ёстой гэж боддог гэдгийг олж мэджээ.


<sup>187</sup> [http://selenge.gov.mn/index.php?option=com\\_content&view=article&id=252%3A2011-03-04-19-29-44&catid=74%3Aub&Itemid=216](http://selenge.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=252%3A2011-03-04-19-29-44&catid=74%3Aub&Itemid=216).

<sup>188</sup> Састэйнабилити Ийст Эйжия ХХК. 2014. Монгол Улсын уул уурхайн салбарын Байгаль орчин, нийгмийн стратегийн үнэлгээ.



**Зураг 5.61 Түүх, соёлын өвийн хамгаалалтын талаархи олон нийтийн ойлголт хандлага, хувиар**

Төслийн бүсэд аман уламжлал маш их ач холбогдолтой юм. Өрхийн түүвэр судалгаагаар "орон нутгийн түүх, соёлын ховор зүйлсийн тухай хэнээс олж мэдэж байна" гэсэн асуултыг асуухад Мандал, Баянгол сумдын оролцогчид аль аль нь соёлын өвийн талаарх мэдээллийн гол эх үүсвэрээ хамаатан садан, гэр бүлийн гишүүд гэж хариулсан байна. Энэ нь Монгол Улсын аман түүх, зан уламжлалын хүрээнд айл өрх нь соёлын өвд маш их хүндэтгэлтэй ханддаг гэдгийг илтгэж байна. Соёлын өвийн талаар мэдээлэл авах хоёр дахь гол эх үүсвэр нь сургууль, албан бус сургалт юм. Соёлын өвийн талаархи мэдлэг, мэдээллийг ихэнх хүмүүс гэр бүл, албан бус сургалтаас олж авч байгаа явдал нь орон нутгийн хүмүүсийн мэдээлэл, боловсролын хэрэгцээг хангах орон нутгийн байгууллагын (мэргэжлийн болон материалын аль аль нь) чадавхи дутмаг байгааг илтгэж байна.



**Зураг 5.62 Соёлын өвийн мэдээллийг олж авдаг эх сурвалж, хувиар<sup>189</sup>**

<sup>189</sup> Олон сонголттой хариулт тул нийлбэр дүн 100%-тай тэнцүү биш

Өрхийн түүвэр судалгаа нь цаашид соёлын өв, уламжлалыг хүндэлж, авран хамгаалахад нь уул уурхайн компаниудад гарын авлага болох бүртгэл, мэдээллийн санг сайжруулах, шаардлагатай хууль эрх зүйн орчинг бий болгохын тулд мэргэжлийн байгууллагууд соёлын өвийн талаар дэлгэрэнгүй судалгаа явуулах хэрэгцээ байгааг харуулсан. Түүнчлэн, судалгаанд оролцогчид соёлын өвийг хамгаалж, арчлах чадавхи бэхжүүлэх нэг гол хэсэг нь орон нутгийн иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлж, мэдээллийг илүү хүртээмжтэй болгох явдал гэж үзэж байна.

### **6.8.6 Дүгнэлт**

Соёлын өвийн талаар гарч буй гол санаа, асуудлуудыг дараах байдлаар нэгтгэн харуулав. Төслийн бүс нутагт соёлын өвийн тухай мэдээллийн гол эх үүсвэр нь хамаатан садан, гэр бүлийн гишүүд юм. Энэ нь Монголд айл өрх, аман түүх уламжлалын хүрээнд соёлын өвийн талаарх ойлголт хүчтэй байгааг харуулж байна. Соёлын өвийн талаарх мэдээллийн хоёр дахь гол эх үүсвэр нь сургууль болон албан бус сургалт юм. Ихэнх хүмүүс гэр бүлээс соёлын өвийн талаар мэдлэг, мэдээллийг олж авч байгаа нь Монгол Улсад баялаг аман түүх уламжлалтай нийцэх боловч орон нутгийн иргэдийн боловсрол, мэдээллийн хэрэгцээг хангах орон нутгийн байгууллагуудын (мэргэжлийн болон материалын аль аль нь) чадавхи дутмаг байгааг илтгэж байна. Үнэхээр ч, төслийн бүс нутагт байх соёлын төвүүдэд мэргэжилтэн/мэргэжлийн ур чадвар дутагдалтай байгаа нь ажиглагддаг. Техникийн болон мэргэжлийн сургалтанд хамрагдсан соёлын өвийн мэргэжилтэн (ялангуяа дээд боловсрол эзэмшсэн) зөвхөн Сэлэнгэ аймагт ч биш Монголд хомсдолтой байгаа нь тулгамдаж буй гол асуудал юм.

Төслийн бүс нутгийн судалгаанд оролцогчид орон нутгийн соёлын өвийн үйл ажиллагаанд дунд зэрэг оролцдог байна. Дунджаар оролцогчдын ихэнх нь соёлын өв ямар ч ач тусаа өгч байгаагүй гэж хариулсан байна. Энэ хариултыг Баянгол сумын оролцогчид илүү хариулж байгаа нь ажиглагдсан ба судалгаанд оролцогчдын талаас илүү хувь (51.1%) нь соёлын өв нь ямар ч ач тусаа өгдөггүй, харин 30.7% нь ач тусаа өгдөг гэж хариулсан байна.

Төслийн талбайн орчим байрлах гол биет бүс соёлын өв нь Ноёын уулыг (уул) тахиx ёслол юм. Ноён уулын ойр орчим амьдардаг өрхүүд Ноён уулыг социализмын үеэс өмнө тахидаг байсан боловч коммунист дэглэмийн үед (1920-1990-ээд оны үед) уулыг тахиx нь хориотой байсан. Шилжилтийн үед уул нуруудыг тахиx уг санаа дахин сэргэсэн. Ноён ууланд байгаа олон төрлийн овоог<sup>190</sup> тахиx зан үйлийг хийдэг байна. Цаашид бөө удганууд жилд хэд хэдэн удаа тахилга хийхээр уг газарт очдог ба бүс нутагт хийсэн судалгаанаас харахад уг уултай холбоотой хорио цээр, домог байдаг нь тогтоогдсон.

Соёлын өв бүхий газрууд, дурсгалууд нь ихэнхдээ Мандал сумын эргэн тойронд байрлах орон нутгийн тусгай хамгаалалттай хоёр газарт байдаг Зуун Модны гол (гол) болон Ноён уулын газруудад байна. Мөн улсын хамгаалалттай хоёр газар (Тужийн нарс, Хан хэнтийн улсын тусгай ангилалд хамгаалалттай газар нутаг), мөн 30 орон нутгийн тусгай хамгаалалттай газар байна (Гацууртын замыг огтлолцсон хоёр газар нь Зуун Модны гол болон Ноён уул). Эдгээр газрууд хадгалалт, хамгаалалтаас хамааран янз бүрийн байдалтай байна.

<sup>190</sup> Ихэвчлэн уулын онгод сахиус болон шүтлэгтэй мод, нуур эсвэл булаг зэргийн сүнслэг ач холбогдолтой байгалийн бие махбодийг тэмдэглэж энэхүү овоог (овоо гэж нэрлэдэг) бүтээдэг байна. Овоо нь орон нутгийн хүрээнд байгалийн гамшигийн (гал түймэр, зуд) үед залбирал, мөрдлөг хийх шашны мөргөлийн газар болгон ашиглах зэргээр олон үүргийг бий болгож байсан.

## **7. НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ**

### **7.1 НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ, НӨЛӨӨЛӨЛ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ**

Энэхүү бүлэгт 4-р хэсэгт дурдсан аргагүйг ашиглан төслийн нийгэм эдийн засгийн нөлөөллийг хэлэлцсэн болно. Төсөл үргэлжлэх нийт хугацаанд Төсөлд дүн шинжилгээ хийсэн: Барилгын үе шат, ашиглалт болон хаалтын үе шат.

Монгол Улсын Байгаль орчин, ногоон хөгжлийн яам (БОНХЯ) (буюу өмнөх агентлаг болох Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)) өмнө дурдсан уурхайн олборлолт, BIOX® үйлдвэр, Хаягдал хадгалах байгууламж, зам зэрэг төслийн бүрэлдэхүүн хэсгийн БОНБНҮ-нүүдийг үнэлж баталсан болно.

Эдгээрүүдэд ус, хөрс, агаар, биологийн олон янз байдал, хог хаягдал зэргийн байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл болон нийгмийн асуудлууд, нөлөөлөл бууруулах арга хэмжээнүүдийг авч хэлэлцсэн байна. Энэхүү тайланд байгаль орчны нөлөөлөлд өртөгч, хүн амд үзүүлэх нөлөөлөл болон нөлөөлөл бууруулах арга хэмжээнүүд, олон нийттэй хийсэн хэлэлцүүлгийн явцад хөндөгдсөн тухайн асуудлуудтай холбоотой иргэдийн санаа зовнил зэргийг оруулсан.

Энэ хэсэгт төслийн барилга, ашиглалт болон хаалтын үе шатанд үүсэж болзошгүй нийгмийн/нийгэм-эдийн засгийн нөлөөллийн хураангуйг тодорхойлсон. 9-р хэсэгт болзошгүй нөлөөллийг тоймлон харуулсан. Тодорхойлогдсон нөлөөллүүдийг нөлөөлөлд өртөж болзошгүй өртөгч/бүрэлдэхүүн хэсгээр нь хуваасан болно. Нөлөөлөлд өртөгч тус бүрийн болзошгүй нөлөөллийн шинж чанарыг тодорхойлсон. Үлдсэн багануудад хяналт, нөлөөлөл бууруулах арга хэмжээг авахаас өмнөх болошгүй нөлөөллийн ач холбогдол, бууруулах арга хэмжээнүүдийн тайлбар болон нөлөөллийг бууруулсаны дараах болзошгүй нөлөөллийн ач холбогдлын үнэлгээ зэргийг оруулж өгсөн. 7.1.1 - 7.1.6 хэсгүүдэд болзошгүй нөлөөллийг тайлбарласан. Төслийн үе шатуудын нөлөөлөл өөр өөр байгаа тохиолдолд тэдгээрийг барилга, ашиглалт, хаалтын үе шатаар нь тус тусад нь тайлбарласан.

#### **7.1.1 Эдийн засаг**

Эдийн засгийн нөлөөлөл нь үндэсний, бүсийн болон орон нутгийн түвшин бүрт тохиолдох төслийн олон өөр хөдлөгч хүчний үр дүнгээс хамаарч мэдрэгдэнэ. Нөлөө нь төслийн бүх үе шатанд хамааралтай ба энэ нь ихэвчлэн татвар, ашигт малтмал ашигласны төлбөр, шууд болон шууд бус хөдөлмөр эрхлэлт, бараа үйлчилгээний худалдан авалт зэрэг Төсөлтэй холбоотой үр ашигтай нөлөө юм. Төслийн орон нутгийн тогтвортой хөгжилд хөрөнгө оруулахаас бусад эдийн засгийн үр ашгийн ихэнхи нь уурхай хаалтын үе шаттай зэрэгцэн буурна гэсэн хүлээлттэй. Төслийн бүх үе шатуудад оролцох гол талууд нь Монгол Улсын Засгийн газар, төслөөс шууд болон шууд бус замаар ашиг хүртэгчид, ажил хайгчид болон ажиллагсад юм.

##### **7.1.1.1 Нөлөөлөл**

##### ***Хөдөлмөр эрхлэлт***

##### **Шууд, Шууд бус болон даавар хөдөлмөр эрхлэлт**

Хөдөлмөр эрхлэлт нь төслийн бүх үе шатны шууд, шууд бус болон даавар хөдөлмөр эрхлэлтийн боломжоос үүснэ, Үүнд:

- Шууд хөдөлмөр эрхлэлтэнд компанид үндсэн болон гэрээт гүйцэтгэгчийн ажил эрхлэлт багтана;
- Шууд бус хөдөлмөр эрхлэлтийн боломж нь гэрээт болон бэлтгэн нийлүүлэгч компаниудийн ажил эрхлэлтийг хэлнэ; ба
- Хүн амын орлого нэмэгдэж, нэмэлт бараа, үйлчилгээний эрэлт хэрэгцээ үүссэнтэй уялдан гарах даавар хөдөлмөр эрхлэлт.

Төслийн барилга, ашиглалт болон хаалтын үе шатанд ажил гүйцэтгэх өндөр ур чадвартай, тусгай мэргэжлийн болон мэргэжилгүй ажилчид шаардагдана. Үндсэн ажилчид, гэрээт гүйцэтгэгчдэд цалин олгосноор Төсөл эдийн засгийн эерэг нөлөөллийг бий болгоно. Төслийн барилгын үе шатны оргил үеийн 15 сарын хугацаанд барилгын ажилд 300 хүн хүч шаардлагатай болно, уурхайн боловсруулах байгууламжийн ихэнхи нь Бороогийн уурхай дээр бэлэн байгаа. Гэсэн хэдий ч, богино хугацаанд, түр ажиллах хүч ХХБ-ийн өндөрлөгөөний ажилд, мөн BIOX® үйлдвэр барих тусгай мэргэжлийн баг ажиллах шаардлага гарна. Үүнээс гадна, барилгын ажиллах хүчний кемпийн үйлчилгээний ажиллагсад шаардлагатай. Зарим тохиолдолд, ажиллах хүчний тоо хэвээр үлдэнэ (барилгын үе шатанд ажилласан ажлын хүч үргэлжлүүлэн ашиглалтын үе шатанд ажиллах).

Төслийн үйл ажиллагааны явцад нийтдээ 1 000 ажлын байр үүсэх ба түүнээс 487 нь компанийн үндсэн ажилчид байх болно.<sup>191</sup> Хүснэгт 7.1 харуулснаар уурхайн ашиглалтын үе шатанд мэргэжлийн, тусгай мэргэжлийн болон ур чадвар шаардлагагүй ажлын байрууд үүсэх болно. Барилгын үе шатны оргил үед 300-аас илүү урт хугацааны ажлын байр байна. Ашиглалтын үе шатанд ажилд орсон хүмүүс нь төслийн үйл ажиллагааны бүхий л хугацаанд үргэлжлэн, тасралтгүй ажиллах болно.

Гацууртын төслөөс үндэсний боловсон хүчний цалинд зарцуулах нийт шууд үр ашиг нь төслийн нийт хугацаанд 147.8 тэрбум<sup>192</sup> төгрөг болно гэж тооцолж байна.

### Хүснэгт 7.1 Сентеррагийн шууд хөдөлмөр эрхлэлт

Сентеррагийн үндсэн ажлын байр	Ажлын байрны тоо
Санхүү болон менежмент	24
Үйлчилгээ болон засвар үйлчилгээ	78
Инженер, техникийн ажилтанууд	77
Харуул хамгаалалтын алба	30
Тоног төхөөрөмжийн операторууд	116
Уурхайн эмнэлгийн ажилчид	8
Захиргаа үйлчилгээний ажилчид	92
? (энэ хэсгийг ppt дэх хүснэгтээс хассан байсан)	62
НИЙТ	487

<sup>191</sup> Гацуурт төслийн тойм 2015 оны 3-р сар

<sup>192</sup> Гацуурт төслийн тойм 2015 оны 3-р сар



Хүснэгт 7.2 –т шууд бус хөдөлмөр эрхлэлтийн тооцоог гэрээт гүйцэтгэгч бүрээр харуулав. Зарим гэрээт гүйцэтгэгчийн ажил нь улирлын буюу түр хугацааны чанартай байна.

### Хүснэгт 7.2 Гэрээт гүйцэтгэгчийн шууд бус хөдөлмөр эрхлэлт

Гэрээт гүйцэтгэгчийн үзүүлж буй үйлчилгээний чиглэл	Ажлын байрны тоо (тооцоолсон)
Кемпийн цэвэрлэгээ, үйлчилгээ, хоол	120
Харуул хамгаалалт	70
Хүдэр тээвэрлэлт	96
Ажиллагсдын тээвэрлэлт	10
Засвар үйлчилгээ	56
Нөхөн сэргээлт (улирлаар)	30
Агуулах, хадгалалт (улирлаар)	10
Хаягдалын далангийн барилга (түр хугацааны)	120
НИЙТ	512

Хүн амын орлого нэмэгдэж, нэмэлт бараа, үйлчилгээний эрэлт хэрэгцээ үүсэхтэй уялдан гарах даавар хөдөлмөр эрхлэлтийн тоог урьдчилан тооцооход хүндрэлтэй ч төслөөс гарах эерэг нөлөөлөл гэж үзэж байгаа. Барилгын үе шатанд бага ажиллах хүч шаардагдах учир даавар хөдөлмөр эрхлэлт хэрэгцээ нь ашиглалтын үе шатанд илүү нэмэгдэх бөгөөд төслийн хаалтын үе шатанд буурна. Уурхай болон ажиллах хүчийг дэмжих үйлчилгээний компаниудын (жишээ: ресторан, гэр ахуйн үйлчилгээ, машин засварын үйлчилгээ) бий болсноор орон нутгийн хөдөлмөр эрхлэлтэнд шинээр ажлын байр үүснэ. Энэ нь орон нутагт ажлын байр бий болж, орон нутгийн бизнест, дэд бүтэц болон үйлчилгээнд хөрөнгө оруулалтаас үүдэлтэй байх болно. Бороо Гоулд уурхайн туршлагаас харахад орон нутгийн үйлчилгээний салбарт ажлын байр нэмэгдэх нь тодорхой. Уурхайн үйл ажиллагааны 1 ажлын байр (гэрээт ажилтан болон ажилтан)-ны бууралтын үржүүлэгч<sup>193</sup>-ийг 0.1 даавар ажлын байртай харьцуулахад төслийн ажиллагсад, гэрээт гүйцэтгэгчийн хэрэгцээг хангах үйлчилгээнд нэмэлтээр 100-д орчим ажлын байр бий болно.

Бороогийн төслийн туршлага дээр үндэслэн бууралтын үржүүлэгчийг сонгосон нь Бороогийн уурхайн ажиллагсдын орлого нэмэгдэж, баталгаат орлоготой болж, зээл аван байр худалдан авах нөхцөл бүрдсэн учир орон нутгийн ажилчид сумаас Дархан хот руу шилжин дараа нь Улаанбаатар руу нүүсэн явдал юм. Зүүнхараагийн хүн амын тооноос хамааран (25,689 хүн) орон нутгаас ажилд орох ажиллах хүчний хэрэгцээг суманд үйлчилгээ үзүүлж буй бараа, үйлчилгээний бизнес хангах боломжтой нь харагдаж байна.

Өмнө нь Бороо Гоулд уурхайн төсөл дээр ажиллаж байсан, Гацууртын уурхайд шаардлагатай үр чадваруудыг эзэмшсэн Мандал сумын иргэдийн дунд (Гацууртын уурхай байрладаг)<sup>194</sup> хөдөлмөр эрхлэлтийн хүлээлт өндөр байгаа. Компани нь хамгийн бага үр чадвар шаардлагатай ажлын байранд орон нутгаас давуу эрхтэйгээр ажилд авах үүрэг хариуцлагатай бөгөөд гэрээт гүйцэтгэгчдэд ижил шаардлага тавина. Үүнийг төслийн бүсэд үүсэх үр ашигтай нөлөөлөл гэж үзэж байгаа бөгөөд Баруунхараа, Зүүнхараа болон Түнхэлийн ажилгүйдлийн түвшинд эерэг нөлөөлөл үзүүлэх болно гэсэн хүлээлт байна. Олон нийттэй хийх хэлэлцүүлгийн явцад иргэдийн ихэнх нь

<sup>193</sup> Салбарын тооцооллыг харвал аж үйлдвэрийн олборлох оператор шууд бий болгож буй ажлын байр бүрт нэгээс дөрвөн ажлын байр дагалдан бий болдог. Энэ тоо олон янз байдаг. Англи Америкд даавар ажлын байр нь шууд болон шууд бус ажлын байрны 10-20 хувь гэж бодохыг зөвлөдөг.

<sup>194</sup> Бороо Гоулд уурхайн хаалтын үе шатны нийгмийн нөлөөлөл, 2014.

ажлын үр чадварын хамгийн бага шаардлагад хүрэхгүй байгаа ч гэрээт гүйцэтгэгчийн ажлын байранд тавигдах шаардлага арай доогуур байж, ажиллах боломж бүрдэнэ гэдэгт итгэж байна.

Бороогийн уурхай дээр үйл ажиллагаа явуулж байсан туршлагатай ажиллах хүчнийг нэн тэргүүн ажилд авах нь БГК-ийн энэхүү бодлогыг амжилттай хэрэгжүүлэх боломж олгоно. Компанид Бороогийн төслийн одоо ажиллаж байгаа чадварлаг удирдах түвшний ажилтануудыг ажилд аван/хадгалж үлдээж, Гацууртын уурхай дээр ажлын байран дээрх сургалт явуулж, удирдах сонголт байгаа. Бороогийн уурхайн хуучин ажилчид өмнө нь 2004 оноос хойш үйл ажиллагаа явуулж байсан бусад уурхайд ажилласан туршлагатай (жишээ нь Эрдэнэт Зэс)<sup>195</sup> учир шинэ ажиллагсдыг бэлтгэх чадвартай. Эдгээр төслийн бүсийн бичиг үсгийн мэдлэг сайтай, дунд сургууль болон ТМБС-ын сургалтын туршлагатай (одоо Мандал сумын ТМБС-д 44 хүн хүнд машин механизмын механик мэргэжлээр суралцаж байгаа) удирдах түвшний ажилтанууд нь өөрийн үр чадвараа нэр хүндтэй ажлын байранд ашиглах боломжтой. Төслийн бүсийн уурхайн салбарт боловсон хүчин бэлдэх сургалтын боломж хязгаарлагдмал, Дархан, Эрдэнэт, Улаанбаатар дахь ТМБС сургуулиуд нь мэргэжлийн сургалтын туршлага их хэдий ч ажлын байран дахь сургалт нь дээр дурдсан сургалтанд хамрагдах боломжгүй төслийн бүсийн иргэдийн хувьд мэргэжлийн үр чадвар эзэмших гол хэрэгсэл хэвээр байна. Хэлэлцүүлгийн явцад сумын захиргаа үр чадвар муутай, мэргэжилгүй болон тодорхой ажил эрхлээгүй хүмүүст төслөөс сургалт явуулахад нь өөрсдийн зүгээс шаардлагатай дэмжлэг үзүүлэхээ илэрхийлсэн.

Уурхайн олборлолт, тээвэрлэлтийн гэрээт компаниуд Сентерра компанийн орон нутгаас ажилчид авах бодлогыг дагаж мөрдөхгүй байх магадлалтай байгаа нь төслийн нийгмийн гүйцэтгэлийн үзүүлэлт, зорилтот үр ашгийг бууруулахад хүргэж болно. Уурхайн олборлолт болон тээвэрлэлт нь олон тооны гэрээт гүйцэтгэгчтэй ажиллах салбар учир их хэмжээний сөрөг нөлөөлөлтэй байх боломжтой.

Хүлээлт биелэхгүй байх нь орон нутагт бухимдал үүсгэж цаашид Монгол Улс даяарх уул уурхайн салбарын уналттай холбоотойгоор бусад уурхайгаас халагдсан ажил хайгчид их хэмжээгээр орж ирж хөдөлмөр эрхлэлтийн өрсөлдөөнийг улам хурцатгах магадлалтай. Улаанбаатартай ойрхон байршилтайн улмаас тухайн ажил хайгчид төслийн бүсэд заавал нүүж суурьших шаардлагагүй хэдий ч өөр уурхайд ажлын шаардлагатай үр чадварыг эзэмшсэн байх тул давуу талтай байх боломжтой. Иймд орон нутгийн хүмүүсээс төслөөс гарах ажлын боломжит байруудыг булаах магадлалтай. Сумын засаг захиргаа нь хэлэлцүүлгийн явцад төслийн ажлын байранд сонгон шалгаруулалт хийхдээ тухайн орон нутагт оршин амьдарч байгаа хугаацаатай холбоотой шалгуур үзүүлэлтийг харгалзан үзэж байх асуудлыг дэвшүүлсэн.

Сентерра нь Гацууртын төсөл дээр 4-с илүүгүй гадны мэргэжилтныг дээд түвшний менежерийн албан тушаалд урт хугацаагаар ажиллуулна гэж төлөвлөж байгаа; Бороогийн төсөлд хэрэгжүүлсэн ажлын байрыг үндэсний болгох загварыг Гацууртын төсөлд авч ашигласнаар хүлээлтэнд сэтгэл дундуур байх эрсдэлийг бууруулна.

Шууд, шууд бус болон даавар хөдөлмөр эрхлэлт буурах уурхайн хаалтын үе шат нь төслийн бүсэд хөдөлмөр эрхлэлттэй холбоотойгоор гарч болзошгүй сөрөг нөлөөллийн хамгийн эгзэгтэй үе байх болно. Эдийн засгийг төрөлжүүлэхгүй бол уурхайн хаалтын үед нь орон нутгийн эдийн засаг

---

<sup>195</sup> Бороо Гоулд уурхайн хаалтын үе шатны нийгмийн нөлөөлөл.

хумигдаж, хөдөлмөр эрхлэлт багасахад хүргэж болох юм. Хөдөлмөр эрхлэлтийн нөлөөлөл нь сөрөг, шууд болон шууд бус байх болно. Үйлчилгээний хэрэгцээ шаардлага буурсантай холбоотойгоор ханган нийлүүлэлтийн сүлжээ болон даавар хөдөлмөр эрхлэлт зэрэгт ажлын байрны тоо багасч алдагдана. Газарзүйн хувьд сум, аймаг, тодорхой түвшинд үндэсний болон олон улсыг (Сентерра-д цөөн тооны гадаад ажилтан ажиллана гэж үзэхэд) хамрана. Нөлөөллийн хэмжээ, мэдрэмтгий байдал нь дунд зэрэг байна. Хугацаа нь урт, уурхайн хаалтын дараа ч үргэлжилнэ. Энэ нөлөөлөл тохиолдох нь тодорхой.

Хүснэгт 9.1-д хүлээгдэж буй шууд, шууд бус болон даавар хөдөлмөр эрхлэлттэй холбоотой нөлөөллүүдийг нэгтгэн дараах байдлаар харуулсан:

- Барилгын үе шатны оргил үед 300 хүн, цаашлаад уурхайн ашиглалтын үе шатанд урт хугацааны<sup>196</sup>, чанартай, уурхайн үйл ажиллагааны бүхий л хугацаанд хүчинтэй байх шууд ажлын байр 482, шууд бус 500 орчим байна гэж тооцоолсон.
- Төслийн ажлын хүчний эрэлт хэрэгцээг хангах үйлчилгээ, ханган нийлүүлэлтийн даавар ажлын байр ойролцоогоор 100 гаруй бий болно.
- Уурхайн хаалтын үе шатны өмнө болон явцад хэрэгжүүлэх цомхотголын улмаас шууд болон шууд бус ажлын байрны тоо буурч, уурхайн ажиллах хүчний бараа, үйлчилгээний эрэлт хэрэгцээ багасч даавар ажлын байрнууд хасагдах болно.
- Уурхайн болон тээврийн гэрээт гүйцэтгэгчид орон нутгаас боловсон хүчийг авч ажиллуулахгүй, эсвэл Сентеррагийн хөдөлмөр эрхлэлтийн туршлагыг дагахгүй байх эрсдэл.
- Төслийн бүсээс гадна мэргэжлийн үр чадвартай ажиллах хүч олон байгаа тул ажлын байранд өрсөлдөөн ихсэж орон нутгийн ажил хайгчид тэнцэхгүй байх буюу ажлын байранд орон нутгийн хүмүүсээс илүүтэйгээр шилжин ирсэн иргэдийг авч ажиллуулж байна гэсэн ойлголтоос үүсэх нийгмийн зөрчил үүсэх зэрэг орон нутгийн иргэд хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хүлээлтэнд сэтгэл хангалуун бус байх эрсдэл.

#### *Хөдөлмөр эрхлэлт болон ажлын байрны нөхцөл*

Бороогийн төслийн адил Гацууртын уурхай нь үндэсний ажиллах хүч давамгайлсан ажиллагсаддаа олон улсын хөдөлмөрийн стандартыг дагаж мөрдүүлнэ. Бороогийн төслийн ажиллагсад нь компанийн өндөр стандарт, аюулгүй ажиллагаа, ажиллагсаддаа үр чадварыг нь өндөр түвшинд сайжруулах боломж олгодог зэргээр тухайн компанид ажилласан туршлагаа ерөнийд нь эерэгээр үнэлж дүгнэсэн байна<sup>197</sup>. Энэ нэр хүндийн ачаар (2012 оны хөдөлмөрийн зах зээлийн нөхцөлөөс бусад тохиолдолд) Сентерра нь өөрийн үйл ажиллагаандаа шаардлагатай үр чадвартай ажилчдаа хадгалж үлдэж чадах боломжтой болсон. 2012 онд олон тооны уурхайнууд үйл ажиллагаагаа эхлүүлж ажилчид сонголт хийх боломжтой байсан, ялангуяа Бороогийн уурхайн хөдөлмөрийн өндөр стандартын талаар орон нутгийн иргэд сайн мэддэг байсан тул өрсөлдөгч компаниуд нь өндөр цалин амлан ажиллах хүчний хойноос хөөцөлдөж байсан. Зах зээлийн одоогийн нөхцөл суларч шаардлагатай үр чадвартай ажиллах хүч хангалттай байгаа хэдий ч Засгийн газрын бодлого үндэсний түвшинд өөрчлөгдөх, эсвэл барааны үнэ өөрчлөгдөх

<sup>196</sup> Тэмдэглэл: Уурхайн үйл ажиллагааны нийт хугацааг 'урт хугацаанд' гэж тодорхойлсон (11 жилийн үйл ажиллагаа).

<sup>197</sup> БГК-н Уурхайн хаалтын нийгмийн нөлөөллийн үнэлгээний хээрийн судалгаа (2013).

зэрэг одоо байгаа байдлыг эрс өөрчлөх гадны 2 хүчин зүйлс нь төслийг хугацаанд нь багтааж ашиглалтанд оруулах явцад илт мэдрэгдэнэ.

Бороогийн төслийн түүхэнд хөдөлмөрийн маргаан бага (сүүлийн 7 жилд нэг) гарч байсан. Бороогийн төслийн ажиллагсад үйлдвэрчний эвлэлтэй хамтарснаар Бороо болон Гацууртын уурхайн хамтын гэрээний нөхцөл өөр байх тохиолдолд, хуучин ажиллагсдыг шинэ ажилчидтай харьцуулах зэргээс төслийн үйл ажиллагааны хуваарь тасалдах боломжтой. Төслийн үйл ажиллагааны хуваарь тасалдаж, хойшлогдох нь магадлал багатай ч төслийн үйл ажиллагааны бүхий л хугацаанд их хэмжээний нөлөөлөл үүсгэх боломжтой.

Хөдөлмөр эрхлэлт, ажлын нөхцөлтэй холбоотойгоор гарч болох нөлөөллийн хураангуйг Хүснэгт 9.1–д дараах байдлаар харуулсан байна:

- Хангалттай чадварлаг ажиллах хүчнийг олж авах боломжгүй байх; ба
- Хөдөлмөрийн маргаан гарах боломж.

#### *Хөрөнгө оруулалт, санхүүгийн үр ашиг*

##### **Эдийн засгийн хөрөнгө оруулалт**

Гацууртын төслөөс Монгол Улсын эдийн засагт оруулах гол хөрөнгө оруулалт нь дараах бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ: төслийн барилгын болон ашиглалтын үе шатанд илүүтэйгээр хамаатай, төслийн хаалтын үед үр ашиг нь багатай байх орон нутгаас хийх худалдан авалт, Засгийн газрын татвар болон роялти, цалин хөлс юм.

##### **Үндэсний хэмжээний хөрөнгө оруулалт, шууд үр ашиг**

Гацууртын төслийн барилгын болон ашиглалтын үе шатуудад төслөөс Монгол Улсын эдийн засагт өмнө нь оруулсан ач холбогдол бүхий эерэг хувь нэмэр нь үргэлжлэх болно. Урьдны албан бус бичил уурхайгаас албан ёсны, арилжааны зориулалттай уурхай болж өөрчлөгдөж байгаа нь улсын хэмжээнд татварын төлөлтийг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. 1997 – 2006 онуудад Монгол Улсад хайгуулын төслүүдэд \$49.7 сая-аас их доллар зарцуулсан байдаг бөгөөд өмнө хийсэн геологийн бүх хайгуулын ажлын зардлыг Засгийн газарт нөхөж төлж, Гацууртын алтны үндсэн ордыг нээхэд нийтдээ 2.6 тэрбум төгрөг зарцуулсан<sup>198</sup>. Бороогийн уурхайг ашиглалтанд оруулахаас өмнө Сентерра нь ойролцоогоор 107.9 тэрбум төгрөг зарцуулснаас \$75 сая америк долларыг Бороогийн уурхайн байгууламжийг барьж байгуулахад<sup>199</sup> зарцуулсан байна. Гацууртын төслийн хүдрийг боловсруулах одоо ашиглаж байгаа ихэнхи байгууламжууд нь Бороогийн төсөлд зориулж барьсан ба шинээр хийх хөрөнгө оруулалт нь BIOX® үйлдвэрийн барилга болон ХХБ-н шинэчлэн засвар байх болно.

Гацууртын төслийн барилгын ажлын хөрөнгө оруулалтын капитал зардал нь ойролцоогоор \$72.4 сая америк доллар, үйл ажиллагааны жилийн дундаж зардал нь ойролцоогоор \$40 сая америк доллар гэж тооцоолсон байгаа.<sup>200</sup> Хүснэгт 7.3-д Монгол Улсад оруулах шууд үр ашгийн задаргааг бүрэлдэхүүн тус бүрийг нийт шууд үр ашгийн хувиар харуулсан<sup>201</sup>.

<sup>198</sup> Сентерра баримтын хуудас (2010).

<sup>199</sup> Сентерра баримтын хуудас (2010).

<sup>200</sup> Байгаль орчин, нийгмийн суурь судалгаа 2014 оны 2-р сар, SNC-Lavalin.

<sup>201</sup> Гацууртын төслийн ерөнхий танилцууллага, 2015 оны 3-р сар.

### Хүснэгт 7.3 Монгол Улсад оруулах шууд үр ашгийн бүрэлдэхүүн хэсгийн задаргаа (нийт үр ашгаас % )

Ангилал	%
Орон нутгийн худалдан авалт (үйл ажиллагааны зардал)	49.3
Засгийн газрын нийт татвар, хураамж	31.9
Орон нутгийн худалдан авалт (хөрөнгө оруулалтын зардал)	10.9
Үндэсний ажиллагсдын цалин	7.1
Бусад	0.8
<b>НИЙТ</b>	<b>100</b>

#### Роялти болон татвар

Улсын болон аймгийн төсөвд хуримтлагдах орлого нь голчлон роялти болон татвараас бүрдэнэ. Гацууртын төслөөс улсын болон орон нутгийн төсөвд хуримтлагдах орлого нь нийтдээ бараг 660 тэрбум төгрөг болох<sup>202</sup> ба үүний ихэнхи бүрэлдэхүүн хэсэг нь роялти (209 тэрбум төгрөг)-аас, 22% нь Гацууртын борлуулалтын орлогоос бүрдэнэ. Гацууртын төсөл 660 тэрбум төгрөгийн 10%-г орон нутгийн төсөвд оруулахаас (жишээ нь Сэлэнгэ аймаг) 6 тэрбум төгрөг нь төслийн ашиглалтын үе шатанд орно. Сэлэнгэ аймгийн 2015 оны татварын орлогыг 12.6 тэрбум төгрөгөөр баталснаас 52 % -г Гацууртын төслөөс орох болно.

Хүснэгт 7.4-д нийт татвар, төлбөр, хураамжийн задаргааг харуулав (сая төгрөг).

### Хүснэгт 7.4 Урьдчилсан байдлаар тооцоолсон татвар, төлбөр, хураамж (төгрөг, сая)

Татвар, төлбөр болон хураамж	Урьдчилсан тооцоо, сая төгрөг
Роялти	209,025
НӨАТ	167,976
Компани орлогын татвар	135,010
Эрүүл мэнд болон нийгмийн даатгал	46,773
Үл хөдлөх хөрөнгийн татвар	29,139
Хувь хүний орлогын татвар	24,836
Гаалийн татвар	15,006
Нийтлэг ашигт малтмал ашиглалтын хураамж	14,168
Усны татвар	10,774
Ашиг орлогын татвар	3,549
Бусад татвар (тээврийн татвар, лицензийн төлбөр, газар ашиглалтын төлбөр, тэмдэгтийн хураамж, виз гэх мэт)	3,517
<b>Нийт татвар, төлбөр болон хураамж</b>	<b>659,772</b>

Төслийн үйл ажиллагааны бүхий л хугацааны туршид улсын төсөвт оруулах нийт бэлэн мөнгөний урсгал нь 814 тэрбум төгрөг байх ба энэ нь нийт бэлэн мөнгөний урсгалын 73%-г эзэлж байна. Сентерра-д оногдох бэлэн мөнгөний хуваарилалт нь нийтдээ 27 % байна. Энэ тооцоолол нь Гацууртын төсөл дэх Засгийн газрын оролцоо болон эзэмшил нь 34 % байна гэж үндэслэсэн бөгөөд Хүснэгт 7.5-д харуулав.

<sup>202</sup> Гацууртын төслийн ерөнхий танилцууллага, 3 сар 2015.

### Хүснэгт 7.5 Гацууртын төслийн хувиарлалт

Бэлэн мөнгөний хуваарилалт	Тэрбум төгрөг	Сая америк доллар	Хуваарилалтын %
Татвар, ноогдол ашгаас өмнөх Гацууртын төслийн бэлэн мөнгөн урсгал	<b>1,112</b>	<b>654</b>	
Үүнээс:			
Төслөөс улсын төсөвд төлөх татвар	660	386	
Улсын ноогдол ашиг (34% бүрэн оролцоно гэж үзвэл )	154	91	
Монголын засгийн газарт хуваарилах нийт бэлэн мөнгө	<b>814</b>	<b>477</b>	<b>73%</b>
Сентеррад хуваарилах нийт бэлэн мөнгө	<b>298</b>	<b>177</b>	<b>27%</b>

### Эдийн засгийн шууд бус үр ашиг

Төслийн эдгээр шууд үр ашгаас гадна бусад шууд бус эдийн засгийн боломжууд үүсэхээс ихэвчлэн төслийн бүсэд төслөөс болон ажиллагсдын зардлаас, улсын хэмжээнд, ялангуяа Улаанбаатарт бий болно. Үүнд хоол хүнс, тээвэрлэлт, байр сууц зэрэг үйлчилгээний зардал, төслийн үйл ажиллагааны бүх үе шатанд ажиллах ажиллагсдын зардал бөгөөд худалдаа арилжааны цэвэр ашиг зэрэг багтана.

Төсөл нь мөн гадаад хөрөнгө оруулалтыг идэвхижүүлэх нөлөөлөл үзүүлнэ. Гацууртын төсөл амжилттай хэрэгжих тохиолдолд дэлхий нийтэд Монгол Улсын уул уурхайд хөрөнгө оруулахад аюулгүй орон болж гэсэн таатай ойлголт бүрдэж, хөрөнгө оруулалтын тогтвортой орчинтой улс дахин болсоноо батлах юм.

### Уурхайн хаалтын үе шатны эдийн засгийн эмзэг байдал

Гацууртын төслийн гурван жил үргэлжлэх хаалтын үе шатанд үйл ажиллагаа буурч, ажлын байр багасаж, төслийн хувь нэмэр буурсны улмаас орон нутгийн эдийн засагт сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Уурхайд ажиллаж байсан хүмүүсийн цомотголын нөхөн төлбөр Хамтын гэрээгээр зохицуулагдаж байгаа (дээр дурдсан) ч төслийн эдийн засгийн хувь нэмрээс үүдэлтэй хөдөлмөр эрхлэлт болон нэмэлт орлого буурах тул орон нутгийн иргэд төслийн хаалтын үе шатанд амьжиргааны өөр эх үүсвэрийг олох шаардлагатай болно.

Бороогийн уурхайн туршлагаас харахад<sup>203</sup> Баянгол сум нь бусад сумаас илүүтэйгээр Бороогийн төслөөс хамааралтай байж ажилгүй иргэд хөдөлмөр эрхлэлтийн өөр боломж хайх сонирхолгүй байсан нь тодорхой байна. Иймд санал болгож буй нийгмийн хөрөнгө оруулалт нь уурхайн хаалтын үе шатанд өөр боломжит бизнес, ажлын байр болон зах зээлийг эрэлхийлэх тал дээр анхаарлаа хандуулсан түншлэлийг бий болгох хэрэгтэй.

Бороогийн уурхайн хаалтын нийгмийн эрсдэлийн үнэлгээнд (2014) үндсэн болон гэрээт ажилчид, ханган нийлүүлэгчдын ихэнх нь суурин хүн ам болон өөр боломжит бизнесүүдийн ойролцоо амьдардаг Баянгол сумыг Бороогийн төслөөс хамгийн их хамааралтай гэж дүгнэсэн байна. 2014 онд Бороогийн төслийн Баянгол сумын нийгмийн даатгалд оруулсан хувь нэмэр нь сард 19-23 сая төгрөг байсан нь суманд төлөгдсөн нийт нийгмийн даатгалын 60-70% эзэлж байсан (аж ахуйн

<sup>203</sup> БГК-ийн Уурхайн хаалтын нийгмийн эрсдэлийн үнэлгээ (2014).



нэгж тус бүрийн цалингийн түвшин, ажиллагсдын тоог харуулсан). Мандал сумын гол ажил олгогч нь эсрэгээр, Засаг даргын тамгийн газар (сум хоорондын цагдаа болон эмнэлгийг багтаагаад), шорон (78 ажилтан), ЭмСиЭс-ийн спиртийн үйлдвэр (200 ажилчин) болон төмөр зам (1,000 ажилчин) байна. Суманд нийт оршин суугчдын 30%-ийг ажлаар хангадаг, дунджаар 8 ажилтантай 130-140 ЖДҮ байна. Мандал суманд бүртгэгдээгүй хүмүүсийг оруулаад нийтдээ 7,300 хүмүүс ажилгүй байгаагийн өөр уурхай дээр ажиллаж байгаа, буюу тусгай техник мэргэжлийн сургалтын гэрчилгээтэй 69 уурхайн операторууд байна. Үүний зэрэгцээ, гэр бүлийн салалт өсөж байгаатай холбоотойгоор төслийн бүсэд эмзэг, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо өссөөр байгаа нь төслийн хаалтын үе шатны нөлөөлөлд илүү их өртөх магадлалтай. Бороогийн уурхайн өмнөх жишээгээр хоол унд, цэвэрлэгээ хийдэг компанийн ихэнх ажилчид өөр газар ажиллах боломж муутай орон нутгийн эмэгтэйчүүд байсан.

Ийм төрлийн туршлага олборлох салбартаа нилээд түгээмэл байдаг бөгөөд Сентерра нь Гацууртын уурхайн үйл ажиллагааны хугацаанд Орон нутаг хөгжүүлэх хамтран ажиллах гэрээгээр (ОНХХА) (Бороогийн алтны төслийн Сумын хөгжлийн санд хамааралтай) дамжуулан бусад боломжит салбаруудыг дэмжих (нөлөөлөл бууруулах хэсэгт дурдсан) замаар ийм төрлийн нөлөөллийг бууруулах зорилго агуулж байгаа. Төслийн орон нутагт оруулах хөрөнгө оруулалтын түвшнээс шалтгаалан (ялангуяа Баянгол сум, Түнхэл багт ажлын цөөхөн байр байгаа нөхцөлд) төслийн бүсийн эдийн засгийн үйл ажиллагаа их хэмжээгээр буурах явдлаас зайлсхийх боломжгүй юм.

Төсөл нь хөрөнгөө татах тул уурхайн хаалт нь сөрөг нөлөөлөл үзүүлэх болно. Газарзүйн хамрах хүрээний хувьд үндэсний/улсын түвшинд байна, тухайн нөлөөллүүд нь сум аймгийн хэмжээнд ижилхэн мэдрэгдэнэ. Нөлөөллийн хэмжээ их бөгөөд удаан хугацааны үр дагавартай, нөлөөлөл нь төслийн хаалтын дараа ч байнга тогтмол үлдэнэ. Итгэл үнэмшлийн түвшин өндөр байна.

### **Орон нутгийн эдийн засагт оруулах хувь нэмэр**

Дээр дурдсан аймгийн цалин, төлбөрөөс гадна Төсөл нь орон нутгийн ханган нийлүүлэгч, орон нутгийн хөгжлийн хөрөнгө оруулалтын боломжуудаар дамжуулан орон нутгийн эдийн засагт эерэг нөлөөллийг үзүүлэх боловч сөрөг инфляцийг мөн үүсгэх магадлалтай.

### **Инфляци**


Орон нутагт үнийн инфляци үүсэх боломж нь төслөөс үүсэх шууд бус сөрөг нөлөөлөл байж болно. Үнийн инфляци нь эдийн засагт орж ирэх 'шинэ' мөнгө, орон нутгийн барааны эрэлт хэрэгцээ (үнийг) ихсэж, хомсдолтой нөөцөд дарамт үүсэх зэргээс шалтгаалж үүснэ. Байр, бараа, үйлчилгээнд илүү үнэ төлөх хандлагатай, нэмэлт орлоготой чинээлэг хүн амын тоо нь өсч байна. Хөдөлмөр эрхлэлтийн хэсэгт дурдсанаар Бороогийн уурхайн туршлагаас харахад орон нутгийн иргэд сумаас Дархан руу, цаашлаад Улаанбаатар руу нүүх хандлагатай байна.

Инфляци нь тогтсон орлоготой, төслөөс хамааралгүй иргэд болох тэтгэврийн хүн, төрийн албан хаагч зэрэг хүмүүсийн амьжиргааны өртөг илүү үнэтэй болгох эрсдэлтэй. Зарим онцгой тохиолдолд, ялангуяа 2009 оны Монгол Улсын уул уурхайн огцом өсөлтийн үед багш, сувилагч, болон зарим төрийн албан хаагчид ажлаа орхиж уурхайд ажиллаж байсан явдал ажиглагдсан нь зөвхөн ганц Гацууртын төслийн үр дагавар биш юм. Төсөл нь орон нутгийн иргэдээс ажилд илүүтэйгээр авах бодлогыг хэрэгжүүлж, өрсөлдөхүйц (хэт өндөр биш) цалин өгөх учраас дээр

дурдсан онцгой нөлөөлөл үүсэх магадлал багатай. Эдийн засгийн эерэг нөлөөллүүд нь ийм төрлийн сөрөг үр дагаврыг сайжруулах болно. Гэсэн хэдий ч, энэ тэтгэврийн хүмүүс, тогтмол орлоготой эмзэг бүлгийн хүмүүст сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлал нь хэвээр байна. Сэлэнгэ аймагт 2010-14 онуудад өргөн хэрэглээний барааны үнэ жил бүр өсч байсан бөгөөд суурь судалгаанд хамрагдсан өрхийн 85% нь инфляцийг гол асуудлаа гэж тодорхойлсон байдаг. Иймд орон нутгийн инфляцийн асуудал нь өрх толгойлсон эмэгтэйчүүд бүхий эдийн засгийн эмзэг бүлэгт хамгийн их хүндээр мэдрэгдэх болно.

### Орон нутгийн хөгжилд оруулах хөрөнгө оруулалт

Сентерра нь өөрийн хүлээсэн үүргийн дагуу Орон нутаг хөгжүүлэх хамтран ажиллах гэрээгээр (Бороогийн алтны төслийн Сумын хөгжлийн санд хамааралтай) дамжуулан орон нутгийн хөгжилд хөрөнгө оруулалтыг үргэлжлүүлэх оруулах юм. Сентерра нь 2004 онд анх байгуулагдсанаас хойш орон нутгийн түншүүдтэй хамтран суманд хөрөнгө оруулалт хийсээр ирсэн ба энэ санааг анх Баянгол болон Мандал сумдын хөгжилд компани хөрөнгө оруулах зорилготой үүсгэн байгуулсан. Сентерра илүү өргөн хүрээгээр олон нийтийн хэрэгцээг анхаарах үүднээс 2006 оноос хойш санг өргөтгөж Сэлэнгэ аймгийг хамруулсан. Эдгээр сангууд нь уурхайн талбайн ойр орчмын орон нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулахаас гадна ажлын байр бий болгох зорилгоор барилгын засвар үйлчилгээ, нийтийн үйлчилгээний шинэ байгууламж барих зэргийг дэмжиж байсан. 2004 оноос хойш СХС нь Сэлэнгэ аймаг, Баянгол, Мандал сумдад нийт 170 гаруй төслийн хэрэгжилтэнд \$6.5 сая америк долларын хөрөнгө оруулалт хийснийг <sup>204</sup> Зураг 7.1-д харуулсан.



**Зураг 7.1 Үүсгэн багуулсанаас хойш сумын Хөгжлийн санд хийсэн хөрөнгө оруулалтууд, АНУ доллар**

СХС-ийн үйл ажиллагааны турш хөрөнгө оруулалтын тоо, төрөл нь хөрөнгө оруулах чиглэлээс хамааран өөрчлөгдөж байсан; Хүснэгт 7.6-д 2012 он хүртэл 8 жилийн хугацаанд 5,077,075 америк доллараар санхүүжүүлсэн төслүүдийг тоог төрлөөр нь харуулсан.


<sup>204</sup> Монгол дахь КНХ үйл ажиллагаа (BGC, 2014).

**Хүснэгт 7.6 Сентеррагийн СХС-гийн санхүүжилтаар хэрэгжүүлсэн төслүүдийн тоо, төрөл, АНУ доллар, 2004 - 2012<sup>205</sup>**

Төслийн төрөл	Тоо	Нийт хөрөнгө оруулалт	Нэгжийн дундаж хөрөнгө оруулалтын дүн
Дэд бүтэц	33	1,552,565	47,047
Боловсрол	21	1,283,650	61,126
ЖДҮ-н хөгжил	16	1,092,000	68,250
Орон нутгийн төрийн үйлчилгээ	20	529,955	26,498
Бичил зээлийн сан	7	373,705	53,386
Эрүүл мэнд	8	146,300	18,288
Нийгмийн халамж	6	98,900	16,483

Сентерра нь 2012 онд тухайн сангийн үйл ажиллагааг дүгнэн үнэлж, Гацууртын төслийн хийхээр үүрэг амлалт авсан хөрөнгө оруулалтууд нь олон улсын салбарын сайн туршлагатай нийцэж байгаа эсэх, Бороогийн төслөөр дамжуулан СХС-г байгуулах санааг орон нутгийн иргэд дэмжиж буй эсэхийг баталгаажуулсан. Үнэлгээний явцад ирээдүйн хөрөнгө оруулалтад тусгах зорилгоор оролцогчдоос ярилцлага авч тэдний бодлоор чухал гэж үзсэн төслүүдийн талаар санал бодлыг нь сонссон<sup>206</sup>.

**Хүснэгт 7.7 Ирээдүйн Сентеррагийн хөрөнгө оруулалтаас орон нутгийн иргэдийн хүлээх хүлээлт**



Аймгийн хэмжээнд ЖДҮ зээл, дэд бүтцийн төслүүд илүү хувь эзэлж байгаа хэдий ч боловсрол, эрүүл мэндийн салбарыг бас тодотгосон байна. Үнэлгээ нь зарим төрийн албан хаагчид СХС-г өөрсдийн 'мөнгөний уурхай' мэт үзэж байгаа нь илрүүлсэн тул цаашид орон нутгийн иргэдийг татан оролцуулсан олон жилийн стратегийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах шаардлагатайг харуулсан. Үүнээс гадна оролцогчид эдийн засгийн сайжруулалтыг дараах байдлаар эрэмбэлсэн байна: орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн боломжууд, орон нутгийн ханган нийлүүлэгчдийг хөгжүүлэх (орон нутгийн бизнесийг тодорхой шаардлага хангахад нь туслаж чадавхижуулах сургалт хийх).

ЖДҮ-н зээлийн туршлагыг нарийвчлан судалж үзвэл Сентерра нь 2006 оноос хойш бичил зээлийн сангаар дамжуулан нийт 994,568,300 төгрөгийн 1,127 бичил зээл олгосон байна (энэ нь

<sup>205</sup> Олон нийтийн Хөрөнгө оруулалтын үнэлгээ (TERI, 2012).

<sup>206</sup> Олон нийтийн Хөрөнгө оруулалтын үнэлгээ (TERI, 2012).

ойролцоогоор нийт сүм хөгжүүлэх сангийн 7% ). Нийт бичил зээлийн 79% нь Баянгол суманд, үлдсэн нь 21% нь Мандал сумын 2 багт олгогдсон. Хөтөлбөрийн үнэлгээ нь бичил зээлүүд орон нутгийн хүмүүст санхүүгийн үйлчилгээ авах боломжийг нээж, бага орлоготой хүмүүст бизнес эхлэх, бизнесээ өргөжүүлэх санхүүгийн боломжоор хангаж өгсөн гэдгийг харуулсан. Бичил зээлийн санг Баянгол сумын туршлагаар мэргэжлийн байгууллага удаан хугацаагаар ажиллуулах нь зүйтэй гэсэн зөвлөгөө гарсан.

Эцэст нь, Сентерраг СХС-гаас санхүүждэг хандивын бодлогыг сайжруулж, бөгөөд Гацууртын төсөлд үргэлжлүүлжх зөвлөмж гарсан:

- Улирал болон жил тутам тодорхой чиглэлийн хандивын мөчлөгийг зарлаж сурталчилах.
- Уурхайгаас үүдэлтэй нөлөөллийг бууруулах асуудал дээр анхаарлаа илүү хандуулан, уурхайн бүтээн байгуулалтын бүсэд амьдарч байгаа хүмүүсийн тогтвортой амьжиргаа, итгэл үнэмшилийг баталгаажуулах зорилгоор зорилтот бүсийн олон нийтэд хандивын чиглэлийг тодорхой болгож танилцуулах.
- Тодорхой чиглэлийн хандивын хэмжээг тодорхойлж зарласан байх , жишээ нь спорт.
- Тогтвортой байдлыг дэмжих үүднээс тэтгэвэрт хөтөлбөрийг (заавал хандив биш) хэрэгжүүлэх<sup>207</sup>.

Эдгээр зөвлөмжүүдийн дагуу Сентерра нь Гацууртын төслийн үйл ажиллагааны нийт хугацаанд орон нутгийн хөгжлийн үйл ажиллагааг аймаг болон төслийн бүсийн сумуудтай хийх Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд гүйцэтгэхээр үүрэг авсан. Хамтын ажиллагааны гэрээ нь дараах зүйлсийг дагаж мөрдөн ажиллах ёстой:

- Гэрээнд санхүүжүүлэхээр тусгасан үйл ажиллагаанууд аймаг болон орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөнд багтсан байх;
- Хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь тогтвортой хөгжлийн зарчим дээр суурилсан байх; ба
- Хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь иргэдийн амьжиргааг сайжруулж, ЖДҮ болон өрхийн бизнесийг дэмжсэн байх.

Хамтын ажиллагааны гэрээний агуулгыг тусгасан Орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулна (Хамтын ажиллагааны гэрээ албан ёсоор хүчин төгөлдөр болсоны дараа). Орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө нь компанийн менежментийн тогтолцооны салшгүй нэг хэсэг байна.

### **Бараа, үйлчилгээ үзүүлэх замаар орон нутгийн эдийн засгийн боломжуудыг бүрдүүлэх**

Гацууртын төсөлд орон нутгийн ханган нийлүүлэгчид үзүүлэх боломжтой тодорхой тооны бараа, үйлчилгээ байна. Эдгээрт<sup>208</sup> дараах бараа багтана: хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн (мах, ногоо, гурил, сүүн бүтээгдэхүүн, талх, өндөг), түлш, ажлын хувцас (аюулгүй ажиллагааны тоноглол), дээжний уут болон алт тээвэрлэх хайрцаг; үйлчилгээнд дараах багтана: харилцаа холбоо, харуул хамгаалалт, хоол хүнс, цэвэрлэгээ, ажиллагсдын тээвэрлэлт, хүдэр тээвэрлэлт, хүнд машин механизмын засвар үйлчилгээ, хаягдал материалын устгал (батерей, дахин боловсруулсан

<sup>207</sup> Олон нийтийн хөрөнгө оруулалтын үнэлгээ, TERI 2012.

<sup>208</sup> Гацууртын төслийн танилцуулга 2015 оны 3-р сар

хуванцар, төмөр), бизнес эрхлэгчдэд бизнесийн төлөвлөлт, бизнес эхлүүлэх тал дээр үзүүлэх дэмжлэг.

Ханган нийлүүлэгчийн гэрээнд тавигдах шаардлага, стандартуудыг тодорхой заасан байна. Бороогийн төсөл нь орон нутгийн ханган нийлүүлэгчдийг хэд хэдэн салбарт амжилттай татан оруулж (ажиллагсдын тээвэрлэлт, зарим хүнсний бүтээгдэхүүн), гэрээт гүйцэтгэгчийн ажиллах хүчийг орон нутгаас авч ажиллуулсан (жишээ нь хүнс, цэвэрлэгээ болон кемпийн үйлчилгээнд) туршлагатай тул Гацууртын төсөлд ч гэсэн энэхүү зохистой менежментийг ижил түвшинд хуулбарлан хэрэгжүүлэх бүрэн боломж байгаа. "Орон нутгийн ханган нийлүүлэгч" болохын тулд аж ахуйн нэгжүүд орон нутагт тодорхой хугацаанд бизнес эрхэлж, үйлчилгээ үзүүлсэн байх, харин орон нутгийн ажиллагсад нь тухайн газар нутагт тодорхой хугацаанд оршин суусан байх шаардлагатай.

Төслийн үйл ажиллагааны бүх үе шатанд өсөн нэмэгдэх худалдааны үйл ажиллагаа, ажлын байр бий болох, тогтвортой орлого нэмэгдэх зэргээс үүсэх төслийн зардлаас эерэг эдийн засгийн нөлөөлөл ерөнхийдөө гарна гэсэн хүлээлт байгаа. Газарзүйн хамрах хүрээ нь орон нутгийн ажиллах хүчинд давамгайл эрх олгож байгаа тул голчлон сум, аймгийн түвшинд байххэдий ч улсын хэмжээнд мэдрэгдэнэ. Хүлээгдэж буй нөлөөлөл нь шууд болон шууд бус, өндөр, эерэг байх болно. Хугацаа нь барилга, ашиглалтын үе шатуудад үргэлжилнэ.

#### **7.1.1.2**      [Сайжруулах болон нөлөөллийг бууруулах арга хэмжээ](#)

##### [Хөдөлмөр эрхлэлт](#)

#### **Шууд болон шууд бус хөдөлмөр эрхлэлт**

Сентерра нь урьд Бороо Гоулд уурхайн уурхайд хэрэгжиж байсан Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого хэрэгжүүлнэ. Тухайн ажлын байранд шаардлагатай мэдлэг, үр чадвар, туршлагатай орон нутгийн иргэдийг давуу эрхээр ажилд авна. Энэ бодлого нь Гацууртын төсөлд цаашид хэрэгжих ба Сентерра нь гэрээт гүйцэтгэгчдэд ижил бодлого дагаж мөрдөхийг шаардана. Энэхүү бодлогын дагуу эхлээд төслийн бүсийн (Түнхэл баг, Мандал, Баянгол сумд) ажилд орох сонирхолтой хүмүүсийг давуу эрхтэйгээр ажилд авч, дараа нь Сэлэнгэ аймгийн иргэд болон бусад аймгийн иргэдийг ажилд авна. Сентерра нь орон нутгийн иргэдийг тухайн ажлын байранд тохируулж бэлдэх шаардлага, менежментийн үйл ажиллагаануудыг баримтжуулсан Хөдөлмөр эрхлэлт, сургалтын төлөвлөгөө боловсруулна. Үүнд: Орон нутгийн иргэдээс ажилд авах давуу эрхийн шалгуурыг төслийн бүсэд амьдарч, оршин сууж байсан хугацаанаас хамаарч тогтоох (энэ нь боловсрол эзэмших боломж ядмаг, ажилгүйдлийн түвшин өндөр байгаагийн улмаас одоогийн хөдөлмөр эрхлэлтийн боломж нь хязгаарлагдсан Түнхэл багийн хувьд их ач холбогдолтой); ажлын байранд тавигдах шаардлагуудыг тодорхой болгох (жишээ нь: хүнд машин механизм жолоодох эрхийн төрөл, ажлын туршлагыг жилээр нь заасан байх); ажлын байрны зарыг орон нутгийн Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс, компанийн цахим хуудсанд байршуулсан байх; Монгол ажиллагсдыг олон улсын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны стандартыг хангуулах холбогдох сургалтын хөтөлбөрийн шаардлагууд дээр МҮСТ-тэй хамтрач ажиллах; сумын засаг даргын тамгын газартай хамтран ажлын байранд тохирсон өргөдөл гаргагчдыг дэмжин ажиллах.

Талуудыг өргөнөөр татан оролцуулсанаар үйл ажиллагааныхаа эрсдэлийн сайн зохицуулахаас гадна, олон нийтийн дэмжлэгийг олж авна. Орон нутгийн иргэд болон төслийн нөлөөлөлд өртөж

болзошгүй оролцогч талуудтай уулзаж, ажлын байрны боломж, тавигдаж буй шаардлага, шалгуур үзүүлэлт, өргөдөл өгөх хугацаа, үнэлгээний үйл явцын талаар тайлбарлаж ярилцах чадвартай Олон нийттэй харилцах хэлтсийн түсгайлан сургасан ажилтанууд орон нутгийн хүмүүсийн хүлээлт, санаа зовоож буй асуудлуудыг хариуцан ажиллана. Бүлэг 8-д харуулсан Байгууллагын бүтцэнд Олон нийттэй харилцах хэлтсийн ажилтнуудын Хөдөлмөр эрхлэлт болон Сургалт бүхий НМТ-үүдийг хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг нарийвчлан зааж өгсөн байна.

Уурхай хаалтын үед ажиллах хүчний тоо буурна. Нөлөөлөл бууруулах арга хэмжээ нь Сентеррад хэрэгжүүлсэн байсантай ижил журам, үйл явцтай урьдчилсан арга хэмжээнүүд байх юм:

- Сентерра нь ажилд авахаар төлөвлөсөн ажиллагсадаа судалж, ирээдүйн ажлын байрны төрөл, тоог тодорхойлж, энэ талаар цомхотголд орж байгаа ажиллах хүчинд мэдээллэх;
- Хөдөлмөр эрхлэлтийн бусад эх үүсвэр, бизнесийн боломжуудыг эрэлхийлэх тал дээр сумын захиргааг дэмжиж ажиллах (жишээ, цомхотголын тэтгэмжийг нэгтгэн шинэ бизнес эхлүүлэх); ба
- Хамтын гэрээнд заагдсан нийтийг хамарсан цомхотголын нөхцөлүүдийг хангах; энэхүү гэрээний хүрээнд 2012 онд цомхотголд орсон ажилчдад компьютер, англи хэлний ур чадварын сургалтыг зохион байгуулсан.

### **Хөдөлмөр эрхлэлт болон ажлын байрны нөхцөл**

Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны эерэг нөхцөлийг хангах зарчмуудад дараах зүйлс багтана: орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг эрэмбэлэх; боломжит ажилтнуудыг ажлын байранд бэлдэх; одоо ажиллаж байгаа ажиллагсад, төрийн гол албан хаагчид болон үйлдвэрчний эвлэл зэрэг гол оролцогч талуудтай сайн харилцаатай байж, мэдээлэл солилцох; хууль эрхзүйн шаардлагуудыг хангаж ажиллах. БГК-ний одоогийн Хамтын гэрээ нь Бороогийн уурхайн ажилчдад хамааралтай бөгөөд хөдөлмөрийн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжуудыг заалтыг дагаж мөрдөхийг шаарддаг.

Хангалттай чадварлаг ажиллах хүч олж чадахгүй байх эрсдэлийг бууруулах үүднээс:

- Хөдөлмөр эрхлэлт болон Сургалтын менежментийн төлөвлөгөөнд оролцогч талуудын харилцааг хангаж, ажиллах үүрэг хариуцлага, ажлын байрны шалгуур, хугацааг тодорхой заах;
- Бороогийн уурхай дээр ажиллаж буй Монгол ажилчдад тогтмол сургалт явуулах;
- Бороогийн уурхай дээр одоо болон өмнө нь ажиллаж байсан ажиллагсдыг удирдах албан тушаалд (тохирсон) томилох, жишээ нь шинэ ажиллагсдыг сургах;
- Шинэ тоног төхөөрөмж дээр ажиллах боломж бүрдүүлэх зорилгоор баяжуулах үйлдвэрт одоо ажиллаж байгаа ажиллагсдыг дахин сургалтанд хамруулах (ялангуяа BIOX® үйлдвэр); ба
- Гадаад ажиллагсдыг зөвхөн тодорхой хугацаагаар ажиллуулах.

Хөдөлмөр, ажиллах хүчинд үзүүлэх нөлөөллийн болзошгүй эрсдэлийг бууруулах үүднээс:



- БГМ-ийн ажилд орон нутгийн иргэдээс түлхүү авах бодлогыг Хөдөлмөр эрхлэлт, сургалтын менежментийн төлөвлөгөөгөөр дамжуулан Гацууртын төслийн үйл ажиллагаанд нэвтрүүлж, хэрэгжүүлнэ;
- Ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээг байгуулж, хянан, хүчин төгөлдөр болгох, төслийн хэмжээнд тогтвортой, тэгш байдлыг хангах үүднээс энэ нь гэрээт ажилчдад бас хамааралтай;
- Бороогийн уурхайд хэрэглэж байсан Ажиллагсдын гомдол барагдуулах механизмыг Гацууртын уурхайд хэрэгжүүлнэ;
- Гацууртын уурхайн ажиллагсад БГК-д одоо байгаа үйдвэрчний эвлэлд нэгдэнэ гэж үзэхийн зэрэгцээ, Сентеррагийн ажиллах хүчинд хандах хандлагыг жигд байлгах зорилгоор БГК-ийн Хөдөлмөрийн гэрээний загварыг Гацууртын уурхайн ажилчдад нийцүүлэн хэрэгжүүлнэ;
- Бүх гэрээт гүйцэтгэгчдэд Хөдөлмөрийн хуулийг дагаж мөрдөн, Хөдөлмөрийн хуулиар хязгаарлагдахгүй заалтуудтай Хамтын гэрээг байгуулах шаардлага тавина. ЕСБХБ-ны PR2-н шаардлага болон хөдөлмөрийн хуулийн хэрэгжилтийг бүх гэрээт гүйцэтгэгч хангаж буйг баталгаажуулах үүднээс ажиллагсдын стандартыг тогтмол хянан, шалгана; ба
- Гэрээт гүйцэтгэгч нь үйлдвэрчний эвлэлгүй байх нөхцөлд ч гэсэн гэрээний хэрэгжилтийг хангах механизм бүхий менежментийн төлөвлөгөөг боловсруулна.

### *Хөрөнгө оруулалт, санхүүгийн үр ашиг*

Эдгээр болзошгүй нөлөөллийг бууруулах зорилго нь: төслийн бүс нутгийн хөдөлмөр эрхлэлт болон худалдан авалтын үр ашгийг нэмэгдүүлэх; орон нутгийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн Ашигт малтмалын тухай хуулийн эрхзүйн шаардлагын дагуу орон нутагт оруулах хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх; уурхайн хаалтын үе шатны сөрөг нөлөөллийг багасгах зэрэг юм. Төслийн сөрөг нөлөөллийг бууруулж (ялангуяа, орон нутгийн эмзэг бүлгийн иргэд), макро эдийн засгийн эерэг нөлөөллийг сайжруулах зорилгоор нөлөөлөл бууруулах дараах арга хэмжээг санал болгож байна:

- Орон нутгийн ханган нийлүүлэгчдийг чиглүүлэх зорилготой Орон нутгийн худалдан авалтын бодлого болон менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, үүнд:
  - БГК нь өөрийн ханган нийлүүлэгчдын гэрээнд бараа, үйлчилгээний чанар, хэмжээ, тоо болон бусад үзүүлэлтүүдийг тогтвортой байлгах үүднээс бараа, үйлчилгээ үзүүлэхэд тавигдах техникийн шаардлагууд, стандартуудыг тодорхой болгох;
  - Орон нутгийн болзошгүй ханган нийлүүлэгчдыг шалгааруулах үүднээс чадварыг нь урьдчилан судлах; ба
  - Ханган нийлүүлэгчийг хөгжүүлэх хөтөлбөрөөр дамжуулан ЖДҮ-ийн ханган нийлүүлэгчдэд зорилтот сургалт явуулж, худалдан авалтыг орон нутгийн ханган нийлүүлэгчээс авах боломжийг бүрдүүлэх.
- Цалингийн түвшинг хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөхүйц, Бороогийн уурхайн одоогийн цалинтай дүйцэхүйц байлгаж, инфляцийн нөлөөг багасгах.

- Засгийн газар, олон нийтийн харилцаа, олон нийттэй хэлэлцүүлэх үйл ажиллагааг тогтмол орлоготой болон өрх гэр толгойлсон эмэгтэйчүүд зэрэг эмзэг бүлгүүдийн санааг зовоосон асуудлуудад анхаарал хандуулсан байхаар зохион байгуулах. Орон нутгийн эдийн засгийн хөгжлийн зорилтот хувилбаруудыг тодорхойлох зорилгоор орон нутаг хөгжүүлэх хамтран ажиллах гэрээний санаачлагын хүрээнд оролцогч талуудыг татан оролцуулах хөтөлбөрийг хэрэгжүүлж, энэхүү үйл ажиллагааг уурхайн хаалтын үе шат руу ойртох тусам идэвхижүүлэх.
- Орон нутгийн инфляцийн нөлөөг багасгах үүднээс худалдан авалтыг төслийн нөлөөлөлд өртөх сүм, багуудаас ээлжилж хийх шаардлагыг Орон нутгийн худалдан авалтын бодлогын дагуу хэрэгжүүлэх.
- Төсөл хэрэгжүүлэх бүсийн эдийн засгийн үр ашгийг дэмжих үүднээс “орон нутгийн ханган нийлүүлэгч”-эд нийцэх шалгуурыг боловсруулж, хэрэгжүүлэх.
- Нийтийн үйлчилгээний өсөж буй эрэлт хэрэгцээ, татварын нэмэгдэж буй орлогыг ил тод, үр дүнтэй байдлаар зохицуулах засгийн газрын чадварыг сайжруулах санаачлагыг дэмжих, ялангуяа орон нутгийн түвшинд эмзэг бүлгүүдийг дэмжих тал дээр, болон Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг дэмжигч компанийн хувьд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын тайлангаар<sup>209</sup> дамжуулан Монгол Улсыг хөрөнгө оруулагчийнх нь хувьд үндэсний болон олон улсын түвшинд сурталчилах.
- ОНХХА гэрээний үйл ажиллагааг чиглүүлэх үүднээс Орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах:
  - Засгийн газар, олон улсын донор байгууллага болон тухайн бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа бусад хувийн хэвшлийнхэнтэй санд хөрөнгө татах зорилгоор хамтран ажиллах боломжийг эрэлхийлэх;
  - ОНХХА гэрээний бичил зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх мэргэжлийн байгууллагатай түншлэл тогтоох;
  - Санхүүгийн жилд төлөвлөсөн хугацаанда зорилтот бүсийн хөтөлбөрийн дагуу ОНХХА гэрээгээр дамжуулан хандив тараах;
  - ОНХХА гэрээний хүрээнд тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлж, хандивыг аажмаар зогсоох; ба
  - ОНХХА гэрээний хүний хөгжилд хийх хөрөнгө оруулалтыг илүү үр дүнтэй болгох үүднээс эрэмбэлэх (хөрөнгө оруулалтын зардал, дэд бүтцээс илүүтэйгээр). Компанийн орон нутгийг хөгжүүлэх хандлага нь эрэлт хэрэгцээг эрэмбэлж, олон нийтэд суурилсан хөгжлийн төлөвлөгөөний төлөвлөлт, хэрэгжилтэнд иргэдийн оролцоог хангах явдал юм.

<sup>209</sup> Сентерра Гоулд нь 2011 онд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг дэмжигч компани болсон, Монгол болон Киргизтанд ОУИТБС –г сурталчилахад идэвхтэй үүрэг гүйцэтгэж, Дэлхийн Тайлангийн Санаачлагыг (GRI G3) 2013 оноос хойш хэвлэн нийтлүүлсэн.



## 7.1.1.3 Хураангуй

Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шинж чанар	Бууруулаагүй ач холбогдол	Үлдэгдэл ач холбогдол
<b>Хөдөлмөр эрхлэлт (EBRD PR 1, 2)</b>			
Уурхайн үйл ажиллагааны нийт хугацаанд шууд болон шууд бус хөдөлмөр эрхлэлтийн боломжууд үүсэх	Тодорхой Шууд эерэг Урт хугацааны Дунд хэмжээний	-	-
Барилга, ашиглалтын үе шатанд уурхай болон уурхайн ажиллах хүчний эрэлт хэрэгцээнээс үүсэн үйлчилгээ, ханган нийлүүлэлтийн даавар ажлын байрнууд	Тодорхой Шууд эерэг Дунд хугацааны Дунд хэмжээний	-	-
Хаалтын үе шатанд шууд, шууд бус болон даавар хөдөлмөр эрхлэлт буурах	Тодорхой Шууд, их дунд сөрөг Урт хугацааны Дунд хэмжээний	Дунд	Бага
<b>Хөдөлмөрийн болон ажлын нөхцөл (EBRD PR 1, 2)</b>			
Уурхайн болон тээвэрлэлтийн гэрээт гүйцэтгэгчид Сентеррагийн хөдөлмөр эрхлэлтийн бодлогын дагуу орон нутгийн иргэдээс ажилд авахгүй байх эрсдэл	Боломжит Шууд, их бага Сөрөг Урт хугацааны Дунд хэмжээний	Өндөр	Бага
Ажилд тохирох үр чадваргүйн улмаас орон нутгийн иргэд ажлын байрны хүлээлтэнд сэтгэл хангалуун бус байх эрсдэл	Тодорхой Шууд сөрөг Дунд хугацааны Өргөн хэмжээний	Дунд	Дунд
Хангалттай үр чадвартай ажиллах хүч олох боломж муу байх	Шууд Сөрөг, их дунд Богино хугацааны Өргөн	Дунд	Бага
Хөдөлмөрийн маргаан	Шууд Сөрөг, их дунд Богино хугацааны Өргөн	Дунд	Бага
<b>Үндэсний болон орон нутгийн эдийн засгийн хөрөнгө оруулалт (EBRD PR 1, 2)</b>			
Ашиглалтын үе шатанд орон нутгийн худалдан авалтын боломжуудыг нэмэх	Тодорхой Шууд эерэг Дунд хугацааны Дунд хэмжээ	-	-
Төслөөс орон нутгийн эдийн засагт оруулах хувь нэмрийн улмаас орон нутагт инфляци үүсэх нөлөө	Тодорхой Шууд, их дунд сөрөг Урт хугацааны Дунд хэмжээний	Дунд	Бага
Барилга болон ашиглалтын үе шатанд улс болон аймгийн төсөвд орох татвар, роялти болон бусад төлбөрийн улмаас орлого нэмэгдэх	Тодорхой Шууд эерэг Дунд хугацааны Дунд хэмжээний	-	-
Уурхайн хаалтын үе шатанд орон нутгийн эдийн засгийн хөрөнгө оруулалт буурснаар төслийн нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэд илүү эмзэг байдалтай болно	Тодорхой Шууд, их дунд сөрөг Урт хугацааны Дунд хэмжээний	Дунд	Бага

## 7.1.2 Хүн амзүй

### 7.1.2.1 Нөлөөлөл

Барилгын үе шатны оргил үеийн 15 сарын туршид 300 ажиллагсад, дараа нь ашиглалтын үе шатанд 1 000 хүн ажиллах тооцоотой байгаа. Хөдөлмөр эрхлэлтийн хэсэгт дурьдсанаар төслийн бүс нутгийн шаардлагатай үр чадвар, туршлагатай орон нутгийн ажиллах хүчийг ажилд илүүтэй авах бодлого хэрэгжих ба энэ бодлого нь одоогийн хөдөлмөрийн зах зээлийн байдлаас харахад амжилт олох бүрэн боломжтой. Төслийн бүсийн сум, баг бүрээс хэдэн хүнийг ажлын байраар хангах тоо эцэслэн тодорхой болоогүй ч ажиллах хүчийг Бороогийн уурхайн туршлагаар Баянгол, Мандал сумд ба Түнхэл багийн иргэдээс бүрдүүлнэ гэж үзэж байгаа.

2014 онд Мандал сумын оршин суугчдын тоо 25,693 ба 1,430 хүн Сэлэнгэ аймаг руу шилжин ирсэн хүний ихэнх нь аймгийн хамгийн том сум болох Зүүнхараа руу нүүсэн байдаг. Тухай хугацаанд гадагшаа шилжин ирсэн хүний тоо 3,129 байсан бөгөөд цэвэр шилжилт хөдөлгөөний хувь сүүлийн 3 жил өссөн үзүүлэлттэй байна. Мандал сумын одоо байгаа нийт хүн амын тоотой харьцуулахад Төсөлд нийт ажиллах хүчний хувь зөвхөн 3.9% байна.

Орон нутгийн одоогийн хүн амаас ажиллах хүч авахаас гадна төслийн бүсэд Төсөлтэй холбоотой шууд болон шууд бус ажлын байрнаас хамааралтай шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахаар төлөвлөсөн байна. Бороогийн төслийн туршлагаас харахад ажиллагсад өөрсдөд тохирсон өрсөлдөхүйц цалингаа ашиглан зээл авч сумаас том суурин газар руу шилжиж байсан. Төсөл Дархан болон Улаанбаатартай ойрхон байгаа нь ажиллагсдыг ээлжийн системээр ажиллах боломжийг бүрдүүлдэг. Бороогийн төсөл дээр амжилттай хэрэгжиж байсны адил Сентерра нь ажиллагсдыг ээлжийн амралтын үед нь байраар хангахгүй. Уурхайн талбайн бүх ажиллагсад ажлын ээлжийн үед байраар хангагдана, ээлжийн амралтаар нь сумын төв, Дархан болон Улаанбаатар дах гэрт нь автобусаар хүргэж өгнө.

Бороогийн уурхайн туршлага дээр үндэслэн төслийн ажиллагсдын шилжилт хөдөлгөөн маш бага байх магадлалтай гэж дүгнэсэн ч Сентерра болон түүний гэрээт компаниудад богино хугацааны гэрээт ажил, эсвэл байнгын ажил хайх зорилгоор төслийн талбай руу шилжин ирэх эрсдэл байгаа. ОУСК нь төслөөс үүдэлтэй хүн амын шилжилт хөдөлгөөнийг дараах гурван хүчин зүйлсийн чанарын дүн шинжилгээгээр тодорхойлох аргыг боловсруулсан: төслийн орчинд тогтмол бус хүн ам байгаа эсэх, төслийн шинж чанар, болон төслийн хэрэгцээг хангаж чадах бүсийн чадвар<sup>210</sup>.

ОУСК-ийн аргыг хэрэглэж хүн амын шилжилт хөдөлгөөн, ажилгүй, мэргэжлээрээ ажиллах боломжгүй хүмүүсийн хувь өндөр байна гэж гарсан ч Бороогийн уурхайн туршлагаас харахад шилжин ирэх хөдөлгөөн бага – дунд түвшинд ажиглагдаж байна. Шууд болон шууд бус барилгын болон хөдөлмөр эрхлэлтийн эрэлт хэрэгцээ дунд байгаа нь төслийн онцлог юм. Төслийн хэрэгцээг хангах төслийн бүсийн чадавхи дунд зэрэг; Сэлэнгэ аймгийн ажилгүй хүн амын 65% нь бүрэн дунд боловсролтой, 18.3% нь тусгай мэргэжлийн боловсролтой байна. Баянгол (55 %) болон Мандал (37 %) сумдын иргэд өөрсдийн ажилгүй байгааг ажлын байр байхгүйтэй холбож тайлбарласан байна. Нийгмийн дэд бүтцийн төслийн хэрэгцээг хангах чадавхийн талаар 7.1.4 хэсэгт нарийвчлан тайлбарласан. Бороогийн төсөл дээр үндэслэн орон нутгийн ханган нийлүүлэх

<sup>210</sup> ОУСК-ийн Эрсдэлийн үнэлгээ

([http://www.ifc.org/wps/wcm/connect/63f07100488658f3b7a2f76a6515bb18/Influx\\_Part3.pdf?MOD=AJPERES&CACHEID=63f07100488658f3b7a2f76a6515bb18](http://www.ifc.org/wps/wcm/connect/63f07100488658f3b7a2f76a6515bb18/Influx_Part3.pdf?MOD=AJPERES&CACHEID=63f07100488658f3b7a2f76a6515bb18)).

бараа, үйлчилгээний чадавхи, ЖДҮ-ийн ур чадвар дунд зэрэг гэж дүгнэсэн ч Сентерра нь цаашдаа ОНХХА гэрээгээр дамжуулан сайжруулах төлөвлөгөөтэй байна.

Одоогийн байдлаар дунд сургуулийн боловсролтой залуучууд улирлын чанартай гэрээт ажил хайн нутгаас явж байна. Мандал сумын одоогийн ажилгүйдлийн хувь асар өндөр (2014 онд аймгийн хэмжээнд бүртгэгдсэн ажилгүйчүүдийн хувь нь 10.2%<sup>211</sup>, сумын хөдөлмөр эрхлэлтийн газрын мэдээлснээр ажилгүйчүүдийн хувь бүртгэгдээгүй ажилгүй хүмүүсийг оруулаад 29% байсан<sup>212</sup>) байна, иймд ажилгүйдэл, мэргэжлээрээ ажиллах боломж хомс байгаа зэрэгтэй холбоотой нийгмийн хагарал (ялангуяа шилжиж ирсэн хүмүүс төслөөс орон нутгийнханаас илүү үр ашиг хүртэх байдлаас) үүсэж болно. Төслийн орчимд үйлдэгдсэн гэмт хэргийн 78% нь эрэгтэйчүүд үйлддэг бөгөөд үүний гуравны нэг нь согтууруулах бодисын нөлөөнд үйлдэгдсэн байдаг. Энэ асуудлыг Орон нутгийн иргэдийн мэндийн 7.1.6 хэсэгт нарийвчлан тайлбарласан. Ихэнх тохиолдолд тухайн бүлэг хүмүүс гадагшаа явахаас илүүтэйгээр орон нутагтаа үлдэж төслөөс гарах боломжуудыг хайдаг байх магадлалтай. Мөн бусад сум руу эдийн засгийн боломжийг хайхаар явсан ч төслийн бүсэд гэр бүл нь үлдсэн хүмүүс гэр бүлдээ эргэн ирж байж төслийн барилга, ашиглалт болон уурхайн хаалтын үе шатуудын шууд, шууд бус эсвэл төслөөс үүдэлтэй эдийн засгийн боломжуудыг эрэлхийлж болно.

Шилжилт хөдөлгөөний албан ёсны баримт нь Сэлэнгэ аймаг руу шилжих хөдөлгөөн буурсан гэж харуулж байгаа ч, олон нийтийн бодлоор өссөн байна. Суурь судалгааны явцад зах зээлд ойрхон шинэ бэлчээр хайх зорилгоор баруун аймгуудаас малчин өрхүүд малтайгаа шилжин ирэх нь элбэг байна. Малчид ур чадвар, салбарын туршлага болон Англи хэлний мэдлэггүйн улмаас мал маллахаа болж, уул уурхайн салбарт (бусад салбарт) ажилд орох боломжгүй гэж үзжээ. Суурь судалгаагаар дотогш чиглэсэн бүртгэгдээгүй шилжилт хөдөлгөөн нь албан ёсны баримтаас 15%-иар илүү байгаа нь харагдсан. Бороогийн уурхайн туршлагаас харахад мал маллахаа больж Сентерра эсвэл гэрээт гүйцэтгэгчийн компанид ажилд орох магадлал маш бага байгаа ба зөвхөн улирлын чанартай, ур чадвар шаардлагагүй ажил л малчдын амьжиргааг тэтгэх магадлалтай юм.

Үндэсний хэмжээнд уул уурхайн ажлын зах зээлийн өрсөлдөөний өнөөгийн түвшин дотогш чиглэсэн шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх учир ажлын байр болон эдийн засгийн боломж хайж гаднаас шилжиж ирэх асуудлыг бууруулах тал дээр компани сумын захиргаатай хамтран ажиллах. Тиймээс шилжилт хөдөлгөөнтэй холбоотой хүн амзүйн болзошгүй сөрөг нөлөөлөл нь дараах зүйлсийг багтаана:

- Төслийн үйл ажиллагааны явцад нийгмийн дэд бүтцэд бага хэдий ч өсөн нэмэгдэх дарамт (цаашид Нийгмийн дэд бүтцийн хэсэгт нарийвчлан оруулсан);
- Төслийн ашиглалтын үе шатанд ихсэх ажлын байрны өрсөлдөөн нь нийгэмд дунд-их хэмжээний хагарал үүсгэнэ (Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, нийгмийн нэгдэл хэсэгт илүү нарийвчилсан тайлбарласан);
- Орон нутгийн чанартай инфляци үүсгэх (Эдийн засгийн хэсэгт тодорхой оруулсан); ба

<sup>211</sup> Суурь судалгаа 2015.

<sup>212</sup> Бороогийн уурхайн хаалтын үе шатны нийгмийн нөлөөллийн үнэлгээ, 2014.

- Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд муудахад хүргэх (жишээ нь бэлгийн замын халдвар өвчин, халдварт өвчин, согтууруулах ундааны хэрэглээтэй холбоотой хүчирхийлэл нэмэгдэх).

#### 7.1.2.2 Сайжруулах болон нөлөөлөл бууруулах арга хэмжээ

Төслийн бүсийн орон нутгийн иргэдийн хүн амзүйн өөрчлөлттэй холбоотой болзошгүй сөрөг нөлөөний талаар сайн ойлголттой байгаа ба хэлэлцүүлгийн явцад болзошгүй нөлөөлөл бууруулах саналыг хэлэлцсэн байна. Үүнд: “орон нутгийн” хөдөлмөр эрхлэлтийн давуу эрхийг эрэмбэлэх зорилгоор оршин суух хугацааг тодорхойлох. Энэ шаардлагыг Засгийн газрын холбогдох агентлагуудтай хамтран дэвшүүлж, эдийн засгийн ашиг олох зорилготой орон нутаг руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг багасгах талаар ярилцана.

Шаардлагатай тохиолдолд, сумын захиргаатай хамтран шилжилт хөдөлгөөний сөрөг нөлөөлөл, ажиллагсад болон орон нутгийн иргэдийн хоорондын болон дотоодын харилцааг бүртгэж, арга хэмжээ авах зэрэг хүн амзүйн өөрчлөлтийн хяналт шинжилгээг хийх.

Барилга дээр ажиллах ажлын хүч харьцангуй бага байх хэдий ч Бороогийн төслийн туршлагаас харахад барилгын кемпын стандартыг мөрдүүлэх нь энэ түр хугацаанд ажиллах хүчний болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад ач холбогдолтой байдаг нь батлагдсан. Тийм болохоор, Бороогийн уурхайн талбай болон гадна байрлах гэрээт гүйцэтгэгчийн ажиллагсад Сентеррагийн шаардлагуудыг ажлын байр, кемп дээр ижил мөрдөнө. Үүнд, мөн Бороогийн уурхайн Мансууруулах бодис, архины хэрэглээний бодлого, Сентеррагийн аюулгүй ажиллагааны шаардлагуудыг барилгын ажлын гэрээт компаниуд хэрэгжүүлэх багтана. Үүний зэрэгцээ, гэрээлэт гүйцэтгэгчид барилгын үе шатанд орон нутгийн үр ашиг нэмэгдүүлэх үүднээс Сентеррагийн орон нутгийн иргэдээс илүүтэй ажилд авах бодлогыг бас дагаж мөрдөх ёстой.

Төсөл нь Засгийн газартай хамтран төслөөс үүсэх дотогш чиглэсэн шилжилт хөдөлгөөний асуудлыг хуулиар зохицуулах тал дээр хамтран ажиллах ба Сентерра нь төслөөс үүсэх аливаа нийгмийн дэг журмын эсрэг гэмт хэргийг зохицуулахдаа цагдаа болон Засгийн газрын холбогдох агентлагуудтай хамтран ажиллана.

Нийгмийн дэд бүтэц, Орон нутгийн эрүүл мэнд, эдийн засаг хэсгүүдийг харна уу.

#### 7.1.2.3 Хураангуй

Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шинж чанар	Бууруулаагүй ач холбогдол	Үлдэгдэл ач холбогдол
<b>Хүн ам зүй (ЕСБХ-ныБ PR 1)</b>			
Ажил хайсан хүмүүсийн тоо нэмэгдэх нь үйлчилгээнд дарамт үүсгэж, орон нутагт нийгмийн хагарал үүсгэх	Тодорхой Шууд/шууд бус, дунд сөрөг Урт хугацааны Дунд хэмжээ	Дунд	Бага

### 7.1.3 Газар ашиглалт болон амьжиргаа

#### 7.1.3.1 Нөлөөлөл

Бороогийн уурхай дээр одоо ашиглаж буй ХХБ болон BIOX® үйлдвэр зэргийг сайжруулж, хэвээр нь авч үлдэн, Сентеррагийн уурхайн хүдэр баяжуулах үйлдвэр барих газрыг Бороогийн уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрлийн бүсэд төлөвлөсөн байна. Төслийн үйл ажиллагааны бүхий л



хугацаанд 2010 онд баригдсан Бороо болон Гацууртын уурхайн хоорондох нийтийн хэрэглээний замыг ашиглах явцдаа зам дагуух газрын бусад ашиглагчдыг (Хэсэг 3:Төслийн хувилбар-т тайлбарласан бэлчээр, газар тариалан, төрийн эзэмшлийн ой бүхий газар) тоос, дуу чимээ, чичиргээний нөлөөлөлд өртөх явдлыг бууруулах арга хэмжээ авна. Гацууртын уурхайн үйл ажиллагаа нь бичил уурхайн үйл ажиллагааны улмаас их хэмжээгээр өөрчлөлтөнд орсон шороон ордууд дээр явагдана. Төсөл нь мод огтлох үйл ажиллагааг хязгаарлах ба аливаа газрыг зөвшөөрлийн дагуу хөндөж, төслийн талбайд мод тарьж, дүйцүүлэн хамгаалахаар төлөвлөсөн байна. Гацууртын төслийн үйл ажиллагаа нь 2004 оноос хойш явагдаж байгаа тул уурхайн талбайг хашаагаар хашиж, харуул хамгаалалтын постыг байрлуулсан байна. ХХБ-н өргөтгөлд одоогийн ил уурхайн шорооны овоолгыг аль болох түлхүү ашиглах төлөвлөгөөтэй байгаа хэдий ч шаардлагатай хэмжээний шороогоор хангах үүднээс газар шорооны нэмэлт ажлууд хийгдэх магадлалтай. Иймд, барилга болон ашиглалтын үйл ажиллагаанд нэмэлт газар шаардлагагүй хэдий ч нэмэлт шороогоор хангах үүднээс зарим газрыг хөндөх шаардлагатай болно. Уурхайн хаалтын үе шатанд дэд бүтцүүдийг татан буулгах; өмнөх бичил уурхайн үйл ажиллагаанаас эвдэрсэн Гацууртын хөндийн газрыг сэргээх зорилгоор Гацууртын уурхайн тусгай зөвшөөрлийн талбайн эвдэрсэн газрыг тогтворжуулж, нөхөн сэргээх зэрэг ажил хийгдэнэ. Газар эзэмших өмнөх үйл ажиллагаатай холбоотойгоор шийдэгдээгүй үлдсэн асуудал байхгүй. Нүүлгэн суурьшуулалтын хаалтын аудит нь нүүлгэн суурьшуулах бүх ажлыг амжилттай гүйцэтгэсэн гэж дүгнэсэн байна.

#### *Бэлчээрт үүсэх нөлөөлөл*

Төслөөс бэлчээрт үзүүлэх нөлөөлөл нь бэлчээр ашиглагчдад үзүүлэх дараах асуудлуудаас үүдэлтэй: ХХБ-г өндөрсгөх барилгын ажил болон нийтийн хэрэглээний замын ашиглалт, ялангуяа: төслийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэлтэй тоос, дуу чимээ, чичиргээ нь нийтийн хэрэглээний зам дагуу болон ХХБ-ын ойролцоох бэлчээр, тариалангийн талбайн чанар, хүртээмжинд нөлөөлөх ба Гацууртын уурхайн үйл ажиллагаанаас бусад усны хэрэглэгчид нөлөөлөлд өртөж болзошгүй.

Газар ашиглалтын судалгаанд (2010) төслийн бүсийн бэлчээрийн газар нь ихэнхдээ малчдын хагас суурин амьдралын хэв маягийн улмаас улирлын чанартай хоёр удаа (өвөл/хавар болон зун/намар) ашиглагддаг гэж дурьдсан байна. Газар тариалан томоохон үүрэг гүйцэтгэдэг болсноор бэлчээрийн газар улам ховор болж; бэлчээрийн доройтолд гол төлөв баруун аймгаас малтайгаа шилжин ирэх олон тооны малчин өрх нөлөөлж байна гэж үзэж байгаа ч хүн амзүйн албан ёсны мэдээлэл эсрэг байна. Бэлчээрийн газрын хомсдол ба/эсвэл малын тоо толгойн өсөлт зэргийн улмаас бэлчээрийн доройтол ноцтой асуудал болж байна.

Мал аж ахуйн үйлдвэрлэл нь малын чанар, түүний ашиг шим болон малын тоо толгой зэргийн тэнцвэр юм. Малын тоо толгой нь ашиглах боломжтой бэлчээрийн газрын хэмжээтэй тэнцүү бөгөөд сайн чанарын бэлчээрийн газар нь эрүүл, ашиг өндөртэй, амьдрах чадвартай мал сүргийн баталгаа болдог. Малчин өрхийн орлого нь мал аж ахуйн бүтээгдэхүүний үнэ, зах зээлийн байршил болон тээврийн зардал зэрэг хүчин зүйлсээс хамаардаг ба эдгээр нь малчдын орлогонд шууд нөлөөлдөг<sup>213</sup>.

<sup>213</sup>

Оюу Толгой Бэлчээрийн газар ба амьжиргааг сайжруулах стратеги (2012).

Бэлчээр ашиглалтыг өрх ба уламжлалт нэгж болох хот айлаар (адаглаад нэг улирал хамтдаа байх бүлэг өрхүүд) зохицуулдаг. Малчдын хамтарсан бүлгийг байгуулах санаачлага гарсан хэдий ч эдгээр бүлгүүд нь дөнгөж хөгжиж байна. Хагас нүүдэлчин малчид болох нутгийн иргэд ихэвчлэн төслийн ойр орчим оршин суух ба зун, өвлийн улиралд ойр орчмын сумдаас зарим малчид түр хугацаанд нүүдэллэн орж ирэн хомсдолтой байгаа бэлчээрийн газарт ачаалал үүсгэн, орон нутгийн малчдын бэлчээрийн хүртээмжид нөлөөлдөг.<sup>214</sup> Бэлчээр болон хадлангийн талбай ашиглах, мал услах худаг зэрэг дээр газар, усны маргаан байнга гардаг. Сум, багийн малчдын дунд маргаан үүсэх нь ховор; гол төлөв сумын хил орчмын газрын оршин суугчид болон шилжин ирсэн малчдын дунд маргаан гардаг гэж 2010 онд хийгдсэн судалгаагаар харагдсан байна. Малчид болон газар тариаланчдын дунд маргаан гарах нь элбэг ба 2015 оны судалгаанд хамрагдсан оролцогчдын 30% нь малчид, хадланчид болон тариаланчдын дунд маргаан байгааг баталсан. Судалгаагаар уг маргаан нь малчид бэлчээр сэлгээдэггүй, тариалангийн талбайг хашаалаагүй зэргээс болж мал тариалангийн талбайд орж ургацыг идэж, сүйтгэдэг гэсэн байна. Тариалангийн талбайг хашаажуулах явдал нэмэгдэж байгаа нь цаашид малчдын бэлчээрийн газар ашиглах боломжийг багасгаж байгаа ба одоогоор маргааныг гол төлөв тохиролцох замаар шийдвэрлэж байгаа нь талуудыг хооронд нь тэмцэлдүүлж байж болох юм.

Бороогийн уурхайн үйл ажиллагааны явцад ХХБ-ийг хоёр удаа өндөрсгөсөн байна. Энэхүү байгууламжийн ханыг өндөрсгөх газар шорооны ажилд шаардлагатай шороо ба шавар материал зөөх болон хүнд тоног төхөөрөмж ашиглах үйл ажиллагаанаас үүдэн гарах тоосжилт, дуу чимээ, чичиргээ нь ойр орчмын бусад, ялангуяа салхин доор байгаа газар ашиглагч нарт (малчид, тариаланчид аль алинд нь) нөлөөлөл үзүүлж болзошгүй. ХХБ-ийн нөлөөлөлд өртөж болзошгүй нэг газар ашиглагч ХХБ-аас 5 км-н зайд байна. Шууд, сөрөг, түр хугацааны болон орон нутгийн чанартай болзошгүй нөлөөллийг үр дүнтэй удирдаж чадаж байгааг Бороогийн уурхайн туршлагаар харуулсан байна.

Зам дагуух газар ашиглагч нарт төслөөс үзүүлэх нөлөөлөл нь замын хөдөлгөөнтэй холбоотой өсөн нэмэгдэж, бэлчээрийн болон тариалангийн газарт тоосжилтийн нөлөөлөл үүсч болно. Одоогийн байдлаар, нийтийн хэрэглээний зам нь шороон зам ба шаардлагатай үед, Сентерра ХХК нь тогтмол хусаж сайжруулдаг. Зам дээр тоос дарагч бодисийг ашигладаггүй. 2015 оны замын хөдөлгөөний судалгаагаар, Бороо, Гацууртын уурхай болон Зүүнхараа сумын хоорондын нийтийн хэрэглээний зам дээр зорчих тээврийн хэрэгслийн тоо, төрлийг судалсан. Бэлчээр эзэмшигч болон газар тариаланчдад хамгийн их нөлөөлөх замын хэсгийг Бороогийн уурхай болон Зүүнхараа сумын хоорондох замын хэсэг гэж тодорхойлсон. Зүүнхараа сумаас Гацууртын уурхай руу орох замын хэсэг нь бэлчээрийн газар, тариалангийн талбай багатай, ой мод ихтэй газар. Энэ нийтийн хэрэглээний зам дээр өдрийн цагаар Улаанбаатараас баруун зүг болох Зүүнхараа сум руу зорчих тээврийн хэрэгслийн ихэнх нь хөнгөн тэрэг байна гэж судалгаагаар гарсан. Суурь судалгаанаас харахад замын нөхцөл сайтай байгаа учраас ихэнх суудлын тэрэг хурдтай явдаг тул тоос босох магадлал өндөртэй байна. Замын энэ хэсэгт өдөрт дунджаар төрөл бүрийн 70-н тээврийн хэрэгсэл зорчиж байна.

Судалгаагаар замын нийт хэсэгт өдөрт дунджаар зорчиж байгаа 357 тээврийн хэрэгслийн 6% нь том оврын машин эсвэл автобус байна гэж гарсан байна. Төсөлтэй холбоотой тээврийн

<sup>214</sup> Газар ашиглалтын судалгаа, Бодлого судлалын төв 2010 оны 12-р сар

хэрэгслийн нэмэлт ачааллыг тооцон үзэхэд цагт дунджаар зургаан тээврийн аччаны тэрэг хөдөлгөөнд оролцох ба эдгээр нь өдөрт 24 цаг, жилд 350 хоног хөдөлгөөнд оролцоно. Иймд эдгээр тээврийн ачааны тэрэг нь бусад тээврийн хэрэгслүүдтэй харьцуулахад илүү том, дуу шуугиан ихтэй, хүнд байх нь ойлгомжтой бөгөөд Гацуурт – Бороогийн уурхайн хоорондох нийтийн хэрэглээний зам дагуу амьдарч байгаа айл өрхүүдэд тоосжилт, дуу чимээ, чичиргээний нөлөөлөл илүү ихээр үзүүлнэ. Суурь судалгаа хийх үед нийтийн хэрэглээний замтай ойрхон гэрт амьдардаг 18 (хагас нүүдэлчин) өрхүүд (нөлөөлөлд өртөгч) байна.

Тээврийн ачааны хүнд машины өдрийн цагаар зорчих үйл ажиллагаа нь нөлөөлөлд өртөгчдөд үзүүлэх дуу чимээ, чичиргээний нөлөөг өөрчлөх өртөх магадлалтай, ба орчны дуу чимээний түвшин доогуур байх шөнийн цагаар илүү их нөлөөлөл үзүүлэх болно гэж үздэг байна. Тоосжилт нь илүү хуурай, салхитай хаврын улиралд илүү их үүсэх хандлагатай.

Дуу чимээ, чичиргээний нөлөөллийг бууруулахдаа замын хөдөлгөөний аюулгүй байдлын арга хэмжээг нэн тэргүүн авч үзнэ. Замын хөдөлгөөн болон замын аюулгүй байдлын талаарх нэмэлт мэдээллийг Хэсэг 7.1.6: Орон нутгийн иргэдийн аюулгүй байдал хэсгээс харж болно.

#### *Ойн нөөц*

Бороо болон Гацууртын уурхайн хоорондох замыг тогтмол ашигласнаар тухайн бүсэд болон зам дээр замын хөдөлгөөн ихсэж, модыг хууль бусаар бэлтгэх зэрэг ойн нөөцийн хууль бус ашиглалтын хэмжээг буурах магадлалтай. Уурхайн талбай хүртэлх одоогийн замын хөдөлгөөн тасалданги байгаа ба өдөрт дунджаар Гацууртын уурхайгаас Бороогийн уурхай хүртэл 13 тээврийн хэрэгсэл, шөнөдөө 6 тээврийн хэрэгсэл явж байгаа бол Гацууртын уурхай болон Зүүнхараа сумын хооронд өдөртөө 19 тээврийн хэрэгсэл, шөнөдөө 5 тээврийн хэрэгсэл явж байна. Ой ашиглагч бүлгүүдийн ашиглаж буй ой бүхий газар нэмэгдэж байгаа хэдий ч төслийн бүсийн эдгээр ойн нөхөрлөлүүдийн зарим нь ашиглаж байгаа ой бүхий газрын хил хязгаараа тодорхойлоогүй, бөгөөд эхлэлийн шатандаа явж байна<sup>215</sup>. Эдгээр ойн нөхөрлөлүүдийн үүрэг хариуцлага нь одоогийн байдлаар бүрэн тодорхойгүй, зохицуулалт муутай, ихэнх нь өөрийн эзэмшлийн газарт хамгийн их тохиолдох зөрчил болох хууль бус мод бэлтгэх үйл ажиллагаатай тэмцэхэд гол анхаарлаа хандуулдаг. Одоогийн байдлаар, эдгээр ойн нөхөрлөлүүдийн гол үйл ажиллагаа нь өөрсдийн эзэмшлийн ой бүхий газрыг хамгаалах байдлаар хязгаарлагдаж байна. Зам барьснаар ой бүхий газрыг ашиглахад илүү дөхөм болсон хэдий ч төслийн барилга, ашиглалтын үе шатанд төслийн бүсэд үйл ажиллагаа идэвхжиж төслийн зам ашиглалт нь ой хамгаалах үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлэх магадлалтай.

#### *Амьжиргаанд нөлөөлөх замын нөлөөлөл*

Нийтийн хэрэглээний замаар төслийн хүнд даацын тээврийн хэрэгсэл явснаар төслийн тээврийн хэрэгсэл мал мөргөлдөх эрсдэлийг нэмэгдүүлнэ. Уурхайн замын хөдөлгөөн орон нутгийн бусад замын хөдөлгөөнтэй харьцуулахад хурд багатай байх хэдий ч хүнд даацын тээврийн хэрэгслийн жин (бүрэн ачаатай) 30 тонн байдаг тул зам дээр мал гарч ирсэн тохиолдолд хугацаандаа зогсч чаддаггүй. Суурь судалгаагаар 2014 онд Мандал суманд (Баянгол суманд бүртгэгдээгүй) 5 машин мал мөргөсөн тохиолдол бүртгэгдсэн гэж гарсан байна<sup>216</sup>. Жилийн хувьд энэ нь бага үзүүлэлт мэт

<sup>215</sup> Бодлого судлалын төв, Газар ашиглалтын судалгаа (2010).

<sup>216</sup> Баянгол болон Мандал сум дахь замын ослын нөхцөл шалтгааны тайлан, 2014.

харагдаж байгаа нь сумын статистик мэдээнд дутуу бүртгэгдсэн, жолооч малчинд нөхөн төлбөр өгөөд, хоорондоо тохиролцсон ч байх магадлалтай юм.

Хүний амь нас, эрүүл мэндэд учрах болзошгүй аюулыг буруулсан байдлаар зам ашиглах нь нэн тэргүүний асуудал. Иймд, энэ асуудалд тохирох нөлөөлөл бууруулах арга хэмжээнүүдээр мал болон малчдын амьжиргаанд үзүүлж болзошгүй нөлөөллийг бууруулж буйг баталгаажуулна. Төслийн бүхий л үе шатуудад шууд, болзошгүй сөрөг нөлөөллүүд бага хэмжээгээр гарсаар л байх болно. Хэсэг 7.1.6: Олон нийтийн аюулгүй байдал-д нөлөөлөл бууруулах арга хэмжээнүүдийг тайлбарласан байна.

#### *Газрын гадаргуу болон газрын эвдрэл*

Газрын гадаргуу, газрын эвдрэлийн нөлөөлөлтэй холбоотой байгаль орчны асуудлуудыг холбогдох БОНБНУ-ний баримт бичигт тусгасан. Энэхүү тайланд нийгэм-эдийн засгийн асуудлууд, нөлөөллийг тайлбарласан.

Гацууртын уурхайн газрын гадаргуу нь төслийн бүхий л үе шатанд ил уурхай болон хаягдал чулуулгийн овоолго зэргийн улмаас байнга өөрчлөгдөнө. Газрын гадаргууд үзүүлэх нөлөөлөл нь шууд, урт хугацааны, бага хэмжээний, бага цар хүрээтэй байна.

ХХБ болон цэвэр усны цөөрмийн барилгын ажилтай холбоотой газар шорооны барилгын материалыг ухаж гаргахад газрын эвдрэлийн нэмэлт нөлөөлөл үүснэ. Барилгын материалыг одоогийн ашиглаж буй карьеруудаас гаргаж авах хэдий ч эдгээрийн өргөтгөлийн үйл ажиллагаанаас гарах сөрөг нөлөөлөл нь шууд, дунд зэргийн бага, бага хэмжээний байх болно.

2010 онд орон нутгийн засаг захиргаа нь орон нутгийн иргэд, компаниудыг байлцуулан Гацууртын уурхайн талбайн ил уурхай, хаягдал чулуулгийн овоолго барихаар төлөвлөсөн хэд хэдэн байршилд мод бүхий газрыг хөндөж цэвэрлэснээр газар хөндөх ажил анх удаа хийгдсэн байна. Газар хөндөх зөвшөөрөл авахад юуны түрүүнд сумын өөр хэсэгт дүйцүүлэн хамгаалах зорилгоор шилжүүлэх суулгах модны тоог гаргах шаардлагатай. Уурхайн үйл ажиллагаа эхлэх үед мод тарих, дахин ойжуулах үйл ажиллагаа Түнхэл баг болон Мандал сумын орчим явагдана. Жишээ нь: 2010 онд Гацууртын уурхайн төсөл нь эхний 82 га газрын ургамалын бүрхэвчийг хөндөхдөө орон нутагт нөхөн төлбөр болгон 4,948 зулзаган мод тарьсан ба үүний 1,260 модыг Түнхэл багт тарьсан байна. Дараагийн 1,048 модыг Гацууртын уурхайгаас Бороогийн уурхай руу Түнхэл багийн ажиллах хүчийн тусламжтайгаар нүүлгэн шилжүүлэн, суулгасан байна.<sup>217</sup>

#### *Бичил уурхай*

2010, 2015 онуудад хийсэн судалгаанд Гацууртын уурхайн бичил уурхай эрхлэгчдын талаарх иргэдийн бодлыг тусгасан байгаа. Бичил уурхай нь хүн амын ядуурлаас үүдэлтэй ч бусад өөр олон хүчин зүйлсээс хамаардаг. Уурхайчдыг ерөнхийдөө байнгын уурхайчид болон орлогын эх үүсвэрээ төрөлжүүлж буй орон нутгийн иргэд гэж хоёр хувааж болно. Сүмбэр суманд хийсэн 2010 оны судалгаагаар нийт сумын оршин суугчдын 80% нь бичил уурхай эрхэлдэг гэж гарсан бөгөөд зун малчид эзгүй байх хооронд бичил уурхай эрхлэгчдын ухаж байгаад битүүлээгүй орхисон нүхэнд мал унаж үхсэн тохиолдолууд бүртгэгдсэн байна. Гэсэн хэдий ч, бичил уурхайчид өөрсдөө бичил уурхайчин болон орон нутгийн иргэдийн хооронд аливаа ноцтой зөрчилдөөн гарч байгаагүй гэж

<sup>217</sup> Сентеррагийн хэвлэлийн хуудас (2010).

(суурь судлагааны 6.6.3.4-н хэсэгт бичил уурхайн талаарх олон нийтийн бодлыг тусгасаныг харна уу) үзсэн байна.

Бороогийн уурхайн талбай дээр байнга тохиолддог байснаас харахад Гацууртын төслийн үйл ажиллагааны бүхий үе шатанд бичил уурхай эрхлэгчид идэвхтэй үйл ажиллагаа явуулна. Орон нутгийн иргэдийн эрүүл мэндэд үүсэх нөлөөллийг Бүлэг 7.1.6-д тодорхойлсон хэдий ч газрын эвдрэлтэй холбоотой нөлөөлөл нь уурхайн хаалтын үе шатанд тодорхой хөндөгдөнө. Сентерра нь Гацууртын уурхайн талбайг бичил уурхайчдын эвдэхээс (1990-д он) өмнөх гадаргуутай дүйцэхүйц, аюулгүй, найдвартай, тогтвортой байдалд буцаан ортол нөхөн сэргээнэ гэсэн үүрэг хүлээсэн байгаа. Бичил уурхайн үйл ажиллагааны болзошгүй нөлөөлөл нь шууд, дунд зэргийн их, сөрөг, удаан хугацааны, бага хэмжээний байх болно. Гацууртын төсөлд зориулж хийсэн суурь судалгааг хийж гүйцэтгэсний дараа үүссэн бичил уурхайн асуудлуудыг цаашид шинжлэхийг хүсвэл Хавсралт В-г харна уу.

#### *Уурхайн хаалтын үе шат*

Төслийн бүсэд буурч буй хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн үр ашгийг тогтвортой үйл ажиллагаагаар дамжуулан дүйцүүлэн нэмэгдүүлэх боломжийг эрэлхийлэх замаар Гацууртын уурхайн хаалтын дараах үе шатны газрын ашиглалтыг Засгийн газрын агентлагууд, ТББ-ууд, орон нутгийн иргэдийн оролцоотой шийдвэрлэнэ.

Уурхайн хаалтын үе шатанд төслийн дэд бүтцийг татан буулгаж, газрын эвдрэлийг нь нөхөн сэргээх болно. Газрын эвдрэлийг одоогийн байгаа үл мөрийн хэмжээнд хязгаарлаж барих учир бусад газруудад хаалтын нөлөөлөл үүсэхгүй гэж үзэж байгаа. Нөхөн сэргээлтийг уурхайн үйл ажиллагаа дууссаны дараа гурван жилийн хугацаанд хийхээр төлөвлөж байна. Хаалтын дараах хяналт шинжилгээг таван жилийн хугацаанд хийхээр төлөвлөж байна. Газрыг бичил уурхайн үйл ажиллагаагаас үүссэн эвдрэлээс өмнөх байдалд хүргэхүйц аюулгүй, найдвартай, тогтвортой байдлаар нөхөн сэргээх тул хаалтын үйл ажиллагаанаас газарт үзүүлэх нөлөөлөл эерэг байна гэж үзэж байна. Нөлөөлөл нь цар хүрээний хувьд бага (жишээ нь төслийн үйл ажиллагаанаас улмаас эвдэрсэн газар), уурхайн талбайг буцаагаад орон нутгийн засаг захиргаанд хүлээлгэн өгөх тул хугацааны хувьд урт байх ба тухайн хаалтын дараах нөхөн сэргээлтийн нөлөө илэрхий байх тул нөлөөлөл нь дунд зэргийн их, эерэг байна гэж харж байна.

#### 7.1.3.2 Нөлөөллийг бууруулах ба сайжруулах арга хэмжээ

Газар ашиглалт, амьжиргаа сайжруулах, нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийн зарчмууд нь барилга болон ашиглалтын үе шатанд газарт суурилсан амьжиргааг аль болох бага сүйтгэх, хаалтын үе шатанд эвдэрсэн газрыг эргэн хэвийн байдалд оруулах (жишээ нь малын бэлчээрийн газар, ой модны нөөцийг дахин зохих хэмжээнд сэргээх), төслийн бүхий л үе шатанд газрыг тогтвортой амьжиргааны зориулалтаар үр ашигтай ашиглах олон төрлийн арга хэмжээнүүдэд холбогдох оролцогч талуудыг татан оролцуулах зэрэг болно.

#### *Бэлчээрийн нөлөөллийг бууруулах*

Нийтийн хэрэглээний замаас гарах тоосжилтын бэлчээрийн газарт үзүүлэх нөлөөллийг бууруулах:

Төслийн бүхий л үе шатанд зам дээр тоос дарагчийг ашигласнаар тоосжилтоос гарах нөлөөллийг бууруулах боломжтой. Энэ нь тухайн төслийн, Төсөлтэй холбоотой болон олон нийтийн хэрэглээний замын хөдөлгөөнд аль алинд нь хамааралтай. Магнийн хлоридыг тоос дарагч болгон

ашиглахдаа холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авч, агаарт ялгаруулах хийн хаягдлын менежментийн төлөвлөгөөг дагаж мөрдөнө. Нэмэлт арга хэмжээнүүдэд дараах багтан:

- Замыг байнга хусаж, тэгшлэх.
- Тээврийн хэрэгсэлээс тоосжилт үүсэж, хүдэр унахаас сэргийлэн ачааг хучих.
- Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөөний дагуу тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөний даац, цаг хугацааг ярилцан тохирох.
- Сумын хөгжлийн сангаас санхүүжүүлж буй үйл ажиллагаанд бэлчээр/газар тариаланг сайжруулах арга хэмжээнүүдийг багтаах:
  - Амьжиргаа сайжруулахад чиглэсэн мал аж ахуй/газар тариалангийн менежмент болон мал эрүүл мэнд/ургацын чанарыг сайжруулахад нь малчид/тариаланчдад дэмжлэг үзүүлэх;
  - Малчид/тариаланчдын нэмэлт орлого бий болгон, төрөлжүүлэхэд чиглэдсэн хамтын ажиллагааг урамшуулан дэмжих; болон
  - Бэлчээр, мал аж ахуйн салбар, нүүдэлчний соёлыг хадгалан хамгаалах.

Хүдэр тээвэрлэх түр журамд "хатуу хучилттай авто зам"-ын тээвэртэй холбоотойгоор замын тоосжилтыг бууруулах нь үр дүнтэй хэдий ч замын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлдөг гэж тайлбарласан байна. Энэ талаар Хэсэг: 7.1.6 Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд-д оруулсан байгаа. Энэхүү ННУ нь төслийн барилга, ашиглалт болон хаалтын үе шатуудын турш зам нь сайжруулсан шороон зам хэвээрээ байсаар байна гэж таамаглал дээр боловсруулагдсан байна.

ХХБ-ийн далан өндөрсгөх үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтын нөлөөллийг бууруулахдаа Бороогийн төслийн ашиглалтын үе шатанд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх ба үүнд барилгын ажлыг цаг агаарын нөхцөл байдалд тохируулан зохицуулж хуваарилах (жишээ, салхи, чийгшил бага үед); тухайн нөхцөлд шаардлагатай тоос дарагчийг ашиглах, барилгын материалын тээвэрлэлтийн хэмжээг багасгах, оролцогч талуудад мэдээлэл өгөх, гомдол барагдуулах механизмыг хэрэгжүүлэх зэрэг багтана.

Олон нийтийн аюулгүй байдлын хэсэгт дуу чимээ, чичиргээний нөлөөллийг бууруулах асуудлыг оруулсан байгаа.

#### *Ойн нөөцийн үр ашгийг нэмэгдүүлэх*

Ой мод ашиглалт илүү ил тод болж, олон нийтийн хянах боломж бүрдэж үр ашгаа өгнө:

- Гацууртын уурхайн бүсийг Сентеррагийн харуул хамгаалалтын алба байнга эргэн, хянаж, хууль бусаар мод бэлтгэгчид тааралдвал үйл ажиллагааг таслан зогсооно.

#### *Газрын гадаргуу, газрын эвдрэлийн нөлөөллийг бууруулах*

Газрын гадаргууд үзүүлэх нөлөөллийг бууруулахдаа Төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай ургамалын бүрхэвчийг хөндөх газрыг хязгаарлах, эдгээр газрыг Гацууртын уурхайн талбайн зүүн эцэст байрлах нарийн хөндийгөөс аль болох сонгох хэрэгтэй. Талбай нь нийтийн эдэлбэрийн газар биш учир олон нийтийн эсэргүүцэлтэй тулгарах нь бага байна. Төслийн явцад Түнхэл багаас Гацууртын уурхайн харуул хамгаалалтын пост хүртэлх замын хөдөлгөөнийг багасгаснаар олон



нийтийн аюулгүй байдалд ашигтайгаас гадна уурхайн хаалтын үе шатын дараа нөхөн сэргээлт дуусах хүртэл газрын гадаргууг хамгаалахад тустай.

Элс, хайрганы карьеруудаас үүдэх газрын эвдрэлийг одоо ашиглаж байгаа карьерыг ашигласнаар бууруулах тул газрын шинэ эвдрэлээс зайлсхийх боломжтой. Элс, хайргыг олборлож дууссаны дараа карьерыг нөхөн сэргээнэ. Бороогийн төсөл дээр амжилттай хэрэгжиж байгаа газар хөндөх, бэлчээрийн газрыг нөхөн сэргээх үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.

Ургамалын бүрхэвчийг хөндөх үйл явцыг дүйцүүлэн хамгаалах замаар өндөр ач холбогдолтой ой бүхий газрыг хамгаалах зорилготой мод тарих үйл ажиллагаа нь улирлын чанартай ажлын байр бий болгож орон нутгийн иргэдийг орлоготой болгох нэмэлт эерэг үр ашигтай. Энэхүү үр ашгийг улам нэмэгдүүлэх үүднээс газар хөндөх үйл ажиллагааны шууд нөлөөнд өртсөн орон нутгаас хүмүүс авч ажиллуулдаг, жишээбэл Түнхэл багийн иргэдээр Түнхэлийн модыг дахин суулгах ажлыг хийлгүүлэх.

#### *Бичил уурхайгаас үүсэх нөлөөллийг бууруулах*

Хаалтын үе шатны дараах бичил уурхайгаас үүсэж болзошгүй нөлөөллийг бууруулах:

- Нийгмийн хаалтын үйл ажиллагаа бүхий Уурхайн хаалтын төлөвлөгөөг Нийгмийн хаалтын ажлын хэсэг бүх холбогдох оролцогч талуудтай (бичил уурхайчдыг оролцуулан) хэлэлцэж, төслийн ашиглалтын үе шатнаас эхлэн хаалтын үе шат хүртэлх хэрэгжилтийг нарийвчилан төлөвлөж, боловсруулна.
- Газрын гадаргууг бичил уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнөх байдалд оруулах зорилгоой бичил уурхайн хаалтын үе шатны төлөвлөгөөг боловсруулахад бусад уурхайчид болон оролцогч талуудыг татан оролцуулах үйл ажиллагааг дэмжинэ.

#### *Уурхайн хаалтын нөлөөллийг бууруулах арга хэмжээ:*

Уурхайн хаалтын нөлөөллийг бууруулах арга хэмжээ нь дараах болно:

- Төслийн талбайн Хөдөлмөр эрхлэлтийн үр ашиг хэсэгт тусгагдсан дахин ургамалжуулалт, мод үржүүлгийн үйл ажиллагааг орон нутгийн иргэдээр хийлгэх.
- Эдийн засаг хэсэгт тусгагдсан Уурхайн хаалтын үе шатанд үүсэх эдийн засгийн эерэг үр ашгийг сайжруулах.

#### **7.1.3.3** Хураангуй

Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шинж чанар	Бууруулаагүй боломжит ач холбогдол	Үлдэгдэл боломжит ач холбогдол
<b>Газар ашиглалт болон амьжиргаа (ЕСБХБ ГШ 1 ба 3)</b>			
Төсөл нийтийн хэрэглээний замыг ашиглаж эхэлсэний улмаас үүсэх тоосжилтын газар болон амьжиргаанд үзүүлэх нөлөөлөл ихсэх	Тодорхой Шууд, дунд зэргийн их, сөрөг Урт хугацааны Бага хэмжээний	Дунд	Бага

Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шинж чанар	Бууруулаагүй боломжит ач холбогдол	Үлдэгдэл боломжит ач холбогдол
Ой модны ашиглалт ил болсоны улмаас ой модыг хууль бусаар огтлох явдал буурах боломж	Тодорхой Шууд эерэг Урт хугацааны Бага хэмжээний	-	-
Төслөөс үйл ажиллагаанаас үүдэлтэй газрын эвдрэл, бодит нөлөөлөл нэмэгдэх	Тодорхой Шууд, дунд зэргийн их, сөрөг Урт хугацааны Бага хэмжээний	Бага	Их бага
Гацууртын уурхайн хаалтын дараа бичил уурхайчдын үйл ажиллагаагаа дахин үргэлжлэх боломж нэмэгдэх	Боломжит Шууд, дунд зэргийн их, сөрөг Урт хугацааны Бага хэмжээний	Бага	Их бага

## 7.1.4 Нийгмийн дэд бүтэц

### 7.1.4.1 Нөлөөлөл

Гацууртын төсөл нь ихэнх ажиллагсадаа төслийн бүсээс авч ажиллуулах ч одоогоор төслийн бүсээс ажиллах хүчнийхээ хэдэн хувийг авах талаар шийдээгүй байгаа учир нийгмийн дэд бүтцийн эрэлт хэрэгцээнд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох боломжгүй байна. Одоогийн байдлаар, төслийн ажиллах хүчээ бүсийн гол хэсэг болох Баянгол, Мандал сумдууд, Түнхэл багаас бүрдүүлэх ба ээлжээр ажиллах ажилчдаа Дархан, Улаанбаатар зэрэг бусад томоохон суурин газраас бас бүрдүүлнэ гэж таамаглаж байна.

Төслийн ажиллах хүчнийг нэн тэргүүнд тухайн орон нутгаас бүрдүүлснээр ихэнхи ажиллагсад, гэрээт гүйцэтгэгчид төслийн бүс нутгийн оршин суугч байх учир тухайн бүсэд нүүж ирэх шинэ ажиллагсдын тоо бага байна гэж таамаглаж байгаа. Төсөл нь Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудад оршин суух ажиллагсад Төсөлд ажиллах зорилгоор нүүж ирэх шаардлагагүй байршилтай бөгөөд ээлжийн ажиллагсдыг төслийн талбайгаас, талбай руу төслийн тээврийн хэрэгслээр зөөх боломжтой. Цөөн тооны ажиллагсад, тэдний гэр бүлийн гишүүд төслийн бүсэд нүүж ирэх магадлалтай ч Хүн амзүй хэсэгт дурдсанаар төслийн ашиглалтын үе шатанд орон нутгийн иргэд зээл авах боломжтой болж орон нутгаас нүүж, шилжилт хөдөлгөөн нэмэгдэх боломжтой. Шууд болон шууд бус хөдөлмөр эрхлэлтээс нийгмийн дэд бүтцэд үзүүлэх цэвэр нөлөөлөл (сургуульд элсэн орох хүүхдийн тоо, эрүүл мэндийн үйлчилгээний эрэлт хэрэгцээ гэх зэрэг) ерөнхийдөө үл мэдэг байх болно.

### *Эдийн засгийн боломж хайсан орон нутаг руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн*

Төслөөс үүдэлтэй хүн амын шилжилт хөдөлгөөн ерөнхийдөө бага байна гэж тооцоолж байгаа (Хүн амзүй, эдийн засаг, эрүүл мэнд гэсэн хэсгээс харна уу) учир төслийн бүс руу чиглэсэн эдийн

засгийн боломж хайсан шилжилт хөдөлгөөний нөлөөлөл бага байх болно. Энэ нь орон нутагт богино хугацаанд оршин сууж буй хүмүүсийг ажилд авах, бараа бүтээгдэхүүн ханган нийлүүлэх боломжийг нь хязгаарлах, төслийн бүсээс гадна орших суух хүмүүст эдийн засгийн ямар боломжууд байгаа талаар зохистой мэдээлэл өгөх тал дээр орон нутгийн сум, багийн захиргаатай хамтран ажиллах зэрэг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдээс хамааралтай.

Төслөөс үүдэлтэй хүн амын шилжилт хөдөлгөөн бага хэдий ч менежмент болон нөлөөллийг бууруулах арга хэмжээг засгийн газрын холбогдох агентлагуудтай хамтран хэрэгжүүлэх шаардлагатай. Орон нутаг руу чиглэсэн шилжилт хөдөлгөөний асуудлууд нь боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний чадавхид нөлөөлөх бөгөөд төслийн бүсийн өөр өөр газар өөр өөр нөлөөлөлтэй байна. Эдгээр нөлөөллийн талаар дараагийн бүлэгт төслөөс эрүүл мэнд, боловсролд үзүүлэх шууд нөлөөллүүдийн хамт тайлбарласан байна.

### *Боловсрол*

Сентерра нь барилгын үе шатанд ажилчдад зориулан ажлын байранд бэлдэх сургалтуудыг зохион байгуулах ба ашиглалтын үе шатанд ажиллах ажиллагсдын ур чадварын шаардлагыг хангах бэлтгэл ажил хийнэ. Суурь судалгаа, Бороогийн уурхайн туршлагаас харахад орон нутгаас төслийн шууд болон шууд бус ажлын байранд мэргэжилгүй, мэргэжлийн өндөр ур чадвар эзэмшээгүй хүмүүсийг авах боломжтой байна. Төслийн бүсийн хүн ам нь өндөр боловсролтой (дээд болон техник мэргэжлийн боловсрол эзэмшсэн нь 50 %-иас дээш байна) байна. Дунд ангиас ахлах анги руу шилжин суралцах сурагчдын тоо буурч байгаа ч эмэгтэй сурагчдын ахлах анги руу шилжин суралцах хувь өндөр байгаа явдал нь цаашдаа боловсролтой болж, хөдөлмөр эрхлэх боломжид хүйсийн ялгаа үүсэхэд нөлөөлж байна. Суурь судалгааны тайланд жилд нийт төгсөгчдийн 40 хувь нь их сургуульд, үлдсэн хувь нь сумын МСҮТ-д орж элсэн орж суралцдаг гэж дурьдсан байна. Энэ нь уул уурхайн салбарын эмэгтэйчүүд ажиллаад байдаггүй мэргэжлээс гадна барилга, ашиглалтын үе шатанд ажиллах эмэгтэйчүүдийг дэмжих боломжийг Төсөлд олгож байгаа юм. Үүний зэрэгцээ, Төсөл нь Мандал сумын МСҮТ-д хүнд тоног төхөөрөмжийн механикчийн мэргэжлээр суралцаж буй 44 оюутныг ажилд авах боломж бүрдэхээс гадна МСҮТ-тэй хамтран нэмэлт ажлын байрны боломжуудыг эрэлхийлнэ.

Боловсрол огт эзэмшээгүй иргэдийн тоо Түнхэл багт (11 %) хамгийн өндөр байгаа нь судалгаанд оролцсон эдгээр өрхийн ихэнх нь Түнхэл багийн төвөөс алслагдсан газар амьдардагтай холбоотой. Энэ нь Түнхэл багт төслийн хөдөлмөр эрхлэлтийн боломжийн хамгийн ихээр бүрдүүлэх шаардлагатай гэсэн үг юм, жишээлбэл, Бороогийн төслийн түр хугацаагаар ажиллах мод тарих гэрээт ажлыг Түнхэл багийн эрэгтэйчүүдээр хийлгэж болох юм.

Сентерра болон түүний гэрээт гүйцэтгэгч нар төслийн үйл ажиллагааг хугацаанд нь гүйцэтгэхийн тулд техникийн ур чадвар шаардагдах зарим ажлын байран дээр мэргэжлийн сургалтуудыг цаг тухайд нь зохион байгуулах хэрэгтэй. Төсөл нь удирдах ур чадвар шаардагдсан ажлын байранд Бороогийн уурхайн одоо ажиллаж байгаа болон өмнө нь ажиллаж байсан компанийн стандартыг мэддэг ажиллагсдыг ашиглахаар төлөвлөсөн юм. Онцгой ур чадвар, мэдлэг шаардагдсан уурхайн барилгын үе шатны ажилд (жишээбэл, BIOX®-ийн байгууламжийг барих, ашиглалтанд оруулах, сургалт зохион байгуулах гэх мэт) гадаад мэргэжилтэн нэмэлтээр авч ажиллуулах шаардлага гарна. Илүү ур чадвар шаардсан ажлын байран дээр орон нутгаас ажиллагсад олдохгүй тохиолдолд бусад аймаг, улс даяар, зарим тохиолдолд хилийн чанадаас шаардлагатай

ажиллагсад авах учир төслийн бүх үе шатанд төслийн бүс дэх хөдөлмөр эрхлэлтийн үр ашиг хязгаарлагдана.

Боловсрол болон уул уурхайн салбарын сургалтанд оруулах хөрөнгө оруулалтыг төслийн бүс болон аймгийн хүрээнд хүний нөөцийн боломжийг сайжруулах эерэг нөлөөлөл гэж үзэж байна. Сентерра нь Бороо Гоулд төсөл дээр амжилттайгаар хэрэгжүүлсэн сургалтын төлөвлөгөөний дагуу орон нутгийн ажиллах хүчинд зориулсан сургалт явуулах бүрэн боломж байгааг харуулж байна. газарзүйн цар хүрээний хувьд мэргэжлийн үр чадварт оруулсан хөрөнгө оруулалтын нөлөөлөл нь үндэсний, аймгийн, сумын түвшинд байх хэдий ч ажиллагсдыг орон нутгаас давуу эрхтэйгээх авах бодлогыг хэрэгжүүлнэ. Компани нь сургалтын төлөвлөгөөг, ялангуяа Түнхэл багтд амжилттай хэрэгжүүлж чадвал нөлөөллийн ач холбогдол нь их эерэг байна. Хүмүүсийн мэргэжлийн үр чадварт хийсэн хөрөнгө оруулалтын үр нөлөө нь төслийн үйл ажиллагаа дууссаны дараа ч байсаар байх учир цаг хугацааны хувьд урт хугацааных байна.

Төслөөс боловсролд үзүүлэх нөлөөлөл нь бага хэдий ч төслийн бүсийн нутгуудад өөр өөрөөр нөлөөлнө. Цэцэрлэгүүд ачаалалтай байгаа учир гэр бүлтэйгээ шилжин нүүж ирж байгаа хүмүүсийн цэцэрлэгийн насны хүүхдийн 13% нь цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байна. Гэр цэцэрлэг байгаа хэдий ч энэ нь зөвхөн зуны цагаар малчид болон алслагдсан өрхүүдийн хүүхдүүдэд зориулагдсан учир шилжиж ирсэн хүмүүст хүртээмжгүй байдаг. Сумын төвүүдэд (Баруунхараа болон Зүүнхараа) бүх шатны сургууль байгаа хэдий ч анги дүүргэлт нь Мандал, Баянгол сумдад болон аймагт хэтэрсэн байна. Түнхэл багт сургуулийн дотуур байр байхгүй тул хөдөөний болон алслагдмал өрхүүдийн хүүхдээ сургуульд хамруулах боломж хязгаарлагдмал байна. Төсөл хэрэгжих нийт хугацаанд (Төсөл дууссаны дараа ч мөн адил) төслөөс үүдэлтэй шилжилт хөдөлгөөн нь төслийн бүсийн ачаалалтай байгаа боловсролын үйлчилгээнд дунд зэргийн бага, сөрөг нөлөөлөл үүсгэж болох юм.

#### 7.1.4.2 Нөлөөллийг бууруулах ба сайжруулах арга хэмжээ

##### *Боловсрол*

Боловсролд үзүүлэх нөлөөллийг бууруулах, сайжруулах арга хэмжээнүүд:

- Хүний нөөцийн нарийвчилсан шаардлагууд, Төсөл хэрэгжих цаг хугацаа бүхий Гацууртын төслийн шаардлагуудыг тусгах зорилгоор сургалтын төлөвлөгөөг шинэчлэх.
- Мэргэжлийн боловсролын байгууллагуудтай (Мандал, Дархан, Эрдэнэт) барилга болон уурхайг мэргэжлийн үр чадвартай ажилчдаар хангах эх үүсвэрийг бий болгох, барилгын болон ашиглалтын үе шатны мэргэжлийн өндөр үр чадвартай ажилчдад зориулан ажлын байранд бэлтгэх сургалтуудыг явуулах зэргээр хамтран ажиллахдаа төслийн барилга, ашиглалт болон хаалтын үе шатуудад шаардлагатай ажиллагсдыг төслийн бүс нутгаас давуу эрхтэйгээр авна.
- Төслийн барилга, ашиглалт, хаалтын үе шатуудын хэрэгцээнд нийцэх чиглэлийн мэргэжлээр төслийн бүс нутгийн, ялангуяа Түнхэл багийн суралцах сонирхолтой, өндөр чадавхитай оюутнуудад зориулсан тэтгэлэгт хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх.
- Бороогийн уурхайн ажилтан ажилд авах бодлого нь Монгол Улсын Хөдөлмөрийн болон бусад хууль тогтоомж, салбарын сайн туршлагыг дагаж мөрдөж байгаа эсэхийг баталгаажуулах.

- Төсөлд шаардлагатай ажиллах хүчнийг орон нутгаас давуу эрхтэйгээр авах боломжийг сайжруулах арга хэмжээг төлөвлөхийн тулд төслийн бүсийн үр чадварын орхигдолын үнэлгээ хийж төслийн сургалтын төлөвлөгөө, үр чадварын хэрэгцээний зураглалыг гаргах. Үүнд, төслийн бүсийн иргэдийн (эмэгтэйчүүдийг багтаасан) хөдөлмөр эрхлэлтэлтэнд чиглэсэн хяналтын механмзм орно.

Төслийн ашиглалтын үе шатны үйлдвэрлэлийн дадлагыг дэмжих тал дээр их дээд сургуулиуд, МСҮТ-ууд болон сургуулиудтай хамтран ажиллах.

- Сургалтын төлөвлөгөөг тогтмол хэрэгжүүлж, эргэн хянаснаар төслийн барилгын үе шатанд хэрэгжүүлж эхэлсэн орон нутгийн хөдөлмөр эрхлэлтэнд давуу эрх өгөх бодлого, зорилготой төслийн хэрэгцээ нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах.
- Ажиллах хүчний сургалтын үр ашгийн хянах (дотоодын болон гуравдагч талаас) шинжилж, шаардлагатай тохиолдолд засаж сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх.

#### 7.1.4.3 [Хураангуй](#)

Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шинж чанар	Бууруулаагүй боломжит ач холбогдол	Үлдэгдэл боломжит ач холбогдол
<b>Боловсрол</b>			
Орон нутаг руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнөөс үүдэн боловсролын үйлчилгээний ачаалал нэмэгдэх	Магадлалтай Шууд бус, дунд зэргийн бага, сөрөг Урт хугацааны Дунд хэмжээний	Дунд	Бага

### 7.1.5 **Эрүүл мэнд**

#### 7.1.5.1 [Нөлөөлөл](#)

Төсөл хэрэгжих нийт хугацаанд эрүүл мэндтэй холбоотой нөлөөллийн асуудлууд:

- Төслийн ажиллагсад болон орон нутгийн иргэдийг эрүүл мэндийн үйлчилгээгээр хангах;
- Ажиллагсдын эрүүл мэнд болон аюулгүй байдал, ялангуяа шинэ уурхайн талбай дээр ажиллахтай холбоотойгоор гарах эрсдэл; ба
- Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд ба үүнд: халдварт өвчин, замын хөдөлгөөний осол, эндэгдэл, аюулгүй байдал болон нийгмийн уялдаа холбоо.

#### [Эрүүл мэндийн үйлчилгээ](#)

Ажлын байран дээр осол гарах, эрүүл мэндийн онцгой байдал үүсэхэд Сентеррагийн шууд болон шууд бус ажиллагсад бүгд уурхайн эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах ба уурхайн талбай дээр эрүүл мэндийн зохих үйлчилгээ үзүүлэх боломжгүй тохиолдолд Улаанбаатарт болон өөр газар үйлчлүүлж болно. Үүнд, Улаанбаатар хотод Сентеррагийн хөрөнгө оруулалтаар барьсан эмнэлэг орно. Ихэнхи ажиллагсад орон нутгийн оршин суугчид тул төслийн бүсэд ажиллах хүчинд

шаардлагатай эрүүл мэндийн нэмэлт үйлчилгээний хэрэгцээ гарах магадлал бага байна. Сентеррагийн ажиллагсад эрүүл мэндийн үйлчилгээг авдаг ба үүнд сүрьеэ, татран зэрэг халдварт өвчний эсрэг вакцин хийх, уурхайн кэмп дээр ажиллагсдыг цэвэр, эрүүл хоол хүнсээр хангадаг, эрүүл хооллолт, зөв, эрүүл ахуйн дадалын талаар боловсрол олгодог. Бороогийн төсөл дээр Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны баг, уурхайн кэмпиин болон катеринг үйлчилгээ үзүүлэгч гэрээт гүйцэтгэгч нар хамтран эрүүл мэндийн үйлчилгээ болон чадавхижуулах арга хэмжээнүүдийг амжилттай хэрэгжүүлсэн ба эдгээрийг Гацууртын төсөл дээр мөн адил хэрэгжүүлнэ.

Ажиллагсдын ажлын байртай холбоотой эрүүл мэндийн үйлчилгээ нь төслийн бүсийн олон нийтэд чиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээнд цэвэр нөлөөлөлгүй, учир нь ажиллагсад өөрсдийн ажлын байрнаас гадуурх эрүүл мэндийн үйлчилгээг орон нутгийн эрүүл мэндийн байгууллагаас авна. Дээд мэргэжилтэй, тусгай мэргэжилтэй ажилчдад зориулсан эрүүл мэндийн үйлчилгээ болон эрүүл мэндийн сайн туршлагыг бэхжүүлэх ажил нь Төсөл хэрэгжих хугацааны дараа ч үргэлжлэх ба төслийн ажиллагсдын гэр бүлд хоёрдогч эерэг нөлөөлөл үзүүлэх боломжтой юм.

Төслөөс үүдэлтэй эрүүл мэндийн нөлөөлөл бага ч хэдий ч төслийн бүсийн өөр өөр газарт өөр өөр байдлаар нөлөөлөх болно. Эрүүл мэндийн үйлчилгээ нь орон нутаг руу чиглэсэн бүх насны шилжин ирэгсдэд хэрэгтэй ба энэхүү орон нутаг руу чиглэсэн эдийн засгийн боломж хайсан гэр бүлтэй шилжилт ирэгсэд эрүүл мэндийн үйлчилгээний ачааллыг нэмэх болно. Эрүүл мэндийн боловсон хүчний хомсдол нь төслийн бүсийн чухал асуудал ба орон нутгийн эрүүл мэндийн үйлчилгээ нь асуудалтай байгаа учир суурь судалгаанд хамрагдсан хүмүүс чанар муутай эрүүл мэндийн үйлчилгээ авдаг гэж дурьдсан байна. Эрүүл мэндийн ихэнхи үйлчилгээг Сүхбаатар эсвэл Зүүнхараагаас авдаг байна. Сэлэнгэ аймгийн эмч нарын тоо бага зэрэг нэмэгдсэн ч одоогийн эрэлт хэрэгцээ, шаардлагыг хангах түвшинд хүрээгүй байна. Мандал суманд эмч нар хангалтгүй, харин сувилагчийн тоо хангалттай сайн байгаа бол Баянгол суманд аль аль улсын дундаж үзүүлэлтээс доогуур байна. Түнхэл багийн суурь судалгаанд хамрагдсан хүмүүс эмнэлэгт хүрэхэд хол, тээврийн хэрэгсэлийн олдоц муу, үнэтэйн улмаас эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаж чаддаггүй учир төслийн бүсийн орон нутгийн иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээнд хамгийн муу хамрагддаг гэж үзэж байгаагаа дурьдсан. Төсөл хэрэгжих нийт хугацаанд (Төсөл хэрэгжих хугацааны дараа ч) төслөөс үүдэлтэй орон нутаг руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн нь эрүүл мэндийн үйлчилгээний хүчин чадалд дунд хэмжээний бага, сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

### *Ажиллагсдын эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа*

Уурхай үйл ажиллагааны явцад тохиолддог ихэнх осол нь шинэ ажилчин, шинэ процесс болон шинэ удирдлагатай холбоотойгоор болдог. Баруун Австралийн Уул уурхай, Газрын тосны яам нь "Баруун Австралийн уул уурхайн салбарын ослын шалгаанаар нас барсан байдал, 2000-2012"<sup>218</sup> гэсэн судалгаа хийсэн байна. Нас баралтын шалтгааны үндсэн нөхцөлүүд нь:

- Нас барсан ажилчны тухайн ажлын байран дээр ажилласан хугацаа: нас барагсдын бараг гуравны нэг нь тухайн ажлыг нэг жил хийж байсан, нас барагсдын 48 % нь хоёр дахь жилдээ буюу түүнээс бага хугацаанд ажилласан байна.

<sup>218</sup>

Баруун Австралийн Уул уурхай болон Газрын тосны яам, 2000-2012: бид ямар зүйлд суралцах вэ? – тайлан.



- Уурхайн талбайд ажилласан хугацаа: нэгээс бага жил үйл ажиллагаа явуулж байгаа уурхай талбай дээр нийт ажилласан хугацаа, салбарын туршлагаас үл хамааран нас баралт 49 %-тай байна.
- Удирдах албан тушаал дээр ажилласан хугацаа: нас барагсдын 68% нь удирдах албан тушаал дээр эхний 3 жил ажиллаж байсан байна.
- Журам, дүрэм дагаж мөрдөх байдал: ихэнх осол нь хохирлыг урьдчилан сэргийлж, хянах боломжтой аюултай нөхцөл байдалтай давтагдах үйл ажиллагаа (нас барагсдын 73% нь) байдаг байна. Гэтэл, журам байхгүйгээс, эсвэл журам дүрмийг дагаж мөрдөөгүйн улмаас нас барагсад 89%-тай байна.

Шинэ уурхай дээр ажиллахтай холбоотойгоор ажиллагсдын эрүүл мэнд, аюулгүй байдал эрсдэлд өртөж (эмнэлэгийн тусламж үзүүлсэн гэмтэл – хөдөлмөрийн чадвар алдсан гэмтэл – нас баралт) болзошгүй тул эдгээр олон улсын туршлагаас Гацууртын төсөлд авч хэрэгжүүлэх нь зүйтэй. Гацууртын төсөл нь Бороогийн төсөлтэй харьцуулахад шинэ оператор, шинэ уурхай, шинэ тоног төхөөрөмж, шинэ технологи (BIOX® байгууламж) болон шинэ аюултай материал (хөвүүлэн баяжуулах технологийн тэсрэмтгий ксантогенат) зэрэг ажиллагсдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг онцгойлон анхаарсан нэмэлт хэмжигдэхүүнүүдтэй байна.

Бороогийн уурхай дээр олон жилийн туршид (сүүлийн 2 жилд 2 хөдөлмөрийн чадвар алдсан тохиолдол гарсан байна) хоёр осол нь саяхан гарсан ба ихэнх томоохон осолууд нь гэрээт гүйцэтгэгчидтэй холбоотой байсан. Ажигласнаар, хатуу хяналт доор гэрээт гүйцэтгэгч гэрээний нөхцлүүдээ сайн биелүүлдэг байна. Өмнө нь гэрээгээ зөрчсөн нөхцөлд торгууль ноогдуулж байсан.

Монгол Улсад мэргэжлийн хяналтын байгууллага нь хяналт, шалгалтыг бага хийдэг, ялангуяа аюулгүй ажиллагаатай холбоотой хяналт шалгалт ховор хийгддэг, ажлын байрны эрүүл ахуйг хааяа шалгадаг учир Төсөл нь өөрийн ажиллагсдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг хангаж ажиллах тал дээр санаачлага гарган, хариуцлагатай ажиллах шаардлагатай байна.

Болзошгүй нөлөөллүүд гарах магадлалтай хэдий ч барилга болон ашиглалтын үе шатны эхний 12 сарын туршид бүсийн түвшинд өндөр ба шууд, их сөрөг нөлөөлөл үүсэж болно.

### **Урьдчилан тооцоологдоогүй онцгой нөхцөл байдал**

Урьдчилан тооцоологдоогүй онцгой нөхцөл байдал нь нөлөөллийн бууруулаагүй ач холбогдолтой үед эрүүл мэндэд нөлөөлөл үүсгэж болзошгүй юм. Эдгээр нь дараахаас үүсэх байгаль орчин, нийгэм ба/буюу аюулгүй ажиллагааны нөлөөллүүд:

- Их хэмжээний гал түймэр/дэлбэрэлт/ үйлдвэрлэлийн болон барилгын бусад томоохон осол (нас баралт багтсан);
- Уурхайн хананы нуралт;
- Уурхайн үер;
- Газар хөдлөлт;
- Ойн түймэр;

- Халдварт өвчний дэгдэлт;
- Эмнэлгийн яаралтай тусламж;
- Уурхайн талбай руу зөвшөөрөлгүй нэвтрэх;
- Цаг агаарын онцгой байдал/байгалийн гамшиг;
- Улс төрийн хямрал/хууль бусаар баривчлах/террорист халдлага;
- Уурхай дээр хүний эрүүл мэндэд нөлөөлөл үзүүлж болзошгүй үс болон эрчим хүчний удаан хугацааны алдагдал; ба
- Бусад төлөвлөгдөөгүй онцгой үйл явдал.

Бороогийн туршлагаас харахад тооцоологдоогүй онцгой байдлын нөхцөл байдал үүсэх магадлал багатай ч үүсэх нөлөөлөл нь шууд, их сөрөг, богиноос дунд хэмжээтэй, багаас дунд хугацааны байж болох юм.

#### *Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд*

Төсөл нь өөрийн үйл ажиллагааны шууд болон шууд бус үйлдлээр орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учруулж, сөрөг нөлөөлөл үүсгэх боломжтой. Суурь судалгаа болон оролцогч талуудтай хийсэн ярилцлагуудын үеэр цуглуулсан мэдээллээ нэгтгэх явцдаа төслийн үйл ажиллагаанаас эерэг болон сөрөг нөлөөллүүд гарч болзошгүй гэж тодорхойлсон..

Нийгмийн нөлөөллийн үнэлгээ нь уурхайн талбай руу зөвшөөрөлгүй нэвтрэх, орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хордлого, орчны эрүүл мэндийн болзошгүй эрсдэл зэрэг энэхүү үнэлгээний ажлын даалгаварт ороогүй зүйлсэд анхаарлаа хандуулсан.

#### **Уурхайн талбай руу зөвшөөрөлгүй нэвтрэх**

Уурхайн талбай нь олон нийтийн аюулгүй байдалд эрсдэл учруулж болох аюул ихтэй газар, ялангуяа олон нийтийн төлөөлөгч уурхай дээр зөвшөөрөлгүй, шаардлагатай зааварчилгаагүй, аюулгүй ажиллагааны мэдлэггүй, хамгаалах хэрэгсэлгүй нэвтрэн орох, тэсэлгээ зэрэг зарим үйл ажиллагааны улмаас ноцтой осолд орж, амь насаа алдаж магадгүй. Одоогийн байдлаар, энэ болзошгүй нөлөөлөл нь Гацууртын уурхайн байгууламж болон Бороогийн уурхайн баяжуулах үйлдвэрээс орон нутгийн иргэд, ажиллахгүй байгаа ажиллагсад, гэрээт гүйцэтгэгч нарын эрүүл мэнд, аюулгүй байдалд хамааралтайюу адилхан хамааралтай. Энэхүү болзошгүй нөлөөлөл нь урт хугацааны туршид (Төсөл хэрэгжих нийт хугацаанд) төслийн талбай дээр (бага хэмжээнд) хүний амь насанд аюул учруулах учир магадлалтай, их хэмжээний сөрөг байна.

#### **Халдварт өвчин**

Сентеррагийн ажиллах хүч нь явуулын ба Түнхэл багийн ойролцоо төслийн үйл ажиллагаа нэмэгдвэл төслөөс орон нутгийн иргэдийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл нь өсөх магадлалтай.

Тодорхой нэгэн хэсэг дэх (барилга буюу ашиглалтын үйл ажиллагааны кэмп) хүн ам огцом өсөлт нь төслийн бүс рүү чиглэсэн хүн амын болзошгүй шилжин хөдөлгөөнтэй (бага ч гэсэн) хамтаар халдварт өвчин тараах, дэгдээх эрсдэлийг нэмэгдүүлнэ. Уурхайн кемпэд хоригдож амьдрах нөхцөл, уурхайн талбайн ариун цэвэр муу нөхцөл нь халдварт өвчин, хоол хүнс, усаар дамжин халдварлах өвчний эрсдэлийг нэмэгдүүлнэ. Төслийн бүс нутагт бүртгэгдсэн халдварт өвчний

төрөл: 60% нь бэлгийн замын халдварт өвчин (БЗХӨ), 25% нь сүрьеэ (ТВ), 2% нь гепатит С. Халдварт өвчний тохиолдлын үлдсэн 13.5% нь бусад нийтлэг халдварт өвчний төрөл байна. Халдварт өвчний тохиодол, тархалт нь бүс нутгийн болон урт хугацаанд байж болох ба шууд бус, сөрөг нөлөөтэй.

Барилгын үе шатны үйл ажиллагаатай холбоотой хүн амын өсөлт нь ХДХВ/ДОХ, халдварт гепатит болон тэмбүү зэрэг БЗХӨ-ийг орон нутгийн иргэдийн дунд тараах эрсдэлийг нэмэгдүүлэх магадлалтай. Архийг хэтрүүлэн хэрэглэх, эрэгтэй ажиллах хүч давамгайлсан газарт бие үнэлэгчид цугларах зэрэг зан байдлын эрсдэлтэй холбоотой хүчин зүйлс нь өндөр эрсдэлтэй бэлгийн зан төлөвийн тохиолдлыг цаашид нэмэгдүүлэх ба бэлгэвч харьцангуй бага хэрэглэснээр энэ асуудлыг улам нэмэгдүүлнэ. Өндөр эрсдэлтэй эдгээр зан үйлтэй бүлгүүд нь гол төлөв өндөр эрсдэлтэй бүлэгт тооцогдоно. Иймд, аль хэдийн өндөр байгаа БЗХӨ-ний түвшин нь төслийн барилга болон ашиглалтын үе шатуудад цаашаа тархвал бүсийн хэмжээнд, урт хугацаанд шууд бус, сөрөг нөлөөлөлтэй байна.

### **Зам тээврийн осол**

Хүнд даацын тээврийн хэрэгсэл бүхий замын хөдөлгөөн нь төслийн шууд нөлөөллийг нэмэгдүүлнэ. Үүнд, уурхайн талбай руу барилгын материал тээвэрлэх тээврийн хэрэгсэл, төслийн бүс дотор болон хооронд ажиллагсдын болон бараа, хүнсний тээвэрлэлт, Бороогийн уурхай Гацууртын уурхай хоорондын нийтийн хэрэглээний замаар хүдэр тээвэрлэх хүнд даацын ачааны тэрэг зэрэг орно. Энэхүү хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нь орон нутгийн иргэдэд бага зэрэг гэмтэхээс эхлээд ноцтойгоор гэмтэх, цаашлаад амь насаа алдах эрсдэлийг нэмэгдүүлнэ. Үүний зэрэгцээ, орон нутгийн онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах чадавхи сул (гэнэтийн осолын үед хариу арга хэмжээ авах нөөц, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж хязгаарлагдмал байдаг ба үүнд Сентеррагийн Онцгой байдлын аврах баг болон тоног төхөөрөмж багтаагүй) байна. Иймд, ослын үед авах аливаа хариу арга хэмжээ нь удаан байх хандлагатай байгаа нь бага хэмжээний ослоос ч гарах үр дагавар хүнд болгох боломжтой юм.

Төслийн тээврийн хэрэгслийн замын хөдөлгөөнөөс үүдэлтэй осол буюу амь насаа алдах явдал нь орон нутгийн чанартай, урт хугацаанд шууд сөрөг нөлөөтэй (жишээбэл, Төсөл хэрэгжих нийт хугацаанд боловч хүнд даацын тээврийн хэрэгсэл их хэмжээгээр ашиглах төслийн ашиглалтын үе шатанд хамгийн өндөр эрсдэлтэй).

2015 онд хийсэн суурь судалгааны хүрээнд замын хөдөлгөөний судалгаа хийгдсэн. Төслийн бүс нутаг болох Баянгол сумын ослын гол шалтгаан нь замын эсрэг урсгалд орж жолоодох, хурд хэтрүүлэх явдал байсан бол Мандал сумын хувьд хурд хэтрүүлэх, тээврийн хэрэгслийг согтуугаар жолоодох, тоормос ажиллахгүй байх зэрэг явдал байв. Баянгол сумын нийт гэмт хэргийн гуравны нэг нь замын хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглахтай холбоотой байгаа нь магадгүй Улаанбаатар хот болон Оросын хил хоорондох хатуу хучилттай авто замтай ойрхон байдгаас болж байж болох юм.

Бороо Гоулд уурхайн орон нутгийн хөрөнгө оруулалтын үнэлгээ (2012)-нээс харахад замын барилгын ажлыг их орон нутагт хамгийн үнэлсэн байна. Судалгаанд оролцогчид нь замтай болсноор орон нутгийн бичил, жижиг бизнесүүд өргөн зах зээлд илүү нэвтрэх (УБ болон орон нутгийн худалдан авагч нар), бизнесээ өргөжүүлэхэд цагаа зарцуулах боломж бүрдсэн учир зам

нь орон нутгийн эдийн засгийн хөгжилд эерэг нөлөөлөл үзүүлсэн гэж үзэж байна. Мөн бэлэн мөнгөний урсгал нэмэгдсэн явдал нь үр ашигт тооцогдож байгаа ба үүний үр дүнд тээврийн хэрэгсэл худалдан авах нөхцөл боломж нэмэгдэнэ. (2008 оны байдлаар Мандал сум 1 200 суудлын тэрэгтэй байсан бол 2011 он гэхэд 1 700 болсон байна). Гэсэн хэдий ч зарим оролцогчид зам дээр мал мөргүүлж, үхсэн хэд хэдэн ослын талаар тэд мэддэг байсан учир замын аюулгүй байдалтай холбоотой үүсэх хүсээгүй үр дагавар гарч болох талаар санаа зовниж байгаагаа илэрхийлж байсан.<sup>219</sup>

Гацуурт болон Бороогийн уурхай хоорондох хайрган гадаргуутай нийтийн хэрэглээний замыг тээврийн зам болгон ашиглаж байгаа. Гол оролцогч талуудын дурьдаснаар 2010 онд ашиглалтанд орсон уг зам бусад нийтийн хэрэглээний замтай харьцуулахад харьцангуй сайн нөхцөлтэй болсон тул жолооч нарын хурд хэтрүүлэх явдал нь нэмэгдсэн байна. Засгийн газрын түр журамд<sup>220</sup> тээврийн зам нь хатуу хучилттай байна гэж заасан байдаг ба энэ талаар орон нутагт маргаан их байгаа:

- Тоосжилтыг бууруулах үүднээс зам хатуу хучилттай байх ёстой;
- Зам хатуу хучилтгүй байснаар жолоочийн хурдаа сааруулж, осол аваар буурна;
- Хүнд даацын тээврийн хэрэгсэл ашиглахаас өмнө замыг улам сайжруулах хэрэгтэй (замын тэмдэг тэмдэглэгээ, зөрж өнгөрөх цэг зэргийг сайжруулах); ба
- Салхины хамгаалалтын шил/нарны хаалт нь эвдэрсэн (жишээлбэл: нийтийн хэрэглээний зам дээрх баруун тал руу чиглэсэн хөдөлгөөний үед нарны гэрэл нүд рүү тусаж ойртож байгаа тээврийн хэрэгсэл/малыг харах жолоочийн боломжийг хязгаарладаг) муучин, муу тээврийн хэрэгсэлийг замын хөдөлгөөнөөс хасах.

Гацууртын нийтийн хэрэглээний замаар зорчиж байгаа тээврийн хэрэгслийн ихэнхи нь хөнгөн тэрэг байдаг бөгөөд төслийн бүс нутагт тохиолдох ослын ихэнхи нь жолоодлогын эрсдэлтэй байдлаас болдог байна. Одоогийн байдлаар, төслийн бүс нутагт зам тээврийн хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглахтай холбоотой олон нийтийн аюулгүй байдал болон гэмт хэрэг нь асуудал болж байгаа нь илт байгааа ч тухайн төслийн бүс нутагт замын аюулгүй байдлын талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, эрсдэлтэй жолоодлогыг бууруулах Засгийн газрын аливаа хөтөлбөр байгаа эсэхийг тогтоох боломжгүй юм. Бороогийн төсөл өмнө нь замын аюулгүй байдлын талаар компанит ажил зохион байгуулж байсан.

Замын хөдөлгөөний судалгаанаас харахад нийтийн хэрэглээний зам дээр зорчих нийт тээврийн хэрэгслийн оргил үе нь өдрийн 2 цагаас шөнийн 11 цаг хүртэл бөгөөд хамгийн ачаалалтай цаг болох оройн 7 цагт нэг дор 24-32 тээврийн хэрэгсэл байршил (Зүүнхараагийн уулзвар) 2 ба байршил (Бороогийн уулзвар) 1-д хоёр урсгалаар зэрэг зорчиж байсан.

Уурхайн таамагласан замын хөдөлгөөнд 30 тонны хүнд даацын ачааны тэрэг, төслийн талбайнуудын хооронд ажиллагсад болон бараа материалыг тээвэрлэх суудлын тэрэг, дунд оврын автобус зэрэг орно. Хүдрийн тээврийн хүнд даацын ачааны машин, уурхайн талбайнуудын

<sup>219</sup> Орон нутгийн хөрөнгө оруулалтын үнэлгээ, Бороо Гоулд, 2006 – 2011 (Сургалт, судалгаа үнэлгээний институт, 2012).

<sup>220</sup> Уурхайн хүдэр тээвэрлэх зам барих, засвар үйлчилгээ хийх болон хэрэглэх түр журам, хавсралт, Захирамж No. 159, 2012 оны 5 сарын 30-ны өдөр

хооронд бараа материал тээвэрлэх, ажиллагсдын зорчих тээврийн хэрэгсэл зэрэг уурхайн замын хөдөлгөөн хувийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс удаан байх хандлагатай. Энэ нь нийтийн хэрэглээний зам дээр уурхайн тээврийн хэрэгсэл орон нутгийн тээврийн хэрэгсэлтэй олон удаа зөрөхөд хүргэх тул осол аваарыг бий үүсгэх боломжийг нэмэгдүүлж байгаа гэсэн үг.

### **Аюулгүй байдал болон олон нийтийн нэгдмэл байдал**

Төсөл нь дараах зүйлсээс хамааралтайгаар орон нутагт зөрчил, нийгмийн хагаралдааны нөлөөллийг үүсгэж болзошгүй:

- Харуул хамгаалалттай холбоотой (жишээ нь: уурхай руу орох хаалга дээр);
- Төсөл нь олон нийтийн зарим бүлэг, оролцогч талын нөгөө бүлгээс илүү анхаарч, үр ашиг илүү хүртээсэн буюу бодит дэмжлэг үзүүлсэн тохиолдолд; энэ нь эдийн засгийн боломжийг эрэлхийлсэн шилжин ирэгсэд байж болно; ба
- Ажиллагсад буюу гэрээт гүйцэтгэгч нар жижиг гэмт хэрэг болох хулгай хийх зэрэг олон нийтийн зөрчил гаргах.

Бороогийн уурхайн үйл ажиллагааны явцад харуул хамгаалалтын ажилтнууд болон олон нийтийн хооронд зөрчил үүсэх нь ховор байсан. Хүний аюулгүй байдлыг эрсдэлд оруулж болзошгүй харилцан үйлдэл нь цагдаа нар Бороогийн уурхайн талбайгаас бичил уурхайчдыг албадан гаргасан ажиллагаа байсан. Харуул хамгаалалтын гэрээт гүйцэтгэгчид нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд хүний эрхийг хүндэтгэхийн зэрэгцээ ажиллагсдын ажлын байрны аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг ханган ажиллах тал дээр компаниудыг чиглүүлэх олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд болох Аюулгүй байдал ба хүний эрхийн сайн дурын зарчмуудыг сурсан байна.

Олон нийтийн нэгдмэл байдлыг хагаралдуулах явдал нь эдийн засгийн боломж хайн шилжин ирэх хөдөлгөөн, байгалийн нөөцийн ашиглалтанд гарах өөрчлөлт бүхий төслөөс үүдэлтэй орон нутгийн иргэдэд үзүүлж болзошгүй нөлөөлөл юм. Энэ нь дараах зүйлээс хамааралтай:

- Бусад сум, багийн иргэд буюу шилжин ирэгсдийг бодвол уурхайд ажиллаж байгаа хүмүүс сургалт/ ажилтай байгаа/ажилгүйгээс үүдсэн хардалт, атаа жетөө;
- Сентеррагийн ажиллагсдын болон гэрээт гүйцэтгэгч нарын хооронд буюу дундын бодит цалингийн зөрүү болон ойлголт;
- Ажилгүйгээс болон орлого нэмэгдэснээс үүдэлтэй нийгмийн хагарал, нийгэмд аюултай зан авир гаргах (бэлгийн дарамт, архины хэт хэрэглээ, дээрэм зэрэг); ба
- Бичил уурхайчд эрхлэгчдийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үүсэх бодит болон таамагласан нөлөөлөл.

Сумын иргэдийн шилжин ирэгсэдэд хандах хандлага өөр өөр байна. Суурь судалгаагаар Мандал сумын оролцогчдын 50% нь, Баянгол сумын оролцогчдын 56% нь шилжин ирэгсэд нь хүн амын өсөлтөнд үр ашиг авчирч байгаа гэж үздэг учир бусад аймаг, сумдаас шилжин ирсэн хүмүүсийг дэмждэг гэж хариулсан байна. Сөрөг хандлагатай гэсэн хариултанд байгалийн нөөц ашиглахтай холбоотой маргаан нэмэгдэх, гадны хүмүүс аюултай, орон нутгийн хүмүүсийн ажлын байрны боломжийг бууруулах зэрэг орсон байна. Энэ нь төслийн бүсэд эдийн засгийн боломж хайн ирсэн

шилжин ирэгсэд олон нийтийн нэгдмэл байдалд асуудал үүсгэж, урт хугацаанд болзошгүй нөлөөллийг (Хэсэг 6.6.3.3-ээс малчдын маргааны талаар харна уу) бий болгоно гэсэн үг.

Суурь судалгаанд хамрагдсан хоёр сумын хоёуланд нь сумын ЗДТГ болон ИТХ нь олон нийтийн дунд илүү их итгэл хүлээсэн байгууллагаар тодорсон (улс төрийн хөдөлгөөн болон ТББ-ууд хамгийн бага итгэл хүлээсэн) байна. Эдгээр бүх байгууллагуудтай хамтран ажиллаж, олон нийтийн хандлагыг таньж мэдсэнээр эерэг хамтын ажиллагаа бий болгоход туслах болно.

#### 7.1.5.2 Нөлөөллийг бууруулах ба сайжруулах арга хэмжээ

##### *Эрүүл мэндийн үйлчилгээ*

Төслөөс эрүүл мэндийн үйлчилгээнд үзүүлэх нөлөөллийг бууруулах үйл ажиллагаанд дараах багтана:

- Сентерра нь өөрийн бүх ажиллагсад болон гэрээт гүйцэтгэгчид ажилтай холбоотойгоор гэмтсэн болон асуудалд орсон тохиолдолд орон нутгийн эрүүл мэндийн тогтолцооноос гадна тохирсон эрүүл мэндийн үйлчилгээгээр хангах үүрэгтэй;
- Төслийн бүс рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөнөөс эрүүл мэндийн үйлчилгээнд үзүүлэх ачааллыг орон нутгийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж, төслийн зүгээс эрүүл мэндийн үйлчилгээнд тогтвортой, материаллаг бус хөрөнгө оруулалтыг хийх арга замыг бууруулах; ба
- Эрүүл мэндийн үйлчилгээ болон дэд бүтэцийг сайжруулах тал дээр Засгийн газар болон нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах.

##### *Ажиллагсдын эрүүл мэнд*

#### **Шинэ уурхай талбайн эрсдэлүүд**

Уурхайн талбайд шинээр ирж байгаа хүмүүс туршлагатай, туршлагагүйгээс үл хамааран шинэ хамт олон, удирдлагууд, ажлын үйл явц болон өдөр, шөнийн ээлжээр ажиллах орчинтойгоо танилцах хугацаа хэрэгтэй байдаг. Нас баралтын зураглал нь (Баруун Австралийн уурхайд) хөдөлмөр эрхлэлтийн эхний саруудад шинэ ажиллагсдыг сургах, хянах, зааварчилгаа өгөх зэргийн ач холбогдолыг харуулсан байна. Бороогийн уурхайн одоо хэрэгжүүлж буй холбогдох арга хэжээнүүдийг Гацууртын уурхайд авч хэрэгжүүлэн эрсдэлийг бууруулна:

- Хөдөлмөр эрхлэлтийн эхний саруудад төслийн ажиллагсад болон гэрээт гүйцэтгэгчдийг зааварчилгаа, сургалт, удирдамжаар хангаж ажиллах,
- Уурхайтай танилцаж, түүний аюулыг тодорхойлох, ажлын байртай холбоотой эрсдэлийг үнэлэх, энэхүү ажлыг гүйцэтгэх арга барилтай холбоотой сургалтын журмыг хэрэгжүүлж, чадамжийг шалгах,
- Шинэ ажлын, шинэ технологи, шинэ үйлдвэрийн эрсдэлийн үнэлгээ хийх,
- Гэрээний хүчин төгөлдөр хугацаанд хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны наад захын шаардлага багтаасан, зөрчил гарсан тохиолдолд оногдуулах торгууль, авах арга хэмжээ зэргийг тусгасан гэрээт гүйцэтгэгчдийн менежментийг шаардлага,
- Гэрээ хийхээс өмнө үр чадварыг шалгаж, сонгон шалгааруулах үйл явцыг хэрэгжүүлэх,



- Зааварчилгаа, өдөр тутмын аюулгүй ажиллагааны уулзалтууд, сар тутмын гэрээт гүйцэтгэгчийн менежментийн аюулгүй ажиллагааны уулзалтууд бүхий гэрээний гүйцэтгэлийн хяналт шинжилгээ,
- Шинэ материалын хор аюулын лавлах мэдээлэл байршуулах, BIOX® байгууламжийн давтан болон шинэ сургалт бүхий ажиллагсад зориулсан сургалт явуулах, мөн BIOX® байгууламжийн стандарт үйл ажиллагааны журам боловсруулах,
- Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, тогтмол сургалт зохион байгуулах,
- BIOX болон тээвэрлэлтийн шинэ арга хэмжээнүүд.

### **Урьдчилан төлөвлөөгүй онцгой байдал**

Сентерра нь үйлдвэрийн үйл ажиллагаа, тоног төхөөрөмжтэй холбоотой аваар, дэлбэрэлт зэрэг онцгой байдлын улмаас хүнд ноцтой гэмтэх, амь насаа алдах зэрэг эрсдэлийг бууруулах үүднээс Бороогийн уурхайн холбогдох арга хэмжээнүүдийг Гацууртын уурхайд авч хэрэгжүүлнэ:

- Сентеррагийн одоо ашиглаж байгаа Хямралын менежментийн төлөвлөгөө, Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөөг хянаж Гацууртын уурхайн нөхцөл байдалд тохируулах.
- Онцгой байдлын менежментийн төлөвлөгөөг олон нийтэд танилцуулах. Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний асуудал дээр онцгой байдлыг хариуцсан байгууллагуудыг татан оролцуулах.
- Цианидыг үйлдвэрлэх, тээвэрлэх, ашиглахад хэрэглэгддэг олон улсын аж үйлдвэрлэлийн салбарын сайн туршлагын дагуу компани нь хэрхэн цианид худалдан авч, тээвэрлэж, хадгалж, ашиглаж болон устгаж байгааг баталгаажуулах Олон улсын цианидын менежментийн кодыг үргэлжлүүлэн даган мөрдөх.

### *Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд*

#### **Уурхай руу зөвшөөрөлгүй нэвтрэх**

Төслийн барилга, ашиглалт болон хаалтын үе (бага ямар ч аюулын хэмжээнд биш) шатанд төслийн талбайн аль нэг хэсэг рүү зөвшөөрөлгүй нэвтрэхтэй холбоотой хүний эрүүл мэнд, амь насанд учрах болзошгүй аюулыг бууруулах үүднээс одоогийн Бороогийн хэрэгжүүлж буй арга хэмжээг Гацууртын төсөлд хэрэгжүүлэх хэрэгтэй.

- Тэсэлгээнээс үүсэх нөлөөллийг багасгах үүднээс олон нийтийг уурхайн үйл ажиллагааны идэвхтэй талбай руу нэвтрүүлэхгүй байх;
- Олон нийтийг уурхай руу зөвшөөрөлгүй нэвтрүүлэхгүй байх үүднээс харуул хамгаалалтын ажилтнуудыг ашиглах;
- Тусгай тэмдэг тэмдэглэгээг орох, гарах бүх цэгт байнга, уурхайн талбайн зурвас, хашаан дээр тодорхой хугацаанд байршуулах;
- Төслийн талбай дотор, гадна орчинд байгаа аюулгүй байдлын гол асуудлуудыг мэдээллэх зорилготой талуудыг тогтмол татан оролцуулах хөтөлбөр;

- Зочдод төслийн талбайг аюулгүй, хяналтан дор байнга танилцуулах сурталчилгааны хөтөлбөр хэрэгжүүлэх.

### **Халдварт өвчин**

Барилга, ашиглалтын үе шаттай холбоотойгоор халдварт өвчин гарах, тархах болзошгүй эрсдлийг бууруулах үүднээс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай:

- Хөдөлмөрийн, ажлын гэрээ хийхээс өмнө бүх ажиллагсад болон гэрээт гүйцэтгэгчид эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд орж, гэрээний/хөдөлмөр эрхлэлтийн хугацаанд тогтмол үзлэг, шинжилгээнд хамрагдаж байх;
- Ажилчдад зориулсан эрүүл мэнд, аюулгүй байдлын зааварчилгааны нэг хэсэг болгож БЗХӨ болон бусад халдварт өвчнүүдээс урьдчилан сэргийлэх талаар мэдлэг, ойлголт өгөх сургалтыг зохион байгуулж, тогтмол явуулах;
- Уурхайн талбайн эмч нартай хамтран эдгээр мэдлэг олгох сургалтуудыг ажиллагсад болон гэрээт гүйцэтгэгчдэд зохих ёсоор тогтмол зохион байгуулах; ба
- БЗХӨ болон бусад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тал дээр орон нутгийн нийгмийн эрүүл мэндийн компани ажлуудыг дэмжих боломжийг тодорхойлох.

Төсөлтэй хамааралгүй БЗХӨ гарах болон тархах боломжийг бууруулахад дараах арга хэмжээг нэмж авч хэрэгжүүлнэ:

- БЗХӨ болон бусад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тал дээр орон нутгийн нийгмийн эрүүл мэндийн компани ажлуудыг дэмжих боломжийг тодорхойлох.
- Уурхайн кемпийн ойр орчимд бие үнэлэх явдлыг таслан зогсоох хатуу бодлого явуулж, биеэ үнэлэгчидтэй холбогдсон аливаа ажилтныг шууд хална.

### **Зам тээврийн осол**

Гацуурт болон Бороогийн уурхайнуудын хоорондох нийтийн хэрэглээний зам дээр гарах зам тээврийн осол, нас баралтын болзошгүй эрсдэлийг бууруулах үүднээс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай:

- Шууд болон шууд бус бүх ажиллагсдад хамааралтай төслийн бүхий үе шатанд ашиглагдах тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг зохицуулах стратеги бүхий Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх.
- Төслийн бүхий хугацаанд хайрган замыг ашигласнаар төслийн болон нийтийн хэрэглээний замын хөдөлгөөны хооронд үүсэх хурдтай холбоотой осол, харилцан үйлчлэлийг бууруулах:
  - Сумтай байгуулсан гэрээний дагуу одоогийн замыг арчилж, тордох.
  - Уурхайн хаалтын төлөвлөгөөны дагуу төрийн холбогдох байгууллагуудтай зөвшилцөн Төсөл дуусах үе шатанд нийтийн эзэмшлийн замыг шинэчлэн, засах зорилгоор төслөөс сан үүсгэж эхлэх.
- Осол гарах болзошгүй байдлыг эрсдэлийг бууруулах үүднээс замын тусгай техник, технологийн хяналтыг боловсруулж хэрэгжүүлнэ:



- Төслийн тээврийн хэрэгсэл орон нутгийн замын хөдөлгөөнд саад болохгүй байдлаар замаас гарч өмнөөс ирж буй тээврийн хэрэгслийг аюулгүй өнгөрөөх зохих тэмдэглэгээ бүхий аюулгүй зорчих газар байршуулж, барих.
- Үзэгдэх орчин хязгаарлагдмал огцом эргэлт болон даваагаар өнгөрөхдөө эрсдэлийг урьдчилан сэргийлэх технологийн хяналт хийх.
- Болзошгүй гарах ослыг бууруулын тулд Бороогийн төсөл дээр хэрэгжүүлж буй жолоочийн дараах хяналтуудыг хэрэгжүүлнэ:
  - Хурдны хяналт/ тээврийн хэрэгслийг төрлөөр нь хязгаарлах/өдөрт зорчих хугацаа/жолоодох үеийн нөхцөл.
  - Бороогийн уурхайн мансууруулах болон согтууруулах ундааны тухай бодлого.
  - Жолоочийн сургалт болон үнэлгээ.
  - Жолоочийн үнэмлэх/ бусад зам ашиглагчдад хялбархан танигдах зорилгоор тээврийн хэрэгслийн дугаар тодорхой байх шаардлагатай.
  - Ур чадваргүй жолоодлого/хурд хэтрүүлсэнийн улмаас осол гаргасан тохиолдолд торгуул оногдуулах.
  - Жолоочийн хувийн хамгаалах хэрэгсэл.
  - Олон нийтийн тээврийн хэрэгсэлүүдтэй харилцан үйлчлэлд орох явдлыг бууруулах зорилгоор хүдрийн тээврийн хуваарь гаргах (замын хөдөлгөөний оргил үед буюу нар жаргах үед хүдэр тээвэрлэх ачааны тэргийг явуулахгүй байх).
  - Хүнд даацын тээврийн хэрэгсэлээс сул чулуу унаж бусад тээврийн хэрэгслийг цохих явдлаас хамгаалах зорилгоор ачааг хучиж, хянах (бэхлэхгүйгээр ачиж болохгүй),.
- Болзошгүй ослыг бууруулах зорилгоор тохирууланч агентлагуудыг татан оролцуулах:
  - Хурд хязгаарлалтыг тогтоож, даган мөрдүүлэх.
  - Аюулгүй ажиллагаа талаас нь тээврийн хэрэгслийг санамсаргүй байдлаар шалгах.
  - Цусан дахь архины хэмжээний хязгаарыг тогтоож, дагаж мөрдүүлэх.
  - Үүрэг хариуцлагыг багтаасан Ослын үед авах яаралтай хариу арга хэмжээний сургалтыг зохион байгуулах.
- Болзошгүй ослыг бууруулахын тулд орон нутгийн иргэдийг татан оролцуулах:
  - Холбогдох түнш байгууллагуудтай хамтран хурдны хязгаар, аюулгүйн бүсийн хэрэглээ, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ зэрэгт онцгойлон анхаарсан замын аюулгүй байдлын компанит ажил зохион байгуулах; компанит ажил нь настай жолооч болон хүүхэд бүхийг эмзэг бүлэгт чиглэсэн байх ёстой.

- Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу харилцаа холбооны давуу эрхтэй хэрэгсэл болох телевиз, олон нийттэй харилцах ажилтнууд, сонин хэвлэл ашиглан зам ашиглагч нарын замын эрсдэл, хүдэр тээвэрлэлтийн хуваарь, давтамж зэрэг мэдээллийг олон нийтэд хүдэр тээвэрлэхээс өмнө урьдчилсан мэдээллэнэ.
- Тухайн жолоочтой холбоотой ямар нэгэн гомдол, хэв журмын зөрчлийг Гомдол барагдуулах механизмын дагуу мэдээлэх.
- Тээврийн хэрэгсэл, хүн, малтай холбоотой бага, томоохон ослын тохиолдолд үзүүлэх яаралтай тусламжийн үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээллээр (хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр болон зам дагаад хажуу хөвөөгөөр байршуулах) хангах.
- Нийтийн хэрэглээний зам дээр малтай харилцан хамааралд үйлчлэлд орох нөлөөллийг бууруулах арга хэмжээ нь дээр дурдсан хүн буюу бусад тээврийн хэрэгсэлтэй адилхан гэдгийн тэмдэглэх нь зүйтэй.

### **Аюулгүй байдал болон олон нийтийн нэгдмэл байдал**

Төслөөс аюулгүй байдал, аюулгүй ажиллагаанд үүсэж болзошгүй нөлөөллийг бууруулахдаа дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай:

- Төслийн аюулгүй байдал нь орон нутгийн оролцогч талуудтай сайн харилцааг бий болгох төслийн зорилготой нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах ; орон нутагтай холбоотой асуудлуудад анхаарал хандуулах гомдол барагдуулах механизмийг бий болгох, үүний зэрэгцээ орон нутгийн иргэдийг хүндэлж, хамгаалахын тулд харуул хамгаалалтын ажилтнуудад хүний эрх, соёлын онцлогын талаарх сургалтыг үргэлжлүүлэн явуулах, харуул хамгаалалтын ажилтнуудад байнгын хяналт хийх;
- Харуул хамгаалалтын ажилтнуудад тусгайлан зориулсан бие зөв зохистой авч явах, оролцогч талуудыг татан оролцуулах, хүчийг зөв ашиглах болон Сайн дурын зарчмуудын хэрэглээг хянах Ёс зүйн дүрмы сургалтыг зохион байгуулах.
- Нөлөөлөлд өртөж болзошгүй бүх оролцогч талууд компанитай хэрхэн холбогдох, гомдол хэрхэн гаргах талаар мэдээлэлтэй байгаа эсэхийг баталгаажуулах зорилгоор оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөөг үргэлжлүүлэн, хэрэгжүүлэх (Гомдол барагдуулах журмын дагуу).
- Ажиллаж байх хугацаанд нь орон нутгийн иргэдтэй аль болох бага харьцуулах зорилгоор ажиллагсдыг уурхайн талбайд байрлуулах (үүнд барилга, ашиглалт болон хаалтын үе шатуудын ажиллах хүч орно).
- Арилжаа наймаа эрхлэгч, эдийн засгийн боломж хайгч нарт учрах болзошгүй нөлөөллийг бууруулсанаар (Хүн амзүйн дагуу) оршин суугчидтай үүсэх маргааны боломжийг хязгаарлах.

- Төслийн ажиллагсад болон гэрээт гүйцэтгэгч нарт зориулсан уурхайгаас гадуур орон нутгийн иргэдтэй харилцах боломжийг бууруулах, бие биендээ байнга хүндэтгэлтэй хандаж, биеэ зохистой авч явах сургалтыг явуулах зэрэг кемпийн дотоод дүрмийг хэрэгжүүлэх.
- Бороогийн уурхай дээр хэрэгжүүлж байсан төрийн хамгаалалттай тогтмол холбоотой ажиллах зэрэг харуул хамгаалалтын үйл ажиллагааны туршлагыг хэрэгжүүлэх.

### *Сайжруулах арга хэмжээнүүд*

Төсөл нь нөлөөлөл бууруулах санал болгож буй арга хэмжээнүүдээс гадна Сэлэнгэ аймаг болон Мандал, Баянгол сумдууд, мөн Түнхэл багт сум хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын хүрээнд төслийн бүс нутаг дахь олон нийт, ялангуяа төслийн үйл ажиллагааны шууд бус нөлөөлөлд өртсөн олон нийтийн эдийн засгийн үр ашгийг урт хугацаанд хангах үүрэг амлалт авч байна. Дараах сайжруулах арга хэмжээнүүдийг авах үүрэг хүлээж байна:

- Хөгжлийн хүлээн зөвшөөрсөн төлөвлөгөөний дагуу төслийн сөрөг нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдэд эдийн засгаа сайжруулах боломжийг бий болгох (Төрийн удирдах албан хаагчид, компани болон иргэдийн төлөөлөл ашиглах одоогоор хууль ёсны болоогүй байгаа Олон нийтийн хамтын ажиллагааны гэрээ).
- Төслийн харилцаа холбоо, хэлэлцүүлгийн явцыг хангах ННҮ-нд хавсаргасан Оролцогч талуудын татан оролцуулах төлөвлөгөөг (ОТТОТ) тогтмол хянаж сайжруулж байх.
- Кемпийн шаардлагуудын (кемпийн дотоод журам, ажлын байран дээр бие авч явах байдал зэрэг орно) хүлээлтийг удирдан зохицуулахын тулд бүх ажиллагсад (дотоод, орон нутгийн болон гадаад) зааварчилгаа өгөх.
- Орон нутгийн захиргаа, иргэний нийгэм болон олон нийтийн төлөөлөлтэй хамтарч олон нийтийн тогтвортой хөгжлийн төслүүдийг боловсруулснаар төслийн хэрэгжилт, үр дүн, ач холбогдолыг баталгаажуулах.

### **7.1.5.3**     Хурангуй

Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шинж чанар	Бууруулаагүй боломжит ач холбогдол	Үлдэгдэл боломжит ач холбогдол
<b>Эрүүл мэнд (ЕСБХБ ГШ 1 ба 4)</b>			
Орон нутаг руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнөөс үүдэн эрүүл мэндийн үйлчилгээний ачаалал нэмэгдэх	Магадлалтай  Шууд бус, дунд хэмжээний бага, сөрөг  Урт хугацааны  Дунд хэмжээний	Дунд	Бага
Шинэ уурхайн талбай дээр ажиллахтай холбоотойгоор ажиллагсдын осол гаргах, бэртэх, амь насаа алдах эрсдэл нэмэгдэх	Боломжит  Шууд, их сөрөг  Богино хугацааны	Их	Дунд



	Өргөн хэмжээний		
Төслийн бүсэд урьдчилан тооцоологдоогүй онцгой байдал үүсч ажиллагсад, онцгой байдлын ажигтанууд, Засгийн газрын агентлагууд болон орон нутгийн иргэд эрсдэлд орох	Магадлал багатай Шууд, гол сөрөг Богино хугацаанаас дунд хугацааны Багаас дунд хэмжээний	Их	Дунд
Гацууртын уурхайн байгууламж, Бороогийн уурхайн баяжуулах байгууламжуудийг ашиглахтай холбоотойгоор хүний эрүүл мэнд, орон нутгийн иргэдийн аюулгүй байдал аюул орох	Магадлалтай Шууд, их сөрөг Урт хугацааны Бага хэмжээний	Их	Дунд
Ажиллагсад дотроо болон хооронд, орон нутгийн иргэдийн хооронд БЗХӨ болон халдварт өвчин тархах эрсдэл нэмэгдэх	Магадлалтай Шууд бус, дунд зэргийн бага, сөрөг Урт хугацааны Дунд хэмжээний	Дунд	Бага
Гачуурт болон Бороо уурхайн хооронд буюу Төслийн болон нийтийн хэрэглээний зам ашиглагч нарын хоорондох нийтийн хэрэглээний зам дээр осол гарах, амь нас алдах эрсдэл	Тодорхой Шууд, их сөрөг Дунд хэмжээний Урт хугацааны	Их	Дунд
Төслийн ажиллагсад болон орон нутгийн иргэдийн дунд болон хооронд, мөн төслийн бүсэд төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй нийгмийн хэв журам алдагдах, буюу нийгмийн эсрэг зөрчил гарах эрсдэл	Магадлалтай Шууд болон шууд бус Дунд зэргийн их, сөрөг Дунд хэмжээний Урт хугацааны	Дунд	Бага
Төсөл болон гол оролцогч талуудын түншлэлийн хүрээнд тогтвортой орон нутгийн хөгжлийн санаачлагууд хэрэгжүүлэх, сайжруулах	Эерэг Шууд Урт хугацааны Дунд зэргийн их Дунд хэмжээний	-	-



### 7.1.6 Соёлын өв

Төслийн үйл ажиллагаанаас соёлын өвөд үзүүлж болзошгүй нөлөөллийн талаар энэ хэсэгт дурьдав, үүнд төслийн бүс нутаг дахь археологийн биет өвөөс гадна биет бус соёлын өвийг багтаасан, төслийн барилга, ашиглалт буюу хаалтын үе шатуудад газар буюу төслийн талбайн аливаа өөрчлөлттэй хамааралтай соёлын үнэт зүйлс алдагдах эсвэл соёлын өв болон археологийн нөөцийг шууд бус байдлаар эвдэгдэх асуудлыг тусгасан.

#### 7.1.6.1 Нөлөөлөл

##### *Үнэлгээний арга барил*

Монголын өвийн тухай хууль тогтоомжуудад суурь тодорхойлолтуудыг тусгасан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012) болон Соёлын өвийг хамгаалах тухай хууль (2014) (Зүйл 7: Соёлын биет бус өв)-иуд багтана. Соёлын нөөцөд үзүүлж болзошгүй нөлөөллийг үнэлэхдээ нөөцийн ач холбогдлыг эхэлж үнэлэх шаардлагатай. Монгол Улсын өнөөгийн хууль эрхзүйн орчинд соёлын биет өвийн газрын ач холбогдолыг үнэлэх тодорхой стандарт, аргачлал тусгагдаагүй.

Санал болгож буй төслийн бодит ул мөрийн хүрээнд гарч болзошгүй археологийн талбай болон нөлөөлөлд өртөж болзошгүй бүсийн хүрээнд байгаа боловч барилгын ажлын бодит ул мөрөөс гаднах талбай (БАБҮМГТ) хоорондын ялгааг гаргах нь нэн чухал. Ерөнхийдөө нөлөөлөлд өртөж болзошгүй бүсийн хүрээнд байгаа боловч БАБҮМГТ нь санал болгож буй төслийн барилга болон ашиглалтын үе шатнуудын шууд нөлөөлөлд өртөхгүй байж болно. Гэсэн хэдий ч БАБҮМГТ-д байгаа соёлын өвийн газарт тэсэлгээний чичэргээнээс болзошгүй нөлөөлөл үзүүлж болох юм гэж үзсэнээр нөлөөлөл бууруулах төлөвлөлт хийсэн байна.

Нөлөөлөл бууруулах арга хэмжээнүүдийг нөлөөллийг боломжит хэмжээнд багасгах, нөлөөллөөс зайлсхийх зорилгоор хэрэгжүүлэх ёстой. Нөлөөлөл бууруулах дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх боломжтой:

- Санал болгож буй төслийн ул мөрийг соёлын өвийн нөөцөөс холдуулан шилжүүлэх, нөөцийн ойр орчмын үйл ажиллагааг хязгаарлах, нөөцийн ойр орчимд хийгдэх барилгын ажлыг хянах, эдгээр арга хэмжээнүүдийг хослуулан хэрэглэснээр зайлсхийх боломжтой.
- Дээр дурдсан зайлсхийх арга хэмжээг ашигласнаар соёлыг өвийн нөөцөд үзүүлж болзошгүй нөлөөллийг боломжийн хэмжээнд багасгах.
- Нөөцөд үзүүлэх нөлөөллөөс зайлсхийх хийх боломжгүй тохиолдолд ойр орчимд байгаа ижил төстэй нөөцийг хамгаалах замаар уг нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, археологийн газруудыг малтан гаргаж, мэдээллийг сэргээх замаар нөөцийг бүрэн баримтжуулах, орон нутгийн нөлөөлөлд өртсөн соёлын өвийг хадгалан хамгаалах ажилд хувь нэмрээ оруулах, санал болгож буй төслийг хэрэгжүүлэх явцад соёлын өвийн нөөцийн талаар цуглуулсан мэдээллийг онцолсон тайлбартай үзэсгэлэн гаргах эсвэл дээр дурдсан стратегиудыг нь хослуулан ашиглах замаар нөлөөллийг бууруулах.

Төслийн бүс нутагт байгаа бүх соёлын нөөцүүдийн нөлөөллийг үнэлэхдээ соёлын өвийн нөөцөд үзүүлэх нөлөөллөөс хэрхэн үр дүнтэй зайлсхийх, бодит хэмжээнд хүртэл бууруулах эсвэл багасгах талаар авч хэлэлцэнэ.

### *Археологийн нөөц*

Гацууртын төслийн орчимд археологийн нөөцийн хоёр судалгааг хийсэн болно.

1999 оны 10 сард ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн Археологийн төвөөс Гацууртын хөндийд судалгаа хийсэн. Үүний дараагаар, 2005 оны 6 болон 8 дугаар саруудад Монгол Улсын их сургуулийн Антрополиги болон Археологийн тэнхимээс судалгаа хийсэн. Судалгаагаар Сентеррагийн уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай болон Гацууртын уурхайгаас Бороогийн алтны уурхай хүртэлх зам, болон Гацууртын хөндийгөөс Түнхэл тосгон хүртэлх газрыг судалсан. 2015 онд Монгол Улсын Засгийн газрын захиалгаар Монгол Улсын ШУА-ийн Археологийн хүрээлэн Гацууртын уурхайн талбай болон эргэн тойронд археологийн нэмэлт судалгаа явуулсан байна.

Эхний хоёр судалгаагаар Хүрлийн үеэс Түрэгийн үеийг хамаарна (2000 МЭӨ –с 8-р зуун хүртэл) археологийн нийт 57 газар тогтоогдсон байна. Хөшөөнүүд уулын бэл, хөндийд усны эх үүсвэрийн дэргэд байршилтай байна. Судалгааны багийн байршил тогтоогчоор координатуудийг нь тогтоосон булш бүхий бүх газрууд Гацууртын уурхайн талбайгаас нилээд хол байгааг баримтжуулжээ. Гэсэн хэдий ч, археологийн судалгааны үр дүн нь<sup>221</sup> биет өвд үзүүлж болзошгүй нөлөөллөөс зайлсхийх буюу төслөөс 'гадна' байхаар тооцож энэхүү чиглэлийг өөрчилсөн байна. Одоо ашиглагдаж буй замын эцсийн хувилбар нь археологийн аливаа олдворт нөлөөлөхгүй байхаар сонгогдсон. Гацууртын уурхайн талбай, 2010 онд барьсан Гацууртын хүдрийн тээврийн зам дээр аливаа эртний булш, бунхан болон бусад түүхэн эд өлгийн зүйлс тогтоогдоогүй болно.<sup>222</sup>

Эд өлгийн зүйл болон археологийн өвийн газар нь орон нутгийн тусгай хамгаалалтын бүс болох Зуун модны гол болон Ноён уулын газарт төвлөрсөн байгаа нь төслийн болзошгүй нөлөөллийн талбайгаас гадна байна. Гацууртын уурхайгаас 7 км–н зайнд байрлах үндэсний ач холбогдол бүхий Ноён уулын Сужигтэй Нуруу булш бүхий газар нь Төсөлд хамгийн ойрхон байрладаг ба аливаа тэсэлгээ эсвэл чичэргээний нөлөөлөлд өртөхгүй.

### **Төслийн үр ашиг ба болзошгүй нөлөөлөл**

Эд өлгийн зүйлийн түүхийн бүрэн бүтэн эвдэгдээгүй байдлыг бууруулах замаар түүхэн ач холбогдол бүхий соёлын өвийн шинж чанарыг шууд буюу шууд бусаар өөрчлөх үед үр нөлөө гарна. Бодитоор урьдчилан тооцож болох нөлөөлөл нь тодорхой цаг хугацааны дараа, хол зайтай хуримтлагдсан байдлаар илэрч болох юм. Болзошгүй сөрөг нөлөөлөлтэй үед Төсөл хэрэгжүүлэгч, холбогдох тохируулагч агентлагуудтай хамтран нөлөөлөл бууруулах арга хэмжээнүүд, тохирсон арга хэмжээний сонголтыг оролцогч талуудтай хэлэлцэж хийх нь зөв гэж зөвлөсөн байна. Санал болгож буй төслийн хувьд нөлөөний дараах үндсэн төрөл гарч болох байна:

- Хөрс хуулалтын үед тухайн эд өлгийн зүйл бүхэлдээ, хэсэгчилэн эвдэрч, гэмтэх;

<sup>221</sup> Ноён уул, Мандал, Сэлэнгэ аймгийн Гацууртын хөндийд археологийн судалгааны тайлан; 6-р сар 6-24, 2005 болон 8-р сарын 12-19, 2005 (Антропологийн болон Археологийн тэнхим, МУИС).

<sup>222</sup> Гацууртын төслийн тойм, 3 –р сар 2015.

- Санал болгож буй төслийн барилга, ашиглалтын үе шатанд эд өлгийн зүйлийн түүхэн онцлог шинжийг алдагдуулах харагдах байдлын, цаг агаарын, дуу чимээ зэрэг байгалийн зүйлсийн нөлөөлөл орох; ба
- Эд өлгийн зүйлийн ашиглах зориулалт, физикийн шинж чанар өөрчлөгдсөнөөр эд өлгийн зүйлийн үнэ цэнэд нөлөөлөх.

Төслийн барилга, ашиглалтын үе шатууд нь соёлын өвийн эх сурвалжид ижил нөлөөлөл үзүүлэх тул хамтад нь авч хэлэлцэнэ.

### **Барилгын болон ашиглалтын үе шатны үйл ажиллагааны нөлөөлөл**

Гацууртын төслийн үл мөр бүхий талбай буюу нөлөөлөлд өртөж болох талбайн хүрээнд хэдэн археологийн өв бүхий газар байдаг ч дээр дурьсан Монгол Улсын ШУА-ийн харьяа Археологийн хүрээлэнгийн зөвлөмжөөр эдгээр газруудад нэмэлт судалгаа хийх шаардлагагүй байна. Төслийн холбогдох үйл ажиллагаануудаас эдгээр газрууд болон бусад археологийн өв бүхий газруудад аливаа бодит хохирол учрахгүй. Төсөл хэрэгжүүлснээр археологийн олдвор бүхий газарт хүрэх боломж нэмэгдэснээр соёлын өвийн эх сурвалжид хүрэх, хулгайлах, хохирол учруулах зэрэг боломжуудыг нэмэгдүүлж болох хэдий ч Гацууртын уурхайн талбайгаас Сужигтэйд олдсон Хүннүгийн булш бүхий газарт хүрэх зам байхгүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Санал болгож буй Төсөл нь төслийн үл мөр бүхий талбайд соёлын өвийн урьд өмнө мэдэгдээгүй эх сурвалжийг санамсаргүй байдлаар илрүүлэх зэрэг соёлын өвд олон төрлийн нөлөөлөл үзүүлж болзошгүй. Эгц, нарийхан, бартаг ихтэй Гацууртын хөндийд археологийн олдвор олдох магадлал багатай гэж үзэж байгаа учир археологийн олдворт дунд, богино хугацааны нөлөөлөл үзүүлж болзошгүй юм. Төслийн барилгын үе шатанд соёлын өвийн урьд өмнө мэдэгдээгүй эх сурвалж санамсаргүй байдлаар олдвол энэ нөөцөд үзүүлэх нөлөөлөл нь шууд, байнгын чанартай байна.

### **Уурхайн хаалтын нөлөөлөл**

Уурхайн хаалтын үе шат болон хаалтын дараа Гацууртын уурхайн талбайн үйл ажиллагаа буурч соёлын өв бүхий газарт хүрэх боломж нэмэгдэх ба Гацууртын уурхай хаасны дараа ч уурхайн талбайд харуул хамгаалалт байсаар байна.

### **Биет бус соёлын өв**

#### **Үнэлгээний арга барил**

Биет бус соёлын өвд үзүүлэх болзошгүй нөлөөллийг үнэлэхдээ нэн тэргүүнд нөөцийн ач холбогдолыг үнэлэх шаардлагатай. Биет бус соёлын өв нь тухайн улс, орон нутгийн хувьд өвөрмөц, цорын ганц зүйл бөгөөд судалгааны талбайн биет бус соёлын өвийн эх сурвалжийн үнэ цэнийг тодорхойлохдоо үндэсний хууль тогтоомж болон олон нийтийн хандлагыг авч ашиглана. Биет бус соёлын өвийн талаарх судалгааны явцад ярилцлаганд хамрагдсан иргэдийн ихэнх нь биет бус соёлын өвийг өндөр ач холбогдолтой, тэдгээрийг хадгалж авч үлдэн, хойч үедээ өвлүүлэхийг хүсэж байна гэжээ. Одоогийн байдлаар Монгол Улсад биет бус соёлын өвийн ач холбогдолыг тодорхойлох шалгуур үзүүлэлт байхгүй болно.

Биет бус соёлын өвийн хувьд төслийн бүс нутаг болон санал болгож буй төслийн бодит үл мөрийн талбай хоорондын чухал ялгааг гаргах хэрэгтэй. Биет бус соёлын өв нь ихэнх тохиолдолд газар хусах зэрэг уурхайн үйл ажиллагаанаас илүүтэй төслийн шууд бус нөлөөлөлд өртдөг. Иймд, биет

бус соёлын өвтэй холбоотой төслийн бүс нь нийгмийн нөөцийг тодорхойлох төслийн талбайтай ерөнхийдөө таарч байна.

### **Төслийн үр нөлөө болон болзошгүй нөлөөлөл**

Төслийн үйл ажиллагаанаас судалгааны бүс дахь биет бус соёлын өвд үзүүлэх нөлөөг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд нь Хөшөө дурсгал, түүхэн газруудын Олон улсын зөвлөлөөс (ICOMOS 2011) гаргасан удирдамж баримт бичгийг үндэслэсэн тодорхойлсон. Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу төслийн үйл ажиллагаанаас биет бус өвд үзүүлэх нөлөөллийг дараах байдлаар ангилж болно:

- **Их хэмжээний нөлөөлөл:** Биет бус соёлын өвийн зан үйл, зохицол, харагдах байдал болон соёлын үнэ цэнэ зэрэгт нөлөөлөх их хэмжээний өөрчлөлт.
- **Дунд хэмжээний нөлөөлөл:** Биет бус соёлын өвийн зан үйл, зохицол, харагдах байдал болон соёлын үнэ цэнэ зэрэгт нөлөөлөх тодорхой хэмжээний өөрчлөлт.
- **Бага хэмжээний нөлөөлөл:** Биет бус соёлын өвийн зан үйл, зохицол, харагдах байдал болон соёлын үнэ цэнэ зэрэгт нөлөөлөх бага хэмжээний өөрчлөлт.
- **Үл мэдэгдэм нөлөөлөл:** Биет бус соёлын өвийн зан үйл, зохицол, харагдах байдал болон соёлын үнэ цэнэ зэрэгт нөлөөлөх үл мэдэгдэм өөрчлөлт.
- **Байхгүй:** байхгүй

Төслийн барилга болон ашиглалтын үе шатууд биет бус соёлын өвд ижил нөлөөлөл үзүүлэх учраас хамтад нь авч үзсэн.

### **Барилга, ашиглалтын үе шатны нөлөөлөл**

Гацууртын уурхайн талбай дээр байршиж буй төслийн дэд бүтэц овоо тахилгын газраас хол байхаар баригдсан. Цаашдаа, орон нутгийн иргэдэд сөрөг ойлголт өгөхөөс сэргийлэх үүднээс төслийн барилга байгууламжийг барих барилгын материалыг орон нутгийн онгон дагшин уул, газраас олборлохгүй байхаар зохицуулсан.

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн Төсөл нь биет бус соёлын өвийн эх сурвалжид олон янзын нөлөөллийг үзүүлж болзошгүй. Үүнд:

- Эдийн засгийн боломжийг эрэлхийлэн төслийн бүсэд шилжин ирэх гадны хүмүүсийн шилжилт хөдөлгөөний улмаас орон нутгийн иргэд гадны соёлын нөлөөлөлд өртөнө, ялангуяа шашны зан үйл болон нийгмийн харилцааны хэлбэрүүд. Үүнд, нутгийн уугуул иргэд дурьдсаны дагуу суурь судалгаанд товчлон оруулсан, уултай холбоотой хорио цээрийг тоомсорлосон эсвэл үлгэр домгыг хүндэтгэсэн овоо тахиалгын зан үйлийг цаашид үргэлжлүүлэх, мөн төслийн бүсийн соёлын өвийн мэдээллийн гол эх сурвалж болох аман түүхийг орхигдуулах явдал зэрэг орно.
- Төслийн бүс нутагт эмийн ургамал ховордох, эдгээр ургамлын ашиглах боломж нь өөрчлөгдсөнөөр төслийн бүс нутгийн ойр орчмын сумдууд, ялангуяа Түнхэл багийн ардын уламжлалт эмчилгээний үйл ажиллагаанд нөлөөлөл үзүүлж болзошгүй юм.

### **Уурхай хаалт үе шатны нөлөөлөл**

Уурхайн хаалтын явцад төслийн бүс нутгийг уурхайн бүс (арилжаа, бичил уурхайн зориулалт) зориулалтаар ашиглуулахаар буцаан хүлээлгэн өгснөөр төслийн соёлын өвийн эх сурвалжид оруулах хөрөнгө оруулалт буурч, орон нутгийн зан заншилд шилжин ирэгсэд үзүүлж болзошгүй нөлөөллийг багасгах зэрэг үр дүн гарна.

#### 7.1.6.2 Нөлөөллийг бууруулах

##### *Археологийн өв*

Сентерра нь төслийн ажиллагсад болон гэрээт гүйцэтгэгч нарын археологийн өвийн эх сурвалжид хүрэх боломжийг нь хязгаарлахын тулд төслийн ажиллах хүчийг Бороогийн уурхай дээр байрлуулах зэргээр археологийн өвд учирч болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Ажиллагсад болон гэрээт гүйцэтгэгч компаниудын дотоод журмаар ажиллагсад болон гэрээт гүйцэтгэгч соёлын өв бүхий газарт орохыг хориглосон байна. Цаашдын арга хэмжээний хүрээнд археологийн өв бүхий газрыг тонож, сүйтгэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор мэдэгдэж буй өвийн талаарх соёлын өвийн мэргэжилтэн зөвлөгөөгүй л бол мэдээлэл өгөхийг хязгаарлана. Сентерра нь уурхай дээр ажиллаж байгаа хүн бүр дагаж мөрдөх "Санамсаргүй олдвор"-ын журмыг хэрэгжүүлнэ. Уг журмын дагуу археологийн аливаа олдвор санамсаргүй байдлаар олдсон тохиолдолд чухал ач холбогдолтой олдвор олдсон газрын ойр орчмын ажлыг бүрэн зогсоож, холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ. Үүнээс гадна, Гацууртын уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай дотор шинээр бүртгэгдсэн газруудын талаар Сентерра нь тухайн газрыг хөндөхөөс (эдгээр газруудыг хөндөх шаардлагатай тохиолдолд) өмнө Монгол Улсын ШУА-тай холбогдож, зөвлөлдөнө.

##### *Биет бус өв*

Биет бус өвд учирч болзошгүй нөлөөллийг бууруулах үүднээс Төсөл нь орон нутгийн өв бүхий газрыг гэмтээх, зан үйлд үл хүндэтгэлтэй хандах тохиолдлыг багасгах зорилгоор үндэсний мэргэжилтнүүдийн оролцоотой боловсруулсан биет бус соёлын өвийн талаар мэдээлэл өгөх сургалт бүхий хөтөлбөрийг төслийн бүх ажиллагсад, гэрээт гүйцэтгэгч нарт танилцуулах зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Сентерра нь орон нутгийн ариун дагшин газруудаас барилгын материал авахаас аль болох зайлхийнэ. Үүний зэрэгцээ, Сентерра нь төслийн хэрэгжилтын бүхий л явцад Гацууртын хүдрийн тээврийн замыг ашиглах үед ч орон нутгийн иргэд соёлын өв бүхий газрыг саадгүй ашиглаж байгааг баталгаажуулна.

Орон нутгийн оролцогч талуудтай шууд, өдөр тутам харилцаж оролцогч талуудыг татан оролцуулах, санал гомдол хүлээж авч барагдуулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Оролцогч талуудыг татан оролцуулах, санал гомдол хүлээн авч, барагдуулах үйл ажиллагаа нь уламжлалт мал аж ахуй эрхэлж буй малчдад онцгойлон анхаарах ба төслийн нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээнүүд уламжлалт мал маллагааны чухал хэсэг болох бэлчээр, усны нөөцөд үзүүлэх аливаа нөлөөллийг багасгахад чиглэсэн байх ба бэлчээрийг сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлж (Газар ашиглалт бүлгийг харна уу) байна. Цаашид Төсөл нь орон нутгийн уламжлал, соёлыг хадгалан, хамгаалах ба орон нутгийн соёлын арга хэмжээнүүдийг дэмжих зорилгоор сумын захиргаа, олон нийтийн бүлгүүдтэй хамтран ажиллах болно.

Биет бус соёлын өв нөлөөлөлд өртсөн эсвэл орон нутгийн иргэд ирээдүйд соёлын өв сөрөг нөлөөлөлд өртөх талаар санаа зовниж байгаагаа мэдэгдсэн бол хяналт шинжилгээ хийх, эдгээр нөлөөллийг бууруулах арга хэмжээг авсах шаардлагатай. Болзошгүй нөлөөллийг бууруулах арга

хэмжээнүүдэд соёлын өвийн мэргэжилтнүүд хангалтгүй байгаа орон нутагт соёлын өвд хүндэтгэлтэй хандах олон нийтийн боловсрол, мэдээллийн хэрэгцээг хангах боломжтой орон нутгийн соёлын байгууллагуудад үзүүлэх дэмжлэг багтана. Сентерра нь төслийн бүсийн аман түүхийн уламжлалыг хадгалах зорилгоор сумын соёлын төвд аман түүхийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, орон нутгийн иргэдэд биет болон биет бус соёлын өвийн талаар мэдээлэх олон нийтийн хөтөлбөр хэрэгжүүлэн, үзэсгэлэн гаргаж болох юм.

### 7.1.6.3 Хураангуй

Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шинж чанар	Буруулаагүй боломжит ач холбогдол	Үлдэгдэл боломжит ач холбогдол
<b>Соёлын өв (ЕСБХБ ГШ 1 ба 8)</b>			
Төслийн талбайд археологийн өв хулгайд алдагдах эсвэл гэмтэх эрсдэл	Шууд, шууд бус Магадлал багатай – боломжтой Их дунд сөрөг Дунд хэмжээний Урт хугацааны	Дунд	Бага
Орон нутгийн ач холбогдол бүхий соёлын өвийн зан үйл орхигдох эрсдэл	Шууд, шууд бус Магадлалтай Их дунд сөрөг Дунд хэмжээний Урт хугацааны	Дунд	Бага

## 7.2 ХУРИМТЛАГДАХ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

Энэхүү хэсэгт төслийн хуримтлагдах нөлөөлөл болон бусад боломжит бүтээн байгуулалтыг оруулсан болно. Үнэлгээ нь төслийн хуримтлагдсан нөлөөллийг урдны, одоогийн, мөн урьдчилан тооцсон бодит бусад холбогдох бүтээн байгуулалттай холбосон ба ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлагын дагуу<sup>223</sup> төлөвлөгдөөгүй гэхдээ өөр өөр байршлуудад дараа нь хэрэгжүүлэхээр урьдчилан таамагласан төслийн үйл ажиллагаануудыг бас авч үзсэн.

Төслийн хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээг хийхийн зэрэгцээ Төсөл нь нийгмийн олон төрлийн нөлөөллүүдийг хамт үнэлсэн (жишээ нь: орон нутаг руу чиглэсэн шилжилт хөдөлгөөний өсөн нэмэгдсэн жин гэх мэт) байна. Бүсэд Төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөсөн тохиолдолд, ерөнхий БОННУ-н үйл явцад нэгтгэх хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээнд дараах зүйлсийг тусгана: (1) судалгаа (2) нөлөөлөлд өртсөн орчны суурь нөхцлийг тодорхойлох болон (3) төслийн бүсийн нийгмийн үр дагаварыг тодорхойлох юм. Хуримтлагдсан нөлөөлөл нь нэг бол эерэг (ажлын байрыг бий болгох, шаардлагатай байгаа нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэх) ба үүнээс үүдэн

<sup>223</sup> ЕСБХБ-ны Байгаль орчин ба нийгмийн бодлого (2014).



бүсийн хүн амын амьдралын чанар сайжрах, нэг бол сөрөг (хүмүүст хор, хохирол учруулах) байх боломжтойг ойлгох нь чухал.

Хуримтлагдсан нөлөөллийг үнэлэх аргачлал нь Бүлэг 5: Судалгааны арга зүй–д тайлбарласан төслийн нөлөөллийг үнэлэхэд ашигласан аргачлалтай үндсэндээ ижил байна. Доорх хүснэгтэнд хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ (БО)ННҮ-ний үйл явцтай хэрхэн уялдаж байгааг харуулсан.

### Хүснэгт 7.8 ННҮ-д хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээг уялдуулах

<b>ННҮ-д хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээг (ХНҮ) уялдуулах</b>	
<b>ННҮ-ийн бүрэлдэхүүн хэсэг</b>	<b>ХНҮ-ийн зарчим</b>
Судалгаа	Өнгөрсөн, одоогийн, ирээдүйн үйл ажиллагааг оруулах. Үндэсний, орон нутгийн засаг захиргаа, хувийн хэвшлийн үйл ажиллагааг оруулах. Нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэд тус бүрт анхаарлаа хандуулах. Ач холбогдол бүхий нөлөөлөлд анхаарлаа хандуулах.
Нөлөөлөлд өртсөн орчныг тодорхойлох	Нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэд тус бүрт анхаарлаа хандуулах. Байгалийн хил хязгаарыг ашиглах.
Үр дагавар тодорхойлох	Нэмэлт нөлөөг авч хэлэлцэх. Нөлөөг сөөрмөгжуулах хэсгийг авч хэлэлцэх. Нэгдмэл нөлөөг авч хэлэлцэх (нийт нөлөөг үүсгэх олон талт хэсгийн хоорондын харьцаа). Төслийн үе шатуудын цаадахыг харах. Орон нутгийн иргэдийн тогтвортой байдлыг авч хэлэлцэх.
Нөлөөллийг бууруулах арга хэмжээг бий болгох	Төслийн нөлөөллийг бууруулах арга хэмжээг боловсруулахдаа төслийн бүсэд үзүүлэх хуримтлагдсан нөлөөллийг анхааралдаа авч нөлөөлөл бууруулахад шаардлагатай арга хэмжээг боловсруулж, тэдгээрийн үр ашгийг хянах.

Суурь судалгаанд төслийн бүсэд, ялангуяа Мандал суманд өөр бусад томоохон ажил олгогч байгааг дурьдсан ч санал болгож буй төслөөс өөр томоохон бүтээн байгуулалт шинээр төлөвлөгдөөхгүй байна. Мандал сумын гол ажил олгогч нь төмөр зам бүхий хувийн салбар байна. Иймд, төслийн бүсэд эдийн засгийн хөрөнгө оруулалт, хүн ам зүйн өөрчлөлт болон нийгмийн дэд бүтцийн шаардлагуудтай холбоотой хуримтлагдсан нөлөөллүүд үүсч байна.

#### 7.2.1 Өмнөх хийгдсэн ажил

Төслийн бүсэд өмнө хийгдсэн том бүтээн байгуулалт нь орон нутгийн хөгжилд хийсэн хөрөнгө оруулалт, худалдан авалт болон орон нутгийн ажиллагсдын цалин, татвар болон ашигт малтмалын төлбөрөөр дамжуулан тухайн бүс нутаг болон үндэсний хэмжээнд эдийн засгийн томоохон хөрөнгө оруулсан Бороо Гоулд төсөл юм. Энэ Төсөл нь орон нутгийн иргэдийг 10 жилийн турш тогтвортой ажлын байраар хангаж, уул уурхайн олон улсын стандартын сургалтанд хамруулсан. Уурхайн хаалтын үе шатны нийгмийн эрсдэлийн үнэлгээний судалгааны (2014) дагуу уурхайн хаалтын үе шатанд ажиллаж буй ажиллагсдын төлөвлөгөө: тэтгэвэрт гарах, өөр уурхайд ажил хайж очих, эсвэл амралтаа авч цаашид Гацууртын төсөлд ажил гармагц үргэлжлүүлэн ажиллах зэрэг өөр өөр байсан<sup>224</sup>.

<sup>224</sup> Бороо Гоулд уурхайн хаалтын үе шатны нийгмийн нөлөөллийн үнэлгээ (2014).

### 7.2.2 Эдийн засгийн хөрөнгө оруулалт

Сентеррагийн төслийн эдийн засгийн хөрөнгө оруулалт төслийн бүсэд чухал ач холбогдолтой байна гэж үзэж байгаа. Бороо Гоулд уурхайн хаалтын үе шатны нийгмийн эрсдэлийн үнэлгээгээр (2014) Бороо Гоулд уурхайн Баянгол сумын нийгмийн даатгалд оруулсан хувь нэмэр нь сарын 19-23 сая төгрөг буюу суманд төлөгдөх нийгмийн даатгалын нийт дүнгийн 60-70 %-ийг эзэлж байсан (тухайн байгууллагад ажиллаж буй хүний тоо болон цалингийн түвшинг харуулсан) гэж гарсан байна. Мандал сумын гол ажил олгогч байгууллагуудад төрийн захиргааны байгууллага (сум дундын эмнэлэг, цагдаа зэргийг багтаасан), шорон (78 ажилтантай), ЭмСиЭс компанийн спиртний үйлдвэр (200 ажилтантай) болон төмөр зам (1 000 ажилтантай) орж байна. Суманд нийт оршин суугчдын 30%-ийг ажлын байраар хангасан, дунджаар тус бүр 8 ажилтантай 130-140 ЖДҮ байна. Мандал суманд 208 өөр төрлийн бусад аж үйлдвэр, Баянгол суманд 80 өөр төрлийн бусад бизнесүүд байна (Сентеррагаас гадна). Аймагт хайгуулын болон уурхайн үйл ажиллагаа байгаа (жишээбэл нүүрс, төмрийн орд гэх зэрэг) боловч эдгээр нь Баянгол суманд байхгүй<sup>225</sup>. Төслийн бүсэд ажлын байрнууд байгаа хэдий ч шинээр бий болж буй ажлын байрны тоо буурч, ажилгүйдэл нэмэгдэх хандлагатай байна. Сэлэнгэ аймагт шинэ ажлын байрны тоо 2013-2014 онуудын хооронд 8.2%-иар буурсан, Мандал суманд 3.3%-иар буурсан байна. Харин Баянгол суманд энэ хугацаанд шинэ ажлын байрны тоо 17.7%-иар (93 шинэ ажлын байр) өссөн байна. Сэлэнгэ аймагт 2012-2014 онуудын хооронд ажилгүйдэл 67.4%-иар өссөн. Сэлэнгэ аймгийн төмөр зам, авто замаар холбогдсон байдал, зах зээлтэй ойрхон байршилтай, усны хангамж сайнтай, эдийн засгийн идэвхтэй хүн ам ихтэй бодит орчин нь цаашид эдийн засгийн хөрөнгө оруулалтыг хүлээж авахад бэлэн байгааг харуулж байна.

### 7.2.3 Уламжлалт амьжиргаа

Гацууртын уурхайн бүтээн байгуулалт, Сэлэнгэ аймгийн ирээдүйн уул уурхай, газар тариалан болон аж үйлдвэрийн төслүүдийн барилга болон ашиглалтын болзошгүй үйл ажиллагаа нь бизнесүүдийг дэмжиж, үйлчлэх салбарт олон төрлийн ажлын байрыг бий болгох магадлалтай. Орон нутгийн ажиллагсдад хөдөлмөр эрхлэлтийн сайжирсан боломжуудыг бий болгохоос гадна хөдөө аж ахуйн уламжлалт амьдралын хэв маягийг хадгалж үлдэхэд тодорхой бэрхшээл үүснэ. Аж үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтын боломжууд болон холбогдох дэд бүтцийн шаардлагууд нь одоогийн бэлчээрийн газарт нэмэлт ачаалал өгч, малчдын орлогыг бууруулан, цаашлаад мал аж ахуйн орлогын эх үүсвэрээс татгалзахад хүргэж магадгүй. Хэрэв энэ нь бэлчээрийн доройтолд хүргэвэл бэлчээрийн газарт үүсэх ачаалал нь улам ихсэх болно. Үүнээс гадна, малчид мал маллахаас илүүтэйгээр уурхайд ажиллах эсвэл тэд малаа орхиж хот суурин газар руу нүүх сонголтыг гаргаж болно (Монгол Улсын одоогийн хотжилтын чиг хандлагаас үүдэлтэй). Хэрэв энэ нь бага хэмжээгээр тохиолдвол бэлчээрийн доройтолыг тэнцвэржүүлэх нөлөө үзүүлж магадгүй юм. Гэсэн хэдий ч, цалингийн зөрүүтэй байдал, бэлчээрийн их хэмжээний доройтол зэрэг нь малчдад нөлөөлж мал аж ахуйгаа орхиход хүргэхээс гадна, цаашлаад тухайн бүсийн соёлд байнга их хэмжээний нөлөөлөл үзүүлэх болно. Уламжлалт амьжиргааг хадгалж үлдэхтэй холбоотой дарамт нь Монгол Улсад өнөөдөр олон төрлийн бэрхшээлийг бий болгож байна. Энэ нь улс даяр

<sup>225</sup> Бороо Гоулд уурхайн хаалтын нийгмийн нөлөөллийн үнэлгээ (2014).

өссөн нэмэгдэж буй хотжилтын чиг хандлага, мөн залуучуудын өмнө тулгарч байгаа харьцуулшгүй өөр амьжиргааны боломжууд болон сонголтуудаас хамааралтай байна.<sup>226</sup>

#### **7.2.4 Орон нутаг руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн ба нийгмийн дэд бүтэц**

Төслийн үйл ажиллагааны явцад эдийн засгийн боломж хайсан худалдаа, арилжааны хүмүүс шилжин ирж болох хэдий ч Мандал суманд ерөнхийдөө гадагш чиглэсэн шилжилт хөдөлгөөн давамгайлах чиг хандлагатай байна. Сэлэнгэ аймаг руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн буурсан явдлыг бэлчээрийн даац хэтэрсэнээс болж газрын доройтол үүсэж, бэлчээрийн газрын хүртээмж муудаж, шилжин ирэгсдийн сонирхолыг татахаа больсонтой холбон тайлбарлаж болох юм. Оролцогч талууд нь бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан болон уул уурхай зэргийн хамтран оршин тогтнох асуудал бүхий газар ашиглалтын хуримтлагдсан нөлөөллийг авч хэлэлцэх хамтарсан уулзалтуудад оролцож малчид, иргэд болон Сентеррагийн хоорондын харилцааг бэхжүүлэх хэрэгцээ байгаа гэдэг асуудлыг сөхөн гаргаж ирсэн байна.

Суурь судалгаанаас харахад Мандал сумын хүн ам шигүү төвлөрсөн байгаа нь нийгмийн дэд бүтэц болон үйлчилгээнд дарамт үүсгэж, ажил хайж буй ажилгүй болон цагийн ажилтай хүмүүсийн тоог нэмэгдүүлж байна. Төслийн бүс нутагт ажилгүйдэл томоохон асуудал болж байгаа (Сэлэнгэ аймагт 2012-2014 онуудад 67.4%-иар нэмэгдсэн) ба энэ нь ялангуяа Түнхэл багийн залуучуудад илүү мэдрэгдэж байна.

Төсөл нь ажилгүйдлийг бууруулах тал дээр хувь нэмрээ оруулж, Сум хөгжлийн сангаар дамжуулан шинэ бизнес болон бизнесийн боломжуудыг дэмжин орон нутгийн хөгжилд хөрөнгө оруулалт хийнэ. Мандал суманд хэд хэдэн томоохон ажил олгогч байгууллагууд байгаа нь үйлчлүүлэгчдэд суурилсан үйлчилгээг төрөлжүүлэх замаар илүү тогтвортой зах зээлийн боломжуудыг бий болгох тал дээр хамтран ажиллах боломжуудыг бий болгож байна. Үүний зэрэгцээ, Мандал сумын иргэд хувиараа хөдөлмөр эрхлэх сонирхолтой байгаа нь бүсэд ЖДҮ шинээр эхлэх хандлага байгааг харуулж байна. Судалгаагаар Зүүнхараагийн нийтийн хэрэглээний замын бүтээн байгуулалт нь төслийн бүсэд зах зээлийн шинэ боломж болон мөнгөний урсгалыг бий болсоныг харуулж байгаа боловч хүний амь, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор зам ашиглалттай холбоотой урт хугацааны хуримтлагдсан нөлөөллийг замын аюулгүй байдлын үр дүнтэй арга хэмжээтэй хамтад нь зохицуулах нь зүйтэй. Төсөл нь өөрийн шууд худалдан авалт, мөн хүний нөөцөд нийгмийн хөрөнгө оруулалт хийх замаар ажилгүй, цагийн ажилтай хүмүүс болон сумын захиргаанд дэмжлэг үзүүлэх замаар хүн амын шинэ өсөлтийг дэмжих боломжтой юм.

#### **7.2.5 Хуримтлагдсан нөлөөллийн дүгнэлт**

Гацууртын төслийг хэрэгжүүлснээр төслийн бүс нутагт одоогийн байгаа бэрхшээлүүдтэй уялдсан эерэг болон сөрөг хуримтлагдсан нөлөөллүүд үүснэ. Эдгээрт нь шинэчлэл, хөгжлийн үед уламжлалт амьжиргаа, амьдарлын хэв маягийг хадгалахтай холбоотой бэрхшээлүүд; өөрчлөгдөж буй хүн амын дэд бүтцийн үйлчилгээ болон хүн амын өөрчлөгдсөн эрэлт хэрэгцээнд нийцсэн нийгмийн үйлчилгээ үзүүлэх, эмэгтэйчүүдийг бодвол боловсрол доогуур залуучууд, тогтмол цалинтай ажил хийхээс илүүтэйгээр хувиараа хөдөлмөр эрхэлж буй бүлэг бүхий одоогийн ажилгүй болон цагийн ажилтай хүн амын эдийн засгийн боломжуудыг бүрдүүлэх явдал юм.

<sup>226</sup> Састэйнабилити Ийст Эйжия ХХК. 2014. Монгол дахь уул уурхайн салбарын байгаль орчин болон нийгмийн стратегийн үнэлгээ

Төслийн бүс нь хамтран ажиллах боломж хайж байгаа, эдийн засгийн боломжоо нэмэгдүүлж, ашиг хүртэж байгаа хүмүүст зориулж төрөлжсөн бизнесүүдийг санал болгож байгаа хэдий ч Төсөл нь эдгээр хуримтлагдсан нөлөөллийг хамтран зохицуулж, дотогш ба гадагш чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг үр дүнтэй хянаж байх зорилгоор Баянгол, Мандал сумдын засаг захиргаатай хамтран ажиллахаар төлөвлөсөн байна. Төсөл нь уламжлалт амьжиргаанд үзүүлэх нөлөөллийг оролцогч талуудад тохирсон оролцооны болон нийгмийн хяналт шинжилгээний үйл ажиллагаагаар зохицуулахаар төлөвлөж байна. Төсөл нь орон нутгийн эдийн засгийн хөгжилд эерэг хувь нэмэр оруулж, хөдөлмөр эрхлэлтийн боломжуудыг сайжруулан, бүс нутгийн хүний нөөцийг нэмэгдүүлэх боломжтой байна.

## **8. НИЙГМИЙН МЕНЕЖМЕНТИЙН ХАМРАХ ХҮРЭЭ**

### **8.1 ОРШИЛ**

Энэ бүлэгт Нийгмийн менежментийн хамрах хүрээний бүтцийг тоймлон харуулсан бөгөөд үүнийг Монгол Улсын Засгийн газраас Гацууртын төслийг батласны дараа бүрэн утгаар нь эцэслэн боловсруулагдана. Тэр болтол уг хамрах хүрээ болон Нийгмийн менежментийн төлөвлөгөө (НМТ) нь бүрэн боловсруулагдаж дуусаагүй гэж үзэж байна. Нийгмийн нөлөөллийн үнэлгээнд тусгасан нөлөөлөл бууруулах арга хэмжээнүүд нь Төсөл хэрэгжих нийт хугацаанд үр дүнтэй хэрэгжих ба ННҮ-г анх боловсруулж байсан үед урьдчилан таамаглаагүй нөхцөл болон бодит байдал дээр тулгуурлан тогтмол шинэчлэн, сайжруулах шаардлагатай бөгөөд үүнд Бороо Гоулд уурхайн барилга, ашиглалт болон хаалтын бүх үе шатанд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг авч ашиглах зэрэг багтана. Менежментийн тогтолцооны энэхүү хамрах хүрээнд Сентерра компанийн удирдлага, Олон нийттэй харилцах багийн зохион байгууллалтын бүтэц, мөн Сентерра компанийн одоогийн менежментийн бүтэц зэрэг багтсан болно.

### **8.2 МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО**

Бороо Гоулд компани нь Бороо Гоулд уурхайн одоогийн үйл ажиллагааг зохицуулж буй Аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд болон байгаль орчны менежментийн тогтолцоог (ААЭМБОМС) хэрэгжүүлдэг. Одоогийн байдлаар энэ нь зөвхөн Бороогийн аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд болон байгаль орчны асуудлуудыг хамарч байгаа боловч цаашдаа Гацууртын төслийн ААЭМБО-ны менежмент, нийгмийн асуудлууд, хүлээсэн үүрэг амлалт болон олон нийттэй харилцах харилцааны үүргийг (ОНХ) нэгтгэн оруулж, авч ашиглахыг санал болгож байна.

ААЭМБОМС нь Сентерра, Сентерра Гоулд уурхай болон Гацууртын төслийн одоогийн бодлого, үйл ажиллагааны баримт бичгүүдийн шатлалд (Зураг 8.1-т үзүүлсэн) нийцэж байна. Уг шатлал нь компанийн бодлого болон төслийн байгаль орчин, нийгмийн тогтвортой хөгжлийн бодлого, журмын хэрэгжилт хоорондын харилцааг харуулж байна.

Шатлалын хамгийн дээд түвшинд Сентерра компанийн ААЭМБО болон тогтвортой байдлын тал дээр хүлээсэн үүрэг, амлалтыг компанийн бодлогоор тодорхой болгосон (жишээ нь Хүснэгт 3.2-т тайлбарласан Стандартын тухай номонд тодотгосон) ба энэ нь цаашид ААЭМБОМС-д Гацууртын төслийн хүлээсэн үүргүүдийг оруулна.

Өргөн хүрээтэй байгаль орчны менежментийн хөтөлбөр нь Байгаль орчны менежментийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ба нийгмийн үйл ажиллагааны менежментийн хөтөлбөрийн бодлогын үүрэг хариуцлагыг Нийгмийн менежментийн жилийн төлөвлөгөөгөөр дамжуулан хэрэгжүүлэх юм. Үйл ажиллагааны стандарт журмын (ҮАСЖ) багцууд нь менежментийн төлөвлөгөөний суурь болсон ба хяналт, хяналт - шинжилгээний аргачлалын зааварчилгааг багтаасан байна.

Сентерра Гоулд ХХК нь дотоод аудит болон БГК-ийн нэгдэн орсон Олон улсын цианидын менежментийн хүрээлэнгийн кодын дагуу Байгаль орчин, нийгмийн менежментийн тогтолцоог хянана.

#### **Зураг 8.1 Компаний бодлого, систем, төлөвлөгөө болон журмын шатлал**



Сентеррагийн БОНМС нь (Ажиллагсдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг) ISO14001: Байгаль орчны менежментийн олон улсын стандартаар батлагдсан. Энэхүү системийн дагуу нийгмийн хамгааллын зарчмуудыг авч ашигласан:

- *Төлөвлө:* нийгэмд үзүүлж болзошгүй нөлөөллийг үнэлэхээс өмнө;
- *Гүйцэтгэ:* болзошгүй нөлөөллөөс зайлсхийж, нөлөөлөл бууруулах буюу багасгах зорилготой арга хэмжээнүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх;
- *Шалга:* хэрэгжүүлж буй бууруулах арга хэмжээний үр нөлөө болон гүйцэтгэлийг хянах;
- *Арга хэмжээ ав:* засаж сайжруулах үйл ажиллагааны хэрэгжилтийг бүртгэх, аудит хийх.

Менежментийн тогтолцоо нь өөрийн үйл ажиллагаанаас нийгэмд үзүүлэх нөлөөлөл, асуудлуудыг тогтмол үнэлэх замаар гүйцэтгэлийг тасралтгүй сайжруулахыг зорьдог. Уг менежментийн тогтолцооны үндсэн бүрэлдэхүүн хэсэгт дараах багтана:

1. Хуулийг дагаж мөрдөх;
2. Эрсдлийн үнэлгээ ба менежмент;
3. Зорилго ба зорилтот тохиргоо;
4. Зохион байгуулалт, үүрэг хариуцлага;
5. Чадавхи, сургалт;
6. Харилцаа холбоо ба хэлэлцүүлэг;
7. Өөрчлөлтийн менежмент;
8. Үйл ажиллагааны хяналт;
9. Онцгой байдлын үеийн бэлэн байдал;
10. Ханган нийлүүлэгч & гэрээт гүйцэтгэгчийн менежмент;



11. Хяналт шинжилгээ ба үнэлгээ;
12. Осол болон үйл ажиллагааны менежмент;
13. Дотоод аудит;
14. Манлайлал, засаглал, хамтын ажиллагаа; ба
15. Удирдлагын хяналт.

Олон улсын стандартын байгууллага (ISO)-н шаардлагад нийцэж байгаа байдал нь системийн гадны хяналт болдог. Сентерра нь төслийн баримт бичигт Менежментийн тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг багтсан ба үүнийг шаардлагатай бол Гацууртын нарийвчилсан БОНМТ-г боловсруулж, сайжруулах замаар нэгтгэнэ.

## **8.3       НИЙГМИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

### **8.3.1     Тойм**

Менежментийн төлөвлөгөө бүр доор заасан стандарт бүтэцтэй байдаг:

- Танилцуулга;
- Хамрах хүрээ;
- Үүрэг хариуцлага (дотоод хяналт, удирдлага бүхий);
- Төслийн стандартууд;
- Нөлөөллийг бууруулах арга хэмжээ ба менежментийн хяналт;
- Хяналт шинжилгээ, аудит ба тайлагналт;
- Нөөц бололцоо, сургалт; ба
- Баримт бичгийн хяналт.

Гацууртын төслийн дотоодын эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны менежмент, байгаль орчны менежмент болон олон нийтийн харилцааны менежмент зэргийг багтаасан Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөний жагсаалтыг Зураг 8.2-д үзүүлсэн байгаа.

**Зураг 8.2 Үйл ажиллагааны чиглэлээр харуулсан Гацууртын төслийн менежментийн төлөвлөгөө**

Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны менежмент	Байгаль орчны менежмент	Олон нийтийн харилцааны менежмент
Онцгой байдлын үед авах ажиллагсдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны хариу арга хэмжээ	Биологийн олон янз байдал Ус Аюултай материал Хог хаягдал Хүчиллэг урсац зайлуулах Агаарын чанар Дуу чимээ болон чичиргээ Тээвэрлэлт Уурхайн хаалт ба нөхөн сэргээлт	Оролцогч талуудыг татан оролцуулах Гомдол барагдуулах механизм Орон нутгийн хөгжил Соёлын өв Байгалийн нөөцийн менежмент Ажил эрхлэлт ба сургалт Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа ба аюулгүй байдал Худалдан авалт ба хангамжийн сүлжээ

Бороо Гоулд компанийн одоогийн үйл ажиллагааны хүрээнд бий болсон гол менежментийн төлөвлөгөөнүүдэд:

- Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөө (2012, 2015 онд шинэчлэсэн);
- Олон нийтийн хандивын бодлого, ба
- Гомдол барагдуулах менежментийн журам (2014).

Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөө нь Нийгмийн суурь судалгаа болон Нөлөөлөх байдлын үнэлгээний дагуу шинэчлэгдсэн байна.

### 8.3.2 Төлөвлө

Нийгмийн менежментийн төлөвлөгөөг Сентерра компанийн болон олон нийттэй харилцах хэлтэс компанийн байгаль орчин, хангамж, засаглал, аюулгүй байдал, хүний нөөц зэргийн хэлтэсүүдтэй хамтран хариуцан ажиллана. Энэ багийн зарим гишүүд нь Бороо Гоулд уурхайн хаалтын хувилбарууд болон үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулан ажлыг хариуцан ажиллаж байна. Зарим ажлын байрууд Гацууртын төслийн (жишээ нь, Түнхэл багийн ОНХА) цаашдын бүтээн байшуулалтаас ихээхэн хамааралтай. Доорх хүснэгтэд компанийн болон олон нийттэй харилцах гол ажилтнуудын Гацууртын төслийн хүрээнд хүлээсэн үүрэг хариуцлагыг харуулав<sup>227</sup>:

<sup>227</sup> Сентеррагийн Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөө (2012).

### Хүснэгт 8.1 Нийгмийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үүрэг, хариуцлага

Албан тушаал	Хариуцлага
Засгийн газартай харилцах хэлтсийн захирал	Хэвлэл мэдээлэлтэй харилцах ажилтанг (2) удирдах Олон нийттэй харилцах ажилтанг (5) удирдах Засгийн газартай харилцах ажилтанг (1) удирдах Засгийн газар, аймаг, сумдын ажилтан, албан хаагчидтай харилцах
Хангамжийн сүлжээ хариуцсан захирал	Ханган нийлүүлэлтийг хариуцах Орон нутгийн ханган нийлүүлэгч бүхий ханган нийлүүлэлтийн сүлжээний харилцааг хөгжүүлэх
Хэвлэл мэдээлэлтэй харилцах албаны менежер	Хэвлэл мэдээлэлтэй тогтоосон харилцаа холбоог хариуцах Оролцогч талуудын гаргаж ирсэн мэдээлэлтэй холбоотой асуудал бүхий оролцогч талуудтай харилцах Хэвлэл мэдээлэлд өгөх гол ярилцлагыг боловсруулах Хамтарсан ажлын хэсгийн уулзалтуудын протоколыг хариуцах
Олон нийттэй харилцах албаны менежер	Суманд байрлах ОНХА-нуудыг удирдах (3) Хамтарсан ажлын хэсгийн уулзалтуудын хөтөлбөрийг боловсруулж, тайлан бичих КНХ-ын төслийн хэрэгжилт, баримтжуулалт, тайлагналтыг удирдан зохион байгуулах Нөлөөлөлд өртсөн олон нийтэд мэдээлэл хүргэх, танилцуулах, хэлэлцүүлэх уулзалтуудыг зохион байгуулах КНХ-тай холбоотой судалгаануудыг удирдан явуулах Гомдол барагдуулах механизмыг хариуцах Хамтарсан ажлын хэсгийн уулзалтуудад оролцох
Баянгол суманд байрлах ОНХА	Баянгол сумын иргэд, олон нийтийн манлайлагч нартай холбоо тогтоох Мэдээлэл хүргэх уулзалт болон хэлэлцүүлгийг зохион байгуулах Компанитай холбоотой асуудлуудын талаарх олон нийтийн санал бодлын талаар тэмдэглэл хөтлөх Нөлөөллийн бүсэд хийж буй КНХ-ын үйл ажиллагаа болон олон нийтийн санал бодлын тэмдэглэлийн сар тутмын тайланг гаргаж хүргүүлэх Хамтарсан ажлын хэсгийн уулзалтуудад оролцох
Түнхэл багт байрлах ОНХА <sup>228</sup>	Түнхэл багийн иргэд, олон нийтийн манлайлагч нартай холбоо тогтоох Мэдээлэл хүргэх уулзалт болон хэлэлцүүлгийг зохион байгуулах Компанитай холбоотой асуудлуудын талаарх олон нийтийн санал бодлын талаар тэмдэглэл хөтлөх Нөлөөллийн бүсэд хийж буй КНХ-ын үйл ажиллагаа болон олон нийтийн санал бодлын тэмдэглэлийн сар тутмын тайланг гаргаж хүргүүлэх Хамтарсан ажлын хэсгийн уулзалтуудад оролцох
Мандал суманд байрлах ОНХА	Мандал сумын иргэд, олон нийтийн манлайлагч нартай холбоо тогтоох Мэдээлэл хүргэх уулзалт болон хэлэлцүүлгийг зохион байгуулах Компанитай холбоотой асуудлуудын талаарх олон нийтийн санал бодлын талаар тэмдэглэл хөтлөх Нөлөөллийн бүсэд хийж буй КНХ-ын үйл ажиллагаа болон олон нийтийн санал бодлын тэмдэглэлийн сар тутмын тайланг гаргаж хүргүүлэх Хамтарсан ажлын хэсгийн уулзалтуудад оролцох

### 8.3.3 Гүйцэтгэ

Сургалт нь менежментийн тогтолцоог амжилттай хэрэгжүүлэх үндсэн бүрэлдэхүүн хэсэг юм. Сургалтын үндсэн шаардлагуудад:

- Барилгын үе шатны үйл ажиллагааг зохион байгуулалттай явуулах албан тушаалтнуудын үүрэг хариуцлага, хэрэглэгдэх стандартын талаар нийтлэг ойлголтыг бий болгох менежментийн зааварчилга өгөх цуглаан;

<sup>228</sup> Одоогийн байдлаар идэвхгүй үүрэгтэй; Төсөл баталж, Монгол Улсын Засгийн газартай гэрээ байгуулж дуусахаар дахин сэргээх юм.

- Төслийн болон гэрээт ажиллагсад компанийн дотоод журманд заагдсан өөрийн үүрэг хариуцлагыг ойлгож байгаа эсэхийг баталгаажуулах зааварчилгааны сургалт; ба
- Орон нутгийн иргэдийн хүсэлт, асуултанд хэрхэн хариулах талаар ажиллагсад гол асуудлуудыг ойлгож байгаа эсэхийг баталгаажуулах зааварчилгаа, мэдээлэл олгох хөтөлбөр.

### **8.3.4 Шалга**

Хяналт шинжилгээ болон аудит нь төслийн нийгмийн үүрэг амлалтуудад тусгасан төслийн зорилго, зорилтууд болон боломжит хугацааны хүрээнд Гацууртын төслийн зорилтуудад хүрсэн эсэхийг бүртгэж, үнэлэх боломж олгодог. Нийгмийн гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтийг бүртгэх зорилгоор хяналт шинжилгээний мэдээллүүдийг цуглуулдаг. Төслийн үйл ажиллагааны бүхий л үе шатуудад Сентерра болон түүний гэрээт гүйцэтгэгч нар төслийн бүсийн ойр орчим амьдардаг иргэд болон ажиллах хүчид учирч болзошгүй нөлөөллийн үнэн зөв зураглалыг гаргах нийгмийн мэдээллүүдийг цуглуулснаар тодорхой цаг хугацаанд урган гарч ирэх асуудлуудыг үр дүнтэй зохицуулж, нөлөөллийг бууруулан, удирдана.

Төсөл хэрэгжих бүхий л хугацаанд төслийн нийгмийн нөлөөлөл, гүйцэтгэлийг хэмжих үзүүлэлтүүдийг тодорхойлох зорилгоор Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүдийг нийгмийн суурь судалгаа болон нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ зэргийг ашиглан боловсруулна. Эдгээр гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүдийг нийгмийн менежментийн төлөвлөгөөтэй уялдуулахаас гадна төслийн үйл ажиллагааны явцад засварлан сайжруулах шаардлагатай. Тухайлбал, нийгмийн үзүүлэлтүүдэд:

- Орон нутгийн иргэдээс хүлээн авсан санал гомдолыг тоо;
- Оролцогч талуудыг татан оролцуулах уулзалтуудын тэмдэглэл, протокол;
- Барагдуулаагүй санал гомдлын тоо; ба
- Төслийн бүсийн олгохыг татгалзсан бичил санхүүгийн зээлийн тоо.

Сумын менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүдийг хараахан боловсруулаагүй байна.

Төслийн бүхий л үе шатуудад хийгдэх дотоодын болон хөндлөнгийн хяналт шинжилгээ, аудит нь төслийн (Сентерра, түүний гэрээт гүйцэтгэгч) байгаль орчин, нийгмийн менежментийн тогтолцооны хэрэгжилтийн нийгмийн гүйцэтгэлийг хэмжих болон нийгмийн нөлөөллийг багасгаж, боломжийг сайжруулах нөлөөлөл бууруулах арга хэмжээний үр ашгийг хэмжих зорилготой. Аудитын хуваарь нь аудитын үр дүн, асуудалтай хэсгийн үүрэг хариуцлага болон ач холбогдлыг харгалзан авч үздэг. Нийгмийн хяналт шинжилгээний төлөвлөгөө нь дараах хяналт шинжилгээний шаардлагуудыг баримтжуулах болно:

- Холбогдох нийгмийн менежментийн төлөвлөгөө;
- Хяналт шинжилгээний үүрэг хариуцлага;
- Үзүүлэлтүүд; ба
- Давтамж.

### **8.3.5 Арга хэмжээ ав**

Дээр дурьдсан үзлэг шалгалт, аудитын явцад илэрсэн аливаа зөрчлүүдийг тайланд оруулж, засаж сайжруулах арга хэмжээ авах төлөвлөгөө боловсруулна. Эдгээрийг гүйцэтгэлийн аливаа зөрчлийг цаашид арилгаж байгааг баталгаажуулах хэрэгсэл болгосноор тасралтгүй сайжруулах боломжтой.

## **9. НӨЛӨӨЛӨЛ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУРААНГУЙ**

Гацууртын төслийн уурхайн барилга, ашиглалт болон хаалтын бүхий үе шатуудын нөлөөлөл ба сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хураангуйлан Хүснэгт 9.1-д харуулав.



### Хүснэгт 9.1 Нөлөөлөл, бууруулах арга хэмжээний хураангуй

Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шинж	Бууруулаагүй үеийн ач холбогдол	Санал болгож буй гол хяналт, нөлөөлөл бууруулах, нэмэгдүүлэх арга хэмжээний тойм	Холбогдох менежментийн төлөвлөгөө & бодлого	Болзошгүй үлдэгдэл ач холбогдол
<b>Хөдөлмөр эрхлэлт (ЕСБХБ-ны ГШ 1, 2)</b>					
Уурхайн үйл ажиллагааны бүхий л үе шатуудад шууд болон шууд бус замаар ажлын байрны боломжууд бий болох	Тодорхой Шууд эерэг Урт хугацааны Дунд хэмжээнд	Дунд	<ul style="list-style-type: none"> <li>Бороо Гоулд компанийн хэрэгжүүлдэг ажилд авах шударга, ил тод үйл ажиллагаа хэрэгжүүлэх</li> <li>Орон нутгийн оюутнуудад Монголын уул уурхайн салбарын хэрэгцээг илүү сайн хангахад чиглэсэн сургалтын хөтөлбөрийг сургалтын дотоодын түншүүдтэй хамтран хүргэх</li> <li>Орон нутгаас ажиллах хүч болон сургалтын түншүүдийг сонгох зэрэг шинэчлэгдсэн материалаар ОНХА-г хангах</li> <li>Орон нутгаас давамгайл эрхээр үндсэн ажил авах бодлогыг хэрэгжүүлж, энэхүү бодлогыг гэрээт байгууллагуудад дагаж мөрдүүлэх</li> <li>Орон нутгийн иргэдийг үндсэн болон гэрээт ажилд авах тал дээр сургалтын байгууллага, засгийн газартай хамтран ажиллах</li> <li>Орон нутгийн ажиллагсдыг ажилд бэлдэх, тусгай мэргэжлийн сургалтанд хамруулах, чадавхи дээшлүүлэх зэрэг ажлыг үргэлжлүүлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хөдөлмөр эрхлэлт, сургалтын МТ</li> <li>Хөдөлмөр эрхлэлтийн бодлого</li> <li>Хөдөлмөр эрхлэлтийн МТ</li> </ul>	-
Төслийн барилга болон ашиглалтын үе шатанд уурхайн болон ажиллагсдын хэрэгцээ шаардлагыг хангах үйлчилгээ, хангамжнаас үүдэн гарах ажлын байр нэмэгдэх	Тодорхой Шууд эерэг Дунд хугацааны Дунд хэмжээнд	-	<ul style="list-style-type: none"> <li>Бизнесийн боломжийг сайжруулах үүднээс орон нутгийн жижиг бизнесүүдийг чадавхижуулах тал дээр хөрөнгө оруулалт хийх</li> <li>Гэрээнд бараа, үйлчилгээг орон нутгаас хангахыг урамшуулан, дэмжих</li> <li>Жижиг бизнесийн тогтвортой хөгжлийг дэмжих үүднээс орон нутгаас ханган нийлүүлэлт, худалдан авалт хийх боломжийг эрэлхийлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хангамжийн МТ</li> <li>Орон нутгийн хөгжлийн МТ</li> <li>Туслан гүйцэтгэгчийн МТ</li> <li>Гэрээний нөхцлүүд</li> </ul>	-
Уурхайн хаалтын үе шатанд шууд, шууд бус, мөн шинэ хөдөлмөр эрхлэлт багасгах	Тодорхой Шууд, дунд зэргийн өндөр, сөрөг Урт хугацаанд Дунд хэмжээнд	Дунд	<ul style="list-style-type: none"> <li>Цомхотголд орсон ажиллагсдад шинээр ажиллах боломж олоход туслах замаар БГК-ийн цомхотгох үйл явцыг авч ашиглах</li> <li>Цомхотголд орсон ажиллагсдад зориулан хөдөлмөр эрхлэлт/бизнес хөгжлийн боломжийн өөр эх үүсвэрийг хайхад сумын захиргаанд дэмжлэг үзүүлэх</li> <li>Хамтын гэрээнд заасны дагуу цомхотголын үйл ажиллагааны хамтын шаардлагыг хэрэгжүүлэх</li> <li>Цомхотголын нөлөөллийг бууруулах зорилгоор эмзэг бүлгийнхэнд чиглэсэн зорилтот дэмжлэгийг бий болгох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хөдөлмөр эрхлэлт ба сургалтын МТ</li> <li>Орон нутгийн хөгжлийн МТ</li> </ul>	Бага
Уурхайн болон тээврийн гэрээт гүйцэтгэгч нар үндэсний болон Сентерра компанийн хөдөлмөр эрхлэлтийн түршлагыг даган мөрдөөгүйгээс гарах эрсдэл	Боломжийн Шууд, дунд зэргийн өндөр, Сөрөг Урт хугацаанд Дунд хэмжээнд	Дунд	<ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн иргэдийг ажилд авах шаардлагуудыг тодорхой заасан сургалтын төлөвлөгөөг ил тод байлгах</li> <li>Гэрээт гүйцэтгэгчид орон нутгийн ажилд авах тодорхой заалтуудыг хангасан тодорхой шаардлагыг дурьдах</li> <li>Сентерра компанид гэрээт гүйцэтгэгчид тайлагнах шаардлагатай ба үүнд тогтмол гүйцэтгэлийн хяналтыг багтаах</li> <li>Гэрээт гүйцэтгэгчид үүрэг амлалтаа биелүүлэхгүй бол торгуулийн тухай заалт оруулах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хөдөлмөр эрхлэлт ба сургалтын МТ</li> <li>Гэрээт гүйцэтгэгчийн МТ</li> </ul>	Бага
Тохирох мэргэжилтэн хангалтгүйн улмаас ажлын байртай холбоотой орон нутгийн иргэдийн хүлээлт биелэгдэхгүй байх эрсдэл	Тодорхой Шууд сөрөг Дунд хугацааны Өргөн хүрээ хамрах	Өндөр	<ul style="list-style-type: none"> <li>НМТ-р дамжуулан орон нутгаас давамгайл эрхтэйгээр ажилд авах бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх.</li> <li>Төслийн бүсэд оршин суух тодорхой хугацаа дээр тулгуурлан орон нутгаас ажилд авах эрхийг бүрдүүлэх.</li> <li>Ажилд авах ажиллагсдын тоо, хугацаа, шаардагдах үр чадварын талаар орон нутгийн иргэдэд ОНХА дамжуулан тогтмол, ойлгомжтой байдлаар мэдээлж байх.</li> <li>Орон нутгийн иргэдийг ажлаар хангах үүднээс сургалтын байгууллагуудтай хамтран ажиллах, ажлын байрны сургалт явуулах зэрэг үр чадварын сургалтанд хөрөнгө оруулах. Төслийн хэрэгцээг хангасан үр чадварыг дэмжих сургалтын төрөл болон сурах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хөдөлмөр эрхлэлт, сургалтын МТ</li> <li>Туслан гүйцэтгэгчийн МТ</li> <li>Нийгмийн менежмент, хяналт шинжилгээний төлөвлөгөө (НММТ)</li> </ul>	Дунд

Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шинж	Бууруулаагүй үеийн ач холбогдол	Санал болгож буй гол хяналт, нөлөөлөл бууруулах, нэмэгдүүлэх арга хэмжээний тойм	Холбогдох менежментийн төлөвлөгөө & бодлого	Болзошгүй үлдэгдэл ач холбогдол
			<ul style="list-style-type: none"> <li>шаардлагатай хугацааг топорхойлох үүднээс сургалтын байгууллагуудыг татан оролцуулах.</li> <li>Бороогийн одоогийн/хуучин ажиллагсдыг боломжтой нөхцөлд удирдах албан тушаалд авч ажиллуулах, жишээ нь шинэ ажиллагсдыг сургах гэх мэт.</li> </ul>		
<b>Хөдөлмөр эрхлэлт ба ажлын байрны нөхцөл (ЕСБХБ ГШ 1 ба 2)</b>					
Хангалттай үр чадвартай ажиллах хүч олох боломжгүй байдал	Шууд, сөрөг, Дунд зэргийн өндөр, Бага хугацаанд Их хэмжээнд	Дунд	<ul style="list-style-type: none"> <li>Оролцогч талуудын харилцааг зохицуулах үүрэг, хариуцлага болон ажлын байрны шаардлага, үргэлжлэх хугацааг тодорхой болгох</li> <li>Бороогийн уурхай дээр одоо ажиллаж байгаа Монгол Улсын ажиллах хүчинд зориулсан сургалтыг үргэлжлүүлэн хийх</li> <li>Одоо ажиллаж байгаа туршлагатай, уурхайн удирдах ажиллах хүчний (БГК-аас) удирдлага дор уурхайн гэрээт ажиллах хүчийг ажиллуулах боломж</li> <li>Шинэ тоног төхөөрөмж дээр ажиллах чадвартай болгох зорилгоор одоо ажиллаж байгаа ажиллагсдыг давтан сургах (BIOX®-ийн үйлдвэр)</li> <li>Үндэсний түвшинд ажиллах хүч олдохгүй тохиолдолд гадны мэргэжилтнүүдийг тодорхой хугацаанд ажиллуулах</li> <li>Удирдах/ахлах түвшний ажиллагсдыг ажилд авахдаа амжилттай төлөвлөх шаардлагатай.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хөдөлмөр эрхлэлт ба сургалтын МТ</li> <li>Гэрээт гүйцэтгэгчийн МТ</li> <li>Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөө</li> </ul>	Бага
Хөдөлмөрийн маргаан гарч болзошгүй байдал	Шууд, сөрөг, Дунд зэргийн өндөр, Бага хугацаанд Их хэмжээнд	Дунд	<ul style="list-style-type: none"> <li>Гацууртын уурхайн үйл ажиллагаанд хөдөлмөр эрхлэлт ба сургалтын менежментийн төлөвлөгөөгөөр дамжуулан орон нутгийн иргэдийг ажилд авах журам бүхий БГК ажилд авах бодлогыг хэрэгжүүлэх</li> <li>Төслийн хүрээнд шууд бус ажиллагсдыг багтаан бүх ажиллагсадтай тэгш буюу шударга зарчимтай хөдөлмөрийн гэрээг хийх, дүрэм журам сахиулах, хянадаг байх</li> <li>Гацууртын төслийн ажиллагсдыг одоо байгаа үйлдвэрчний эвлэлийн нэг хэсэг гэж үзсэн учраас Сентерра компанийн ажиллах хүчний хүрээнд нийцүүлэн БГК-ын авч хэрэгжүүлсэн хөдөлмөрийн гэрээний загварыг Гацууртын төслийн ажиллагсдад зориулан авч хэрэгжүүлэх</li> <li>Гацууртын төсөл дээр одоогийн Бороогийн уурхайд ажиллагсдын гомдол барагдуулах механизмыг хэрэгжүүлэх; бүх гэрээт ажиллагсдад наад захын Хөдөлмөрийн хуулийн шаардлагуудад нийцүүлэхийг шаардах ба үүнд Хөдөлмөрийн хуулинд нийцсэн хэд хэдэн заалттай хамтын гэрээг байгуулах, Бүх ажиллагсдад үйлчлэх хөдөлмөрийн хууль болон ЕСБХБ-ны ГШ 2 -н шаардлагуудад нийцсэн ажиллагсдын стандартын хяналтыг тогтмол хийж байх</li> <li>Тодорхойлсон шаардлагуудад нийцсэн механизмын дагуу Гэрээт гүйцэтгэгчдийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хөдөлмөр эрхлэлт ба сургалтын МТ</li> <li>Хөдөлмөр эрхлэлтийн бодлого</li> <li>Ажил эрхлэлтийн МТ</li> <li>Гэрээт гүйцэтгэгчийн МТ</li> </ul>	Бага
<b>Үндэсний болон орон нутгийн эдийн засгийн хөрөнгө оруулалт (ЕСБХБ ГШ 1 ба 2)</b>					
Төслийн ашиглалтын үе шатанд орон нутгийн худалдан авалтын үйл ажиллагаанд оролцох боломж нэмэгдэх	Тодорхой Шууд эерэг Дунд хугацааны Дунд хэмжээнд	-	<ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн ханган нийлүүлэгчдийг тохирсон орон нутгийн худалдан авалтын бодлого, менежментийн төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хангамжийн МТ</li> <li>Орон нутгийн хөгжлийн МТ</li> </ul>	-
Орон нутгийн эдийн засагт үзүүлэх төслийн нөлөөлөл нь орон нутгийн шинжтэй инфляцид нөлөө үзүүлэх	Тодорхой Шууд, дунд зэргийн өндөр Урт хугацаанд Дунд хэмжээнд	Дунд	<ul style="list-style-type: none"> <li>Одоогийн БГК-ны цалинтай дүйцэх, хөдөлмөр эрхлэлтийн зах зээл дээр өрсөлдөхүйц цалингийн хэмжээг тогтоох</li> <li>Орон нутгийн эдийн засгийн хөгжилд чиглэсэн хувилбаруудыг тодорхойлоход анхаарсан орон нутаг хөгжүүлэх хамтын ажиллагааны гэрээний санаачлагын хүрээнд тодорхой хөтөлбөрийг боловсруулах, оролцогч талуудыг татан оролцуулах ажлыг зохион байгуулах; төслийн үйл ажиллагааны үе шатанд эдгээрийг турших ба уурхайн хаалтын үе шат руу шилжих явцад эдгээр нь нэмэгдэх эсвэл өргөжинө.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хөдөлмөр эрхлэлтийн МТ</li> <li>Хангамжийн МТ</li> <li>Орон нутгийн хөгжлийн МТ</li> </ul>	Бага

Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шинж	Бууруулаагүй үеийн ач холбогдол	Санал болгож буй гол хяналт, нөлөөлөл бууруулах, нэмэгдүүлэх арга хэмжээний тойм	Холбогдох менежментийн төлөвлөгөө & бодлого	Болзошгүй үлдэгдэл ач холбогдол
			<ul style="list-style-type: none"> <li>Төслийн нөлөөлөлд өртсөн сум/багийг багтаан Орон нутгийн худалдан авах бодлогын шаардлагуудыг хэрэгжүүлэх</li> <li>Татварын нэмэгдсэн орлого, нийгмийн болон нийтийн үйлчилгээний эрэлт хэрэгцээний өсөлтийг үр дүнтэй, ил тод зохицуулах Засгийн газрын чадавхийг бэхжүүлэх санаачлагуудыг дэмжих.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн хөгжлийн МТ</li> </ul>	-
Уурхайн хаалтын үе шатанд орон нутгийн түвшинд эдийн засгийн хөрөнгө оруулалтыг бууруулснаар төслийн нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдийг их эмзэг байдалд хүргэх	Тодорхой Шууд, Дунд зэргийн өндөр, сөрөг Урт хугацаанд Дунд хэмжээнд	Дунд	<ul style="list-style-type: none"> <li>Сумын хөгжлийн сангийн үйл ажиллагааг зохицуулах зорилгоор ОНХХА гэрээний орон нутгийн хөгжлийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн хөгжлийн МТ</li> </ul>	Бага
<b>Хүн ам зүй (ЕСБХБ ГШ 1)</b>					
Орон нутгийн шинж чанартай боломжит нийгмийн дэд бүтэц болон үйлчилгээнд ирэх дарамтыг үүсгэж байгаа эрсдэлтэй ажил хайгчид нэмэгдэх	Тодорхой Шууд/шууд бус Дунд зэргийн сөрөг Урт хугацаанд Дунд хэмжээнд	Дунд	<ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн иргэдийг ажилд авах бодлого нь хүний нөөцөд тавигдах наад захын шаардлага, ажилласан туршлагыг багтаасан байх</li> <li>Орон нутагт хөдөлмөр эрхлэлтийн давуу эрхийг бий болгох зорилгоор "орон нутаг" гэдгийг тодорхойлохдоо тухайн газар нутагт оршин суугаа хугацааг харгалзах</li> <li>Төсөлд руу чиглэсэн эдийн засгийн боломж хайгчдын шилжилт хөдөлгөөнийг багасгах зорилгоор сумын албан тушаалтантай хамтран ажиллах</li> <li>Орон нутаг руу чиглэсэн шилжилт хөдөлгөөний эерэг, сөрөг нөлөөлөл болон хүн амзүйн өөрчлөлтийг сумын засаг захиргаатай хамтран хянах</li> <li>Төсөлд нөлөөллөж болзошгүй нийгмийн хэв журмын эсрэг зан байдал болон/эсвэл хууль сахиулах шаардлагуудтай холбоотой аливаа асуудлуудыг шийдэх тал дээр Засгийн газартай хамтран ажиллах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хөдөлмөр эрхлэлтийн МТ</li> <li>Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны МТ</li> <li>Орон нутгийн хөгжлийн МТ</li> </ul>	Бага
<b>Газар ашиглалт ба Амьжиргаа (ЕСБХБ ГШ 1 ба 3)</b>					
Төсөлд нийтийн хэрэглээний зам тээврийг ашигласнаар тоосжилт үүсэж газар нутаг болон амьжиргаанд төслийн нөлөөлөл нэмэгдэх	Тодорхой Шууд, дунд зэргийн өндөр, сөрөг Урт хугацаанд Бага хэмжээнд	Дунд	<ul style="list-style-type: none"> <li>Агаар мандалд ялгарах хийн хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулна. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>Тоосжилт дарагч бодисын хэрэглээ (баталсны дагуу магнийн хлорид)</li> <li>Замыг тогтмол хугацаанд нэмэлтээр хусах ажлын үед</li> <li>Хүдрийн тээврийн ачааны машинаас хүдэр унах болон тоосжилт үүсэхээс урьдчилан сэргийлж тээврийн хэрэгслийн ачааг бүтээх</li> </ul> </li> <li>Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөөний дагуу тээврийн ачааны машины хөдөлгөөний хугацаа болон даацыг мэдээлэх</li> <li>Сумын хөгжлийн сангийн санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаануудад бэлчээр/газар тариаланг сайжруулах арга хэмжээг багтаах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Агаарын хийн хаягдалын МТ</li> <li>Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөө</li> <li>Орон нутгийн хөгжлийн МТ</li> </ul>	Бага
Ойн ашиглагчид мэдэгдэхүйц нэмэгдэх замаар хууль бус ойн ашиглах боломж буурах	Тодорхой Шууд, эерэг Урт хугацаанд Бага хэмжээнд	-	<ul style="list-style-type: none"> <li>Сентерра компанийн буй харуул хамгаалалтын ажилтанууд Гацууртын төслийн ойр орчмыг тогтмол хянаж, хууль бусаар мод бэлтгэх үйл ажиллагаагаа илэрсэн тохиолдолд зогсоож, талбайгаас гаргах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөө</li> <li>Орон нутгийн хөгжлийн МТ</li> </ul>	
Төслийн үйл ажиллагааны харагдахуйц нөлөөллөл болон газрын эвдрэл нэмэгдэх	Боломжтой Шууд, дунд зэргийн өндөр Урт хугацаанд Бага хэмжээнд	Бага	<ul style="list-style-type: none"> <li>Төслийн үйл ажиллагааны ургамлан бүрхэвч хөндөх шаардлагатай газруудыг багасгах</li> <li>Гацууртын уурхайн талбайн зүүн талын нарийн хөндийг ашиглан уурхайн талбайг шалгах</li> <li>Уурхайн хаалтын үе шат хүртэл олон нийтийг Гацууртын төслийн талбайд нэвтрэхээс сэргийлэх</li> <li>Элс хайрганы карьер шинээр бий болгохоос илүүтэйгээр одоогийн ашиглаж буй карьераа өргөжүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны МТ</li> <li>Уурхайн хаалтын төлөвлөгөө</li> <li>Хөдөлмөр эрхлэлт, сургалтын МТ</li> </ul>	Маш бага

Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шинж	Бууруулаагүй үеийн ач холбогдол	Санал болгож буй гол хяналт, нөлөөлөл бууруулах, нэмэгдүүлэх арга хэмжээний тойм	Холбогдох менежментийн төлөвлөгөө & бодлого	Болзошгүй үлдэгдэл ач холбогдол
			<ul style="list-style-type: none"> <li>Элс хайрга олборлож дууссаны дараа уг карьераа нөхөн сэргээх</li> <li>Өндөр ач холбогдолтой ой бүхий газрыг дүйцүүлэн хамгаалах зорилготой мод тарих үйл ажиллагаанд төслийн бүсийн орон нутгийн иргэдийг татан оролцуулах замаар улиралын чанартай ажлын байр, орлого бий болгох.</li> </ul>		
Уурхайг хаалтын дараах Гацууртад үйл ажиллагааг дахин явуулах зорилгоор бичил уурхайчдад боломж нэмэгдэх	Боломжтой Шууд, дунд зэргийн өндөр Урт хугацаанд Бага хэмжээнд	Бага	<ul style="list-style-type: none"> <li>Уурхайн хаалтын үе шатны нийгмийн асуудалтай холбоотой үйл ажиллагааг багтаасан уурхайн хаалтын төлөвлөгөөг уурхайн хаалтын нийгмийн асуудал хариуцсан ажлын хэсэг боловсруулж, төслийн ашиглалтын үе шатаас эхлэн уурхайн хаалтыг хэрэгжүүлэх үе шат хүртэл шинэчилж, сайжруулах</li> <li>Газрын гадаргууг бичил уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнөх байдалд хүргэх байдлаар хийсэн уурхайн хаалтын төлөвлөгөө, уурхайн хаалтын дараах газар ашиглалтын төлөвлөлтийг дэмжих</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Уурхайн хаалтын төлөвлөгөө</li> <li>Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөө</li> </ul>	Маш бага
<b>Боловсрол</b>					
Дотоод руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнөөс үүдэлтэй боловсролын үйлчилгээнд ачаалал нэмэгдэх	Боломжийн Шууд бус, дунд зэргийн бага, сөрөг Урт хугацаанд Дунд хэмжээнд	Дунд	<ul style="list-style-type: none"> <li>Төслийн үйл ажиллагааны бүхий л хугацаанд шаардлагатай хүний нөөцийн дэлгэрэнгүй шаардлага, цаг хугацааг багтаасан одоогийн Гацууртын уурхайн тусгай шаардлагуудыг тусгасан сургалтын төлөвлөгөөг шинэчлэх</li> <li>Төслийн барилга, олборлолтын үе шатанд шаардлагатай үр чадвартай ажиллагсдыг төслийн бүсээс давуу эрхтэйгээр ханган нийлүүлэх, уурхайн барилга, ашиглалтын үе шатны ажиллагсдад ажлын байрны бэлэн байдлын сургалтуудыг явуулах чиглэлээр МУСТ-үүдийг татан оролцуулах</li> <li>Уурхайн барилга, ашиглалт болон хаалтын үе шатуудад ажиллах Түнхэл баг, төслийн бүсийн өндөр чадавхтай төгсөгчдөд чиглэсэн төслийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сэдвээр суралцах явдлыг дэмжих тэтгэлэгт хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлэх</li> <li>БГК-нийн ажилд авах бодлогыг Монгол Улсын хууль тогтоомж, Хөдөлмөрийн тухай хууль болон салбарын бусад сайн туршлагатай нийцэж байгаа эсэхийг хянан шалгах</li> <li>Орон нутгийн иргэдийг ажилд эрэмбэлэн авах боломжийг сайжруулах арга хэмжээг боловсруулах зорилгоор төслийн бүс нутгийн үр чадварын орхигдол багтаасан төслийн сургалтын төлөвлөгөө болон үр чадварын хэрэгцээг зураглан гаргах. Үүнд төслийн бүсийн ажилтай хүмүүсийг (ялангуяа эмэгтэйчүүд) хянах механизм багтана.</li> <li>Уурхайн ашиглалтын үе шатанд салбартай танилцах үйл явцыг дэмжихийн тулд сургууль, МУСТ болон их дээд сургуулиудтай хамтран ажиллах</li> <li>Уурхайн барилгын үе шатанд тавьсан зорилгын дагуу орон нутгийн иргэдийг ажилд түлхүү авах бодлого төслийн хэрэгцээнд нийцэж байгаа эсэхийг баталгаажуулсан сургалтын төлөвлөгөөг боловсруулж, хянах</li> <li>Ажиллах хүчний сургалтын (танхимын болон гуравдагч талын) үр дүнг хянаж, шаардлагатай тохиолдолд, сайжруулах арга хэмжээг авах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хөдөлмөр эрхлэлт ба сургалтын МТ</li> <li>Олон нийтийн хөгжлийн МТ</li> <li>Гэрээт гүйцэтгэгчийн МТ</li> <li>Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөө</li> </ul>	Бага
<b>Эрүүл мэнд (EBRD PR 1, 4)</b>					
Дотоод руу чиглэсэн шилжих хөдөлгөөний эрсдэлээс үүдэлтэй эрүүл мэндийн үйлчилгээнд ачаалал нэмэгдэх	Боломжийн Шууд бус, дунд зэргийн бага, сөрөг Урт хугацаанд Дунд хэмжээнд	Дунд	<ul style="list-style-type: none"> <li>Сентерра компанийн бүх ажиллагсад болон гэрээт гүйцэтгэгчид нь ажлын байртай холбоотой асуудал, осол гэмтэлийн үед орон нутгийн эрүүл мэндийн үйчилгээгээс хараат бус эрүүл мэндийн зохих үйлчилгээ авч байгаа эсэхийг баталгаажуулах.</li> <li>Төсөл нь эрүүл мэндийн үйлчилгээний салбарт тогтвортой, хөрөнгийн бус хөрөнгө оруулалт хийх боломжтой арга замыг тодорхойлохын тулд, орон нутгийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдтай хамтран ажиллах замаар шилжих хөдөлгөөнөөс эрүүл мэндийн үйлчилгээнд үзүүлж болзошгүй ачааллыг багасгах</li> <li>Эрүүл мэндийн дэд бүтэц, үйлчилгээг сайжруулж, хянаж ажиллах тал дээр Засгийн газар болон орон нутгийн захиргаатай хамтран ажиллах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хөдөлмөр эрхлэлт ба сургалтын МТ</li> <li>Эрүүл мэнд, аюулгүй байдлын МТ</li> <li>Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөө</li> <li>Олон нийтийн хөгжлийн МТ</li> </ul>	Бага

Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шинж	Бууруулаагүй үеийн ач холбогдол	Санал болгож буй гол хяналт, нөлөөлөл бууруулах, нэмэгдүүлэх арга хэмжээний тойм	Холбогдох менежментийн төлөвлөгөө & бодлого	Болзошгүй үлдэгдэл ач холбогдол
Шинэ уурхайд ажиллах ажиллагсдын осол, гэмтэл эсвэл амь насанд аюултай байдалд өртөх эрсдэл нэмэгдэх	Боломжит Шууд, их сөрөг Богино хугацааны Өргөн цар хүрээтэй	Өндөр	Бороогийн уурхайд хэрэгжүүлж буй арга хэмжээг Гацууртын уурхайд авч хэрэгжүүлэх: <ul style="list-style-type: none"> <li>Ажлын эхний саруудад ажиллагсад болон гэрээт гүйцэтгэгч нарыг зааварчилгаа, сургалт болон удирдамжаар хангаж ажиллуулах, мөн тэдгээрийг давтан сургалтанд тогтмол хамруулах</li> <li>Уурхайн талбай, болзошгүй аюул, мөн ажил хийж гүйцэтгэх хугацаанд гарах аюул, тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд шаардагдах уурхайн арга барилтай танилцаж, сурах сургалтын журам хэрэгжүүлж, ур чадварыг шалгах</li> <li>Шинэ ажил, үйлдвэр, систем тус бүрт эрсдэлийн үнэлгээ хийх</li> <li>Гүйцэтгэгчийн менежментийн шаардлага нь гэрээний хугацаанд зөрчил тус бүрийн хариуд авах арга хэмжээ авах/торгууль тавих зэргээр хөдөлмөр хамгааллын хамгийн доод түвшинг хангасан байх,</li> <li>Хөдөлмөрийн гэрээ хийхээс өмнө ур чадварыг урьдчилан шалгаж баталгаажуулсан байх</li> <li>Зааварчилгаа, өдөр тутмын аюулгүй ажиллагааны зааварчилгаа, сар тутмын аюулгүй ажиллагааны гүйцэтгэлчийн удирдлагын үүлзалт зэргийг ашиглан гэрээний гүйцэтгэлд хяналт тавих</li> <li>Шинэ материал тус бүр Хор аюулын лавлах мэдээлэлтэй байх, BIOX® байгууламжийн давтан, шинэ сургалтуудыг ажилтнуудад зориулж явуулах, мөн BIOX® байгууламжийн аюулгүй ажиллагааны журам боловсруулах</li> <li>Онцгой байдлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэн тогтмол сургалт явуулах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Зааварчилгааны төлөвлөгөө</li> <li>Хөдөлмөр эрхлэлтийн МТ</li> <li>Ажиллагсдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны МТ</li> <li>Туслан гүйцэтгэгчийн МТ</li> <li>Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны хяналт шинжилгээний төлөвлөгөө</li> <li>Ажиллах зөвшөөрөл бүхий журмууд</li> </ul>	Дунд
Төслийн бүсийн ажиллагсад, онцгой байдлын ажиллагсад, засгийн газрын агентлаг болон орон нутгийн хүмүүст нөлөөлөх урьдчилан тооцоолоогүй гэнэтийн осол аюулын эрсдэл	Боломж бага Шууд, их сөрөг Богино - дунд хугацааны Бага болон дунд хэмжээнд	Өндөр	Бороогийн уурхайд хэрэгжүүлж буй арга хэмжээг Гацууртын уурхайд авч хэрэгжүүлэх: <ul style="list-style-type: none"> <li>Сентеррагийн одоо хэрэгжүүлж буй Хямралын менежментийн төлөвлөгөө, онцгой байдлын төлөвлөгөөг Гацууртын уурхайн нөхцөл байдалд тохируулж боловсруулах</li> <li>Онцгой байдлын үед авах арга хэмжээг онцгой байдлыг хариуцсан байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх</li> <li>Компани цианид худалдан авах, тээвэрлэх, хадгалах, хэрэглэх, устгах үйл ажиллагаандаа олон улсын аж үйлдвэрийн стандартыг хангаж ажиллаж байгааг баталгаажуулахын тулд цианид үйлдвэрлэх, тээвэрлэх, ашиглах явцад хэрэгжүүлдэг олон улсын Цианидын менежментийн кодыг (ICMC) үргэлжлүүлэн мөрдөх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Онцгой байдлын МТ</li> <li>Аюултай материал МТ</li> <li>Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын МТ</li> </ul>	Дунд
Бороогийн уурхай дахь боловсруулах байгууламж буюу Гацууртын уурхайн байгууламжийг ашиглахтай холбоотой орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд ирэх аюул	Боломжийн Шууд, гол сөрөг Урт хугацаанд Бага хэмжээнд	Өндөр	Бороогийн уурхайд хэрэгжүүлж буй арга хэмжээг Гацууртын уурхайд авч хэрэгжүүлэх: <ul style="list-style-type: none"> <li>Тэсэлгээний нөлөөллийг багасгах зорилгоор уурхайн идэвхтэй бүсээс орон нутгийн иргэдийг холдуулах</li> <li>Орон нутгийн иргэдийг хориотой бүс рүү зөвшөөрөлгүй оруулахгүйн тулд харуул хамгаалалтын ажилтнуудаар хамгаалуулах</li> <li>Бүх орц/гарц, уурхайн талбайн хил хязгаар / хашааны гадна тэмдэг, тэмдэглэгээ байршуулах</li> <li>Уурхайн талбайн ойр орчим, дотор, гаднах аюулгүй ажиллагааны гол асуудлуудын талаар оролцогч талуудад тогтмол мэдээлж байх</li> <li>Уурхайн талбайг танилцуулах сурталчилгааны хөтөлбөрийн хүрээнд зочдыг авчрахдаа харуул хяналт, аюулгүй байдлыг хангах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны МТ</li> <li>Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөө</li> <li>Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын МТ</li> </ul>	Дунд
Ажиллагсад болон олон нийтийн хооронд БЗХӨ болон халдвар өвчний тархалтын эрсдэл нэмэгдэх	Боломжийн Шууд бус, дунд зэргийн бага Сөрөг Урт хугацаанд Дунд хэмжээнд	Дунд	<ul style="list-style-type: none"> <li>Хөдөлмөрийн/түр гэрээгээр ажиллагсад болон гэрээт ажиллагсдыг ажилд авахаас өмнө эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулах</li> <li>Ажиллагсад эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөхдөө БЗХӨ болон бусад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалтыг тогтмол хийх.</li> <li>Төслийн эрүүл мэндийн багтай хамтран уурхайн талбай дээр ажиллах шууд болон гэрээт ажиллагсад боловсрол, мэдлэг олгох зохих сургалтуудыг зохион байгуулах</li> <li>БЗХӨ болон бусад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн орон нутгийн нийгмийн эрүүл мэндийн кампанит ажлуудыг дэмжих боломжийг тодорхойлох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эрүүл мэнд, аюулгүй байдлын МТ</li> <li>Хөдөлмөр эрхлэлтийн МТ</li> </ul>	Бага

Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шинж	Бууруулаагүй үеийн ач холбогдол	Санал болгож буй гол хяналт, нөлөөлөл бууруулах, нэмэгдүүлэх арга хэмжээний тойм	Холбогдох менежментийн төлөвлөгөө & бодлого	Болзошгүй үлдэгдэл ач холбогдол
Гацуурт болон Бороогийн уурхай хоорондын нийтийн хэрэглээний зам дээр, мөн төслийн болон нийтийн хэрэглээний зам ашиглах явцад замын хөдөлгөөнөөс үүдэлтэй осол, гэмтэл гарах эсвэл амь насаа алдах эрсдэл	Тодорхой Шууд, Их сөрөг Дунд хэмжээнд Урт хугацаанд	Өндөр	<ul style="list-style-type: none"> <li>Уурхайн кемпийн эргэн тойронд биеэ үнэлэх явдлыг хориглосон бодлогын дагуу биеэ үнэлэгч авсан аливаа ажилчныг ажлаас нь нэн даруй халах</li> <li>Төслийн ажиллагсад, гэрээт ажилчдад үр ашиг бүхий Төслийн бүхийн үе шатуудын тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжүүдийг зохицуулах стратеги бүхий Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх</li> <li>Төсөл хэрэгжүүлэх хугацаанд хайрган замыг ашиглахад Төслийн болон нийтийн хэрэглээний замын хөдөлгөөний явцад хурд хэтрүүлэхээс үүсэх ослыг багасгах</li> <li>Замын ослоос урьдчилан сэргийлэх үүднээс замын тусгай технологийн хяналтыг боловсруулж, хэрэгжүүлэх</li> <li>Ослыг бууруулах үүднээс одоогийн Бороогийн уурхайн жолоочийн хяналтыг авч хэрэгжүүлэх.</li> <li>Учирч болзошгүй ослыг бууруулах тал дээр замын аюулгүй ажиллагаа, замын хөдөлгөөний аюулгүй байдлын кампанит ажлыг Монгол Улсын Засгийн газартай хамтран боловсруулж, хэрэгжүүлэх.</li> <li>Ослыг бууруулах тал дээр орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн иргэдийн Замын хөдөлгөөний МТ</li> <li>Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөө</li> <li>Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны МТ</li> </ul>	Дунд
Төслийн ажиллагсдын болон олон нийтийн дунд төслийн бүс нутагт төслийн үйл ажиллагаанд нөлөөлөх нийгмийн эсрэг зан байдал буюу нийгмийн хагарлаас үүдэлтэй эрсдэл	Эргэлзээтэй Шууд буюу шууд бүс Дунд зэргийн өндөр Дунд хэмжээнд Урт хугацаанд	Дунд	<ul style="list-style-type: none"> <li>Сайн дурын зарчмуудын хэрэглээний дотоод хяналт, хүч хэрэглэх, хүчээр оролцуулах зэрэг бие авч явах зохих байдлыг тодорхой гаргасан ёс зүйн дүрэмтэй холбоотой сургалтыг харуул хамгаалалтын ажилтнуудад зохион байгуулах</li> <li>Нөлөөлөлд өртөж болзошгүй бүх оролцогч талууд компанитай хэрхэн холбоо барих, санал гомдлоо хэрхэн гаргах (Гомдол барагдуулах журмын дагуу) талаар мэдээлэх зорилгоор оролцогч талуудыг байнга татан оролцуулах</li> <li>Ажиллагсдыг уурхайн талбай дээр ажиллах хугацаанд нь орон нутгийн иргэдтэй харилцах харилцааг багасгахын тулд тэднийг орон байраар хангах</li> <li>Арилжаа, худалдаа/эдийн засгийн боломж хайн шилжин ирэгсдийн (хүн амзүй дагуу) боломжийг багасгаснаар орон нутгийн иргэдтэй зөрчил үүсэх боломжийг хязгаарлах.</li> <li>Төслийн болон гэрээт ажиллагсдад зориулж "уурхайн кемпийн дүрэм" хэрэгжүүлэх ба уурхайн талбайгаас гадна орон нутгийн иргэдтэй харилцах явдлыг багасгаж, тэдэнтэй байнга хүндэтгэлтэй харьцаж, бие зөв авч явах сургалтыг зохион байгуулах</li> <li>Бороогийн уурхай дээр хэрэгжүүлж буй харуул хамгаалалтын боловсон хүчний түршлагыг авч хэрэгжүүлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө</li> <li>Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөө</li> </ul>	
Төсөл болон гол оролцогч талуудын хоорондох түншлэлийг бэхжүүлэх, тогтвортой олон нийтийн хөгжлийн санаачлагуудыг хэрэгжүүлэх	Эерэг Шууд Урт хугацаанд Дунд зэргийн өндөр Дунд хэмжээнд		<ul style="list-style-type: none"> <li>Харилцан зөвшилцсөн хөгжлийн төлөвлөгөөний дагуу Төслийн нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдэд зориулж сайжруулсан эдийн засгийн боломжуудыг бий болгох</li> <li>Төслийн харилцаа холбоо болон хэлэлцүүлгийн явцад Нийгмийн нөлөөллийн үнэлгээний нэг хэсэг болгон Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөөг шинэчилж, тогтмол хянах</li> <li>Уурхайн кемпийн шаардлагуудын (ажлын байран дээр бие авч явах байдал, кемпэд амьдрах шаардлагууд) хүлээлтийг зохицуулахын тулд бүх ажиллагсдад (үндэсний, орон нутгийн болон гадаад мэргэжилтнүүд) зааварчилгаа өгөх</li> <li>Орон нутгийн засаг захиргаа, иргэний нийгэм болон орон нутгийн иргэдтэй хамтран тэдгээрийн уялдаа холбоо, хэрэгжилтийн үүрэг хариуцлага, үр дүнг хангах зорилгоор Орон нутгийн тогтвортой хөгжлийн төслүүдийг боловсруулах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө</li> <li>Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөө</li> </ul>	
<b>Соёлын өв (ЕСБХБ ГШ 1 ба 8)</b>					
Төслийн талбай дахь археологийн өвийн хулгай эсхүл хохирол гарах эрсдэл	Шууд болон шууд бүс Эргэлзээтэй – боломжтой Дунд зэргийн өндөр	Дунд	<ul style="list-style-type: none"> <li>Төслийн болон гэрээт ажиллагсдын соёлын өвийн нөөцөд хүрэх боломжийг хязгаарлахын тулд Бороогийн уурхайн ажиллагсдыг уурхайн талбай дээр орон байраар хангах</li> <li>Ёс зүйн дүрмийн дагуу төслийн болон гэрээт ажиллагсдыг соёлын өв бүхий газар нутагт орохыг хориглох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Соёлын өвийн менежментийн төлөвлөгөө</li> <li>Хөдөлмөр эрхлэлтийн МТ</li> </ul>	Бага



Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шинж	Бууруулаагүй үеийн ач холбогдол	Санал болгож буй гол хяналт, нөлөөлөл бууруулах, нэмэгдүүлэх арга хэмжээний тойм	Холбогдох менежментийн төлөвлөгөө & бодлого	Болзошгүй үлдэгдэл ач холбогдол
	Эсрэг Дунд хэмжээнд Урт хугацаанд		<ul style="list-style-type: none"> <li>Соёлын өв бүхий газар нутагт хулгай гарах, өвд хохирол учрахаас урьдчилан сэргийлж соёлын өвийн шинжээчид зөвлөөгүй л бол мэдэгдэж байгаа өвийн нөөцийн талаар дэлгэрэнгүй нийтлэхгүй байх</li> <li>Чухал ач холбогдол бүхий олдворууд олдсон газрын орчимд ажил түр зогсоож, холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэх зэрэг Санамсаргүй олдворын журмыг хэрэгжүүлэх.</li> </ul>		
Орон нутгийн ач холбогдол бүхий соёлын өвийн үйл ажиллагаанд саад учруулах эрсдэл	Шууд болон шууд бус Боломжтой Дунд зэргийн өндөр Эсрэг Дунд хэмжээнд Урт хугацаанд	Дунд	<ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн соёлын өв бүхий газар нутаг, зан заншлыг үл хүндэтгэх, соёлын өвд хохирол учруулах магадлалыг бууруулах зорилгоор орон нутгийн мэргэжлийн шинжээчдийн санал бодлыг тусгасан соёлын өвийн мэдлэг олгох сургалт бүхий зааварчилгааны хөтөлбөрийг Төслийн болон гэрээт ажиллагсдад хүргэх</li> <li>Орон нутгийн ариун дагшин газар нутгаас барилгын материалыг олборлохоос зайлсхийх</li> <li>Төслийн бүхий л үе шатуудад Төслийн хүдрийн тээврийн зам ашиглах үед орон нутгийн иргэд соёлын өвд чөлөөтэй хүрж буйг баталгаажуулах.</li> <li>2015 оны судалгааны дагуу Төсөл нь аливаа газар шорооны ажил эхлүүлэхийн өмнө Монгол Улсын ШУА-ийн харьяа Археологийн хүрээлэнтэй зөвлөлдөх.</li> <li>Оролцогч талуудыг татан оролцуулах болон гомдол барагдуулах үйл явцыг хэрэгжүүлэх</li> <li>Бэлчээрийн газрын стратегийг боловсруулах, хэрэгжүүлэх</li> <li>Орон нутгийн соёл, уламжлалыг бэхжүүлэх, хадгалан хамгаалах болон орон нутгийн соёлын арга хэмжээг дэмжихийн тулд олон нийтийн бүлгүүдийг болон сумын засаг захиргаатай түншилж, хамтран ажиллах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Соёлын өвийн менежментийн төлөвлөгөө</li> <li>Хөдөлмөр эрхлэлтийн МТ</li> </ul>	Бага

## **ХАВСРАЛТ А**

### **СУУРЬ СУДАЛГААНЫ НЭМЭЛТ БИЧИГ БАРИМТ**

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Сэлэнгэ *аймгийн* танилцуулга, 2015 оны 5-р сар, хуудас 37 – 39.

Кэйн, Ай. Шлэгэр, Эй. Али, С. Кэмп, Д. Мкинтайрэ, Н. МкКенна, П. Лэчнер, А. Далайбуян, Б. Лахири-Дат, Булович, Н. (2015). Монгол Улсын хариуцлагатай уул уурхай: Эерэг оролцоо сайжруулах. Тогтвортой Ашигт малтмалын хүрээлэн: Брисбан.

Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулах судалгааны эмхтгэл, 2012, хуудас 210.

УУНХТ, С. (2014 оны гуравдугаар сарын 14). Монгол Улсын товч түүх. Куисландын их сургуулийн Уул уурхайн нийгмийн хариуцлагын төв: <https://www.csr.uq.edu.au/mongolia/history>

Европын Сэргээн босголт, хөгжлийн банк. 2014. Байгаль орчин, нийгмийн бодлого. <http://www.ebrd.com>.

Эрнст & Янг. (2012/13). Монгол Улсын уул уурхай, татварын гарын авлага.

2009 оны Өрхийн түүвэр судалгаа, хуудас 1.

Олон улсын санхүүгийн корпораци. 2012. Байгаль орчин, нийгмийн тогтвортой бодлого. [www.ifc.org](http://www.ifc.org).

Олон улсын санхүүгийн корпораци. 2012. Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн стандарт. [www.ifc.org](http://www.ifc.org).

Олон улсын санхүүгийн корпораци. 2007. Байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны удирдамж. [www.ifc.org](http://www.ifc.org).

Олон улсын валютын сан, 2015. ОУВС-ийн тайлан No.15/109.

Жамсранжав С. 2009. Монгол Улсын Тогтвортой бэлчээрийн менежмент: Малчдын бүлгийн үүрэг.

Экваторийн зарчим III. 2013. [www.equator-principles.com](http://www.equator-principles.com).

Сэлэнгэ *аймгийн* Байгаль орчны хэлтэс. 2015. Сэлэнгэ *аймгийн* усны эх үүсвэрийн жагсаалт.

Монгол Улсын иргэнд газар эзэмшүүлэх тухай хууль, Зүйл 4.1.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль (2012).

Газрын төлбөрийн тухай хууль (1997).

Засаг даргын тамгын газар (2015). Сэлэнгэ *аймгийн* Нийгэм – эдийн засгийн үзүүлэлт, 2014, Сэлэнгэ *аймгийн* Засаг даргын тамгын газар.

Мандал *сумын* ИТХ тэргүүлэгчдийн тогтоол #256.

Мандал *сумын* Нийгэм – эдийн засгийн статистикийн мэдээ, 2014.

Шинжлэх ухааны академи (2015). Гацууртын орд, түүний орчны бүсэд хийсэн угсаатны зүйн судалгаа.

ҮСХ (2012). 2010 оны хүн ам, орон сууцны тооллогын нэгдсэн үр дүн, Сэлэнгэ *аймаг*, Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, Улаанбаатар.

ҮСХ, НҮБХХ (2012). Монгол Улсын хүн ам, орон сууцны тооллого дээр үндэслэн гаргасан 2010 оны ядуурлын зураглал, Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Улаанбаатар.

ҮСХ (2015). Сэлэнгэ *аймгийн* статистикийн эмхэтгэл, 2014, Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, Улаанбаатар.

ҮСХ (2015). Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2014, Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, Улаанбаатар.

ХАССТ (2000). “Залуучуудын жендерийн асуудал”, судалгааны тайлан, Хүн амын сургалт судалгааны төв, Монгол Улсын их сургууль, Улаанбаатар.

Ноён уулын археологийн олдворуудын талаархи албан ёсны мэдэгдэл. 2012.

<http://news.gogo.mn/r/83991> Роберт Л. Вондер болон Андреа Матлс Савада, редакторууд. Монгол Улс: Улсын судалгаа. Вашингтон: Конгрессийн номын сангийн GPO, 1989.

Сэлэнгэ *аймгийн* Баянгол, Мандал *сумад* гарсан замын ослын шалтгаан, нөхцөл байдлын тайлан, 2014.

Замын засвар арчилгаа, замын хөдөлгөөний аюулгүй байдал, Хурдны замын зөвлөх эдийн засагч – Б. Энхтөр, 2013.

Тогтвортой бичил уурхай төсөл. 2011. БУ-чдын амьжиргааны түвшний суурь судалгаа. хуудас 186.

Сэлэнгэ *аймаг*. Сэлэнгэ *аймгийн* Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын жагсаалт, 2007.

Сэлэнгэ *аймгийн* танилцуулга, 2015 оны 5-р сар, хуудас 46.

Мандал *сумын* Нийгэм – эдийн засгийн танилцуулга. 2014. (зөвхөн монгол хэл дээр).

Мандал *сумын* Статистикийн хэлтэс. 2014. <http://land.eic.mn/TaLandInventory>; <http://baruunkharaa.gov.mn>; Мандал *сумын* Нийгэм – эдийн засгийн танилцуулга, 2014.

Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2014, хуудас 376; Мандал *сумын* Нийгэм – эдийн засгийн статистикийн мэдээ, 2014, хуудас 62; Нийгэм – эдийн зэсгийн гол үзүүлэлт, 2014.

Састэйнабилити Ийст Эйжия ХХК. 2015. Гацууртын төслийн Нийгмийн суурь судалгааны Өрхийн судалгаа.

Састэйнабилити Ийст Эйжия ХХК. Монгол Улсын Уул уурхайн салбарын Байгаль орчин, нийгмийн стратегийн үнэлгээ. 2014.

Састэйнабилити Ийст Эйжия ХХК & Түүх, археологийн хүрээлэн, Монгол Улсын Шинжлэх ухааны академи. 2015. Гацууртын төслийн уурхайн бүсийн биет бус соёлын өвийн угсаатан зүйн судалгааны тайлан, Мандал сум, Сэлэнгэ аймаг, Монгол.

МҮСТ, 2014-2015, Мандал *сумын* статистикийн мэдээ, 2015.

НҮБ-ын Хүүхдийн сан. Монгол Улсын тойм – Статистикийн мэдээ. [www.unicef.org](http://www.unicef.org).

Аптон, С., бусад. 2013 он. Орон нутаг, газар нутаг, мал аж ахуй: Социалист нийгмийн дараах Төв Азийн Байгаль орчин ба Нийгэм. Монгол Улсын тайлан. Леверхульм сангийн судалгааны төслийн тэтгэлэг F/00 212/AI, 2010 – 2012.

Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга зам /Гарын авлага/, 2003.

<http://selenge.gov.mn/>

<http://www.1212.mn>

[http://selenge.gov.mn/index.php?option=com\\_content&view=article&id=949:2014-02-17-04-47-13&catid=46:uu&Itemid=111](http://selenge.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=949:2014-02-17-04-47-13&catid=46:uu&Itemid=111).

[http://sam.mn/info\\_en.php?url=intro](http://sam.mn/info_en.php?url=intro).

<http://mram.gov.mn/images/stories/mram/UUSH/BichilUurhai/regulation.pdf>.

[http://www.mofa.gov.mn/new/index.php?option=com\\_content&view=article&id=114&Itemid=207](http://www.mofa.gov.mn/new/index.php?option=com_content&view=article&id=114&Itemid=207).

<http://www.legalinfo.mn/law/details/216>.



# SUSTAINABILITY

EAST ASIA LLC

[http://selenge.gov.mn/index.php?option=com\\_content&view=article&id=252%3A2011-03-04-19-29-44&catid=74%3Aub&Itemid=216](http://selenge.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=252%3A2011-03-04-19-29-44&catid=74%3Aub&Itemid=216).

[http://www.selenge.gov.mn/index.php?option=com\\_content&view=article&id=1240:2014-06-30-01-54-38&catid=104:sus&Itemid=162](http://www.selenge.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=1240:2014-06-30-01-54-38&catid=104:sus&Itemid=162)

[http://www-rohan.sdsu.edu/faculty/rwinslow/asia\\_pacific/mongolia.html](http://www-rohan.sdsu.edu/faculty/rwinslow/asia_pacific/mongolia.html).

<http://www.selenge.gov.mn>.

## СУУРЬ СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

### СУУРЬ СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү Гацууртын төслийн Нийгмийн суурь судалгааны хамрах хүрээг дараах байдлаар авч үзэв:

- **Хүн ам ба хүн ам зүйн мэдээлэл:** нийт хүн амын тоо ба хүн амын өсөлтийн түвшин, хүн амын бүтэц (насны бүтэц, хүйсийн тэнцвэр), яс үндэс, хэл, бичиг үсэг тайлагдсан байдал, боловсрол ба шилжилт хөдөлгөөн бүхий хүн амын үндсэн үзүүлэлтүүд;
- **Засаглал ба нийгмийн бүтэц:** Улсын, бүс нутгийн ба орон нутгийн түвшний засаглалын зохион байгуулалт;
- **Эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт ба амьжиргаа:** Улсын ба орон нутгийн эдийн засаг, нийт ажиллах хүч, хөдөлмөр эрхлэлт, улсын, аймгийн ба орон нутгийн түвшний хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл;
- **Газар ашиглалт:** улсын, бүс нутгийн ба орон нутгийн түвшний усны нөөц, бэлчээр ба газар тариалан ашиглалт ба газар ашиглах эрх;
- **Тээвэрлэлт ба нийгмийн дэд бүтэц:** зам, агаар ба төмөр замын тээвэр, цахилгаан эрчим хүч, усан хангамж, хог хаягдалын менежментийн байгууламж, эрүүл ахуйн нөхцөл, боловсрол ба харилцаа холбооны байгууламж;
- **Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа ба аюулгүй байдал:** өвчлөл, нас баралтын төлөв байдал, халдварт, халдварт бус өвчний тохиолдол, эх хүүхдийн эрүүл мэнд, хоол хүнс, тэжээл, эрүүл мэндийн үйлчилгээний хангамж, эрүүл мэндийн даатгал ба олон нийтийн аюулгүй ажиллагаа ба аюулгүй байдал зэрэг эрүүл мэндтэй холбоотой чухал мэдээлэл; мөн
- **Соёлын өв дурсгал:** биет бус өв ба археологи, палеонтологи бүхий биет соёлын өв.

### Судалгааны бүс нутаг

Энэхүү нийгмийн суурь судалгаа нь байгаа мэдээлэл дээр үндэслэн төслийн “судалгааны бүс нутаг” буюу “Төслийн нөлөөллийн бүс”-ийг тодорхойлсон. Нөлөөллийн бүсийг нийгэм, эдийн засаг, соёлын нөхцөл байдал нь шууд буюу шууд бус нөлөөлөлд өртөж болзошгүй газар нутаг гэж тодорхойлсон. Үүнд Сэлэнгэ аймгийн Мандал, Баянгол сумдууд, ялангуяа Түнхэл баг багтсан байна.

#### Хүснэгт А1 Төслийн бүс нутаг

Суурин	Төрөл	Хүн ам	Гацууртын төслийн талбай хүртэлх зай	Бороогийн төслийн талбай хүртэлх зай
Баруунхараа	Сумын төв нь Баянгол	5,594 (1675 өрх)	Сайжруулсан замаар 76.4 км-т	Сайжруулсан, хатуу хучилттай замаар 32.8 км-т
Зүүнхараа	Сумын төв нь Мандал	25,693 (7382 өрх)	Сайжруулсан замаар 39.2 км –т	Сайжруулсан замаар 49.4 км-т
Түнхэл баг	Мандал сумын багийн төв	3,234 (923 өрх)	Сайжруулсан шороон замаар ойролцоогоор 70 км -т (Зүүнхараагаар дамжин явбал) /	Сайжруулсан шороон замаар 90 км-т





Суурин	Төрөл	Хүн ам	Гацууртын төслийн талбай хүртэлх зай	Бороогийн төслийн талбай хүртэлх зай
			сайжруулаагүй замаар 18 км-т (Балж голын дагуу явбал)	(Зүүнхараагаар дамжин явбал)
Хөдөөгийн малчин өрх	Улирлын чанартай нүүдэлдэг, хагас суурин айл өрхүүд	49 (18 өрх)	Янз бүр (<1 -с 100+км хүртэл)	Янз бүр (<1 -с 100+км хүртэл)

## Суурь судалгааны хамрах хүрээ

Суурь судалгааны хүрээнд Төсөл, төслийн нөлөөллийн бүстэй холбоотой бичиг баримтуудтай танилцаж, судалсан. Үүний зэрэгцээ, хянасан бичиг баримтыг нягтлах, төслийн нөлөөллийн бүсийг үнэлэх зорилгоор компани болон зээлдүүлэгчийн гол төлөөлөл болон гол оролцогч талуудтай Улаанбаатар хот болон Сентеррагийн төв оффис дээр хэлэлцүүлэг хийсэн бөгөөд олон нийттэй анхан шатны хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Суурь судалгааны гол үр дүн нь Нийгмийн суурь судалгааны хээрийн ажлын (үүнд, судалгааг гүйцэтгэх нарийвчилсан төлөвлөгөө багтсан) мэдээлэл өгөх Оролцогч талуудыг татан оролцуулах, мэдээлэл цуглуулах төлөвлөгөө, мөн Төслийн нөлөөллийн бүс гэж Хүснэгт А.1-т тодорхойлсон газруудын зөвшилцөл зэрэг болно.

## МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГА ЗҮЙ, ХЭРЭГСЭЛ

Нийгмийн суурь судалгааны мэдээлэл цуглуулах явцдаа тоон болон чанарын судалгааны арга зүйг авч ашигласан. Дараах аргуудыг хослуулсан хэрэглэсэн:

- **Баримт бичиг судлал, хоёрдогч мэдээлэл:** Засгийн газрын агентлаг, газруудын жилийн болон дунд хугацааны явцын тайлан, тооллогын мэдээ, бусад холбогдох судалгааны тайлан бүхий улс, бүс нутаг, орон нутгийн түвшинд боловсруулсан нийгэм эдийн засгийн хөгжлийн баримт бичгүүдийг ашигласан. Хавсралт А (Ном зүй)-д ашигласан хоёрдогч мэдээллийн жагсаалтыг хавсаргасныг үзнэ үү.
- **Гол талуудтай хийсэн ярилцлага:** Ярилцлага хийх зааварчилгааг (Хавсралт Б-д харуулсан) гол оролцогч талтай хийх нүүр тулсан ярилцлагын үед ашигласан. Гол талуудтай хийсэн ярилцлаганд 32 хүн хамрагдсан.
- **Өрхийн судалгааны асуумж:** Хагас бүтэцтэй асуумж хуудас ашиглан сонгогдсон 400 өрхөөс мэдээлэл цуглуулсан (Хавсралт Б-д Өрхийн судалгааны асуумжыг хавсаргасныг үзнэ үү).
- **Зорилтот бүлгийн хэлэлцүүлэг:** Дунджаар 7 – 10 хүнтэй, 13 зорилтот бүлгийн хэлэлцүүлгийг зохион байгуулан явуулсан (Хавсралт Б-д Зорилтот бүлгийн хэлэлцүүлэг явуулах зааварчилгаа, Хавсралт В-д Гол талуудтай хийсэн ярилцлага, Зорилтот бүлгийн хэлэлцүүлгийн оролцогчдын жагсаалтыг хавсаргасан)

## Суурь судалгааны түүвэр

Сентерра компанийг төлөөлж Састэйнабилити компани нь Нийгмийн суурь судалгааг гүйцэтгэх зорилгоор Оролцогч талуудыг татан оролцуулах, мэдээлэл цуглуулах төлөвлөгөөг боловсруулсан. Нийгмийн суурь судалгааны мэдээлэл цуглуулах явц нь хэд хэдэн шаардлагыг

хангасан. Тоон, чанарын түүвэр судалгааны анхдагч мэдээллийг цуглуулахад даарах шаардлага тавигддаг ба үүний дэлгэрэнгүйг доор танилцуулав.

#### *Тоон судалгааны түүвэрлэлтийн арга зүй*

Тоон судалгаа нь цаашдаа нийгмийн нөлөөллийг хэмжих шалгуур болгон ашиглах нийгмийн гол үзүүлэлтийн суурь мэдээллийг бүрдүүлдэг бөгөөд нөлөөллийг бууруулж, тогтвортой хөгжлийг үнэлэх, төслийн нөлөөллийн эмпирик хэмжилтийг хийх боломж олгодог.

Гацууртын төслийн нийгмийн суурь судалгаанд өрхийн судалгаа бүхий тоон судалгааг дараах мэдээлэл цуглуулахад ашигласан:

- Хүн ам зүй, өрхийн бүтэц;
- Хөдөлмөр эрхлэлт ба амьжиргаа;
- Боловсрол, ур чадварын түвшин;
- Өрхийн орлогын эх үүсвэр ба хэмжээ;
- Өрхийн зарлага;
- Өрхийн бүтэц, газар ба бусад хөрөнгө;
- Эрүүл мэнд, боловсрол ба бусад үйлчилгээний хүртээмж;
- Эрүүл мэндийн үзүүлэлт; ба
- Ерөнхий чиг хандлага.

Тоон судалгааны түүвэрлэлтийн зориулалтаар судалгаанд оролцсон өрхүүдийг багийн байршил ба сумын хүн амтай багийн хүн амыг харьцуулсан байдлаар сонгосон.

Багийн судалгаанд оролцох өрхийн тоог тодорхойлсны дараа (түүвэр хийх хүн ам) энэхүү түүвэр хийх хүн амын дундаас санамсаргүй түүвэрлэлтээр судалгаанд оролцох өрхүүдийг сонгосон.

#### **Эх олонлог:**

Түүвэрлэлтийн хамрах хүрээг Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос явуулсан хүн ам, орон сууцны 2012 оны тооллогын мэдээн дээр тулгуурласан болно.

Түүвэр судалгаанд Сэлэнгэ аймгийн Мандал (Түнхэл багийг оролцуулан), Баянгол сумдыг хамруулсан. Эдгээр сумдын өрхүүд түүвэрлэлтийг багтаасан эх олонлогийг бүрдүүлэх ба 2012 оны мэдээнд тулгуурласан нийт эх олонлог 9,057 хүн ам байв.

#### **Хүснэгт А2 Тоон түүвэрлэлт хийх арга зүй**

Сум	Өрхийн Тоо	Хүн ам
Мандал сум	7,382	25,693
Баянгол сум	1,675	5,594

Түүвэрлэлтэнд суурин газрын өрхүүдийн 1%, хөдөө орон нутгийн өрхүүдийн 10%-ийг хамруулахад судалгааны талбайн хүн амыг оновчтой төлөөлнө гэж тодорхойлсон. Төслийн талбайтай ойр байрлах бүх өрхүүд, Гацууртын төсөл, Бороогийн төслийн уурхайн талбай

хоорондын хүдрийн тээврийн зам дагуух өрхүүдийг судалгаанд хамруулах шаардлагатай гэж тодорхойлсон.

0.05 хувийн стандарт алдаа, 95 хувийн итгэмжлэгдэх интервал хүлээн зөвшөөрөгдөнө.

Кластер эффектээс зайлсхийж, түүврийн бус алдааг багасгахын тулд тус судалгааны түүвэр өрхийн тоог 389 байлगाхаар тогтоосон.

#### Түүврийн хамрах хүрээ:

Байршил, хүн амын харьцааны шалгуурыг харгалзан үзэж түүвэрлэлтэнд багуудыг дараах байдлаар сонгосон:

- Мандал сум (суурин) болон Түнхэл, Хэрх багууд (хөдөө); мөн
- Баянгол сум (суурин) ба Гонир баг (хөдөө).

Судалгаанд хамрагдсан нийт өрхийн задаргааг Хүснэгт А3-д харуулсан ба үүнд тоон судалгааны аргын түүврийн хамрах хүрээг харуулсан байна

#### Хүснэгт А3 Тоон судалгааны түүврийн хамрах хүрээ

Байршил	Тэмдэглэгээ		Өрх	Хүн ам	Түүврийн хэмжээ		Нийт (бодит)
					1%	10%	
Сэлэнгэ аймаг							
Мандал сум			7,382	25,693			
	Суурин		5,211	18,448	52		56
	Хөдөө		2,171	7,245			
		Түнхэл баг	923	3,234		92	93
		Хэрх баг	903	3,029		90	94
Баянгол сум			1,675	5,594			
	Суурин		1,089		11		121
	Хөдөө		586			59	
		Гонир баг	503	1,558		50	
Төслийн талбайтай ойр өрхүүд						35	36
Нийт өрхийн асуумж (Бодит)							400

#### Чанарын судалгааны түүвэрлэлтийн арга зүй

Чанарын судалгааны ярилцлага хийх арга зүйг орон нутгийн нийгмийн байгууллагууд, манлайлал болон шийдвэр гаргах явцын талаар ойлголт авахын тулд ашигласан. Чанарын судалгаа нь өрхийн амьжиргааны хэлбэр, нийгмийн ялгаа, үндэстний цөөнх, зөрчилдөөн, эмэгтэйчүүдийн үүрэг, гол нөөц бололцоо, орон нутгийн иргэдийн төслийн талаарх ойлголт зэрэг тодорхой мэдээллийг олж авахад үр дүнтэй байдаг. Түүнчлэн, энэ нь тоон мэдээллийг хянан баталгаажуулахад бас үр дүнтэй байдаг. Дараах төрлийн чанарын судалгааны арга зүйг энэхүү Нийгмийн суурь судалгаанд ашигласан:

- **Зорилтот бүлгийн хэлэлцүүлэг:** орон нутгийн иргэдэд тулгамдсан асуудлыг ойлгохын зорилготой (тухайлбал эмэгтэйчүүд, залуучууд, нийгэм буюу соёлын байгууллагууд, цөөнхийн бүлгүүдтэй уулзах);

- **Гол талуудтай хийсэн ярилцлага:** сайн мэдээлэлтэй эх сурвалжаас дэлгэрэнгүй, цогц мэдээллийг олж авах;
- **Кейс судалгаа:** Зорилтот бүлгийн хэлэлцүүлэг, гол оролцогч талтай хийсэн ярилцлагаас нарийн тодорхой мэдээллийг иш татах.

Чанарын судалгааны арга зүйг ашиглан цуглуулсан мэдээллийн төрөлд дараах багтана:

- Хүн амын амьдралын стандарт;
- Нийгмийн ялгааны онцлог шинж;
- Нийгмийн байгууллага, уламжлалт аргаар шийдвэр гаргах үйл явцын бүтэц;
- Нийгмийн байгууллагуудын өвөрмөц шинж төрх;
- Байгалийн нөөцийн менежмент, газар ашиглалт;
- Соёлын өв бүхий газар;
- Амьжиргааны эх үүсвэр;
- Нийгмийн шилжилт хөдөлгөөн, хөдөлмөр хуваарилалт;
- Бүс нутгийн хөгжлийн талаарх ойлголт, мэдлэг;
- Тогтвортой хөгжлийн боломжийн талаарх ойлголт, мэдлэг; ба
- Төслийн нөлөөлөл, нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаарх ойлголт, мэдлэг.

Чанарын судалгааны түүвэрлэлтийн цар хүрээг тухайн газар нутагт хамааралтай сэдэв, тухайн сэдэвтэй холбоотой гол оролцогч талууд, мэдээлэгч нарын хэмжээн дээр үндэслэж тогтоосон.

#### Хүснэгт А4 Чанарын судалгааны түүвэрлэлтийн хүрээ

Аймаг / сум	Мэдээлэл цуглуулах арга	Түүвэрлэлтийн нэгж	Түүвэрлэлтийн хэмжээ (Төлөвлөсөн)	Түүвэрлэлтийн хэмжээ (Бодит)
Сэлэнгэ аймаг	Гол талуудтай хийсэн ярилцлага	<ol style="list-style-type: none"> <li>1. Засаг дарга ба Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга;</li> <li>Дараах байгууллагуудын төлөөлөлтэй уулзсан:</li> <li>2. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын гишүүд</li> <li>3. Засаг даргын тамгын газар</li> <li>4. Цагдаагийн хэлтэс</li> <li>5. Татварын хэлтэс</li> <li>6. Байгаль орчны хэлтэс</li> <li>7. Нийгмийн халамжийн хэлтэс</li> <li>8. Хөдөлмөрийн хэлтэс</li> <li>9. Газар, барилга, хот байгуулалтын хэлтэс</li> <li>10. Боловсролын хэлтэс</li> <li>11. Дэд бүтэц, зам, тээврийн хэлтэс</li> <li>12. Газар тариалан ба жижиг дунд үйлдвэрлэгчид</li> <li>13. Нэгдсэн эмнэлэг</li> <li>14. Сав газрын захиргаа ба Сав газрын зөвлөл</li> </ol>	12 Гол талуудтай хийсэн ярилцлага	14 Гол талуудтай хийсэн ярилцлага



Аймаг / сум	Мэдээлэл цуглуулах арга	Түүвэрлэлтийн нэгж	Түүвэрлэлтийн хэмжээ (Төлөвлөсөн)	Түүвэрлэлтийн хэмжээ (Бодит)
Мандал сум	Гол талуудтай хийсэн ярилцлага <i>Сумын төв, ба Түнхэл баг</i>	1. Засаг дарга; 2. Засаг даргын Тамгын газрын дарга; 3. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын гишүүд х 2. Дараах байгууллагуудын төлөөлөлтэй уулзав: 4. Байгаль орчны улсын байцаагч, Байгаль орчны бодлого хариуцсан ажилтан ба Газрын мэргэжилтэн 5. Татварын байцаагч 6. Нийгмийн ажилтан ба 7. Нийгмийн хөгжлийн бодлого хариуцсан ажилтан 8. Хөдөлмөрийн мэргэжилтэн 9. Боловсрол, соёл ба хүүхдийн асуудал хариуцсан ажилтан 10. Газар тариалан хариуцсан ажилтан 11. Эмнэлэгийн ажилтан	12 Гол талуудтай хийсэн ярилцлага	12 Гол талуудтай хийсэн ярилцлага
	Зорилтот бүлгийн хэлэлцүүлэг <i>Сумын төв болон Түнхэл багт</i>	1. Зам ашиглагчид (Төрийн, малчдын болон олон нийтийн төлөөлөл) 2. Жижиг дунд үйлдвэрлэгчид (Сумын хөгжлийн сан, Бизнесийн болон олон нийтийн төлөөлөл) 3. Газар тариалан эрхлэгчид (Төрийн байгууллагын болон олон нийтийн төлөөлөл) 4. Ойн аж ахуй эрхлэгчид (Ойн нөхөрлөлийн төлөөлөл) 5. Бичил уурхай эрхлэгчид (Албан ёсны бүртгэлтэй бичил уурхай эрхлэгчдийн бүлгүүдийн төлөөлөл) 6. Малчид	10 Зорилтот бүлгийн хэлэлцүүлэг	9 Зорилтот бүлгийн хэлэлцүүлэг
Баянгол сум	Гол талуудтай хийсэн ярилцлага	1. Засаг дарга; Засаг даргын Тамгын газрын дарга; ба Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, болон Дараах байгууллагуудын төлөөлөлтэй уулзав: 2. Байгаль орчны улсын байцаагч болон Байгаль орчны бодлого хариуцсан ажилтан ба Газрын мэргэжилтэн 3. Татварын байцаагч 4. Нийгмийн ажилтан ба Нийгмийн хөгжлийн бодлого хариуцсан ажилтан 5. Хөдөлмөрийн мэргэжилтэн 6. Боловсрол, соёл ба хүүхдийн асуудал хариуцсан ажилтан 7. Газар тариалангийн мэргэжилтэн 8. Эмнэлэгийн ажилтан	8 Гол талуудтай хийсэн ярилцлага	8 Гол талуудтай хийсэн ярилцлага
	Зорилтот бүлгийн хэлэлцүүлэг	1. Жижиг дунд үйлдвэрлэгчид (Сумын хөгжлийн сан, Бизнесийн болон олон нийтийн төлөөлөл) 2. Газар тариалан эрхлэгчид (Төрийн болон олон нийтийн төлөөлөл) 3. Малчид	3 Зорилтот бүлгийн хэлэлцүүлэг	4 Зорилтот бүлгийн хэлэлцүүлэг
Чанарын судалгаа болох зорилтот бүлгийн хэлэлцүүлэг, Гол оролцогч талтай хийх ярилцлагын нийт тоо			45	47

### **Бэлтгэл ажил ба туршилт**

Хээрийн судалгааны ажил эхлэхээс өмнө судалгааны багийн гишүүдийг зааварчилга сургалтанд хамруулсан. Хээрийн судалгааны өмнөх сургалт нь багийн гишүүдэд аюулгүй ажиллагааны арга хэмжээ, орон нутгийн иргэдийн асуултанд өгөх нийтлэг хариулт, хээрийн судалгааны явцад үр дүнтэй харилцах удирдамж бүхий мэдээлэл дамжуулах протоколыг (Хавсралт В-г үзнэ үү) таниулах ач холбогдолтой байсан юм.

Үүнээс гадна, өрхийн судалгааны асуумжийг судалгааг албан ёсоор эхлүүлэхээс өмнө туршиж үзсэн. Судалгааны багийг энэхүү судалгааг явуулах аргад сургасны дараа үнэлэх хэлбэрээр энэхүү асуумжийг туршиж үзсэн. Састэйнабилити нь өрхийн судалгааны асуумжийг өөрийн ижил төстэй төслүүд дээр ашиглаж байсан учраас өрхийн судалгаа ба цуглуулсан мэдээллийн чанарт итгэлтэй байна.

### **Судалгааны төлөвлөгөөт ба бодит түүвэрлэлтийн зөрүүтэй байдлын тайлбар**

Өрхийн судалгаанд 389 өрхийг хамруулахаар төлөвлөж байсан боловч судалгаанд хамрагдсан өрхүүдийн бодит тоо нь 400 болсон байв. Энэхүү зөрүү нь судалгааны баг цагаасаа өмнө төлөвлөсөн тоог гүйцээж, нэмэлт судалгаа хийхээр шийдсэн гэж тайлбарлаж болно.

Гол ч талуудтай хийсэн ярилцлагын төлөвлөсөн болон бодит тоо нь нэг их зөрүүгүй байна (45 гэж төлөвлөсөн байснаас 47 ярилцлага хийсэн). Энэхүү зөрүү нь судалгааны үеийн нөхцөл байдал, судалгаанд оролцсон гол оролцогч талуудын боломжоос шалтгаалсан.

### **Суурь судалгааны мэдээллийг цуглуулах явцад тулгарсан бэрхшээлүүд**

Суурь судалгааны мэдээлэл цуглуулахад ашигласан аливаа арга зүй нь өөрийн гэсэн дутагдалтай байдаг ба энэ нь мэдээллийн олдоц/ үнэн зөв байдал, хэрэглэсэн техник арга зүйгээсээ хамаарсан байж болно. Энэхүү нийгмийн суурь судалгааг явуулахад хэд хэдэн бэрхшээл саад тулгарсан. Үүнд:

- Сүүлийн үед Мандал суманд хийгдсэн (2014) чанартай тооллогын мэдээ<sup>229</sup> байсан бол Баянгол сумын хувьд байдал өөр байсан нь суманд тооллого ойрд хийгдээгүй, Статистик хариуцсан мэргэжилтэн байдаггүйтэй холбоотой байсан. Мандал сумын тооллогын мэдээ нь маш сайн хоёрдогч мэдээлэл байсан бөгөөд өрхийн судалгааны явцад цуглуулсан мэдээлэлтэй харьцуулахад хялбар байв. Хэрэв Баянгол суманд ийм төрлийн мэдээлэл цуглуулах боломжтой байсан бол сумдын хооронд болон Баянгол сумын өрхийн судалгааны мэдээлэлтэй илүү нарийвчилсан харьцуулалт хийх боломжтой байх байлаа.
- Өрхийн судалгааны мэдээлэл нь төслийн нөлөөллийн бүсийн өрхүүдийг төлөөлөхүйц болсон юм. Энэхүү тайлангийн өрхийн судалгаагаар цуглуулсан мэдээлэл, хоёрдогч мэдээлэл, гол талуудтай хийсэн ярилцлага, зорилтот бүлгийн хэлэлцүүлгийн явцад цуглуулсан мэдээлэл зэргийг ялгаж харуулах бүхий л хүчин чармайлтыг гаргасан.

<sup>229</sup> Мандал сумын нийгэм эдийн засгийн эмхтгэл. 2014. (Зөвхөн Монгол хэлээр).



- Судалгааны багийн аймагт (Сэлэнгэ) цуглуулсан мэдээллийн ихэнхи нь “нууцын” зэрэглэлтэй байсан учраас хоёрдогч мэдээллийг олж авахад түвэгтэй байв. Албан тушаалтнууд мэдээллийг биечлэн өгөхөөс татгалзсан бэрхшээлтэй тулгарч байсан ч үнэн зөв, сүүлийн үеийн хоёрдогч мэдээллийг онлайн эх сурвалжаас олж авах боломжтой байсан.
- Хээрийн судалгааны багийн Гацууртын төслийн талаар гол талуудтай хийсэн ярилцлага, зорилтот бүлгийн хэлэлцүүлгийн явцад төр захиргааны албаны хүмүүс идэвхигүй байсан нь 2016 онд сонгуулийн өмнө эдгээр албан тушаалтан өөрсдийн улс төрийн карьерт саад учруулж магадгүй гэж болгоомжилсны улмаас (ялангуяа Гацууртын төсөлтэй холбоотойгоор улс, орон нутгийн хэмжээнд “улс төржиж” байгаа учраас) санаа бодлоо илэрхийлж, чөлөөтэй ярилцахаас зайлсхийж байсантай холбоотой юм. Ерөнхийдөө хээрийн судалгааны баг нь мэдээллийн нууцыг хадгалж, аль нэгэн талыг баримтлахгүй гэдгийг сайн тайлбарснаар энэхүү асуудлыг амжилттай даван туулсан юм.

## **МЭДЭЭЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА**

Мэдээллийн өвөрмөц шинж чанараас шалтгаалж дүн шинжилгээний олон төрлийн аргыг ашигласан. Өрхийн судалгааны ярилцлагын агуулгаас тайлангийн үндсэн чиглэлүүдийг боловсруулж, гол талуудтай хийсэн ярилцлага, зорилтот бүлгийн хэлэлцүүлгээс олж авсан мэдээллийг нэгтгэн түвшинг гурав хэсэгт хуваасан болно.

Түүнээс гадна, хээрийн судалгааны явцад олж авсан мэдээллийг бататгах зорилгоор аймаг, сумдын түвшинд олж авсан хоёрдогч мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн.

Судалгааны анхдагч мэдээллийг боловсруулж, дүн шинжилгээ хийхдээ нийгмийн судалгааны SPSS 11.5 статистик шинжилгээний программыг ашигласан. Судалгааны гол үр дүнг нэгтгэж, энгийн

## **ЧАНАРЫН ХЯНАЛТ**

Мэдээллийн чанарын хяналтын зорилго нь дараах шаардлагыг хангасан мэдээлэл цуглуулах явдал юм:

1. Хүн амын бодит байдлыг үнэ зөвөөр төлөөлж чадахуйц;
2. Зорилтот хүн амыг бүхэлд нь төлөөлж чадахуйц.

Нийгмийн суурь судалгааны дээрх шаардлагыг хангасан мэдээлэл цуглуулах гол зорилго нь түүврийн ба түүврийн бус алдааг багасгах явдал байв. Дээр тайлбарласанчлан энэ судалгаанд ашигласан түүвэрлэлтийн арга зүй нь судлагааны зорилтот хүн амыг төлөөлөхуйц түүвэрлэлттэй, Хүн ам зүй судлаачаар баталгаажсан найдвартай юм. Хэмжилтийн алдаа, сонголтын алдаа, хариулт авахгүй байх зэрэг түүврийн бус алдаанаас зайлсхийхийн тулд хэд хэдэн аргыг хэрэгжүүлсэн. Анхан шатны арга болох цогц бэлтгэл ажлыг хэрэгжүүлсэн нь (2.2.2 Бэлтгэл ажил ба туршилт хэсгээс үзнэ үү) гол талуудтай хийсэн ярилцлага, зорилтот бүлгийн хэлэлцүүлэг явуулах удирдамж бүхий “Оролцогч талуудыг татан оролцуулах , мэдээлэл цуглуулах төлөвлөгөө”-г нарийвчлан боловсруулсан явдал юм. Састэйнабилити компанийн үндэсний зөвлөхүүд өрхийн судалгаа, гол талуудтай хийсэн ярилцлага, зорилтот бүлгийн хэлэлцүүлгийн удирдамжийг орон нутагт тохирсон, ойлгогдохуйц байхаар, дахин дахин хянаж боловсруулсан. Түүнээс гадна, Састэйнабилити компани нь уг суурь судалгаанд ашиглагдсан өрхийн судалгаа,

гол талуудтай хийсэн ярилцлага, зорилтот бүлгийн хэлэлцүүлгийн удирдамжийг Монголд явуулж байсан ижил төстэй төслийн хүрээнд өмнө нь амжилттай хэрэглэж туршсан асуулга дээр түшиглэн боловсруулсан.

Чанарын баталгааг хангаж, хээрийн судалгааны үед гарах аливаа алдааг хуримтлагдахаас өмнө завсарлах зорилготой “хээрийн судалгааны үеийн хяналт” (Өрхийн асуумж судалгааг бөглөсний дараа шууд хянах) хийх замаар хэмжилтийн алдааг багасгасан юм. Чанарын хяналтын өөр нэгэн ололттой тал нь туршлагатай судлаач болох Доктор Алгаагийн Солонгыг судалгааны багт багтаасан явдал байсан юм. Др. Солонго нь Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн профессор бөгөөд Хүн амын сургалт, судалгааны төвийн захирал юм. Тэрээр өрхийн судалгааны хээрийн ажлын өмнөх чанар болон цуглуулсан мэдээллийг индексжүүлэн шалгаж, мэдээллийг SPSS програмд оруулж, боловсруулалт хийсэн. Цуглуулсан мэдээллийн чанарыг өрхийн судалгааны төлөвлөсөн тооноос илүү нэмэлт өрхийн асуумж явуулах замаар баталгаажуулсан. Энэ нь өрхийн аливаа алдаатай судалгааг (жишээлбэл, дутуу бөглөгдсөн/буруу хийгдсэн ярилцлага/техникийн асуудал гэх мэт) нийт судалгаанд нөлөөлөлгүйгээр орхих боломж олгосон юм. Аз болоход бэлтгэл ажил болон судалгааны загварыг сайн гаргасан учраас асуудал үүсгээгүй.

## **ХАВСРАЛТ Б ГАЦУУРТ ТӨСӨЛ - БИЧИЛ УУРХАЙН ХАВСРАЛТ**



## ГАЦУУРТ ТӨСӨЛ – БИЧИЛ УУРХАЙН ХАВСРАЛТ

Огноо : 14/04/2016

### Зорилго

Энэ хавсралтын зорилго нь Гацууртын төсөлд үүсэн бий болсон бичил уурхайн асуудлыг шийдвэрлэх нэмэлт суурь судалгаа, нөлөөллийн үнэлгээ, менежментийн арга хэмжээнүүдийг тогтоох юм. 2015 оны 3-4 сард Гацууртын төслийн анхны суурь судалгааг хийж байх үед бичил уурхайн асуудал гараагүй байсан учраас энэ талын судалгааг нэмэн гүйцэтгэж үр дүнг нь энэхүү хавсралтаар оруулж байна. Бичил уурхайн асуудал нь 2015 оны 9-р сард хурцаар тавигдах болсноор энэ асуудлыг дангаар нь авч үзэх шаардлага үүсэн бий болж, үүссэн нөхцөл байдал, цаашдын нөлөөлөлд дүн шинжилгээ хийж асуудлыг үр дүнтэй шийдвэрлэх менежментийн арга хэмжээ болон компанийн үүрэг хариуцлагыг тодорхойлох шийдвэр гарсан болно.

### Суурь нөхцөл ба нөлөөллийн үнэлгээ

#### Бичил уурхайн салбар (БУС) - Олон улсын нөхцөл байдал

Дэлхий нийтийн хэмжээнд нийт 15 сая гаруй хүн алтны бичил уурхайтай шууд холбоотой гэсэн тооцоо байдаг байна. Үүнээс бүр илүү буюу ойролцоогоор 100 сая хүний амьжиргаа бичил уурхайн үйл ажиллагаанаас хамааралтай байдаг байна. Бичил уурхай нь дэлхий нийтийн хэмжээнд төр засаг, уурхайн компаниуд, төрийн бус байгууллагууд, түслэмжийн байгууллагууд болон хандивлагчдын хувьд хөгжлийн ээдрээтэй нэг асуудал болсоор байна. Бичил уурхайн төрлүүд өөр өөр бөгөөд тэдгээрийн асуудлыг шийдвэрлэхэд мөн өөр өөр шийдэл шаардлагатай байдаг. Бичил уурхайн асуудал нь нийгэм, эдийн засаг, байгаль орчны болон засаг захиргааны асуудлуудтай холбогддог нь бэрхшээл үүсгэдэг бөгөөд эдгээр асуудлыг цогцоор нь авч үзэх шаардлагатай байдаг.

Монголтой төстэй олон улс оронд энэ асуудлыг шийдвэрлэхээр хэдэн арван жилийн туршид хийгдсэн бодлогын өөрчлөлт, хэрэгжүүлсэн арга хэмжээ нь энэхүү нарийн төвөгтэй асуудлыг шийдвэрлэж хараахан чадаагүй л байна. Дэлхийн нийтийн хэмжээнд, ялангуяа энэ талын хуулийн зохицуулалт сул газруудад, бичил уурхай эрхлэгчдийн тоо өссөөр байгаа бөгөөд уул уурхайн хөгжилтэй холбоотойгоор олон нийтийн санаа бодлыг илэрхийлэх эрхийн хүрээнд тэд өөрсдийн эрхийн асуудлыг мөн гарган тавьсаар байна. Зарим засгийн газар бичил уурхайн салбарыг эдийн засгийн боломж талаас нь харж эхлэж байгаа бол хандивлагчид ч мөн энэ салбарыг дахин сонирхож байна. Компаниуд ч мөн компаний гаднах оролцогч талуудтайгаа хамтран бичил уурхайг тойрсон нийгмийн төвөгтэй асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх асуудлыг хайж байна. Бичил уурхайн төвөгтэй байдлыг шийдвэрлэх, үр ашигтай салбар болгон өөрчлөхөд оролцогч талууд өөрсдийн үүрэг, хариуцлагаа ухамсарлаж нэгдмэл байдлаар ажиллах шаардлагатайг харуулж байна.

#### Монгол дахь бичил уурхайн салбар

Өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд Монгол улсад бий болсон бичил уурхайн огцом өсөлтийг Дэлхийн банк болон бусад байгууллагууд (*Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ), Швейцарийн Хөгжлийн Агентлаг (ШХА), Дани ба Гренландын Геологийн Судалгаа (ДГГС)*) судалсан байна. Энэ судалгаагаар социализмийн тогтолцоо нуран унаж зах зээлийн эдийн засаг руу шилжсэн өөрчлөлт, цаг агаарын хүнд нөхцөл байдалтай байсан зэрэг нь олон малчин иргэдийн орлогод сөргөөр нөлөөлж, тэднийг бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэх замыг сонгоход хүргэсэн хэмээн дүгнэжээ. Монгол улсад 1990 оны эхэнд бараг байхгүй байсан бичил уурхайчдын тоо өнөөдөр даруй 140,000 гаруй болсон тооцоо байна. Энэ тоо өссөөр байгаа бөгөөд ихэнх (90%) бичил уурхайчид алт, үлдсэн хэсэг нь нүүрс, жонш болон бусад төрлийн ашиг малтмал хайж олборлож байна. Энэ нь нийт хүн амын тав орчим хувийг эзэлж байгаа ч тэдгээрийн ард байгаа, энэ албан бус салбараас шууд бус хамааралтай, иргэдийн хувь үүнээс өндөр байх магадлалтайг илэрхийлж байна. Гацууртын төслийн орчим дахь бичил уурхайчдын тоог нарийн гаргахад хэцүү бөгөөд олон тооны хүмүүс зөвхөн сонирхлоороо юмуу нэмэлт орлого олох зорилгоор тогтмол бус байдалтайгаар бичил уурхайд ажилладаг бол байнга бичил уурхайн ажил эрхлэгчид ч мөн бий.

Монголд бодлого боловсруулагчид, ард иргэдийн дунд бичил уурхайг тааламжгүй байдлаар хүлээн авдаг бөгөөд үүнийг зогсоох ёстой гэсэн түгээмэл ойлголт байдаг. Энэ талаарх ойлголтын гол хүчин зүйл нь бичил уурхай нь хүн амын ядуурлыг багасгах, хөдөөгийн иргэдийн амьжиргааг дэмжих тогтвортой ажлын байр гэхээсээ илүү түр зуурын үзэгдэл мэт харагддаг оршино. Бичил уурхай эрхлэгчид нь Монголд хууль ёсоор хүлээн зөвшөөрөгдөдгүй тул нийгмийн үндсэн үйлчилгээ авч чаддагүй зэрэг хүндрэл бэрхшээлтэй тулгарч байна. Бичил уурхайн талбайнуудад ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны стандарт байдаггүй бөгөөд эрүүл мэндийн баталгаагүй орчин нөхцлөөс болж өвчний тархалт байнгын аюул занал болдог (Тогтвортой бичил уурхайн төсөл, 2011). Бичил уурхайн үйл ажиллагаанд мөнгөн ус болон бусад химийн бодисыг ашиглаж байгаа нь гол ус, хөрс, агаар бохирдуулах, түүнчлэн газрыг сүйтгэж байгаа нь байгаль орчинд эрсдэл учруулж байна. Монгол дахь бичил уурхайн үйл ажиллагааг албажуулах санал 2010 оны 4-р сард УИХ-д олонхын дэмжлэг авсан. Энэ хууль тогтоомж нь бичил уурхай эрхлэгчдэд найдвартай олборлолт явуулах уурхайн газар, цаашлаад тогтвортой ажлын байр, орлого олох боломжыг олгож байна. Энэ шийдвэрээр ажлын байрны аюулгүй ажиллагаа, нийгмийн хангамж, эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжыг бичил уурхайчдад мөн бүрдүүлж өгсөн (Тогтвортой бичил уурхайн төсөл, 2011). Гэсэн хэдий ч бодит амьдрал дээр бичил уурхай нь эрхзүйн хувьд ч, дэмжлэгийн хувьд ч, нийтээр хүлээн зөвшөөрөх талаар ч төрийн болон нийгмийн зүгээс гадуурхагдах байдалтай байсаар байна (SAMP KII, 2014). Хэдийгээр эрхзүйн хувьд шийдэгдсэн ч гэсэн хууль ёсоор газар ашиглах боломж энэ салбарт тулгарч буй өнөөгийн гол бэрхшээлүүдийн нэг болж байна. Монгол орны газар нутгийн ихэнх хэсэг нь геологийн судалгаа, уул уурхайн ашиглалтын болон хайгуулын лицензт талбайд орсон, эсвэл хамгаалалтанд авагдсан буюу авагдахаар төлөвлөгдсөн байна. Энэ нь ерөнхийдөө Монгол улс дахь газар ашиглалтын өнөө болон болон ирээдүйд тулгарч буй гол зөрчил юм. Журамд заагдсанаар бичил уурхай эрхлэгчид нь уурхай эрхлэх газрын зөвшөөрөл хүсэх шаардлагатай болдог. Харин зөвшөөрөл хүссэн газруудад нь бичил уурхай эрхлэх боломжгүй, өнөө болон ирээдүйд өөр зориулалтын газар ашиглалт төлөвлөгдсөн байдгаас тэд хүссэн газраа авах боломжгүй болдог. Бичил уурхайг зохицуулсан эрхзүйн орчин гарчихаад байхад үйл ажиллагаагаа явуулж чадахгүй байгаа нь бичил уурхай эрхлэгчдэд тэднийг гадуурхсан байдлаар хандаж байна гэсэн ойлголтыг төрүүлж байгаа бөгөөд энэ асуудал цаашид ч даамжрах төлөвтэй байна. Сумын засаг захиргаа, уурхайн компани, албан ёсны бичил уурхайн нөхөрлөлүүдийн хооронд гурван талт гэрээг хуулийн дагуу байгуулах боломжтой ба ингэснээр бичил уурхайн нөхөрлөлийг албан ёсны лицензтэй талбайн зөвшилцөж

тохирсон хэсэгт ажиллуулах боломжтой. Ийм байдлаар ажиллахад оролцогч бүх талуудын хооронд бие биедээ итгэх итгэлцэл болон гэрээгээ хэрэгжүүлэхтэй холбогдсон хариуцлагаа бүрэн ухамсарлах шаардлагатай. Одоогоор итгэлцлийн болон хариуцлагын асуудал талуудын хувьд учир дутагдалтай байсаар байна. Дээрхээс харахад Монгол улс дахь бичил уурхай нь өмнө байгаагүйгээр хүлээн зөвшөөрөгдсөн хэдий ч батлагдсан хууль журмыг бодитойгоор хэрэгжүүлэхэд томоохон бэрхшээлүүд тулгарсаар байна.

Бичил уурхайн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх асуудал нь сум, аймаг, Засгийн газрын түвшинд бэрхшээлтэй асуудал болсоор байх шинжтэй байна. Тус салбарын үр дүнтэй удирдах нөөц бололцоо (өөрөөр хэлбэл бичил уурхайн сөрөг нөлөөллүүдийг зөвхөн бууруулах биш, түүнчлэн үүсгэгч хүчин зүйлүүдийг нь шийдвэрлэх) нь хязгаарлагдмал байна (ялангуяа өнгөрсөн хугацааны уул уурхайн салбарын уналтыг харгалзан үзвэл). 2014 онд хийгдсэн *Монгол улс дахь уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн стратегийн үнэлгээнд*<sup>230</sup> дурдсанаар бичил уурхай эрхлэгчид болон Монгол улсын Засгийн газар, түүнчлэн том хэмжээний уурхайнуудын хооронд үүсэх газар ашиглалтын зөрчил нэмэгдэж болзошгүй байна.

Бороо гоулд компанид тулгараад байгаа бичил уурхайн бэрхшээлүүдийг бүрэн ойлгохын тулд ерөнхийдөө болон Монгол улс дахь том хэмжээний уурхай ба бичил уурхайн салбарын хоорондын хамаарлыг цаашид гүнзгийрүүлэн авч үзэх шаардлагатай байна.

### **Том хэмжээний уул уурхай ба бичил уурхайн хамаарал**

Ерөнхийдөө бичил уурхай нь бага хэмжээний хөрөнгө оруулалт болон механикжуулалттай байдаг учраас том хэмжээний уурхайгаас маш өөр байдаг. Өмнө дурьдсанчлан бичил уурхай нь олон янзын хэлбэрээр ашиглагддаг ба дэлхий нийтийн хэмжээнд өөр орлогын эх үүсвэргүй ч байж болох нилээд олон тооны хүн амын амьжиргааг залгуулж байдаг. Хэдий тийм ч бичил уурхай нь үргэлж нийгмийн болон хүний эрхийн зөрчил, байгаль орчны доройтлыг нэмэгдүүлж, ихэвчлэн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны шаардлага хангах туршлагаар дутмаг харагддаг. Бичил уурхай нь ихэвчлэн том хэмжээний уул уурхай байдаггүй газарт бий болдог ба том хэмжээний уурхайн салбар бичил уурхайн үйл ажиллагаанд нөлөөлөх чадамж бололцоо туйлын хязгаарлагдмал байдаг. Энэ хоёр уурхай давхцаж байгаа газар бүр хоорондоо мөн зөрчилдөөд байдаггүй бөгөөд (Гана, Гвиней, Конго, Папуа Нью Гвиней, Танзани зэрэг улсад) энэ нь уурхайн онцлог болон байршлаас хамаардаг байна. Ийм нөхцлүүдэд том хэмжээний уурхайн лицензтэй газарт зөвшөөрөлтэй эсвэл зөвшөөрөлгүй явагдаж буй бичил уурхай орж болох бөгөөд бичил уурхай эрхлэгчид тухайн нутгийн иргэд эсвэл нүүлгэн шилжүүлэгдсэн иргэд, эсвэл шилжиж ирэгсэд байдаг. Энэ үйл ажиллагаа нь компани болон орон нутгийн иргэдийн хамтын ажиллагаа хэлбэртэй байж болох бөгөөд энэ тохиолдолд бичил уурхай нь гадны оролцогч эсвэл орон нутгийн төлөөлөл бүлэг хэлбэртэй болсон байдаг.

Бичил уурхай нь мөн компанийн үйл ажиллагаа болон ажиллагсдын аюулгүй байдалд аюул эрсдэл учруулдаг. Үүнийг эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны талаар ямар нэгэн үүрэг хариуцлага үүрдэггүй бичил уурхайг дагасан гэмт хэргийн эсвэл зэвсэглэсэн бүлэглэлүүд гаргаж болзошгүй байдаг. Нөгөө талаар бичил уурхайнууд нь том уурхайдтай адид төвшинд яриа хэлэлцээ хийх боломж бололцоо байдаггүйгээс тэдний ашиг сонирхол, амьжиргааны асуудлууд доогуур тавигдах болдог. Энэ асуудал нь дан ганц уурхайн компанийн шийдэх асуудал биш юм.

<sup>230</sup> Састэйнабилиити Ийст Эйжия ХХК 2014. Монгол улс дахь уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн стратеги үнэлгээ. Монгол улсын уул уурхайн яам Дэлхийн банктай хамтран захиалган хийлгэсэн судалгаа.



Бичил уурхайн асуудалд дан ганц уурхай биш, зөв зохистой бодлого шаардсан төр засаг, нийгмийн асуудал юм.

Лицензтэй том хэмжээний уул уурхайн компаниуд болон бичил уурхайн хоорондын төвөгтэй харилцаа, бэрхшээлийг Уул уурхай, металлын дотоод зөвлөл (УУМДЗ), Уул уурхайн, ашигт малтмал, металл ба тогтвортой хөгжлийн засгийн газар хоорондын форум, Дэлхийн банк/Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК) зэрэг олон улсын байгууллагууд, хандивлагчид ч хүлээн зөвшөөрч байна. Бичил уурхай нь дан ганц Монгол улсын эсвэл Бороо гоулд компанийн асуудал биш бөгөөд үүнийг шийдвэрлэх хялбар арга ч мөн байдаггүй.

Томоохон уурхайн компаниуд бичил уурхайн асуудлуудаар яриа хэлэлцээр хийхэд дэмжлэг үзүүлэх боломжтой. Том хэмжээний уурхайн компаниудын үүрэг оролцоо тухайн орон нутгийн нөхцөл байдлаас хамаараад өөр өөр байна. Том уурхайн компаниудын тулгардаг зарим төвөгтэй асуудлууд нь бичил уурхайн сүйтгэсэн байгаль орчны хариуцлагыг хэн хүлээх, бичил уурхайтай холбогдсоноор үүсэж болзошгүй нэр хүндийн асуудал, тухайлбал хүүхдийн хөдөлмөр, хүний наймаа зэрэг юм. Тухайн улсын төр захиргаа болон бусад холбогдох газрууд эдгээр асуудлуудыг шийдвэрлэх ерөнхий чиглэлийг тодорхойлох, ингэснээр том хэмжээний уурхайнууд бичил уурхайтай харилцан ойлголцох, цаашдаа бичил уурхайн хөгжлийг сайжруулахад нь дэмжих тогтолцоог бий болгож болно.

Дээрхээс гадна том уурхайн салбар нь (Дэлхийн Алтны Зөвлөлтэй ижил төстэй замаар) ямар нэгэн зөрчилд холбогдоогүй, зохих байгаль орчин, аюулгүй ажиллагаа, хөдөлмөр эрхлэлтийн арга туршлагыг хангасан хариуцлагатай бичил уурхайг зах зээлд нэвтрэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлж болно. Харин том уурхайнууд нь гэмт хэргийн бүрэлдэхүүн ба зэвсэглэсэн бүлэглэлийн хяналтан дор явагддаг Зөвшөөрөлгүй, Хууль бус уурхайн (ЗХБУ) үйл ажиллагаа эсвэл гэмт хэрэгт холбогдсон үйл ажиллагааг дэмждэггүй. Зөвшөөрөлгүй хууль бус бичил уурхай ба амьжиргааг дэмжсэн уламжлалт бичил уурхайг ялган ойлгох нь чухал юм (доорх хэсэгт илүү дэлгэрэнгүй тайлбарласан Гацууртын өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан үзвэл энэ ялгаан анхаарах нь чухал). Үйл ажиллагаа нь гэмт хэргийн шинжтэй бичил уурхайг дэмжихгүй байх хариуцлагыг том уурхайнууд хүлээдэг. Гэхдээ, гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй, зэвсэглэсэн ЗХБУ- үйл ажиллагааг таслан зогсооход төрөөс авах тодорхой арга хэмжээ, хүсэл эрмэлзэл байхгүй тохиолдолд дээрх алхмуудыг том уурхайн зүгээс хэрэгжүүлэхэд хүндрэлтэй юм. Энэ нь ялангуяа бичил уурхайн талаарх хууль тогтоомжийн зохицуулалт хангалттай хэмжээнд байхгүй Монгол улсын хувьд хамаатай бөгөөд хууль тогтоомжыг шинэчлэх ажлын хүрээнд өмнө нь ийм төрлийн үйл ажиллагааг үр дүнтэй удирдан зохицуулж байсан төр засгийн туршлага байхгүй байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэх зохистой арга хэмжээ авах, хуулийг чандлан мөрдүүлэх тал дээр засгийн газраас тодорхой арга хэмжээ авч ажиллахад нь олон улсын хөгжлийн байгууллагууд, том хэмжээний уурхайн салбар, иргэнийн нийгэм болон бусад талууд бүгд дэмжих ажиллах үүрэгтэй.

### **Гацууртад үүссэн нөхцөл байдал**

Гацууртын орчимд үүссэн (2015 оны 9-р сараас өнөөг хүртэл) бичил уурхайн нөхцөл нь Монгол улсын бусад хэсэгт байдаг шиг ядуурлаас шалтгаалсан амьжиргаагаа дээшлүүлэх зорилгоор хийгдэж буй асуудал биш бөгөөд харин эсрэгээрээ өмнө дурьдагдсан Зөвшөөрөлгүй, Хууль бус уурхайн үйл ажиллагаа гэж тодорхойлогдохоор байгааг тэмдэглэх нь зүйтэй. Гацууртад болж буй үйл явдлыг харахад эдгээр нь нь урьдаас бодож төлөвлөсөн гэм хэргийн үйлдэл гэж харагдахаар байгаа бөгөөд эдгээр хүмүүс олон тооны том оврын тээврийн хэрэгслийн цуваа үүсгэн уурхайн

талбайд байрлуулсан саадыг эвдэн нэвтрэх, байгаль орчны болон аюулгүй ажиллагааны зориулалтын бусад хашилтыг санаатайгаар давах, үл хайхрах зэрэг үүнийг илтгэж байгаа юм. 2015 оны 9-р сараас хойш Гацуурт дахь хууль бус үйл ажиллагаа хурдацтай нэмэгдсэн ба Бороо гоулд компанийн хамгаалалт, цагдаагийн байгууллагатай хамтран 28 удаагийн ажиллагаагаар 5,000 гаруй хүмүүс, 200 гаруй тээврийн хэрэгслийг тухайн талбайгаас гаргасан байна.



### **Нөлөөллийн хураангуй**

Дээрх хууль бус уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийг уурхайн барилгын болон ашиглалтын үе шатанд Гацууртын зөвшөөрөлтэй талбайгаас гаргах зорилготой байна. Гацууртад үүсээд байгаа нөхцөл байдлаас харахад богино хугацаанд үйл ажиллагаа явуулаад өөр газрууд руу шилжин явах чадавхи боломжтой бүлгүүд энд ажиллаж байгаа нь илэрхий бөгөөд тэд Гацууртаас явсан тохиолдолд өөр тийшээ, магадгүй Бороогийн уурхай руу шилжин тэндхийн ил уурхайнуудыг ашиглах нөхцөл ч үүсэж болзошгүй юм.

Хууль бусаар алт олборлогчид Гацууртад үйл ажиллагаагаа үргэлжүүлсээр байх тохиолдолд төслийн хамгаалалтын алба (улсын болон хувийн) тэдэнтэй зөрчилдөөнд орох эрсдэл байгаа юм. Эрх бүхий холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж буй аюулгүй байдлыг хангах

ажиллагааг өнөөг хүртэл асуудалгүй, тайван замаар гүйцэтгэж байна. Төслийн барилгын болон ашиглалтын үе шатанд илүү олон тооны ажилчид ирэх бөгөөд уурхайн аюулгүй байдлын бие бүрэлдэхүүн ч мөн нэмэгдсэн байх болно.

Уурхайн барилгын болон ашиглалтын үе шатанд хууль бус алт олборлолт эрхлэгчдийн сонирхол мөн өөрчлөгдөх ба (жишээ нь ил уурхай, овоолгонууд бий болсноор) энэ талаар байнгын хараа, хяналттай байх шаардлагатай хэмээн Төслийн зүгээс үзэж байна. Гацууртад хууль бусаар алт олборлох сонирхол мөн эдийн засгийн ерөнхий байдал, тухайн бүс нутаг дахь бусад уурхайнуудын үйл ажиллагаа зэрэг гадаад хүчин зүйлүүдээс ихээхэн шалтгаалах нь дамжиггүй. Тиймээс алтны хууль бус уурхайн нөлөө цаашид ямар байхыг урьдчилан таамаглахад төвөгтэй бөгөөд энэ талын хяналтыг байнга хийхийг шаардах болно. Төлөвлөж буй нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд нь хууль бус уурхай эрхлэгчдийн талаар өнөөг хүртэл цуглуулсан мэдээ мэдээлэлд хийсэн шинжилгээнд үндэслэсэн бөгөөд шаардлагатай шинэчлэлүүд цаашид хийгдэнэ гэж тооцсон байгаа.

Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шинж чанар	Бууруулах арга хэмжээ авагдаагүй үеийн үр дагавар	Хянах, Бууруулах, Сайжруулах арга хэмжээнүүд	Холбогдох менежментийн төлөвлөгөө, бодлого	Арга хэмжээ авсаны дараа гарах үлдэгдэл үр үр дагавар
<b>Газар ашиглалт ба амьжиргаа (ЕСБХБ ГШ 1, 3) (ЕСБХБ ГШ 1, 2)</b>					
Хууль бус олборлолтын үйл ажиллагаанаас болж Гацууртын лицензийн талбайд нэвтрэх боломж алдагдах	Тодорхой Шууд сөрөг Урт хугацааны Өргөн хүрээнд	Бага	<ul style="list-style-type: none"> <li>Албадан гаргах.</li> <li>Мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийж, үр дүнд үндэслэн нөлөөлөл, бууруулах арга хэмжээнүүдийг дахин үнэлэх (доорх компаний үүрэг амлалт хэсгийг харна уу).</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Стратегийн Арга хэмжээний Төлөвлөгөө</li> <li>Хамтын ажиллагааны гэрээ</li> </ul>	Маш бага
<b>Иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал (ЕСБХБ ГШ 1, 4)</b>					
Хууль бус уурхай эрхлэгчид болон Төслийн аюулгүй байдлын ажилтнуудын хооронд зөрчил үүсэх эрсдэл	Боломжтой Шууд Дундаж өндөр сөрөг Урт хугацааны Дунд хэмжээний хүрээнд	Дунд	<ul style="list-style-type: none"> <li>Аюулгүй байдал, хүний эрхийн талаарх сайн дурын зарчмуудтай (АБХЭСДЗ) бүрэн нийцүүлэх, үүнд цагдаагийн байгууллагтай хамтран ажиллах гэрээ болон аюулгүй байдлын талаарх компанийн тусгай удирдамжууд</li> <li>Гол түншүүд болон бусад Монголын оролцогч талуудтай хамт Стратегийн Арга хэмжээний Төлөвлөгөө боловсруулах (дэлгэрэнгүйг доорх компаний үүрэг амлалт хэсгээс харна уу).</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Стратегийн Арга хэмжээний Төлөвлөгөө</li> <li>Хамтын ажиллагааны гэрээ</li> </ul>	Бага

## Компанийн үүрэг амлалт

### Менежментийн арга хэмжээ

Бороо гоулд компанийн хууль бус алт олборлогчидтой харилцах харилцаа нь тэдний гаргаж буй гэмт хэргийн шинжтэй үйлдлүүдээс үл хамааран сөргөлцөх бус байдлаар хийгдэж байгаа бөгөөд компанийн зүгээс авах арга хэмжээний стратеги нь **Аюулгүй байдал, хүний эрхийн талаарх сайн дурын зарчмуудтай (АБХЭСДЗ)** бүрэн нийцэж байгаа болно. БГК нь Гацуурт орчмын аюулгүй байдлыг сайжруулахад хичээн ажиллаж байгаа бөгөөд энэ ажлын хүрээнд цагдаагийн байгууллагатай Хамтын ажиллагааны гэрээ байгуулж, мөн аюулгүй байдлын талаарх компанийн тусгай удирдамжуудыг хэрэгжүүлж байна. Гэсэн хэдий ч эдгээр арга хэмжээнүүд нь дангаараа хууль бус уурхайн асуудлыг урт хугацаанд шийдэж чадахгүй нь тодорхой юм.

Цаашдаа БГК нь Стратегийн Арга хэмжээний Төлөвлөгөөг боловсруулахад гол түншүүд болон бусад оролцогч талуудыг тодорхойлж хамтран ажиллана. Үүний тулд БГК нь цагдаагийн байгууллагын ажилтнуудыг Байрлуулах ажиллуулах гэрээнд нэмэлт өөрчлөлтийг хийгээд байна. Мөн дотоод журмууддаа АБХЭСДЗ зэрэг олон улсын сайн туршлагууд, хүний эрхийг дээдэлж хамгаалах зарчмуудыг суулгаж байна.

Төлөвлөгдөж буй Стратегийн Арга Хэмжээний Төлөвлөгөө нь дараах асуудлуудад голчлон анхаарна:

#### Мэдээлэл цуглуулах ба дүн шинжилгээ хийх:

- Нийгэм/аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээг хийх ба шинэчлэх;
- Хууль бус уурхайн гол шалтгаанууд болон холбогдох нийгмийн нөлөөллийг нарийн тодорхойлох, ойлгох;
- Шүүх, Цагдаагийн байгууллагуудтай хамтран ажиллаж одоогийн байгаа хариуцлагын арга хэмжээний боломжуудыг үнэлэх;
- Гол оролцогч талуудтай мэдээлэл цуглуулах сүлжээний тогтолцоог бий болгох.

#### Мэдээлэл, сурталчилгааг сайжруулах:

- Хууль бус уурхайн үйл ажиллагаанд иргэдийг автахас сэргийлсэн боловсролын хөтөлбөрийг орон нутгийн иргэдэд хүргэх (хууль бус уурхайд холбогдох, мөн байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны эрсдэл/нөлөөлөлтэй холбоотой болзошгүй хууль эрх зүйн сөрөг үр дагаварыг шийдвэрлэх);
- БГК-ын бүх ажиллагсад хууль бус уурхайтай холбогдох, тэдэнтэй тулгарах үеийн эрсдлийн талаар сургалт сурталчилгааны хөтөлбөрүүд үргэлжлүүлэн явуулах;
- БГК-ын гомдлын механизмын талаарх орон нутгийн иргэдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, мөн Орон нутагтай харилцах хэлтэс нь хүний эрхийн зөрчлийн асуудалд юу ордог, энэ талын мэдээллийг дотооддоо хэрхэн дамжуулах талаар бүрэн мэдээлэлтэй байлгах арга хэмжээ авах.

#### Засгийн газар болон Иргэний нийгмийн оролцоо

- Орон нутгийн иргэдийн аюулгүй байдлыг сайжруулах компани ажил зохион явуулах, энэ талын нөөц боломжыг ашиглахад төрийн байгууллагуудыг татан оролцуулах (иргэдэд түшиглэсэн Дэг журам сахиулах загвар гэх мэт);
- Бичил уурхайтай холбоотой хуулийн хэрэгжилтийг хангах, хууль бусаар уурхайн талбайд нэвтрэхтэй холбоотой арга хэмжээ болон олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ биелүүлэхэд нь бүх шатны төрийн байгууллагуудад туслах, холбогдох бүхий л аргаар дэмжих;



- Бичил уурхайг албан ёсны болгоход дэлхий нийтийн хэмжээнд тулгарч буй бэрхшээлүүд болон бичил уурхай том уурхайтай зэрэгцэн оршиход гарах асуудлуудын талаар төрийн болон орон нутгийн мэдээллийн хэрэгсүүдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх;
- Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага, Азийн сан, Швейцарийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Агентлаг зэрэг бичил уурхайг сонирхогч төрийн бус байгууллага, хандивлагчидтай хамтран ажиллах боломжыг үнэлэх (тогтвортой бичил уурхайн (ТБУ) төсөл).

#### **Үр дүнтэй хориг саад:**

- Аюулгүй байдлын хэлтсийн стандарт ажиллагааны журмууд, арга тактикууд, бэлтгэл сургуулилалт, тоног төхөөрөмж, нөөц бололцоог хянах, үнэлэх, шаардлагатай үед засаж сайжруулах;
- Цагдаагийн байгууллагатай хийсэн Хамтын ажиллагааны гэрээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, хэрэгжилтийн хяналт тавьж байх;
- Хууль бус олборлолтын явцад ухсан нүх хонгилог буцаан булах ажлыг орон нутгийн засаг дарга, цагдаа, онцгой байдлын газартай хамтран нарийн чанд журмын дагуу тогтмол хэрэгжүүлэх;
- Ажиглалт хяналтын одоогийн аргуудаа сайжруулж (дулаан мэдрэгч камер, CCTV хяналтын камер, гэрэл зураг, аюулгүй байдлын эргүүл, ажиглалтын цамхаг) мэдээллийг цаг алдалгүй цуглуулах болон баримтжуулах зорилгоор ашиглах хувилбаруудыг үнэлэх;
- Хашаалах, зохих саад ба тэмдэг тэмдэглэгээг ашиглан лицензийн талбайн хил заагийг тодорхой, нүдэнд харагдахуйц байдлаар сайжруулахад чиглэсэн Орчны хамгаалалтын төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавих (ерөнхий төвт хяналтын тойрог, хамгаалалтын орчны бүс).

#### **Аюулгүй байдлын хариу арга хэмжээ:**

- Болзошгүй аюул занал тулгарсан үед үр дүнтэй хариу арга хэмжээ авахад шаардлагатай хүн хүч, удирдлага зохион байгуулалт, тоног төхөөрөмж, хамгаалах болон холбооны хэрэгсэл, хүний амь насанд учруулахгүй байх багаж хэрэгслээр бие бүрэлдэхүүнийг хангах;
- Аюул занал тулгарсан үед хуулиар зөвшөөрөгдсөн хүч хэрэглэх, багаж хэрэгсэл ашиглах, нөхцөл байдлын эрсдлийн үнэлгээ хийх зэрэг шаардлагатай үр чадвар эзэмшүүлэх зорилгоор холбогдох ажилтнуудыг зохих сургалтаар хангах;
- Аюулгүй байдлын ноцтой зөрчилд юуг хамруулахыг тодорхойлж, зөрчил гарсан үед компани дотроо болон гадагшаа (цагдаагийн байгууллага) хэрхэн мэдээлж, авах арга хэмжээг тодорхой болгосон байх (зөрчлийн дагуу Онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг мөн хянах);
- Аюулгүй байдалтай холбоотой бүх үйл явц, арга хэмжээнүүдэд олон улсын хүний эрхийн зарчмууд, ялангуяа **АБХЭСДЗ**-д тусгагдсан асуудлууд тусгагдсан байхад хяналт, анхаарал тавих;
- БГК-ын бүх ажиллагсад, түүнчлэн аюулгүй байдлын үүрэг гүйцэтгэхээр илгээгдсэн хүчний байгууллагын ажилтнуудыг хүний эрхийн тухай сургалтаар хангах.